

**ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ**



**АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР**

**ДӨРӨВДҮГЭЭР БОТЬ**



Их Багш нар Дээдийн Номыг үг хэлээр л уламжилдаг төдий биш, Тэдэнд харагдахад л та гэгээрч байдаг.

*“Бурхан хэрхэн эгэл хүн болж хувирсан бэ?”* айлдвараас





Хичээнгүйлэн бясалгах тусам таны бодол сэтгэл уужуу тайвуу болно. Дэлхий ертөнцийг харлаа гэхэд тэр нь угаас амар амгалан, сайн ч биш, муу ч биш байдаг.

*“Бурхан хэрхэн эгэл хүн болж хувирсан бэ?” айлдвараас*

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ

АГШИН ЗУУР  
ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР

Дөрөвдүгээр боть

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг

## АГУУЛГА

Намтрын өмнөх үг .....	6
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн товч намтар.....	7
Өмнөх үг .....	11
Бурхан хэрхэн эгэл хүн болж хувирсан бэ?.....	12
Уламбана баярын уг гарал.....	37
Багш хималай ууланд байсан нь.....	61
Авшиг хүртмэгц бурханы хутагт хүрнэ.....	80
Хүндэтгэлийн найман номын ёсны шинэ тайлбар .....	96
Сүнс гарах болон түүнчлэн ирсэн байдал адилгүй.....	109
Багшийн адислалын хүчийг хэрхэн таньж мэдэх вэ? .....	127
Брадига будда бурхан.....	143
Ногоо идэх нь ч бас үйл түйтгэртэй.....	161
Хэнийг бурхны шашинтан гэх вэ?.....	169
Веган хоолны ач тус.....	190
Эрүүл мэнд ба хоол хүнс.....	191
Экологи ба хүрээлэн буй орчин.....	194
Дэлхийн өлсгөлөн .....	195
Амьтны зовлон .....	195
Гэгээнтнүүд ба үйлс нэгтнүүд .....	196
Авшиг хүртэхүй - арьяабалын бясалгалын арга .....	198
Таван сахил.....	200
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ном хэвлэлийн жагсаалт.....	201
Бидэнтэй хэрхэн холбогдох вэ? .....	204

## НАМТРЫН ӨМНӨХ ҮГ

Ихээр билиг нээгдсэн нэгэн Их Багшийн дэсийг эгэл хүний чадвар болон энэ ертөнцийн үг хэлээр илэрхийлэх боломжгүй байдаг. Түүний бүхий л амьдрал, үзэл санааг хичээнгүйлэн тодорхой дүрсэлсэн ч бүрэн гүйцэд өгүүлэх аргагүй. Эрт цагт Энэтхэгийн нэгэн бясалгагч Багшийнхаа намтар түүхийг бичихээр томилогджээ. Хэдэн сарын дараа бичиж дууссан эсэхийг түүнээс асуухад дуусаагүй гэв. Дахин хэсэг хугацаа өнгөрсний дараа мөн л асуухад: “Миний багш эгэл ертөнцөөс хэтийдсэн төрөлтөн болохоор түүний дэсэд хүрч байж л би Багшийнхаа дүрстэй, дүрсгүй ажлыг жинхэнээр нь ойлгож чадна. Тийм болохоор энэ ажлыг хэзээ ч дуусгах аргагүй юм” гэжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өөрийн урьдын амьдралын түүхээ дурдсан нь тун бага. Гэвч олон орны шавь нар нь Багшийнхаа намтрыг ихэд сонирхож, янз бүрийн асуултыг давтан тавьдаг учраас өөрийн түүхээ нээн өгүүлсэн билээ. Энэ товч намтарт Их Багшийн амьдралын замнал, түүхээс нь эмхэтгэн цуглуулж, найруулан бичсэн байна. Иймээс бүрэн гүйцэд биш байхыг үгүйсгэх аргагүй тул хүлцэл өчье.

## Товч Илгээлт

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай нь уран бүтээлч, оюун санааны агуу хөгчийн хувьд сүнслэг гоо сайхныг илэрхийлэх бүхий л хэлбэрт дуртай. Иймээс Тэрээр Вьетнамыг “Ау Лак”, Тайванийг “Формоса” гэж нэрлэдэг. “Ау Лак” нь Вьетнамын эртний нэр бөгөөд амар амгалан амьдрах гэсэн утгатай. Харин “Формоса” буюу үзэсгэлэнтэй сайхан гэсэн утгатай нэр энэ эрдэнийн арал болоод ард түмнийх нь гоо сайхныг бүрэн дүүрэн илэрхийлдэг. Ийм нэрийг хэрэглэх нь тухайн нутаг орон, ард иргэдэд сүнслэг дэвшил, буян хишгийг авчирна гэж Их Багш үздэг юм.

## ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ТОВЧ НАМТАР

### Хайр Энэрлийн Зам

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол дэлхий дахинаа алдар суу нь түгсэн оюун санааны их удирдагч, уран бүтээлч, хүмүүнлэгийн үйлстэн билээ. Их Багшийн хайр энэрэл хүн төрөлхтний соёл, ёс заншлын хил хязгаарыг давж, дэлхий даяар түгж байдаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Ау Лакын (Вьетнам) төв нутагт мэндэлж, Европт очиж суралцсан бөгөөд тэндээ Улаан загалмайн нийгэмлэгт ажилласан байна. Тэрээр энэ хугацаанд дэлхий дахин зовлон зүүдүүрээр дүүрэн байгааг олж мэдээд үүнээс ангижрах арга замыг эрэн хайхаар шийдсэн нь Түүний амьдралын эрхэм дээд зорилго болсон байна.

Тэрбээр тухайн үед герман эмчтэй гэр бүл болж, аз жаргалтай амьдарч байсан ч тус тусын зам мөрийг хөөх хэн хэндээ амаргүй шийдвэрийг гаргаж, нөхрийнхөө чин сэтгэлийн ерөөлийг өвөрлөн өөрийн зорилгоо биелүүлэх аяндаа морджээ. Ийнхүү Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай үнэнийг эрэн хайж, сүнслэг гэгээрлийн зам мөрөөр замнаж эхэлсэн байна. Эцэст нь Энэтхэгийн Хималайн ууланд нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш түүнд дотоодын Гэрэл болон Аялгууг ажиг "Арьяабалын Бясалгалын Арга"-ыг уламжилжээ. Ийнхүү Тэрбээр хэсэг хугацаанд хичээнгүйлэн бясалгасны эцэст Төгс Гэгээрэлд хүрсэн ажээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн гэгээрлийн сургаал номлолыг удирдлага болгосон Олон улсын нийгэмлэг 1980 онд байгуулагджээ. Хүмүүсийн чин сэтгэлийн хүсэлтээр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Арьяабалын бясалгалын аргыг уламжилж, тэднийг өөрийн дотоод дахь Бурханлаг чанараа нээн илрүүлэхэд нь дэмжин зоригжуулж эхэлсэн юм. Удалгүй Америк, Европ, Ази, Австрали, Африк таван тив болон Нэгдсэн Үндэсний Байгууллагаас Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайг ном тайлуулахаар урин залах болжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай энэрэн нигүүлсэх сэтгэлээрээ зовж зүдэрсэн олон түмэнд бүх талаар хайр энэрэл, тус дэмжлэг үзүүлдэг бөгөөд Түүний хүмүүнлэгийн ажил нь аливаа хориг саадыг

даван туулж, дэлхийн өнцөг булан бүрийн орон гэргүй ядуучууд, дорой буурай амьдралтай өндөр настнууд, шоронгийн хоригдлууд, хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны хомсдолтой иргэд, дүрвэгсэд, Америкийн ахмад дайчид зэрэг хүмүүст түгэн хүрчээ.

Дулаарлаас үүдэлтэй элдэв хямрал дэлхий дахинд нүүрлээд байгаа өнөө үед Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өгөөмөр сэтгэлээр олон сая долларын хүмүүнлэгийн тусламжийг үзүүлдэг бөгөөд байгалийн элдэв гамшигт нэрвэгдсэн хүмүүст туслуулахаар нийгэмлэгийнхээ гишүүдийг дэлхийн бүхий л оронд илгээж байна. Үүнээс гадна Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай энэ дэлхийд бидэнтэй зэрэгцэн оршигч эрхэм ариун амьтад болон хүрээлэн буй орчны асуудалд ихэд санаа тавьдаг билээ.

Их Багшийн энэрэл хайр, асрал нигүүлсэл олон сая хүний сэтгэлийг хөдөлгөж, бусдын төлөөх харамгүй сайхан сэтгэл нь тэдний даган дуурайх үлгэр жишээ болж байна. Их Багш өөрийн уран зураг, дэнлүү чимэглэл, хувцасны загвар, үнэт эрдэнийн гоёл зэрэг урлагийн бүтээлүүдийнхээ орлогоороо тусламж хэрэгтэй Эзэн Бурханы үр хүүхдүүдийг дэмжин тэтгэдэг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сүүлийн жилүүдэд бичсэн “Шувууд миний амьдрал”, “Ноход миний амьдрал”, “Эрхэм ариун амьтад” хэмээх гурван ном нь дэлхийн хамгийн их борлуулалттай номоор шалгарч, олон хэлээр орчуулан гаргасан байна. Их Багш телепат холбоо болон сүнслэг ажиглалтаараа эрхэм ариун амьтдын сэтгэл хөдлөл, бодол санааг гүн гүнзгий ойлгож, тэдний эрхэм дээд санаа зориг, хэзээ ч хариу үл нэхэх өгөөмөр хайрыг энэ бүтээлүүддээ тод томруун тусган харуулжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш хүмүүст үлгэр дуурайл болох зөв ёс зүйтэй сайн үйлсийг урамшуулан сайшааж 2006 оны 3 сард “Дэлхийн Гэрэлт манлайлын шагнал”-ыг, мөн удалгүй “Дэлхийн Гэрэлт Баатарын шагнал”, “Дэлхийн Гэрэлт Нигүүлсэнгүй үйлсийн шагнал”, “Дэлхийн Гэрэлт шударга үйлсийн шагнал”, “Дэлхийн Гэрэлт Зохион Бүтээгчийн шагнал” зэрэг олон цол шагналыг бий болгожээ. Энэ бүх нэр төртэй шагналыг хувь хүн, албан байгууллага, улс оронд олгодог бөгөөд тэдний үлгэр дуурайлтай ажил үйлс нь манай гарагийг улам гоо үзэсгэлэнтэй, эв зохиролтой болгож, дэлхийн тогтвортой хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж байна. Тухайлбал: Словени Улсын хоёр дахь Ерөнхийлөгч доктор Жанез Дрновшек, АНУ-ын 45 дахь Дэд ерөнхийлөгч, 2007 оны Нобелийн Энх тайвны шагналт, НҮБ-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо (IPCC)-ны гишүүн Аль Гор, НҮБ-ийн Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо (IPCC)-ны тэргүүн бөгөөд Энэтхэг улсын Эрчим Хүч, Эрдэс Баялгийн Хүрээлэн (TERI)-гийн тэргүүн, НҮБ-ын Хүний суурьшлын хөтөлбөрийн 2010 оны шагналт, доктор Ражендра К.Пачаури, АНУ-ын Сансар Судлалын Үндэсний Төвийн (НАСА) тэргүүн, 2009 оны Карл Густаф Россби судалгааны шагналт, доктор Жэймс Е.Хансен, Английн нэрт доктор, бичний овгийн хөхтөн амьтан



судлаач Жэйн Гуудал нарын олон хүн эдгээр шагналыг хүртсэн байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай амиа үл хайрлан аюул эрсдэлийг сөрж, бусдын амь насыг аварсан бидний эрхэм анд нөхөр амьтдын баатарлаг үйлсийг нь сайшаан “Дэлхийн Гэрэлт Баатарын шагнал”, “Дэлхийн Гэрэлт оюун ухааны шагнал”-ыг олгодог бөгөөд үүгээр амьтдын баатарлаг зориг, сэргэлэн ухаан, хайрын сэтгэлийг илчлэн харуулдаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн хөгжил дэвшилд оруулсан сүнслэг болон материаллаг асар их хувь нэмрийг олон улс орны төр засгийн газар, хувийн байгууллагууд өндрөөр үнэлэн шагнаж, хүндэтгэлээ илэрхийлсэн байна. Тухайлбал: Гуси Энх Тайвны шагнал (2006 он), Телли-гийн 27 дахь жилийн шалгаруулалтын Мөнгөн Эрдэнийн тэргүүн шагнал (2006 он), Лос Анжелесын Хөгжмийн Долоо хоногийн Сайшаалын гэрчилгээ (2002 он), Дэлхийн Оюун Санааны Удирдагчийн шагнал (1994 он), Дэлхийн Хүний Эрхийг Дэмжигчийн Шагнал (1994) зэргийг дурдаж болно. Түүнчлэн АНУ-ын төр засгаас жил бүрийн 2 дугаар сарын 22 болон 10 дугаар сарын 25-ны өдрүүдийг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Өдөр” болгон тэмдэглэж байхаар зарласан юм. Их Багшийн дэлхийд өргөсөн тусламж, түүний бие сэтгэлийн харамгүй их үйлсийг олон орны төрийн тэргүүн, ард иргэд ихэд үнэлэн талархлаа илэрхийлсээр байдаг билээ.

Их Багш Чин Хай бол өөрийн билиг ухаан, баатар зоригороо цаг уурын өөрчлөлтийн сэдвийг зоригтой хөндөж тавьсан өнөө үеийн хүрээлэн буй орчныг хамгаалагчдын манлайлагч юм. Үнэн хэрэгтээ хориод жилийн өмнөөс хүрээлэн буй орчныг хамгаалахыг уриалж байсан бөгөөд “Та ийм амьдралыг сонгож болно”, “SOS-дэлхийн дулаарлыг зогсоох нь” зэрэг үйл ажиллагааг санаачлан эхлүүлжээ. Түүнчлэн дэлхийн цаг уурын өөрчлөлтийн хуралд зочин илтгэгчээр оролцож, дэлхий ертөнц дээр өнөө үед тасралтгүй гарсаар байгаа байгалийн гамшгийн үндсэн шалтгаан болон түүнийг шийдвэрлэх гол арга болох нигүүлсэнгүй веган амьдралын хэв маягийг сонгох тал руу олны анхаарлыг хандуулж байна.

Олон нийтэд хэдийнээ танил болсон “Веган болж, энх тайвныг цогцлоо” хэмээх уриаг Их Багш Чин Хай дэвшүүлсэн билээ. Хоол хүнсний сонголт нь цаг уурын өөрчлөлтөд асар их нөлөөтэйг үндэслэн энэрэнгүй, тогтвортой амьдралын хэв маягийг сонгоход нь хүмүүст туслахын тулд “Loving Hut” веган хоолны сүлжээ ресторан нь Их Багш Чин Хайн урамшуулал дэмжлэгээр амжилттай өргөжин тэлсээр байна. Олны таашаалыг хүлээсэн энэ хоолны газрууд дэлхий даяар тархаж, олон төрлийн эрүүл, тэжээллэг, хямд үнэтэй, амтлаг веган хоолоор үйлчилдэг. Дэлхий ертөнц, түүний оршин суугчид, зэрэгцэн оршигч төрөлтнүүд болоод бидний үр хойчийг дэлхийн дулаарлаас үүдэлтэй сүйтгэгч нөлөөнөөс аврахын тулд үүний эсрэг хамгийн үр дүнтэй арга болох эрүүл, энэрэнгүй хоол хүнсийг дэлгэрүүлж байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хосгүй гайхамшигт энэ гараг дэлхийдээ хүн төрөлхтөн гэрэлт ирээдүйгээ цогцлоох үйлсэд нь амь биеэ огоорон эцэс цуцалтгүйгээр тусалсаар байгаа билээ.

## ӨМНӨХ ҮГ

Их Багш Чин Хай гүн утгагай, ойлгоход хэцүү үг хэллэг хэрэглэхээс ямагт зайлсхийж, хамгийн ойлгомжтой ярианы хэлбэрээр ном тайлдаг. Түүний ном хэвлэлүүд нь уран яруу илэрхийллийг бус, уншихад хялбар ойлгомжтой байхыг урьтал болгодог. Их Багшийн адислалын хүчийг бууруулахаас эмээж, түүний шавь нар эгэл хүний ухаанаар номын агуулгыг өөрчилдөггүй.

## БУРХАН ХЭРХЭН ЭГЭЛ ХҮН БОЛЖ ХУВИРСАН БЭ?

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай  
Формоса буюу Тайвань, Тайбэй хотын  
Улсын Ван да бага сургууль.*

*1988 оны 3 дугаар сарын 11 (Эх нь хятад хэлээр)*

Эрхэм хүндэт гэгээнтнүүд ээ! Уг нь энэ сүүлийн хоёр өдөр бол ном тайлах өдөр биш байсан ч, энэ удаагийнх нь та нарыг урамшуулж байгаа бэлэг болчихлоо. Учир нь таван, зургааны өдөр ном тайлж дөнгөж дуусаад наймны өдөр авшиг хүртээж, есний өдөр амарсан, гэтэл залгаад бас нөгөө л газартаа үргэлжлүүлэн ном тайлж байгаа нь арай дэндсэн хэрэг болж байна шүү. Бид уг нь ингэж төлөвлөгөөгүй байсан биз дээ.

Учир нь Багш нь өмнөд газарт очиж, бараг хоёр сар хэртэй ном тайлаад буцаж ирээгүй, буцаж ирэх эсэхээ ч хараахан шийдээгүй байсан. Тэр үед бид яг Пин дүн голын хөвөөнд майхан барьчихаад сууж байлаа. Гэтэл Тайбэйгийн авшигтнууд Багшийгаа буцаж ирэхгүй болчихлоо гэж ихэд сандран Багшийгаа залж ном тайлуулах газрыг яаравчлан зохицуулжээ. Ингэснийхээ дараа Багшийгаа ирэхгүй байх вий гэхээс санаа зовохгүй болсон байна, учир нь нэгэнт эндхийг төвхнүүлээд зохицуулчихсан юм чинь!

Тэд ном тайлах газар хайж байх үед олдохгүй байсан гэнэ. Сонсоод байх нь ээ, түрээслүүлэгч хүмүүс нь Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн нэрийг сонсмогцоо ном дэлгэрүүлэх байрыг түрээслүүлэхгүй болчих юм гэнэ. (бүгд инээлдэв) Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай ямар муу зүйл хийснийг би мэдэхгүй байна, та нар мэдэх үү? Би өмнөд нутагт байсан болохоор үүний учрыг мэдээгүй, зөвхөн ийм яриаг л олж сонссон төдий.

Зарим нь байраа түрээслүүлэх үгүйгээ шийдэж чадахгүй, эцсийн хоромд л шийдвэрээ гаргадаг учраас хурлын хоёр танхимыг нэгэн зэрэг түрээсэлжээ. Ингэх нь арай багалгаатай хэрэг байж л дээ. Тэд хурлын хоёр танхимынхаа түрээсийн мөнгийг нэгэнт төлчихсөн байна, тэгээд нэгэнт л хоёр байрны хөлс төлсөн болохоор хоёр удаа ном тайлах болчихлоо. Энэ нь бас Тайбэйгийн хүмүүс Багштайгаа ерөөл барилдлагатайг харуулж байгаа хэрэг юм. Учир нь авшиг хүртсэн хүн Тайбэйд нилээд олон бий. Тиймээс номоо илүүхэн тайлсан ч хамаагүй дээ.

Өчигдөр Багш нь бурхан бодьсадва бидэнд туслахыг боддог хэдий ч тийм ч амар хялбар туслах боломжгүй байдаг тухай ярихын зэрэгцээ өөрийнхөө түүхийг ярьсан билээ. Тухайлбал: Эцэг, эх маань одоо болтол Вьетнамд байсаар байна. Тэдний амьдралын хэв маяг минийхтэй огт адилгүй учраас би тэднийг дэргэдээ авчрах аргагүй байдаг. Хэрвээ тэд гэрээс гарч, Арьяабалын номын цогцосыг бясалгадаг, мөн чин үнэн сэтгэлээр бясалгаж, туулан гэтлэхийг боддог бол энэ нь тун амар байхсан.

Гэвч манай гэрийнхэн мах идэх дуртайг Багш нь та нарт нэгэнтээ ярьсан билээ. Тэд энд ирсний дараа Багш нь тэдэнд идүүлэх гэж мах худалдан авахаар дэлгүүрт очиж ч магадгүй болно. Учир нь би шавь нараараа мах авчруулж болохгүй биз дээ! Харин тэд миний эцэг, эх болохоор би их дэлгүүрээс мах, ногоо худалдан авах гэж очихгүй байж болохгүй. Та нар бодоод үз дээ, сонинд “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай үхрийн хэрчсэн мах худалдаж авахаар их дэлгүүрт очлоо” (бүгд инээлдэв) гэж нийтэлнэ. Ингэсний дараа миний шавь нарын яахыг нь та нар төсөөлөн бод доо, энэ бол мэдэж ойлгоход маш амархан асуудал, тэд бас тийшээ гүйж очих нь гарцаагүй.

Үүнтэй адилаар, хэрвээ бид бурхан бодьсадвагийн энэрлийг олж хүртэе гэвэл тэдэнтэй адилхан дэстэй, адилхан дадал зуршилтай, адилхан зан араншинтай, амьдралын адилхан хэв маягтай байх ёстой. Ингэвэл сая бурхан бодьсадва нарт бидэнд туслахад нь нилээд хялбар болох болно. Жишээлбэл: Бид мөрийтэй тоглох зуршилтай мөртлөө Төгс баясгалант оронд очвол бурхан бодьсадва бидэнд мөрийтэй тоглох хэрэггүй гэж хэлэхээсээ санаа нь зовно. Учир нь бид мөрийтэй тоглох тун дуртай. Та нар мэдэж байгаа, мөрийтэй тоглодог хүний тэр зуршлыг нь болиулахад хар тамхи хэрэглэдэг хүнийг хар тамхи хэрэглэхийг нь болиулахтай адил хэцүү хэрэг байдаг. Бүр тамхи татах зэрэг багахан муу зуршлыг хүртэл өөрчлөн болиулахад амаргүй байдаг, тийм биз дээ?

Хэрэв бидний дадал зуршил бурхан бодьсадва нарынхтай адилгүй бол Төгс баясгалант оронд очих тэр цагт тэнд тийм зүйлс байхгүй болохоор бурхан бодьсадва ч бидэнд туслах аргагүй болно. Учир нь бурхан бодьсадвагийн оронд бас бурхан бодьсадвагийн хууль дүрэм байдаг. Хэдийгээр бурхан бодьсадва нар зарим хуулийг өөрсдөө бичиж, өөрсдийн иргэдэд зориулан гаргасан байдаг ч гэсэн тэд өөрсдөө тэр хуулиа мөн л хүндлэн сахидаг нь мэдээжийн хэрэг. Тийм байх ёстой биз дээ? Архи ууж, тамхи татах зэргээр бид өөрсөндөө юу дадуулж байдгийг бурхан бодьсадва угаасаа хайхардаггүй ч харин тэндхийн хүмүүс хайхардаг юм.

Авид Бурханы сударт: Төгс баясгалант оронд байдаг хамаг төрөлтөн бүгдээрээ Бурханы хутагт хүрсэн байдаг биш, тэд бол зөвхөн бясалгалтан төдий бөгөөд буцашгүй бодьсадва л юм. Тэд тэнд саяхан ирсэн ч байж мэднэ, тиймээс тэд бурхантай адилгүй гэжээ. Жишээ нь: Хэрэв Багшийн чинь эцэг, эх энд ирвэл Багш нь тэдний шүүст идээ идэх, эсвэл ургамал хоол идэхийн аль нь ч байсан хайхрахгүй байж,



гагцхүү эцэг, эхдээ элбэрэл ачлалтай байхыг бодоод мах худалдан авч, тэдэнд идүүлнэ. Гэтэл би өөрөө үүнийг тоохгүй ч миний шавь нар харин хайхарч тооно шүү дээ. Учир нь энэ дүрэм журмыг би өөрөө гаргаж, бусад хүнийг мах идэж болохгүй гэхчээд харин өөрөө мах худалдаж авахаар дэлгүүрт очих хэрэгтэй болно. Би тийм зүйл хийх эрхтэй байлаа ч гэсэн дүрэм журмаа зөрчиж болохгүй биз дээ. Ойлгож байна уу?

Би өөрөө Багш, тэгээд бас шавь нараа сургадаг, гэвч шавь нар маань ямар хууль дүрмийг хүндэтгэж байна, би ч бас тэр хуулийг хүндэтгэх нь зүйтэй шүү дээ. Тийм биз дээ? Эцэг, эх маань миний хамгийн ойр дотны, эрхэм хүндэт хүмүүс боловч би тэдний төлөө хууль зөрчиж болохгүй. Учир нь Багш нь юу хийсэн ч өчнөөн олон хүн Багшийг чинь ажиглан харж байгаа.

Бурхан бодьсадва мөн л адил. Бурхан бодьсадва нэн энэрэнгүй, нигүүлсэнгүй боловч хэрвээ бид хууль зөрчвөл тэд биднийг аварч чадахгүй, учир нь орчлон ертөнцөд өөрийн гэсэн хууль дүрэм байдаг. Нэгэн их бясалгалтан энд ирдэг нь биднийг айлган сүрдүүлэх юмуу, эсвэл албадан шахах гэсэн хэрэг биш. Зөвхөн бидний урьд нь огт олж дуулж байгаагүй дүрэм журам, урьд нь мэдэж байгаагүй хууль ёсыг сонсохын тулд юм. Учир нь бид үүнийг мэддэггүйгээсээ болж алдаа гаргаад байдаг. Одоо бид бурхан бодьсадватай хамт байхыг хүсвэл тэр бидэнд үүнийг хийж болохгүй, түүнийг үйлдэж болохгүй хэмээн хэлж өгнө. Түүний сургаж зааварласнаар хийвэл бид даруй бурхантай адил болж, дээш гарах боломжтой болно. Гэвч эгэл хүмүүсийн хувьд үүнийг сонсох нь тийм ч амархан байдаггүй, Бурхан бодьсадва бидэнд туслахыг хүсэвч бид харин үгийг нь сонсохыг хүсдэггүй. Үгийг нь сонсох эсэх нь бидний эрх, бурхан бодьсадва биднийг албадахгүй.

Үүнтэй адилаар, хэрвээ би гэртээ буцаж очвол эцэг, эхээсээ: “Та нар намайг дагаж Тайваньд (Формоса) очиж надтай хамт бай, би та нарыг ачилж асарна. Гэхдээ нэг зүйлийн дүрмийг та нар сайтар дагах ёстой. Намайг дагаж ургамал хоол идэж, ууланд сууж, тун ядуу зүдүү амьдрах болно. Та хоёр ингэж байж чадах уу?” гэж асууна. Миний хувьд эндхийн бясалгалт амьдрал маань маш баяр баясгалантай санагддаг. Гэтэл тэдний хувьд энэ нь баяр баясгалангүй ч байж мэднэ. Тиймээс тэднийг энд авчрах нь тийм амар биш байна л даа.

Үүнтэй адилаар, Авид Бурхан Төгс баясгалант оронд шавь нараа заан сургаж байгаад нэг хоёр хүний залбирал, эсвэл Тайваний (Формоса) нэг зуун хүний, эсвэл арван мянган хүний залбирал даатгалаар Төгс баясгалант орныхоо тийм чухал үүрэг хариуцлагаа орхиод биднийг гэтэлгэхээр бууж ирж болохгүй. Мэдээж, тэр бас бууж ирж ч болно л доо, гэхдээ хэрвээ бид тэндхийн ёс журмыг нь хүндэтгэхгүй юм бол тэр биднийг дээш авч гарч чадахгүй. Төгс баясгалант оронд очихыг хүсвэл Төгс баясгалант орны дүрэм журам болон тэндхийн амьдралыг урьдаар сурч судлах хэрэгтэй.

Авид Бурхан тун завгүй байдаг тул хүмүүний энэ ертөнцөд хүн

явуулж, зааж сургаж ч магадгүй. Бурхан элчээ явуулах үед тэр илгээсэн хүний үгийг нь бид сонсох хэрэгтэй. Үгүй бол бид дээш гарч чадахгүй болно. Тийм бус дээ? Энд би одоо эцэг, эхээ авчрах аргагүй, учир нь миний ажил тун яаруу, би бас шавь нараа сургах хэрэгтэй, хоёрхон хүний төлөө өдий олон шавиа орхиж чадахгүй. Олон хүний төлөө тэр хоёрыгоо аргагүй орхигдуулах биз. Багшийнхаа санааг ойлгож байна уу?

Тиймээс би Вьетнамд очиж тэднийг авчирч чадахгүй. Хэрвээ би тэднийг авчирья гэвэл нэг хүнийг Вьетнам (Ау Лак) руу томилон явуулж, “Чи намайг төлөөлөн нэг хэргийг бүтээгээд ир, миний эцэг, эхийг энд аваад ир” гэвэл болох л доо. Гэхдээ тэр хүн надтай ойр дотно, танил, миний санааг сайн ойлгодог, вьетнам болон хятад хэлээр гаргууд сайн ярьдаг байх ёстой. Ингэвэл тэрээр хоёр улсын хооронд хялбар зорчиж чадна. Тэр хүн бас энэ хоёр улсын хууль дүрмийг сайн мэддэг, коммунист улсын хуулийг хүндэтгэн сахидаг байвал зохих бөгөөд тэднийг дураараа шүүмжилж болохгүй. Жишээлбэл: Би хүн томилж Вьетнам руу явуулбал тэр хүн Вьетнамын хууль дүрмийг дагаж, сайтар сахин орон нутгийн төрийн захиргааны байгууллагад найдаж, тэднээр засаг захиргааны асуудлуудыг шийдвэрлүүлэх хэрэгтэй. Өдөр бүр тэдэнтэй хамтран ажиллаж, тэд юу хий гэнэ, түүнийг нь ёсчлон биелүүлж, аяар нь шийдүүлэх хэрэгтэй. Харин “би бол тайвань хүн” гээд тэдний хууль, дүрмийг хүндэтгэхгүй байж болохгүй.

Багш нь аль хэдийн туулан гэтэлсэн боловч Вьетнамд очоод тэр хоёрыг онгоцонд суулгалгүй шууд л нисгээд авчирч болохгүй биз дээ? Учир нь тэндхийн хууль дүрэм нь адилгүй. Хэрвээ бурхан бодьсадва энд хүрч ирээд биднийг аваачна гэвэл тэр бас эндхийн хууль дүрмийг хүндэтгэхээс биш харин “Одоо чи минийх болсон, бид даруйхан Төгс баясгалант оронд нисэн очъё” гэж хэлж болохгүй. Ингэж болохгүй.

Үүнтэй адилаар, авшиг хүртэхийг хүсч байгаа хүмүүс эхлээд анкет бөглөх хэрэгтэй бөгөөд ингэснээр засаг захиргааны ажил эхэлнэ, дараа нь бурхан бодьсадва тэднийг алгуурхнаар Төгс баясгалант оронд аваачих юм. Цаг нь болоод засаг захиргааны ажил дуусаж, тамга дармагц тэд даруй явж болно. Зарим хүн Багшаас нь “Авшиг хүртсэний дараа тэр даруй ангижирч болох уу?” (бүгдээрээ инээлдэв) гэж асуухад нь би “Болно, гэхдээ бас арай болоогүй” гэж хэлж байлаа. Энэ нь маш ээдрээтэй, учир нь бид энэ дэлхий дээр амьдарч байхдаа олон хүнтэй харилцан холбоотой болсон болохоор ганц нэгхэн хүнийг аваад явбал болчих юм биш. Бид одоо ч төрөл садан, найз нөхөдтэй хэвээр байгаагаар барахгүй бас бусадтай өгөө, аваатай байсаар байна. Гэр байшингаа худалдаж амжаагүй, цуглуулсан зоос мөнгөө сайтар шийдвэрлээгүй (бүгд инээлдэв) гэх мэтийн байдал байдаг.

Заримдаа бид бусдыг банкнаас мөнгө зээлэхэд нь батлан даадаг, гэтэл бидний батлан даасан тэр хүн зугтааснаас болж бид мөнгөний өрөнд ордог. Мөнгийг нь зээлсэн хүн зугтаж одсоныг банк авч хэлцэхгүй, тэд зөвхөн зээлүүлсэн мөнгөө буцааж авахыг л мэднэ. Тиймээс бид үлдэж

байгаад тэр өрийг төлөх л хэрэгтэй. Тийм биз? Тайван хүмүүс сэтгэл сайтай, сонсоод байхад маш олон хүн өөр хүнийг батлан дааснаасаа болж хэрэгт холбогддог, учир нь нөгөө даалгуулсан хүмүүс нь зугтаасан болохоор тэд энд үлдэж, өрийг нь төлөхөөс өөр аргагүй болдог.

Үүнтэй адилаар, та нарыг Төгс баясгалант оронд очиж чадахыг Багш нь батална. Гэвч та нар хэрвээ мөнгөний асуудалд орох юм бол Багшид чинь бас төвөг болно. (бүгдээрээ инээлдэв) Тиймээс авшиг хүртээх үедээ Багш нь та нарыг хичээнгүйлэн бясалгаарай гэж захидаг, бас та нараас өдөрт хоёр цаг гучин минутыг л бадарлан гуйя. Та нарын мөргөл, өргөл тахил надад хэрэггүй, та нараар сүм хийд барьж босгуулахгүй. Би хаана ч очиж хонгосон хамаагүй, майхан босгоод ч сууж болно. Учир нь би хамаг төрөлтнийг зовоох дургүй, авшигтнуудад төвөг болох дургүй, тэднээр их мөнгө гаргуулж, сүм хийд бариулах дургүй.

Бидний энэ ертөнц угаасаа мөнх бус, Багш нь энд ирсэн нь хэрхэн бясалгахыг хүмүүст заан сургаж, бясалгагчийн үлгэр жишээ болж, хүн нэг бүрийг хамтаараа бясалгахад зоригжуулах гэсэн юм. Та нар өдөр бүр намайг гоё хувцас (Багш орхимжоо заав) өмсдөгийг харж байгаа. Энэ нь үнэндээ нэг л иж бүрдэл хувцас төдий. Сайхан юмс олон байсны хэрэггүй. Нэг иж бүрэн хувцас байвал болчихно. Угаавал дорхноо хатаж, маргааш нь дахиад л өмсөж болно, бас сайхан харагддаг. Та нарын өмсөж байгаа хувцасны аль нь ч миний хувцас шиг сайхан харагдахгүй. (бүгдээрээ инээлдэж, алга ташив) Багшийн өмсөж байгаа нь үнэхээр сүр жавхлантай юм гэж та нар хэлдэг. Гэтэл та нарын өмсөж байгаа хувцас миний өмсөж байгаагаас хэд дахин илүү үнэтэй.

Зарим хүний нэг хос хувцас хэдэн арван мянган юанийн үнэтэй байдаг, зарим нь хэдэн мянган юанийн үнэ хүрнэ. Багшийн чинь энэ иж бүрдэл хувцас хямдхан, хэдхэн зуун юанийн л үнэтэй. Тийм биз? Хамгийн үнэтэй нь нэг мянган юань болно, энэ бүс нь хамгийн хямд, нэг яард (0.910 метр) нь арван долоон юанийн үнэтэй, хэрвээ өөрөө оёж өмсвөл тавь, жаран юаньтай байхад нэг гоё сайхныг хийчихнэ. Тэгээд их мөнгө зарахгүйгээр өдөрт нэг сайхныг өмсөж болно. Тиймээс Багшийнх нь мөнгө хэрэглээд барагдашгүй байдаг. Учир нь надад зардал гэхээр юм алга.

Бидний гэрээс гарагчид өдөрт нэг удаа л жинхэнээр хоол иддэг. Заримдаа өглөөний хоол идэх ч үгүй. Юу байна, түүнийгээ л иднэ. Бага зэрэг жигнэмэг идчихээд буцалсан ус ууж, орой үлдсэн ногоогоо идээд л болдог. Хааяа ном тайлаад оройтвол гэрээс гараагүй шавь нар биднийг гэртээ урьж аваачаад нэг тогоо гоймон чанаж өгдөг. Зарим үед бид бараг идэх ч үгүй. Ганцхан үдийн хоолоор болгоно. Гэхдээ үдийн хоолондоо ч би их юм идэж чаддаггүй. Бидний мөнгө хэрэглээд дуусахгүй байдгийн учир нь бид илүү ихийг хэрэглэдэгүүд л байгаа юм. Харин зарим хүнд мөнгө нь хүрэлцэхгүй байдаг нь тэд хэтрүүлж үрдгээс болж байгаа юм.

Багшаасаа авшиг хүртэхэд та нарын өргөх өргөл барьц, эсвэл

байгуулж өгөх том сүм хийд надад хэрэггүй. Би юу ч бариулахгүй, тиймээс авшиг хүртээх үедээ та нарыг ууланд очуулж зүрхлэхгүй, учир нь бидний амьдардаг газар маш эгэл жирийн, зөвхөн дөрөв таван хулсан мод босгоод дээгүүр нь майхны бөс даавуугаар бүтээсэн байгаа, тиймээс та нар шиг их, бага ноёдыг би аймшиггүй залж аваачих зориг алга. Та нарын өмсөж байгаа хувцас бүгд үзэсгэлэнтэй сайхан, бас үнэтэй. Миний бодлоор та нар бүгдээрээ бурхан болохоор би та нарыг өөрийн өвсөн овоохойдоо залж зүрхлэхгүй.

Хэрвээ Багштайгаа хамт сууя гэвэл надтай хамтрах ёстой. Бидний сууж байгаа нь тийм энгийн, хямд төсөр боловч надтай хамт суухад бас тийм ч амар биш. Учир нь тийм ядуу зүдүү амьдралд та нар дасаагүй. Ууланд суух нь хялбар биш. Урьд нь бид халуун усгүй, өдөр бүр хүйтэн усаар угааж цэвэрлэдэг байсан. Та нар тийм амьдралыг тэсвэрлэж чадах уу? Өвөл бол мэдээж бүр ч тэсвэрлэж чадахгүй. Тиймээс бидний хувьд баяр баясгалантай санагддаг зарим зүйл та нарт баяр баясгалангүй санагдах биз.

Бурхад ч үүнтэй адил. Тэд дээд оронд суугаад маш баяр баясгалантай байдаг. Гэтэл бид Авид бурхнаас “Дээд оронд караоке байгаа юу?” (бүгд инээлдэв) гэж асуувал тэр “үгүй” гэвэл бид тэнд очих дургүй болно. Зарим хүн мөрийтэй тоглох дуртай тул “Дээд оронд казино байна уу?” гэж асуухад нь “үгүй” гэвэл тэр дорхноо очих хүсэлгүй болно. Учир нь баяр баясгалангийн тухай бидний ойлголт бурхан бодьсадвагийнхтай адилгүй байдаг. Гэтэл Шагжамуни Бурхан: “Хамаг төрөлтөн бүгдээрээ бурхан” гэж хэлсэн. Багш нь бас “хамаг төрөлтөн бүгдээрээ Бурхан” гэсэн. Бүгдээрээ бурхан байтлаа яагаад мөрийтэй тоглогч бурхан, тамхи татагч бурхан, архи уудаг бурхан, бүжиг бүжиглэдэг бурхан, караоке дуулдаг бурхан гэж байна вэ? Бидний уг язгуур маань бурхан байтал яагаад бид эгэл хүн болсон юм бэ гэдгийг Багш нь мөдхөн тайлбарлаж өгнө.

Багш нь эхлээд нэг түүх ярьж өгье. Маш эрт урьдын цагт, асанги галавын үед, тоолшгүй олон жилийн өмнө нэг бурхан байж гэнэ, тэр бурхан нэргүй байв, учир нь дөнгөж мэндэлсэн байжээ. Нэр бол зөвхөн замбуутивд л байдаг. Дээд оронд тэдэнд нэр байдаггүй. Бид түүнийг түр зуур “Нэргүй бурхан” гэе, “нэргүй” гэдэг нь дуудах нэргүй гэсэн санаа юм. Үнэндээ заавал бурхан гэж дуудах ч хэрэггүй, түүнийг нэг Богд хүн гэх юмуу, үгүй бол Ван мүн ниан1, эсвэл Их Есүс Христ гэх мэтийн өөр маш олон янзын нэрээр дуудаж болно.

Тэрээр маш эрт урьд цагийн бурхан юм. Тэр өөрийн оршин байсан, маш өндөр дэсийн, маш гэрэл гэгээтэй, маш баяр баясгалантай орноосоо энэ замбуутивийг харахад эндхийн хүмүүс маш гашуун зовлонтой, амьтад бас маш гашуун зовлонтой, аливаа бүхэн бүгд зовлон зүдгүүртэй байгааг олж үзээд сэтгэл нь зовж, тэднийг аврахаар бууж ирэх хүсэл төржээ. Тэр ингэж бодонгуут дээрээс бууж ирэв. Учир нь бурхны хүсэл тун хурдан, бодмогц нь тэр дороо биелдэг хэрэг. Ойлгов уу?

Тэр гүн халуун сэтгэлээр бууж ирээд, их нигүүлсэнгүйгээр хамаг төрөлтөнд хандан: “Энд тийм сайн биш, хамаг төрөлтөн хоорондоо харилцан хэрцгийгээр өширхөн, хөнөөлдөж байна, та нар юунд аяга хоолны төлөө ингэж харгислан хөнөөлдөж байна вэ? Та нар дээд оронд очиж болно, тэнд надад байшин олон байна, та нарыг үнэ төлбөргүйгээр суулгаж, хоол хүнсийг ч зүгээр үнэгүй идүүлэе, хувцас хунар юу л өмсөхийг хүсвэл бүгд байна, та нар дээш гарах уу?” гэж асуусан байна. Тэр үед түүний үгийг хамаг төрөлтөн ойлгосонгүй. Учир нь хүмүүс хоорондоо хүний үг хэлээр ярилцаж байхад, тэр бурхны хэлээр хэлсэн тул энэ нь тэдэнтэй адилгүй байжээ. Тэрээр маш хурц гэрэлтэй, маш үзэсгэлэнтэй, тун ч сүр жавхлантай байж гэнэ. Гэтэл бидний эгэл хүмүүс түүнтэй адилгүй болохоор тэд цөм түүнд итгэсэнгүй.

Тэр ингэж нэг өдөр, хоёр өдөр, нэг сар, хоёр сараар тасралтгүй туршиж үзсэн боловч ер тус болсонгүй. Учир нь бурхан угаас хүний талаар ерөөсөө ямар ч ойлголтгүй байжээ. Тэгээд тэрхэн мөчид бурхан сэхээрч, хүнийг зааж сургая гэвэл эхлээд хүний үг хэлийг сурах хэрэгтэй юм байна гэж бодож олов. Хүний үг хэлийг сурсны дараа тэр хүмүүсээс: “Та нар юунд миний үгийг сонсохгүй байна вэ? Дээд оронд маш сайхан байдаг гэж би хэлсэн шүү дээ. Та нар яагаад итгэхгүй байна вэ?” гэж асуусанд тэд: “Бид ер нь тийм зүйлсийн талаар олж сонсож байгаагүй, тэгээд ч эндхийн амьдралдаа дасчээ. Гэтэл та энд бууж ирээд юу хийсэн ч бидэнтэй адилгүй байх юм. Бид танаас айж эмээж байна, учир нь ярьж байгаа зүйлийг чинь ойлгохгүй байна. Таны өмсөж зүүж байгаа хувцас, таны зүс царай, хоол унд тань биднийхтэй адилгүй, та юу ч идэхгүй байж болно, бид харин идэхгүй байж чадахгүй, та бидэнтэй ер адилгүй, яг л гадны хүн шиг байтал бид танд яаж итгэх юм бэ?” гэжээ.

Тэр үед бурхан хоёрдахь удаагаа сэхээрчээ, тэрээр: Хэрвээ хүнийг зааж сургая гэвэл хүний амьдрал, ахуй байдлыг сурч, тэдний сэтгэлийг ойлгож, тэдэнд юу хэрэгтэй байгаа, тэд юунд дуртай вэ, тэд яагаад ийм байдаг вэ гэдгийг мэдэх хэрэгтэй юм байна гэж боджээ. Тэгээд бурхан дахин суралцаж эхэлжээ.

Гэхдээ хүн төрөлхтний ажил төрөл гэдэг нь маш олон янз байдаг. Тиймээс эхлээд тэрээр хүмүүс идэх хамгийн дуртай гэдгийг олж мэдээд газар тариалангийн ажил сурч эхэлжээ. Ногоо тарих, хоол хийхийг сурсны дараа тэднийг урьж, хоол идүүлэхэд, цадсаныхаа дараа тэдний сэтгэл санаа баясгалантай болоод зааж сургахад хялбар болсон гэнэ. Хоолонд дуртай тэр хүмүүс түүний хийсэн амттай хоолонд маш их талархаж, өдөр бүр тэднийд очиж хооллон ярихыг нь сонсох болжээ. Ингээд сая асуудалгүй болж гэнэ.

Гэтэл арилжаа наймаа хийдэг зарим хүн мөнгө зоосонд л дуртай, тэд зөвхөн арилжаа наймааг яаж хийвэл ашигтай байж, мөнгө хурдан олж болохыг л боддог болохоор бурхан тэднийг гэтэлгэж чадахгүй байв. Учир нь тэдний бодол санаа, амьдрал ахуйг нь бурхан ойлгохгүй. Бурхны оронд арилжаа наймаа хийх, зоос мөнгө олох явдал байхгүй, гэвч тэр сурахыг мөн л мэрийн хичээж, тэдэнтэй хамт арилжаа наймааных нь



ажлыг хийж, аажмаар суралцаж эхэлжээ. Тэр сайн сурсан учир хүмүүстэй хамт худалдаа хийж, тэднийг маш их мөнгөтэй болгосонд, тэд түүнийг ихэд бахдан бүгдээрээ түүнийг зөвлөгчөөрөө залж, яаж арилжаа наймаа хийхийг асууж сурах болж гэнэ. Тэр бурхан учраас тэднээс илүү цэцэн сэргэлэн байж, хурдан сурдаг, мөнгө олохдоо ч тэднээс хурдан байжээ. Иймээс хүмүүс тэрхүү бурхнаар ихэд бахархаж, түүнээс асууж, сурах болсон тул тэр хүмүүсийг алгуураар гэтэлгэсэн аж.

Энд бас өөр төрлийн хүмүүс байгаа нь гарцаагүй. Тайваньд л гэхэд олон төрөл зүйлийн ажил мэргэжил байдаг. Ямар ч гэсэн тэр бүгдийг нь сурах ёстой. Нэг хоёрхон төрлийн мэргэжил ч биш, эмч, эрдэмтэн, зохиолч, гүн ухаантан, хэл шинжээч, ядуу хүн, баян хүн гэх мэтээр маш олон янзын мэргэжилтэй хүмүүс байдаг тул тэр бүгдийг аажмаар сурахын зэрэгцээ тэднийг гэтэлгэх хэрэгтэй байлаа.

Тэр ингэж суралцаж байх явцдаа эгэл хүмүүстэй маш удаан хамт байж, холилдооны улмаас аливаа зүйлээ бүгдийг нь мартан төөрөлджээ. Ингэж суралцах явцдаа тэр улам сайн сурч завдахгүйгээсээ айн сандарч, илүү их сурвал мартахаас айгаад тэр ч байтугай өөрийгөө бурхан гэдгээ ч мартжээ. Өглөөнөөс үдэш болтол гагцхүү суралцаад завгүй. Тэдэнд мөнгө төгрөг олж өгөхөөр яарна, газар тариалангийн ажил эрхэлж яарна, хоол, унд хийж яарна, хувцас оёж яарна, ирсэн зочныг нь дайлахаар яарна, тэднийг баярлуулах зүйл хийхээр яарна.

Маш олон ажил хийсээр ер завгүй байдаг болж. Ингээд тэр бидэнтэй адил хүн төрөлтөн болж хувирчээ. Та нар одоо өөрсдийгөө таньж авав уу? Энэ чинь яг бид мөн. Бид өөрсдөө бурхан байснаа мартчихаад өглөөнөөс орой болтол энэ тэр ажилд яарч, завгүй байсаар эгэл хүн болчихжээ. Тэр бурхан бас үүнээс болж эгэл хүн болчихжээ.

Гэвч тэр үүрд эгэл хүн байж чадахгүй. Учир нь бурхан бол хэзээ ямагт бурхан л байдаг болохоор аль нэгэн өдөр тэр ухаарч сэхээрээд: “Би яагаад өдөржингөө ийм ажилд яардаг билээ? Миний хамгийн анхны зорилго юу байсан бэ? Би чухам юу хийх гэж энд ирсэн билээ? Би үүнийг ч хийх албагүй, түүнийг ч хийх албагүй шүү дээ.” гэж боджээ.

Тэгээд тэрээр өөрөөсөө асууж эхэлжээ, Би ядарчихжээ, хичнээн мэрийвч ямар ч үр дүнд хүрсэнгүй, хэнийг ч гэтэлгэж чадсангүй, өөрөө ч төөрчихсөн, бас ядарснаасаа болоод суралцах явдлаа ч дуусгаж чадахгүй болжээ. Тэр үед тэр дахин сэхээрч “Ийм байх нь арай ч биш ээ” гэж бодох болно. Тэгээд эргэн тойронд байгаа хүмүүсээс өөртэй нь адил бодолтой хүн байгаа эсэхийг асуухад, хэн нэг хүн түүнд: “Надад бас тийм бодол бий, гэвч юу хийхээ мэдэхгүй байна” гэж хэлж ч магадгүй.

Учир нь энд олон бурхан бууж ирсэн бөгөөд нэг нь энэ газарт, нөгөө нь тэр газарт байдаг. Тэд өөрсдөөсөө: “Бид яагаад дахин дээд орондоо очиж чадахгүй болчихов оо?” хэмээн асууж байдаг юм. Тэр үед бас нэгэн бурхан байсан байж мэднэ. Тэр бурхан энэ ертөнцөд урьд нь ерөөсөө бууж ирээгүй, эндхийн зүйлсийг дэндүү их хараагүй байв. Тэгээд маш олон бурхан бүгдээрээ яах учраа мэдэхээ болиод мөргөн

даатгаж, хэрхэн буцах аргаа олохгүй байгааг мэджээ. Тэр бурхны сэтгэл нь хөдөлж, тэднийг өрөвдмөгц, тэр дороо бууж ирэв. Тэр дөнгөж бууж ирсэн учир урьд өнгөрснөө маргаагүй, тиймээс маш түргэн сэхээрч ухаараад төөрөлдсөн тэр бурхдад зарим учрыг тайлж өгөөд яаж буцаж харих аргыг нь зааж өгчээ. Гэвч өнөө төөрч будилж байсан бурхад буцахаасаа өмнө маш олон хүнд туслах ёстой юм. Багшийнхаа хэлж байгаа санааг ойлгож байна уу?

Учир нь одоо тэрээр аливаа бүгдийг ухаарч ойлгосон байна. Худалдаачид, эмнэлгийн ажилтнууд, тариачид гэх зэрэг хүн юу бодож, юу хүсэж байдгийг, тэд ажлаа яаж хийвэл зохистой зэргийг бүгдийг мэддэг болжээ. Тиймээс бурхад бодьсадва нар маш ухаантай байдаг. Тэд юу сурсан ч маш түргэн байдаг бөгөөд бусдаас сайн сурдаг. Шагжамуни Бурханыг бичиг, цэргийн эрдэмд нэвтэрхий, эрдэм чадвар төгс гэж бид сонсож байсан. Тэрээр балчир байхаасаа л маш их зүйл сурч эхэлсэн бөгөөд багш нь хүртэл түүнийг гайхан шагшиж байжээ. Тэр гоц оюун ухаантай, авьяаслаг хүүхэд байсан тул Тэрээр төрөл төрөлдөө нэгэнт бүгдийг сурчихсан байна.

Хамаг төрөлтөнд туслахын тулд л бидэнд ийм их зүйл сурах хэрэгтэй байдаг. Та нар ойлгож байна уу? Хэрэв бид бурхан байлаа ч, хамаг төрөлтнийг хэзээ ч ойлгодоггүй бол, тэднийг яаж гэтэлгэх юм бэ? Тиймээс та нар одоо Шагжамуни Бурхан яагаад “хамаг төрөлтөн бүгдээрээ бурхан” гэж хэлснийг мэдэж авлаа. Бид угаасаа цэцэн мэргэн бөгөөд билиг ухаантай.

Саяхан бууж ирсэн тэр бурхан бол энгийн төрөлтнийг гэтэлгэдэггүй, харин зөвхөн саяхан сэрж сэхээрсэн тэдгээр бурхныг гэтэлгэн гэрт нь аль болох хурдан буцаадаг. Тэр эгэл хүмүүсийг гэтэлгэдэггүй, учир нь тэрээр эгэл хүмүүсийг ойлгодоггүй, хэрвээ хамаг төрөлтнийг гэтэлгэе гэвэл гашуун зовлонг амьдралыг олон жилээр туулж өнгөрүүлсэн тэр бурхдад найдах хэрэгтэй. Энэ бурхад сэхээрч, гэгээрснийхээ дараа хамаг төрөлтнийг гэтэлгэж чадна. Учир нь тэд хамаг төрөлтний элдэв бодол санааг сайн ойлгодог, “хамаг төрөлтөнтэй төрөл төрөлдөө хамт байж олон зүйлд суралцсан” байдаг. Тиймээс л “Бурхан ерөөл барилдлагагүй хүмүүсийг гэтэлгэдэггүй” гэдэг нь ийм утгатай ажээ.

Бид энэ ертөнцөд ирээд зовлон зүдгүүр амсаж, энэлэн зовж, олон хүнтэй хутгалдан хамт амьдрахдаа бусдад тэрслэгдэж, сайн, муу үйл хийж байдаг нь бүгд л суралцахын төлөө ажээ. Хэрвээ бид муу хүмүүсийг гэтэлгэе гэвэл муу үйлийг яаж хийдгийг бас мэдэх хэрэгтэй. Тэгэхгүй бол, бид түүнтэй хэрхэн ярилцаж чадах вэ, бид ерөөсөө муу хэрэг хийж байгаагүй болохоор өөрийн биеэ тун эрхэм дээд гэж бодон түүнийг дорд үзэн гүтгэхийг л мэднэ шүү дээ. (бүгдээрээ алга ташив) Тиймээс муу үйл хийх нь бас нэгэн суралцах арга юм. Наян дөрвөн мянган номын цогцос гэдэг нь ийм утга санаа биз. Бид наян дөрвөн мянган номын цогцосыг нэг л насандаа сурч дуусгаж чадна гэсэн санаа биш, тийм биш ээ. Нэг зүйлийн номын цогцосыг бясалгаж байснаа өөр нэг зүйлийн номын цогцосыг бясалгахаар л бурхан болчихдог биш, аль

нэг номын цогцосыг сурмагц л Бурханы хутагт хүрчихдэг биш, үүнийг ихэнх хүн буруугаар ойлгодог.

Тарни унших нь нэг зүйлийн номын цогцос, бурханд сүсэглэн мөргөх нь бас нэг зүйлийн номын цогцос, эдгээр нь бүгд буруугүй боловч цөм Бурханы хутагт хүрэх номын цогцос биш, ойлгож байна уу? Бурханы хутагт хүрэх номын цогцос бол хамгийн эцсийн зам мөр болно. Үүний тулд Арьяабалын номын цогцосыг бясалгах ёстой. Миний уншсан ном сударт бүгдэд нь ингэж өгүүлсэн байна. Зөвхөн Бурханы шашны сударт хэлсэн төдий биш.

Тиймээс та нарын зарим нь Багш яагаад ном тайлах бүртээ Бурхны шашны судрыг тайлахгүй, харин Есүс Христ, Мухаммед, Лууз, Күнз зэргийг яриад байна вэ? хэмээн гайхдаг. Гэтэл тэд бүгд нэг адил зүйлийг сургасан. Харамсалтай нь бидний билиг нээгдээгүй болохоор харж чаддаггүй. Эрхбиш Арьяабалын номын цогцосыг бясалгаж, билиг нээгдээний дараа сая ойлгож мэдэх болно.

Одоо та нар Зул уламжлах тэмдэглэлийг (the Chuan Deng Lu) уншсан ч чухам юу хэлж байгааг нь ойлгохгүй. Хэдийгээр та нар бурхны шашинтан боловч, Зургаадугаар үеийн Дээд багшийн Мандалт судрыг (the Six Patriarchal Altar Sutra) уншаад юу ярьж байгааг нь ойлгохгүй. Тэр ямар номын цогцосыг зааж сургаж байгааг мэдэхгүй. Түүний санаа юу болохыг ойлгохгүй. Зургаадугаар үеийн Дээд Багшийн тайлсан номд тун энгийн явдлыг ярьсан билээ. Гэвч бид үүнийг уншаад л өнгөрсөн болохоос сурч судлаагүй учраас яаж ойлгох билээ дээ. Хэрвээ бид угаас шинжлэх ухаанд суралцаагүй байж эрдэмтэн, судлаачдын бичсэн ном бичгийг уншвал тэд чухам юу бичсэн болохыг мэдэхгүй нь лавтай. Учир нь тэдний хэлсэн үг өгүүлбэр нь ондоо болохоор бид ерөөсөө ойлгож чадахгүй. Хэдийгээр инженерийн толь бичиг, анагаах ухааны толь бичиг, техникийн толь бичиг, тусгай мэргэжлийн толь бичиг гэх зэрэг маш олон төрлийн энгийн толь бичиг байдаг ч анагаахад суралцсан хүн инженерийн технологийн толь бичиг үзээд үг хэллэгийг нь ойлгож чадахгүй байдаг, энэ нь тэдний хэрэглэдэг нэр томьёо, үг хэллэг нь хоорондоо адилгүй, ондоо байдгаас болж байгаа юм.

Бурханы шашны толь бичиг бас маш төвөгтэй. Жишээлбэл: Нирваан, Samsara, Buddha гэх зэргийг католик шашинтан ойлгодоггүй. Хэрвээ та нирваан, нирваан гээд байвал тэр: “Нирваан гэж юу вэ?” хэмээн асуух болно. Харин та тэнгэрийн орон гэж хэлбэл тэр: “Үүнийг бол би ойлгоно.” гэж хэлнэ. Ойлгож байна уу? Хэрвээ тоост хорвоо гэж Луузын (Бумбын) сургаалтнуудад хэлбэл тэд: “Тоост хорвоо” гэдэг нь ямар утгатай вэ? хэмээн асуух болно. Хэрэв та дэлхийн бөмбөрцөг гэвэл тэд шууд ойлгоно.

Яагаад тийм төвөгтэй үгсийг хэрэглэдэг вэ? Багш нь ойлгомжтой, энгийн хялбар үгсийг хэрэглэх дуртай. Ингэвэл хүн бүр ойлгоно. Аль ч шашныхан ойлгоход хялбар. Ямар шашин байх нь хамаагүй, бид хамтдаа эв нэгдэлтэй амьдрах боломжтой байх хэрэгтэй. Юу ч болсон

бай, бид нэгэнт хамтдаа байгаа бөгөөд бүгдээрээ энэ ертөнцийн иргэн мөн. Бид нэгэнт ахан дүүс болчихсон учраас, энэ тогтсон үйлийн үрийг өөрчлөхийн аргагүй. Нэгэнт ийм холбоотой болчихсон юм чинь бид өөрсдийн үйл хэргээ хамтдаа шийдвэрлэж, хамтдаа нягтран нэгдэж, зүйл зүйлийн нөхцөл байдал болон үйл түйтгэрийг даван туулж, баяр баясгалантай амьдарвал зохино.

Хэрвээ бурхны шашинтны хувцсыг өмссөн хүн диваажинд очих замыг мэддэг бол бид даруйхан түүнээс суралцах ёстой. Учир нь хүн бүгд адилхан, зөвхөн өмссөн хувцас нь ондоо байдаг төдий юм. Бид бүгд Диваажинд очих, Тэнгэрийн оронд очих, Нирваандаа буцах гэсэн нэгэн адил хүсэлтэй. Тийм биз? Бид бүгдээрээ төгс төгөлдөр хүн болж хувираад тэрхүү хамгийн Дээд эрхэм хүнтэйгээ уулзахыг хүсдэг.

Хүсэл зорго адил болохоор, хэрвээ католик шашинтан: “Би зам мэднэ, би тэнд очиж байсан, би чамайг дагуулж очиж чадна” гэж хэлбэл бидний бурхны шашинтнууд тэр дороо очиж, түүнээс суралцвал зохино. Учир нь хүн болгон маш олон замыг туулж байж л сая жинхэнэ зам мөрөө эрж олдог. Тийм биз дээ? Заримдаа бид өмнө нь гарч үзээгүй уулын оройд Эрдэнэсийн сан байна гэж сонсоод тэр ууланд авирч гарахдаа салж гарах болдог биз дээ? Жишээлбэл, та өмнүүр нь гарвал, би хойгуур нь гарна, бас нэг нь дундуур нь гарч, нөгөө хүн нь араар нь гарна гэх мэтээр салж, тус тусдаа хайвал хялбар дөхөм байдаг. Хэрвээ хэн нэг нь хайгаад олбол дохио өгч, бусдадаа мэдэгдэнэ. Тэр үед бид бүгдээрээ түүн лүү гүйж очих юмуу, эсвэл хамгийн түрүүнд хайж олсон тэр хүн буцаж ирээд биднийг дээш дагуулж гарна.

Хэдийгээр дэлхий дээр маш олон шашны бүлэг байдаг ч, хайгаад олчихсон хүн эргэж ирээд: “Би түүнийг хайгаад олчихлоо, одоо бүгдээрээ цугтаа гарья” гэж бүх хүнд хэлбэл зүйтэй. Ингэвэл зөв биз дээ? Гэтэл тэр хүн эргэж ирэх үед баярлан угтах хүн яагаад байхгүй байна вэ? (бүгдээрээ халуунаар алга ташив) Энэ бол үнэхээр нэг том ном хаялцаан гэмээр. Гэвч энэ нь бас аргагүй, баярлан угтахгүй бол яая гэхэв дээ. Тэр хүн эрдэнэс хайгаад маш их удсан тул түүнийг буцаж ирэхэд нь тэндхийн хүмүүс мартчихаад хэн гэдгийг нь танихгүй болчихсон ч байж магадгүй. Түүнийг харахад өөр болжээ. Учир нь тэр уул давж, ус гатлан хээр хонож, хэц дэрлэж, зовлон зүдгүүр зөндөө амссан болохоор гадна төрх нь өөрчлөгдөн хувирчээ.

Дөнгөж эхлээд уул давах үедээ тэр хүн хээнцэр, ихэмсэг, өмссөн хувцас нь цэвэрхэн байсан байж болно, гэтэл уул өөд авирах замдаа маш их зүдэрчээ. Түүний хамаг бие шарх сорвиор дүүрч, хөхөрч хавдсан байна (бүгдээрээ алга ташив), нүдний шилээ гээж, хувцас нь хиртсэн ч байж магад. Тиймээс бид түүнийг танихаа больж: “Та бол харийн хүн, манай бүлгийнх биш, та биднийг мэхлэж байна” гэж хэлж мэднэ. Нэг Их Багшийг хүрч ирэх үед иймэрхүү “угталт” болдог юм.

Хэдийгээр төрөл төрөлдөө бид найз нөхөд, сайтар сэхээрсэн хамт бясалгагчдаа хайж олдог боловч, харин тэд Их Багш нарыг таньдаггүй

нь өөрчлөгдөж хувирснаас нь болдог. Жишээ нь: Шагжамуни Бурхан биднийг гэтэлгэхийн тулд буцаж ирэхийг хүсчээ гэж бодъё. Бид хэдийгээр өдөр бүр түүнд мөргөж, сүсэглэн бахархаж байдаг ч тэр ирэх үедээ энэтхэг хувцас өмссөн байх албагүй билээ. Учир нь түүнд ялгаварлах сэтгэл байхгүй. Тэр ганцхан энэтхэг хэв маягт дуртай биш, тиймээс өөрийн хүссэн ямар ч хувцас өмсөж ирээд хүмүүсийг гэтэлгэж болно. Тэр вьетнам, эсвэл хятад хувцас өмсөөд ирж болно. Эрэгтэй хүний хувцас юмуу, эсвэл эмэгтэй хүний хувцас ч өмсөөд ирж магадгүй.

Та нарын зарим нь өчигдөр хар өнгөтэй хувцас өмсөж байснаа өнөөдөр сольж, цагаан хувцас өмссөн харагдана, зарим нь өчигдөр урт байсан үс гэзгээ өнөөдөр хагасыг нь тайрч хаяад нөгөөдөр юу ч үгүй болтол нь хусуулж мулзан болж ч мэднэ. (бүгдээрээ инээлдэв) Гэвч тэр яасан ч байсан нөгөө хүн хэвээрээ. Ойлгов уу? Тиймээс бид зөвхөн гаднах байдлыг нь харж болохгүй. Жишээлбэл: Багш нь угаас эмэгтэй хүн шиг харагддаг. Та нар Багшийнхаа гэрээс гарахаас өмнөх гэрэл зургийг үзвэл үнэхээр үзэсгэлэнтэй байжээ гэж хэлнэ, энэ нь Багшийгаа эмэгтэй гэдгийг мэдэж байна гэсэн үг биш үү? Эмэгтэй хүн шиг харагдаж байвал үзэсгэлэнтэй байна биз дээ? Одоо бүгдээрээ Багшийгаа цэвэрхэн, сайхан гэж хэлж байна. Энэ нь Багшийгаа эрэгтэй хүн шиг гэсэн санаа биз.

Маш олон хүн шавь нараас минь “Танай Багш чинь эрэгтэй юм уу, эмэгтэй юм уу?” гэж асуухад тэд юу гэж хариулсныг та нар мэдэх үү, “Мэдээж, эмэгтэй хүн, гэхдээ тэр эрэгтэй хүн шиг харагддаг” гэжээ. Үс гэзгээ тайрч, хуссаны дараа харахад өөрчлөгдөж, ондоо болдог байхад, хэрэв төрөл арилжаад эргэн ирвэл хэрхэн таньж чадах билээ? Та нар Багшдаа итгэдэг болохоор Багшийгаа дахин буцаж ирээрэй гэдэг, эсвэл энэ дэлхийгээс битгий яваач гэж үргэлж гуйдаг. Гэвч би өнө мөнх энэ махан биетэйгээ байгаад байж болохгүй биз дээ. Би хөгширч өглөөд шүдгүй болох үед ном тайлахад амаргүй болно. (бүгдээрээ инээлдэж, алга ташив) Хувцас элэгдэж урагдвал солих хэрэгтэй, хувцсаа сольсон юм бол эрхбиш төрөл арилжиж, дахин буцаж ирэх хэрэгтэй. Гэвч дахин төрөх үедээ яг адилхан хувцсыг хайгаад олохгүй ч байж мэднэ. Хувцас урагдаж навтарсаар өөр болно. Учир нь цаг үе өөр болсон болохоор нэг янзын хувцсаа л өмсөөд байж болохгүй. Жишээ нь: Эртний Тан улсын үед одоо Багшийнх нь өмсөж байгаа хувцастай бараг ижил хувцас өмсөж байлаа. Харин орчин үеийн хүмүүс барууны жийнсэн өмд өмсдөг. Энэ нь орчин үед ихэд дэлгэрсэн болохоор одоогийн хүмүүс уламжлалт хувцсаа өмсөх нь тун ховор болжээ. Тийм биш гэж үү? Та нар Сан ди минд очиж үзвэл, одоо ууланд амьдардаг хүмүүсийн зарим нь уламжлалт хувцсаа өмсөх ч үгүй байдаг, хааяа хурим найрын үеэр л тэр хувцсаа өмсөж байхыг нь олж харна. Тэд хааяа өмсөхөд нь бид олж хараад маш их гайхан сонирхдог. Урьд нь тэд нүүрэн дээрээ хоёр хав хар зураас шивүүлдэг заншилтай байжээ. Тэр нь хэдий том байна, төдий гоё харагддаг гэнэ. Одоо бид тийм хүнтэй таарвал айснаасаа болоод бараг үхэхэд хүрнэ. Тийм үү, үгүй юу? Уламжлал бүгд хувирсан учраас бурхан



бодьсадва ч хувирах хэрэгтэй болжээ. Багшийнхаа санааг ойлгож байна уу?

Энэтхэгт Шагжамуни Бурхан гэрээс гарагчийн хувцас өмсөж байгаагүй, Энэтхэгт тийм зүйлийн хувцас өмсдөггүй юм. Вьетнамд гэлэнмаа нар бас тийм хувцас өмсдөггүй. Гэтэл би нэгэнт Хятад улсад ирчихсэн юм чинь хятад хувцас өмсөх хэрэгтэй. Яагаад үгүй гэж, өмсчихвөл та нар баярлах болно. Тиймээс бид зөвхөн гадна талын байдлыг л хараад байж болохгүй.

Багш нь гурав хоногийн өмнө ном тайлахдаа хэрвээ би эрэгтэй хүн байсан бол Вьетнамын дайнд аль хэдийний амь үрэгдэх байсан гэж хэлсэн. Учир нь ихэнх эрэгтэй хүн цэргийн алба хаах үүрэгтэй байдаг. Намайг төрөхөд миний эцэг, эх “Яагаад охин төрчихөв өө” хэмээн гомдоллож байсан гэнэ лээ. Харин дараа нь “Хэрвээ чи хүү байсан бол хэрэг бишдэх байлаа. Цэрэгт яваад буцаж ирж чадахгүй болсон байж ч магад” гээд баярлаж байсан.

Хэрвээ Багш нь Тайвань хүн болсон бол бас л төвөгтэй болно. Тайваньд Төгс Гэгээрсэн Их Багш байхгүй болохоор түүнийг би хэрхэн хайж олох вэ? Хар багаасаа гэрээс гарч мэднэ, гэрээс гарсны дараа өглөөнөөс аваад үдэш хүртэл хүн юу хий гэнэ, тэрийг нь хийх болно. Ихэнх сүм хийдэд бүгд ийм байдаг. Хэн ч дураараа явж болохгүй, ном сонсохоор очиж болохгүй, бас дураараа өөр хүнийг хайж болдоггүй. Та нар мэдэж байгаа байх, хаана гэрээс гарсан бол тэндээ “хадагдаж”, нэг алхам ч холдож чадахгүй. Тиймээс Багшийг чинь ном тайлах үед гэрээс гарсан хүн тун цөөхөн ирдэг. Өнөөдөр харин гэрээс гарсан, маш сонирхолтой хоёр хүн ирж ном сонсож байна. (бүгдээрээ инээлдэв) Багшийг нь дагаж гэрээс гарсан хүмүүс бүр ч сонирхолтой шүү.

Би хэрвээ Тайваньд байгаад гэрээс гарсан бол надад ямар ч тусгүй, хэзээ ч Арьяабалын номын цогцосыг олж сурч чадахгүй байсан байх. Тиймээс Вьетнамд охин болж төрсөн нь аюулгүй, бас ач тустай болж. Цаг үе ондоо болсон учраас хэрвээ би эрэгтэй хүн болж төрсөн бол хаана ч төрсөн их аюултай, Америкт төрсөн бол хэдийгээр надтай хамаагүй байлаа ч, алс хол явуулж, Вьетнамын дайнд оролцуулна, гэтэл дайны үеэр маш олон хүн амиа алддаг.

Хэрвээ би Японд төрсөн бол өглөөнөөс аваад үдэш болтол өдөржин ном хаялцаанд яарч, улмаар омгорхог болж, ам нээмэгц “би бол даяанч” гээд юу ч сурахгүй, бас ямар ч хүний үгийг сонсохгүй болно. Учир нь “би” бол хамгийн дээд, аливаа бүхэн бүгд “хоосон” гэнэ. Ингэвэл баларсан хэрэг болох биш үү. Өөрийн биеэ ч гэтэлгэж чадахгүй юм чинь, өөр бусдыг хэрхэн гэтэлгэж чадах вэ? Ямар ном сурч чадах вэ?

Тайваний эрэгтэйчүүд мөн л адил. Өглөөнөөс аваад үдэш болтол суралцан эрдмийн зэрэг цол хамгаалах гэж яарна. Тайваньд эрдмийн зэрэг цолгүй бол бараг эхнэр олдохгүй. Эрдмийн зэрэг цол хамгаалахгүй бол болохгүй гэж эцэг, эх нь байнга шахна. Мөн дараа нь албадан байж гэрлүүлнэ. Угсаа залгамжлах хүү учраас гэрлэхгүй байж чадахгүй. Энэ

нь дорно дахины уламжлал. Эцэг, эх нь хүүгээ ихэд чухалд үзэж, эрхбиш эзэндээ шударга, эх орондоо хайртай, элбэрэл журамтай хүн болохыг шаарддаг болохоор эрэгтэйчүүдийн нийгэм болон гэр бүл дэх үүрэг, оролцоо маш хүнд, хэцүү байдаг. Хаашаа ч явж чадахгүй, яг бат бөх гинжээр гинжлүүлсэн мэт. (бүгдээрээ алга ташив)

Тиймээс Тайваньд гэрээс гарсан эр хүн тун цөөхөн. Гэртээ сууж бясалгах эрэгтэйчүүд ч бас тун цөөн. Өнөөдөр би Тайдүнээс ирүүлсэн нэг захидлыг үзлээ, нэг эрэгтэй багшийн захиа байсан. Тэрээр намайг дагаж бясалгах тун дуртай боловч түүний эхнэр нь Бурханы шашинд дургүй тул тэр бясалгалын номоо нууж далдлан байж үздэг гэнэ. Тэр өдөр нь хичээлээ зааж, үдэш нь харьж ирээд арилжаа наймаандаа туслан бас хүүхдээ асардаг болохоор бясалгал хийх цаг байдаггүй гэнэ.

Энэ захидлыг хүлээж авсны дараа би түүнээс: “Танд хэзээ цаг зав гарч бясалгах вэ?” гэж асуумаар санагдаж байв. Би түүний асуултанд хариулж чадаагүйн учир нь тэр тун завгүй. Иймэрхүү асуудлыг олж сонсох үед сэтгэл минь их зовинодог. Би түүний байр байдлыг үнэхээр ойлгож байна. Тэр нэгмөсөн уягдаад Багшийнх нь номыг судалж болохгүй мөртлөө бас багшийн ажлаа хийх хэрэгтэй. Тэгээд гэртээ харьсны дараа хүүхдээ асарч, эхнэрийнхээ арилжаа наймааны ажилд тусална. Тэр одоо бараг дөч, тавь хүрсэн хүн байна. Дахиад хэдхэн арван жил өнгөрвөл энэ насных нь амьдрал дуусаад өмнөх төрөлтэйгөө адил хов хоосон буцна. Тэгээд дахин ирж, сансрын хүрдэнд эргэлдэх нь үнэхээр санаа зовмоор хэрэг. Эрэгтэй хүмүүсийн ихэнх нь яг ийм байдалтай байдаг.

Сонсоод байхад эмэгтэй хүний үйл түйтгэр хүнд хэцүү гэх юм. Харин миний бодлоор яг үүний эсрэг байдаг шиг. Миний шавь нарын ихэнх нь эмэгтэй. Тэд нэлээн зав чөлөөтэй байдгийн учир нь хүмүүс тэднийг төдийлөн хэрэгцээгүй гэж боддогоос болдог хэрэг. Тэд зөвхөн хэрэлдэж шуугилдахгүй байж, бясалгал хийн цаг өнгөрөөвөл болчихно. Бид мэтийн “том эр нөхрүүд” бол улс, гэрийнхээ хэргийг шийднэ гэж эрчүүд боддог. Тиймээс эмэгтэй хүн байх нь тун ач тустай гэх яриа одоо үед их дэлгэрч байна, үүнээс л болж Багш нь эмэгтэй хүн болсон ч байж магад. Бид хэрэв эмэгтэй хүн бясалгаж чадахгүй гэж бодвол буруудна. Сандуй бурхан гэдэг нь хэн бэ?, Арьяабал бурхан гэдэг нь хэн бэ? Төвөдийн хамгийн дээд бурхан нь эмэгтэй билээ. Нууц тарнийн ёсыг бясалгадаг хүмүүсийн хамгийн ихээр бишрэн шүтдэг бурхан нь эмэгтэй бурхан байдаг, үүнийг та нар мэдэх үү?, та нарын дунд Нууц тарнийн ёсыг бясалгадаг хүн байна уу? (Тиймээ, гэж нэгэн хүн хариулав) Тиймээс би эмэгтэй хүн болсондоо тун их баярладаг.

Төвөдөд эмэгтэй хүн нилээд чухал. Тэд олон эртэй гэрлэхэд асуудалгүй. (бүгдээрээ инээлдэв) Та нар энэ тухай сонсох их дуртай байна аа, тийм үү? (бүгд алга ташив) Үнэндээ энэ нь зан заншил, дадал зуршил төдий юм. Бясалгагчид бид үүнийг өөрийн дураар шүүмжлэн ярихгүй байвал дээр. Ёс суртахууны талаарх ойлголт нь бүх тохиолдолд зөв, оновчтой байдаг гэж хэлж болохгүй. Тэд Төвөдөд төрсөн, тэндхийн

зан заншил нь ийм болохоор энэ үйлдэл нь гэмт явдал гэдгийг мэдэхгүй байдаг. Тиймээс нэг эмэгтэй хүн хэд хэдэн эртэй гэрлэж болохоор барахгүй, гэрлэсэн эрчүүд нь төрсөн ах дүүс байдаг. Улс болгоны зан заншил болоод дадал зуршил адилгүй. Хятад улсад бол энэ нь хууль зөрчсөн гэмт хэрэг, ёс суртахуунгүй зүйл болно. Гэвч Төвөдөд бол энэ нь маш энгийн хэрэг болно, эсрэгээрээ тэр ёсоор гэрлэхгүй гэвэл харин ёс суртахуунгүй хэрэгт тооцогдоно. Жишээлбэл, дүү нь ахтайгаа хамт нэг эхнэр авахаас таггалзвал гэрийнхэн нь түүнд мөнгө өгөхгүй. Хэрвээ төрсөн ах дүү тавуулаа юм уу, эсвэл гурвуулаа нэг эхнэр авахад хүрвэл хамгийн бага дүү нь тэр эхнэрээс таггалзаж магадгүй. Учир нь тэр нас залуу болохоор, залуу эхнэртэй болохыг хүснэ, хөгшин эхнэртэй суух дургүй. Гэрийнхэн нь түүнийг шахаж шаардвал эрхбиш тэр дургүйцэн гэрээсээ явж, өөр газарт очиж, ажил олж хийх хэрэгтэй болно.

Төвөдөд ажил олж хийнэ гэдэг тун бэрх. Өөрөө бие дааж наймаа арилжаа эхлүүлэх нь маш хүнд. Тиймээс аргагүй гэрийнхээ өв хөрөнгөнд түшиглэх хэрэгтэй болдог. Хэрвээ энэ ёс заншлаа дагахгүй гэвэл чамд сохор зоос ч өгөхгүй. Төвөдөд “ял хийх” (уламжлалт зан заншлаа дагах)-ээ дургүйцэх юм бол ёс суртахуунгүй хүн болно. Гэтэл бид Тайваньд ингэх юм бол ямар ялд унахыг мэдэхгүй. Тиймээс улам их бясалгаж, улам уужим саруул болоод дэлхий дахин угаас амар амгалан, сайн ч биш, муу ч биш гэдгийг ойлговол зохино. Мөн маш олон зүйлийг Багш нь ярихад зохимжгүй, бас ярьж байх цаг байхгүй болохоор зөвхөн ярих шаардлагатайг нь л ярилаа.

Би та нарыг харсандаа их баяртай байна, учир нь уулзаагүй хэдэн зуун жил болчихжээ. Ямар онцгой зүйлийг сонсох хүсэлтэй байна вэ? (Юуг Арьяабалын номын цогцос гэх вэ? гэж нэг хүн асуув) Та нар үргэлж энэ л асуултыг л асуугаад байх юм. Та миний номыг уншсан уу? (Үгүй гэв). Ном уншаагүй учраас л энэ асуултыг асуугаад байгаа юм. Хариад сайтар уншаарай. Бидэнд Үлгэр дэвтэр бий, хариад уншвал Арьяабалын номын цогцосын талаар бага сага ойлгох болно. Арай зузаан номуудыг нь уншъя гэвэл бидэнтэй холбоо барьж болно. Гэхдээ би товчхон ярьж өгье.

“Юуг Арьяабалын номын цогцос гэх вэ?” гэж олон хүн Багшаас нь асуудаг, тэгэхэд нь би: “Тэр бол нэг зүйлийн жам ёсоороо хэлбэлзэж байдаг хүч, нэг зүйлийн өөрсдийн чинь эрх юм” гэж хариулдаг. Өөрийн дуртай аливаа нөхцөл байдлаа бид өөрсдөө бүтээх чадвартай. Бид өөрсдийн бодол санаанд нийцсэн хүслэнт ахуй буюу ертөнцийг бүтээн төрөл садан, найз нөхдөө суулгах эрх мэдэл, хүч чадал бидэнд бий. Бид хэрвээ тэрхүү хүч чадлаа гаргаж ашиглаж чадвал заавал энэ ертөнцөд амьдрах шаардлагагүй болно. Бид өөр нэгэн ертөнцийг бүтээгээд амьдарч болно. Энэ нь яг бид маш их мөнгөтэй болоод хуучин гэр байшингаа шинэ гэр орноор солих, эсвэл хилийн чанадад хүрч, илүү үзэсгэлэнтэй, илүү иргэншиж соёлжсон улс оронд очин илүү ая тухтай амьдралаар амьдрахтай адил юм.

Үүнтэй адилаар, бидний дотоодод нэг зүйлийн сэтгэгдэшгүй,

хэмжээлшгүй, тийм их хүч чадал байдаг. Арьяабалын бясалгал нь энэ хүчээ ашиглахад бидэнд тусалж чадна. Энэ хүчийг бид “Мөн чанар”, “Уг дүр”, эсвэл “Эзэн Бурхан”, эсвэл “Мөр” гэж нэрлэдэг. Арьяабалын бясалгал нь бидэнд тусалж энэ хэлбэлзлийн хүчтэй холбож өгдөг. Бид тэр хүчтэй холбогдсоноор, тэр даруйхан түүнийг сэрэн мэдэрч, ойлгон таньж, түүний янз байдлыг нь бага зэрэг харж чадна, гадна төрхийг нь таньж мэдэх болно, эсвэл түүний хэлбэлзлийн хүчийг олж сонсох болно. Энэхүү хэлбэлзлийн хүч нь бидний өөрийн эрх мэдлийг төлөөлж байдаг бөгөөд бид түүнийг хэрэглэх тусам улам өсч, улам хүч чадалтай болно.

Олон хүн надаас: “Арьяабалын номын цогцосыг бясалгаж, дотоодын Аялгууг сонсох үед яагаад үйл түйтгэр арилдаг вэ?” гэж асуудаг. Аялгуу ажих гэдэг нь дотоодын дуу аялгуугаа ажих гэсэн үг. Ойлгож байна уу? Энэ дуу аялгуу нь энгийн нэг дуу аялгуу биш, үүнийг хүмүүсийн шүтэн барилдлагад нийцүүлэхийн тулд “Аялгуу” гэж нэрлэдэг. Тэр нь бодит дуу аялгуу биш, гэвч тохиромжтой үг олдохгүй болохоор л “Аялгуу” гэж одоохондоо нэрлэдэг юм.

Энэ Аялгууг ажвал үйл түйтгэр яагаад арилдаг вэ? Юуны өмнө бидний үйл түйтгэр гэгч ер нь юу вэ гэдгийг ойлгох хэрэгтэй. Энэ нь мөн л нэг зүйлийн хэлбэлзлийн хүч, нэг зүйлийн хүч чадал, нэг зүйлийн бидний тархи толгойдоо шингээж авсан мэдээлэл юм. Бидний тархи толгойнодоо шингээж авсан зүйл бол нэг зүйлийн хэлбэлзлийн хүч мөн гэдгийг эрдэмтэд нэгэнт олж нээсэн байна. Та нар сонсоогүй юу? Нэгэн тархины эс мэдээллийг хүлээн авсны дараа радио долгионы давтамжтай адил давтамжаар хэлбэлзэх болно, учир нь тийм давтамж байгаа болохоор л, тийм дуу аялгууг сонсож байгаа юм.

Бидний тархи ч мөн адил, дуу сонсох юмуу, мэдээллийг хүлээн авах үеийн сайн, муу, дадал болсон, болоогүй, дуртай, дургүй аливаа туршлага нь бүгд л нэг зүйлийн хэлбэлзлийн хүч юм. Тэр нь тархин дотор уламжлан дамжсаар эндээс тэнд, тэндээс энд хүрнэ, тэгээд тархины хамгийн гүнд хүрэхэд дахин шингээж бичиж авна. Дараа нь ерөнхий захирагч: “Би үүнд дуртай, түүнд дургүй, үүнийг хийх дуртай, түүнийг хийх дургүй” гэж тушаал буулгана, тэгснээр бид хариу үйлдэл хийдэг. Тийм үү, үгүй юү?

Энэ нь радио сонсохтой адилхан, бид зарим дуртай нэвтрүүлгээ цааш нь үргэлжлүүлэн сонсдог. Дургүй бол зарим үед сонсож, зарим үед ажлаа хийгээд анхаарч сонсдоггүй, бүр цаашилбал уур хүрч унтрааж орхидог. Тийм биз? Бид хэн нэг нь нөгөөдөө муугаар хандсаныг сонсвол сэтгэл зовдог, эсвэл бидний хамгийн хайртай элгэн садан нас барлаа хэмээн сонсвол шаналан зовж, бүгдээрээ уй гунигт автдаг. Энэ нь бүгд бидний сонсож байгаа тэр хэлбэлзлийн давтамж бидний тархинд орж ирснээс болсон хэрэг.

Үүнтэй адил замаар бид өдөр бүр маш олон мэдээллийг цуглуулж авдаг, учир нь бидний тархинд хэлбэлзлийн хүч байдаг, тэгээд бидэнд маш олон зүйлийн учрыг мэдээлдэг. Мэдээллэж дууссаны дараа зарим

мэдээлэл нь бидэнд хэрэгцээгүй зүйл байдаг, тийм мэдээллийг бид агуулахдаа хадгалдаг бөгөөд тэдгээрийг хожим дахин хэрэглэж ч мэднэ. Жишээлбэл: өнөөдөр нэгэн хүн биднийг загнавал бид дургүйцэж байвч, тэр хүний байр суурь дэндүү өндөр тул түүнийг яаж ч чадахгүй байдаг, тэгээд бид “За яахав ээ, чи хүлээж байгаад дараа нь хараарай” гэдэг. Бидний тархины агуулахад тийм мэдээлэл нэгэнт бий болсон учраас тэр хүний байр суурь нь уруудах үед бид тэрхүү мэдээллээ гаргаж хэрэглэн түүнийг зодох болно.

Бид муу хэрэг үйлдэх үед бидний тархи тэр үйлдлийг мөн л шингээж авдаг бөгөөд бид муу хэрэг хийснээ өөрсдөө мэддэг. Учир нь хар багаас минь эцэг, эх маань сайн үйл хийхийг сургасан. Эцэг, эх маань зааж сургаагүй байлаа ч багш биднийг сайн үйл хийж, сайн хүн болохыг сургадаг. Жишээлбэл: амь хороож болохгүй, хулгайлж болохгүй, садар самуун явж болохгүй, худал хэлж болохгүй, архи ууж болохгүй гэх зэргээр сургамжилдаг. Нэг ч багш бидэнд архи уу, тамхи тат гэж сургахгүй, тэр өөрөө тамхи татдаг байлаа ч харин биднийг тамхи тат гэж сургахгүй. Энэ үнэн биз дээ? (бүгдээрээ инээлдэв)

Тиймээс бид том болоод тэр ёс дүрмийг баримтлахгүй байсан ч, ингэж болохгүй гэдгийг тов тодорхой мэдэж байсан ч бид тэгчихдэг. Бид ингэсний дараа тархи толгой маань үүнийг шингээж авна. Тэр бидний сэрэл мэдрэхүй болон үйл хөдлөлийг бүгдийг нь шингээж авдаг. Бид муу үйл хийх үед тархи биднийг муу хэмээн шингээж авна. Бид өөрсдийн талаар муугаар сэрж мэдрэх үед тархи аль хэдийнээ шингээж авсан учраас бас л биднийг муу гэнэ, тэгээд цаг нь болох үед шингээн авч хадгалсан тэр зүйлстэйгээ бид учраа олох хэрэгтэй болдог. Энэ нь бидний үйл түйтгэр гэж хэлдэг тэр зүйл юм, эсвэл үүнийг бид өвгө дээдсийн үлдээж уламжилсан нүгэл хилэнц, эсвэл өөрсдийнхөө урд төрлийн үйлийн үр гэдэг. Үйл түйтгэр гэдэг нь бидний тархины шингээж авсан муу мэдээллүүд л юм.

Заримдаа бас бид өөрсдөө хийе гэж хийгээгүй байдаг, бид нийгмээс олон муу зүйлийг сурдаг, хэдийгээр үүнийг сайн биш гэдгийг мэддэг ч маш олон хүн ингэдэг тул бидэнд татгалзах хангалттай хүч байдаггүй. Тэднийг хориглож чадахгүйгээр барахгүй, өөрсдөө тэдний нөлөөнд автдаг. Учир нь тэдний хүч нь их, бидний хүч бага болохоор аялдан дагаж, тэдэнтэй адил хэргийг хийдэг. Энэ нь бас л үйл түйтгэрт тооцогдоно. Учир нь бид өөрсдийгөө хянаж, захирч чадаагүй, тиймээс бидний тархи “чи үүнийг сайнаар хийж чадаагүй” гэж хэлдэг. Та хэний нөлөөгөөр хийсэн нь хамаагүй, та хийсэн л бол энэ нь сайн биш. Хэдийгээр өөрийгөө жолоодож захирах аргагүй байсан ч, энэ нь үйл түйтгэрт тооцогдоно.

Үйл түйтгэр гэж юу вэ? Энэ нь бид хийх ёсгүй байсан зүйлээ хийсэн явдал юм, тэгээд бид үр дагаврыг нь амсах хэрэгтэй болно. Тухайн үйлийг үйлдсэн даруйдаа үр дагаврыг нь амсахгүй бол, нэг хэсэг хугацааны дараа амсана, эсвэл дараа жил нь ч юмуу, эсвэл дараа төрөлдөө амсана. Ингэж амсахдаа заавал хүний биеэр ирж амсдаг ч юм

биш. Жишээлбэл: хэн нэг хүн өөр нэг хүнд мөнгөний өртэй байгаад үхэх үедээ төлж барагдуулаагүй бол, үхсэнийхээ дараа дахин хүн болж төрөөд тэр хүнийхээ ажлыг хийж, өрөө барагдуулахгүй байж болно, харин түүний нохой юмуу, эсвэл морь, эсвэл үхэр нь болж төрөөд ажлыг нь хийж өгч байж өрөө төлөх бүрэн магадлалтай. Энэ нь маш эмгэнэлтэй хэрэг билээ.

Бидний тархинд бас мэдээлэл нэмэгддэг, нэг мэдээлэл нь гурав, дөрөв, эсвэл таван мэдээлэл болж хувиран хэмжээгээ нэмэгдүүлдэг, ингэж байгаа нь тархи бидний анхаарлын хүчийг чангаруулахын тулд юм. Ойлгож байна уу? Гэхдээ энэ нь тархи маань биднийг зориудаар зовоож байгаа, эсвэл үйл түйтгэрийг хүндрүүлж байгаа хэрэг биш, харин энэ бол түүний ажил нь л юм. Жишээлбэл: Нэг хүн цалин хөлсөө нэмэгдүүлэхийг хүсвэл энэ тухайгаа даргадаа өдөр бүр 2-3 удаа хэлэх болно. Дарга нь түүнийг сонсох үедээ дотроо дургүйцэж: “Энэ хүн яагаад нэг л зүйлээ өдөр бүр хэлээд байдаг юм бол? Тэр ганцхан зүйлийг ярьдаг ч түүнийгээ өдөр бүр л яриад байх юм” гэж бодно. Энэ нь яг л бид хэдийгээр ганц радио станц, эсвэл хэд хэдэн хүчирхэг станцтай бол нилээд олон улс орон радио нэвтрүүлгийг маань хүлээн авч чадахтай адил юм.

Бидний тархи ч үүнтэй адилхан, их олон зүйлийг бүтээн гаргадаг зуршилтай. Бид хэдийгээр өчүүхэн бага үйл түйтгэр бүтээсэн байтал түүний үйлийн үр нь харин маш их болчихдог. Учир нь тархи ялгаж салгаж чаддаггүй, бидэнд чухам юу муу болохыг ойлгодоггүй. Тэр нь яг компьютертэй адилхан өөрийнхөө зуршлын дагуу ажиллаж байдаг бөгөөд нэг зүйлийг сурчихсан бол түүнийгээ л хийсээр байдаг. Тиймээс албан байгууллага, компаниуд өөр өөр зориулалттай олон компьютертэй байдаг, учир нь компьютер бүр зөвхөн тухайн ажлыг хийхэд л зориулагдсан байдаг.

Энэ бүх компьютерыг ер нь бидний тархины чадамжийг дуурайлган хийсэн. Эрдэмтэд бидний тархи тийм уран нарийн болохыг хараад хүний тархийг дууриалгаж зохион бүтээхэд аажмаар суралцжээ. Гэвч одоо болтол бүрэн дүүрэн сурч чадаагүй, энэ нь тархины зөвхөн нэг хэсгийг л ашигласан төдийхөн хэрэг юм. Учир нь бидний тархи бол юунаас ч илүү маш нарийн гайхамшигтай “компьютер” билээ. Жишээлбэл: Бидний тархин дотор эс болон мэдрэлүүд байдаг. Хэрвээ тэдгээрийн нэг, хоёр эсвэл дөрөв, тав нь гэмтлээ гэхэд бидний тархи ямар ч асуудалгүйгээр ажилласаар байна. Тэр үед бидний толгой бага зэрэг будилж мэднэ, гэвч хэсэг хугацааны дараа зүгээр болно. Гэтэл компьютерийн нэг ширхэг нарийн утас нь гэмтвэл тэр компьютер тэр чигтээ эвдрэнэ. Тийм үү? үгүй юу ?

Тиймээс эрдэмтэд одоо болтол нэгэн бүрэн төгс компьютер бүтээх аргагүй тул сэтгэл ханамжгүй байдаг. Гэвч тэд бидний тархинаас маш олон зүйлийг судлан суралцаад улам сайжруулсаар байна. Хэдийгээр одоо компьютер хамаагүй сайжирсан ч, мөн л бидний тархинаас илүү сайн болгох аргагүй байна.



Та нар, “Энэ нь Арьяабалын номын цогцостой ямар хамаатай юм бэ?” гэж асууж мэднэ. Жаахан байж байгаад Багш нь үүнийг тайлж өгье. Заримдаа миний онгод ордог, энэ нь сонсогчдын байдлаас хамаардаг. Багш нь ном тайлахдаа өөрийн шаардлагад нийцүүлж ярьдаг юм биш, харин та нарт юу хэрэгтэй байгаагаас шалтгаалдаг. Хэрэв та нар, та нарын уураг тархи болон Арьяабалын бясалгалын хоорондын харилцаа холбооны талаар сонсохыг хүсвэл би тэр учрыг тайлж өгнө. Ном тайлах нь та нарт маш сонирхолтой санагдаж байвал, та нар сонирхолтой зүйлд дуртай учраас тэр юм. Хэрвээ та нар уйтгартай хэрэг явдалд дуртай бол Багш нь бас уйтгартай зүйлийг ярьж өгч болно. Тиймээс тайлсан номыг минь сонсууштай, сонсмооргүй гэж Багшийгаа буруутгасны хэрэггүй. Үүний учир нь бүгд та нартай холбоотой.

Компьютер нь бидний Арьяабалын номын цогцосыг бясалгаж байгаатай ямар холбоотой талаар одоо ярья. Компьютер дотор хадгалагдсан мэдээллийг устгаж арилгаж болно. Түүний нэг товчийг нь дарвал хадгалагдсан бүх мэдээлэл нь бүгдээрээ алга болчихдог. Санаандгүй ямар нэгэн товчийг буруу дарах юмуу, эсвэл цахилгааны ямар нэгэн утас нь гэмтвэл доторх мэдээлэл нь бүгдээрээ алдагдаж үгүй болно. Ямартаа ч бидний тархи толгой тийм хялбар биш билээ.

Биднийг нас барах үед бидний үйл түйтгэр мөн л оршоор байдаг, учир нь тэр дэндүү уран нарийн, тун ч нарийн. Үйл түйтгэр нь маш сэтгэгдэшгүй болохоор түүнийг угааж арилгахын тулд эрхбиш нэгэн сэтгэгдэшгүй хэлбэлзлийн хүчийг хэрэглэх хэрэгтэй. Жишээлбэл: Хоёр улс хоорондоо дайтаж байх үед нэг улсынх нь радио өдөр бүр “тэд сайн биш, бид хичнээн олон дайсныг устгалаа...” гэх мэдээг зарладаг. Нөгөө улс мэдээлэхдээ бас л адил зүйл ярьж, нөгөө этгээдээ муулж, мөн л дайсныхаа хичнээн олон цэргийг устгалаа гэнэ. Хоёр этгээд нэг нэгнийгээ их харгис хэрцгий гэж буруутгадаг. Тэдэнд нөгөө этгээдийнхээ цахилгаан долгионыг тусгайлан эвдэхэд зориулсан систем байдаг. Хэрвээ энэ улсынхан нөгөө улсынхаа мэдээг бидэнд сонсохыг хүсэхгүй бол шаржигнах чимээ гарган саад болсноор бид олж сонсож чадахгүй болно. Нөгөө улсын радио нь мөн л адилхан систем ашигладаг. Энэ улсын мэдээгээр, “хичнээн олон дайсан алагдаж, бид ялалт байгууллаа...” гэх зэргээр мэдээлэх үед нөгөө улс нь бас адил нэг системээр шаржигнах чимээ гаргаж саад болдог.

Үүнтэй адилаар маш олон хүн “Арьяабалын аргаар бясалгахад тархиа хов хоосон болгох ёстой юу?” хэмээн надаас асуухад нь би “Хов хоосон болгосны хэрэггүй” гэдэг, тэд мөн л “Бид өөрсдийн бодлоо хянан захирч, элдэв зүйл бодохгүй байлгах хэрэгтэй юу?” гэж асуух юм.

Хэрэв бидний тархи толгой элдвийг бодон будилах үед, бид түүнийг хянан захирахгүй байвал хамгийн сайн, тэр үед гагцхүү “шаржигнах” чимээ гаргаж, саад болдог системийг хэрэглэвэл болчихно. Миний санааг ойлгож байгаа биз? (бүгд инээлдэв) Учир нь тэр үед таны тархи юу хэлж байгааг та олж сонсохгүй болохоор хамааралгүй болчихно. Яг л тэр радиод саад болдог системтэй адилаар, хүчтэй хэлбэлзлийг

хэрэглэж байж л сая угаас байгаа тэр хэлбэлзлийн хүчийг хааж дийлнэ. Ойлгож байна уу?

Учир нь бид дуу гаргаж байгаа тэр газар нь очоод тэдний системийг эвдлэх чадахгүй. Тэнд ороход амаргүй, эвдлэхэд ч хялбар биш. Өнөөдөр эвдлэхийг гэхэд маргааш нь тэд бас өөр нэгийг гаргаад л ирнэ. Энэ нь өнөөдөр бодол санаагаа хянан захирч чадлаа ч маргааш бас өөр нэгэн бодол санаа орж ирэхтэй адил. Бид төрөл төрөлдөө маш олон мэдээллийг шингээж авснаас гадна, өдөр бүр маш олон мэдээлэл цуглуулж байдаг болохоор хэзээ тэр бүгдийг угааж арилгаж барах вэ? Тиймээс угаасны хэрэггүй. Зөвхөн шаржигнах чимээтэй дуугаар өдөр бүр хаагаад байвал болчихно. Арьяабалын бясалгал бол бидний гархинд шингэсэн үйл түйтгэрийн хэлбэлзлийн хүчинд саад болж чадах дээд зэргийн хэлбэлзлийн хүч мөн.

Багш чинь шинжлэх ухаанлаг аргаар тайлбарлавал та нар ойлгож, мэдэхэд хялбар байх. Хэрвээ нууцаас нууц, далдаас далд аргаар тайлбарлавал бүгдээрээ айна биз. Тийм ээ? (бүгдээрээ алга ташив) Одоо та нар юуны учраас Арьяабалын номын цогцосыг бясалгадаг вэ? Юуны учраас энэ Аялгуу үйл түйтгэрийг арилгаж чаддаг вэ? гэдгийг ойлгосон байх ёстой. Бидний үйл түйтгэр нь баригдашгүй бөгөөд бид түүнийг бичиж тэмдэглэн авч чадахгүй, тэр нь хаана байдаг, мөн хэзээ гарч ирэхийг нь ч мэдэхгүй. Тиймээс бид эвдлэгч системээр түүнийг эвдлэх ёстой. Түүнийг гарч ирэх бүрт нь эвдэх хэрэгтэй. Ингэвэл бид юу ч үгүй хоосон болно. (бүгдээрээ алга ташив).

Үүнийг бас нэг зүйлийн эвдлэгч номын цогцос гэж хэлж болно. Гэхдээ тэр нь тусгайлан үйл түйтгэрийг эвдэлж, үхэж, төрөх сансрын хүрдний үйлийн үрийг эвдэлж, тэдэнд оршин байх боломж олгохгүй байж, бидний тархийг юуг ч шингээж авч чадахгүй болгодог. Жишээлбэл: Өмнөх төрөлдөө үйлдсэн бидний муу хэрэг одоо гарч ирэх цаг нь болоод бидэнд сонсогдоход хүрвэл бидний сэтгэл их зовинож, өөрийн биеэ яллан залхааж эхлэх болно. Үүнийг бид Эзэн бурхан залхаан шийтгэж байна гэж хэлдэг. Үнэндээ бид өөрийн биеэ уучилж чадахгүй, өөрийгөө зовоож байгаа хэрэг билээ. Одоо энэхүү саад болдог дууны системийг хэрэглэдэг л юм бол тэр үйлийн үр сонсогдохгүй болж, өмнөх төрөлдөө юу хийснээ мэдэхгүй болно.

Бид юу хийхийг Оройн Дээд Бурхан ерөөсөө хамаардаггүй. Бурхан бодьсадва ч биднийг юу хийхийг ер хамаардаггүй. Тэд биднийг хэмжээлшгүй их хайрладаг гэдгийг л бид санах ёстой. Бидний тархи толгой л биднийг уучлахгүй, тэр зүйлсийг шингээж аваад бидэнд буцаан сонсогдог. Хэрвээ бид сайн үйл хийсэн бол тэр бидэнд “Бид очигдөр ийм нэгэн сайн үйл хийжээ” гэж сануулна. Хэрвээ муу үйл хэрэг үйлдвэл тэр бас бидэнд хэлж өгдөг. Тэр яг нэг даргын дуулгавартай туслах шиг, бүгдийг нь бичиж аваад маргааш нь бидэнд уншиж өгдөг. Багшийнхаа хэлж байгаа санааг ойлгож байна уу? Бид хэдийгээр завгүй байлаа ч хамаагүй, тэр даргын туслах бидэнд уншиж өгнө. Нэг төрлийн үнэхээр залхмаар даргын туслах байдгийг дарга бологчид бүгд мэднэ дээ,

тэрээр “Үүнийг та өнөөдөр уншиж өгөөрэй гэсэн болохоор би бичиж дуусгачихсан юм чинь, одоо заавал уншиж өгнө” гэж хэлэх болно.

Үүнтэй адилаар бидний тархи толгой бас өөрийгөө хянан захирах аргагүй байдаг. Тэр нь зөвхөн нэг зүйлийн машин төдий зүйл билээ. Хэрэв бид түүнийг ашиглаж чадвал нэг зүйлийн тун сайн багаж болно. Ашиглаж чадахгүй юмуу, эсвэл буруугаар хэрэглэвэл яг л атомын бөмбөг шиг аюултай. Атомын энергээр маш олон ач тустай хэргийг бүтээж, манай дэлхийг соёлжиж иргэншсэн болгож, маш олон хүнд тусалж, маш олон өвчнийг анагаан эдгээж чадна. Атомын энергийг нээснээс хойш маш олон зүйлийг бүтээн гаргажээ. Гэвч атомын энерги бас тун аюултай байдаг. Маш олон улс гүрэн атомын бөмбөг ашиглан дайтаж байдгийг та нар бүгд мэднэ. Сонсоод байхад одоо бүр хэцүү болжээ. Урд нь агаарын довтолгооноос хоргодох байр барих юмуу, эсвэл байшингийн суурийн хонгилд орж атомын бөмбөгийн дэлбэрэлтээс зайлж чадах байсан. Харин одоо тэгж чадахгүй, яаж далдалсан ч тэр аюулаас зайлж чадахгүй болсон. Та нар сонин уншвал мэдэж болно. Сонсоход, Герман улс нэгэн атомын бөмбөг бүтээсэн нь газар өрөмдөж ороод нууж далдалсан газрыг тань хайж олон тэгээд та нарын хамрыг шүргэмэгц дэлбэрэх ажээ. (бүгд инээлдэн, алга ташив) Тиймээс бидэнд улам аюултай болоод хаана нуугдаж далдлахаа ч мэдэхгүй болжээ. Саран дээр очиж бүр ч болохгүй. Учир нь атомын бөмбөг бас тэнд хүрч чадна. Тэгээд бас нэг дор хоёулаа очоод тэнд дэлбэрэх болно. Саран дээрх хүмүүс айгаад бүгд нүүгээд явчихаж ч мэднэ. Тэр үед бид амьдрах газаргүй болно. Тэгвэл бид яах билээ?

Миний бодлоор, зөвхөн Арьяабалын бясалгал л хамгийн зөв зам, хамгийн эцсийн зам мөн. Бидний Арьяабалын бясалгагч нар хожим юунаас ч айх хэрэггүй. Учир нь нэг зүйлийн сэтгэгдэшгүй хамгаалах хүч гэж үнэхээр байдаг бөгөөд энэ нь бидний өөрсдийн хүч юм, хэрэв бид түүнийг хэрэглэхгүй бол тун харамсалтай хэрэг болно. Та мөнгөтэй бол, өдөр бүр гарч гуйлга гуйхын оронд, түүнийгээ яагаад хэрэглэхгүй байх билээ? Яагаад ийм байна вэ? Хамгаалалтын хүч байсаар байтал яагаад хэрэглэхгүй байна вэ? Бид өдөр болгон зөвхөн айдастай байж, хаа сайгүй явж, бурханд мөргөдөг, хааяа бас чөтгөр сахиулсан, цагаан өвгөнд очиж мөргөдөг. Ингэх ямар хэрэгтэй юм бэ?

Бид өөрсдөө эзэн хаан байтлаа юунд нэгэн эрхэмсэг хаан шиг байхгүй, харин доорх хүмүүсээсээ өдөр бүр тусламж гуйж байдаг юм бэ? Энэ нь үнэхээр харамсмаар хэрэг. Бид өөрсдийгөө дэндүү дорд үзэж, өөрийн дэсээ доош татаж, өөрсдийгөө гутааж байна. Энэ бол бид өөрсдийн эрхэм дээд байр сууриа таньж мэдээгүйгээс болж байгаа хэрэг.

Багшийн чинь зааж сургаж буй энэ бясалгал нь шинжлэх ухаантай нийцэхээр барахгүй бас Бумбын сургаалтны Сүв бэлчирийн онолтой тохирдог. Хүний биед үлэмж олон чухал эмчилгээний цэг (сүв бэлчир) байдгийг та нар мэдэх үү? Зарим нь хүнийг эрүүлжүүлж, зарим нь хүнийг үхүүлж, бас зарим нь гэгээрүүлж чаддаг. Бумбын шашинд ингэж ярьдаг.

Эрдэмтэд харин, нэгэн хэлбэлзлийн хүчийг хэрэглэн бусад хэлбэлзлийн хүчийг эвдэж, тэдэнд саад болсноор, цааш хөгжихгүй болгож болох юм гэж ярьдаг. Шашны хэллэгээр бол, бид сэтгэгдэшгүй дээд дэсийн хүч чадлыг хэрэглэн бидний бузар бохир үйл түйтгэрийг угааж арилгана гэж байгаа юм. Энэ нь яг эмээр өөрсдийнхөө өвчнөө эмнэж, засаж байгаатай адил. Бидний бие махбод өвчлөх үед материаллаг эмээр эмнэн засна. Оюун ухаан эмзэг болох үед оюун ухааныг эмнэх эмээр засна. Сүнсэн бие өвчлөх үед Ариун Сүнслэг эмээр эмнэх хэрэгтэй. Ойлгож байна уу?, ийм л юм шүү дээ, тийм ч нууцлаг гайхалтай хэрэг биш.

Өнөөдрийн шинжлэх ухаан ихэд хөгжин дэвшсэн учир бид одоо нууц далд зүйл гэж дахин ярих аргагүй. Тодорхой болгохын тулд аливаа хэргийг шинжлэх ухаанаар тайлбарлавал зохино. Бурхны шашин маш шинжлэх ухаанч, Католик шашин ч бас шинжлэх ухаанч. Гагцхүү урьдын их бясалгагч нарын үг хэллэг одоогийнхтой адилгүй байсан төдий байдаг. Учир нь тэр үед шинжлэх ухаан гэж байгаагүй болохоор тэдэнд жишээ татаж тайлбарлах арга байсангүй, тайлбарласан ч хүмүүс ойлгохгүй. Одоо шинжлэх ухаантай болсон болохоор бид энэ аргыг хэрэглэж байна. Энэ нь цаг үеийн шаардлагад нийцнэ. Урьд нь шинжлэх ухаан байгаагүй болохоор, мэдээжээр, эш татах боломжгүй байсан.

Аливаа асуулт та нарт бүгдээрээ чухал гэж би бодож байна, учир нь та нарт бүгд л хамгийн чухал байдаг. Хэдийгээр зарим үед бясалгалын талаарх асуулт биш байдаг ч, та нарын асуултанд хариулсны дараа та нар бясалгахыг хүсдэг, учир нь тухайн үед асуусан тэр асуулт л та нарт хамгаас чухал байсан байдаг.

(Нэг хүн Багшаас “Ном уламжлах талаар Багш та тайлбарлаж өгнө үү?” гэж асуув.) Энд тайлбарлаж болохгүй. Ном уламжлах нь үг хэлээр ярьж болдоггүй бөгөөд чихээр бас сонсож сонорддоггүй, тиймээс би энд тайлбарлан ярихын аргагүй. Эртний хүмүүс ном уламжлахдаа үг хэлээр уламжилдаггүй байсан. Одоо Багш нь ном уламжилж байгаа биш, зөвхөн танилцуулж байгаа төдий юм. Ном уламжлах үед үг ярихгүй. Тэр нь нэг зүйлийн дүрс хэлбэргүй түлхүүр бөгөөд ном уламжлах үед та нар олж авна. Гэвч та нар түүнийг барьж авч чадахгүй, ойлгов уу?

Энд ийм хөгжөөн шуугиантай тул яаж уламжилж болох вэ? Хэдийгээр уламжилж байгаа зүйл байгаа боловч та нар ойлгож мэдэхгүй. Та нар нам тайван болох хэрэгтэй. Багш нь тодорхой тайлбарлаж өгнө, дараа нь та нар: “Аан, та ном уламжилж байгаа юм байна шүү” гэж мэднэ. Зөвхөн тэр үед л та нар олж авна. Одоо энд ийм хөгжөөн шуугиантай байхад Багш нь хэдийгээр ном уламжилсан ч, Багш юу уламжилж байгааг та нар мэдэхгүй бөгөөд ойлгохгүй. Үнэн хэрэгтээ уламжилж байгаа зүйл байгаа. Багшийнх нь хэлж байгаа үг бол зууны гучин хувийг л эзэлнэ, харин үлдсэн далан хувийг нь та нар хүртэж байгаа. Гэтэл та нар одоо дэндүү ихээр үймэлдэн шуугилдаж байгаа болохоор өөрсдөө ном хүртэж байгаагаа мэддэггүй. Тиймээс жинхэнээр ном уламжлах хэрэгтэй, тэгвэл сая та нар: “Багш надад ном уламжилж

байгаа юм байна, тэгээд одоо би бурхны Гэрлийг олж үзлээ, бурхны Аялгууг олж сонслоо, өөрийн уг чанараа, өөрийн уг дүрээ олж харлаа” гэж ярих болно.

Гэтэл одоо бас ном сонсож байгаа хүмүүсийн дунд байгаа зарим хүн нь олж үзсэн, зарим хүнд нь олж авсан юм бий. Тиймээс ном уламжлагүй гэж хэлж болохгүй. Та нарын дэс чинь дээгүүр биш болохоор олж аваагүйгээс биш, Багшийн чинь буруу биш. Ямар хүн ирж ном сонссон ч хамаагүй Багш нь адилхан л уламжилна. Тэгэхэд зарим хүн ном олж авснаа мэднэ, зарим хүн олж авсан юмгүй гэж бодно. Зарим хүн хөгжөөн наргиантай газарт олж авч чаддаг, гэвч ихэнх хүн эрхбиш нам тайван болсныхоо дараа сая олж авснаа мэддэг юм. Хөгжөөн наргиантай газарт нэг талаар ном сонсож, нөгөө талаар ном олж авч чадах хүн тун ховор шүү. Ойлгов уу?

Энд тийм хүн байна уу, гараа өргөөрэй. Ямар нэг зүйл олж авсан хүн байна уу? (нэг хүн гараа өргөв) Хойд талд нэг хүн байна, тэр хүн сүсэг барилдлагатай тул юм олж харжээ. Жишээлбэл, Багшийн биеэс гэрэл цацрахыг харах юмуу, эсвэл өөр ямар нэгэн мэдрэмж үүсэх мэт болдог хүмүүс байдаг. Гэвч ихэнх хүний хувьд нам тайван болоод зааврыг тодорхой сонссоныхоо дараа л сая ном олж авч чадна. Бид үүнийг жинхэнээр авшиг уламжлах гэж ярьдаг юм. Үнэндээ хэн ирж ном сонссон ч хамаагүй, Багш нь бүгдэд нь авшиг уламжилдаг. Гэвч дэс нь адилгүйгээс олж авсан нь бас адилгүй байдаг.

Зарим хүн “Багш надад юу ч уламжлагүй” гэж хэлдэг. Ийм байдал нь яг бяцхан хүүхдийг хурим найранд дагуулж очих үед, тэр хүүхэд цаг үргэлж унтаад сэрэхгүй, гэртээ эргэж ирсэн ч унтсаар байсан болохоор, дараа нь түүнээс: “Чи хаана очсон бэ, биднийг бүжиглэж байсныг харсан уу? Эсвэл ямар нэг хөгжим сонссон уу?” гэж асуувал тэр хүүхэд: “Үгүй ээ, та намайг хаашаа ч дагуулж очоогүй” гэж хэлэхтэй адил. Учир нь тэр хүүхэд үдшийн турш унтсаар байжээ.

Та нар Гурван улсын үлгэрийг (Romance of the Three Kingdoms) уншсан уу? Дайн хийж байх үед Лю Бэй-гийн хүү А Дөү-г нэг гавьяат сайд үүрч, нэг талаар байлдан нөгөө талаар А Дөү тайжийг хамгаалж, зам нээн гэрт нь аваачжээ. Гэрт нь хүргэх үед тэр гавьяат сайдын бие хүнд шарх олсон боловч харин А Дөү яагаа ч үгүй байжээ. Тэр сайд А Дөүг тэврэн “Авид бурхан” хэмээн залбирч байсан байлгүй дээ. Үгүй ээ, тэр үед тэрээр Авид Бурханыг дурсаагүй байх. (бүгдээрээ инээлдэв), тэрээр магад “Эзэн тэнгэрт талархъя” гэж хэлсэн байх. Учир нь А Дөү тайж өчүүхэн ч шархдаагүй болохоор тэр бурхан бодьсадва, эсвэл эзэн тэнгэрт ихэд талархсан биз. Тэр сайд А Дөүг Лю Бэйд буцааж өгөх үед Лю Бэй А Дөүг тосож авмагцаа газар шидчихсэнд олон хүн хирдхийн ихэд цочив. Тэгэхэд Лю Бэй А Дөүд: “Чиний төлөө би тулгуур төрийг минь байгуулалцсан нэг гавьяат сайдаа алдчих шахлаа” гэжээ.

Лю Бэй маш цэцэн сэргэлэн нэгэн. Тэр ингэж хэлсэн нь хүмүүс түүнийг хамгаалахын төлөө үхэхээс ч буцахгүй шударгаар зүтгүүлэхийн

төлөө байжээ. Учир нь түүнд хөвгүүн нь гавьяат сайд шиг нь чухал биш гэж тэд итгэх юм. А Дөү тэр үед дайн байлдаан болж байгааг мэдэхгүй байжээ, учир нь тэрээр бүр хамгийн аюултай үед ч унтсаар байсан бөгөөд хааны ордондоо хүрсний дараа мөн л унтсаар байсан билээ. Бид түүхийг нь уншвал мэдэж болно. Тэрээр өөрийн бүхий л амьдралын турш унтсаар, ямар ч сайн үйл хэрэг хийгээгүй аж. Үүнтэй адилаар энд байгаа зарим хүний дэс нь маш өндөр, тэд маш мэдрэмтгий учраас Багшийнхаа адислах хүчийг хүртэж, билиг ухаан нь нээгдэж чадна, харин зарим нь хүртэж чаддаггүй. Тийм хүмүүс, “Багш минь ээ, та бидэнд ном уламжилж болох уу?” гэж хэлэхээр би дахин нэг удаа ном уламжилдаг. Тэгсэн ч зарим хүн бас л юу ч олоогүй болохоороо гомдож эхэлнэ. Багш нь хүн бүхнийг баярлуулах аргагүй.

Энэ номыг үг хэлээр ярих боломжгүй. Багш нь үгээр хэлж өгөх их дуртай. Гэтэл үүнд “Ном гэхээр зүйл үгүй”, тэр нь “Дүрс үгүй” зүйл болохоор хэлчихмээр юм бас үгүй. Багш нь дуугүйгээр ном уламжлахаас биш хэлж ярихын аргагүй. Яагаад гэвэл энэ нь дотоодын зүйл болохоор “Сэтгэлийн авшиг уламжлах” гэдэг юм. Багшийнхаа санааг ойлгож байна уу? Их Багш нар бүгд л үгээр ном уламжилдаг биш, тэд таныг харах л юм бол билиг ухаан тань нээгдэх болно.

Та нар даяаны бүлэгтний арван үхэрчний зургийг (The Ten Oxherding Pictures) үзсэн үү? Нэгэнт туулан гэтэлсэн тэр хүн хэлсэн нь: “Би зөн билгийг зориуд хэрэглэж хүний насан хутгийг уртасгасангүй, гэвч зам дээр байгаа нэгэн суурь хувхай модыг олж үзэх үед тэр мод тэр дороо амилах юм. Би яргачин, дээрэмчинтэй найз болж чадна. Ямар ч хүн байсан хамаагүй би нэг л хармагц тэд тэр дороо билиг ухаан нь нээгдэнэ” гэсэн нь яг ийм санаатай. Хэрвээ та нар одоо ч Багшаараа үгээр ном уламжлуулах гэх юм бол тэр нь даанч гэнэн хэрэг болно доо. (Бүгдээрээ алга ташив)

**Асуулт:** Юуг бурхныг дурсаж, самадид орох гэдэг вэ?

**Их Багш:** Бид жинхэнээр бурхныг дурсаж, самадид орох үеийг бурхныг дурсах санмөи гэнэ. Санмөи “samadhi” гэж хэлдэг. Самадид орох гэсэн утгатай.

**Асуулт:** Авшиг хүртэх хүнээс ямар нөхцөл байдал шаардах вэ?

**Их Багш:** Ямар ч нөхцөл байхгүйг номыг маань уншвал, мэдэж болно. Зөвхөн хулгайлахгүй, архи уухгүй, худал хэлэхгүй, садар самуун явахгүй, амь хороохгүй л байвал болно. Амь хорооход: Өөрөө хороох, эсвэл хороохыг үзээд даган баясах гэсэн хоёр төрөл хэлбэр байдаг. Өөр хүн алсныг бид аваачиж идэх нь бас амь хороохыг үзээд даган баяссан хэрэг болдог, тэр үедээ бид дэндүү ихээр баярладаг болохоор тэр амьтдын зовлонтой байдлыг сэрж мэдрэхгүй байдаг. Энэ нь тэр чигээрээ та нарын буруу биш. Багш нь та нарыг зориудаар шүүмжилж байгаа юм биш, нийгмийн хүлээнээс мултрана гэдэг нь тийм ч амаргүй гэдгийг би мэднэ. Зарим үед бид өөрсдийн өндөр дээд байр сууриасаа болж бүр ч чанга хүлэгддэг. Тэр үедээ бид өдөр бүр бусдад залагдан хүндлэгддэг.



Хэрвээ бид “би ургамал хоолтон” гэж хэлбэл тэд элгээ хөштөл инээнэ. Тэгээд бас нэг хэсэг махыг маш сайхан хэрчиж, дээр нь амтлагч цацаж, сайхан үнэр амттай болгоод биднийг хууран мэхэлдэг. Хэрвээ тэд нэг хэсэг өмхий мах юмуу, цус нөж нь гоожсон махыг авчраад бидэнд идүүлэх гэвэл бид айгаад идэж чадах уу? Мэдээж, бид идэж зүрхлэхгүй. Хүмүүс бүгдээрээ биднийг хуурч, гэнэдүүлдэг юм, тэгээд л бид алдаа гаргадаг.

Хэрэв та нар үхрийн шарсан маханд дуртай бол үхрийн шарсан махыг яаж хийвэл амттай болохыг мэдэх үү? (бүгд мэдэхгүй гэж хариулав) Тэгвэл би та нарт хэлж өгье. Урьдаар хэд хоног юмуу, эсвэл хэдэн долоо хоног махыг нь илжрүүлээд бүр өнгө нь хувирч ногоорч харласан үедээ хамгийн амттай, хамгийн үнэтэй (олноороо инээлдэв) болдог. Мах худалддаг хүмүүс үүнийг бүгд мэднэ. Хэрвээ та нар итгэхгүй байвал тэднээс “хамгийн үнэтэй үхрийн шарсан мах гэдэг нь нэгмөсөн илжрээд өнгө нь бүр хувирсан мах биз дээ?” гэж асуу. Учир нь тэгж илжрүүлсэн мах хамгийн зөөлөн, чихэрлэг амттай болдог байна.

Хэрвээ тэр хэсэг нь нэлдээ илжирсэн байхад тэрийг нь огтолж хаяхгүйгээр танд авч ирж өгвөл та жигшээд лавтай идэхгүй дээ. Гэтэл хэрвээ үхрийн мах юмуу, үгүй бол гахайн махыг хуурч шараад гадна талыг нь сайн өнгөлөөд өгвөл та жигшихгүй болно. Энэ нь яг наймаачин хүн тахиа, нугасны бие дээр үнэрт эд түрхэж шарсныхаа дараа дахин улаанаар будаж өнгөлж гялалзуулаад гаднаа өлгөж худалдах үед эвгүйцэм байдал ер харагдахгүй, харин ч тахиа, нугас маш баяртай байх шиг, тэд өвдөж, зовж байгаа байдалгүй, харин ч хошуугаа том ангайлган инээх байдалтай байдагтай адил юм. (бүгдээрээ инээлдэв) Гахай ч мөн адилхан амаа ангайлгасан байгаа нь их л инээж баярласан юм шиг харагдана. Бас гүйлс цэцгээр түүнийг маш сайхан гоёж сахиулсныг тахиж, өргөлд өргөх үед гахай хамгийн үзэсгэлэнтэй, тун баяр баясгалантай байгаа юм шиг харагддаг.

## УЛАМБАНА БАЯРЫН УГ ГАРАЛ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Тайбэй хот, ШинДиең  
1987 оны 9 дүгээр сарын 6 (Эх нь хятад хэлээр)*

Та нар өөрсдийгөө бурхны шашинтан гэх юм. Тэгсэн атлаа Моломын үлгэрийг (Уламбанагийн түүхийг) яагаад мэддэггүй юм бэ? Зарим хүн Багшийг чинь гадаад номтон гэдэг. Гэтэл би Бурхны шашны талаар бурхны шашинтан нараас ч илүү мэддэг, тэгэхлээр үнэхээр сонирхолтой гадаад номтон байна даа. Хэрвээ зарим хүн Моломын үлгэрийг сонсох дургүй бол би өөр зүйлийн талаар ярьж болно. Жишээлбэл, Хималай уулын тухай байж болно. Та нар юу сонсох дуртай байна вэ? (бүгдээрээ Хималай уулын тухай гэж хариулав) Бурхны шашинтнууд байтлаа Моломын үлгэрийг сонсохыг хүсэхгүй, харин Хималай уулын тухай сонсох гэх юм, та нар надаас бүр ч илүү гадаад номтон байна даа! (бүгдээрээ инээлдэв) Аль ч шашин байсан Багшийн чинь хувьд бүгд нэгэн адил. Тэдгээр нь угаасаа нэгэн адил гэдгийг гэгээрснийхээ дараа та нар мэднэ. Гэхдээ бид бол бурхны шашинтан болохоор Бурхны шашны талаар илүү ихийг мэдвэл зохино, хүмүүс биднээс асуух үед л сая мэдэх гэх биш. Нэг шашны ёс суртахууныг ойлгож мэдвэл хүнийг гэтэлгэхэд хангалттай. Тийм их зүйлийг мэдэх гэсний ч хэрэггүй. Гагцхүү ёс суртахуунтай л байвал нэг, хоёр судрыг ойлгож байхад болчихно. Хэрвээ Арьяабалын аргаар бясалгаж чадвал хамгийн сайн.

Шагжамуни Бурхан амьд байх үед түүнд нэгэн Модгалъяана (Молом тойн) (Maudgalyayana) гэдэг их шавь байжээ. Тэр зургаан зөн билигтэй гэнэ. Зургаан зөн билиг гэдэг нь юу вэ гэвэл, эхнийх нь тэнгэрийн нүдтэй, тэр нь алс холыг, диваажин, тамын орныг ч харж чадна. Удаах нь тэнгэрийн чихтэй, тэрээр хэн юу ярьсан ч бүгдийг ойлгож, бүгдийг мэддэг бөгөөд диваажин, тамын орны байдлыг олж сонсдог. Тиймээс тэнгэрийн чихтэй гэдэг. Тэр мөн урьд өнгөрсөн төрлийг тольдон харж чадна. Жишээлбэл, урьд төрөл, урьд төрлийн амьдралыг харж чаддаг. Үүнээс гадна, тэр хаана ч саадгүй хүрч чадах бөгөөд бусдын бодол сэтгэлийг нэвт мэддэг. Аливаа нисванисаа бүрэн тасалсан. Гурван ертөнцийн үйлийн үрээс ангижирсан зэрэг чадвартай байжээ.

Нэгэн өдөр тэр тэнгэрийн нүдээрээ тамын орныг харсанд түүний эх нь нас барсныхаа хойно бирд болсон байхыг олж үзжээ. Бирд гэдэг нь юу вэ?, самгарьд хэлээр Preta (Прета) гэнэ. Бирдийн хэвлий маш том, хүзүү нь нарийхан, яг л зүү шиг нарийн, тэр юу ч идсэн цадаж ханадаггүй болохоор өдөр бүр ихэд өлсөж, их зовдог. Хүн тэднийг хооллоё гэж хичнээн оролдовч, тэд идэж чаддаггүй. Учир нь тэд ус хармагц цус болон хувилна, тэдэнд идээ үзүүлмэгц гал болон хувирч, идэж чадахгүй учир өлсгөлөнгийн зовлонг ихэд амсана гэж судар номд дүрслэн бичсэн байдаг.

Яагаад хүмүүс бирд болж хувирдаг вэ? Тэд амьд байх үедээ өглөг өгдөггүй, маш харамч, бусдад сайнгүй ханддаг, эцэг, эхдээ ачлалгүй бөгөөд тэднийг тэжээж тэтгэдэггүй, үр хүүхэддээ харгис муугаар хандаж, идэх юм хангалттай өгдөггүй, тэдэнд боловсрол олгодоггүй, үгүй бол тэдэнд шаардлагатай зүйлсийг нь өгдөггүй байсан, мөн бусдаас юмаа харамладаг, хэрвээ гуйлгачин юмуу, хэн нэг тусламж хэрэгтэй хүн ирвэл туслахгүй мөртлөө хөөж тууж, харааж занчих гэх мэтийн ааш арашинтай байсан хүмүүс бирд болдог юм. Энэ нь миний сонссон зүйл болохоос та нарыг айлгаж байгаа хэрэг биш шүү. Та нар тэдэнд өргөл өгөх, өгөхгүй байх нь хамаагүй. Энэ нь хувийн асуудал, хувь хүний эрх, ингэ, тэг гэж хэн ч та нарыг албадахгүй. Хүсвэл өгсөн ч болно, бас өгөхгүй байсан ч болно, мөнгө бол та нарын хувийн зүйл.

Модгальяана эхийгээ бирд болсныг хараад мэдээж, сэтгэл нь ихэд шимширсэн ч, эхийнхээ сэтгэлийг тайтгаруулахын тулд юу хийхээ мэдэхгүй байжээ. Тэр зөн билгээ хэрэглэн тамын оронд нисч очоод нэг аяга будаа болон тансаг үнэр амттай хоолыг аваачиж эхдээ өгч идүүлэх гэв. Эх нь идье гэж хүссэн боловч идэж чадсангүй. Хоол будаа нь тэр доороо гал болон хувирсан болохоор залгихад тун зовууртай байжээ. Тэрээр хоол олж идэж чадахгүйдээ их зовж байсан бол, харин одоо идэх үедээ бүр ч зовууртай болжээ. Одоо яадаг билээ? Модгальяана маш ихэд эмгэнэн гашуудаж, буцаж ирээд Бурхан багшид ярьсанд Бурхан багшид ямар ч арга байсангүй. Уг нь Бурхан их хүчтэй гэж бид сонсож байсан, тийм үү? Бурхан маш олон хүнийг аварч чадна, туулан гэтэлгэж чадна, гэтэл одоо яагаад ямар ч аргагүй болсон бэ? Яагаад гэдгийг та нар мэдэх үү? Бурхан багшид аврах арга гарцаагүй байгаа, гэхдээ түүнийг ганцаараа аварч чадахгүй. Энэ тухай жаахан байж байгаад Багш нь та нарт тайлж өгье.

Модгальяана бол Бурхан багшийн их шавь бөгөөд бас маш олон зөн билигтэй хүн. Тэр диваажинд нисэж хүрье гэвэл хүрдэг, тамын оронд очъё гэвэл очиж чаддаг их хүч чадалтай билээ. Бурхан багш ч цаглашгүй их хүч чадалтай, гэсэн ч түүний эхийг аврах аргагүй. Яагаад вэ гэвэл, түүний эх амьд байх цагтаа үйл түйтгэр маш ихтэй байжээ, тэрээр Гурван Эрдэнийг болон Модгальяаны багшийг муулан гүтгэсэн байна.

Гурван Эрдэнийг муулан гүтгэх гэдэг нь Их Багш хийгээд түүний номын сургаал ёс, мөн түүний хуврагуудын бүлэгт итгэхгүйг хэлнэ.

Үүнээс гадна Модгальяаны эх маш ховдог шунахай, тэр бурхныг тахиж, өргөл өргөхгүй мөртлөө муулан гүтгэдэг, тэгээд бас бусад муугаар ханддаг байж. Тамд унасныхаа дараа ч сэтгэл нь өөрчлөгдсөнгүй. Модгальяана зөн билгийн хүчээр хоол авч очин идүүлэх үед түүний харамч ховдог сэтгэл дахин илрэн гарсан бөгөөд өөр бусад бирд ирж идэхээс айгаад хоёр гараараа хоолоо бүтээн таглаж байжээ.

Модгальяаны эх тамд байхдаа хүртэл гэмшсэнгүй, бас Гурван Эрдэнийг хүндлэхгүй, харамч ховдог сэтгэлээ тасалж орхиж чадахгүй байсан болохоор, Модгальяана хичнээн их хүч гаргаж хүчлэн тусалсан ч тус болсонгүй. Хэлснийг минь ойлгож байна уу, зөвхөн ганц хүний хүчинд найдах нь хангалттай биш байна. Түүний дотоодыг нь өөрчлөх хэрэгтэй болохоос гадаад нөхцөл байдлыг нь өөрчлөх явдал биш.

Модгальяана хоол аваачиж идүүлэх гэхэд идэж чадахгүй болох үедээ тэр сая гэмшиж эхэлжээ. Модгальяана түүнд, “Та эндээ хүлээж бай, би буцаж очоод бурхнаас аврал гуйя, гагцхүү бурхны аврал баймааж нь сая таныг аварч чадна” гэж тайлбарлан хэлсэн ч байж магадгүй. Тэр үед эхийнх нь сэтгэл нь сая эргэж, бурхныг жаахан хүндэлж эхэлсэн ч байж мэднэ. Учир нь тэр үед түүнд тун гаслан зовууртай байсан хэрэг, хүү нь хоол авч ирсэн ч тэр идэж чадахгүй байжээ, тиймээс түүний сэтгэл өөрчлөгдөн тэр агшинд бурхныг хүндлэх болж, дотооддоо байгаа бурхнаас аврал эржээ. Яг тэр үед л бурхан сая хөндлөнгөөс оролцож, тусалж чадах юм. Тиймээс Модгальяана буцаж ирээд Бурхан багшаас аврал гуйх үед Бурхан багш “Хүлээж бай, би арга бодьё” гэж хэлжээ. Хэрвээ Модгальяаны эх гэмшээгүй, бурхнаас аврал гуйгаагүй бол бурхан түүнд тусалж чадахгүй билээ.

Ийм учраас Багш нь та нарт, “Та нар өөрөө өөртөө тусалж байгаа, харин Багш нь тусалж байгаа юм биш” гэж байнга хэлдэг. Учир нь хэрвээ та нар гуйхгүй бол Багш нь тусалж чадахгүй. Та нар номыг хүндлэхгүй бол би бас уламжилж чадахгүй. Та нар хэрвээ Багшдаа итгэхгүй бол Багш нь та нарт туслахын аргагүй. Үүний учрыг ойлгож байна уу?

Үүнтэй адил, бясалгал хийх нь өөрөө бясалгаж, өөрийн биеэ гэтэлгэж байгаа хэрэг юм. Хэдийгээр өөрөө бясалгаж, өөрийн биеэ гэтэлгэж байгаа боловч эрхбиш Төгс Гэгээрсэн Их Багш байх хэрэгтэй. Учир нь бид хэдийгээр бясалгахыг хүсэж байлаа ч хэрхэн яаж бясалгааа мэдэхгүй байдаг. Тиймээс бидэнд хэрхэн бясалгахыг зааж жолоодох Төгс Гэгээрсэн Их Багш байх хэрэгтэй. Гэхдээ бид бас өөрсдөө бясалгах дуртай байх хэрэгтэй. Бид ямар ч төвшинд байсан ч хамаагүй, бид аврагдах дуртай байвал болчихно, тэгэхгүй бол хэн ч биднийг аварч чадахгүй. Тиймээс Багш чинь үргэлж: “Та нарт төвөг учрах юмуу, эсвэл ямар нэгэн асуудал тохиолдох үед Багшаасаа гуйх хэрэгтэй, үгүй бол Багш чинь зөвхөн тэнд зогсоод хажуугаас чинь харахаас биш, хөндлөнгөөс оролцож чадахгүй” гэж хэлдэг. Жишээ нь, хэрвээ машины осол тохиолдох үед та гуйхгүй бол би бас туслахын аргагүй. Учир нь Багш нь бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцож болохгүй. Хөндлөнгөөс оролцож болохгүйдээ ч бас биш. Гэвч энэ орчлон ертөнцөд өөрийн гэсэн хууль дүрэм байдаг.

Миний хэлж байгааг ойлгож байгаа биз? Үүнээс гадна бурхан бодьсадва ерөөсөө хамаг төрөлтийг албаддаггүй, хамаг төрөлтийг өөрсдийнх нь аяар байлгадаг. Тэрээр хамаг төрөлтийг хүслээр нь байлгаж, тэднийг сайн дураар нь хийлгэхээс биш, өөрөө санаачлага гаргадаггүй, хамаг төрөлтийг албаддаггүй. Тэдэнд ямар нэгэн тэмдэг дохио үзүүлэх юмуу, эсвэл бясалгал хийлгэхээр албаддаггүй. Ёс суртахуунтай зүйлс хийлгэхээр хүмүүсийг албадах талаар бүр ярилтгүй. Учир нь хамаг төрөлтөн өөрийн хичээлээ өөрсдөө л сурах ёстой. Түүний цаг нь болоход бурхан бодьсадва хүлээж байгаад сая тусалдаг юм.

Хамаг төрөлтөн бүгдээрээ бурхан бодьсадва учраас Багш нь та нарт “Гэртээ харьсны дараа эцэг, эх, хань ижил тань авшиг хүртсэн ч, хүртээгүй ч тэдэндээ сайн байх ёстой” гэж байнга сургадаг. Учир нь тэд бүгд ирээдүйн бурхад бодьсадва мөн юм. Бид авшиг хүртэхээс өмнө тэдэнтэй л адилхан байсан, ялгаа юу байна? Авшиг хүртээгүй ч тэднийг муу хүн гэж хэлж болохгүй, энэ нь гагцхүү тэдний цаг нь болоогүй байгаа л хэрэг.

Тиймээс та нарын зарим нь гэртээ харьсны дараа эр нөхөртэйгээ таагүй харилцахад би их дургүй. Би тийм хүнийг зэмлэнэ, учир нь тэгж байгаа нь түүний билиг ухаан нээгдээгүй, харанхуй мунхаг байгааг нь харуулж байгаа юм. Билиг ухаан нээгдсэний дараа гэртээ харьвал хань ижил, эцэг эхдээ бүр илүү сайн хандах байтал Багшийнхаа сургаал ёсыг буруу ойлгосон хүмүүс л ийм байдалтай байдаг. Хэрвээ Багшийнхаа номлолыг ойлгосон бол гэртээ хариад эхнэр, нөхөртөө бүр ч сайнаар ханддаг юм. Учир нь тэд бол ирээдүйн бурхан бодьсадва болохоор биднээс ялгаа юу байх вэ? Тэд авшиг хүртдэг л юм бол адилхан болно, ойлгов уу? Түүнд өөрийнх нь эрдэнэсийн сан байгаа, тэр зөвхөн нээгээгүй байгаа төдий, тэр мөнгөө банкинд хадгалуулчихаад авч хэрэглээгүй байгаа хэрэг. Үнэндээ тэд бидэнтэй л адил. Бид Төгс Гэгээрсэн Их Багшаа эрж олоогүй, билиг ухаан нээгдээгүй байх үедээ бас л тэдэнтэй адилхан байсан, тэр үед биднийг муу хүн байсан гэж хэлж болохгүй. Иймээс тэд ургамал хоол идэхгүй байсан ч бид тэднийг албадан ургамал хоол идүүлэх учир юу вэ?

Ургамал хоол идсэнээр л бурхан болчихдог юм биш. Үхэр, заан, морь хэдийгээр бүх насаараа ургамал хоолтон байсан ч тэд бурхан болж чадахгүй. Тиймээс хүмүүсийг албадах хэрэггүй. Хэрэв тэр мах идэхийг хүсвэл, идэг. Тэр архи уух гэвэл, түүнд зориулан худалдаж ав. Гэвч түүнд “Би үүнийг муу гэдгийг мэднэ, чиний бие махбод хийгээд сүнсийг чинь харгалзан бодож, энэ бол хор гэдгийг хэлж байна. Гэвч та авна гэвэл би таны саналыг хүндэтгэнэ. Та бясалгах эсэх нь хамаагүй, та юу хийсэн ч таны дур, бясалгасан ч болно, бясалгахгүй байсан ч болно” гэж хэлэх хэрэгтэй. Бид өөрийнхөө саналыг бусдад албаар хүлээн зөвшөөрүүлж болохгүй, ойлгож байна уу? Бусад хүн биднийг мах ид гэж албадах үед бид дургүйцдэг, тийм байтлаа хүмүүсийг ургамал хоол ид гэж яаж албадах юм бэ? Энэ нь сайн, муугийн аль нь ч байсан албадаж байгаа хэрэг мөн, бусдыг албадаж байгаа л бол сайн хэрэг биш.

Бусдыг албадах нь тэмцэл маргааныг ихээр үүсгэж, гэр бүл дотроо эв зохиолгүй болж, бидний бясалгал ч бас амгалан тайван биш болно, хожим гэр бүлийн хүмүүсээсээ улам улмаар хөндийрч, “Та бясалгах тусмаа улам муу болсон, би таныг итгэхийн аргагүй болсон” гэж гэр бүлийн тань хүн хэлэх болно. Уг нь та түүнийг гэтэлгэх гэж бодож байтал харин түүнийг хорлосон явдал болох юм. Энэ нь бүгд бид бусдыг хүчилж албадсанаас болжээ. Бид уужим саруул сэтгэлгүй, бас тэдний хүслийг харгалзаагүйгээс ийм болжээ. Харин бид тэдний хүслийг харгалзвал хүмүүс юу ч хийсэн бидэнд хамаагүй. Бид эвтэй зөөлөн байж, түүнтэй ярилцах ёстой. Тэр бидний саналыг хүлээж авахгүй байх нь түүний эрх юм. Хүн бүхэнд бясалгах эсэхээ сонгох эрх байгаа. Бурхны шашин, эсвэл Каголик шашныг шүтэх эсэх нь тэдний эрх. Бид тэдний эрх мэдэлд халдаж болохгүй. Энэ санааг ойлгож байна уу? Үгүй бол бид бусад хүмүүсийн эрх чөлөөнд хөндлөнгөөс оролцсон хэрэг болно. Энэ нь болохгүй хэрэг, бид ингэж болохгүй.

Бурхан бодьсадва ч нэгэн адил юм. Бид тэдэнд гуйж даатгахгүй бол тэд бидэнд тусалж чадахгүй. Багшдаа гуйж даатгахгүй бол Багш нь та нарт тусалж чадахгүй. Ойлгов уу? Авшиг хүртэхийг Багшаасаа гуйхгүй бол Багш чинь албадаж болохгүй бөгөөд бас юу ч ярьж чадахгүй. Та нарын дураар л болог, надад хамаагүй. Дэлхий дээр өчнөөн их хүн байхад би алийг нь хамаарч дийлэх вэ, хамаарахад хүрвэл хэзээ гэтэлгэж барах вэ? Хэрвээ хамаг төрөлтнийг гэтэлгэж барж чадах байсан бол Бурхан Багш аль хэдийн гэтэлгээд дуусгачих байсан, Есүс Христ ч аль хэзээний гэтэлгээд дуусгачихсан, бид ном балрах цаг үед хамаг төрөлтнийг гэтэлгэхээр энд ирэх шаардлагагүй байсан. Ном балрах цаг үед хамаг төрөлтнийг гэтэлгэхэд тун бэрх. Шагжамуни Бурхан байх цагт шижир Алтан Эриний Зөв номтны цаг үе байсан мөртлөө тэр бас гэтэлгэж дуусаагүй юм чинь, одоогийн бид яахан гэтэлгэж барах вэ? Хоёр мянга гаруй жилийн өмнө Есүс Христ ирээд бас гэтэлгэж дуусаагүй юм чинь бид тэднийг хэрхэн гэтэлгэж барах вэ?

Тиймээс хамаарсны хэрэггүй. Хэрвээ хэн нэгэн хүн биднийг дагаж бясалгах гэвэл, мэдээж, бид түүнийг баярлан угтана, биднийг дагаж бясалгаагүй байсан ч нөхөрсөг сайхнаар хандаж, түүнийг дураар нь байлгах хэрэгтэй. Морин мэлхий бол морин мэлхийгээрээ л байдаг, чийгийн улаан хорхой мөн чийгийн улаан хорхойгоороо л байг. Бид чийгийн улаан хорхойг морин мэлхий болгож хувиргаж болохгүй, ингэвэл түүнийг гэмтээх болно. Хэрвээ чийгийн улаан хорхойг маш урт болгон татаж сунган могой болгох гэвэл тэр үхнэ. Учрыг нь ойлгож байна уу? Энэ орчлон ертөнцийн түмэн бодис өөрийн гэсэн эрх мэдэлтэй тул тэднийг дураар нь байлгахаас биш бид албадаж хүчилж болохгүй.

Үүнтэй адилаар, Модгальяана тийм сайн бясалгасан байтал түүний эх нь яагаад тамд унасан бэ? Учир нь тэр хоёрын бодол гэтэл нь адилгүй, бас дэс нь ч адилгүй юм. Нэг нь бурхнаас туулан сэтгэл авралыг эрнэ, харин нөгөө нь туулан гэтлэхгүй, ертөнцийн эд зүйлсэд шунаад салахгүй тул ангижирч гэтлэж чадахгүй. Нэгэнт түүний эх нь



энэ замыг сонгосон болохоор бурхан бодьсадва түүнийг тэр замаар нь явуулбал зохино, харин Модгальяана туулан гэтлэх замыг сонгосон учир бурхан бодьсадва түүнийг дээш авч гарчээ.

Одоо Модгальяаны учрыг ярья. Тэр буцаж ирээд Бурхан багшид айлтгах үед Бурхан багш: “Түүнийг гэтэлгэхэд тун бэрх, учир нь эхийн чинь үйл түйтгэр маш хүнд, тэр ч байтугай түүний далд ухамсар нь хараахан өөрчлөгдөөгүй байна. Тэр ерөөсөө бурханд итгэдэггүй, бурхныг гүтгэдэг тул одоогоор түүнийг гэтэлгэхийн аргагүй” гэжээ. Жишээлбэл, тэнд гэрэл байхад та буруу харж зогсвол мэдээж тэр гэрлийг олж харахгүй, хэрэв та эргэж харвал тэр даруйдаа гэрэл олж харна.

Шагжамуни Бурханд ерэн есөн хүний амийг хороосон нэгэн шавь байсан гэдгийг бид цөм мэднэ. Тэр хэдийгээр ерэн есөн хүний амийг хөнөөсөн хэдий ч Шагжамуни Бурхан түүнийг гэтэлгэж чадсан бөгөөд архад болгосон. Модгалаяаны эхийн үйл түйтгэр нь яагаад хүн хөнөөсөн тэр хүнийхээс ч хүнд болсон юм бэ? Та нар мэдэх үү? (мэдэхгүй гэж бүгдээрээ хариулав) Энэ нь бидний ухамсар болон сэтгэлтэй холбоотой гэж би саяхан ярьсан, “Сэтгэл” эргэх үед аливаа үйл түйтгэр арилчихдаг юм.

Тиймээс Багш нь “Авшиг хүртсэний дараа таван үеэрээ төрөл дээшилнэ, бид тэдэнтэй холбоотой болохоор, бид туулан гэтэлсний дараа тэд аяндаа төрөл нь дээшилнэ” гэж хэлдэг. Үүнээс гадна та нарын төрөл төрлийн үйл түйтгэр цөм үгүй болно. Яагаад гэвэл, ухамсар агшин зуур өөрчлөгдөн солигдох юм бол аливаа юм бүхнийг угаан арилгаж чаддаг. Энэ нь яг дууны хуурцагтай адил хичнээн хоногоор бичиж шингээсэн маш олон зүйлийг устгая гэвэл товчийг нь дармагц бүгд арилна. Тийм биз дээ?

Шагжамуни Бурхан яагаад Модгальяаны эхийг аварч чадахгүй байсан бэ? Түүний эхийн үйл түйтгэр нь хэтэрхий ноцтой хүнд бөгөөд өөрөө бас үүнийгээ засах дургүй байжээ. Гэвч тамын оронд үйлээ үзэхийн үед тэр бага зэрэг засарсан байна. Тэр агшинд тэрээр Бурхан багшийн тусламжийг гуйсан ч байж мэднэ. Тиймээс тэр үед Бурхан багш сая “За болжээ, би дахин завшаан тохиолыг үзэж байгаад чамд тусалъя” гэжээ.

Шагжамуни Бурхан Модгальяанад юу хийхийг захисан бэ? Тэрээр: “Чи ганцаараа хүч хүрэлцэхгүй, арван зүгийн хуврагууд нэг дороо цугларч, зуны оршилд суухыг хүлээж байгаад долоодугаар сарын арван тавны өдөр тэдэнд өглөг тахилга өргөж, аврал гуй” гэжээ.

Хуврагууд гэдэг нь бясалгал хийдэг хүмүүсийг хэлж байна. Судар номд, “хуврагууд гэдэг нь даруй бурхад бодьсадва, архад, гэлэн, гэлэнмаа зэрэг болно” гэж Шагжамуни Бурхан ярьсан байна. Бурхан бодьсадва гэдэг нь зөвхөн гэлэн, гэлэнмаа байдаг биш, гэрээс гараагүй шавь нар ч бас бодьсадва байж магад. Та нар Багшийгаа дагаж бясалгаж байгаа бол бодьсадва мөн. Учир нь та нарт ч бодьсадвагийн ахуй ойлголт байгаа. Тийм биш үү? Архадын ахуй ойлголт ч та нарт бас бий. Тиймээс энэ нь

нэг төрлийн бодьсадва, архад юм.

Бурхан бодьсадва гэдэг нь ямар утгатайг Багш нь өнөөдөр та нарт ярих болно. Бурхан бодьсадва гэдэг нь дотоодын хувиралт болохоос биш, гадна талынхыг зааж байгаа биш, ойлгов уу? Хэрвээ тэр одоо Шагжамуни Бурхан, эсвэл Арьяабал бурхантай адилхан хувцас өмсвөл, бодьсадва болчихдог, учир нь бид тийм гадна төрх байдалд илүү дасчихсан болохоор хэрвээ тэр жийнсэн өмд юмуу, эсвэл биеийн тамирын өмд өмсвөл их бодьсадва шиг харагддаггүй. Тийм биз дээ? Үнэндээ тэд юу өмссөн нь ер хамаагүй, бүгдээрээ бодьсадва юм. Бодьсадва энгийн хүнтэй адилхан харагддаг, ялгаа нь тэд дотоодын хувиралт, далд чанарын хувиралт, сүнсний хувиралт, дэсийн хувиралтад орж, аль хэдийнээ билиг ухаан нь нээгдчихсэн байдаг.

Тэр үед Бурхан багш Модгалъяанад: “Чи яваад бурхад бодьсадва хийгээд хувагуудад тахил өргөвөл зохино. Учир нь тэд энгийн эгэл хүмүүс биш, тэд нилээд онцгой, зуны оршилд суусны дараа тэдний ач буян асар их болно” гэжээ.

Зуны оршил гэдэг нь юу вэ гэвэл зуны улирлын гурван сард олноороо нийлж бясалгал хийж, тэд багшаасаа, эсвэл бясалгалаар өндөр дээд хүнээс гүн номлолыг илүүхэн олж суралцан туршлага солилцохыг хэлж байна. “Суралцах гэдэг нь” зөвхөн ном, судар уншихыг хэлж байгаа биш, дотооддоо суралцана гэсэн үг. Бясалгал хийх үед ахуй ойлголттой, хүслэнт ахуйтай болдог. Ойлгож байна уу? Тэд тэгж суралцахдаа ахуй ойлголтоо харилцан солилцож, багшаасаа “Энэ ямар учиртай вэ? Би ийм байгаа нь дэвшиж байна уу, эсвэл ухарч байна уу? Надад ийм хүслэнт ахуй илэрч байгаа нь ямар дэсэд хүрснийг төлөөлж байна вэ?” гэх мэтчилэн “суралцах” болно.

Үүнээс гадна бас гэмшин наманчлах сэтгэл байх хэрэгтэй. Гурван сарын хугацаанд чин сэтгэлээсээ гэмшин наманчилж, хичээнгүйгээр бясалгаж, бие, хэл, сэтгэл цөм цэвэр ариун байх хэрэгтэй. Маш яаралтай чухал хэрэг учир гарахаас бусдаар, гаднах үймээн түйвээнээс зайлахын тулд чадахын хэрээр гадагш гарахгүй байдаг, хэрвээ гарахад хүрвэл түргэн буцаж ирэхээс биш кофе, сүү уухаар явдаг биш, караокед дуулахаар очих зэрэг явдал байдаггүй. Энэ нь яг л долоо хоногийн даяантай адилхан, долоо хоногийн даяан, эсвэл долоо хоног бурхныг дурсах үеэр бүгдээрээ цугларч, чин сэтгэлээр бясалгаж, бурхан, ном, хувраг, бясалгалын тухайд сэтгэлээ төвлөрүүлэн бодож, эгэл ертөнцийн элдэв зүйлийн хэрэг учрыг бодохгүй байдаг. Үүнийг битүүмжлэн суух гэдэг.

Зуны оршил гэдэг нь зун нэгэн газарт цугларан амирлан сууж, ном тайлахаар явахгүй, бадарлахаар хаашаа ч явахгүй, нам тайван байхыг хэлж зааж байна. Яагаад ингэдэг вэ? Учир нь Энэтхэгийн зун нь бороо ус ихтэй, Тайвань ч адил, зундаа бороо ус ихтэй, хар салхи салхилдаг. Зуны цагт шавь нар нь жижигхэн аягаа бариад бадарлаж явах нь гашуун зовлонтой байдгийг Шагжамуни Бурхан олж үзээд олноороо нийлэн

бусдын өргөл барьцыг хүртэж болно гэжээ. Нөгөө талаар зун хорхой шавьж маш элбэг, хэрвээ хол замд явбал тэдгээр амьтныг гишгэж, алж мэдэх тул зуны оршлыг шавь нартаа тогтоож өгчээ.

Үүнээс гадна, хэрвээ олноороо нийлж гурван сар бясалгавал эрдэм чадал үлэмж нэмэгдэн бүтэн жилээр хамаг төрөлтийг гэтэлгэж чадна. Энэ нь яг та нар ажлын өдрүүдэд их ажиллаад амралтаа авсан үедээ хэмнэсэн мөнгөө зарцуулж хэрэглэдэгтэй адил. Тийм биз дээ? Тэр үед ажиллахгүй байсан ч зарж үрэх мөнгөтэй байдаг. Тиймээс гурван сар цугларан зуны оршилд суудгийн зорилго нь эрдэм чадал, ач буянаа арвиан хэмнэсний дараа хэрэглэж болох учиртайд байдаг. Бид зуны оршлоор нилээд удаан суусан болохоор хэмнэсэн бясалгалын ач буянаа жаахан хэрэглэж болно. Тиймээс л та нарыг энд ирүүлсэн юм.

Нэг зүйлийн бэлгийг бид харж болдог. Жишээлбэл, би чамд ном бэлэглэвэл чи лавтай олж харна. Нэг гүйлс цэцэг бэлэглэвэл чи бас барьж болох бөгөөд үнэртэж чадна. Гэтэл чамд ач буян өгвөл чи түүнийг олж хархгүй, тийм биз? Зарим үед сэрж мэдэрч болно. Жишээ нь: Зарим хүн Багштайгаа уулзсаны дараа өвчин нь эдгэрдэг. Үүнийг зөвхөн та нарт ярьж байгаа юм, олонд дэндүү ихээр зарлах хэрэггүй. Миний хэлж байгаа санаа бол, бид хэдийгээр ач буяныг үзэж харж чадахгүй боловч тэр нь бидний бие махбод, оюун санаанд нөлөөлж чадна. Зарим хүн бурхан бодьсадваг олж үзмэгц билиг ухаан нь нээгддэг. Зарим хүн Их Багшийг олж хармагц билиг нь ухаан нь нээгддэг. Энэ нь Их Багш нарт үзэгдэж, харагдашгүй эрдэм, дүрс хэлбэргүй хүч чадал байдгаас болж байгаа юм. Ойлгож байна уу? Тиймээс бид материаллаг зүйлсэд бүрмөсөн найдаж болохгүй.

Бидэнд харагдаж байгаа юмс л оршиж байдаг бус, харагддаггүй зүйлс ч бас оршиж байдаг. Одоо бидний мэдэж байгаагаар болон эрдэмтдийн нотолсноор орчлонд дүрс хэлбэргүй ертөнц байна. Энэ нь мухар сүсэг биш. Хэлбэр дүрсгүй чөтгөрийн талаар ярилгүй, харин нянгийн талаар жишээлж ярья. Бид түүнийг нүдээрээ олж харж чадахгүй, харин микроскопоор харж чадна. Энэ санааг ойлгож байна уу? Тиймээс бидэнд үзэгдэж харагдахгүй юм бүхнийг оршдоггүй гэж хэлж болохгүй.

Та нарт илэн далангүй хэлэхэд, үзэгдэж харагдаж байгаа юмс нь харин хамгийн бүдүүн тойм, хамгийн хэрэгцээгүй зүйл байдаг юм шүү. Нүдэнд үзэгдэхгүй олон жижиг бичил юм нь хамгийн их хүч чадалтай. Чулууг үзэхэд хүнд атлаа хатуу байдаг, гэтэл ус түүнийг өдөр бүр элээсээр бүр байхгүй болгочихдог. Тийм биз дээ?

“Салхи” бидэнд хэдийгээр харагддаггүй ч, харин ус, бүдүүн мод, чулуу гэх мэтийн том хатуу зүйлийг цөмийг нь хийсгэдэг. Тайваньд хар салхи ихтэй тул салхины энэ их хүч чадлыг эндхийн хүн бүр мэдэх ёстой. Салхинд хэлбэр дүрс байна уу, гарт баригдах уу? Түүнийг цүнхэндээ хийж чадах уу? Банкинд аваачиж хадгалаад ирэх жил хэрэглэж чадах уу? Чадахгүй! Гэхдээ тэр олон төрлийн ажил хийж чадна. Хэрвээ бид хичээхгүй юм бол энэ зусланг ч үлээн хийсгэж мэднэ. Тийм биз?

Тиймээс дүрс үгүй юм нь дүрстэй юмнаасаа хэцүү, бүр ч илүү хүч чадалтай байдаг.

Үүнтэй адилаар бясалгахын ач буян нь сэтгэгдэшгүй, тиймээс эртнээс нааш бясалгагч нарыг маш их хүндэтгэдэг билээ. Учир нь тэдний бясалгалын хүч болон эрдэм чадал нь ямар вэ гэдгийг бид мэднэ. Урьд нэг улсад маш харгис догшин хаан байж гэнэ. Тэр Бурханы шашинд ороод сайн хүн болж хувирчээ. Тэр хаан ач тусыг нь хүртсэн болохоор Бурхны шашныг ихэд хүндэтгэдэг байж. Бурхны шашин гэдэг нь зөвхөн ном судар уншихын төдий зүйл биш, мэдээж, түүнд ном уламжилж өгснөөр, тэр хаан бясалгаж суудаг, бас өөрийн дэсээ мэдэж, дээд хүслэнт ахуйд очиж, бурхан бодьсадваг хардаг байжээ. Тиймээс тэрээр маш их талархалтай байж, гадагш гарах бүртээ лам хувраг харагдмагц тэргэнээсээ бууж наманчлан ёсолдог байжээ. Энэ байдлыг түүний тэргүүн шадар түшмэл хараад сэтгэл нь ихэд зовж: “Эрхэм хүндэт хаан минь ээ, та бол улсын хамгийн дээд эрх мэдэлтэн билээ. Тэд ямар ч байлаа гэсэн зөвхөн таны ард иргэд, бадарын аяга барьсан гуйранчид төдий юм шүү. (бүгдээрээ инээлдэв) Гэтэл та тэднийг харах бүртээ яагаад алга хавсран бөхөлздөг юм бэ? Үүнийг хараад миний сэтгэл зовоод болохгүй байна шүү” гэжээ. Тэр үед хаан юу ч хэлсэнгүй, харьж оджээ. Ордондоо ирсний дараа тэр хаан дээд түшмэлдээ: “Та нар надад тусалж юм худалдахтун, би амьтдын толгой болон хүний толгойг худалдана” гэхэд, дээд түшмэл нь, “За болно, асуудалгүй” гэжээ. Хаан юм худалдуулахаар дээд түшмэл сайдуудаа явуулахдаа нэгийг нь гахайн толгой, өөр нэгийг нь үхрийн толгой, нөгөөг нь тахиан толгой, бас өөр нэгийг нь туулайн толгой гэх зэргийг худалд хэмээн илгээв. Харин хааныг хуврагуудад наманчлан ёслохыг хориглосон шадар түшмэлийг нэгэн ялтны толгойг худалдуулахаар илгээжээ.

Үхрийн толгой, загасны толгой гэх мэт амьтны толгойг бүгдийг нь худалдаж дууссан ч хүний толгойг худалдаж авах хүн байхгүй болохоор хаанд буцаан авчирч өгөв. Хаан түшмэлээсээ: “Та яагаад хүний толгойг худалдаж чадсангүй вэ?” гэж асуухад шадар түшмэл нь: “Хүний толгой ямар ч хэрэггүй тул авах хүн алга, үхрийн толгой, гахайн толгойг идэж болно, тэр ч байтугай засал чимэглэлийн зүйл хийвэл маш үзэсгэлэнтэй сайхан, гахайн хялгасаар сам хийж болно, гахайн толгойг хүнд өгч идүүлж болно, тахианы толгойг чанаж шөл гаргаж болно. (бүгдээрээ инээлдэв) Тиймээс тэр амьтдын толгойг цөмийг нь худалджээ. Гэтэл хүний толгой хэрэггүй, ямар ч хэрэггүй аж” гэжээ. Хаан: “Хүн бүрийн толгой хэрэггүй юмуу, эсвэл ганц тэр хүний толгой хэрэггүй байв уу?” гэсэнд шадар түшмэл: “Хүн бүхний толгой хэрэггүй, ямар ч үнэ цэнэгүй.” гэжээ. Хаан: “Тэгвэл миний толгой бас адилхан уу?” гэхэд шадар түшмэл айгаад дуугарсангүй. (бүгдээрээ инээлдэв) Хааныг асуугаад салахгүй болохоор нь тэр шадар түшмэл аргагүйд хүрч эцэстээ зөвшөөрөн: “Тийм, хаан таны толгой ч гэсэн ямар ч үнэ цэнэгүй, өршөөнө үү!” гэжээ.

Тэр үед хаан: “Та одоо ойлгосон байх аа. Би энэ үнэ цэнэгүй

зүйлээр ач буянтай хүнд ёслоход юу нь муу байх вэ? Энэ толгой угаас үнэ цэнэгүй атал та түүнийг хайрлаж хамгаалаад яах гэсэн юм? Та тэр гэрээс гарсан хүмүүсийн зөвхөн гадна талыг нь харсан төдий байна. Тэднийг харахад тун ядуу, мөнгөгүй, гуталгүй, эсвэл бие нь ядруухан, та тэдний аяга барьж бадарлаж байгаа гадна байдлыг нь л харсан төдий, тэдэнд харин цаглашгүй эрдэм байхыг нь олж хараагүй байна, тэдний хэн болохыг мэдсэнгүй. Тэдний сүр жавхлан, тэдний хүч чадлыг олж мэдээгүй болохоор та намайг саатуулж, тэдэнд наманчлан ёслохыг минь хориглож байгаа юм. Үүнээс хойш ингэж болохгүй” гэжээ. Тэр үед л тэргүүн шадар түшмэл учир ёсыг бага сага ойлгосон байна.

Бясалгахын хүч чадлыг юугаар ч хэмжиж чадахгүй бөгөөд өнгөн талаас нь олж харахын аргагүй юм. Гуан Чин (Guang Qin) өвгөн хуврагийг бид бүгдээрээ мэддэг. Тэр их нэр алдартай боловч жижигхэн туранхай биетэй, алхаж гишгэх нь тун хурдан шаламгай, түүнд сүр жавхлантай гэмээр юм үгүй байсан. Тийм биз дээ? Сүр жавхлантай бурхан гэдэг нь өндөр, том бөгөөд тарган, алхаж гишгэх нь улсын хаантай адил байх ёстой гэж ихэнх хүн боддог. Гэтэл тийм биш юм, миний бодоход Гуан Чин өвгөн хуврагийн алхаж гишгэх нь их хөөрхөн, яг бяцхан хүүхэд гэмээр байсан. Бясалгагч хүн бяцхан хүүхэд шиг хөөрхөн байвал зохино. Тэд өчүүхэн төдий омгорхог зангүй, юу хийсэн ч аяндаа хийх бөгөөд ариун цайлган, зориудаар хуурмаг авирладаггүй юм. Тиймээс бид хүний байдлыг харахдаа түүний гадна талыг нь харах биш, харин түүний бясалгалыг харах ёстой. Ойлгож байна уу?

Шагжамуни Бурхан дотоодын бясалгалтай хүмүүсээс тусламж гуйгаарай гэж Модгальянад хэлжээ. Таван төрлийн амтат жимс, тансаг идээ, эсвэл хувцас хунар, өдөр тутмын хэрэглээний эд зүйлс, жижигхэн дүүжин ор авч оч гэжээ. Урьд цагт Энэтхэг хүмүүс гадагшаа гарахдаа цөмөөрөө нэгэн жижигхэн дүүжин ор авч явдаг, үдэш орой түүнийгээ модонд өлгөөд унтдаг байжээ. Хуврагууд ч мөн тэгдэг байв. Одоо ч энэ нь хэвээрээ байгаа. Өргөлийн зүйлсийг тэдэнд хүрэлцэхүйц аваачиж өгөөд хамтын хүчээр хавсран туслаач гэж гуйвал Модгальяаны эхийг аварч чадна хэмээжээ.

Модгальяаны эх нь ганцхан хүн байтал яагаад тийм олон хүний хүчийг ашиглаж байж л сая түүнийг аварч чадах вэ? Яагаад таван үеэрээ төрөл дэвшсэнгүй вэ? Үнэндээ чухамдаа таван үеэрээ төрөл дэвшиж болох байсан. Гэтэл түүний эх нь ганцаараа төрөл дэвшиж чадсангүй. Учир нь түүний үйл түйтгэр нь маш хүнд бөгөөд тэр өөрийн ухамсраа өөрчлөх дургүй байж. Багшийнхаа санааг ойлгож байна уу?

Таван үеэрээ төрөл дэвших гэдэг нь хүн бүхэн бүгд төрөл дэвших биш юм, энэ таван үеийн дотроос зууны наян хувь нь л төрөл дэвшиж, Модгальяаны эхийн байдалтай адил ганц хоёр хүн үлдэж мэднэ. Хэрвээ Шагжамуни Бурхан Багшийн чинь адилаар “таван үеэрээ төрөл дэвшинэ” гэж хэлээгүй гэх юм бол, Модгальяана яагаад эцгээ хайж олоогүй юм бэ? Яагаад авгаа эрж олоогүй, эсвэл үеэлээ ч юмуу, үгүй бол эмэг эх, өвгө эцгээ олоогүй юм бэ? Яагаад тэднийг эрж олоогүй мөртлөө

ганцхан эхийгээ л хайж олсон хэрэг вэ? Энэ нь юуг илтгэж байна вэ? Ганцхан түүний эх нь л үлдэж хоцорсныг илтгэж байна. Учир нь эх нь тун зөрүүд, үйл түйтгэр нь хэтэрхий хүнд, бодол сэтгэлээ өөрчлөх дургүйгээс тэр тамд ганцаар үлдэж, өөр бусад таван үеийнхэн нь цөм төрөл дэвшчихсэн байна.

Шагжамуни Бурхан таван үеэрээ төрөл дэвших талаар яриагүй гэж та нар бодож болохгүй. Тэр таван үеэрээ төрөл дэвшихийг хэлснээр барахгүй, есөн үеэрээ төрөл дэвшихийг ч ярьж, “Нэг хүн Мөрийг олбол есөн угсаагаараа тэнгэрт мэндэлнэ” гэсэн билээ. Тиймээс Багшийнхаа номлолыг Шагжамуни Бурхныхтай адил гэдгийг бид таньж мэдэх ёстой. Хэрвээ таван үеэрээ төрөл дэвшээгүй бол Модгалъяана өөрийнхөө авга ах, эмэг эх, өвгө эцэг, нагац эгчээ эрж олох байсан. Ойлгож байна уу? Яагаад тэр хүмүүсийг хайж ололгүй, ганцхан эхийгээ л олсон бэ? Учир нь түүний эхийн үйл түйтгэр маш хүнд болохоор хуврагууд бүгдээрээ нийлж байгаад зуны оршлын эрдэм чадал бүхнээ цөм түүнд өгч байж л, ганцхан түүнийг аварч дийлэх юм. Тэгээд бас түүний сэтгэл нь эргэсэн тул түүнийг аварч чадах болжээ. Хэрвээ түүний сэтгэл нь эргээгүй бол түүнийг аврах боломжгүй байх байсан, бурхан байгаад ч түүнийг аврах аргагүй, буй бүхий хувраг бүгдээрээ цөм хүч чадлаа түүнд өгсөн ч хэрэгцээгүй байх байсан. Хүний бодол сэтгэлийн хүч маш их байдаг учраас “аливаа бүхэн цөм сэтгэлээр бүтдэг” гэдэг билээ.

Хэрвээ бид сэтгэлээ өөрчилбөл дэлхий бүхэлдээ өөрчлөгдөнө. Хэрвээ бид сэтгэлээ өөрчлөхгүй юм бол, гаднах нийгмийн байдлыг өөрчлөх, өглөг өгөх зэргээр юу ч хийсэн ямар ч тус нэмэргүй байх болно. Тиймээс сэтгэл маш чухал, сэтгэлийн хүч чадал тун их, диваажинг бүтээж чадна, тамын орныг ч эвдэж чадна. Аливаа зүйл энэ сэтгэлд л зориулагдсан.

Энэ сэтгэл гэдэг нь зүрхийг хэлж зааж байгаа биш, харин бидний үзэл санаа, бидний далд ухамсар, бидний үзэл бодол, бидний итгэл зориг, дотоодын хүсэл эрмэлзэл, дотоодын үзэл санааг зааж байгаа юм. Бид юу бодно, тэр биелнэ. Гэвч хүн бүр ингэж чаддаг биш, учир нь бид энэ хүчийг хэрэглэдэггүй, тиймээс бидний санасан юм бүхэн биеллээ олж чаддаггүй. Хэрвээ бид их бясалгаж, энэхүү дотоодын хүчээ нээвэл, хожим бид юу л хүснэ, тэр нь биелнэ.

Бясалгал сайтай хүн юм бодохоос ихэд айж, тун хичээж болгоомжилбол зохино. Учир нь тэр юу бодсон ч хамаагүй, бүгд биеллээ олдог, тэр чулуу бодвол чулуу хүрч ирнэ. Үүнийг гэрчилж нотлох маш олон жишээ татаж болох боловч, Багш нь дотоод ахуй ойлголтоо задруулахыг хүсэхгүй байгаа болохоор та нарт ярихгүй.

Гэвч би та нарт хэлж өгье. Багш нь юу л бодвол юутай ч болж чадна, ямар ч асуудалгүй. Та нарт мөнгө олох нь их хэцүү байдаг. Багш нь хэрвээ мөнгө олъё гэвэл тэр доороо хүрч ирнэ, гэвч би ингэж бодож зүрхлэхгүй, учир нь аливаа юм бүхнийг бид эргүүлэн төлж дуусгах учиртай байдаг. Энэ дэлхий дээр төлбөргүй юм гэж нэг ч байхгүй,



тиймээс шунахай сэтгэлтэй байж бас болохгүй. Зарим хүн бясалгал нь ямар нэгэн төвшинд хүрээгүй байтлаа мөнгөнд их шунадаг. Тэд бүгд л хулгайлдаг, гэхдээ эндээс (Багш билгийн мэлмийгээ заав)-ээ хулгайлбал болчихно, банкнд очиж хулгайлах шаардлагагүй. Хулгай дээрэм хийгсэд мөнгө булаахын төлөө хүн алах нь даанч хөөрхийлөлтэй. Үнэн хэрэгтээ ингэх нь тун төвөгтэй, хаана очсон ч цагдаагаас айна, хүнийг хорлож, хүн алчихаад өөрөө бас шоронд орох нь магад билээ.

Үнэндээ хулгайल्या гэвэл маш амархан хэрэг, гэвч бясалгал хийх хэрэгтэй. Бясалгагч хүн эндээсээ хулгайлж болно. Швейцарьт очоод Ролекс бугуйн цаг хулгайлж, АНУ-д очоод америк доллар хулгайлж, Францад очоод эрдэнийн чулуу болон сүрчиг хулгайлж болно. Ингэхдээ хүчирхийлэл хэрэглэх шаардлагагүй бөгөөд хаана ч очих хэрэггүй байх юм. Тиймээс хүмүүс мөнгө олох гээд зовж зүдэрч байгааг бясалгалтан хүн үзвэл их инээдэмтэй байдаг. Тэдэнд угаасаа мөнгө олох шаардлага үгүй юм. Жишээлбэл, та бясалгаад маш өндөр төвшинд хүрсэн бол бясалгаж суух үед сүнсэн бие, эсвэл жинхэнэ хүн тань тун өндөр төвшинд хүрч очно. Тэр үед та зөвхөн “маргааш надад хүнд өрөө төлөх хоёр сая зоос хэрэгтэй байна” гэж бодоод буцаж ирэх үед хоёр сая зоос орон дээр чинь тавиатай байх болно. Энэ нь үнэн зүйл, худал биш, гэхдээ та бясалгаж их өндөр дээд төвшинд хүрвэл л сая ингэж хувиргаж чадна. Энэ нь санаанаас гадуур хэрэг байдаг, зориуд ингэсэн хэрэг биш, учир нь бясалгал сайтай хүн зориудаар ингэж боддоггүй. Ойлгож байна уу? Тэд тэгж бодож зүрхлэхгүй бөгөөд тэр тухай боддог ч үгүй. Тэд угаас мөнгө төгрөгийг төдийлөн хайхардаггүй.

Тэр нэг өдөр Багш нь шууданд мөнгө хадгалуулахаар очсон маань маш инээдэмтэй. Би тэдэнд есөн зуун мянгыг хадгалуулна гэж хэлсэн байтал харин хадгалуулахаар авч очсон мөнгө нь нилээд их байсанд тэд ихэд цочин гайхаж: “Та яагаад урьдаар тоолсонгүй вэ? Таны мөнгө чинь хэд байсан бэ?” гэж асуухад би: “Хамаагүй ээ, илүү гарсныг нь надад буцаагаад өгчихвөл болчихно шүү дээ” гэж хэлэхэд тэд бас л асуугаад зогсохгүй байлаа. Тэд лавтай, яагаад ийм ядмаг хүн байтлаа мөнгөө тодорхой тоолох ч үгүй бүгдийг нь гаргаж хүнд өгдөг юм бол гэж бодсон байх. Тэд их цочирсон байсан, шуудангийн бүх хүн бүгдээрээ хүрч ирээд бид хоёрыг хараад байх юм. Би тэдэнд: “Хамаагүй ээ, та нар тоолоод гүйцээчихвэл болно. Бусдыг нь надад буцаагаад өгчих. Би тоолоогүй, та нар мөнгө тоолдог машинаараа тоолж өгч, надад туславал хурдан байх биз” гэж хэлсэн ч тэд бас гайхаад зогсохгүй, тав, зургуулаа нийлэн хараад юуг, яахыг надад зааж гарсан.

Тэд “дараа та ингэж болохгүй, урьдаар тоолж тодорхой болгохгүй бол мөнгийг чинь хүн авчихна” гэж хэлэхэд нь би “би айхгүй, энэ мөнгө минийх биш, хамаагүй” гэв. Ийм их мөнгө авч явж байгаа мөртлөө тоолох ч үгүй гэж тэд намайг ихэд гайхаж байлаа.

Тэр мөнгөөр газар худалдаж авах юмуу, үгүй бол ном хэвлүүл гэж та нар надад өгсөнийг би бүгдийг нь цүнхэндээ чихчихсэн юм. Хэн ямар зав чөлөөгөөрөө тэр эрээн цааснуудыг тоолж байх юм бэ, нэг

удаа тоолох нь хүнийг тун ихээр хашраадаг байтал сүүлд мөнгө нэмж хийх үед дахиад бас тоолох нь яршиг төвөгтэй болохоор бүгдийг нь цүнхэндээ чихчихдэг юм. Шууданд тийм нэг мөнгө тоолох зориулалтын машин байдаг болохоор би: “Та нар тоолоод хэрэгцээтэйг нь аваад илүү гарсныг нь дугтуйнд хийгээд надад буцаан өгвөл болчихно. Хамаагүй ээ.” гэж хэлсэнд, тэд бас л итгэж чадахгүй, дотроо, “Ийм зүйл байж яаж болох вэ? Энэ хувраг яагаад ийм тэнэг юм бэ? Үнэхээр тэнэг хүн юм” гэж бодсон байлгүй дээ. (бүгдээрээ инээлдэв)

Мөнгө гэдэг нь нэг зүйлийн цаас, ямар ч хэрэгцээгүй эд, бас муухай үнэртэй, бохир зүйл. Энэ бүгд бол та нарын төлөө би газар, бясалгалын танхим худалдаж авах гэснээс л болсон хэрэг. Та нар байгаагүй бол надад үүнийг худалдаж авах хэрэг юун. Бясалгалын газар худалдаж авбал түүнийгээ цэвэрлэж, өвсийг нь хадах хэрэгтэй. Муу хадсан бол би бас хадсан хүнийг нь зэмлэх хэрэгтэй болно, тэгснээр миний цаг зав, хүч чадал их үрэгдэнэ. Та нар бүгд Багшийнхаа үйл түйтгэр нь юм. Та нар байгаагүй бол би Тайваньд суух ч хэрэггүй байхсан. Тийм их яршиг төвөг ч болохгүй, Багш нь олон хүний гүтгэлэг, дургүйцэл, дайралт, хорлолыг амсахгүй байхсан билээ. Үнэндээ би угаас ямар ч хэрэг хийгээгүй ч бодьсатва та нарынхаа төлөө л ийм зүйл амсдаг хэрэг.

Шууданд очоод бусдад зэмлүүлсэн нь мөн л та нарын төлөө л юм. Учир нь та нар тэр мөнгийг тоолоогүй, хичнээн мөнгө байгааг нь тэмдэглэлгүйгээр тэнд аваачиж тавиад Багшаараа тоолуулах гэсэн байна. Багшид нь тийм цаг зав байхгүй болохоор тэр мөнгийг тоололгүй, бөөнөөр нь авч яваад шууданд очиж, хүний элэг доог болох хэрэг. Та нар байгаагүй бол надад ерөөс мөнгө хэрэггүй, мөнгө тоолох ч хэрэггүй, хадгалах ч шаардлагагүй, юу ч хийсний хэрэггүй байсан, бас бусад хүн Чин Хай гэж хэн болохыг мэдэх ч үгүй байхсан. Тэгсэн бол надад маш амар чөлөөтэй байхсан.

Хоёр гурван жилийн өмнө надад шавь байгаагүй. Тэр үед би үнэхээр амар тайван байжээ, нүүр царай минь булцайгаад улаа бутарч, хэдийгээр өдөрт нэг л удаа хоол идэж байсан ч дугариг, улайчихсан байдаг байсан. Та нар итгэхгүй бол миний урьд нь амьдарч байсан тэр газрын хүмүүсээс асуувал мэднэ. Багшийнхаа урьдын гэрэл зургийг үзвэл мариалаг байсныг харна, гэтэл одоо шуугдаад мариагүй болжээ.

Уул нь Модгальяаны үлгэрийг ярьж байгаад шууданд оччихжээ. (бүгдээрээ инээлдэв) Та нар Хималай уулын талаар сонсох дуртай байхад Багш нь харин та нарыг шууданд дагуулж очоод, мөнгө тоолох болгочихлоо. Үнэхээр санаа зовчихлоо. Энэ тухай ярихаа больё.

Одоо газар худалдаж авах мөнгө хүрчихсэн шиг л байна, та нар дахиж өргөл өргөсний хэрэггүй. Худалдаж авч болох газар олон байна, чухам алийг нь авахаа л мэдэхгүй байна. Урьд нь бидэнд газар худалдах хүн байгаагүй. Одоо бид мөнгөтэй болчихсон чинь газраа худалдах гэсэн хүн олон болчихжээ. Тийм олон газраас алийг нь худалдаж авахаа би мэдэхгүй байна. Гэхдээ тэдгээрийн аль нь ч адилхан их үнэтэй. Бид

хямд газрыг нь хайж байгаад худалдан авахаар очиж магад. Заавал их мөнгөтэй болж байж газар худалдаж авдаг юм биш. Бид их мөнгө гаргахгүйгээр газар худалдан авч болно, мөн бага мөнгөөр сайн газар худалдан авч болно. Та нар мэдэхгүй, үнэтэй юм бүхэн бүгд сайн байдаг юм биш. Энэ нь яг Төгс Гэгээрсэн Их Багш нартай адил, нэрд гарснаар л Төгс Гэгээрсэн Их Багш болчихдог юм биш. Тийм биз дээ? Багш нь одоо нэрд гарсан болохоор Төгс Гэгээрсэн Их Багш биш болчихжээ. (бүгдээрээ инээлдэв.)

Модгальяаны тухай үлгэрийг ярьж дуусгая. Түүнийг хуврагуудад тахил өргөсний дараа Шагжамуни Бурхан тэднийг нийлүүлж тарни уншуулж, бүх ач буяныг нь түүний эхэд олгосны ач тусаар эх нь тэр өдөртөө диваажингийн оронд дэвшжээ. Зөвхөн Модгальяаны эх төдийгүй тэр өдөр тамын орон хоосорсон байна. Гэвч удалгүй бас дүүрчихсэн аж. Учир нь хамаг төрөлтөн минут, хором тутамд үйл түйтгэр үйлдэж байдаг юм. Тиймээс өдөр бүр мөнгө олж байгаа хүнийг чухал гэж хэлж болохгүй. Бид бас олж байгаа, гэвч бидний олж байгаа нь нүдэнд үзэгдэхгүй мөнгө. Та нарын олж байгаа нь цаасан мөнгө, харин бясалгалтны олдог мөнгө бол асар их ач буянтай байдаг.

Ийм нүдэнд үзэгдэхгүй мөнгө, нүдэнд үзэгдэхгүй ач буянаар дүрс үгүй нисэх онгоцны тасалбар худалдаж аваад Хималай ууланд очиж болно. Та нар бясалгаагүй учраас Хималай ууланд очиж чадахгүй. Мэдээжээр, та нар энэ ертөнцийн нисэх онгоцонд суувал бас очиж болно. Гэтэл тэнд очоод юу хийх вэ, зөвхөн цас юмуу, уулыг л олж үзнэ. Нарыг олж үзнэ, нарс, майлсыг л олж үзэх төдий, өөр юу ч олж үзэхгүй.

Хималай уулын олон газарт их бясалгалтнууд нуугдаж байдаг бөгөөд тэдний зарим нь асанги галавтай чацуу амьдарчээ. Тэдний насыг тоолохын аргагүй, хоёр гурван мянган жилээр ч биш, тэд маш урт насалсан. Тэд бидний оршин байгаа дэлхийн бөмбөрцөг бүтэхээс эхлээд одоог хүртэл тэнд амьдарч байна. Тэр газарт тэд бас маш нууц номын ёсыг хамгаалж байдаг, тухайлбал, Арьяабалын номын цогцос. Тэдний ажил бол энэхүү номын судсыг таслуулахгүй байхад оршдог. Учир нь гаднах хүмүүс бясалгал хийхгүй, эсвэл сайн шавь байхгүйгээс болоод уламжлал нь тасрахад хүрвэл, хожим Арьяабалын номын цогцосыг уламжлах хүн үгүй болно. Тиймээс тэд үлдээд шавьгүй үед шавь хайх юм. Ойлгож байгаа биз? Гарамгай шавь нар нь бүгд нас барах, уламжлал нь тасрах, бясалгагчид нь номын гай зовлонд учрах буюу хорлогдох, бясалгалтан байгалийн гай гамшигт дайрагдаж үрэгдэх, эсвэл улс гүрэн нь бүхлээрээ сөнөж устах зэрэгт тэдгээр их бясалгалтан үеийн үед амьд байж, энэхүү туулан гэтэлгэх номын цогцосын уламжлалыг хамгаалж, түүнийг хүлээн авч чадах боломжтой хүнд уламжилж өгдөг юм.

Хэрвээ бид Хималай ууланд очъё гэвэл мөнгөтэй л бол хүрчих биш, харин ач буянаа хэрэглэх хэрэгтэй. Та нар илүүхэн бясалгасны дараа нэгэн өдөр ямар нэгэн Их Багш та нарыг Хималай ууланд залж аваачаад тийм нэгэн бясалгалын нууцлаг бүлгэмээс суралцуулж магадгүй. Ийм байдал маш ховор. Учир нь тэд эгэл хүнд дургүй, эгэл хүмүүс тэнд

очлоо ч хэрэгцээгүй, тэднийг тэнд сургахын аргагүй. Эгэл хүн даанч мугуйд бөгөөд уур амьсгал нь муу болохоор зөвхөн тэдэнд яришг төвөг болохоос хэтрэхгүй. Гэтэл тэдний үүрэг тушаал нь бүх хүн төрөлхтнийг харж харгалзахаас биш, ганц хоёрхон хүнийг хамаарах биш, тиймээс бид очъё гэхээрээ л тэнд хүрчихэж болох юм биш.

Бид тэнд очлоо гэхэд тэднийг олж харж чадахгүй. Тэд маш сайхан, тун гоё хүн болохоор бид хармагцаа таньчихмаар биш. Ойлгож байна уу? Тэд биеэ далдалж чадна. Хэрвээ тэд бидэнд үзэгдэхгүй гэвэл бид тэднийг олж үзэхийн аргагүй. Бидэнд тэд үзэгдлээ гэхэд бид тэдний байгаа газарт хүрч чадахгүй. Учир нь тэр газар их нууц далд бөгөөд их бөглүү, тун өндөрт, бараг далайн төвшнөөс дээш хорин таван мянган фут (1 фут = 30,5 см) өндөрт байдаг. Тэр газар агаар нь их сийрэг, хүчилтөрөгч тун бага, цас нь гүн, их хүйтэн болохоор эгэл хүн гарахын аргагүй. Сүнсэн биеэ хэрэглэхээс биш, хэрвээ махан биеэрээ тийш мацах юм бол, ямар ч хэрэгцээгүйгээр үхэхэд хүрнэ.

Тэд тэнд суугаад юу иддэг вэ гэвэл Бүтээгчийн хүчийг иднэ. Тэд юм идэх ч үгүй, өмсөх ч үгүй, гэхдээ тэд бас хувцас хувилган өмсөж чадна. Тэд Арьяабалын номын цогцосыг бясалгаж, Арьяабалын хүч, энэхүү дотоодын Аялгууны хүч, орчлонгийн хүчийг хэрэглэж өөрийн бие махбодоо тэжээж тэтгэдэг.

Тиймээс тэд хэдийгээр хэдэн арван сая жил амьдарсан ч харахад гучин настай, хорин таван настай гэмээр тун залуухан харагддаг. Нэг өдөр та нарыг тэнд хүрч үзнэ гэж найдаж байна. Энэ нь Хималай уулын хамгийн үзүүштэй зүйл. Үүнээс бусад нь тийм ч сонирхолтой биш, мэдээж, тэнд тун үзэмжтэй, тун гоё сайхан, хожим үзэхээр очих боломж бидэнд олдож болох юм. Гэтэл махан биеэрээ зөвхөн гаднах зүйлсийг нь л олж үзэх боломжтой.

Кашмер үнэхээр үзэсгэлэнтэй, тэр бол Энэтхэгийн хамгийн үзэсгэлэнтэй газар. Яагаад гэвэл газрыг нь засаж тэгшилсэн, олон нууртай бөгөөд оршин суугаа хүмүүс нь цөм усан дээр байх завь онгоцонд амьдардаг. Би тэнд очихдоо зочид буудалд буугаагүй, завин дээр хоноглонсон. Тэндхийн ихэнх зочид буудал нь завин дээрх сууц байдаг, жишээ нь, нэг айлд гурав, дөрвөн том завь байдаг, тэр нь маш үзэсгэлэнтэй сайхан. Завинууд нь өндөр, бас том, яг л байшин шиг. Завь болгон гурваас таван тасалгаа, эсвэл өрөөтэй, бид зочид буудалтай адил нэг юмуу, хоёр өрөөг нь хөлслөн сууж болно. Гэхдээ энэ нь зочид буудалд байрласнаас илүү сонирхолтой. Нуурын төвд хоноглоход дээрээ үүлтэй, доороо устай, энэ талаараа цастай байхад тэр талаар нь модтой, бас уулс үргэлжилнэ. Энэ бүхэн нь үнэхээр үзэсгэлэнтэй харагддаг. Тэр газарт эрт цагийн улсын хаанаас нь үлдээж өгсөн, алдартай цэцгийн хүрээлэн олон бий. Тэндхийнхэн цэцгэнд дуртай болохоор маш сайхан засаж тэгшилжээ. Цэцгийн хүрээлэн нь хэмжээгүй том, тийм үзэмж төгс цэцгийн хүрээлэнг би урьд нь харж байгаагүй, тэнд халуун орны элдэв зүйлийн цэцэг, навч ургамал цөм бий. Устай бөгөөд уултай, тэнд хэдэн мянган жил болсон аварга бүдүүн модод бий, зарим ургамал, цэцгийг

урьд нь огт харж байгаагүй. Тэндхийн уур амьсгал нь цэвэр ариун, өдөр бүр тэнгэр цэнхэрлэн цэлмээд хурган цагаан үүлс нүүж байх нь үнэхээр сайхан, үнэнхүү цэлийсэн цэнхэр огторгуй, үнэнхүү чандаган цагаан цас, үнэнхүү мөнхийн ногоон нарс мододтой, үнэхээр үзэсгэлэнтэй сайхан. Үүнийг би дүрслэн хэлэхийн арга алга.

Харамсалтай нь тэр үед би нэгэн уул усны эзэн, сахиусыг шүтэх бясалгалтан, тун ядуу бөгөөд гэрэл зургийн аппаратгүй байв. Гэхдээ гэрэл зургийн аппарат байгаагүй нь харин сайн болжээ гэж бодох юм. Учир нь зургийн аппаратаар зөвхөн нэг жижигхэн хэсгийг л тусгах тул ямар хэрэг байх вэ? Үнэндээ би тэр үед юу ч хийж чадаагүй шиг санагдана. Зурья гэсэн ч зурж чадахгүй, гэрэл зургийн аппарат байлаа гээд ч хэрэггүй. Учир нь очих болгонд үзэмж нь өөрчлөгдөн адилгүй болсон байдаг. Өдөр бүр адилгүй, газар болгон адилгүй юм чинь, нэг өнцөг буланг нь буулгаж зураглаж авлаа гээд ямар хэрэг байх вэ дээ? Тэр нь зөвхөн үзэмжит байдлын үхмэл зураг л болно. Би гэрэл зургийн аппарат хэрэглээгүй, өөрөө очиж үзээд аливаа бүгдийг цөмийг тархиндаа шингээн авсан минь дээр болжээ гэж бодож байна.

Хималай уул маш гоё, тэр энэ дэлхий дээрх хамгийн сайхан газар, хамгаас илүү онгод хөглөсөн орон. Тэнд төрлөөс төрөлд бүгд л бясалгагч хүн байж, одоо ч бас хэдэн мянган настай, хэдэн зуун настай маш олон хүн амьдарч байдаг юм. Тэд энгийн хүмүүн биш, тэд бол тэнгэрийн төрөлтөн, бурхан бодьсатва юм. Тэдэнд хийх онцгой ажил байгаа болохоор тэд энд ингэж үлдэх хэрэгтэй байжээ. Тэдэнд хийх ажил байгаа болохоор заавал махан биеэ үлдээх хэрэгтэй. Харин бид мэтийн энгийн хүн ингэж үлдээд хэрэггүй, цаг нь болбол бушуухан явчихвал болчихно. Удаан хугацаагаар үлдэх юм бол улам л гашуун зовлонтой. Тийм биз дээ? Хэрвээ үлдэх дуртай хүн байвал бас үлдэж болно. Багш нь та нарыг шүдгүй болтлоо энд үлдэж болох арга хайя. Та нар хүсч байна уу?

Багш нь та нарт өнгөрсөн долоо хоногт Хималай ууланд нэгэн төрлийн үхэшгүй мөнхийн рашаан байдаг талаар ярьж өгсөн билээ. Тэр рашааныг уувал маш урт насална. Өтлөөд нэг ч шүдгүй болоод шүдний эмчийг хайх ч хэрэггүй болно. (бүгдээрээ инээлдэв) Үнэндээ бид тийм мөнхийн рашааныг хайж олъё гэсэн ч олохгүй. Миний сонссоноор, эрт урьд цагт нэгэн улсын хаан Энэтхэгт түрэмгийлэн ороод энэ газарт ирж, мөнхийн рашааны эх сурвалжийг нь хайж олоод өөрийн доорх хүнээ зарж, тэрхүү рашааныг авч ирүүлэн уух гэтэл, өтлөөд шүд нь унасан, муухай царай, үрчлээтсэн нүүртэй өвгөн түүнтэй уулзахаар ирээд чичирхийлсэн дуугаар: “Эзэнтэн минь түр байж бай, битгий уу, та намайг харвал мэдэх болно. Би дөрвөн зуун жилийн өмнө энэ усыг ууснаас хойш ийм болжээ. Одоо өвчин туссан ч үхэхгүй, явах гээд ч явж чадахгүй, та үз дээ, үүнд ямар сайн зүйл байна вэ? Битгий уу, бүү уугаач!” гэжээ. Тэр үед хаан айгаад ууж зүрхэлсэнгүй гэнэ.

Үнэндээ тэр ингэж хувирсан нь энэ усыг хамгаалж, олон хүнд нийтэд нь мэдэгдэхгүйн төлөө юм. Тэгэхгүй бол хэн нэгэн хүн ирж

зочид буудал байгуулан усыг нь худалдах болно. Тэрний дараа хэдэн сая хүн ирж, өвс ургамлыг нь талхалж, усыг нь АНУ, Франц, Англид гарган худалдвал, удахгүй ус нь хатаж үгүй болно. Тиймээс тэнд эрхбиш ном хамгаалагч сахиус байх хэрэгтэй. Тэр өндөр настай өвгөн бол ном хамгаалагч байсан учраас тэр хаанд уулгасангүй. Учир нь хаан уусныхаа дараа буцаж очоод өөрийн хороо цэрэгт аваачиж уулгах нь лавтай. Сүүлд нь өөрийгөө хязгаарлан захирч дийлэхээ болиод эцэстээ бүх дэлхий түүнийх болох юм. Тиймээс болохгүй. Бусад энгийн хүн ирсэн ч болохгүй. Тиймээс тэр хүн нэгэн өндөр настан болж хувилдаад тэр хааныг хориглосон байжээ.

Хэрвээ бид тэр мөнхийн рашааныг олдог юм бол тэр даруй уух хэрэгтэй, айх хэрэггүй. Та нар түүнийг хайж олохыг хүсэж байна уу? Дараа нэг өдөр бид хамтдаа хайхаар очъё, тэгэх үү? Мөнхрөхийг бодож байгаа хүн гараа өргө. (нэг хүн гараа өргөв.) Та тэгж хүсэж байна уу, үнэхээр тэнэг байна даа. (бүгдээрээ инээлдэв) Ертөнцийн гашуун зовлонг хэлээд барахгүй байтал та бас мөнх амьдрахыг хүсэх юм. Танд гашуун зовлон байхгүй юу? Та энэ ертөнц дээр маш их баяр баясгалантай байна уу? Бид энэ дэлхий дээр мянган жил насалвал, мянган жил ажиллах хэрэгтэй болно, тэтгэвэртээ ч гарч чадахгүй. Таныг тэтгэвэртээ гарсны дараа хэн танд мөнгө өгөх вэ? Тэр үед явъя гээд ч явж чадахгүй, өдөр бүр мөнгө олохоор ажиллахаас биш, тэтгэвэртээ ч гарч болохгүй. Үхэшгүй мөнхөд амьдрахыг хүссэн юм чинь мөнхөд ажиллах ёстой. Энэ биеэ тэжээн тэтгэхийн тулд өдөр бүр ажиллаж байгаад мөнгө олж хоол идэх хэрэгтэй, үнэхээр эгдүүцмээр юм. Та хэзээ нэг өдөр энэ дэлхийгээс явахыг хүслээ ч явж чадахгүй. Ойлгов уу?

Мөнхөрье гэвэл бясалгал хийх хэрэгтэй. Удаан бясалгасны дараа үхэшгүй мөнхийн Их Багш болоод Хималай уулын Их Багш нартай адил юу ч хэрэглэхгүй болно. Ойлгов уу? Тэд тэнд үлдэж хоцорч байгаа нь энэ дэлхийг хамгаалахын төлөө, хамаг төрөлтийг аврахын төлөө юм. Ингэж урт наслвал сая сайн, зовлонгүй байна.

Тэд юунд ингэж өөрийн цагийг үрж, энэ ертөнц дээр биднийг хамгаалж байдаг вэ? Тэд яагаад дээд хүслэнт ахуйд суулгүй энэ мөнх бусын ертөнцөд ирж сууна вэ? Энд хоцорч биднийг авардаг нь юун билээ? Үүнийг хэн мэдэх вэ? (Бурхан бодьсадва машид энэрэл нигүүлсэлтэй, тэд хамаг төрөлтийг туулан гэтэлгэхийн тулд энэ дэлхий дээр өнөд үлдэхээр андгайлжээ” гэж нэг хүн хариулав.) Зөвхөн ийм гэж үү? Би та нарт хэлж өгье. Тэд тийм ч нигүүлсэнгүй биш, ингэх нь тэдний хийвэл зохих ажил л юм.

Учир нь тэд ном уламжлахгүй, хүмүүсийг ёс суртахуунтай болгохгүй, энэ дэлхийн сүнслэг чанарыг ариутган дээшлүүлэхгүй бол тэд өөрсдөө бас оршиж чадахгүй, үхэхэд хүрнэ. Ийм уур амьсгал тэднийг тавгүйтүүлднэ. Учир нь тэдний хэлбэлзэл нь адилгүй, тэд бол богд гэгээнтнүүд болохоор хэлбэлзлийн хүч нь тун нарийн. Тийм нарийн хэлбэлзэл баймааж нь тэд бясалгаж чадна, оршиж чадна. Тэд юунд Хималай ууланд нуугдана вэ? Учир нь тэндхийн хэлбэлзэл нь



илүү сайн, бохирдол нь бага, тиймээс тэдний ихэнх нь Хималайд биеэ нууж байгаа юм.

Хэрвээ энэ дэлхий дээр хэн ч бясалгал хийхгүй, ёс суртахуун нурж сүйдэхэд хүрвэл тэд бас Хималай ууланд биеэ нууж бясалгал хийх аргагүй, учир нь тэр муу нөлөөлөл нь их болох үед эргэн тойрны уур амьсгал нь бас Хималай ууланд хүрнэ. Одоохондоо арай хүрээгүй байна. Тиймээс тэд биднийг хамгаалж байгаа нь бас өөрсдийнхөө оршин байхуйг хамгаалж байгаа хэрэг юм. Үгүй бол тэд эрхбиш дээд хүслэнт ахуй буюу өөр ертөнцөд очих хэрэгтэй болж, энд үлдэж, энэ дэлхийг харж харгалзаж чадахгүй болно. Тэдэнд тэдний ажил байгаа, тэд энэ ертөнцийг хамгаалдаг. Тухайлбал, манай энэ дэлхийн хүмүүсийг хамгаалж тав дахь ертөнцөд хүргэх юмуу, эсвэл Гурван ертөнцийг давуулах юм.

Мэдээж, тэд дээд хүслэнт ахуйд очин ажиллаж чадна, нааш цааш хаа ч очиж чадна, гэхдээ тэдэнд энд ажиллавал илүү дээр байдаг. Учир нь энэ бол хамгийн доорд орон болохоор аливаа хэлбэлзэл, аливаа адислал цөм энд хүрч ирдэг. Тэд энэ адислалын хүчийг хамаг төрөлтөнд түгээж өгдөг, ингэх нь хамгийн сайн. Яг л их далай тэнгис шиг, мөрөн гол бүхэн их далай тэнгист цутгаж ордог. Хичнээн олон усан онгоц байлаа ч их далай тэнгис бүгдийг нь асуудалгүй багтаадаг. Гэтэл нарийн голд нэг усан онгоц байхад л багтаж чадахгүй байх. Тиймээс бурхан бодьсатва нар энэ дэлхий дээр ажиллах нь хамгийн сайн. Судар номд бодьсатва нар замбуутивд ажиллах хамгийн дуртай гэж мөн өгүүлсэн байдаг билээ.

Тиймээс та нар энэ тоост хорвоог тийм муу гэж битгий бодоорой. Энэ бол хамгийн сайхан үзэсгэлэнтэй, маш нууцлаг гайхамшигтай орон. Та нар хар л даа, хүн бүр цөм адилгүй, үй түмэн хүн бүгд ондоо байдаг, тэгээд хоёр адилхан хүнийг хайж олох нь маш гайхамшигтай явдал байх болно, олж авлаа ч тэд яг адилхан байж чадахгүй. Тэдний зан ааш нь адилгүй, биен дээрээ бас адилгүй мэнгэ, тэмдэгтэй байна. Хэрвээ илүү сайн ажиглавал хэн нь эгч нь, хэн нь охин дүү нь вэ гэдгийг мэдчихнэ. (энэ үед хурлын талбайд адилхан төрсөн хоёр ихэр бяцхан бясалгалтан эгч, дүү байв)

Энэ дэлхийд бас тун олон амьтан, мод, цэцэг, жимс, уул, ус, хайр сэтгэл, хүн төрөлхтний хоорондын харилцаа, хүн төрөлхтний хайр, хүн төрөлхтний цэцэн ухаан гэхчлэн бидний хамгаалах хэрэгтэй зүйл маш олон бий. Бид өдөр бүр зөвхөн энэ биеэ хамгаалах биш, бас дэлхийгээ хамгаалах ёстой. Дэлхийгээ хамгаалахын тулд юу хийвэл зохих вэ гэвэл энэ дэлхийгээ хэтэрхий харанхуй болгож болохгүй, ойлгож байна уу?

Ёс суртахуунаар түнэр харанхуй байх нь хамгийн хэцүү уршигтай явдал. Манай улс гүрэн газрын баялаг маш ихтэй, их мөнгө олж болох байсан ч, бүгдээрээ ёс суртахуунгүй учраас өдөр бүр түүнийгээ хулгайд алдахаас айж байдаг бол энэ нь бидэнд ямар ашигтай байх вэ? Бидний гэр бүл баян тансаг байсан ч бидний хөвгүүд, охид харанхуй мунхаг,



эгэл хүн болсон учраас өдөр бүр элбэрэл журамгүй байх юм бол энэ нь бидэнд ямар тустай вэ? Бид хамгийн алдартай хүн байсан ч цөмөөрөө бясалгалын үндсэн ёс суртахуунгүй болохоор өдөр бүр өөр бусад хүн бидэнд атаархахаас айж, биднийг нууцаар хөнөөхөөс эмээж, эсвэл бидэнд хортой зүйл өгч идүүлэхээс айдаг бол энэ нь ямар ач тустай байх вэ?

Тиймээс бясалгах нь маш чухал. Бясалгавал бидний сайн санааны уур амьсгал нь эргэн тойрны хортой амьсгалыг цэвэрлэж, гаднах нөхцөл байдлыг хувирган өөрчилж чадна. Жишээ нь, өөр хүн бидэнтэй уулзах үедээ их ууртай байсан ч эцэст нь тун их сайн санаатай болдог. Бидэнтэй уулзах үедээ тэд юу ч хэлж зүрхлэхгүй. Уг нь уураа гаргахаар ирсэн байтал эцэстээ биднийг олж хармагц уурлахаа болиод муухай ааш гаргасандаа санаа нь зовно, бүгдээрээ хамтдаа хооллосны дараа эв найртай болчихдог. Багшийнхаа хэлж байгаа санааг ойлгож байна уу? Ямар ч хүчирхийлэл хэрэглэхгүйгээр ингэж хийх нь даруй дэлхийгээ хамгаалж байгаа хэрэг болно, дэлхийгээ хамгаална гэдэг нь бид өөрсдийгөө хамгаалж байгаа хэрэг болно. Бид баян тансаг байсан ч энэ дэлхий ертөнц ороо бусгаа бол энэ нь бидэнд ямар ашигтай байх вэ, эрт орой энэ бүх баялаг өөр хүнийх болно. Яг л дайн тулаан болж байгаа шиг, бидний эд хөрөнгийг бусад хүн булаан цөлмөж, элгэн садныг минь алж хорооно. Тиймээс ёс суртахуунтай байх нь маш чухал, бясалгах нь маш чухал.

Ёс суртахуунд гадна талын болон дотоодын гэсэн хоёр төрөл байдаг. Гадна талын ёс суртахуун гэдэг нь бусдыг албадаж байгаад хийлгэж болдог зүйл юм. Үүнийг хууль дүрэм мөрдүүлэх, эсвэл айлган сүрдүүлэх арга замаар хүнийг албадаж байгаад сахиулж болно. Харин дотоодын ёс суртахуун гэдэг нь хамгийн үндсэн, хамгийн чухал, хамгийн тогтвортой, хамгийн шаардлагатай зүйл. Дотоод ёс суртахуун байвал гадна ёс суртахуун заавал байна. Гэтэл зөвхөн гадна талдаа ёс суртахуунтай байгаад дотооддоо ёс суртахуунгүй бол хэзээ нэг өдөр лавтай энэ дэлхий үймээн самуунтай болж, аль нэг улсад гай зовлон учирна. Тиймээс бидний бясалгаж байгаа нь дотоод ёс суртахууныг олж авахын тулд билээ.

Нэгэн бясалгалтан, нэгэн бясалгаж суудаг сайн сэтгэлтэн, эсвэл Арьяабалын номын цогцосыг бясалгагч хүн ясан ч хүнийг хөнөөхгүй, хэзээ ч тэгж чадахгүй, тийм биз дээ? Тэд хэзээ ч хулгай хийхгүй, эсвэл бусдын амийг хороохгүй, тиймээс тэдэнд ёс суртахууны хамаатай учир явдлыг ярьж хэлсний шаардлагагүй. Бид Арьяабалын номын цогцосыг бясалгаж л байвал бүх зүйл бүгд бидэнд байна. Мөр байвал ёс суртахуун байна, Мөр үгүй бол ёс суртахуун үгүй болно. Тиймээс Мөр ёсны судар (Тао Те Чинг)-т Лууз: “Гагцхүү Мөр байвал даруй бүгд байна. Мөр үгүй болсноос сая өршөөл, журам, ёслол, билиг ухаан, итгэл болж хувирчээ” гэж ярьсан байдаг. (Мөр ёсны судрын 18-р бүлэгт: “Их Мөр хаягдвал өршөөл, журам буй болно” гэжээ. Мөр ёсны судрын 38-р бүлэгт: “Тиймийн тулд, Мөрийг алдсаны дараа сая ёс суртахуун бий

болно. Ёс суртахууныг алдсаны дараа өршөөл бий болно, өршөөлийг алдсаны дараа журам бий болно. Журмыг алдсаны дараа ёслол бий болно” гэжээ.) Энэ бүхэн нь цөм гадна талын ёс суртахуун билээ. Мөрийг алдсан болохоор хүнийг хязгаарлах хэрэгтэй. Юу хийхийг нь сургах хэрэгтэй. Өршөөл, журам, ёслол, билиг ухаан, итгэл байх хэрэгтэй, хүнийг албадаж, ёс суртахуунтай хэрэг учрыг хийлгэхээр сургах хэрэгтэй. Хэрэв хэн нэг хүн Мөр ёстой байвал тэр өөрөө аяндаа хийж, юу ч сурах шаардлагагүй. Ойлгож байна уу? Хэрвээ хүн бүхэн сайн бол угаасаа хууль дүрэм байхын хэрэггүй юм.

Үүнтэй адил, маш олон хүн бясалгадаг юм бол энэ ертөнц хувиран өөрчлөгдөнө, тийм биш бол энэ ертөнц удалгүй устаж сүйрэх болно. Тиймээс бидний бясалгаж байгаа нь өөрийн амь насаа аврахын тулд юм, бид дэлхийгээ аварч байгаа нь өөрийн биеэ аварч байгаа явдал мөн. Дэлхийгүйгээр бид яаж оршин тогтнох вэ? Энэ дэлхий тун гоё, үзэсгэлэнтэй, тийм түргэн устаасай гэж би хүсэхгүй байна. Энэ дэлхий дээр одоо ч маш олон сайн хүн бий, маш олон үзэсгэлэнтэй сайхан газар бий бөгөөд маш сайхан хүсэл эрмэлзэл ч бий юм. Дэлхийн эргэн тойрны уур амьсгал нь муу байсан ч хамаагүй, бид засаж сэлбэж болно. Хэрвээ засаж сэлбэе гэвэл Багштайгаа хамт бясалгахун. Бидний бясалгаж байгаа нь энэ дэлхийг засан сэлбэж, түүнийг дэндүү түргэн устгуулахгүйн төлөө юм. Эс бөгөөс үнэхээр харамсалтай хэрэг болно. Тоолшгүй олон галавыг өнгөрөөж байж сая ийм нэгэн гараг дэлхийг бүтээсэн бөгөөд үүнийг элбэг баян, үржил шимтэй газар болгоно гэдэг тийм ч амархан энгийн хэрэг биш юм.

Америк улс хичнээн их мөнгө зарцуулж байж сая нэг сансрын хөлгийг саранд илгээсэн бэ? Та нар мэдэх үү? Үүнд маш их мөнгө зарцуулсан. Гэтэл энэ газрын бөмбөрцгийг харж харгалзсан хүн алга. Энэ газрын бөмбөрцгийг бүтэж бүрэлдэхэд зарцуулсныг мөнгөөр хэмжихийн аргагүй. Сэтгэгдэшгүй хүчийг хэрэглэж, асанги галавыг өнгөрөөж байж сая нэг юм ийм нэгэн гоё сайхан газрын бөмбөрцгийг бүтээж чадсан юм. Газрын бөмбөрцөг дөнгөж бүтэж бүрэлдэх үед энэ нь зөвхөн нэгэн гараг төдий байсан. Энэ гараг нь маш халуун, ямар ч хэрэггүй байв. Дээр нь хүн амьдрах боломжгүй, гадуураа халуун агаартай, дотроо халуун нурамтай, амьтад ч байхгүй, модод ч байхгүй, юу ч үгүй, яг мөхөж сөнөсөн од гараг шиг, ямар ч хэрэгцээгүй байсан. Асанги галав өнгөрсний дараа сая хөрч эхлээд аажмаар устай, уултай, модтой, зүлэг ногоотой болсны дараа амьтантай, загастай, тэгээд хүмүүстэй болжээ. Энэ газрын бөмбөрцөг тун эрхэм нандин, маш ховорхон эд шүү. Тун олон амь нас цөм газрын бөмбөрцгийг түшиж байж л амьдарч, оршин тогтнож чадна. Гэтэл бид үүнийгээ харж харгалзахгүй байдаг нь үнэхээр харамсалтай.

Хүн төрөлхтөн маш их мөнгө хэрэглэж байгаад саран дээр очиж үзсэн байтлаа харин газар дэлхийгээ харж хамгаалахад тийм ч их мөнгө зарцуулаагүй. Ийм байж таарахгүй. Үнэндээ мөнгө хэрэглээгүй нь бас нэг талаар сайн. Үүнийг харж хамгаалахын тулд мөнгө зарцуулна

гэвэл бүгдээрээ ихэд айх байх, тийм үү? (бүгдээрээ инээлдэв) Мөнгө зарцуулсны хэрэггүй, бид зөвхөн Арьяабалын номын цогцосыг бясалгадаг л юм бол даруй эх дэлхийгээ харж хамгаалж чадна. Улам олон хүн Арьяабалын аргаар бясалгавал уур амьсгал сайжирч, хувирч чадна, эргэн тойрны нөлөө тусгал, амьсгал нь ч улам сайн болно. Ингэвэл улам л ёс суртахуунтай болж, улам улам тогтуун болж, гай гамшиг гэхээр юм үгүй, ертөнц дэлхий бас галав юүлж сүйрэхгүй байх болно.

Ингэхгүй бол энэ нь лавтай үнэн болж мэдэх юм. Та нарын мэдэж буйгаар дэлхийн Хоёрдугаар дайн нэгэнт болоод өнгөрсөн боловч, Гуравдугаар дайн ч амархан үүсч болохыг та нар төсөөлж чадах байх. Хүчирхэг их улс гүрнүүд одоо маш олон мөхөл сүйрлийн чанартай цөмийн зэвсэг үйлдвэрлэж байна. Аль нэгэн өдөр ямар хэн нэгэн хүн улайран галзуурч, эхнэртээ уураа гаргахдаа тэр нэг товчийг нь дарчихвал бид бүгдээрээ сүйрэх болно. Америк улс Оростой дайтах ч шаардлагагүй, зөвхөн цөмийн зэвсгийг хариуцаж байгаа тэр хүний уур нь хүрвэл болчих хэрэг шүү дээ. Энэ санааг ойлгож байгаа биз дээ? Аль нэг өдөр тэр хүн галзуурч болно. Эсвэл эхнэртэйгээ муудалцан уурлаад нэг товч дарахад л аль байсан бүх зүйл дэлбэрнэ. Дайн эхлүүлэх ч шаардлагагүй, зөвхөн нэг хоёрхон хүн юмуу, эсвэл ямар нэг бүлэг галзуурах юм бол бид алив бүхнээ алдаж, энэ газрын бөмбөрцөг тэгээд дууссан хэрэг болно.

Үүнийг бид хязгаарлан захирч чадахгүй бөгөөд бас тиймэрхүү хүмүүсийн талаар сайн сайхан үгээр хэлэхийн аргагүй. Бид тэр улсын ерөнхийлөгчид хэлж анхааруулж чадаж л магадгүй. Гэтэл түүнд энэ талаар хэлэх хариуцлагатай албаны хүнийг хэрхэн эрж олох вэ? Учир нь энх тайвныг хамгаалахад ганцхан ерөнхийлөгчид найдах биш, мөн түүний доорх бага тушаалтнуудад түшиглэх хэрэгтэй. Тэр бага тушаалтнууд хэрэг тарьж мэдэх юм. Тиймээс Америк, эсвэл Оросын ерөнхийлөгч энх тайвныг хичнээн их хамгааллаа ч бид мөн л тун түгшүүртэй, маш аюултай байдалд оршиж байгаа юм.

Маш олон хүн нийлж дайн үүсгэдэг, харин ганцхан ерөнхийлөгч үүнийг шийдэж чадахгүй. Хэрэв ерөнхийлөгч нь дайныг хүсэхгүй бол түүний доорх их түшмэлүүд болон цэргийн хүмүүс нь түүнийг хөөж явуулна. Тиймээс бидэнд аюул хэвээрээ байна. Аюулаас сэргийлэх хамгийн баталгаатай арга нь бясалгалаараа энэ ертөнцийн эргэн тойрны уур амьсгалыг хувиргаж, хорсол занал бүхий орчны уур амьсгалыг үгүй болгох явдал юм. Үүнээс өөр ямар ч арга хэрэггүй. Бид хүний зүрх сэтгэлийг худалдан авч чадахгүй, бас тэдэнд юу хийхийг нь хэлж зааж болохгүй. Учир нь хүний зүрх сэтгэл хувиран өөрчлөгдөж байдаг. Өнөөдөр та амар амгалан байхын чухлыг түүнд хэлж өгвөл тэр сонсоод зүйтэй гэж бодож: “Зүйтэй, тэгвэл бид цөмийн зэвсэг хийхээ больё” гэснээ, маргааш нь эхнэртээ уурлавал бас хийчихэж ч магадгүй. Учир нь хүн бол санаан зоргоороо өөрийн биеэ хязгаарлан захирч чадахгүй, гадны нөлөөнд ихээр автдаг. Тийм биш гэж үү?

Эр нөхөр нь эхнэртэйгээ муудалцаж хэрэлдэхэд ямар байдгийг

та нар бүгд мэдэж байгаа, тийм үү? Хүүхдээ барьж зоддог биз дээ? Хүүхдүүд ер гэмгүй байж байгаад зодуулдаг. Хэрэв гэрт нь зочин ирсэн бол тэд зочиндоо найрсаг биш хандан хачин их гомдолтой царайлж, юм хумаа шидлэн хагалж орхидог. Тийм биз дээ? Тэр улс төрчид ч бас адилхан. Тэд бас эгэл хүн болохоор гэр бүлийнхээ эргэн тойрны уур амьсгалын нөлөөнд автдаг. Хүүхдийнх нь биеийн эрүүл мэндийн байдал тэд нарт ч мөн нөлөөлдөг юм. Тиймээс энэ ертөнцийн хүний зүрх сэтгэлд найдах нь тун аюултай. Жишээлбэл: Хүсэл зорилго нь адилгүй зарим улс хоорондоо итгэлцэхийн аргагүй болж, хэдэн арван жил хэлэлцээ хийн маш их виски, кока кола, кофе ууж, маш их үхрийн мах, гахайн мах идэж, маш сайхан тэргүүн зэргийн зочид буудалд бууж байрлан улсынхаа ард иргэдийн татварын мөнгийг зарж үрэн хэлэлцээ хийдэг ч, ямар ч бодит үр дүнд хүрээгүй. Учир нь хүмүүсийн зүрх сэтгэл хувирч өөрчлөгдөж байдаг, тэгээд бие биендээ итгэж чаддаггүй, бас гадаад байдлын нөлөөнд амархан автдаг. Гагцхүү дээд бясалгалтай хүн л гадаад байдлын нөлөөнд автдаггүй юм.

Хэн, ямар хүн байсан ч хамаагүй, гадаад байдлын нөлөөнд автдаг. Тэр хүн нь ерөнхийлөгч, улсын хаан, цагдаа, эсвэл хог цэвэрлэдэг хар ажилчин байсан ч хамаагүй, цөм гадаад байдлын нөлөөнд автдаг. Тиймээс зарим үед өөр хүн бидэнд илүү сайнаар хандвал бид тэр дороо баярлан тэд юу л гэвэл түүгээр нь болдог. Гэтэл өөр хүн бидэнд муугаар хандах юмуу, эсвэл дарга биднийг зэмлэж загнах, эсвэл эр нөхөр нь эхнэртэйгээ хэрэлдэх үед байдал тун хүнд болдог. Гэрт чинь найз нөхөд ирсэн ч ярих дургүй, хүн юм худалдаж авах гэсэн ч түүнд юмаа худалдах дургүй байдаг. Тэр үед мөнгө санаанд орох ч үгүй, өөр олон хэрэг явдлыг ч хамаарах дургүй болдог. Тиймээс бид бясалгахгүй бол аюулгүй байх арга ер байхгүй. Аюулгүй байя гэвэл заавал бясалгах хэрэгтэй.

Багш чинь болон гэрээс гарагчид маань та нарын өмнөөс бас бясалгаж байдаг юм. Зуны оршлын гурван сард бид бас хагуужилтай бясалгасан. Гэхдээ та нар бас бясалгах хэрэгтэй. Бясалгахгүй байж болохгүй. Бясалгах нь өөрийнхөө сайн сайхны төлөө болохоос биш, харин Багшдаа харуулахын тулд биш билээ. Зарим хүн энд ирэхээрээ бясалгадаг, гэртээ Багш нь байхгүй байх үед бясалгадаггүй. Тийм биз? Багшийнхаа тайлсан номын талаар асуух асуулт байна уу? Хэрвээ асуулт байхгүй бол одоо хооллохоор бэлтгэе. Эхлээд бурханд өргөх өргөлийн зүйлсээ авч ирээрэй, тэгээд өргөсний дараа сая зооглоцгоох болно.

Бурхан тахих гэдэг нь юу вэ? Энэ нь ихэд билиг нээгдсэн Төгс Гэгээрсэн Их Багш, төрөл төрлийн Төгс Гэгээрсэн Их Багш, арван зүг, гурван цагийн Их Багш, ёс суртахуунтай хүмүүсийг тахихыг хэлж байгаа юм. Хэрвээ тэд байгаагүй бол бид угаас ямар ч үнэ цэнэгүй, ихдээ л зуун жил амьдраад л энэ махан бие ялзарч өмхрөөд ямар ч үнэ цэнэгүй болчихно.

Энэ “Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр” ном (Нэгдүгээр дэвтэр) өчигдөр хэвлэгдсэнд би их баяртай байна. Та нар хариад заваараа уншиж болно. Ингэвэл илүү олон зүйлийг мэднэ. Үүнээс өмнө ном гэмээр юм

үгүй, сар бүр жаахан тараах материал өгөх нь шим тэжээл дутагдаад байх шиг, ер нь өсч бойжиж өгөхгүй байх шиг санагдаад байсан. Харин одоо нэг номтой болсон болохоор нилээд дөхөм болжээ. Энэ нь Нэгдүгээр дэвтэр юм. Хожим Хоёр, Гурав, Дөрөв, Тав, Зургаадугаар... дэвтэртэй болохыг хүсэж байна. Ингэвэл та нарт бүр ч дөхөм болно. Өдөр бүр Багшийнхаа номыг уншихад адислалын хүчтэй болж, билиг ухаан чинь нээгдэж чадна, Багшийнхаа ном тайлахыг сонссонтой бараг адилхан байдаг юм шүү.

Та нар бас Багшийнхаа дуу хоолойг бичсэн хуурцгийг илүүхэн сонсож байгаарай. Жишээ нь, та нарын нойр хүрэхгүй байх юмуу, ямар нэг асуудалтай болох үедээ Багшийнхаа дуу хоолойг бичсэн хуурцгийг тавьж сонсож болно. Унтахдаа Багшийнхаа дуу бичсэн хуурцгийг сонсоод унтвал, сэрснийхээ дараа урьдынхтай адилгүй, өөр болдог юм. Эсвэл Багшийнхаа номыг уншсаны дараа унтвал сэрснийхээ дараа бас адилгүй болсон байна. Бас Багшийн номыг дэр болгон дэрлэж болно. (Ингэж болох юм уу? гэж нэг хүн асуув.) Болно, билиг ухаан чинь улам нээгдэнэ. (бүгдээрээ инээлдэв) (Лус сахиуст зодуулахгүй юу?) Тэгэхгүй ээ. (Гэтэл Бурхны шашны судар номд судрыг дэрлэж болохгүй гэж хэлсэн байдаг.) Багш чинь “болно” гэвэл болно. Би бол орчин үеийн номын багш шүү. (бүгдээрээ инээлдэв)

Орчин үед хүмүүс цаг завгүй яаруу болсон болохоор номоо дэрлэж унтвал илүү сайн сулна. Учир нь та нар ном уншихдаа ихэвчлэн уншиж дуусмагцаа мартчихдаг, номоо дэрлэж унтвал харин санах бөгөөд Багш нь та нарыг сургана. Унтаж байх үеэр нь сургавал хамаагүй хялбар байдаг. Тархи толгой чинь тийм гөжүүд зөрүүд биш байдаг (бүгдээрээ инээлдэв) болохоор нүхэлж цоолоход хурдан, амархан байдаг юм. Мэдээж, номоо бас унших хэрэгтэй, зөвхөн дэрлэхивэл л болчих юм биш, тэгэх нь ач тусгүй. Өдөр бүр бага зэрэг унш, нэг удаадаа дэндүү их унших хэрэггүй. Хэрвээ дуртай бол нэг удаадаа бүгдийг нь уншиж дуусгасан ч болно, гэхдээ өдөр бүр нэг хэсгийг уншиж байвал сайн. Учир нь энэ бие махбод өдөр бүр хоол идэж байдагтай адилаар, оюун ухааныг ч гэсэн өдөр бүр асарч тэжээх хэрэгтэй. Та нар бас Багшийнхаа дуу хоолойны бичлэгтэй хуурцгийг сонсож байж болно. Ингэвэл та бүхний бясалгал түргэн дэвшихэд тустай шүү. Ойлгож байна уу? Та нарын бясалгалын дэвшилт дэндүү удаан байна.

Хэрвээ та нар бүтэн өдөр зав чөлөөгүй, тэр бүү хэл, шөнө орой ч бас цаг завгүй бол унтах үедээ Багшийнхаа дуу хоолойг бичсэн хуурцгийг тавьж болно. Багш нь ярихаараа ярьж л байг, чи унтахаараа унт. Ингэх нь бас ач тустай. Бид арга бүхнээ сүвэгчлэн ашиглаж байгаад бясалгах хэрэгтэй. Учир нь одоо үеийн хүмүүст цаг хүрэлцэхгүй, бас дээр нь гадны нөлөө их, адын саад ч их. Адын саад гэдэг нь ад чөтгөртэй адил юм биш. Тэр нь бидний өөрсдийн үүсгэсэн эргэн тойрны уур амьсгал, цөмийн зэвсгийн эргэн тойрны нөлөө, цацраг туяаны нөлөө юм. Тиймэрхүү эргэн тойрны уур амьсгал бидэнд маш их нөлөөлдөг.

Хэрвээ болдогсон бол долоо хоногийн нэг өдөр мацаг барьж байвал

зохилтой. Тэгж чадахгүй бол юу ч бодохгүй байж, тархи толгойгоо нэг өдөр хоослох хэрэгтэй. Энэ нь манай Бурхны шашинд байдаг “Увш ув санжаагийн найман сахил” юм. Та нар “Увш ув санжаагийн найман сахил” ямар утгатайг мэдэж байх ёстой. Өлсгөлөн явж, судар ном уншаад л болчих биш, харин Арьяабалын номын цогцосыг бясалгах нь сая жинхэнэ “Увш ув санжаагийн найман сахил” болно. Аялгууны урсгалаар үйл түйтгэрээ угааж, гаднах нөлөөгөө цэвэрлэвэл бид бясалгах аливаа нэг завшааныг ашиглах боломжтой болж чадах юм. Хэзээ ямагт, цаг үргэлж ердөө л бясалгаж байвал зохино. Унтах үедээ бас бясалгана, Багшийнхаа дуу хоолойг бичсэн хуурцгийг тавиад унт. Машиндаа ч бас дуу бичсэн хуурцаг тавь, эсвэл машинд сууж байхдаа бясалгал хийх юмуу, Багшийнхаа номыг уншиж болно. Ингэвэл сая бясалгалын дэвшилд чинь ач тустай болно.

Та нарын бясалгалын дэвшилт тун удаан, надад хүлээх тэсвэр тэвчээр алга. Авшиг хүртээд хоёр сар болчихсон байхад урьдахтайгаа адилхан өсөж дэвшээгүй байсаар л байна. Харьсныхаа дараа Багшийнхаа бясалгаж байгаа номын цогцосыг дэрлэж унтсанаас биш, бясалгаагүй байна. Тийм биз дээ? Багшдаа туслахыг хүсье! Гуйж найдья! Багш чинь өдөр бүр хоёр цаг хагасыг л та нараас гуйя, болох уу? Надад мөнгө өгсний хэрэггүй, зөвхөн өдөр бүр хоёр цаг хагасаа өгөх нь л хангалттай. Багш нь идэх хоолгүй бол хээрийн ногоог идсэн ч амьдарч чадна. Гэтэл та нар бясалгахгүй бол энэ гараг дэлхий удахгүй мөхөж сөнөнө, ойлгож байна уу? Хээрийн ногоо Багшийн чинь биеийг тэжээж чадна, мөнгө зоос хэрэггүй.

Багшийгаа тахих хамгийн сайн арга нь Арьяабалын номын цогцосыг бясалгах юм, хэдий чинээ их бясалгавал төдий чинээ сайн. Мэдээж, заримдаа та нар хоёр цаг хагас бясалгаж чадахгүй байдгийг би мэднэ. Гэвч бололцоо л гарвал хичнээн л бол төчнөөн бясалгах хэрэгтэй. Хэрвээ цаггүй бол ариун цэврийн өрөөнд орох цагтаа бясалгаж болно, тэнд та нар арван минут бясалгаж болно. Хэрэв ариун цэврийн өрөөнд орох цагтай байгаа бол бясалгах цаг ч бас байж болно, тэнд бас бясалгаж болно, тийм үү, үгүй юу? Ариун цэврийн өрөөнд орох үед хэн ч таныг үймүүлэхгүй, арилжаа наймаагаа ч бодохоо болино, эхнэр, нөхөр тань хаалганы цаана байх зуур та арван минут амар тайвнаар бясалгаж болно шүү дээ. Хооллох цаг байгаа юм бол бясалгах цаг ч бас байх ёстой.

## БАГШ ХИМАЛАЙ УУЛАНД БАЙСАН НЬ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай  
Формоса, Тайбэй хотын Шиндиан  
1986 оны 8 дугаар сарын 23 (Эх нь хятад хэлээр)*

Хималай уул бол дэлхий дээрх хамгийн өндөр нуруу билээ. Тэндхийн уур амьсгал тун хүйтэн, хагас жилийн туршид уулан дээр гарах боломжгүй байдаг. Хурсан цас нь маш гүн, зузаан болохоор юугаар ч ухаж, нэвтрэх зам гаргаж чадахгүй. Нэвтрэх зам гаргалаа гэхэд цас ихээр лавсан орж байдаг учраас хагас цаг болоход л эргээд цасаар битүү хучигдчихдаг. Эндхийн газар нь өргөн уудам, газрын байц нь маш эгц өндөр, уур амьсгал нь хүйтэн жихүүн. Хилийн зааг дээр цэргийн анги, хил хамгаалах цэрэг байрлан хуарагнаж байдаг бөгөөд тэдний сууж байгаа газар нь харьцангуй тэгшхэн боловч бас их өндөрт оршдог. Тэнд хүрье гэвэл хамгийн тохиромжтой нь Григорийн тооллын зуны тавдугаар сараас эхлэн очиж болох боловч эрхбиш тэндхийн суугуул цэргүүд багажаар цас малтахыг хүлээж, тэднийг малтаж байхтай нь зэрэгцэн машинаа жолоодон дагаж явна. Гэсэн хэдий ч энэ нь заримдаа маш аюул түгшүүртэй байдаг, учир нь заримдаа цас нурах юмуу, эсвэл том том мөсөн хавтан унаж ирээд явах замыг эвдлэн сүйтгэж орхидог.

Хималай уулын ихэнх газар нь маш нэр алдартай бясалгалын орон бөгөөд уур амьсгал нь тун хүйтэн. Энэтхэгт маш олон номын багш байдаг учраас газар сайгүй тэдний ул мөр байдаг ч тэднийг хайж олоход маш бэрх. Зарим бясалгалтан мөсөн агуй малтаж, дотор нь ороод хувцас хунар ч өмсөөгүй сууж байдаг. Зарим нь хоол ч иддэггүй, учир нь тэндхийн уур амьсгал тун цэвэр ариун. Хэрэв та нар өөрийнхөө бясалгаж байгаа номын цогцос дээр нэмж өөр нэг номын цогцосыг бага сага бясалгавал хоол идэх шаардлагагүй болно, мөн өвөл хүйтнийг мэдрэхгүй, даарахгүй байж чадна.

Хувцас өмсдөггүй бясалгалтныг би олж үзсэн удаа бий. Намайг Энэтхэгт очих үед тавдугаар сар, зун болж байлаа. Тэр бясалгагч зөвхөн богино өмдтэй, гутал өмсөөгүй байв. Тэр үед цас мөс гүн зузаан хэвээр, гадаа их хүйтэн байсан учир европ хүмүүс нөмрөг, дах нөмөрч, цасны хувцас өмссөн байв. Би тийм ч зузаалаагүй боловч хүзүүтэй битүү ноосон цамц, зузаан жийнсэн өмд өмсөөд гадуураа борооны цув



нөмөрсөн байлаа. Багш нь л ингэж нимгэн хувцасласнаас биш, ихэнх хүн маш зузаалсан байжээ. Гэрт байсан ч маш хүйтэн байсан тул зузаан хөвөнтэй хөнжил нөмрөх хэрэгтэй болж байлаа. Гэтэл тэр бясалгалтан их өндөр нуруутай, арьс нь хүрэгтэй улайчихаад ганцхан богино өмд өмчихсөн хаа сайгүй явж байхад ямар ч асуудалгүй байсан, тэрээр маш удаан хугацаанд бясалгасан бололтой.

Тэндхийн зун нь манай эндхийн өвлөөс хүйтэн байдаг, гэтэл ийм хүн байдаг гэдэгт та нар итгэх үү? Үзээгүй, хараагүй болохоор итгэхгүй байж мэднэ, гэвч Багш чинь хэлсэн болохоор итгэж болно. Өөр бусад маш олон бясалгалтан бас яг тийм байдаг. Тэд арай олон хувцас өмссөн байж мэдэх ч тийм ч их биш, хоёр гурван хувцас юмуу, эсвэл ямар нэг юм нөмөрчихвөл болчихдог. Тэдэнд хүйтнээс хамгаална гэхээр зүйл бараг байхгүй, учир нь тэд нааш цааш явган явдаг болохоор тийм их зүйл авч явах боломжгүй, тэгээд ч үүндээ дасчихсан байдаг.

Зарим бясалгалтан хувцас гэмээр юм юу ч өмсдөггүй. Хэсэг даавуугаар өөрийн нууц хэсгээ далдалснаас өөр тэдний биед хүйтнээс хамгаалах зүйл байхгүй, бүх биедээ ердөө л үнс түрхчихсэн байдаг. Тэд бол жинхэнэ бясалгалтан хүмүүс. Тэд яагаад ингэж байна вэ? Нэгд, тэд ингэж заншсан. Хоёрт, тэд маш их итгэл зоригтой. Бид ч гэсэн юу л хийе гэвэл юуг хийж чадна, хэрэв тэгье гэж хүсвэл өөрийн биеэ тэгж дадуулж чадна, энэ нь боломжгүй зүйл биш билээ.

Гурван сарын өмнө би Энэтхэгт байсан. Тэр үед Энэтхэгийн арван хоёр жилд нэг удаа хийдэг бясалгалтны Их хурал цуглаантай яг таарсан билээ. Энэтхэгт нэр нь ихэд алдаршсан их ариун дагшин дөрвөн газар орон, өөрөөр хэлбэл ном гурах газар байдаг. Түүний дотроос нэгийг нь Hariward (Харивард) гэнэ. Наг гэдэг нь хан хурмаст, бодьсадва, бурхан гэсэн утгатай. Hariward гэдэг нь “Диваажинд нэвтрэх үүд”, “Хан хурмастад хүрэх хаалга” гэсэн утгатай юм. Тэдний хурсан энэ жилийн номын хурал дээр маш олон нүцгэн бясалгалтан байхыг би харсан, ийм хүмүүс одоо ч гэсэн байдаг.

Тэд ялимгүй жаахан бөс даавуугаар нууцын орноо халхалж байдаг бөгөөд хоол идэх үедээ маш олон үйлдэл хийдэг. Бидэнтэй адил бурхан, ном, хуврагийг арван хэдхэн минут дурсах төдий биш. Тэд нэг зүйлийн хөдөлгөөнөө хэд хэдэн удаа давтдаг, тэдний идэх юм нь ч тун энгийн, бусдын өргөсөн тахилын идээ төдийхөн. Тэд байгалийн сав хэрэгслийг ашигладаг, том зузаан навч болон байгалийн ширхэглэг ургамлаар аяга, таваг сүлжиж, дотор нь бага сага идэх юм хийгээд маш олон хөдөлгөөн үйлддэг. Тэд юу хийж байгааг бүү мэд. Ингэж хэд хэдэн удаа давтаад байхыг нь хараад миний залхуу хүрч, тэд ингэж байхдаа өлсдөггүй л юм байх даа гэж дотроо бодож байлаа. (бүгдээрээ инээлдэв) Энэ нь үнэхээр тун төвөгтэй, хожим нь тэд түүнийгээ идсэн үгүйг нь би олж үзээгүй.

Номын Их хурлын тэр өдөр хуралд оролцсон бясалгалтан бүгдээрээ Ганга мөрний хөвөөнд очиж биеэ угаан цэвэрлэснээс хойш өнө мөнхийн хувраг болж, их бясалгалтан болж, богд хүн болж, богдчуудын бүлэгт



Бясалгал хийж гэгээрсэн хүнийг харахад ямар ч онцгой шинж байхгүй байж магад, гэвч түүний царай зүс нь тун гэрэл гэгээтэй, сэтгэл нь маш уудам, өршөөнгүй, тусархаг, бусдад ач тустай л бол аливааг даруй хийдэг, түүнд аминч үзэл байдаггүй.

*“Сүнс гарах болон түүнчлэн ирсэн байдал адилгүй” айлдвараас*



Бидний нуугдмал хүч чадал асар их. Хэрвээ бид сайн бясалгаж, өөрийн биедээ бүрэн дүүрэн итгэлтэй байвал ямар ч хэрэг явдлыг хийж чадах боломжтой.

*“Багш Хималайн ууланд байсан нь” айлдвараас.*

нэгдэн ороод дахиж хэзээ ч гэртээ харьж гэрлэж, хар хүн болохгүй, эсвэл арилжаа наймаа хийхгүй байх болно.

Тэдний ихэнх нь тун залуу боловч бие нь тун хар. Энэ нь үнс түрхсэнээс болсон байж болох ч бие нь хав хар, африк хүн гэмээр, яг л хар будгаар будчихсан юм шиг хар байсан. Гэхдээ бие нь тун чийрэг, хатуу бясалгал хийсэн янз байдалгүй, тэд хамтдаа зэрэгцэн сууж байх нь асар сүр жавхлантай ажээ.

Тэд өөр зүйлийн юм иддэг ч байж магадгүй, тэрийг нь би мэдэхгүй. Тэдэнд төө хэрийн хулс бий, түүнийгээ савх болгон хоол идэхээс өөр эд хөрөнгө гэмээр юу ч үгүй. Бидэнд хүйтэнд гадуур өмсөх урт, богино, шар, улаан гээд элдэв янзын хувцас байхад тэдэнд юу ч үгүй. Нэгэн богд хүн болох нь ийм л байдаг, биеэ халхлах хэсэгхэн бөс даавуунаас өөр юу ч үгүй. Тэд биеэ халхлах өөр зүйл огт хэрэглэдэггүй, өвөл, зунгүй ийм л байдаг. Бүр Хималай ууланд байсан ч ялгаагүй, тэд биедээ ямар ч юм нөмөрч халхлахгүйгээр тэсэж тэвчиж даджээ. Тэд аажмаар, хатуужилтай бясалгадаг. Бясалгал хийснээр тэдний бие нь маш сайн байж, орчиндоо дасан зохицож чаддаг. Бид биеэ бас тэгж сургаж дадуулж чадна, боломжгүй зүйл биш.

Би нэг түүх олж сонссон нь Англи улсад нэг эмэгтэй байжээ. Тэр энгийн нэгэн гимнастикч бөгөөд зарим үед хоол унданд тэгж их дурладаггүй байсан гэнэ. Тэр хэлэхдээ, ууланд гарч цасан дээр гулгахад тэндхийн агаар сайн байсан учир гурван сараар юу ч идэхгүй байсан ч хамаагүй байсан, гэтэл Лондон хотдоо буцаж иртэл агаар бохир болж, хүн бүхэн яаран бужигналдаж, сэтгэл нь хөөрч байдаг тул, тэрээр ууланд байснаасаа өөр болоод хоол идэхээс өөр аргагүй болсон гэнэ. Ууланд байхдаа хоол идэхгүй байж чадна, харин харьж ирсний дараа тийм байх боломжгүй болсон гэж тэр ярьжээ.

Ууланд байсан гурван сардаа тэр үнэхээр юу ч идээгүй мөртлөө бие нь муудсангүй, бие нь маш эрүүл чийрэг, тун ч тааламжтай байсан гэнэ. Тэрээр өвөл өндөр ууланд цас орох үеэр богино түрийтэй гутал өмсөөд нөмрөх юмгүйгээр гадуур явж, гурван сар юу ч идээгүй байтал биед нь маш тааламжтай байжээ. Гэтэл бохирдсон агаартай газарт буцаж ирэхэд тийм байж чадахгүй болно. Бидний бие махбод олон зүйлийг сурч дадаж чадна. Хэрэв бид цаг завтай байгаад жинхэнээр бясалгах юм бол агаарын бохирдолтой нөхцөлд ч гэсэн мацаг барьж чадна.

Саяхан нас барсан нэгэн гэлэнмаа Миаолид байж билээ. Тэр юу ч идэлгүйгээр хорь гаруй жил болсон, магадгүй, бага зэрэг ус уудаг байсан байх. Иймэрхүү байдал нь Энэтхэгт тун энгийн хэрэг юм. (Ингэж бясалгавал гадаад номтон болох уу? гэж нэг хүн асуув.) Яагаад гадаад номтон болох гэж? Буруу номын цогцосыг бясалгавал гадаад номтон болно, сайн номын цогцосыг бясалгавал ямар ч асуудалгүй. Гадаад номтон, дотоод номтны ялгаа нь сэтгэл дотор байхаас биш, гадна талд байдаггүй. Энэтхэгт номын хурал дээр миний олж харснаар тэдний ихэнх нь эрэгтэй, ердөө хэдхэн эмэгтэй хүн байсан. Гэхдээ тэд



цөм шар хувцастай, тэдний дунд хатуу номын цогцосыг бясалгадаг хүн байгаагүй. Зарим хүн маш хурц үзүүртэй хадаастай орон дээр сууж байхыг би харсан. Ингэж бясалгаж байх нь гадаад номтон, эсвэл дотоод номтны алинд нь харьяалагдахыг би яримааргүй байна, гэхдээ тэдэнд жинхэнэ ийм чадал байгаа юм. Тэд гадаад номтон уу, дотоод номтон уу гэдгийг би мэдэхгүй, энэ нь надад хамаагүй. Ямартаа ч тэднийг харах үедээ би хүндэтгэж, ийм бясалгалтан олж харсандаа маш их баярласан билээ.

Зарим гэрээс гарагчид нь шар хувцастай, зарим нь цагаан хувцастай байв. Хувцсаа шараар будах зэрэг учрыг хамааралгүйгээр тэд зүгээр л цагаанаар нь өмсөж байсан ч үүнийг хэн ч тоож анзаарахгүй байв. Тэднийг хармагц маш удаан бясалгасан нь мэдэгдэнэ, тэд заавал шар хувцас өмсөх шаардлагагүй. Тэд маш удаан хугацаанд салхинд гандаж, бороонд норж, арьс хөрс нь бараан өнгөтэй, хатуу болсон тул тэднийг шумуул, чичүүр хорхой хүртэл хатгаж чадахгүй болдог, (бүгдээрээ инээлдэв) тэд хатгангуутаа хошуу нь хугараад хожим хүний цусыг дахин сорж чадахгүй болж ч магадгүй. (бүгдээрээ инээлдэв) Тэдний зарим нь маш залуу бөгөөд тун сүр жавхлантай. Тэд бөсөөр хийсэн богино өмд өмсдөггүй, оронд нь төмөр ялтсаар биеэ ороогоод эмэгтэй хүнтэй өнө үүрд ойртохыг хүсэхгүй байдаг. Үүнээс өөр юу ч өмсдөггүй, тэд энгийн үедээ модон доор суун судар уншиж байдаг.

Нэг хүн хэрэв хувцас өмсөөгүй бол гадаад номтон мөн гэдгээ илэрхийлж байгаа хэрэг биш, ойлгож байна уу? Ийм байх нь бясалгал хийхэд нь илүү амар хялбар байдаг байж мэднэ. Урьдаар өөрийгөө хатуу ширүүн байдалд дадуулвал, хожим хүссэн газар луугаа явж чадах бөгөөд тийм их зүйл, эсвэл ачаа тээш авч явах хэрэггүй болно. Би бас тийм эрхт хүн болохыг хүссэн боловч энэ биеэ тэгж дадуулах цаг олдсонгүй. Одоо бас шавь нартаа уягдчихаад байна. Тиймээс л би урьд нь шавь сургахыг хүсдэггүй байсан юм. Би чөлөөтэй байж, дүүлэн нисэж, маш олон юм сурч, өөртөө маш олон зүйлийг давтан дадуулахыг бодож байсан ч одоо аргагүй болжээ. Та нар улам чанга зуурчихаад тавихгүй болсон учраас явж чадахаа больжээ. Одоо та нар энэ нэг бүрэн төгс биш Багшийгаа хүлээж авах л хэрэг болж дээ. (бүгдээрээ инээлдэв) Би өөрийн дураар байж чадахгүй болсон, хувцас өмсөх ёстой, хоол идэх ёстой, унтах ёстой. Гэхдээ хамаагүй ээ, яасан ч гэсэн бүгд адилхан л даа.

Тэр йогийн бясалгалтнууд хамаг төрөлтөнд яршиг төвөг удахгүй, идэх, унтах, хувцас өмсөх зэрэгт сэтгэл зовохгүй гэж том ам гарсан ч байж мэдэх юм. Тиймээс тэд биеэ даахад болон амьдралд шаардлагатай зүйлсээ багасгахад өөрсдийгөө сургаж дадуулдаг.

Сайн номын цогцосыг бясалгах нь дотоод номтон, харин хар зүгийн ид шид, зөн билгийг бясалгах нь гадаад номтон болно, Өмссөн хувцас тань таныг гадаад номтон болгодог юм биш. Хэрвээ сайхан хувцас өмссөн ч сайн номын цогцосыг бясалгахгүй бол бас л гадаад номтон болно. Юу идсэн ч хамаагүй дотоод номтон болоод юм идэхгүй бол гадаад номтон болчихдог юм биш. Идэх, идэхгүй байх нь нөхцөл

байдлаас шалтгаална. Жишээлбэл, Хималай ууланд Арьяабалын номын цогцосыг бясалгаж байх үед тэнд идэх юм байхгүй, эсвэл дэндүү ховдоглон идэж болохгүй тул гэсвэрлэх хэрэгтэй болсон ч нэгэн адил зөв номтон болно. Бас жинхэнээр нь “Мөр”-д орж чадаагүй бол гадаад номтон болох юм. Шагжамуни Бурхан амьд сэрүүн байхдаа: “Тэр мэтийн гадаад номтон бясалгаад амжилтанд хүрч чадахгүй” гэж ном тайлахдаа айлдсан байдаг. Учир нь тэр үед энэ дэлхийд амьд сэрүүн бурхан байсаар байтал тэд ирж, түүнийг дагаж бясалгахгүй, өөрсдөө бас бие даан бясалгаж чадахгүй байсан учраас Бурхан багш тэднийг гадаад номтон гэж хэлснээс биш, хувцас өмсдөггүй одоо, өнгөрсөн, ирээдүй аль ч цагийн хүн бүгдийг гадаад номтон гээгүй юм.

Хувцас өмсөж байсан ч нэгэн адил гадаад номтон болж болно. Үсээ хусчихаад, хуврагийн хувцас өмслөө ч гадаад номтон болж болно. Сэтгэл дотроо алдар нэр, ашиг хонжоо хөөцөлдөж, зөн билигтэй болохыг хүсэж, том сүм хийдтэй болохыг шунаж, ид шидтэй болоод бусдаар хүндлүүлэхийг боддог хүн ямар хувцас өмссөн ч хамаагүй, бүгдээрээ гадаад номтон болно. Танд ямар нэгэн амьд сэрүүн Их Багш ном уламжилж өгөөгүй бол та мөн л гадаад номтон болно. Гадаад номтны томъёолол тодорхой байх ёстой. Бурхан Багшийг амьд сэрүүн байх үед л гадаад номтон байгаад одоо байхгүй болчихсон юм биш, эрин цаг бүрт гадаад номтон байдаг. Хэрвээ сэтгэл тань “дотооддоо” хандахгүй бол “гадаад” л болно.

Энэтхэгт маш олон бясалгалтан өдөрт нэг удаа л хооллох юмуу, эсвэл зөвхөн өглөөний хоол идээд үдийн хоол болон оройн хоол иддэггүй. Тэд бас ганц биш, маш олон зүйлийн номын цогцосыг бясалгадаг. Тэд газар сайгүй явж, Их Багшийг эрж хайн Мөрийг сурвалжилж, энэ багшаас сурч, тэр багшаас суралцаж байдаг бөгөөд тэдэнд тогтсон гэр гэж үгүй, тэд хаа очсон ч явган явдаг болохоор бие нь хар өнгөтэй болоод эрүүл чийрэг, хэнийх нь бие илүү хар бол тэр хүнийг хэр их бясалгасныг нь мэдчихмээр. Тэдний бие нь өндөр тарган биш, намхан жижиг байж болох ч маш чанга, чийрэг байдаг. Хэрвээ тэд ой хөвчид суунал тэндхийн шумуул цөм өлбөрч үхэж мэднэ. (бүгдээрээ инээлдэв) Чичүүр хорхой түүний “дотоод хүч чадал”-ыг бишрээд хойшид номд нь орж, түүнээс таван сахил хүртэж ч магадгүй. (бүгдээрээ инээлдэв) Тиймээс тэд ууланд амьдрахдаа могой, бараас айхгүй, учир нь бар хазаж дийлэхгүй болохоороо тэднийг яах ч аргагүй. (бүгдээрээ инээлдэв) Миний бодлоор тэдний арьс нь тун хатуу тул хадаас ч нэвтлэхгүй. Тэд өдөр бүр бясалгаж суудаг, идэх, унтахдаа хүртэл бясалгаж, зөвхөн нэг минутын хэр бясалгах төдий байдаг биш болохоор тэдний дотоод хүч чадал ямар вэ гэдгийг та нар гадарлаж болно.

Иймэрхүү байвал бар ч тэднийг яах ч аргагүй байх. Барын араа шүд нь айхавтар хэцүү боловч төмөр хадаасны дайтай хатуу, хурц биш болохоор тэд бар, арслангаас айдаггүйн учир нь үүнд байгаа бололтой. Хэрвээ та нар Багшдаа хэдэн жилийн чөлөө өгөөд тэднээс суралцуулдаг юм бол хожим харьж ирснийхээ дараа илүү олон түүх ярьж өгч болох

юм. Гэвч энэ бүхэн нь өчүүхэн бага эрдэм чадал болохоос, үнэндээ хамгийн дээд нь биш. Та нар сонсохыг хүсээд байгаа болохоор л би ярьж өгч байна. Гэвч билиг ухаантай болж туулан гэтлэх нь хамгийн чухал гэдгийг ойлгох хэрэгтэй.

Зарим хүн гал дотор ороод ч шатдаггүй. Иймэрхүү явдал Нью-Йоркод бас болж байсан бөгөөд заримдаа сонинд ч нийтэлж байсан. Бид бас ийм номын цогцосыг бясалгаж чадна. Энэ нь маш хурдан, бараг зургаан цаг хэртэй бясалгавал болчих боловч эрхбиш жинхэнээр итгэх хэрэгтэй. Хэрэв эргэлзээ сэжиг тасрахгүй юм бол галын дундуур явж байх зууртаа шатаж ч мэднэ. Өөрийн биедээ маш итгэлтэй байх ёстой. Хэрвээ нэг талаар тарни уншиж, нөгөө талаар итгэхгүй юм бол энэ нь тусгүй болоод шатаж мэднэ. Гэхдээ зарим хүн шатдаггүй, энэ бол үнэн явдал, худал юм биш.

Бидэнд нуугдмал асар их хүч байдаг. Хэрвээ бид сайн бясалгаж, өөрийн биедээ бүрэн дүүрэн итгэлтэй байвал ямар ч учир явдлыг хийж чадах боломжтой. Тиймээс та нар Бичин багшийг хар л даа. Тэр нэгэн сармагчин байтлаа тийм сайн бясалгаад далан хоёр зүйлээр хувиж чадах зөн билигтэй болсон билээ. Сармагчин хүртэл хийж чадаж байхад бид яагаад хийж чадахгүй байх билээ?

Одоо та нар юу бясалгах гэж байна вэ? Ус, гал, эсвэл мөсийг бясалгах гэж байна уу? (**Асуулт:** Идэхгүй байхыг бясалгах номын цогцос бий юу?) Та идэхийг хүсэхгүй байна уу? (**Хариулт:** Хоол идэх нь даанч яршигтай.) Болохгүй, та юм идэхгүй гэвэл эд маань ирэхдээ бүгд танд идүүлэх гэж юм авч ирэх болно. Ингэвэл хоол идэхээс ч яршиг төвөгтэй болно. Тайваньд энэ аргыг бясалгаж болохгүй, та хүсвэл Хималай ууланд очиж өөрийн биеэ битүүмжилж байгаад бясалгах хэрэгтэй. Гэхдээ таныг тийм орчин ахуйг тэвчиж тэсэж чадахгүй байх гэдгээс би айж байна. Өчигдөр та гал ноцоох нь хар яршиг, яагаад гэр ахуйн хий хэрэглэж болохгүй юм гэж надад хэлж байсан. Хималай ууланд ахуйн хий ч, мөн тань шиг залуу авхайн биеийг угаачих халуун ус ч байхгүй билээ.

Олон хүн Хималай ууланд очоод хэзээ ч буцаж ирээгүй. Бүр мөргөл хийхээр ууланд очлоо гэхэд ч маш аюултай байдаг. Хэдийгээр олон хүн тэнд очихыг хүсдэг боловч айгаад явдаггүй. Би очихоосоо өмнө энэ нь тийм их аюултай гэдгийг мэдээгүй байсан. Хэрвээ урьдаар мэдсэн бол айгаад очиж зүрхлэхгүй ч байсан байж мэднэ. (бүгдээрээ инээлдэв) Хималай уулнаас буцаж ирсний дараа, Та тэнд очоод яаж буцаж ирж чадав аа? гэж маш олон хүн надаас гайхан асууж байсан. Яагаад буцаж ирж чадахгүй болно гэж? хэмээн намайг асуухад тэнд очиход ямар их, зүйл зүйлийн аюул түгшүүртэй байдал гардгийг тэд надад хэлж өгсөн ч, би нэгэнт очоод ирчихсэн байлаа.

Америкт байсан нэг Энэтхэг хүнд би Хималай ууланд очсоноо ярихад тэрээр: “Би Энэтхэг хүн мөртөө одоо болтол тэнд очиж зүрхлээгүй байтал, та тэнд хүрчихэнд би үнэхээр их биширч байна” гэж



хэлсэн ч, өөрөө очих зориг түүнд байгаагүй. Энэтхэг хүмүүсийн талаас илүү нь тийм газарт очиж үзээгүй бөгөөд миний очоод ирсэн газарт тэд аймшиггүйгээр очиж зүрхлэхгүй.

Намайг дөрөв, таван жилийн өмнө очих үед зарим газар нь явганаар гуч, дөчин километр явах хэрэгтэй болж байв. Тэгээд бас тэр нь тэгш бус, энхэл донхолтой уулын зам болохоор шавар шалбаагтай зам нь тод харагдахгүй, халтиргаа ихтэй бөгөөд аюултай. Зарим газартаа зөвхөн ганц хүн явж болох явцуу нарийн замтай. Хималай уул нь маш өндөр, хэрвээ та санамсаргүйгээр уначихвал шороо тоос болчих магадлалтай. Тэгвэл булшлах шаардлагагүй болохоор тун цэвэр ариун байх биз. (бүгдээрээ инээлдэв) Хэрэв Ганга мөрөнд уначихвал яг сайхан угаан ариутгагдсаны дараа диваажингийн оронд очно шүү дээ. (бүгдээрээ инээлдэв) Ганга мөрөнд биеэ угаавал туулан гэтэлж чадна гэж Энэтхэг хүн итгэдэг болохоор ингэж унасан ч зүгээр, тэр дороо туулан гэтлэх юм.

Ганга мөрөн нь Энэтхэгийн ариун дагшин мөрөн болохоор тэнд өдөр бүр хүмүүс биеэ угааж байдаг. Гайхалтай нь тэд биеэ угаана, хувцсаа угаана, элдэв юм хумаа бүгдийг нь энэ мөрөн лүү хийдэг байтал Ганга мөрний ус нь хоргүй байдаг. Манай энд химийн хор арилгах маш олон зүйлийг усанд хийдэг ч гоожуурын усыг уувал өвчин тусна. Харин тэд Ганга мөрний усыг өдөр болгон уусан ч өвддөггүй.

Хималай ууланд Ганга мөрний хоёр эргийн зарим газарт нойтон хамуутай хүмүүс байдаг. Тэдний ялгадас нь бас Ганга мөрөнд ордог. Энэтхэг хүмүүс эрүүл ахуйн ариун цэвэр гэдэг зүйлийг бараг мэдэхгүй. Мөрний урсгалын доод хэсэгт байгаа хүмүүс бүгд Ганга мөрний уснаас ууж ундаж, тухалж тоглож, биеэ угааж байсан ч ямар ч асуудал гардаггүй. Багш нь бас тэр уснаас ууж л байсан. Өдөр бүр биеэ угаахын сацуу бага сага амталж байлаа. Учир нь өдөр нь аагим халуун байдаг бөгөөд өөр уучихмаар зүйл олдохгүй, гэвч уусны дараа бас ямар ч асуудал гараагүй билээ.

Харин дээд хэсгийн ус нь маш ариун, тунгалаг, эрдэнийн чулуу мэт ногоорон харагддаг, маш гоё. Зарим газар нь тод цэнхэр, нэг зүйлийн номин огторгуйн цэнхэр хөх өнгөтэй, гойд гоёыг нь харахаас биш, зурж гаргаж чадахааргүй. Тэнгэр нь цэлмэг, ямар ч үүлгүй, нар нь маш том харагддаг, нарс модод нь эгц шулуун, ус нь ариун, цэвэрхэн байдаг. Замаар явахад доод талаар нь тув тунгалаг Ганга мөрний номин цэнхэр ус урсаг болохоор алхаж байхдаа ядарч зүдрэхийг ер мэдэрдэггүй, нэг талаар зам хөөж, нөгөө талаар юм үзэж харж явдаг, энэ нь үнэхээр үзэсгэлэнтэй сайхан. Ганга мөрөн зарим хэсэгтээ өргөн, зарим хэсэгтээ давчуу боловч тийм ч нарийхан биш. Ганга мөрний эх ундарга нь Хималай уулнаас ундаргатай боловч Энэтхэг хүмүүс Ганга мөрний усыг диваажингаас бууж ирдэг гэдэгт эргэлзээгүй итгэдэг юм.

Ганга мөрний ус дэлхийд хосгүй. Аливаа бузар муухай юм Ганга мөрөнд унавал тэр нь цэвэр ариун болохоос биш, усыг нь хортой

болгодоггүй. Эрдэмтэн, судлаачид Ганга мөрний усыг шинжилж үзэхэд ямар ч хортой зүйл юмуу, эсвэл нян олж илрүүлсэн удаа байхгүй. Тиймээс Ганга мөрөнд хүн орж биеэ угаагаад уснаас нь уухад ямар ч асуудал гардаггүй. Хэрвээ Ганга мөрний усыг лонхонд савлавал арван жил хадгалсан ч муудахгүй, анх савласантайгаа адил цэвэр ариун хэвээр, ууж болдог. Энгийн ус харин муудаж, өмхийрдөг боловч харин Ганга мөрний усыг арван жил хадгалсан ч ямар ч асуудалгүй байдаг.

**(Асуулт:** Энэтхэгт яагаад арван хоёр жилд ганцхан удаа бясалгалтны их хурал цуглаан болдог вэ?) Энэтхэг тийм өргөн уудам болохоор яаж өдөр бүр хурал цуглаан хийх боломж байх вэ? Гэтэл тэд энгийн үедээ бас бясалгалаа хийх хэрэгтэй. Тэд бол жинхэнэ битүүмжлэн хааж бясалгадаг хүмүүс. Хималай уулын өндөрлөг газруудад очиж бясалгаад хэдэн арван жил харьж ирдэггүй болохоор, ингэж арван хоёр жилд нэг удаа хийх нь тэдэнд бас дэндүү хурдан болчих шиг санагддаг байна. Тэдний бясалгах нь нэг, хоёрхон жил ч биш, хэдэн арван жил, зуун жил, мянган жилээр бясалгадаг. Зарим хүн зуун жил, бүр мянган жил бясалгасан байдаг ч мөн амьдарсан хэвээрээ л байдаг. Энэ нь бидний эндхийнхтэй адилгүй, бид нэг, хоёр өдөр бясалгавал ядарч, их гэж боддог. Гурав хоногийн даяаны сүүлийн өдөр болоход бид аль хэдийнээ: Маргааш дуусгаад гэртээ харина. Эхнэр, нөхөр минь намайг гэртээ хүлээж байгаа. Арилжаа худалдаа маань намайг хүлээж байгаа. Эр нөхөр минь гэртээ юу гэж байгаа бол? Сурагчид маань намайг бас хүлээж байгаа даа гэх зэргээр боддог. Бид өөрсдийгөө дэндүү чухалд үзэж, дэндүү цаг завгүй болчихжээ.

Энэтхэгийн бясалгалтнууд тун төвөггүй, өөрийн биеэ чухалд үздэггүй, гагцхүү бясалгах нь хамгийн чухал гэж үзнэ. Тиймээс тэд явж одлоо гэхэд нийгэм ч хэвээрээ, орчлон ертөнц ч хэвээрээ байна гэж боддог. Өөрийгөө их чухал болгож энд үлдчихээд нийгэмд туслан энэ тэр ажил хийж, ийм нэгэн эхнэр хатагтай болохгүй бол, тийм нэгэн эр нөхөр болох ёстой гэж биеэ үздэггүй болохоор энэ бүхнийг тэд цөмийг нь тоож хамаардаггүй. Тэдний “би” гэх үзэл тийм их биш болохоор бясалгал нь тун түргэн, юу ч бясалгасан хамаагүй нилээд амархан бүтэмжтэй байдаг. Би дахин цааш ярихгүй бол дээр байхсан, хэрэв цааш яриад байвал бүр чөлөө гуйж эндээс явж одмоор болж байна. (бүгдээрээ инээлдэв) Ярих тусам чөлөө гуйж, тэнд очиж бясалгаж суухыг хүсээд байх юм.

Энэтхэгийн газар нутаг өргөн уудам, хэрвээ жил бүр тийм том номын хурал цуглаан хийгээд байх юм бол тэд ирж оролцохын аргагүй болно. Учир нь тэд цөм явган явдаг, тэдэнд мөнгө байхгүй, энгийн цагтаа бага сага зүйлээ эвлүүлж нийлүүлээд л идчихдэг. Хэрэв нэг удаад номын хурал хийлээ гэхэд нэг хүн Хималай уулнаас алхаж ирэхэд зургаан сар явж байж хүрч ирж мэднэ. Тэд нэг талаар явж, нөгөө талаар амарч, яарч сандралгүйгээр алгуур аажмаар зам хөөдөг. Яг л бид өдөр бүр бага сага ажилладагтай адил, тэд өдөр бүр багахан зам л туулдаг. Тэд хаа хүрсэн ч, юу л байна түүнийгээ идэж, дууссаныхаа дараа амарна. Дараа нь Ганга мөрөнд биеэ угааж, бясалгаж суух дуртай бол бясалгаж, суух дургүй бол

явдаг. Маргааш нь бас өөр нэгэн газар очоод мөн л тэгж байдаг, ямар ч явдал учиргүй, маш эрх чөлөөтэй, тааваараа байдаг.

Тиймээс зургаан сар, эсвэл нэг жил ч явах магадлалтай. Ингэж явж байж л тэр номын хуралд хүрч ирнэ. Цаг нь түүнийх болохоор урт, богино байх нь хамаагүй. Хаа хүрсэн ч сайн хүмүүс өргөл өргөж, түүнийг залан ном тайлуульж магадгүй, тэгвэл тэр тэнд хоёр сар, зургаан сар суугаад дахин цааш явна. Тэдэнд ингэвэл сайн, тэгвэл муу гэх явдал үгүй болохоор номын хуралд хүрэх эсэх нь ч хамаагүй. Арван хоёр жилийн дараа тэд дахин ирж чадна. Тэдний хувьд цаг давчуу биш, учир нь тэд багаасаа ийм эгэл амьдралаар амьдарч ирсэн тул өөр ямар нэг учрыг боддоггүй. Тэд ном унших, бясалгал хийхийг л мэддэг бөгөөд багаасаа бясалгал дадуулж эхэлсэн ч байж магадгүй, үсээ хусаж, шар жанч өмссөний дараа л бясалгаж сурсан биш юм.

Энэтхэгт маш олон хүүхэд багаасаа бясалган сууж, эцэг, эхтэйгээ хамт бясалган ургамал хоол иддэг билээ. Энэтхэгчүүд ямар шашныг шүтсэн ч хамаагүй, олонх нь ийм дадал зуршилтай байдаг. Тэд оройд гэртээ ирсний дараа судар ном унших, бурхны дуу, тахилгын дуу, эсвэл богдын дууг дуулах, эсхүл судар уншина, судар уншиж бүх гэр бүлийн хүмүүстээ сонсгосны дараа сая унтдаг. Бясалгаж суух эсэх нь өөр нэгэн хэрэг учир болно.

Та нар хэрвээ ийм дадал зуршилтай болохыг хүсвэл бас маш сайн. Оройдоо ажлаа дуусгачихаад хэсэг цаг гарган судар ном уншиж, гэрийнхэндээ сонсгох нь маш их утга учиртай юм. Гэрийнхэн чинь багшаас сурч чадахгүй байсан ч хамаагүй тэдэнд ном уншиж сонсговол бага сага ч гэсэн ёс суртахууны ойлголттой болгож чадна. Бурханы ном, Библи судар бүгд болно. Нэгэн сайн газрыг сонгож байгаад гэрийнхэндээ нэг өдөр нэг хэсгийг нь сонсговол тэд их сайхан унтана. Бурхны судрыг уншиж дууссаны дараа Библи судар, Мөр ёсны судар, эсвэл Күнзийн Шүүмжлэл өгүүлэл ном гэх зэргийг бүгдийг уншиж болно. Юу сурна гэвэл тэдний дураар л болог. Хожим тэд юуг ч сонгон сурч болно, зөвхөн Бурхны шашин, Католик шашныг сур гэсэн биш, ингэх шаардлагагүй.

Шашин шүтлэгтэй болох нь зөвхөн унших төдий л зүйл биш, “Мөр ёсыг дадуулах” хэрэгтэй гэдгийг би жаахан байхдаа нэгэнт мэдчихсэн байсан. Судар номд юу ярьсан байна, бид түүнийг хийвэл зохино. Есүс Христ бясалгаж суудаг, Бурхан Багш бас бясалгаж суудаг байсан. Бурхан Багш ургамал хоол иддэг, Есүс Христ бас ургамал хоол иддэг байсан юм чинь бид бас тийм байх ёстой. Бясалгаж суухдаа ургамал хоол идэхгүй бол бидний бие махбод хүндэрч, таагүй байдал үүснэ.

Номын Их хурлыг арван хоёр жилд нэг удаа хийхэд маш олон бясалгалтан Энэтхэгийн газар газраас ирдэг бөгөөд Энэтхэгийн ерөнхий сайд хүртэл оролцож, хүндэтгэлээ илэрхийлдэг билээ. Тэгээд олноороо нэг доороо цуглаарад бясалгахын учрыг ярьж хэлэлцэхийн зэрэгцээ гэрээс гараагүй хүмүүст тэднээс суралцаж, өргөл барьц өргөн өөрсдийнхөө бясалгалын тухай асуух боломж олгодог. Нэг сарын дараа

тэд бүгдээрээ тэндээс явж үргэлжлүүлэн бясалгадаг юм.

Энэ жилийн дөрөвдүгээр сард би тэр номын хурлаас буцаж Тайваньд ирсэн. Энэ удаагийн номын хуралд Далай лам бас хүрч ирсэн байв. Олон бясалгалтан нэг дороо ингэж хурж цуглардгаас биш, зарим хүнийг онцгойлон урьдаггүй. Далай лам очиж болно, өөр түвд хүн очсон ч болно. Гэвч номын хуралд түвд бясалгалтан тун цөөхөн байгааг би харсан. Тэнд хүн бүр заавал нэг сар байх ёстой гэсэн биш, тиймээс тэд энд ирээд нэг, хоёр өдөр юмуу, үгүй бол нэг, хоёр долоо хоног болоод явчихаж мэднэ.

Хэдэн жилийн өмнө би Далай ламтай нэг удаа уулзсан. Тэр надтай уулзах болгондоо их баярлаж, маш халуун дотноор гар барьж, хамгийн үнэтэй ховор нандин эмнээсээ надад өгдөг юм. Энэ эмийг тэр өөрийн гараар найруулдаг гэнэ. Багшийн чинь биеийг өсөхгүй байна (бүгдээрээ инээлдэв) гэж тэр айсан бололтой, уулзах болгондоо эм авчирч өгдөг юм. Багшийг чинь харахад эцэнхий туранхай, бас жижигхэн өрөвдмөөр болохоор уулзах бүртээ надад эм өгдөг.

Энэ эм маш үнэтэй тул түүний дүү нь хүртэл худалдаж авдаг юм. Би түүнээс эм залах гээгүй байтал Далай лам надтай уулзах болгондоо туслахаа дуудаж, тэр дор нь эм авчруулж, надад өгдөг. Заримдаа тэр тун яаруу, надтай уулзаж ярилцах завгүй үедээ намайг дэргэдээ байлгаж түр хүлээлгэдэг юм. Тэр угаас тун завгүй, Энэтхэгт очих болгонд нь маш олон хүн түүнтэй золгохоор ирдэг. Гэтэл хэдий яаруу байсан ч хамаагүй тэрээр өөрийн цаг заваа гаргаж надтай ганцаараа уулзаж ярилцдаг, тэр надтай маш олон зүйлийн талаар ярилцах гэхэд нь би харин юу хэлэхээ мэдэхгүй болчихдог.

Нэгэн удаа Нью-Йоркод уулзсандаа тэр баярлажээ. Нилээд хэдэн жил уулзаагүй болохоор тэр миний гарыг чанга атгаад явуулахгүй байсанд би их ичиж байлаа, учир нь түүнтэй уулзахаар ирсэн мянган хүн миний ард эгнэн дугаарлаад зогсож байгааг би харсан. Тэр харин надаас: “Та сайн уу? Та хаана сууж байна вэ? Одоо юу хийж байгаа вэ?” гэж асуухад нь би арагшаа ажиглан хараад түүнд: “Одоо би явахгүй бол болохгүй нь, би ичиж байна.” гэж хэлэв. Түүний асуултанд би хариулаагүй, тэгж олноос онцгой байхыг хүсээгүй юм. Зөвхөн сайн найзтайгаа уулзахаар ирээд ямар нэгэн юм түүнд өгсөн боловч, тэр намайг явуулахгүй байсанд би “би эрхбиш явах хэрэгтэй” гэж түүнд хэлэхэд тэрээр: “Та хажууд жаахан хүлээж бай, би танд эм өгнө” гэсэн юм. Тухайн үед тэр их яаруу байсан болохоор намайг тэндээ түр хүлээж бай гэж хэлээд дүүгээ дуудаж эм авчруулан надад өгсөн билээ.

Тэр надад тун найрсаг ханддаг ч ийм үнэтэй ховор эмийг олж авъя гэж би өөрөө хүсээгүй, би тэр эмээр юу хийх вэ? Хожим хүмүүст хуваан өгснөөс биш өөрөө уугаагүй, учир нь тэр эмэнд амьтны гаралтай зүйл орсон байдаг. Далай лам хэдийгээр надад өгсөн боловч харамсалтай нь би түүнийг ууж чадахгүй. Гэсэн ч би түүнийг нь хүлээж авсан. Яагаад гэвэл тэр надад өгнө гэж аль хэдийн амалсан болохоор би тэнд зогсоод:

“Миний эм хаана байна вэ?” гэж асууж байсан ч, авсныхаа дараа бүгдийг нь хүмүүст тарааж өгсөн. Авсан хүмүүс бүгд маш ихээр баярлаж байв. Өөр хүн бол их мөнгө гаргаж байж нэг үрэл худалдаж авч магад. Далай лам онцгойлон өөрөө өгсөн эм болохоор дотор нь лав түүний адислах хүч их байгаа гэж тэд боддог. Гэтэл надад ямар ч адислалын хүч хэрэггүй, Өөрт байгаа минь хэрэглэхэд хангалттай. Тиймээс тэр эмийг өөр хүмүүст өгсөн билээ. Би бас өөр хүнд өгөхдөө онцгой хүнийг хайж байгаад өгснөөс биш, ямар нэгэн хаа хамаагүй хүнд өгөөгүй л дээ. Тэд хэрвээ энэ эмийн ховор, үнэтэйг нь мэдэхгүй бол би тэдэнд өгөхгүй, өгсөн ч ямар ч ач тус болохгүй.

Тэрхүү капсултай жижигхэн үрлээс сард зөвхөн ганцыг уудаг байтал, надад арван хэдэн үрэл өгсөн байлаа. Далай лам хүн нь их сайхан, тун хөөрхөн хүн. Тэр надад ном бэлэглэсэн бөгөөд дээр нь бас өөрийн гарын үсгээ зуржээ. (Багш номоо гаргаж ирэн авшигтнууддаа үзүүлэв). Төвөд хүн байлаа гэсэн ийм завшаан тийм олон хүнд олдохгүй байж мэднэ. Хэрэв ямар нэгэн хүн Далай ламын гарын үсэгтэй ном олох юм бол гэртээ аваачаад түүнийг тахиж мөргөнө. Үгүй бол өдөр болгон толгой дээрээ өргөж яван хүн болгонд үзүүлж, өөрийгөө Далай ламтай онцгой харилцаатай гэдгээ бусдад харуулж мэдэгдэнэ. Тэдний хувьд Далай лам бол амьд бурхан билээ.

(Багш аа, та эхлээд Нууц тарнийг бясалгасан юмуу, эсвэл Даяаныг бясалгасан юм уу?) Би багаасаа эхэлж олон зүйлийг сурсан. Нууц тарнийг урьд нь нэгэнт сурсан байсан. Хималай ууланд сууж байх тэр үеэр нэгэн удаа миний сууж байсан газар түвдүүдийн суугаа газартай тун ойрхон байлаа. Энгийн цагт онцын хэрэг гардаггүй болохоор би тэндхийн түвд номын санд гүйж очоод бичиг үзэн ном судар шагайдаг байв. Дараа нь буцаж очоод бясалгал хийнэ, бясалгал хийгээд өлсвөл иднэ, идэж дуусвал усанд орно. Өдөр болгон ийм л байдаг, үүнээс өөр хийх зүйлгүй байв. Хэрэв хэн нэгэн ном тайлж байгааг сонсвол очиж үзнэ.

Миний сууж байсан газар Далай ламын сууж байсан газартай тун ойрхон, ганц хоёрхон минут явган алхаад хүрч болохоор. Гэвч миний сууж байсан газрын байц нилээд гүн далд болохоор гаднаас нь олж харахад нилээд бэрх. Тэр хэсэг ууланд миний сууж байсан газар нь бусад газраас нилээд өндөрт байсан бөгөөд өндөр нарс модоор эргэн тойрон хүрээлэгдсэн тул гаднаас харагдахын аргагүй. Тэнд байх хэдэн чулуун гэр нь цемент гэмээр юм бараг үгүй, зөвхөн чулууг давхарлан босгосон жижигхэн чулуун гэр төдий байв. Энэ нэг гэрийн чулууны завсраар нөгөө гэрийг нь олж үзэж болно, цонх гэгээвч гэмээр зүйл хэрэггүй. Борооны ус ч орж ирж болох бөгөөд салхи жавар сийгэн нэвтэрч, өглөө болоход олон чулуу үйрч бутарч унана. Хэрэв та тэнд суух юм бол одоо ямар эрин цаг болж байгааг мэдэхгүй, танд ганц харагдах зүйл нь тоолшгүй олон од мичид хийгээд сар, хаа сайгүй гүйж байгаа чичүүр хорхой, шавж байх бөгөөд тэд тун эрх чөлөөтэй, тэнд хэн ирсэн ч бүр болохоор юм.

Миний сууж байгаа газраас Далай ламын сууж байгаа газрыг олж харж болох боловч, Далай лам миний сууж байгаа газрыг олж үзэх аргагүй. Тэр үед би одоогоосоо бүр их зоригтой байжээ. Заримдаа номын санд очоод буцах үед орой болсон байдаг. Гэвч би өөр бясалгалтныг хайж очоод ном судрын тухай хэлэлцэн ярилцаж, буцаж харих болоход нэгэнт тун орой болсон байдаг байв. Уулын хормойгоос уул өөд өгсөхөд ганц хүн гартаа гар чийдэнгүй, гагцхүү таяг барьж, сохор хүн шиг уулын зөрөг замаар тэмтчин явахад, хэдийгээр дотроо эвгүйцэх боловч итгэл зоригтой байвал хаа ямар газраар явсан ч сэтгэл дотор айдас төрөхгүй санагдаж байсан билээ.

Энэ бүхнийг яримагц Хималай ууланд буцаж очмоор санагдаж байна. Тэнд үнэхээр тун сайн, маш нам сэлүүн, ганцаараа үед өлсвөл иднэ, нойр хүрвэл унтана, хаа явъя гэвэл явна. Тэнд маш олон бясалгалтан сууж, адилгүй номын цогцосыг бясалгаж байгаа юм. Тэдний дэс нь адилгүй байж магад, гэвч хамаагүй, тэд бүгд Мөр ёсыг хайх сэтгэл нь гүн зузаан хүмүүс билээ.

Зарим үед бид гадуур явахдаа модон доор хоёр гурвуулаа суугаад горхины ус ууж, түвд талх иддэг. Түвдийн талх нь манай эндхийн талхтай адилгүй, овъёсны гурилаар хийсэн болохоор шим тэжээл сайтай, ургамлын гаралтай цөцгий түрхчихээд, сууж болох газар хайн томхон модны навчийг газарт дэвсэж, талхаа тавиад бас нэгэн бяцхан лонх устай, тэгээд нэг талаар идэж уун нөгөө талаар ном судар болон бясалгалын тухай ярилцдаг. Тэнд бясалгахад тун тохиромжтой газар, тэнд нэг минут суухад энд нэг жил сууснаас ч илүү баяр баясгалантай байдаг.

Хималай ууланд байхад тэндхийн амьтан болон ургамлын аль нь ч нэг тийм уян зөөлөн, эв найрамдуу уур амьсгал ялгаруулж байх шиг санагддаг юм. Тэндхийн тэнгэр нь тэнгэр уудам, амарлингуй, нарс моддыг нь харахад ээлтэй дотно санагддаг. Миний сууж байсан газар тун өндөрт байсан болохоор цагаан үүлс дэргэдүүр минь нүүдэллэж, би яг л үүлэн дээр хөвөн алхаж байх шиг санагддагсан. Ингэж байгаа нь би үүл манан хөлөглөн дүүлж байгаа биш, тэнд үнэхээр цагаан үүлс өөрсдөө нүүж байсан юм. Заримдаа зураг дээрээс та нар үүлэн дээр байгаа хүнийг хардаг. Тэр байдал нь миний ярьж байгаатай бараг адилхан. Иймэрхүү хүслэнт ахуй нь диваажинд биш, харин хүний ертөнцийн Хималай ууланд байдаг.

Энгийн цагт би өдөр бүрийн үдийн хойно бурхны хөргийг нэг, хоёр удаа эргээд харина. Харьсны дараа юу хийх вэ? Хөрш зэргэлдээ хүмүүстэйгээ ярилцах юмуу, үгүй бол бясалгал хийнэ, унтана, маргааш нь хэдийд босохыг хүснэ, төдийд л босно. Босох дургүй бол бүхэл өдрөөр бясалгал хийсэн ч үймүүлэх хүн үгүй, цахилгаан хонх, цахилгаан утасны чимээ саад болохгүй, өлсвөл өөрөө хоол будаа чанаж иднэ. Тосон зуух худалдан авч болох юм, эсвэл тэнд мод их болохоор гурван чулуу тулж гал түлэн байгаа зүйлсээ тогоон дотроо хийж чанаад бага сага давс нэмбэл идэхэд хангалттай. Хэрвээ залхуурвал түүхийгээр

нь идсэн ч болно. Би хааяа бага сага ногоо чанаж иддэгээс биш, энгийн цагт түүхийгээр нь идвэл хурдан байх учраас зэрлэг ногоо түүж ирээд дээр нь давс бага зэрэг цацаад идчихдэг байсан.

Хималай ууланд байх үед заримдаа хоол хийж чадахгүй байдгийн учир нь тэндхийн агаарын даралт тун их болохоор ус буцлахгүй маш удаг. Тийм үед Ганга мөрний усанд ногоогоо угаагаад түүхийгээр нь идэхэд тун амттай байдаг юм. Ингэж идлээ гээд надад ямар ч асуудал гараагүй, харин өөр хүмүүс ингэж идээд гэдэс нь өвдөж, суулгасан байна лээ.

Хималай уул бол хамгийн сайхан газар. Халуун усгүй ч хамаагүй, хүйтэн усаар угааж болно. Хүйтэн усанд орох нь маш сонин сайхан, ус хүйтэн болохоор бие агших мэт санагддаг. Тэр агшинд би нэг, хоёр, гурав, дөрөв гэж тоолоод мөс шиг хүйтэн голын уснаас үсрэн гарч ирэхэд, бие маань цэцэг мэт дэлгэрч байх шиг санагдсан. Надад маш сонин бахархмаар санагдаж, бас дахин нэг удаа ингэж тогломоор бодогдож билээ.

Би нэг л газартаа байнга битүүмжлэн суудаггүй байв. Тэр үед миний битүүмжлэн суусан газар нь түвдүүдийн суугаа газартай ойр, тийм их аюултай биш байжээ. Тэндхийн зарим газраас юм худалдан авч болох бөгөөд цахилгаантай тул хоол хийж идэж болно. Агаар нь тийм ч сийрэг биш болохоор будаа, ногоогоо чанаж болгож болно. Тэнд өвөл цас бага байдаг ч өндөрлөг газар нь цас их ордог. Миний сууж байсан тэр газарт хэдийгээр цас бага боловч өдөр бүр очоод байх газар биш. Тийшээ зун гарч болно, өвөл бол болохгүй, гарахад тун бэрхтэй газар билээ.

Зарим гүн далд газарт жил бүр маш олон мөргөлчин ирдэг юм. Тэд морь унах юмуу, эсвэл хүнээр үүрүүлж, замчаар газарчлуулж байв. Би ганцаараа эмэгтэй байсан бөгөөд бас явган явж байхыг тэд үзээд бүгдээрээ гүйлдэн ирж хардаг нь тэдэнд үнэхээр санаанд багтамгүй санагдаж байсан хэрэг. Энэтхэгт эмэгтэй хүн ганцаараа замд гардаггүй, нэн ялангуяа миний бие жижигхэн, харахад яг хүүхэд шиг болохоор, Та яагаад ганцаараа явж байгаа билээ? гэж асууна. Тэр үед миний өмсөж зүүсэн нь их нимгэн байв. Замд алхаж явахад халууцан хөлс их гардаг тул би хүзүүтэй ноосон цамцаа ч өмсөөгүй байлаа. Тэд намайг хараад ихэд гайхан биширнэ. Учир нь тэд цөм цасны зузаан хүрэм өмсөөд морин дээрээ маш олон юм ачсан байтал би харин нимгэн хувцас өмсөж, тун хялбархан ачаатай явж байсан юм. Тиймээс намайг ууланд гарч очих үед маш олон хүн миний дэргэд ирэн надтай ярилцаж, бас надтай найзлахыг хүсэж байв.

Энэ жил би Энэтхэгт очихдоо хоёр хүнд авшиг хүртээсний нэг нь эмч, нөгөө нь эмчийн охин билээ. Тэдэнтэй би бараг дөрөв, таван жилийн өмнө танилцсан, энэ нь Энэтхэгт болсон хэрэг юм. Энэ жил би Энэтхэгт очихдоо тэдэнтэй уулзахаар дахин очсоны учир нь тэд надад ирүүлсэн захидалдаа, хэрвээ Энэтхэгт ирвэл заавал тэдэнтэй уулзахыг



гуйсан байлаа. Намайг очиход тэд маш их баярласан. Тэр гэр бүлийнхэн тун сайн хүмүүс, нөхөр болон хүү нь хуульч, эх нь эмч, харин охин нь сургуульд сурдаг.

Уг нь тэд бүх гэр бүлээрээ авшиг хүртэх гэж байсан ч би тэнд зөвхөн нэг, хоёр өдөр л болох байсан болохоор, тэдэнд өглөө таван цагт босох хэрэгтэй хэмээсэнд эрчүүд нь босож чадаагүй, тэгээд зөвхөн хоёр хүнд нь л авшиг хүртээсэн юм. Гэвч энэ хамаагүй, хожим нь тэд бас өөр нэгэн “гүрү”-г хайж олоод, сурч болно. Энэ нь Энэтхэгт хэцүү асуудал биш. Гэвч тэд надад: “Та биднийг үзэхээр заавал ирээрэй, учир нь одоо та бол бидний Их Багш болсон болохоор шавиа ирж үзэх ёстой.” гэсэн юм. Тэгэхэд нь би, Энэтхэгт маш олон гүрү байна, би та нарыг дагуулж тэдэнтэй уулзахаар очвол, та нар нэгэн адил аргаар бясалгаж чадна гэв. Хималай ууланд байгаа найз нар маань маш хайрлалтай, маш өхөөрдөм, анхандаа найз нөхөд байсан бол одоо харин шавь нар болжээ.

**Асуулт:** Энэтхэгт зарим бясалгалтныг “Бабажи” гэж дууддаг. Энэ нь ямар утгатай вэ?

**Их Багш:** Бабажи (Babaji) гэдэг нь агуу их хаан гэсэн утгатай. Maharaji (Махаражи) гэдэг нь бас адилхан. Энэ нь Энэтхэгчүүдийн хувьд хамгийн хүндтэй цол. Манай энд, Дэлхийн Хүндэт Нэгэн, Бурхан багш, Түүнчлэн ирсэн гэж бид хэлдэгтэй адил, энэ бүгдийг бид Энэтхэгээс орчуулж авсан байдаг.

**Асуулт:** Энэтхэг эмх замбараагүй, ядуу хоосон байхад Багш та яагаад энэ орныг буянтай орон гэж хэлнэ вэ?

**Их Багш:** Ядуу нь ядуу. Гэхдээ тэнд одоо ч идэх зүйл хүрэлцээтэй байна. Буян гэдэгт мөнгө зоосны буяныг л хэлж байна гэж үзэж болохгүй. Буяныг мөнгөөр худалдаж авч чадахгүй. Шагжамуни Бурхан бас мөнгөгүй байсан, уул нь тэр хэдийгээр хаан хөвгүүн байсан ч баян тансаг амьдралаа огоорч, хожим нь нэгэн гуйлгачин болоод бадарласан. Түүний ингэснийг буянгүй гэж хэлж болно гэж үү? Тэд буяныг тоож хамаардаггүй, хэр их мөнгөтэй байхыг ч хайхардаггүй, тэдний ихэнх нь маш энгийн, сэтгэл нь тун шулуун байдаг. Тийм биш бол тэд бас мөнгө олохоор чармайн ажиллаж чадна шүү дээ. Энэтхэг хүн Тайвань хүнтэй л адилхан, тэд яагаад мөнгө олж чадахгүй байх билээ?

Тэдэнд мөнгө чухал биш, юу байна, түүнийгээ хэрэглээд л болчихно, илүү ихийг хүсдэггүй. Би та нарт хэлье. Энэтхэгт ядуу хүн ч бясалгаж байдаг. Тэр ч байтугай гуйлгачин нь ч бясалгаж байдаг юм. Миний багш нэг тосгонд очиход бараг гурван зуугаас таван зуун хүн бүгдээрээ авшиг хүртсэн байна. Эрэгтэй, эмэгтэй, залуу, хөгшин, тахиа, үхэр, нохой, муургүй бүгдээрээ ирсэн. (бүгдээрээ инээлдэв) Тэнд тун ядуу хоосон, өндөр сүрлэг барилга ч үгүй, тэдний гэр нь шавраар барьсан, ариун цэврийн өрөөгүй, мөн тохитой гэр ахуйн төхөөрөмж ч байхгүй байв. Бид бүгд шалан дээр өөрсдийнхөө зүйлийг дэвсээд унтсан юм. Гэхдээ биднийг очих үед тэд тэр дор нь бие угаах жижигхэн байр болон ариун цэврийн өрөө бариад усанд орж биеэ угаах боломжоор хангаж өгсөн.

Биднийг очихоос өмнө тэнд юу ч үгүй, хүмүүс нь үхэртэйгээ хамт амьдарч байсан ч цэвэр ариун, газар нь маш цэвэрхэн, гэтэл их хот нь харин бохир заваан. Энэ нь зөвхөн Энэтхэгт төдий биш, Европын их хотууд ч мөн адил цэвэрхэн биш байдаг. Харин Энэтхэгийн хөдөө тосгон нь тун цэвэр цэмцгэр, би маш олон жижиг тосгонд очиж үзсэн. Газрыг нь үзэхэд цэв цэвэрхэн болохоор модон доор хэвтмэгц унтаж болно. Гэтэл хот дотор бохир буртаг их, хүн амьтан хэтэрхий олон, тэгээд бас ус нь боогдож хаагдсан, ууж идсэн идээ ундаагаа бүгдийг нь эмх замбараагүй тавьсан байдгаас усны хоолой нь бохирдсон, элдэв зүйлийн өмхий үнэртэй зүйлтэй байдаг, хөдөө тосгонд ийм зүйл байхгүй.

Тэд хэдийгээр тун ядуу боловч цэвэр цэмцгэр, тэгээд бас эгэл жирийн, цөмөөрөө бясалгах дуртай тул хүмүүст амар амгалан уур амьсгалыг авчирдаг. Тэдний хүүхэд нь хар багаасаа бясалгал хийж өсдөг болохоор өсч торнисныхоо дараа мэдээж, сайн хүн, богд хүн, их бясалгалтан, их хувраг болно. Энэ нь тэдний амьдралын хэвийн байдал юм. Энд харин бид нилээд хөгшин болтлоо хүлээдэг ч бас л бясалгахгүй юмуу, үгүй бол хэдхэн өдөр бясалгаад алга болж, тэгээд нэг, хоёр жил үзэгдэхгүй болно. Зарим хүн долоо хоногийн даяаныг дааж тэсэхгүй болоод бясалгалын хагуужлыг тэссэнгүй гэж Багшдаа зэмлүүлэхээс айн Багшийгаа үзэхээр ч ирж зүрхлэхгүй болно.

**Асуулт:** Энэтхэгт англи хэлээр ярьдаг уу?

**Их Багш:** Англи хэл, энэтхэг хэлний аль алин нь боломжтой байдаг, гэвч ихэнх хүн энэтхэг хэлээр ярьдаг ч маш олон нутгийн аялгатай байдаг. Англи хэлийг ихэнх энэтхэг хүн ойлгодог, бүр мэдэхгүй хүн ч гэсэн танд “straight ahead” (чигээрээ яв) гэж хэлэх юмуу, эсвэл “very good” (тун сайн) гэж хэлнэ. Та тэдэнтэй хичнээн удаан ярилцсан ч, тэд зөвхөн straight ahead гэх ганц үгээр хариулаад өөд өөдөөсөө харан инээгээд байдаг, та ойлгохгүй байсан ч хамаагүй. Дэлхий дахин угаас амгалан, та явахаараа яв, тэр явахаараа явна. (бүгдээрээ инээлдэв.)

Та хэрэв түүнээс зам асуувал тэр танд “straight ahead” гээд байхаас биш, зүүн, баруун тийш эргэхийг ерөөсөө хэлэхгүй. Хэрэв та түүний хэлж зааснаар явбал очих газраа олохгүй болно шүү. Тэгээд өөр хүнээс асуухад хүрвэл тэр нь бас straight ahead гээд байх болно. (бүгдээрээ инээлдэв) Дараа нь та явах тусам очих гэсэн газраасаа улам холдоод уг нь хойд зүгт очих гэсэн байтал өмнө зүгт очихоод эцэстээ эрхбиш галт тэргэнд суун буцаж ирэх хэрэгтэй болно. Тиймээс Энэтхэгт очих хүн эрхбиш хичээн болгоомжлох хэрэгтэй. Тэд үнэхээр англи хэл мэддэг эсэхийг нь тодруулах хэрэгтэй. Хэрвээ тэр зөвхөн straight ahead, ok, very good (чигээрээ яв, зүгээр, маш сайн) гэж хариулаад байх юм бол түүнд итгэхгүй байвал хамгийн сайн, англи хэл ойлгодоггүй хүн нь ч ингэж хэлдэг юм. Энэтхэгт байх нь их сонирхолтой, тэд бүгдээрээ ok, very good, how are you (зүгээр, маш сайн, та сайн уу - юу байна) гэж хэлдэг. Хүн ойлгох, ойлгохгүйг хамаарахгүй, хүүхэд хүртэл ингэж хэлдэг, тэд хүнтэй уулзвал бүгд инээмсэглэдэг юм.

Та нар мэтийн авхай нар тэнд очоод юу хийх вэ? Та нар Тайваньд нутагшаад ихэд удсан, энд үнэхээр тав тухтай, таксинд суухад ч сэрүүн агааржуулагчтай байх ёстой. Зуны улиралд ч усанд орохдоо халуун усаар биеэ угаана, ийм нөхцөл байдлаас Энэтхэгт очвол хоёр хоног ч хүлцэн тэсвэрлэж чадахгүй, хоёр километр явмагц хэвтээд өгч мэднэ. Та нар тэнд очихдоо маш олон ачаатай бол явж чадахгүй, учир нь зарим газар машин, морь байхгүй тул ачаагаа өөрсдөө үүрч, явган явах ёстой болно. Хэрэв хамт аялах найз нөхөдгүй бол тун хэцүү, нэг хоёр эмэгтэй найз олж хамт явбал болох юм.

Нэг Их Багш тийм амархан илэрч, биеэ хүнд харуулдаггүй. Та түүнтэй уулзчихсан байлаа ч хувь барилдлага, асар их буянтай байж гэмээнэ л сая түүнийг таньж чаддаг. Тэдний бясалгаж байгаа нь хүнд харуулахын төлөө биш, та Тайваниас ирлээ гэх юм бол тэр тантай уулзах санаагүй болж мэднэ. Та мах идээд түүний тэр газрыг бузарлаж магад гэж тэр бодно, тэр ч байтугай жирийн айлууд ч таныг гэртээ оруулахгүй биз. Бясалгаж байгаа газраа тэд тун сайн далдалсан байдаг болохоор бид хайсан ч олохгүй, зарим газраар тэд явж чадахаас биш, бид явахын аргагүй, тэд зөн билгээ ашиглаж байгаад гарч болно, бидэн шиг “энгийн хүний чадал”-аар гарч чадахгүй. Тэдний бясалгаж байгаа нь бидэнд үзэгдэж харагдахын тулд биш, бас олон шавьтай болохын тулд ч биш. Тэд нуугдаж байгаад нам сэлүүн бясалгах дуртай болохоос Багшийн чинь адил ингэж гарч ирээд хамаг төрөлтөнтэй цуг байхаар тийм тэнэг биш. (бүгдээрээ алга ташив)

Та нар үнэхээр очъё гэж бодож байна уу? (Шавь нар: Багшийн ярьсан нь маш гайхалтай тул тэнд очихыг цөм хүсэн мөрөөдөж байна гэж хариулав.) Миний нүдээрээ олж харсан нь та нарын олж харахтай адилгүй, та нар Энэтхэгт очвол гагцхүү бохир талыг нь л олж харж магадгүй, тэгээд Ганга мөрний ус ийм бохир юм чинь яаж ууж болох вэ гэж та нар бодох бол, харин би тэр газрыг ихэд бахаддаг.

**Асуулт:** Бясалгахдаа заавал хөлөө зөрүүлж, завилж суух хэрэггүй гэж Багш та хэлсэн. Гэтэл их бясалгалтан бүгдээрээ завилж суусан байдаг. Завилж суувал самадид орох нь амархан уу?

**Их Багш:** Хүй Нэн Их Багш үргэлж завилж суудаг байгаагүй. Гэхдээ тэр бас битгий завилж суу гэж хэлээгүй, та ямар янзаар сууна, дураараа л суу, дараа нь дасаж дадахаараа завилж суугаад бясалгал хийж чаддаг болно. Гэвч эхэн үедээ өөрийн биеэ албадах хэрэггүй. Зарим хүн өвчин хуучтай болохоор завилж сууж чаддаггүй. Түүнийг бясалгаж болохгүй гэж хэлж болохгүй биз дээ? Зарим хүн хөлгүй, түүний бясалгахыг зөвшөөрөхгүй байж болно гэж үү? Хүн бүр бясалгах тэгш эрхтэй байх ёстой.

Олон хүн өндөр газар бясалгаж сууж зүрхэлдэггүй. Өндөр газар суувал амархан самадид орж чадахгүй, орсны дараа унаж ойчихоос айна. Тиймээс Багш нь та нарыг бясалгал хийж дууссаныхаа дараа байрандаа чимээгүйхэн очоорой гэж хэлдэг. Өндөр сандал дээр суувал

ардаа түшлэгтэй байх хэрэгтэй. Тэгэхгүй бол самади агуулсны дараа унавал яана? Хэрвээ өндөр сандал дээр бясалгал хийх бол нуруугаа цэх байлгах хэрэгтэй. Хэвтээгээрээ ч бясалгаж болно, зөвхөн тайвширвал самадид орж чадна. Хэрвээ биеэ хэт шахаад байвал самадид орж яаж чадах вэ? Биеийн чинь хаана өвдвөл, сэтгэл чинь тэнд төвлөрнө. Угтаа бол хөл байгаагаа өөрөө анзаараагүй байтал бясалгал хийх үед хоёр хөл чинь хоорондоо муудалцаж эхлээд цаашилбал гурван хөл ч болж мэднэ. (бүгдээрээ инээлдэв) Тэгээд энд өвдөхгүй бол тэнд өвдөөд уул нь хөл байна гэж анзаарахгүй байсан бол одоо харин тийм олон хөлтэй болчихож гэмээр санагдах нь үнэхээр аргагүй. Анхаарлаа хөл дээрээ тавилгүйгээр харин билгийн мэлмийдээ хандуулвал хамгийн сайн.

Долоо хоногийн даяаны үеэр авшигтнууд ингэж ч, тэгж ч, олон янзаар суудаг хэдий ч ахуй ойлголт нь тун өндөр байсан. Бусад даяанчийн даяаны танхимд шавь нар нь завилаад цэх сууж, хөдөлж ч болохгүй байдаг ч тэдэнд ямар ч ахуй ойлголт байдаггүй. Багш нь урьд нь энэ мэтийн даяанд оролцож байсан болохоор үнэндээ зовлонгоос өөр юу ч үгүй байдаг гэдгийг мэднэ.

Хүмүүс бүгд л бясалгахад заавал зовж зүдрэх ёстой гэсэн нэг зүйлийн буруу үзэл, ойлголттой байдаг. Үнэндээ тэгж зовж зүдрэх албагүй. Бид угаас бурхан байтлаа юунд тэгж зовж зүдэрч болох вэ? Багш нь зовлон зүдрэлийг амссан нь Багшийн чинь үйл түйтгэрээс болсон хэрэг. (бүгдээрээ инээлдэв) Учир нь нэг хүн зовлон амсвал бусад олон хүн зовлон амсах хэрэггүй болно. Шагжамуни Бурхан зургаан жил хатуугаар бясалгаж тун их зовуурь зүдгүүрийг амссан, гэтэл түүний шавь нар нь тэгж зовж зүдэрч бясалгах шаардлагагүй, тэглээ ч гэсэн тэд бясалгаад архад, буцашгүй бодисавагийн хутгийг олж, энэ төрөлдөө Бурханы хутагт хүрч чадсан. Бурхан Багш шавь нартаа асар их буянаа өгсөн болохоор хүн болгон Шагжамуни Бурхан шиг тэгж зовлон зүдүүр амсаагүй юм.

Бясалгах нь тийм их зүдгүүртэй биш, урьд нь Шагжамуни Бурхан хатуу бясалгал хийж, буруу номыг бясалгаж байсан болохоороо тэгж зовж зүдэрсэн байжээ. Учир нь тухайн үедээ тэр мэдэхгүй байсан хэрэг. Харин тэр үүнийг ойлгосныхоо дараа энэ хамгийн гэрэл гэгээтэй замыг хайж олоод өөр бусдыг дагуулан явж чадсан. Эхний хүн анх эхэлж бясалгах үедээ зам мөрөө хайж олохгүй байж магад, тиймээс баахан гашуун зовлонтой бясалгадаг. Хоёрдахь хүн нь түүний гаргасан замаар замнахад нилээд амархан, асуудалгүй. Тиймээс та нар Хималай ууланд очихын хэрэг байхгүй, Багшийгаа дагаж сурвал болчихно.

## АВШИГ ХҮРТМЭГЦ БУРХАНЫ ХУТАГТ ХҮРНЭ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формосагийн Тайбэйгийн Шиндиан  
1987 оны 1 дүгээр сарын 1*

Авшиг хүртмэгц Бурханы хутагт хүрч, нэгэн бурхан болно, гэвч харамсалтай нь үүнийг бүгдээрээ ойлгодоггүй. Хүн бүхэн бурхан, энд байгаа хүмүүсийн дотор бурхан болоогүй хүн нэг ч үгүй. Гэхдээ та нар одоо ч итгэхгүй байгаа болохоор л хараахан бурхан болоогүй байгаа юм. Та нар өөрийн биедээ итгэхгүй байна. Уг нь бол авшиг хүртмэгц л бурхны дэсэд хүрсэн, өөрөө нэгэн бурхан болсноо таньж мэдсэн эсэхэд л гол учир нь байна. Өөрийгөө бурхан гэдгээ яаж таньж мэдэх вэ, туршлагатай болж байж л сая таньж чадна. Яарсны хэрэггүй, хожим хувь барилдлага зузаарахаар бид бол бурхан гэдгийг бидэнд ойлгуулна. Тиймээс хамаг төрөлтөн маш чухал. Хамаг төрөлтөн байхгүй бол бурхан гэж үгүй. Жишээлбэл, Нэг хүн уулын агуй дотор бясалгаад нэгэн өдөр гэнэт билиг нь нээгдэж, өөрийгөө нэгэн бурхан болсныг олж мэдэх шиг болжээ. Гэвч хожим нь энэ байдлаа шалгаж үзээгүй, мөн туршлага байхгүй болохоор энэхүү “гэгээрэл”-дээ байнга итгэх аргагүй болж, билиг ухаан нь нээгдсэн тэр агшин зуурт итгэхгүй болдог. Тиймээс хамаг төрөлтөн үгүй бол бурхан бас үгүй гэдэг нь энэ билээ.

Авшиг хүртмэгц бурхан болсноо бясалгах тусмаа улам ойлгодог болохоор үргэлжлүүлэн бясалгах хэрэгтэй. Хэрвээ үргэлжлүүлэн бясалгахгүй бол тэр нь нэг л өдрийн бурхан төдий болоод өөр өдөр нь бурхан биш болчихоод мартаж орхино. Жишээлбэл, нэг эмч хүн, тэр хэдийгээр сургууль төгсөж эмч болсон боловч өвчтөнийг эмнэсэн туршлагагүй, ямар ч эмчилгээний багаж хэрэгсэл болон эмнэлгийн нэр томъёог ашиглаж байгаагүй, эмчлэх туршлагагүй бол хэдэн арван жил өнгөрөхөд л бүгдийг нь мартчихна биз дээ? Тэр хичнээн их юм сурсан нь хамаагүй, ямар ч хэрэггүй болоод түүнд дурсамж төдий бага сага юм л үлдэнэ.

Үүн шиг, жишээлбэл, нэг хүн хөгжмийн зэмсгээр тоглохдоо тун гарамгай байсан ч арав гаруй жил оролдохгүй байж байгаад дахин тогложээ гэвэл яруу сайхан хөгжимдөж чадахгүй, урсам сайхан аялгуу гарахгүй. Англи хэл сурах нь ч мөн адил. Зарим хүн англи хэлэндээ тун

сайн байдаг, гэтэл гучин жил хэрэглээгүй бол сайн ярьж чадахгүй болно. Би хэдийгээр Вьетнамд төрж өсөөд вьетнам хэлээр арав гаруй жил ярьж байсан ч, одоо вьетнамаар ярихдаа урьдынхтайгаа адил тийм сайн биш, вьетнам хэлээр шүлэг бичих гээд чадахгүй, хэрэв би одоо шүлэг бичмээр байвал англиар бичээд дараа нь вьетнам хэл рүү орчуулдаг. Цаашилбал олон вьетнам үгийг мартчихжээ. Гэхдээ энэ нь бас бүүр муу болчихсон юм биш, учир нь би одоо ч хааяа вьетнам үг хэллэг хэрэглэж байдаг юм. Хэрвээ ямар нэг хүн эзгүй арал дээр ганцаараа хоригдоод вьетнам хэлээр олон арван жил ярихгүй бол, хэлээ бүрмөсөн мартаж мэднэ, тийм биз дээ? Бид англи хэл юмуу, өөр хэл сураад сургуульд байх үедээ бага сага ярьж байснаа сургууль төгссөний дараа ярих тохиолдол гарахгүй, эсвэл түүнийгээ хэрэглэхгүй байвал мартчихна. Ойлгож байна уу?

Агшин зуур гэгээрэх номын цогцосыг бясалгавал уг чанараа дорхноо харж, бурхны дэст хүрч чадах нь буруугүй. Бурханы Гэрлийг харвал бурхантай нэгэн цогц болж, бурхны дэсэд хүрчихсэн байдаг. Энэ бурхны Аялгууг сонсмогц хэр их сонссон нь хамаагүй, бурхантай нэг цогц болчихсон байдаг. Жишээ нь, Багшийнхаа гар, хөл, толгойд хүрэлцсэн байвал Багшийнхаа биенд хүрсэнд тооцож болно. Учир нь эдгээр нь цөм Багшийн чинь биеийн нэг хэсэг юм. Үүнтэй адилаар, бурхны доод дэсийн Аялгууг олж сонссон ч тэр нь мөн л Бурханы Аялгуу юм. Бурханы доод дэсийн Гэрлийг олж үзсэн ч тэр нь мөн л Бурханы Гэрэл болно. Бурханы хөлд гар хүрсэн байвал бид бас Бурханы хутагт хүрсэн, бурханыг олж харсан, бурхантай хүрэлцэнд тооцогдоно, зөвхөн бид хараахан бурханы царайг хараагүй болохоор өөрийгөө итгэж ядах төдий байгаа юм. Энэ нь яг л дөрвөн сохор хүн зааныг тэмтэрсэнтэй адил. Нэг нь зааны чихийг тэмтрээд заан тавагтай адил гэж гэнэ. Нөгөө нь зааны хамрыг тэмтрээд заан нь усны хоолойтой адил гэж, бас нэг нь зааны хөлийг тэмтрээд зааныг баганатай адил гэдэг. Тэд бүгдээрээ зааныг олж барьжээ, гэхдээ тэдний бодож мэдэрсэн нь адилгүй байна.

Бясалгагч хүн ч мөн адил, бид бүгдээрээ авшиг хүртэх үедээ нэгэнт Бурханы хутагт хүрчихсэн байдаг. Гэтэл өөрийнхөө Бурхан чанараа одоо болтол бүрэн таниагүй болохоор өөрийнхөө бурхны төгс чадвараа, бүхнийг чадагч хүч чадлаа бүрмөсөн таньж хараахан чадаагүй байдаг, тиймээс та нар өөрсдөө бурхан гэдэгтээ итгэдэггүй. Тиймээс хэзээ бурхан болохоо хүлээсний хэрэггүй, авшиг хүртмэгц аль хэдийн бурханы дэсэд хүрсэн, бидэнд зөвхөн итгэл, туршлага дутагдаж байгаа төдий л юм. Бидний бясалгал жаахан сайжирч, бясалгалын хүч хангалттай болж, хамаг төрөлтийг гэтэлгэх үед бид ямар бурхан гэдгээ мэдэх болно. Гэтэл хамаг төрөлтийг гэтэлгэхэд торолгүй мэтгэлцэх чадвар, билиг ухаантай байх хэрэгтэй. Дотоодын билиг ухаан болон туршлага бүрэн гүйцэд байх ёстой нь мэдээж, гэвч гадна талын туршлага болон мэдлэг дутааж болохгүй, ингэж байж л сая хамаг төрөлтийг гэтэлгэж чадна.

Зөвхөн нэгэн бурхан болох төдий нь ашиг тус багатай. Тиймээс Брадигабудда бурхан (Prateyuka Buddha) хүнд ном уламжлахын аргагүй байдаг, учир нь түүнд багш үгүй, тэрээр мөрийг өөрөө сэхээрч олсон

байдаг. Эсвэл тэр ямар нэг Их Багшийг дагаж Арьяабалын номын цогцосыг сургаад авшиг хүртэх үед билиг ухаан нээгдсэн боловч дараа нь багш нь нас барсанд тэр өөрөө үргэлжлүүлэн бясалгаж байгаад нэг өдөр гэгээрлийг олсон хэдий ч Их Багшийн жолоодлого үгүй учраас хамаг төрөлтнийг сургаж болох ямар нэгэн систем гэмээр юмгүй, амаараа ном уламжлах туршлагагүй байдаг. Энэхүү “амаараа ном уламжлах” мэдлэг нь хамаг төрөлтнийг татаж ном сонгох болно, мөн хамаг төрөлтний анхаарлын хүч болон хүндэтгэлийн сэтгэлийг татаж чадах явдал юм. Иймээс хэдийгээр бидний билиг ихэд нээгдлээ ч торолгүй мэтгэлцэх чадваргүй бол билиг нээгдээгүй бусад хүнд билиг ухаанаа мэдүүлэхийн аргагүй. Энэ л хамгийн хэцүү явдал.

Билиг нээгдэх нь бэрх биш, хамаг төрөлтнийг гэтэлгэх нь л бэрх. Тиймээс Шагжамуни Бурханы хутагт хүрсний дараа арван зүг, гурван цагийн бурхад цөм түүнийг таван цөвүүн муу ертөнцөд байгаа ч гэсэн хамаг төрөлтнийг гэтэлгэж чаддаг гэж сайшаан магтжээ. Ертөнцийн үг хэлээр Бурхан чанар болон бясалгалын дотоод дэсийг илтгэхэд тун бэрх болохоор үг хэлээр илэрхийлэн гаргах чадвар нь маш чухал байдаг. Хэрвээ үг хэлээр илэрхийлэхгүй юм бол билиг ухаан нь маш өндөр, урьд төрлийн барилдлагаар сайн, маш гүн, үлэмж буянтай хүмүүсээс бусад нь биднийг ойлгохгүй. Тиймээс бид эрхбиш дотооддоо бясалгаж, дээд хүчин чадлаа тэжээн өсгөхийн хамт гадна талдаа Төгс Гэгээрсэн Их Багш, бясалгал сайтай хүнээр удирдуулах хэрэгтэй. Өөрөө бие даан бясалгадаг хүмүүсийн олонх нь, жишээ нь, бурхныг дурсах, судар унших, эсвэл ямар нэгэн тарни унших үедээ бас дотоодын Аялгуугаа сонсож ч магадгүй. Гэвч энэ өдөр сонсож байснаа маргааш нь үгүй болчих юмуу, эсвэл нэг, хоёр өдөр ахуй ойлголттой байгаад дараа нь тэр нь бүрмөсөн үгүй болно. Тэд өдөр бүр ахуй ойлголттой байсан ч тэр нь ямар ч хэрэггүй. Яагаад вэ? Учир нь ямар дуу Аялгуу нь сайн бэ? Ямар дуу Аялгуу нь муу вэ? Ямар хүслэнт ахуй нь сайн бэ? Ямар хүслэнт ахуй нь муу вэ? гэдгийг тэд ялгаж чадахын аргагүй, бас асуух хүн үгүй. Тэгээд эцэстээ адад мэхлэгдэж, адад чирэгдэн явна. Энэ нь маш их яршиг төвөгтэй хэрэг. Тиймээс маш олон хүн бясалгаж байгаад төөрч, гадаад номтон болдог нь энэ учир шалтгаанаас болдог юм.

Авшиг хүртээх үеийн “Агшин зуур гэгээрэх” гэдэг нь тэр доороо билиг нээгдэж, цэцэг дэлгэрч, бурхан харагдаж, тэр дороо уг чанараа харж, бурхны дэсэд хүрэхийг хэлж байгаа юм. Энэ нь ташаа зүйл биш, гэтэл бидэнд билиг ухаан үгүй, итгэл зориг үгүй учраас билиг нь хэдийгээр нээгдсэн ч өөрсдөө харин олж мэдээгүй байдаг. Үнэн хэрэгтээ бид ерөөсөө мэддэггүй, Их Багш нар бүгдээрээ: “Хамаг төрөлтөнд бүгдэд нь Бурхан чанар бий, гэтэл тэд өөрсдөө үүнийгээ таньдаггүй, тиймээс ямар ч хэрэггүй” гэж хэлсэн билээ. Үхэр ч гэсэн Бурхан чанартай, гэхдээ тэр үүнийгээ мэдэж танихгүй болохоор хэрэггүй юм. Энэ нь яг л нэг хүнд хэдийгээр эрдэнэсийн сан, өв хөрөнгө байгаа ч хэрвээ тэр нь хаана байгааг мэдэхгүй бол тэр ядуу хүн хэвээр байхтай адил.

Тиймээс Бурханы хутагт хүрэх эсэх нь бидний сэтгэлээс хамаарна,



бидний итгэл зоригийн хүчийг түшиглэнэ. Харин их “суух”-аар л Бурханы хутагт хүрчихдэг юм биш, хэрвээ хичнээн удаан суугаад нэгэн бурхан болчихдог юм бол тэр нь “суугаа бурхан” л болно. Удаан хэвтсэнээс нэгэн бурхан болчихдог бол тэр нь “хэвтээ бурхан” л болно, ингэх нь гэгээрсэн бурхан биш. Хэдийгээр Багш нь авшиг хүртээмэгц Бурханы хутагт хүрнэ гэж хэлсэн боловч илүүхэн бясалгаж, сэтгэлээ нам тогтуун байлгах хэрэгтэй, сэтгэл нам тогтуун болж байж л сая бид өөрийгөө хэн бэ гэдгээ таньж чадна. Бурхны дэсэд хараахан хүрээгүй байсан юм биш, авшиг хүртмэгц бүгд бурхны дэсэд хүрчихсэн, “хичнээн галавын дараа, тийм тийм бурхан болж, тийм тийм улс гүрэнд, тийм тийм хамаг төрөлтнийг гэтэлгэнэ” гэх зөгнөлийг хүлээсний хэрэггүй. Ийм зөгнөл нь үнэндээ тоглоом төдий зүйл.

Олонх бурхан сударт Шагжамуни Бурхан “Тийм, тийм хүн хичнээн галав юмуу, эсвэл тоолшгүй асанги галавын дараа сая Бурханы хутагт хүрч чадна, тийм, тийм нэртэй бурхан, тийм, тийм улс гүрэнд заларна” гэж зөгнөсөн. Хэрвээ би түүний шавь нь байсан бол: “No, thanks.” (Үгүй ээ, баярлалаа.) гэж хэлэх байсан, учир нь энэ нь дэндүү холын хэрэг болчихжээ. Бас тэгээд тоолшгүй асанги галавыг хүлээх юм чинь, хэн ийм удаан амьдарч чадах вэ? Тэр хооронд нь бид юу хийх вэ? Цагийг дэмий өнгөрөөж, дэндүү их сүйтгэнэ. Хэрвээ асанги галавыг хүлээж, тоолшгүй үеийг өнгөрөөж байж л сая нэг бурхан болохоо хүлээх юм бол бид анааш болж хувирчихгүй юу? Авшиг хүртсэн хүн аль хэдийнээ Бурханы хутагт хүрчихдэг болохыг Багш нь та нарт баталж чадна.

Багш нь бурхан биш юм бол хэн бурхан болох вэ? Хэрэв Багш нь бурхны дэсэд хүрч чадахгүй юм бол, бурхны дэсэд хүрч чадах хүн бас байхгүй, ойлгож байна уу? Учир нь хүн бүхэн бурхны дэсэд хүрч чадна. Бурхан гэдэг нь билиг ухаан нээгдсэн хүн, их мэдлэгтэй хүн, Төгс Гэгээрсэн Их Багшийг хэлдэг, ийм л юм. Хэрвээ бид аливаа бүхнийг бүгдийг ойлгож чадвал тэр нь бурхны дэс болох юмуу, эсвэл Төгс Гэгээрсэн Их Багш, Туулан Гэтэлсэн дэс болно. Та нар өдөр бүр бясалгаж, өдөр бүр зарим зүйлийн учрыг ойлгож, өдөр бүр гэгээрч, билиг нээгдэн өдөр бүр бясалгаж суухдаа Төгс Баясгалант оронд очоод дахин буцаж ирж байгаагаа заримдаа санаж, заримдаа мартчихдаг. Энэ нь ангижралын утгыг агуулж байдаг юм.

Бид бурхантай уулзахаар очих тэр үед бид бол бурхан мөн. Зөвхөн бурхан л сая бурхны оронд амьдарч чадна. Үгүй бол ядаж бурхантай адил зан чанартай байж байж л бурхантай хамт байж чадна. Тиймээс бурхны оронд очиж чадвал та бурхан болчихсон гэсэн үг, мөн Бурханы Гэрлийг харж чадвал бурхан болчихно, бурхан гэдэг нь ийм л юм. Бурхан мянган мутар, мянган мэлмийтэй юмуу, эсвэл зуун мутар, зуун мэлмийтэй, эсвэл маш олон мэлмийтэй биш юм. Тэрээр тоолшгүй олон мэлмийтэй, тоолшгүй олон мутартайгаас биш, мянган мутар, мянган мэлмийтэй төдийхөн биш. Гэвч бид хэрвээ ямар нэг хүнд “Арьяабал Бурханд тоолшгүй олон мэлмий, тоолшгүй олон мутар бий” гэж хэлбэл тэр ойлгохгүй, тэр нь ямар утгатайг төсөөлөхийн аргагүй

байдаг. Тиймээс мянган мутар, мянган мэлмийтэй гэж хэлэх л хэрэгтэй болжээ, ингэвэл тэр сая ойлгож, мянган мутар, мянган мэлмий гэдэг нь дэндүү олон ажээ гэж бидэнд ярих болно. Ер нь бид хүнийг дүрслэхдээ “гурван толгой, зургаан гартай” гэвэл хүч чадал нь их болсныг хэлж байгаа хэрэг. Хэрвээ мянган мутар, мянган мэлмийтэй гэж хэлбэл тэр нь үнэхээр сэтгэгдэшгүй болохоор түүний сэтгэл бүрэн ханаж толгой дохиод “Арьяабал Бурханы хүч чадал үнэхээр сэтгэгдэшгүй” гэнэ. Ойлгож байна уу? Учир нь мянган мутар, мянган мэлмий нь түүний хувьд хэдийнээ дэндүү олон болохоор мянган мутар, мянган мэлмийтэй гэжээ. Үнэндээ Арьяабал Бурхан мянган мутар, мянган мэлмийтэй биш, хамаг төрөлтөн тийм олон байхад мянган мутар, мянган мэлмий нь хэрэглэхэд хүрэлцээгүй шүү дээ.

Бурханы дэсэд хүрнэ гэдэг нь би та нарыг долоон цагт бурхад болгоно гэж зөвшөөрвөл та нар долоон цагт бурхад болчих биш, одоо аль хэдийн болчихсон байгаа, та нар угаасаа л бурхан. Авшиг хүртсэний дараа наад зах нь та нарыг бурхны хүчтэй нэвтрэлцүүлж, бурхны эх булагт чинь буцааж чадахыг батална. Бурхны эх булагтаа буцаж чадах л юм бол болчихно, хэзээ ямар үед нэгэн бурхан болохоо хүлээсний хэрэггүй. Хэдийгээр та нар энэхүү бурхны хүчийг хараахан хэрэглэж чадаагүй, бас суралцах шатандаа байгаа боловч хамаагүй, эхлээд түүнийг хажуудаа байлгаж л байвал дараа нь мэдэх олно. Жишээлбэл, нэг хүн ажиллаж эхлэх л юм бол тэр доороо мөнгөтэй болно. Тийм биз дээ? Учир нь дарга сарын эцэст мөнгийг бэлэн өгнө. Тэр ажилласан өдрөөсөө эхлээд тэр үйлдвэрийн ажилтан болсон, харин сарын сүүл болох үед л болдог биш. Даргын хувьд мөн л ажилласан өдрөөсөө тэрээр аль хэдийн дарга болсон байдаг, харин хэдэн арван жил ажиллахаа хүлээж байгаад дарга болдог биш юм. Гэвч ажиллаж эхлэх үедээ тэр өөрийгөө дарга болсноо тэр дороо, тийм хурдан сэрж мэдрэхгүй. Учир нь хэнийг ч таньж амжаагүй, ажилдаа сайн дасаагүй, үйлдвэр нь тийм том, тийм уудам тул үйлдвэрийнхээ өнцөг булан бүрийг, нарийн ширийн зүйлсийг ойлгохын аргагүй байдаг билээ.

Зарим үед тэр ажилчдаасаа, доорх албан тушаалтнуудаасаа “Хаана ямар машин байна вэ? Тэнд ямар хүн ажиллаж байна вэ?” гэж асуух хэрэгтэй болно, тийм үү? Тэр өөрийгөө нэгэн суралцагч хүн гэж бодохоос биш, дарга хүний өөртөө итгэлтэй ааш араншин ч үгүй байна. Тэр үйлдвэрт орж ирсэн анхны өдрөөсөө аль хэдийн дарга болчихсон, гэтэл тэр одоогоор дөнгөж ирсэн шинэ хүн болохоор маш олон зүйл сурах хэрэгтэй. Бас үйлдвэрийн систем болон үйлдвэрийн нөхцөл байдалд дадах хэрэгтэй. Аажмаар тэр өөрийгөө дарга болсноо нэгэнт мэдэж, улам итгэл зоригтой болно, дарга болсон хүний тийм мэдрэмж болон ааш араншин нь улам хөгжих болно. Тийм биш гэж үү?

Үүнтэй адилаар, авшиг хүртмэгц даруй нэгэн бурхан болно. Гэхдээ тэр хүчийг хэрэглэх завшаан хараахан олддоггүй байгаа, хэрэв та нарт хэрэглэх боломж олдвол хэрэглэнэ, энэ бүгдийг л Багш нь хэрэглэж байдаг юм. Та нар одоогоор хэрэглэхгүй байгаа болохоор цааш нь тавьж,

хадгалж байгаад хожим хэрэглэх цаг болох үед аяндаа “Аан! Би чинь бурхан юм байна” гэдгээ мэдэх болно. Ойлгож байна уу? Тэр үед бүх дэлхийгээрээ таныг бурхан биш гэж хэлэхэд та итгэхгүй. Омгорхог бардам болсноос тэгж байгаа юм биш, учир нь бурхны дэсэд хүрэх үед тэр нь яг идэх, унтахтай л адил жам ёсоороо болсон шиг бодогддог, тийм ч гайхалтай биш болохоор омогшин бардамнамаар юм үгүй. Хэн нэг хүн Багшийг нь омгорхож байна гэж хэлбэл, омгорхог байна гэдэг нь юу болохыг би мэдэхгүй.

Бурханы хутагт хүрэх нь анагаах ухааны дээд сургууль төгсөх юмуу, эсвэл их сургууль төгсөхтэй адил юм. Их сургуулийн хичээлээ сурч дуусвал төгсөх нь тэр, бардамнах юм юу байх вэ? Жишээлж хэлбэл, зарим хүн хөгжмийн зэмсгийг маш удаан хугацаагаар тоглож сураад сурсныхаа дараа өдөр бүр түүнийгээ чавхдан тоглох нь тун зугаатай сайхан байхаас биш, түүнд бардамнах бодол төрдөггүй, ойлгож байна уу? Мөн дэлхий дээр хөгжмийн зэмсгээр тоглож чаддаг хүн олон байдаг. Хүн бүр сурсныхаа дараа ингэж хөгжимдөж чадах нь мэдээжийн хэрэг болохоор тэдэнд бардамнах сэтгэл төрөхгүй, учир нь бардамнах зүйл үгүй юм.

Дэлхий дээр энэ хамгийн энгийн үнэн ёсыг таньж мэдсэн хүн тун цөөхөн болохоор хэн нэг хүн өөрийгөө бурхан мөн гэж хэлбэл тэд “тэр хүнд ад наалджээ, ихэд бардамнаж байна, тэр хүн бүр солиорчихсон байна” гэж хэлэх байх. Гэтэл нэгэн бурхан болсон хүний хувьд энэ нь тийм гайхалтай гэж бодогддоггүй, жам ёсны л зүйл байдаг. Жишээлбэл, тэр өдөр Багш нь та нарт тийм, тийм авшигтан тийм, тийм чадвартай, тэрээр гэртээ байх үед нь хадам эцгийнх нь өвчин нь сайжирдаг гэж ярьсан. Өөр нэг авшигтан мөн адил, эмнэлэгт очоод бясалгаж суухад хүүгийнх нь өвчин сайжирсан байна. Зарим хүн Багшийнхаа ном тайлахыг сонсоод билиг нь нээгдсэн, эсвэл Багшийнхаа номыг уншмагц билиг нь нээгдсэн гэх зэрэг явдал байдаг нь ялимгүй өчүүхэн, энгийн зүйл юм.

Энэ нь зөвхөн архад, эсвэл бодьсадвагийн дэс. Бид урьдын тийм, тийм бодьсадва, эсвэл архадад хүнийг өвчнөөс аврах чадал байдаг гэж үргэлж сонсож байсан. Тэдэнтэй хамт байх л юм бол аяндаа тийм буян хариулалтай болно. Тиймээс манай авшигтнуудын төрөл төрөгсөд нь хэдийгээр авшиг хүртээгүй, Арьяабалын номын цогцосыг бясалгаагүй боловч ойр төрлийн хүн нь Арьяабалын аргаар бясалгасан тул тэд бас төрөл дэвшиж чаддаг. Энэ нь тэдний садан төрөл нь хэдийн бодьсадва, эсвэл архадын дэсэд хүрснийг харуулж байгаа юм. Тиймээс сая тийм буян хариулалтай болж, тэдэнтэй ойргон харилцдаг л юм бол төрөл дэвшиж чадна. Гэтэл Багшийнх нь саяхан ярьсан тэр авшигтан яаж бардамнахаа өөрөө мэдэхгүй, түүний хувьд бол энэ нь аяндаа л болсон хэрэг. Бодьсадва болсноо тэр өөрөө ч мэдээгүй, эсвэл тэр өөрийгөө сүрхий архад болсноо сэхээрээгүй байдаг. Ойлгож байна уу? “Билгийн цаад хязгаарт хүрсэн очироор огтлогч” хэмээх сударт: “Хэрвээ архад буюу бодьсадва нь өөрийгөө бодьсадва болсон гэж боддог, эсвэл мэддэг

бол тэр нь бодьсадва биш” хэмээсэн байдаг.

Судар номд бичсэнээр, бурхан бодьсадва нь “бурхан бодьсадва” гэдгийг ямар утгатайг нь ч мэдэхгүй байдаг тул бардамнахгүй, бас өөрийгөө бодьсадва болсон гэж хэлэх ч үгүй. Түүнд тийм хандлага байхгүй болохоор их зан гаргадаггүй, гэхдээ тэр өөрийгөө хэн бэ гэдгээ мэднэ. Мэдэж байгаа мөртлөө мэдэхгүй, өөрийгөө таньж мэдэх нь зөвхөн ямар нэгэн багаж хэрэгсэл гэмээр бие махбод төдийхөн байгаагаар л мэднэ, эгэл хүний энэ “би гэх үзэл” нь цөм үгүй болон арилж, одоо дотоодод нь зөвхөн бурхан бодьсадвагийн хүч чадал л байна, энэ хүч чадал нь хүссэн бүхнээ хийж чадна, бид түүнийг захирч чадахгүй.

Өөрийгөө бурхан гэж Багш нь сая хэлсэн боловч, бурхан гэдэг нь ямар утгатайг тайлбарлаж чадахгүй. Хэрвээ Багшийгаа бурхан биш гэвэл бас болохгүй, энэ нь зөв биш. Багшийгаа бурхан гэвэл бас таарахгүй, бурхан биш гэвэл бүр ч таарахгүй, буруу болно. Учир нь судар номын ёсоор яривал тэр бол бодьсадва гэх юмуу, эсвэл тэр бол бурхан, тэр хүн Бурханы хутагт хүрсэн гэж хэлэх ёстой, гэтэл үүнийг үгээр ингээр илэрхийлэх ямар ч боломжгүй. Үүнийг тайлбарлахад тийм хялбар биш, ойлгож байна уу? Ойлгохгүй бол надад бас өөр арга алга.

Энэ нь Шагжамуни Бурхантай адил, тэрээр өөрийгөө Түүнчлэн ирсэн мөн, Түүнчлэн ирсний дэсэд хүрсэн гэжээ. Тэр эцэгтэй: “Би одоо эгэл хүний хөвгүүн биш, би нэгэнт Бурханы хутагт хүрчихсэн. Та уламжлалт ёсоор намайг дуудахтун” гэж хэлсэнтэй адил. Учир нь түүний эцэг нь учрыг нь олохгүй байснаас урьдын байдлаар түүний гарыг барьж, тэврээд “чи бол миний хөвгүүн” гэж хэлэхээс тэр болгоомжилсон байна. Ингэвэл сүр жавхлантай байдалгүй болох учир тэр нэгэнт Мөрийг олж, бурхны дэсэд хүрснээ тодорхой хэлж өгөх хэрэгтэй болжээ. Тэр ингэж хэлсэн үү, үгүй юу? (Хэлсэн, гэж бүгдээрээ хариулав) Түүний ингэж хэлсэн нь эцэг хааныгаа өөртөө мөргүүлэх гэсэн юмуу, эсвэл өөртөө зориулуулж ямар нэгэн дуулиантай ёслол хийлгэх гэсэн хэрэг биш, зөвхөн тун энгийн үнэн ёс, үнэн бодитой учрыг л ярьсан хэрэг билээ.

Энэ нь яг нэг эмч бусдад би сургуулиа төгсчихсөн гэж ярихтай адил, эсвэл гэрээс гарсан эмэгтэй толгой дээрээ сахилын гурван толботой болсны дараа “Би нэгэнт гэлэнмаа болсон” гэж хэлэхтэй адил юм. Ийм л юм, тийм ч сүрхий хэрэг биш. Гэлэнмаа болсны дараа гэлэнмаа болохын өмнөхтэйгөө адилхан хүн байхаас биш, онцгой ямар нэг зүйл хийгээгүй, тийм биз? Бурханы хутагт хүрэх нь мөн адил. Хэрвээ үгээр илэрхийлье гэвэл бас ингэж л хэлэх ёстой. Энэ нь омгорхож бардамнаж байгаа хэрэг биш юм. Зарим хүн өөрийгөө бурхан гэж хэлдэггүй боловч түүний төрх байдал, зан араншин нь нэн омгорхог байдаг, тийм үү? Тэр өөрийн биеэ бусдаар хүндлүүлэн мөргүүлж, мөнгө, эд зүйл авч байдаг нь омгорхон бардамнаж байгаа хэрэг юм. Бурхны дэсэд хүрсэн хүн өөрийгөө бурхан гэх нь омогшиж бардамнахын үүднээс үүссэн биш, харин үнэн учир, жам ёсны тун энгийн учраа ярьсан төдий явдал юм. Энэ нь яг “би идэж цадлаа” гэж хэлж байгаатай адил, идэж цадсан бол “идэж цадлаа” гэж

хэлнэ, үүнд бардамнах юм юу байх вэ?

Бурханы хутагт хүрчихсэн бол “Би Бурханы хутагт хүрсэн” гэж л хэлнэ. Учир нь би өөрөө Бурхан чанараа нэгэнт таниад өөрөө бурхан болсноо мэдэж байдаг. Бас хамаг төрөлтөн ч бүгдээрээ бурхан гэдгийг нь мэдсэн тул тэр цагт омгорхож бардамнах зүйл үгүй байна. Би болон хамаг төрөлтний зөрөө гэвэл би бурхан гэдгээ мэдсэн, харин хамаг төрөлтөн өөрсдийгөө бурхан гэдгээ мэдээгүй төдий л юм. Гэхдээ Бурханы хутагт хүрсэн хүний хувьд хүмүүс бүгд л эрх тэгш болохоор тэр тэгж бардамнадаггүй, тэр хамаг төрөлтөнтэй адилхан юм чинь бардамнамаар юм юу байх вэ? Та нар утгыг нь ойлгож байна уу?

Тиймээс нэгэн бурхан болно гэдэг тун жирийн хэрэг. Авшиг хүртвэл Бурханы хутагт хүрнэ, Бурханы их далайтай нэвтрэлцсэнээр бид бас энэ их далайн ус болно. Нэг дусал ус далайд унаж далайтай нэвтрэлцээд далай болох тэр үедээ “Би хэзээ далайд орох бол доо?” гэж асуух хэрэгтэй гэж үү? Аль хэдийнээ далайд орчихсон шүү дээ, ойлгож байна уу? Аажмаар гэлэн замхарч, эцэстээ үзэгдэхгүй болоод бүр далай болно. Үүнтэй адилаар, бид авшиг хүртэх үедээ Бурханы далайд ороод бурхад болчихсон, бидний хүч чадал сэтгэгдэшгүй, зөвхөн хэрэглээгүй байгаа төдий л юм. Цаг нь болоод хэрэглэх л юм бол бидний хүч чадал хичнээн аугаа их гэдгийг бид мэдэх болно. Одоо үүнийг хэрэглэх гэж хүчилж болохгүй, энэ хүч чадлыг хэрэглэе гэсэн ч хэрэглэхийн аргагүй, тиймээс та нар өөрсдийгөө бурхан гэдгээ мэддэггүй. Цаг нь болж, хэрэглэх нөхцөл байдалтай болох үед аяндаа хэрэглэх юм. Тэр үед та нар өөрсдийн хүч чадлаа ямар гэдгийг мэдэх болно, одоо мэдь гэсэн ч болохгүй, цаг нь хараахан болоогүй байна, мөн одоо энд суралцаж байгаа болохоор хэрэглэх шаардлага байхгүй.

Үнэн хэрэгтээ одоо ч үүнийг хэрэглэж болно, зөвхөн та нар мэддэггүй л юм шүү дээ. Бясалгаж суугаа үедээ маш олон төрөлтөнд ач тус хүртээж болно, бидний хэлбэлзлийн хүч бүх улс орныг гэрэлтүүлж, бүхий л орчлон ертөнцийн далд ухамсрыг дээшлүүлж чадна. Гэхдээ бид үүнийгээ мэдэхгүй байвал хамгийн сайн, хэрвээ мэдэх юм бол бидэнд “би гэх үзэл” үүснэ. Энэ бол яагаад удтал бясалгасны дараа л Төгс Гэгээрсэн Их Багш болж чаддагийн учир юм. Бид өөрсдийн би гэх үзэл болон хувийн зан чанараа сургаж, би гэх үзлээ хянан захирах хэрэгтэй. Бидний би гэх үзэл арилсны дараа угаас байсан хүч чадлаа ашиглахад аюулгүй байдаг. Жишээ нь, эцэг, эх нь хүүхдэдээ их мөнгө өгдөг ч бүгдийг нь банкинд хадгалж байгаад хүүхдээ арван найман нас хүрсний дараа сая хэрэглүүлдэг. Яагаад вэ гэвэл хэдийгээр энэ мөнгө бага наснаас нь авахуулаад арван найм хүртэлх хугацаанд түүний мөнгө байсан ч арван найман нас хүрэхээс нь өмнө хэрэглүүлж болохгүй. Учир нь тэр мөнгөө дураараа хэрэглэж, хэрэгцээгүй зүйл ихээр худалдаж аваад мөнгөө үрчихнэ, эсвэл мөрийтэй тоглоом тоглож, тэр ч байтугай бусдад мэхлэгдэх гэх мэт явдал байдаг болохоор эцэг, эх нь түүнд өгч хэрэглүүлэхгүй байдаг. Гэвч энэ мөнгө нэгэнт түүнийх учир арван найман нас хүрсэн үедээ гарган авч хэрэглэх юмуу, эсвэл гэрлэх үед нь

түүнд өгнө, учир нь тэр үед тэр хэрэглэж болно. Тэр нэгэнт өсөж, ухаан суусан болохоор энэ мөнгөө хэрхэн зарцуулахаа мэдэх учир дэмий үрэхгүй, бас бусдад мэхлэгдэхгүй байж чадна.

Одоо та нар Багштайгаа адилхан, адилгүй гэмээр юм үгүй. Цорын ганц ялгаа гэвэл та нар энэ хүчийг хянаж чадахгүй бөгөөд яаж хэрэглэхээ мэдэхгүй байгаа. Та нар өөрийн хүч чадлаа ухаарч мэдээгүй байгаа. Алгуур аажмаар хувь барилдлага гүйцэхээр та нар хамаг төрөлтийг гэнэт гэтэлгэж чадах болно. Тэр үед бид бидний мөнгө хэрэглээд барагдашгүй, бидний хүчин чадал сэтгэгдэшгүй бөгөөд бид бол бурхад болсон гэдгээ улам бүр ойлгох болж, сэтгэл амар амгаланд хүрнэ.

Наян найман бурхан гэдэг нь наян найман бурхан байдаг гэсэн үг биш, тэр нь зөвхөн бишрэл магтаалын нэр төдий юм. Жишээ нь, багш нь гэгээн тунгалаг биетэй болоод гэрэл нь маш их бол энэ бүх шинж чанар нь зарим нэг бишрэл магтаалын нэр болон хувирч, шавь нар нь: “Би энэ болор бурхнаас сахил хүртэж дагасан, цаглашгүй гэгээн гэрэлт бурхнаас сахил хүртэж дагасан” гэж хэлэх болно. Энэ нь тэд өөрийн багш - нэгэн бурхныг сайшаан магтаж байгаа л төдий хэрэг. Учир нь түүний багшид тун олон чанар бий, энэрэнгүй, нигүүлсэнгүй мөртлөө бас гэгээн биетэй, болор биетэй, үүнээс өөр маш олон чанар ч бий. Тиймээс наян найман бурхан гэдэг нь наян найман бурхан байдгийг хэлж байгаа юм биш, ойлгож байна уу? Учир нь нэгэн Их Багшид маш олон шинж чанар байдаг болохоор бид: “Багш аа, та бол их энэрэнгүй, нигүүлсэнгүй, гэгээн гэрэлтэй, их хүч чадалтай, их эрх чөлөөтэй” гэж ярьж магад.

Наму гэдгийн утга нь: Би сайшаан магтамуу, их энэрэнгүй, их нигүүлсэнгүй багшийгаа сайшаан магтамуу, цаглашгүй, хязгаарлашгүй ач буянт багшийгаа сайшаан магтамуу, цаглашгүй гэрэлт багшийгаа сайшаан магтамуу гэсэн үг юм. Багш гэдэг нь бурхан гэсэн утгатай, “наму их гэгээн гэрэлт бурхан” гэдэг нь “би их гэгээн гэрэлт багшаа сайшаан магтамуу” гэсэн ийм л утгатай юм. Тиймээс бурхадын алдар нэр тун олон байдаг ч үнэндээ зөвхөн ганцхан Бурханыг л сайшаан магтсан хэрэг юм.

Бяруузана (Vaigocana) нь хамгийн дээд Бурханыг төлөөлж байгаа юм. Хичнээн олон бурхны нэрийг уншиж байвал төдий чинээ олон бурхан байна гэж бодож болохгүй, тийм утгатай биш. Жишээлбэл, Арьяабал Бурханы цолыг зарим хүн “Эрхшээлт бодьсадва” гэж дууддаг, зарим хүн “Эрхэт хоншим бодьсадва” гэж дуудна, бас зарим хүн “Ялгуусан аймшиггүй өглөгт бодьсадва” гэж дууддаг. Тиймээс “Наму аймшиггүй өглөгт бодьсадва”, “Наму эрхэт хоншим бодьсадва”, “Наму Бодалин уулын биндэрьяа болор бодьсадва”, “Наму хоншим бодьсадва”, “Наму мянган мутарт, мянган мэлмийт бодьсадва” гэх мэтээр хэлж байгаа ч үнэндээ бүгд ганцхан Арьяабал Бурханыг л хэлж байгаа юм. Үүнтэй адилаар наян найман бурхан гэдэг нь нэг бурхныг олон янзаар дуудсан магтаал дуудлагын төдий юм. Жишээлбэл, нэг үзэсгэлэнтэй бүсгүйг магтахдаа олон янзын нэрээр дуудаж болно, америк хүн өөрийн хайрт



хүнээ дуудах үедээ “чи бол миний амраг” гэхгүй, харин “чи бол миний зөгийн балхан” гэх юм уу, үгүй бол “чихэр бурамхан” гэнэ, эсвэл “янаг хонгорхон минь” гэдэг, тийм биш үү? Хэдийгээр хичнээн олон нэрээр дуудсан ч үнэндээ энэхүү гоо үзэсгэлэнг, өөрийн найз бүсгүйгээ л нэрлэн дуудаж байгаа хэрэг билээ. Дундад улсын эртний хаад өөрийнхөө хатнаа хонгор минь, хайртай хатан минь, хайрт минь, хатан минь гэхчлэн дууддаг нь үнэндээ өөрийн эхнэрээ л дуудаж байгаа хэрэг юм.

Үүнтэй нэгэн адилаар урьдын шавь нар Их Багшийгаа сайшаан магтахдаа олон янзын магтаал нэр хэрэглэж байсан ч байж магадгүй, тиймээс их гэрэлт бурхан, хотол гийгүүлэгч бурхан, хиргүй тунгалаг бурхан... гэх мэтийн наян найман бурхан болжээ. Наян найман бурхан гэдэг нь нэг бурхан ч биш, бас наян найман бурхан ч биш юм. Мянга түмэн бурхан гэдэг бас нэгэн адил, хамгийн агуу нэг Бурханыг сайшаан магтаж байгаа л хэрэг юм. Түүний цог чанар нь тийм үлэмж арвин, тэр нь тийм төгс чадвартай, түүний хүч чадал нь тийм сэтгэгдэшгүй болохоор нэг нэрээр нь түүний нэг чадварыг төлөөлүүлснээс тийм олон дуудлага нэртэй болсон хэрэг.

Бурхан мөн нэг адил, зарим хүн Түүнийг Аллах гэж дуудна. Зарим хүн түүнийг Яхве гэж дуудна. Зарим хүн түүнийг “Эзэн Бурхан” гэж дуудна. Бас зарим нь “Юй Хуан Да Ди3” гэх мэтээр дууддаг нь бүгд л хүмүүс тийм нэрэнд дуртай болохоороо тэгж нэрлэдэг байснаас болсон хэрэг. Хожмын хүмүүс үүнийг ойлгохгүй болоод үргэлжид дуудлага нэрийн тухайд маргалдан “миний нэр чиний нэрээс гоё сонсголонтой” гэж булаацалдаж байдаг. Хүмүүс үнэхээр хөөрхөн, ганц хоёр нэрийн төлөө тэр ч байтугай дайтаж мэднэ. Ингэж маргалдахад Багш нь хамгаас дургүй.

Бурхан нь наян найм биш, нэг бурханд өчнөөн олон цог чанар бий гэж би сая ярьсан. Хотол гийгүүлэгч бурхан, хотол ариутгагч бурхан, хиргүй сайн зандан бурхан, зандан гэрэлт бурхан, маани эрдэнийн банжид чимэгт бурхан, баясгалан зүрхэн маани эрдэнийн давхарлагт бурхан, ертөнцийн аливааг баясан үзэгч их хичээнгүй дэвшилтэт бурхан гэх мэтээр яаж нэрлэж дуудсан ч үнэндээ бүгд нэгэн адил. Энэ нь яг Арьяабал Бурханд гучин хоёр лагшин дүр байдагтай адил, Авид Бурханыг зарим хүн цаглашгүй гэрэлт гэнэ, зарим хүн цаглашгүй урт наст гэнэ, зарим хүн Авид Бурхан гэнэ, зарим хүн Амитаба (Amitabha) гэнэ. Энэ нь цөм адил нэг утгатай, гэтэл хожмын хүмүүс хоорондоо тэмцэлдэн маргалдах юм. Одоо бид толь бичигтэй болсон болохоор тэндээс хайж олоод Amitabha гэдэг нь Авид Бурханыг хэлж байгааг мэдэж болно.

Тайваньд дөнгөж ирээд байхдаа би тэднийг бурхны долоон хоногийн даяанд суухыг хараад тэдэнтэй хамт нэг, хоёр удаа бурхны хөргийг гороолсон юм. Тэд бурхныг дурсан унших болгондоо “Наму Ави дүүфүү” (тайвань хэлээр “наму Ами тофу”) гэж уншиж байх шиг сонсогдоод байв. Тэгэхэд би дотроо: “Сонин юм даа! Яагаад бурхныг дурсан уншихгүй зүгээр л дүүфүү, дүүфүү гэж уншаад байна вэ?”

(бүгдээрээ инээлдэв) гэж бодож байсан. Үнэхээр наму Ави дүүфүү гэж уншиж байх шиг байдаг, тийм үү, үгүй юу? Тэр үед би хятадаар ярьж чадахгүй, тайвань хэлийг бүр ч ойлгодоггүй байсан. Гэхдээ бидний вьетнам хэлээр “дүүфүү” (энэ нь тайвань аялгатай их төстэй сонсогддог) гэж хэлдэг болохоор би: “Сонин юм! Эд яагаад дүүфүүг вьетнам аялгаар уншаад байна вэ?” гэж бодож байв. Тэдний аялгуулан уншиж байгаа наму Ави дүүфүү-г би үргэлжлүүлэн сонсож байгаад: “Үд арай болоогүй байтал эд тэгж их өлсөөд байгаа юм байх даа?” (бүгдээрээ инээлдэв) гэж бодож байсан билээ.

Тиймээс аливаа маргаан тэмцэлдээн нь ер нь нэрийн төлөө юм. Жишээлбэл, Хятад хэлэнд “ус” гэхийг герман хэлээр wasser гэнэ, франц хэлээр eau гэж хэлдэг, үнэн хэрэгтээ энэ нь бүгдээрээ л усыг нэрлэж байгаа. Урьд нь толь бичиггүй байсан болохоор их хурц ширүүн маргалддаг байжээ, одоо арай дээр болсон. Тиймээс Эзэн Бурхан болон Бурхан Будда гэж ярих нь бас адилхан. Зарим хүн Багшийнхаа Эзэн Бурхан гэж байнга ярихыг сонсмогц тэр дорхноо: “Та яагаад Эзэн Бурхан гэж ярьдаг юм бэ?” гэхэд нь би: “Би энэ тухай ярьж болно, та сонсохгүй байсан ч хамаагүй.” гэж хариулдаг. Тэр хүмүүс үнэхээр бядуу, ердөө л нэрийн төлөө маргалддаг юм.

Намайг Америкт очих үед нэг номч багш надтай уулзах гэсэн юм. Тэгээд би түүний суугаа газарт хоёр хоног суухдаа тэнд дахин саатах дургүй болсон. Учир нь тэр надаас асуусан болохоор би үнэнээр нь ярьсанд, тэрээр тэр дорхноо: “Та яагаад Эзэн Бурханыг ярина вэ?” гэж асуусан нь би яг л хүнд ял хийчихсэн гэмээр байв. Тэгэхэд нь би: “Тэгвэл ярихаа больё. Танд Эзэн Бурхан байхгүй байгаа нь таны хэрэг, надад бол байгаа юм” гэсэн билээ.

Энэ нь даанч бядуу, тун ч тэнэг маргаан мөн, энэ нь байж болшгүй мунхагийн хана юм. Хэдийгээр энэ ханыг эвдвэл л болчих байтал үнэхээр эвдэхийн аргагүй, та нар төсөөлж чадах уу, тийм хялбархан хэргийг тэр харин ойлгож чадахгүй байх нь үнэхээр сэтгэл зовмоор хэрэг. Учир нь энэ бүхнийг бид үзвэл маш амархан, тун ойлгомжтой хэрэг, тийм биз дээ? Гэтэл тэр харин тэнд төөрөлдөөд гарахын аргагүй байдаг, ийм байдлаар яаж ном дэлгэрүүлж чадах вэ? Тэгээд бясалгах тусмаа сул дорой болж, улам бясалгавал улам өнчрөх нь үнэхээр хүмүүсийн урмыг хугалж, санаа алдуулах хэрэг.

**Асуулт:** Авшиг хүртэж, Бурханы хутагт хүрчихсэн байтлаа яагаад хааяа зарим хүн муу санаа үүсгэж бусдыг хорлодог юм бэ?

**Их Багш:** Энэ бол түүний дутагдал, хувийн зан чанар болон дадал зуршил нь болохоос эзвүүрхмээр зүйл биш юм. Бид ойлгохгүй учраас түүнийг муу санаа гэж боддог. Үнэндээ энэ бүхэн нь үйлийн үртэй холбоотой. Бурханы хутагт хүрсний дараа хамаг төрөлтөнтэй үйлийн үр байхгүй болчихдог биш, үйлийн үр мөн л оршоор байдаг. Тиймээс зарим хүн Бурхан Багшийг хөнөөхийг завдаж, зарим хүн Бурхан багш луу чулуу шидэж байсан байна, ойлгож байна уу? Шагжамуни Бурханы

толгой нь бас өвддөг байсан. Тэр хэлэхдээ, урьд нь үхлүүт байсан нэг загасыг өшиглөснөөс болсон гэжээ. Иймхэн юмнаас болж толгой өвдөх үйлийн үртэй болсон байна. Шагжамуни Бурханд ч бас үйлийн үр байсан хэрэг. Тэр нэг газар бадарлахаар очоод гурван сар өнгөрөхөд бадарлах хоол олдсонгүй. Учир нь өөр бусад гадаад номтнууд түүнийг гүтгэж байж, гэвч тэр өөрөө энэ бол миний үйлийн үр гэж хэлж байжээ. Урьд нь ямар үйл тарьсан бол одоо тийм үрийг хураана гэдгийг судар номд тун тодорхой өгүүлсэн байдаг.

Заримдаа Бурхан Багш бас шавь нартаа уурладаг байж. Тэр Ананд, Рахула нарыг загнаж байсан нь муу санаанаас болсон биш, бас ширүүн зантайгаас нь болсон ч биш, харин Рахула, Ананд хоёр дэндүү бядуу байснаас болжээ, ойлгож байна уу? Тэр нь үйлийн үртэй холбоотой бөгөөд хамаг төрөлтний үйл түйтгэрээс болжээ. Тиймээс Бурхан Багшийн хувьд муу санаатай хүн гэж үгүй, муу хүн ч гэж үгүй. Гэвч “муу биш” гэж хэлэх аргагүй болохоор “муу” гэж хэлэх л хэрэгтэй болдог. Энэ нь хамаг төрөлтний дэстэй хамааралтай болохоор ингэж хэлсэн хэрэг. Бурхан Багшийн хувьд ял гэм гэж байдаггүй, муу санаа гэж үгүй, бас сайн санаа ч гэж үгүй. Муугүй, сайнгүй, гэмгүй байдгаас яг бяцхан хүүхэдтэй адилхан болж хувирдаг. Бяцхан хүүхэд юуг гэм нүгэл гэдэг, юу муу зүйл болохыг мэдэх үү? Мэдэхгүй, тэд тун гэнэн цайлган. Тэд чухамдаа тун цайлган, сэтгэл нялхрах гэдэг нь ийм учиртай билээ.

Бурханы хутагт хүрсний дараа сайн ч үгүй, муу ч үгүй болно. Зургаадугаар үеийн өвгө багш Хүй Нэн: “Сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй байх нь сая Бурхан чанар мөн болой” гэж хэлжээ. Ойлгож байна уу? Тиймээс бурхан хэзээ ч гэм нүгэл хийхгүй. Тэр юу хийсэн ч ердөө гэм хийхгүй. Тэр гэм хийдэггүйн учир нь хамаг төрөлтөн буруугаар ойлгохоос болгоомжилдог, тэд ойлгохгүй байх вий гэдгээс эмээдэг. Хэдийгээр бурхны билиг нээгдсэн ч хамаг төрөлтний билиг нээгдээгүй болохоор бурхан юу хийсэн ч зүй ёсонд нийцүүлж байдаг билээ.

**Асуулт:** Авшиг хүртээгүй хүмүүст ч Бурхан чанар байна, тэд бас бурхан мөртлөө муу үйл үйлддэг. Жишээлбэл, хүн алсны дараа алсан болон алагдсан хоёр этгээд нь хоорондоо өшөө хорслын барилдлагатай болдог.

**Их Багш:** Тийм, учир нь тэд энэ чухал чанарыг ойлгодоггүй. Өөрсдийгөө л үйлдсэн гэж боддог, тэдэнд хорлогдсон хүн нь бас түүний үйлдсэн хэрэг л гэж бодож байдаг. Тэгээд энэ хоёр нь нийлж, нэг зүйлийн хорсол заналын уур амьсгалыг бүрдүүлдэг юм, ойлгож байна уу? Тэд завшааныг хүлээж байгаад хариугаа авахаар буцаж ирэх болно. Тиймээс тэд үйлийн үрийн энэ хүрдэн дотор эргэлдээд л байдаг.

Бурхан бодьсатва юу хийсэн ч бүгд ял гэмгүй, үйлийн үр байдаггүй, учир нь тэд нэгэнт энэ бүхнийг нэвт харчихсан байдаг, хувь барилдлагыг тун тод хардаг болохоор үүнийг би хийсэн гэж ярьдаггүй, ойлгож байна уу? Тэр өөрөө үүнийг хийсэн биш гэдгээ мэддэг бөгөөд тун тодорхой

ойлгодог, тиймээс тэр үйлийн үрийн холбоост орохгүй, түүний тархи толгой нь үүнийг бичиж шингээж авахгүй. Та нар утгыг нь ойлгож байна уу? Энэ нь түүний хийсэн зүйл биш гэдгийг тэр мэддэг учраас энэ нь түүний хувьд ямар ч асуудал биш байдаг. Гэтэл хамаг төрөлгөн үүнийг ойлгодоггүй, тэд өөрсдийгөө хийсэн гэж боддог учраас үйл түйтгэртэй болдог. Тиймээс өдөр бүр Аялгууны урсгалаар энэ үзэл бодлоо угааж ариусгах хэрэгтэй. Жишээ нь, өнөөдөр та ял гэм хийсэн бол ял гэм хийгээгүй гэж өөрийнхөө биед хэлэхийн аргагүй байдаг. Тийм учраас Аялгуу ажиж, тэр гэмт бодлоо угааж цэвэрлэх хэрэгтэй, үүнээс өөр ямар ч арга байхгүй, ингэж угаагаад нэг хэсэг хугацаа өнгөрсний дараа угаамаар юмгүй болно. Угааж дадсаны дараа зөвхөн Аялгуу ажиг л үлдэнэ. Гэмт бодол орж ирэхээс өмнө угааж арилгах учраас тэр үед гэмт бодолгүй байж, зөвхөн Аялгуу ажиж, Аялгууны урсгал дотор нь байхад ямар ч гэмт бодол орж ирж чадахгүй болно. Орж ирэхээс нь өмнө хэдийн угаагаад арилгачихсан байдаг, ойлгож байна уу?

Бидний одоогийн бясалгал хараахан хангалттай биш болохоор өнгөрсөн хугацаанд хуримтлагдаж ирсэн гэмт бодол арвин ихээр үлдэж хоцорсон байгаа юм. Хэдийгээр Аялгууны урсгал аль хэдийнээ оршин байгаа боловч тэр нь тэр бүхнийг тэгж хурдан угааж амжихгүй. Бид маш их угаасны дараа Аялгууны урсгал нь гэмт бодлоос давуу болох тэр үед л аливаа гэмт бодол орж ирмэгцээ угаагдан цэвэрлэгдэнэ. Энэ нь яг нэг хүн их өлсөөд бага сага юм олж идсэн ч идээгүйтэй бараг адил байдаг шиг, эсвэл цэлгэр их далай дотор хог новш хийсэн ч хийгээгүйтэй адил, бохир ус хийсэн ч бохирдуулж чадахгүйтэй адил юм. Ойлгож байна уу?

Нэгэнт билиг нээгдсэн байтлаа өөрийгөө харин дорой бядуу гээд өдөржин Багшаасаа: “Би яагаад ийм бядуу юм бэ? Би яагаад ахуй ойлголтгүй юм бэ?” гэж асуух юм. Хэрвээ нэгэн хүн ахуй ойлголтгүй байсан ч Багшдаа нэгмөсөн бүрэн итгэдэг бол зарим үед тэр нь ахуй ойлголттой байснаас ч илүү дээр байдаг. Ахуй ойлголттой байсан зарим хүн харин зугтаж орхидог. Ахуй ойлголт байхгүй ч гэсэн Багшдаа итгэдэг бол түүний дэс маш өндөр бөгөөд далд ухамсар нь тун тодорхой ойлгодог гэдгийг илэрхийлж байгаа юм, тиймээс тэрээр Багшдаа итгэж байгаа хэрэг, ойлгож байна уу? Өөр хүн хэдийгээр бага сага ахуй ойлголттой болсон байдаг ч тэр нь асуурийн орны, эсвэл хоёрдахь ертөнцийн ахуй ойлголт төдий л юм байдаг. Шүүн магадлах билиг ухаан нь хангалтгүй болохоор Багш нь ямар ч муу зүйл хийгээгүй байхад тэр харин аль хэдийн зугтаачихсан байдаг. Тэр тэгж байгаа нь Багшдаа зэмлэгдсэндээ биш, Багшдаа зэмлүүлсэн шавь тэгж зугтсан бол бас ойлгож болно. Зэмлүүлээгүй шавь ингэж зугтаах нь тэдний дэс нь өндөр биш, билиг ухаан нь гүйцээгүйгээс болж байгаа хэрэг. Зөвхөн билиг ухаантай хүн л Багшдаа итгэж чадна.

Тиймээс бусдын хүслэнт ахуйг хамаарч хэрэггүй. Бусдын хүслэнт ахуй нь өндөр дэсийг төлөөлж чадна гэж хэлэхийн аргагүй, асуурийн орон ахуй ойлголтоор дүүрэн байдаг. Асуурийн ертөнцөд нэг зуун тавиас илүү хүслэнт ахуй байдаг бөгөөд тэдгээр нь тодорхой ялгагддаг, мөн

хүслэнт ахуй бүрт маш олон бага хүслэнт ахуй бий. Хэрвээ та тэнд зугаалахыг хүсвэл хичнээн галав тойрч зугаалсан ч асурийн орныг дуусгаж чадахгүй, дээд хүслэнт ахуйг бол бүр ярих ч юм биш.

Тиймээс хүслэнт ахуй нь тийм ч сүрхий юм биш, билиг ухаан байх хэрэгтэй. Билиг ухаан байгаа эсэхийг тун амархан мэдэж болно. Хэрвээ нэг хүн Багшдаа маш их итгэдэг бол тэр хүний барилдлага тун гүнийг мэдэж болно. Өмнөх төрөлдөө бясалгал хийснээс билиг ухаан нь маш өндөр болоод Багшийнхаа сургаал номлолыг ойлгох болж, Багшдаа итгэдэг юм. Яг л Мьял богд (Milagera)-той адил. Түүнийг та нар мэдэх үү? Тэр анх гарч ирэх үедээ ямар ч ахуй ойлголтгүй байжээ, учир нь түүний багш нь юу ч зааж өгдөггүй, өдөртөө загнахгүй бол зодно, зодохгүй бол загнана, бас хөөнө, зүйл бүрийн зовууртай номын цогцсоор түүнийг зовоож байсан ч тэр багшдаа итгэсэн хэвээрээ байж, долоон жилийн турш хүлцэхүйеэ бэрх хүчир зовлонг тэвчсээр байсан юм. Хэрвээ эгэл хүн, эсвэл билиг ухаан нь өндөр биш хүн байсан бол тэр даруйдаа орхиж одох байсан, тэр дороо салж яваагүй байсан ч гурав, дөрвөн жилийн дараа явах л байсан. Гэтэл тэр долоон жил салж явсангүй. Өдөр бүр байшин барина, дараа нь нураана, бас барина, дахин нураана, хараалгуулна, зодуулна, хөөгдөнө. Тэр юу хийсэн ч буруу болоод багшдаа нэг ч удаа магтуулж байгаагүй аж. Түүнийг магтах нь байтугай, харин түүнийг загнахгүй бол аль хэдийнний гайхалтай хэрэг байжээ. Ийм нөхцөл байдалд тэр хүчлэн тэсвэрлэхээс биш, ахуй ойлголт гэх юм түүнд байсангүй. Учир нь багш нь түүнд номын цогцосыг зааж өгөөгүй юм чинь ахуй ойлголт яаж байх вэ? Өдөр бүр түүнд байх ахуй ойлголт нь цусаа гартал ажиллаж, бүх бие нь шарх сорви болсон ч юу ч ярьж болохгүй, багштайгаа уулзахад тун бэрх, багшаасаа юу асуусан ч багш нь хариулахгүй, багшаасаа номын цогцос уламжлахыг гуйсан ч зааж өгөхгүй байх зэрэг төдийхөн. Гэтэл эцэст нь тэр Их Багш болоод өнөөг хүртэл алдартай хэвээр байгаа билээ.

Тиймээс ахуй ойлголттой болбол сайн гэсэн үг биш гэдгийг бид ойлгох хэрэгтэй. Ахуй ойлголт байгаад л болчих биш гэдгийг их билиг ухаантай хүн тодорхой мэддэг учраас Багшдаа маш их итгэдэг юм. Ахуй ойлголттой байх эсэхийг нэг их анхаарсны хэрэггүй, ойлгосон биз? Учир нь зарим хүн Багштайгаа хамт ажиллах ёстой, Багштайгаа хамт энэ тоост хорвоод байх хэрэгтэй учраас дэндүү их ахуй ойлголттой байж болохгүй. Хэрвээ ахуй ойлголт нь ихэдвэл ажиллах аргагүй болно, тэд үүндээ сэтгэл ханаж, мансуурах болно. Одоо Багш нь юу зааж байгаа, эсвэл юу хийлгэж байгааг та нар ер ойлгож мэдэхгүй байглаа тийм их ахуй ойлголттой болчихвол ажиллаж чадахгүй, тэгээд Багш нь л ганцаараа энд үлдэж ажиллах болно. Ажиллах хүнгүй болоод бүгдээрээ сэтгэл ханаж, рашаан ууж, тэндээ мансууран суух болно. Одоо ахуй ойлголт гэмээр юм үгүй байтлаа болохоо больчихоод би хаалга нээ гэхэд цонхны хөшиг нээдэг, би цонхны хөшиг нээгээч гэвэл тэр очиж хаалга нээдэг. Хэрэв өдөржингөө ахуй ойлголтон дотроо мансуураад байвал одоо яадаг хэрэг билээ?

Тиймээс бясалгал хийдэг хүн зарим үед дэндүү их ахуй ойлголттой байж болохгүй, учир нь бид энд хийх ажилтай, санааг минь ойлгов уу? Жишээлбэл, бид бусдад зориулж хоол хийх хэрэгтэй гэж бодъё. Хоол хийж байгаа үедээ бид элдэв амтганыг зооглож болохгүй. Учир нь бид хоол бэлтгэж, хүмүүсийг хооллох гэж яарч байгаа болохоор зарим үед тэр нь ямар амттай болсныг нь өөрөө ч мэдэхгүй, гагцхүү хурдан болгоод хүнд идүүлэхийг л боддог. Тэдний “шав шув” хийн идэж байхыг сонсоод гал тогооны байранд байгаа бид гайхан тэд яаж ийм их ахуй ойлголттой болсон бэ? гэж бодох болно. (бүгдээрээ инээлдэв) Хэрвээ та үзэмжтэй сайхан хувцас өмсөж, амтархан ташаахаар хоолны ширээний ард сууж, хүнээр дайлуулахыг бодож байвал хоол хийж чадахгүй. Та хоол хийхийг хүсвэл тэнд суугаад эрхэм дээдийг элдэх, эсвэл сайхан амтганыг амтархан, бусдаар зочлуулах боломжгүй байх болно, ойлгож байна уу? Үүнтэй нэгэн адил, өчигдөр та нар өвгөн багшийнд очиж хоол идэх үеэр бусдаар зочлуулж, үдийн хоол амтархан зооглочихоод гэр лүүгээ буцсан. Та нарыг зочилж байх үедээ тэд өөрсдөө хооллож чадаагүй бөгөөд ямар амттайг нь амтлах боломжгүй байсан. Та нарыг амтархан зооглож байх үед юуг амтархан таашааж байгааг тань тэд мэдэхийн аргагүй, ойлгож байна уу? Бидний үүрэг бол ажиллах болохоос таашаал авах биш юм, ажиллаж дууссаны дараа бид бас жаргалыг нь хүртэж чадна. Бид хүн бүрт зориулан хоол унд бэлтгэдэг болохоор бүгд идэж цадсаны дараа бид бас суугаад хамтдаа хооллож болно.

Бид Төгс баясгалант оронд очих үедээ л иднэ, одоо идсэний хэрэггүй. Хэрвээ одоо идвэл хоол хийх хүнгүй болно. Ер нь бусдад хоол хийж өгөх хүн байх ёстой. Хэрвээ бүгдээрээ идэж таашаахыг л бодох юм бол хэн хоол хийх вэ? Ойлгож байна уу? Ажиллах дуртай хүн тун цөөн, бодь сэтгэл үүсгэх хүн тун цөөхөн. Хамаг төрөлтөн бурхан бодьсадвад найддаг, өөрийн биедээ найдах хүсэлгүй, тэгээд бас ажиллах хангалттай эр зориг ч байдаггүй, учир нь ажлаасаа таашаал авч чаддаггүй. Ажиллаж байгаа хүнд жаргах завшаан тун ховор байдгийг та нар ойлгох хэрэгтэй. Багшид нь тийм хурдан самади агуулах завшаан олдож байсныг та нар харж байсан уу? Самадид ортол “пин” гэх дуунаас цочоод гарч ирнэ. Зарим үед ингэх нь тун аюултай байдаг болохоор би самадид гүн орж зүрхэлдэггүй. Учир нь гэнэт цочоод гарч ирэх нь маш аюултай, биед тун муу, гэмтэж мэднэ.

Багш нь бас унтахыг хүслээ ч унтаж чаддаггүй, уг нь долоо хоногийн даяаны үеэр Багш нь амарч байх ёстой байдаг ч, жаахан ч гэсэн амрах боломж олдсонгүй. Нэг талаар би та нарыг харж харгалзаж байхад нөгөө талаар хүн орж ирээд үймүүлдэг. Тэднийг орж ирүүлэхгүй байж бас болохгүй. Долоо хоногийн даяан болгонд үргэлжид үймүүлж саатуулах зүйл тун олон гардаг. Зуны оршлын үед ч тэд долоо хоног болгон хүрч ирдэг, зуны оршил дуусах дөхөх тусам Багш нь улам их ядардаг. Багш нь үргэлжид ажиллаж байснаас биш, нэг өдөр ч амарч чадаагүй, долоо хоногийн даяанд сууж байхдаа ч Багш нь мөн л ажилласаар байдаг. Дөнгөж сая ярьсан шиг та нарыг унтаж байхад



Багш нь бас ажиллах хэрэгтэй болдог, та нарыг хоол идэж байхад Багш нь хэдийгээр идэх дургүй байсан ч та нарыг адислахаар очих хэрэгтэй болдог. Багш болох ч үнэхээр амаргүй дээ!

## ХҮНДЭТГЭЛИЙН НАЙМАН НОМЫН ЁСНЫ ШИНЭ ТАЙЛБАР

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Тайбэй хотын Шиндиан  
1987 оны 12 дугаар сарын 29*

Эцэг, эх болсон хүмүүс үр хүүхдээ юу гэж боддогийг та нар мэдэх үү? Та юу болсон ч хамаагүй, улсын хаан болсон байсан ч хамаагүй, тэд таныг өөрийнхөө хүүхэд хэмээн бодож, таныг тэврэх юмуу, үгүй бол элгэндээ нааж энхрийлэн хайрлах гээд байдаг. Шагжамуни Бурхан хүний ийм сэтгэлийг ойлгож, мэдэж байсан болохоор нагац эх нь гэрээс гарсны дараа иймэрхүү байдал үүсэхээс санаа нь их зовж байсан байх. Учир нь тэр нэгэнт Бурханы хутагт хүрээд тэнгэрийн болон хүн төрөлтний Их Багш болсон болохоор эгэл нэг эх хүнд захирагдаж болохгүй билээ. Энэ нь ачлалгүйгээс болж байгаа юм биш, ингэх нь түүний ном уламжлахад нь амаргүй байж, юм болгон дөхөм дөтгүй, сэтгэлийн аяар болохгүй болж, ер нь үргэлж нэг хүн хажуугаас нь захирч, асууж, бас ингэж, тэгж хий гэж зааж дохиод таныг нэгэн эрхт хүн байлгахгүй байвал та хэрхэн ном дэлгэрүүлж чадах вэ? Тиймээс тэрээр нагац эхийгээ гэрээс гарахыг зөвшөөрөөгүй байжээ. Ананд нагац эхийнх нь өмнөөс хэд хэдэн удаа гуйсны ачаар Шагжамуни Бурхан нагац эхийгээ гэрээс гарахыг зөвшөөрчээ. Энэ хүндэтгэлийн найман номын ёсыг Шагжамуни Бурхан ярьсан байж мэднэ, учир нь тэр нагац эхийнхээ сэтгэлийг эргүүлж буцаах санаатай байсан аж. Хэрвээ өөрийнхөө нагац эхийг гэрээс гарахыг зөвшөөрвөл үүнээс хойш бусад олон эмэгтэйг бас гэлэнмаа болгох ёстой болно. Өмнө нь эрэгтэй, эмэгтэйчүүд нэг дороо бясалгаж байгаагүй болохоор эрэгтэй, эмэгтэй хүмүүс нэг дор олноороо цугларвал асуудал гарахаас тэр ихэд айж байжээ. Эрт цагт орчин үетэй адилгүй байсан. Одоо бол гадуур явж байгаа эмэгтэйчүүдийг хаа сайгүй харж болно. Урьд нь энэ нь тийм түгээмэл биш байсан, ойлгож байна уу? Эмэгтэй хүмүүс бүгдээрээ далдалж нуугддаг байсан, хэрвээ гадагш гарах хэрэгтэй болбол хэн нэг эр хүн дагалдан явах хэрэгтэй, ингэвэл гадны хүмүүс түүнд халдаж чадахгүй. Хурим хийж гэрлэхээс өмнө эхнэр болох хүнээ ямар зүс царайтайг ч мэдэхгүй, гэртээ буулгаж аваачсаны дараа тэр нь хичнээн муухай царайтай байсан ч тэсвэрлэн хүлцэх ёстой болно. Нийгмийн тийм нөхцөл байдалд эмэгтэй хүнийг гэлэнмаа болгох

нь тун бэрхтэй асуудал болохыг Шагжамуни Бурхан мэдэж байсан. Ингэх нь нийгэмд маш том өөрчлөлт гаргаж, эрэгтэйчүүдийн бүлгэмийн бясалгалд тун их нөлөөлөх болохоор тэр нагац эхийгээ хүлээн авч гэрээс гаргаж зориглохгүй байсан биз ээ. Харин гэлэнмаа нь гэлэнгийн дайтай бясалгаж чадахгүй гэсэн санаа огт биш.

Бас Шагжамуни Бурхан гадагш гарах үед гэлэнтэй хамт явдаг. Сүүлд нь ирсэн гэлэнмаа, тухайлбал, түүний нагац эх юмуу, үгүй бол түүний хатан, эсвэл хааны ордны олон охид, эмэгтэй ирээд түүнийг дагаж гэрээс гарах юм бол тэдэнд өөрсдийн урьдын үүргээ гэж орхих нь хэцүү байх болно, түүний ар, өврөөс нь дагадаг хуучин заншлаараа, гэлэнд ингэх, тэгэх хэрэгтэй гэж зааварлах юмуу, эсвэл зэмлэн загнах зэрэг учир явдал гаргахаас тэр их айж байсан байх. Тиймээс гэлэнмаа нь гэлэнд ёслох хэрэгтэй хэмээн тогтоожээ. Учир нь гэлэнгүүд түүнтэй удаан хамт байгаа бөгөөд гэлэнмаа нар хэн байсан ч бай хамаагүй, бүгд саяхан ирсэн болохоор гэлэнд хүндэтгэл үзүүлэх ёстой нь мэдээжийн хэрэг, ойлгож байна уу? Тэд өөрсдийгөө хаадын угсаа гэж боддог учраас хуврагийн бүлгэмд ирсний дараа ч гэрээс гарсан хүний амьдрал ямар ядуу зүдүү гэдгийг мэдэхгүй, өөрсдийгөө язгууртан гэж үзсээр байна байх гэж Шагжамуни Бурхан эмээж байв. Мөн түүнтэй хамт бясалгаж байгаа тэр гэлэнгүүд ямархуу ёс суртахуунтай байх бол гэдгийг мэдэхгүй, учир нь түүнийг дагаж бясалгаж байсан маш олон гэлэн хааны удмынх биш, дээд зиндааны нийгмийн байр суурьтай гэр бүлээс гарч ирсэн биш, тэдний зарим нь тун ядуу хоосон юмуу, эсвэл байр суурь нь тун доогуур хүмүүс байжээ. Тиймээс Шагжамуни Бурхан нагац эх, эсвэл эхнэр нь гэрээс гарсны дараа тэднийг дорд үзэж өөрсдийгөө Шагжамуни Бурханы төрөл садан хэмээн бардамнаж, гэлэнгүүдтэй муугаар харилцаж, тэднийг хүндэтгээгүйн улмаас өөрсдөдөө үйл түйтгэр бүтээхээс айж байсан байх.

Энэ шалтгаанаас болсон байж ч болзошгүй, Шагжамуни Бурхан тийм чанга хатуугаар нагац эхээсээ асуусан нь: “Та тэр бүх учир зүйд үл нийцэх сахил санваарыг сахиж чадна гэвэл би таныг үлдээе” гэжээ. Үүний уг санаа нь түүнийг шахамдуулж байгаад буцаах гэсэн хэрэг, учир нь түүний нагац эх нь сахил нь санаанд багтамгүй ийм хатуу чанга гэдгийг мэдвэл хүндээс нь бэрхшээн буцах байх гэж тэр боджээ. Гэтэл Шагжамуни Бурханы санаж байснаас өөрөөр нагац эхийнх нь Мөрийг хайх сэтгэл хатуу чанга байсан бөгөөд тэрээр даруу хичээнгүй байж, аливаа нөхцөлийг нь хүлээн зөвшөөрсөн байна. Тэр үед Шагжамуни Бурхан түүнийг гэрээс гарахыг нь зөвшөөрөхгүй байхын аргагүй болжээ.

Энэхүү хүндэтгэлийн найман ёсыг Шагжамуни Бурхан тогтоосон байж магадгүй ч тэр нь тухайн үеийн онцгой нөхцөл байдлаас болсон байна. Тэгэхлээр бид өнөөдөр тэр бүх үйл хэрэгт хэт хүлэгдэх хэрэггүй, ойлгож байна уу? Учир нь өнөөдрийн нөхцөл байдал огт өөр болсон. Шагжамуни Бурхан нэгэнт нирваандаа буцчихсан, бид өөр нэгэн амьд сэрүүн байгаа бурхнаас гурч байгаа болохоор түүний нөхцөл шаардлага нь адилгүй байна, учир нь цаг үе өөр болсон болохоор нөхцөл шаардлага

ч бас өөр болох ёстой. Сахил санваар гэдэг нь хувиршгүй зүйл биш, тэр нь улсын хууль дүрэмтэй л адил. Улс бүр өөр өөрийн хууль дүрэмтэй байдаг. Цаг үе одоо болох үед улсын хууль цааз ч бас өөрчлөгдөн хувирдаг, тийм үү, үгүй юу? (Бүгдээрээ тийм гэж хариулав) Урьд нь машин тэрэг байхгүй байсан учраас замын хөдөлгөөний дүрэм гэж байгаагүй, машинаа яаж жолоодох, явган хүн хаагуур, яаж явах нь хамаагүй, улаан, ногоон гэрэл гэж ч байхгүй байсан нь мэдээж. Гэтэл одоо бид замын гэрлэн дохиотой болсон, машин тэрэг, моторт дугуй, нисэх онгоц, галт тэрэгтэй болсон, хэрэв бид эрт дээр үеийн замын дүрмийг л дагаад байвал явахын аргагүй болно.

Яао болон Шүн-гийн цаг үед хэрвээ бид эд зүйлсээ гадаа хаяж орхивол авах хүн байхгүй, шөнө болоход хаалга үүдээ хааж түгжсэний ч хэрэггүй байжээ. Гэтэл одоо хаалга үүдээ хаахгүй бол яришгтай болно. Одоо хаалга үүдээ хаахаар барахгүй бас түгжээд гадуур нь төмөр хашаа, төмөр хаалга хийж бэхлэх хэрэгтэй. Хэдий тэгсэн ч бас аюултай байна. Яао, Шүнгийн үеийн хууль дүрэм тийм байтал одоо яагаад хаалга үүдээ хаах болсон бэ гэж хэлж болохгүй биз дээ? Та өөрийнхөө түрийвчийг өөрөө л сайн харж хандахаас биш, зам дээр зориуд тавьчихаад бусдыг авахгүй байх гэж бодож болохгүй биз дээ? Түрийвчээ та халаасандаа хийсэн ч хүн ухаад авчих юм чинь бас яалаа гэж зам дээр тавих билээ дээ? (Бүгд инээлдэв) Та мөнгөө банкинд хадгалуулах юмуу, гэртээ тавьсан ч бусад хүн нэгэн адил хаалгыг тань эвдэж байгаад аваад явах юм чинь зам дээр тавьсан юмыг хэн ч авахгүй байна гэж яаж байх вэ?

Цаг үе адилгүй болвол сахил санваар ч адилгүй болох учраас эрт үеийн ёс журамд найдаж болохгүй. Мэдээж, хулгай хийхгүй байх зэрэг үндсэн сахилуудыг үлдээж хэрэглэвэл бидэнд бас ач тустай. Жишээ нь, хулгайлахгүй гэх сахилыг хэрэв хувраг хүн зөрчвөл маш муухай явдал болох биш үү? Улсын хууль дүрэмд ч ийм явдлыг зөвшөөрдөггүй. Аливаа сахил санваарт бүгдэд нь л улсын хууль дүрмийн тухай ярьсан байдаг. Сахил санваарт тогтоосноор бид амь хороож болохгүй, мөн хүн алж болохгүй гэжээ. Амьтныг алж хороох үед түүнийг тэгж их зовж байгааг нь хараад бид тэсэж чадахгүй байтал нэн ялангуяа хүн алахыг хэлэх хэрэг байна уу? Бид ямар хатуу сэтгэлээр хүн алах билээ? Энэ нь сахил санвааргүй байсан ч мэдвэл зохих энгийн хэрэг юм. Тиймээс хувраг байтлаа амь хорооно гэж яаж байж болох вэ? Аливаа төрөлтийг хайрлаж хамгаалах нь нэг зүйлийн тун энгийн хэрэг юм.

Садар самуун явахгүй нь ч бас яриангүй зүй ёсны учир болно. Гэрээс гарсан хүнд чөлөө зав гэж байхгүй байтал хаана ямар заваараа садарлан самуурах вэ? Хэрвээ хань ижилтэй бол хэзээ өөрийн биеийг гэтэлгэж чадах вэ? Хэзээ хамаг төрөлтийг гэтэлгэж чадах вэ? Хэрвээ та хэд хэдэн хүүхэдтэй болбол өдөржингөө тэднийг асраад бясалгал хийх ер хэрэггүй болж, гэртээ байгаа хүнтэй адил болно. Тиймээс гэлэн, гэлэнмаагийн аяг нь ч мэдээжээр гэрлэж болохгүй нь учир зүйтэй хэрэг юм. Хэрэв тэд аяга барьж бадарлах бол нэг талаар бадарлаж, нөгөө талаар хүүхдээ гэвэрч, өөрийн идэх хоолоо бадарлахаас гадна бас дахин

“Сүү байна уу?” гэж асуух болно. (бүгдээрээ инээлдэв) Мэдээж ингэж болохгүй.

Шагжамуни Бурханы тухайн үед тогтоосон сахил нь бүгд л хуврагийн бүлгэмээ хамгаалж, тэдний бясалгал хийхэд дөхөм байхыг бодсон хэрэг. Учир нь тэд өдөр бүр зам хөөж, замын хажууд унтдаг байтал хэрхэн эхнэр, хүүхэдтэй байж болох вэ? Амь хороохгүй, хулгайлахгүй, садар самуун явахгүй, худал хэлэхгүй, архи уухгүй гэдэг нь үндсэн сахил болох учраас тэд яриангүй тодорхой мэдэж, чадах чинээгээрээ сайн сахих хэрэгтэй. Хоёр долоо хоногт нэг удаа, эсвэл хоёр хоногт нэг удаа усанд орох зэрэг бусад сахил нь тийм ч чухал биш. Миний бодоход, ямартаа ч та нар хичнээн удаа усанд орсон ч хамаагүй, бурхны дэсэд хүрч чадах боломжтой.

Хүндэтгэлийн найман ёсны нэгдүгээрт: “Нэг гэлэнмаа сахил аваад зуун жил болсон байсан ч хамаагүй, саяхан сахил авсан гэлэнтэй тааралдвал түүнд мөргөх ёстой” гэж тогтоосон байдаг. Шагжамуни Бурхан чухам ингэж хэлсэн эсэхийг бид тодорхой мэдэхгүй, учир нь тэр нэгэнт нирваандаа буцсан, судар номууд нь түүнийг нирваан дүр үзүүлээд дөрвөн зуу гаруй жил өнгөрсний дараа жинхэнээр бичиг үсгээр тэмдэглэгдэн гарч ирсэн. Тэр үеэс одоог хүртэл хоёр мянга гаруй жил болж байгаа, энэ хооронд олон удаа орчуулж, хуулбарлаж байснаас буруу ташаа олон зүйл бичигджээ. Жишээ нь, сахил санваарын нэг хэсэгт: Нэг эмэгтэй хүн гэрлэсэн бол арван хоёр жилийн дараа л сая гэлэнмаагийн сахил хүртэж болно гэжээ. Гэтэл өөр нэгэн орчуулгад харин: Хэрвээ нэг эмэгтэй хүн нэгэнтээ урагласан бол арван хоёр настайдаа гэлэнмаагийн сахил хүртэж болно гэж дурдсан байдаг. Энэ нь Вьетнамд: Гэрлэсэн эмэгтэй хүн ураг салаад арван хоёр жил болсны дараа л сая гэлэнмаагийн сахил хүртэж болно гэх болсон байдаг. Олон янзын үзэл санаа байдаг, зарим судар номд арван хоёр нас болон арван хоёр жилийн алиныг ч дурдсангүй, зөвхөн арван хоёр гэж бичсэн байдаг нь бид юу гэж төсөөлөн бодсон ч болохоор юм. Тиймээс ном судар заримдаа тийм ч найдвартай биш байдаг.

Одоо би хамгийн алдартай тэр хүндэтгэлийн найман ёсыг тайлбарлая. Учир нь олон гэлэнмаа Багшдаа: “Бид хаана очсон ч ялгаагүй гэлэнгүүд ерөөс хүндэтгэлийн найман ёсоор гэлэнмааг дарж, ам нээмэгц хүндэтгэлийн найман ёс гээд гэлэнмааг заавал түүнд мөргүүлэх юм. Зарим гэлэнгийн бясалгал сайн биш, судар номоо ч ойлгохгүй мөртлөө харин өөртөө мөргүүлэх гээд байхаар бид дургүйцдэг” гэв. Энэ нь хамаагүй, гэлэнд мөргөсөн нь чулуунд мөргөсөнтэй адил. Чулуун бурхан, модон бурханд мөргөж болоод байгаа атал яагаад амьд бурханд мөргөж болохгүй гэж? Хамаг төрөлтөн бүгдээрээ бурхан, хэрвээ бид ингэж бодох юм бол ямар ч асуудал гарахгүй билээ.

Одоо бид энэ хүндэтгэлийн найман ёсыг Шагжамуни Бурхан ярьсан эсэхийг ярилцъя. Хэрвээ “тийм” бол тэр яагаад тэгж хэлсэн бэ? Учир нь манай дэлхий ертөнцөд ерөөсөө эрэгтэй хүнийг хүндэлж, эмэгтэй хүнийг дорд үздэг ёс байсаар ирсэн билээ. Аль ч улсад ийм л

байдаг, азийн улсууд бүр ч горьгүй, ингэж эрэгтэйг хүндэтгэж, эмэгтэйд доогуур хандах үзэл нь олон мянган жил оршин байгаа тул одоо сольж өөрчлөхийн аргагүй. Эмэгтэй хүн гадуур явахад яагаад тийм хэцүү байдаг вэ? Яагаад гадагш гарах нь ховор байдаг вэ? Учир нь гадагш гарах үед нь үргэлж эрэгтэй хүмүүс тэдэнд төвөг учруулдаг нь тун аюултай байдаг. Тиймээс эмэгтэй хүн ном дэлгэрүүлэх юмуу, эсвэл арилжаа наймаа хийх, үгүй бол ямар нэгэн эрсдэлтэй хэргээр ганцаараа гадагшаа гарах нь тун амаргүй байдаг. Тиймээс эртнээс аваад одоог хүртэл эмэгтэй хүн нэр алдартай болсон нь тун цөөн. Цэрэгт элсэхээр очсон ч хувцсаа сольж эрэгтэй хүн шиг харагдах хэрэгтэй, яг л Хуа Мулан юмуу, эсвэл өөр эмэгтэй баатрууд шиг. Манай Вьетнамын Арьяабал Бурханы намтарг Арьяабал Бурхан эрэгтэй хүн хэмээн хуурмаглаж байгаад сахил авсан гэдэг билээ. Энэ дэлхий дээрх хамгийн том асуудал бол эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн асуудал юм. Эрт дээр үеэс олон улсын дайн байлдаан цөм эмэгтэй хүний төлөө болж байжээ, тийм биз дээ? Олон ч улсын хаад хаан суудлаа алдсан нь мөн л эмэгтэй хүний өнгө зүснээс болжээ. Олон хүн ажил үйлс, амь нас, алдар нэрээ алдаж байсан нь бас л эмэгтэй хүний өнгө зүснээс болж байжээ. Тиймээс эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн өнгө зүснээс их айдаг юм. Нэг агуу эр хүний ар талд лавтай нэг агуу эмэгтэй бий гэж бид бүгд ярьдаг. Үүний санаа нь: Агуу эмэгтэйн тусламж үгүй бол тэр эрэгтэй тэгж хөгжин дэвших боломжгүй бөгөөд тэглээ их алдаршиж чадахгүй гэсэн үг билээ. Ихэнх хүн яагаад ингэж хэлдгийг би мэдэхгүй. Гэхдээ энэ бүх зүйлийг тоох хэрэггүй.

Сахил санваар нь яагаад эмэгтэй хүнийг тэгж ихээр дарж дарамталдаг юм бэ? Энэ нь эмэгтэйчүүдийн хүч нь дэндүү ихээс болсон байж мэднэ. Учир нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн өнгө зүсийг хармагц дурлаж, ямар нэгэн асуудалтай болчихдог. Гэтэл эмэгтэй хүн тийм амархан татагддаггүй, нэг эрэгтэйг харангуутаа гэртээ харьсны дараа түүнийг санаж мөрөөдөх юмуу, эсвэл түүнд амархан итгээд байдаггүй. Тийм үү, үгүй юу? Гэтэл эмэгтэй хүнийг харвал эрчүүдэд асуудал үүсэх нь нилээд амархан. Тиймээс Шагжамуни бурханы хугтгий олсны дараа зөвхөн эрэгтэй шавь хүлээн авч байсан юм. Тэр цаг үед зөвхөн эрэгтэй хүн гэрээс гарахаас биш, эмэгтэй хүн гэрээс гардаггүй байжээ. Шагжамуни Бурхан тодорч гарсны дараа л гэлэнмаа бий болсон, түүнээс өмнө байгаагүй.

Энэтхэгт эмэгтэй хүн гадуур явахад тун хэцүү гэдгийг би өчигдөр та нарт ярьсан. Формоса, Ау Лак, Хятад зэрэг азийн улсад бас эрэгтэй хүнийг хүндэлж, эмэгтэй хүнийг доогуур үздэг асуудал оршиж, эрэгтэй, эмэгтэйчүүдийн байр суурь эрх тэгшгүй боловч эмэгтэй хүн ганцаараа замд явахад тийм ч их асуудал гарахгүй. Харин Энэтхэгт энэ нь том асуудал үүсгэдэг. Эмэгтэй хүн хэзээ ч ганцаараа гадагш гарч болдоггүй, өнөөг хүртэл ийм хэвээрээ л байна. Багш нь Энэтхэгт очих үед хэдийгээр гэрээс гарагчийн хувцас өмсөж байсан ч бас л асуудал гардаг байв. Гэрээс гарсан хүний хувцсыг өмсөхөөс өмнө, мэдээжээр, олон хүн надад анхаарал хандуулж, зарим нь надтай ярилцах гэж ирдэг



байсан ч би аргацаан шийдвэрлээд байсан болохоор асуудал үүсээгүй. Гэрээс гарагчийн хувцас өмссөний дараа ч мөн л асуудал байсаар байдаг. Тиймээс эрт үед эмэгтэй шавь хүлээн авах нь их том хэрэг, яг нэгэн хувьсгалт хөдөлгөөн шиг том хэрэг болсон юм. Шагжамуни Бурхан асуудал гарахыг мэдэж байсан болохоор эмэгтэй хүнийг шавиа болгох дургүй байжээ. Гэвч хамгийн түрүүнд ирж түүнийг дагаж сурах гэсэн эмэгтэй хүн нь өөрийнх нь нагац эх болохоор тэр татгалзахын аргагүй болжээ. Тэр ч байтугай Ананд бас өсгөсөн эхийнх нь өмнөөс олон удаа гуйсан болохоор Шагжамуни Бурхан аргагүйн эрхэнд эмэгтэй хүнийг гэрээс гарахыг зөвшөөрчээ. Ананд ярихдаа маш чадамгай, тэрээр: “Бурхан минь ээ! Эх тань таныг балчир багаас тань хайрлан энхрийлж, халамжлан өсгөсөн билээ. Та түүний ачийг хариулахгүй байж болохгүй шүү дээ” гэжээ. Тэр тэгж хэлэхэд, мэдээжээр, Бурхан Багшид цааш татгалзах арга үгүй болжээ. Ананд бол түүний хамгийн хайртай, эрх шавь нь юм. Тэр тэгж олонтоо гуйсны ачаар эмэгтэй хүн гэрээс гарч болохыг Бурхан Багш эцэстээ зөвшөөрчээ. Одоо маш олон гэлэнмаагийн сүм хийдэд Анандыг дурсахын тулд түүний хөрөг зургийг шүтэн тахиж, хүндэтгэл үзүүлж байдаг. Учир нь хэрвээ Ананд байхгүй байсан бол гэлэнмаа ч бас байхгүй байх байсан.

Одоо бид хүндэтгэлийн найман ёсны нэгдүгээрхийг үзье: “Өндөр настай гэлэнмаа байсан ч шинээр сахил авсан гэлэнг харвал босон ёсолж амрыг нь айлтган залж суулгах хэрэгтэй” гэжээ. Шагжамуни Бурхан яагаад ингэж хэлсэн бэ? Түүний нагац эх нь Шагжамуни Бурханы байгаа газарт анх очих үедээ их шийдэмгий байсан бөгөөд түүний гэрээс гарах гэсэн чанга хатуу сэтгэлийг Шагжамуни Бурхан хараад түүнийг буцаах гэж шаардах аргагүйгээ мэдсэн байна. Түүний харснаар нагац эх нь гутал ч өмсөөгүй, бие нь тоос шороонд дарагдаж, хувцас нь урагдаж навтарсан байв. Тэр хол газраас явган ирснийг Шагжамуни Бурхан хармагцаа, тэр лавтай гэрээс гарахаар ирснийг мэдээд маш их айж, бушуухан арга сүвэгчлэж, түүнийг шахамдуулан гэрт нь буцаахыг боджээ.

Шагжамуни Бурхан яагаад нагац эхийгээ гэрээс гарахад тэгж их айсан бэ? Нэгдүгээрт, нагац эх нь хааны удам, улсын эх болохоор бэрх хатуу амьдралыг туулаагүй тул хожим тэсэж тэвчиж чадахгүйгээс айсан. Хааны ордны амьдрал гэдэг нь ар, өврөөс нь хүн дагахаас гадна доорх зарцаараа асруулж сурсан байдаг. Одоо нэгэнт нас ахисан хүн болохоор хуврагийн бүлгэмд орж яахан болох вэ? Бурхан Багшийн хуврагийн бүлгэм нь бүгд эрэгтэй хүмүүс болохоор түүнийг асарч харгалзах хүнгүй. Эрэгтэй хүн эмэгтэй хүнийг асарч яаж болох вэ? Тэд угаасаа ганцаар амьдарч дассан, өөрийн биеэ асран харгалзаж чадахгүй байтлаа настай хүнийг яаж асарч чадах билээ? Тэгээд бас нагац эх нь хааны гэр бүлийн хүн, түүний авах гэсэн юм нь тийм ч амар олдохгүй. Урьд нь тэр нэг л зарлиг буулгамагц тэр дороо хэдэн зуун хүн гарч, авах гэсэн юмыг нь хайдаг байсан, харин энд ирээд бас тэр байдалтайгаа адил амьдралыг хүсэх юм бол болохгүй. Хэрвээ түүнд муу хандах юм бол ачлалгүй болоод уур амьсгал тун муу болж мэдэх болохоор түүнийг үлдээж авах

нь тийм ч амар хэрэг биш. Тэгээд ч тэр бас Бурхан Багшийн нагац эх билээ. Тэр хаа очсон ч, мэдээжээр, хүн бүр түүнийг хянан захирах аргагүй болж мэднэ, түүнд юм зааж сургахад амаргүй байна. Түүний би гэх үзэл нь тун их болсноос өөрийн эрх мэдэлдээ эрдэж, Бурхан Багшийг ч гэсэн юу хийхийг нь зааж сургаж ч магадгүй гэж Тэрээр айж байв. Тэр бол орчлон ертөнцийн эрх хүндтэн, эгэл хүн биш, түүний хөвгүүн биш болсныг мартаж орхино. Одоо тэр бол орчлонгийн эрхт ард, орчлонгийн эрдэнэ болсныг тэр мартаж орхих болно. Тиймээс Шагжамуни Бурханд нагац эхийгээ үлдээж авах нь тун амар биш байсан хэрэг, үүнийг би сайн ойлгож байна.

Түүнээс гадна нагац эх нь түүнийг гэжээж өсгөсөн нь бурхны эхтэй тэнцэх учир ножим тэрээр архадыг хүндлэлгүй, энэ, тэр гэж шаардлага тавиад шууд захиран жолоодох гэвэл бүр ч илүү уршигтай болно. Ингэхэд хүрвэл гэрээс гарсан бусад хүн сэтгэл амаргүй болно, бас Бурхан багш голч шудрага байж чадахгүй гээд болохгүй болох юм. Хэрвээ нагац эхийгээ үлдээх юм бол үүнээс хойш ордны сул хатад, гоо бүсгүйчүүд бүгдээрээ хүрч ирээд гэрээс гарна гэвэл яадаг билээ? Тэд маш үзэсгэлэнтэй авхай нар болохоор гэлэнгүүд үүнээс болж дуусаж ч магадгүй гэдгийг та нар төсөөлж байна уу? Ордны сул хатан, үзэсгэлэнтэй авхай нар гэдэг нь бүгд л хааны ордны эрх танхи хүмүүс. Тэд үзэсгэлэнтэй сайхан бөгөөд энхрийлүүлж хайрлуулж байдаг болохоор хуврагийн бүлгэмийн гэлэнгийн сэтгэлийг хөдөлгөхөд хүрвэл тэр гэлэн архадууд дууссан хэрэг болно биз дээ? Тэд угаасаа ийм олон сайхан эмэгтэйг харж байгаагүй болохоор хамаг анхаарал нь сарниж мэдэх юм.

Үүнээс гадна нагац эх нь гэрээс гарсны дараа өвдвөл ордны сул хатан, үзэсгэлэнтэй авхай нар түүнийг үгүйлэн санагалзаж, бүгдээрээ уулзахаар ирж мэднэ. Тэдний ингэж ирэх нь гэрээс гарах гэсэн биш, зөвхөн нагац эхийг нь харахаар ирсэн төдийхөн байсан ч энэ нь бас уршиг тарьж, асуудал үүсгэх юм. Хуврагийн бүлгэмд нэгэн хэсэг үзэсгэлэнтэй авхай нар ирээд нүүрэндээ оо энгэсэг тавьж, гоёж будаад гоёмсог сайхан хувцаслан өдөр бүр нагац эхэд нь үйлчлэн асарч, түүний уйтгарыг сэргээж, өдөржин ярилцан инээлдэх юм бол энэ нь тэр архад, гэлэнгүүдэд маш их уршиг тарина биз дээ? Үр дагавар нь ийм болохыг Шагжамуни Бурхан мэдсэн болохоор ихэд айж, нагац эхийгээ үлдээхгүй юмсан гэж боджээ. Гэвч Ананд ахин дахин гуйгаад болохгүй болохоор нагац эхээ үлдээж, гэрээс гарахыг нь зөвшөөрчээ.

Тэр угаасаа нагац эхийгээ үлдээх санаагүй байсан болохоор зориуд ийм хатуу бөгөөд зүй ёсонд үл нийцэх найман ёс журмыг тогтоож, нагац эхийгээ айлгаж буцаах гэжээ. Ойлгож байна уу? Нагац эх нь угаас хааны удамтай болохоор мэдээж, эрхэм дээд зан сургалтай, түүний ааш авир, биеэ авч явах байдал нь эрхэмсэг, улс орны ард иргэд бүгд түүнийг хүндэтгэдэг, учир нь тэр бол улсын эх хүн мөн юм. Тиймээс сахилын нэгдүгээрт түүнийг гэлэнгүүдэд мөргөх ёстой гэж тогтоогоод үүнийг

мөрдөж чадах эсэхийг нь харах гэжээ. Уг нь хүн бүр түүнд хүндэтгэл үзүүлдэг байсан бол одоо тэрээр хуврагийн бүлгэмд орж ирээд ам нээж, үг хэлэхээсээ өмнө гэлэнгүүдэд мөргөх ёстой болжээ, мөн тэдний нас нь хэд гэдгийг ч хамаарахгүй нэгэн адил мөргөх юм.

Шагжамуни Бурхан хэрвээ тэр энгийн хүн бол тэр дороо сэтгэл нь эргэх байх гэж боджээ. Бурхан байж яагаад ёс зүйд үл нийцэх зүйл ярьдаг юм бэ? Ярьсан үг нь яагаад ийм хүний санаанд багтамгүй байгаа юм бэ? Яагаад зуун настай гэлэнмаа нь хорин настай гэлэнд мөргөх ёстой юм бэ? гэж түүний нагац эх бодох болно, нагац эхэд нь ийм сэжиг таамаг төрөх нь гарцаагүй. Хэрвээ тэр ам нээж маргалддаг л юм бол болчихно, Бурхан багш тэр доор нь: “За болжээ, та дургүй байвал эндээс явж болно, миний ёс журам ийм юм. Та хэрвээ хүлээж авбал үлд, хүлээн авч чадахгүй гэвэл яв даа.” гэж хэлэх гэжээ. Тиймээс Шагжамуни Бурхан зориудаар хүндэтгэлийн найман ёсыг тогтоосон байна. Миний хэлэх гэсэн санаа бол: Хэрэв тэр өөрөө тогтоосон бол энэ нь нагац эхийгээ хэцүү хүндээс нь бэрхшээн буцаахын тулд л зориудаар тогтоосон байна. Гэхдээ одоо хүн бүр Шагжамуни Бурхан хүндэтгэлийн найман ёсыг тогтоосон гэж байхад би бусадтай маргалдахыг хүсэхгүй байна. Хүндэтгэлийн найман ёсны нэгдүгээр ёсыг тайлбарласан нь логик учир зүйд нийцэж байна уу? (Тийм, гэж бүгдээрээ хариулав.) Шагжамуни Бурхан зориудаар ингэж тогтоох хэрэгтэй байж, ингэснээр нагац эхээ сахил хүртсэнийх нь дараа Шагжамуни Бурхан түүнийг хязгаарлан захирч, нагац эхийгээ бусад хуврагуудтай эрх тэгш болгож чадах юм. Үгүй бол нагац эх нь өөрийгөө олноос онцгой гэж бодно, ойлгож байна уу? Ер нь нагац эх нь аль хэдийнээ онцгой байсан, гэлэнмаа болсны дараа бүр ч илүү онцгой болно, учир нь тэр бол түүний нагац эх нь мөн. Хамгийн агуу Их Багшийн нагац эх нь болохоор мэдээж, тун онцгой юм. Тиймээс Шагжамуни Бурхан түүний би гэх үзлийг хязгаарлаж, түүнд өөрт нь онцгой юм үгүй гэдгийг мэдүүлэх гэжээ. Тэр Бурхан Багшид мөргөх төдий бус, бас залуу гэлэнгүүдэд мөргөх ёстой, ингэвэл сая тэр өөрийнхөө байдлаас мэдэх болно. Бурхан Багшийн санаа нь хуврагийн бүлгэмд ирсэн явдал нь хаан суух гэсэн биш гэдгийг түүнд мэдүүлж, түүний тэр би гэх үзлийг дарж авах гэсэн байжээ. Нагац эхийнх нь байдлаас бид харвал тэр үнэн сэтгэлээсээ Мөрийг олох гэсэн байна, тийм биш бол тэр дороо зугтаачих байсан байлгүй, тийм үү?

Одоо хоёрдугаар ёсыг тайлбарлая: “Гэлэнгүүдийг доромжлон гүтгэж болохгүй.” Гуравдугаар ёс нь: “Гэлэнгийн ял гэмийг дурдаж, тэдний алдаа бурууг хэлж болохгүй, гэлэн харин гэлэнмаагийн алдаа бурууг хэлж болно” Нагац эх нь хааны удмын хүн, хүмүүсийг захирч дадсан болохоор энд ирсний дараа тэрээр, энэ гэлэнгийн хоол идэх нь муухай, тэр гэлэн нь бохир заваан, хааны удмын намба төрхгүй гэж шүүмжлэн уршиг тарьж мэднэ. Шагжамуни Бурхан нагац эхтэйгээ хорин хэдэн жил хамт амьдарсны дараа л салж явсан болохоор нагац эхийнхээ ааш араншинг сайн мэднэ. Тиймээс ингэж хэлсэн байна, ойлгож байна уу? Тийм биш бол юу гэж тийм хатуу чанга байх вэ?

Ер нь бол, хэрэв өөрийн эх маань ирсэн бол бид лавтай алгуур аажмаар: “Ээжээ, та мэдэх ёстой, та хэрвээ гэрээс гарч намайг дагавал би машид баярлан хүлээж авна. Гэвч та миний байр суурийг ойлгох хэрэгтэй, би хүүгийн ёсоор танд хандах аргагүй болжээ. Та тун зовж зүдэрч, сэтгэл шаналж мэднэ, учир нь би олон түмэнд голч шударгаар ханддаг болохоор одоо би ганцхан таны л хүү байдгаа больсон” гэж хэлэх байсан билээ. Бид байсан бол ингэж аажмаар тайлбарлаж өгөхөөс биш, Бурхан Багштай адил шууд тийм чанга хатуу тогтоол гаргаж: “Гэлэнмаа нь гэлэнгүүдэд мөргөх ёстой, хэдийгээр зуу насалсан гэлэнмаа байсан ч хорин настай гэлэнд мөргөх ёстой. Мөн гэлэнгүүдийг муулж болохгүй, харин гэлэн нь гэлэнмааг шүүмжлэхэд асуудалгүй” гэхгүй байсан. Шагжамуни Бурханы нагац эх нь хатуу чанга зан араншинтай хүн байсан байж магадгүй, Шагжамуни Бурхан тиймэрхүү зан чанарт нь дургүй байсан ч байж мэднэ. Шагжамуни Бурхан түүний төрсөн хүү биш, харин түүний эгчийнх нь хүү юм. Хувийн зан чанар нь адилгүй хүмүүс хамт амьдрах бол хэдийгээр эх, хүү, эсвэл эгч, охин дүү байсан ч хоорондоо таарахгүй, олон асуудал үүсэх нь гарцаагүй. Тиймээс нагац эх нь орж ирмэгц Шагжамуни Бурхан урьдаар түүнд “уршиг тарихаар энд ирсэн биш гэдгээ та мэдэх ёстой” гэж тодорхой хэлж өгчээ. Энэ нь тэр хоёрын хоорондын асуудал гэж би хажуугаас нь бодитойгоор ажиглаж байна л даа. Тийм биш бол Шагжамуни Бурхан өөрийн хамгаас хүндэтгэн хайрладаг хүндээ тэгж чанга хатуугаар хандаж яаж чадах вэ? Нагац эхийнхээ ааш араншинг тун сайн мэддэг болохоор л түүнийг сургахын тулд тэр ийм аргыг хэрэглэх ёстой байсан ч байж магадгүй. Ингэвэл сая түүний би гэх үзлийг арилгаж, түүнийг ахиж дэвшихэд нь тусалж, бясалгалыг нь сайжруулан Мөрийг хурдан олуулж чадах юм.

Хоёр болон гуравдугаар ёсны агуулга нь бараг адил. Нагац эх нь бусдыг шүүмжлэх дуртайг Шагжамуни Бурхан мэдэж байсан байж магадгүй, гэртээ тэр бусдыг шүүмжлэн буруушааж дадсан болохоор доорх хүмүүсээ, эсвэл хүү болон бэрээ буруушаан зэмлэх үед тэд өөдөөс нь дуугарч зүрхэлдэггүй байжээ. Гэтэл хуврагийн бүлгэмд ирвэл тийм биш, тэр үед Шагжамуни Бурханыг дагаж байсан гэлэнгүүдийн бясалгал нь хэдийнээ маш сайн байсан, тэд гэрээс гараад маш удсан хүмүүс байжээ. Тэд хатуужилтайгаар бясалгаж, зарим нь архад, зарим бодьсадва, зарим нь Бурханы шашны хоёрдугаар дэсийн мөрийн хуггийг (si tuo han) олсон хүмүүс байжээ. Хэрэв нагац эх нь энд ирээд эгэл хүний сэтгэлээр тэднийг доорд үзэх юм бол болохгүй, эсвэл буруушаан шүүмжлэх хандлагаа хуврагийн бүлгэмд гаргавал бүр ч болохгүй, ингэснээрээ нагац эх нь үйл түйтгэр бүтээж, үг хэлээр нүгэл үйлдэхээс тэр айжээ.

Эгэл хүн архад, бодьсадваг буруушаан шүүмжилж болохгүй. Тиймээс Шагжамуни Бурхан эхлээд нагац эхдээ ямар байр сууринд байхыг нь тодорхой хэлж мэдүүлэх гэжээ. Учир нь нагац эх нь нас ахисан хойноо гэрээс гарсан болохоор, мэдээж, түүнд ач буян гэмээр зүйл ихгүйн дээр бас хэл ам нь зүгээргүй, бусдыг шүүмжлэн буруушаана. Тэр

тэдний тэнд очлоо ч гэсэн хэлээр үйлдэх нүглийг амархан хийх болно. Тиймээс эхлээд: “Та хэдийгээр гэлэнмаа боллоо ч гэлэнгүүдийг дур зоргоороо муулж болохгүй. Тэд харин таны мууг хамаагүй хэлж болно” гэж тодорхой хэлж өгөх ёстой байжээ. Яагаад тэр вэ? Шагжамуни Бурхан шударга бус болохоороо тэгсэн юм биш, түүний хэлсэн санаа бол тэр гэлэнгүүд нь нэгэнт архад буюу богд хүн болсон болохоор тэдний үзэл бодол нь харьцангуй тодорхой болсон, тэд богд хүний нүдээр харж, төв сэтгэлийг барин ямар ч ялгаварлах сэтгэлгүйгээр хандаж чадах юм. Жишээ нь, түүний нагац эх нь ямар нэгэн зүйлийг буруу хийж мэднэ, тэгвэл гэлэнгүүд түүнд “та тэгж хийж болохгүй” гэнэ. Тэд Бурхан Багшийн өмнөөс түүнийг сургаж чадах болохоор Бурхан Багш түүний алдаа дутагдлыг гэлэнгүүдээр хэлүүлж гэж зөвшөөрсөн биз. Багшийнхаа хэлж байгаа санааг ойлгож байна уу? Нагац эх нь саяхан ирсэн тул их зүйл сураагүй, ёс журмыг ч мэдэхгүй, тиймээс олон алдаа гаргах нь дамжиггүй. Нас ахивал хүмүүс ер нь бодол ухаан нь удааширч, буруу зөрүү юм хийчихэж ч магадгүй. Тэгээд хааны ордонд байхад нь суусан дадал зуршлаа ил гарган хүмүүсийг бодлоггүйгээр загнаж мэднэ. Тиймээс Шагжамуни Бурхан: “Та гэлэнмаа болсны дараа гэлэнгүүдийн алдаа бурууг хэлж болохгүй. Харин гэлэнгүүд гэлэнмаагийн алдаа бурууг шүүмжилж болно” гэжээ. Энэ нь би бодит байдлыг ажиг мэдсэн зүйл шүү. Хэрвээ үнэхээр ийм бол би ч бас зөвшөөрнө. Учир нь тэр гэлэнгүүд Шагжамуни Бурханыг дагаж бясалгаад их удсан, тэдний бясалгалын дэс төвшин нь нилээд сайн юм. Гэтэл гэнэт нэгэн хаан угсааны өндөр настай эмэгтэй хүрч ирээд тэднийг шүүмжилж, хянан захирч, дорд үзвэл, мэдээж, болохгүй. Тиймээс Шагжамуни Бурхан тийм хатуу чанга сахил санваарыг тогтоохоос өөр аргагүй байжээ. Энэхүү сахил нь түүний нагац эхийн байсан цаг үе болон нагац эхийнх нь хувьд зүйтэй байжээ. Гэвч үүнийг өнөө цаг үед, эсвэл Бурхан Багшийн бусад шавийн хувьд зүйтэй гэж хэлж болохгүй, заавал хүн бүр ингэх ёстой биш, эдгээр сахил нь зөвхөн тухайн үедээ л тохирч байсан зүйл юм.

Дөрөв дэх ёс: “Сахилыг олон хуврагийн дунд авах хэрэгтэй.” Энэ нь мэдээж, тэр үед гэлэнмаа байгаагүй болохоор тэр өөр хаана очиж гэлэнмаагийн сахил авах билээ дээ? Бурхан Багшийн санаа бол, тэр хувь хүний хайрын сэтгэл юм уу, үгүй бол хүмүүсийн хоорондын хувийн харилцаа холбооноос болж, ялангуяа түүнд ганцаарчлан гэлэнмаагийн сахил хүртээж болохгүй юм. Гэлэнмаагийн сахилын ихэнх нь эмэгтэй хүмүүст хамааралтай тул тэдгээрийг нагац эхдээ ганцааранд нь хэлэх тохиромжгүй болохоор олны өмнө хэлж, тэдний хооронд ямар ч асуудал, харилцаа холбоо байхгүй гэдгийг олон түмэнд мэдүүлэх гэжээ. Хожмын гэлэнмаа нар ч мөн адил, нэг гэлэнгээс ганцаарчлан сахил авч болохгүй, олонтой хамт сахил авах хэрэгтэй, ойлгож байна уу? Юу л байна түүнийгээ ярина, бүр зарим зүйлийг эмэгтэй хүнд хэлэхэд тийм ч таатай сонсогдохгүй юмуу, эсвэл эрчүүдийн өмнө хэлж болохгүй зүйлс байсан ч олон хүмүүсийн өмнө хэлсэн болохоор нууц гэмээр юм үгүй болох юм. Ийм л учир шалтгаанаар Бурхан Багш ингэж тогтоосон

байна. Та нар утгыг нь ойлгож байна уу? Түүний хэлсэн санаа нь: Олны дунд сахил авах хэрэгтэй, учир нь маш олон зүйлийг хэлэхэд нүүр улайх юмуу, эсвэл эндүүрэл үүсэж мэднэ. Бие махбодтой холбоотой зүйл маш олон байдаг болохоор хэрвээ ганц нэгээрээ нөгөөдөө хэлбэл хайр сэтгэл, эсвэл тачаангуй хүсэл үүсэж мэднэ. Тиймээс “Гэлэнмаа нь олон хуврагийн дунд гэлэнмаагийн сахил авах хэрэгтэй” гэжээ. Үүнийг би бас зөвшөөрнө.

Тав дахь ёс: “Хэрэв хуврагийн сахилаа хүндээр зөрчвөл гэлэн, гэлэнмаагийн дунд хагас сард нэг удаа наманчлал хийх хэрэгтэй.” Учир нь хагас сар тутамд олны өмнө гэмшин наманчилсны дараа гэмгүй болдог. Энэ нь ч мөн мэдээжийн хэрэг юм, учир нь гэвэл гэлэн болон гэлэнмаа нар хамтдаа бясалгадаг болохоор ямар ч үйлдлийг олны өмнө ил тод хамтдаа хийх нь зүйтэй. Багш нь энд хүн зэмлэх үедээ бас ил зэмлэн түүний үйл түйтгэрийг олонд хуваан даатгаж байсан. Багш нь зэмлэсний дараа тэр сайжирдаг, гэтэл энэ нь бусдад нь ч жаахан нөлөөлдөг, ингэж жаахан муугаар нөлөөлдөгийн учир нь хүн бүр бага сага өөрийн чинь муу зүйлээс хуваалцсанаас болж байгаа хэрэг юм. Тиймээс Багш нь олны өмнө зэмлэх нь ач тустай, Багш нь та нарыг өөрийн байрандаа аваачиж загнахгүй. Багш өөрийнхөө өрөөнд загнахгүй яагаад олны өмнө зэмлэдэг вэ гэж Багшийгаа буруутгасны хэрэггүй. Учир нь олны өмнө зэмлэн загнах нь их ач тустай, тэд бүгдээрээ таны үйл түйтгэрийг бага сага хувааж авдаг болохоор хойшид та цэвэр ариун болно. Тиймээс Багш нь та нарыг олны өмнө гарган гэмших наманчлал хийлгэж байдаг нь ийм санаатай гэдгийг одоо мэдсэн биз дээ? (Гэвч хэрвээ та нар үйл түйтгэрээ арилгахын тулд зориуд Багштайгаа маргалдаж, Багшаараа загнуулах юм бол үйл түйтгэр нь маш хүнд ноцтой болно.) Та нар хагас сар болгонд олны өмнө өөрийн үйл түйтгэрээ гэмших наманчлал хийх хэрэгтэй. Одоо та нар үйл түйтгэргүй болоод бүгдээрээ Багшдаа үзүүлэхээр чимээгүйхэн өдрийн тэмдэглэл бичиж байх төдий л байдаг. Энэ нь үйл түйтгэрээ бүгдийг нь надад өгөх гээд байгаа хэрэг үү? (Бүгдээрээ инээлдэв)

Зургаа дахь ёс: “Хагас сар бүр хуврагуудын дундаас сургаал хүртэх хүн хайх хэрэгтэй.” Хэрвээ бид нэг бүлэгт цуг байвал шинэ хүн нэмж ирэх юмуу, эсвэл зарим хүн ямар нэг мэдээжийн асуудлыг тодорхой ойлгохгүй байх явдал гарч мэднэ, тиймээс хагас сар бүрт нэг удаа сануулж байх нь зүйтэй юм. Манай эндэхтэй адил, аль аль учрыг хэлж болохгүй, ямар ямар хэргийг хийж болохгүй гэж Багш нь байнга сануулж байдаг нь та нар алдаа гаргаад л байдгаас болдог юм. Тиймээс Багш нь зөвхөн та нарт сэрэмжлүүлж байгаа хэрэг билээ.

Долдугаарт: “Гэлэнгүй газар зуны оршил хийж болохгүй.” Энэтхэгт эмэгтэй хүмүүс ганц нэгээрээ явж суух нь тун тохиромжгүй зүйл гэж Багш нь түрүүхэн хэлсэн. Эрхбиш эрэгтэй хүмүүс байх хэрэгтэй, үгүй бол гадны эрчүүд ирээд төвөг учруулна. Эрчүүдтэй хамт байвал бусад эрчүүд ойртож зүрхлэхгүй болохоор аюулгүй амгалан байж болно, ийм л юм.



Наймдугаарт: “Зуны оршил дуусахад гэлэнгүүд дээр очоод үзсэн, сонссон, эргэлзээтэй зүйлүүдийнхээ талаар асууж лавлах хэрэгтэй.” Энэ нь бас мэдээжийн хэрэг, яагаад гэвэл гэлэнмаа нар дөнгөж гэрээс гарсан, гэтэл гэлэнгүүд Шагжамуни Бурханыг дагаж гэрээс гарч гэлэн болоод их удсан учраас гэлэнмаа нарын хувьд багш болох нь зүйтэй бөгөөд үүнийг амархан ойлгож болох хэрэг. Гэтэл одоогийн гэлэнгүүд бүгд гэлэнмаа нарын багш болж болно гэсэн үг биш, цаг үе нь өөр болжээ, ойлгож байна уу? Энэ сахилыг бүгдээрээ ташаа ойлгоод байх юм, ташаараад байдаг газар нь яг энд байна. Гэлэнгүүд нь бүгдээрээ гэлэнмаа нарт багш болж чадах биш, Шагжамуни Бурханыг дагаж бясалгасан гэлэнгүүд л тэр үеийн гэлэнмаа нарт багш болж чадах байж. Учир нь тэр үеийн гэлэнмаа нар нь цөм саяхан гэрээс гарсан, үүнээс өмнө гэлэнмаа гэж байгаагүй байжээ. Гэтэл гэлэнгүүд нь Шагжамуни Бурханыг дагаж бясалгаад нэгэнт их удсан, олонх нь архад, богд болсон, тиймээс тэдэнд гэрээсээ саяхан гарч, сурч байгаа гэлэн болон гэлэнмаа нарыг зааж сургах эрх мэдэл, хүч чадал, билиг ухаан бүрэн байсан нь мэдээжийн хэрэг, зөвхөн гэлэнмаа нарыг л сургах төдий биш. Энэ нь мэдээжийн хэрэг болохоор ойлгоход тун амархан.

Гэтэл энэ сахил санваарыг одоогийн энэ цаг үед авчирч хэрэглэвэл зохимжгүй. Одоо байгаа гэлэн болгон гэлэнмаагийн багш болж чадах биш, олон гэлэнмаагийн билиг ухаан нь гэлэнгүүдийнхээс хэтэрч, тэднээс өндөр болжээ. Учир нь өөр өөр цаг үед адил биш бурхад байдаг. Өнөөдөр нэг гэлэн ирээд манай хуврагийн бүлгэмд орох гэвэл тэрээр эхлээд гэлэнмаагаас суралцах хэрэгтэй. Миний хэлж байгаа санаа бол манай энд жинхэнээр сахил авсан гэлэн гэж хараахан байхгүй байгаа учраас тэрээр гэлэнмааг дагаж суралцах хэрэгтэй гэсэн үг. Учир нь тэд маш ихийг мэднэ, мөн ёс дүрмийг ч ойлгодог, Багш нь тэдэнд бүгдийг нь сургачихсан. Багшийнхаа номын ёсыг тэд нилээд сайн ойлгодог болохоор гарцаагүй тэднээс суралцах ёстой юм. Энэ хүндэтгэлийн найман ёсыг бүр тонгоруулаад эсрэгээр нь ойлговол таармаар болчихжээ. (Бүгдээрээ инээлдэв)

“Хүндэтгэлийн найман ёсны тухай” Багшийнх нь тайлбар ийм байна. Тун амархан ойлгож болох учир байгаа биз дээ? (Бүгдээрээ тийм гэж хариулав) Цаг үе нь өөр болсон бол сахил санваар нь ч бас өөр болох ёстой. Урьдаар нэг бурхныг олж авах ёстой, дараа нь сая сахил санваарын тухай ярих хэрэгтэй, учир нь тэр бурхан сахил санваарыг тогтоох болно. Тэр бурхан тун даруу, маш амар амгалан бусадтай адил байж мэднэ. Гэвч бүгдээрээ тун дорой бядуу байвал тэр бурхан өөр нэгэн сахилыг зохион тогтоож магадгүй. Учир нь Шагжамуни Бурханаас өмнө гэлэнмаагийн сахил гэж зүйл байгаагүй, тиймээс гэлэнмаагийн сахилыг тэр өөрөө тогтоох ёстой болсон аж, ойлгож байна уу?

Үүнтэй адилаар, цаг үе адилгүй болсон учраас гэлэнмаагийн сахил хожим шинээр бий болж мэднэ. Гэрээс гарагчид нь гэр бүлээсээ салж, хувь хүний хайрын сэтгэлээ тэвчих хэрэгтэй, хайр сэтгэлтэй байсан ч түүнийгээ олон түмний төлөө огоорвол зохино. Хуврагийн бүлгэмтэй

хамт бясалгал хийх хүмүүс энэ сахилыг хүлээн зөвшөөрч, хувь хүний хайр сэтгэлээ огоорох хэрэгтэй. Тиймээс Шагжамуни Бурхан ойр төрлийн хүний хайрын сэтгэлийг тэр дор нь огоорч, нагац эхдээ: “Хэрвээ та гэрээс гарах гэж байгаа бол гэлэнгүүдэд ёсолж, бусадтай эрх тэгш адил байхаас биш, миний нагац эх хэмээн санааны зоргоороо байж болохгүй.” гэжээ. Тэрээр Бурхан Багшийн ойрын төрөл болохоор Шагжамуни Бурхан түүнд тийм хатуу чанга байсан нь тодорхой, ойлгож байна уу? Хэрэв Бурхан Багштай төрөл садны холбоогүй өөр эмэгтэй хүн гэрээс гарахыг гуйсан бол энэхүү хүндэтгэлийн найман ёс байхгүй ч байсан байж магад.

Аливаа судар ном, аливаа сахил санваарт онцгой шалтгаан байдаг. Бид түүнийг тодорхой ойлгож унших ёстойгоос биш, мухар сохроор шүтэж, хүн юу гэвэл түүнийг дагаж болохгүй. Хэрвээ яагаад гэдгийг нь мэдэхгүйгээр, ямар ч сэжиг таамаггүйгээр бат итгэх юм бол энэ нь билиг ухаангүй гэсэн үг. Шагжамуни Бурхан хүнийг ийм дорой байлгахгүйн тулд бурханд хүртэл итгэж болохгүй гэж хэлжээ. Хэнд ч итгэж болохгүй, учир явдал нь үнэхээр үнэн болохыг өөрсдийнхөө биеэр баталсны дараа л бид сая итгэх хэрэгтэй. Багш нь маш логик учир зүйтэй сэтгэлгээтэй. Учир зүйд нийцэхгүй зүйлд би дургүй, учир зүйд нийцэхгүй зүйл байвал ухаг асуугаад учир зүйд нийцсэн тэр цагт л сая зогсдог юм. Хэрвээ учир зүйтэй нийцэхгүй бол хэн хэлсэн нь хамаагүй, хэзээ ч итгэхгүй. Тийм биш бол бид улам их бясалгавал улам бядуу дорой болж, чухам юу нь, яагаад гэдгийг нь мэдэхгүй байтлаа бусад хүн юу гэж хэлбэл бид түүнд нь итгэчих болно.

Эрт үеийн сахил одоо үед тохирохгүй болсон байтал бид түүнийг хэрэглэж яаж болох вэ? Яг л Багшийнх нь өчигдөр хэлсэнтэй адил, Шин нүн, эсвэл Яао Шүнгийн цаг үед эд зүйлсээ зам дээр хаяж орхисон ч түүнийг авах хүн байдаггүй байжээ, гэтэл одоо ямар нэг зүйлээ цүнхэндээ хийсэн ч хулгайлаад авчихна. Бүр банкинд хийх юмуу, гэртээ хадгалж байсан ч хүн орж ирээд хулгайлж мэдэх байтал зам дээр орхисон зүйлийн тухайд ярьсны ч хэрэг алга.

Урьд нь машин, унадаг дугуй, мотоцикл гэх зүйл үгүй байсан болохоор угаасаа замын хөдөлгөөний дүрэм гэмээр юм байсангүй, хэрвээ бид хоёр, гурван зуун жилийн өмнөх юмуу, эсвэл таван мянган жилийн өмнөх замын хөдөлгөөний дүрмийг өнөөдөр хэрэглэвэл мэдээж болохгүй биз дээ. Тийм үү, үгүй юү? Сахилууд ч мөн адил, хэрэглэж болохыг нь хэрэглэж, хэрэглэж болохгүйг нь хаяж орхихгүй юм бол бид ахиж дэвшиж чадахгүй. Хэрвээ бид цаг үетэйгээ зохицохгүй мухар сохроор сүсэглэвэл тун харамсалтай, ямар ч хэрэгцээгүй зүйл болно. Сахил санваарын тухай Багшийнх нь тайлал ийм байна. Та нар зөвшөөрөх үү? (Бүгд зөвшөөрнө гэж хариулав.)

## СҮНС ГАРАХ БОЛОН ТҮҮНЧЛЭН ИРСЭН БАЙДАЛ АДИЛГҮЙ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формосагийн Тайнан хотын Чи гү бясалгалын төв  
1987 оны 12 дугаар сарын 4 (Эх нь хятад хэлээр)*

Энгийн хүний хэлдэг сүнс гарах гэдэг нь бидний асури бие гарч явахыг л хэлж байгаа юм. Гэтэл бид Арьяабалын номын цогцосыг бясалгаад ямар нэг тодорхой дэсэд хүрсний дараа хаана ч оршиж, ямар газарт ч очиж чадна. Ингэх нь нилээд хялбар, дэлхийн бөмбөрцгийн хаана ч хүрч очоод хүнийг аврах, туслах ч юмуу, очиж үзэж болно. Гэтэл бид дээд хүслэнт ахуйд мөн л адил маш эрх чөлөөтэй байдаг. Үй түмэн хувилгаан бие бол нилээд дээд дэсийнх юм шүү, ойлгож байна уу? Жишээлбэл, Багш нь өчигдөр та нарт сүнс гаргах номын цогцосыг зааж өгсөн тул та нарын сүнсэн бие гарч болно. Тэр сүнсэн бие гэдэг нь ямар бие вэ? Хамгийн гадна байгаа бие цогцсоо тайлж хаясан хэрэг. Энэ нь бид хамгийн гадна талын хувцсаа тайлж хаясантай адил, гэсэн ч бидний бие цогцост тайлж хаяагүй өөр олон давхар хувцас байсаар л байдаг. Ойлгож байна уу? “Агшин зуур гэгээрэхийн түлхүүр” номд Багш нь сүнс гаргах нь Түүнчлэн ирсний мөрийн хутаг биш, тэгээд бас ямар нэгэн дээд дэсийн сүнсний аялал ч биш гэдгийг тун тодорхой тайлбарласан билээ. Дээд дэсийн сүнсэн биеийн аялал нь Түүнчлэн ирсний дэс бөгөөд хаа ч оршдог, диваажинд ч байна, тамд ч байна, энэ ертөнцөд ч байна, аливаа бурхны оронд цөмд нь байдаг. Тэр үед “хотол зохилдогч” болж хувирна, Арьяабал Бурхан болж хувирна, аль ч газрын дууг сонсож, хаана ч хүрч чадна.

Олон хүн: “Хэн хэн гэдэг хүнээс, ямар ямар номын цогцос олж сурснаас сүнс минь гарч яваад тийм тийм хүнтэй уулзсан” гэдэг. Үнэндээ тэр нь тун энгийн хэрэг, тийм ч сүрхий зүйл биш. Тайваньд нэг хүн өөрийгөө нэгэнт бурхны дэсэд хүрсэн тул аль ч, ямар ч газраар очиж, хэнтэй ч уулзаж чадна гэх зэргээр мэдэгдэж байхыг бид сонсож байсан удаатай. Энэ нь Багшийнх нь өчигдөр зааж өгсөн сүнс гарах байдал юм. Өчигдөр та нар бүгд харсан, сүнс гарах гэдэг нь ямар учиртайг энд байгаа хүмүүсийн дотроос наад зах нь хэдэн хүн мэднэ. Манай эндхийн гэрээс гарсан нэг хүн бас сүнсээ гаргаж чадна. Энэ нь тийм гайхалтай

хэрэг биш, тэр эндээс гүйж гараад бие засах газарт очих (бүгд инээлдэв) юмуу, хамгийн ихдээ худалдааны том зах руу явна, эсвэл Америк зэрэг улсад очин энэ ертөнцийг л үзэж харахын л төдийхөн.

Сүнс гаргах тийм номын цогцосыг ашиглаж дэлхийг тойрон аялахад, мэдээжээр, онгоцны тасалбар ч авах хэрэггүй. Гэтэл үүнд нэг зүйлийн аюул оршиж байдаг, учир нь сүнс гаргах аргаар гарч яваад тоглож зугаацах нь тун энгийн бөгөөд хялбархан болохоор хожим тийм дадал зуршилтай болчихно. Нүдээ аних бүртгээ сүнсээрээ гарч газар бүхнээр тойрон явахыг бодож хүсэх болоод биед байгаа өөр бусад хувцсаа тайлж, бүр илүү өндөр хүслэнт ахуйд очихоо мартаж орхино, бүр илүү дээд Мөрийн хутгаа хайж олохоо мартана. Багшийнхаа хэлж байгаа санааг ойлгож байна уу? Ингэх нь өдөржингөө зөвхөн энэ тоост ертөнцийг тойрч явахаас өөр ямар ч ашиггүй юм.

Тиймээс Багш нь энэ сүнс гаргах номын цогцосыг заадаггүй нь харин мэдэхгүйдээ биш. Багш нь маш олон номын цогцосыг мэдэх боловч хараад байхад тэр номын цогцос нь ер хэрэггүй, учир нь бидний бясалгаж байгаа зорилго маш чухал. Хэрвээ зөвхөн хямдхан “аялах”-ыг бодоод онгоцны тасалбар худалдаж авахыг хүсэхгүй бол өчигдөр Багшийнхаа заасан тэр сүнсээ гаргах номын цогцосыг бясалгаж болно. Гэвч бид хэрвээ туулан гэтлэхийг хүсдэг, хамгийн дээд Мөрийн хутгийг олохыг боддог бол Арьяабалын номын цогцосыг бясалгах ёстой. Арьяабалын номын цогцосыг бясалгадаг хүн зарим үед тун өндөр төвшинд хүрэх боловч бидний тархи толгой шингээж авч чаддаггүй учраас буцаж ирэх үедээ бүгдийг нь мартчихдаг юм. Зөвхөн ямар нэгэн газар очсон гэмээр, биенд нь ямар нэгэн юм үлдсэн мэт санагдах боловч чухам юу вэ гэдгийг мэдэхгүй байдаг. Иймэрхүү байдал нь биднийг маш өндөр хүслэнт ахуйд хүрснийг илтгэж байгаа юм.

Зарим хүн Багшдаа: “Би бясалгаад их удаж байна, заримдаа юу ч хардаггүй, зөвхөн Аялгуу сонсдог.” гэдэг. Аялгуу олж сонсож байгаа нь нэгэнт тун сайн болчихсон хэрэг, учир нь энэ Аялгуу бол рашаан мөн. Хэрвээ энэ Аялгуу байхгүй бол рашаан үгүйтэй адил болоод бид хатахад хүрнэ. Бид Гэрэлгүй байж болох ч Аялгуугүй бол бидний сүнс амьдрахад амаргүй болно. Зарим үед бид тун өндөр хүслэнт ахуйд хүрээд буцаж ирсний дараа хэдийгээр мартчихдаг боловч зарим авшигтан бидэнтэй хамт очихдоо өөр бусад сүнсийг хардаг. Жишээлбэл, Тайбэйд нэгэн авшигтны аав нь хорт хавдар тусаж, хүндрээд хэдэн жил болжээ. Эцгийнх нь өвчин их хүндрэх үед үхэхийг хүсэвч үхэхгүй, амьдарч ч чадахгүй тун ч зовлонтой гаслантай байсанд тэр авшигтан Багшаасаа тусламж гуйсан. Түүний аав нь ямар ч бясалгал хийгээгүй, бас ургамал хоол иддэггүй байсан боловч охин нь маш их ачлалтай болохоор уйсаар ирээд Багшаасаа тусламж дэмжлэг гуйсан юм. Би түүнд яах ёстойг зааж өгсөн тул тэр буцаж хариад Багшийнхаа заавар ёсоор хийсэнд түүний аав нь үнэхээр маш амарлингуй, тун амар тайван нас баржээ.

Түүний аавыг нас барах үед өөр нэгэн авшигтан хамт байжээ, тэрээр Багшаасаа хоёр жил гаруй суралцсан бөгөөд бас тийм ч

хатуужилтайгаар бясалгаагүй. Тэр бол мэргэжлийн ажилтан бүсгүй бөгөөд энгийн цагт ихэвчлэн гадагшаа ажлаар явдаг болохоор бясалгах цаг түүнд бараг байдаггүй байж л дээ. Гэвч бас муу биш, бясалгал хийж нүдээ анимагц даруй явчихдаг, сүнс нь тэр дороо дээш гарч очоод олон хүслэнт ахуйг харсан болохоор Багшийнхаа хүч чадлыг тэр маш сайн ойлгодог юм. Тэр өдөр тэрээр бясалгаж байхдаа аав нь нас барсан бясалгалтан аавынхаа сүнсийг дагуулж нилээд дээд төвшинд очихыг харсан байна. Нас барсан хүний охин нь Багшийгаа орлож, тэр явдлыг хийж байсан ч өөрөө үүнийгээ мэдээгүй аж. Багш нь түүний сүнсэнд аавынхаа сүнсийг яаж аюулгүй амгалан оронд аваашихыг зааж өгсөн юм. Жишээлбэл, нэг юмуу, эсвэл хоёрдугаар ертөнцөд аавыг нь хүргэж, тэндээ Багшийг дагаж бясалгал хийхийг зааж өгсөнд охин нь өөрөө мэдээгүй аж, гагцхүү бясалгал хийж байгаад олж харсан тэр авшигтан л мэджээ.

Багш нь энэ явдлыг ярьж байгаагийн гол санаа учир нь зарим үед бид хэдийгээр Мөрийг олсон боловч Мөр олсноо мэдэхгүй байдаг гэдгийг та нарт хэлье л гэсэн хэрэг. Ойлгож байна уу? “Билгийн цаад хязгаарт хүрсэн очироор огтлогч” хэмээх сударт: “Хэрвээ бурхан, бодьсадва, архад нь одоо нэгэнт Бурханы хутагт хүрсэн гэж юмуу, эсвэл архадын хутагт хүрсэн гэж үнэхээр боддог бол тэр бурхан бус, архад бус, эсвэл би бодьсадвагийн дэсэд хүрсэн гэж бодох юм тэр нь жинхэнэ бодьсадва биш.” гэж тун тодорхой өгүүлсэн байдаг. Яагаад тэр вэ? Учир нь бидний тархи толгой хязгаартай. Тархи толгойгоороо ойлгож чадах хүрээ хэмжээний хамгийн доод хязгаар нь энэ материаллаг ертөнц бөгөөд хамгийн ихдээ зөвхөн хоёрдугаар ертөнцөд л хүрч чадна.

Хоёрдугаар ертөнцийг мөн үйл үрийн ертөнц буюу мэдлэгийн ертөнц гэж нэрлэдэг бөгөөд мөн л мэдлэгийн хүрээнд багтдаг. Энэ мэдлэгийн ертөнцөөс хэтийдэн давбал тархи толгой ойлгохын аргагүй болж, шингээж авч чадахгүй болно. Жишээлбэл, нисэх онгоц нь мэдээж, машинаас илүү сайн, маш өндөрт нисэж чадна. Энэ дэлхий дээрх тээврийн бусад бүх хэрэгслээс илүү өндөрт нисдэг боловч нисдэг тавагны байдлыг тэр чинь ойлгож чадахгүй. Учир нь нисдэг таваг нэгэнт хамгаалалтын давхаргын дэсээс хэтэрч, дууны хурдын дэсээс давсан болохоор хэдийгээр хамгийн хурдан, хамгийн хүч чадалтай онгоц байсан ч түүнийг хөөж гүйцэх боломжгүй, тэр ч байтугай түүний хойноос даган хөөх ч аргагүй байдаг. Тийм биз дээ? Хэрвээ нисдэг таваг цааш үргэлжлүүлэн хөөрч тун өндөрт очоод дахин буцаж ирэх үедээ тэнгэрт байгаа онгоцыг хараад магадгүй түүнтэй мэндчилэх боловч тэр онгоц нисдэг таваг юу хийгээд байгааг ойлгох аргагүй. Үүнтэй адилаар, хэрвээ бид ямар нэгэн юм олж үзье гэж бодвол, эсвэл буцаж ирэх үедээ маш олон зүйлийг маргалгүй санаж байхыг хүсвэл тархи толгой байх хэрэгтэй, ингэвэл сая цээжилж, үг хэлээр бичиж, эсвэл тайлбарлаж чадна. Учир нь дээд дэсийн хүслэнт ахуйд үг хэлээр хэлэлцэн нэвтрэлцэж чадахгүй. Жишээлбэл, дөрөв дэх юмуу, тав дахь ертөнцөд очих үед бид тэндэх нөхцөл байдлыг ойлгохгүй байдаг биш, гэвч бидний ойлгож

байгаа зүйл нь энэ дэлхийн “ойлголт” гэж нэрлэгддэг зүйлээс ялгаатай. Учир нь тиймэрхүү дээд дэсийн хүслэнт ахуй нь манай дэлхийнхтэй өчүүхэн ч адилгүй юм.

Хэрвээ бид зөвхөн асурийн тэнд хүрч очвол тэнд хэрэглэж байгаа багаж хэрэгсэл нь манай дэлхийнхтэй бараг адилхан бөгөөд тэндхийн хүслэнт ахуй нь эндхийнхтэй адил байдаг. Жишээлбэл, бид бүгд энэ ертөнцөд европ маягийн хувцас өмсдөг. Бид нэгдүгээр ертөнцөд очих үед тэндхийн хүмүүс мөн ийм хувцас өмсөж байгааг харна. Учир нь бид тэнд очих үедээ сүнснийхээ зөвхөн хамгийн гадуурх хувцсыг л тайлснаас биш бүгдийг нь тайлж хаядаггүй. Хэрэв сүнсэн биеийнхээ гадуурхыг бүгдийг нь үлдээлгүйгээр тайлж хаявал хувцасгүй болно. Тэр үед сүнс нь нэг хэсэг Гэрэл болж хувираад бие, хэл, сэтгэл, нүд, чих, хамар, бие цогцос, үзэл бодол гэмээр зүйл юу ч үгүй болно. Тийм байдал бол тун өндөрт хүрчээ гэсэн үг.

Бид дээд хүслэнт ахуйд хүрэх үед тэндхийн хүмүүс тиймэрхүү эрт үеийн урт хувцас өмссөн байхыг, эсвэл цагаан буурал сахалтай, нүднээс нь гэрэл цацарсан хүн биднийг угтан ирэхийг олж харахгүй ч байж мэднэ. Тэд харин жийнсэн өмд өмсөөд биднийг угтан ирж мэднэ. Учир нь сүүлийн үеийн загварын хувцсыг тэнгэрийн элч нар бас мэддэг. Дундад улсын урьдын хүмүүс ондоо загварын хувцас өмсөж байсан, тэд нас бараад тэнгэрийн элч болох үедээ бас тиймэрхүү хувцсаа л өмсдөг байв. Одоо жийнсэн өмд өмсөх явдал их дэлгэрсэн байна, нас барсныхаа дараа ч мөн нэгэн адил байх болно.

Эрт урьд цагт нэгэн улсын хаан байж гэнэ. Тэр уг хүн нь нилээд сайн боловч өглөг өгөхийг бараг мэддэггүй, түүний ордонд маш их мөнгө, хөрөнгө байсан боловч ядуу зүдүү ард иргэддээ хувааж өгдөггүй, зөвхөн өөрөө л эдэлдэг байжээ. Нэг өдөр тэрээр энгийн хүнтэй адил нас баржээ. Аль нэг өдөр бид бас бүгдээрээ нас барна шүү дээ. Улсын хаан нас барсныхаа дараа дээш гарах үедээ нэг газар хүрсэнд нэгэн хоосон байшин байж гэнэ. Маш гоёмсог алтан ордон байснаас биш, өөр юу ч үгүй байжээ. Ордны дотор байгаа ширээ сандал нь гоёмсог, ор нь маш тааламжтайг тэр үзээд тэнд унтаж гэнэ. Унтаж сэрсний дараа сандал дээр сууж үзээд цэцэрлэгт хүрээлэнд орж хаа сайгүй зугаалав. Хэсэг байгаад ядарч, өлсөх шиг болоод юм идэхийг хүссэн ч идэх юм олдсонгүй. Тэр ингэж нааш цааш гүйсээр их ядран ундаасч, юм уухсан гэж бодсон ч уучихмаар юм олдсонгүй. Нэг хүн өлсөж, эсвэл ангаж үхэхийн үед яаж их зовж, яаж хэцүүдэж дэлбэртлээ уурлахыг та нар бүгд лавтай мэдэх байх. Тэр хаан тэнгэрийн элчид очоод: “Сонин юм даа, миний байшинд яагаад юу ч үгүй байна вэ? Идэж уучихмаар юм юу ч үгүй болохоор ийм гоёмсог сайхан орд харш байх ямар хэрэгтэй юм бэ? Энэ нь чухам ямар учиртай юм? Намайг хуурч мэхэлж байна уу?” гэж гомдолложээ. Тэнгэрийн элч түүнд “Та орж очоод хайж үз дээ” гэж хэлсэнд тэр: “Би удтал хайсан ч юу ч олсонгүй, хов хоосон байна.” гэжээ. Тэнгэрийн элч түүнээс: “Та амьд байхдаа хүнд юм өгч байсан уу? Жишээ нь, өлсөж үхэх шахсан гуйлгачин ирээд идэх юм гуйх үед



та юм өгч идүүлж байсан уу?” гэж асуухад тэрээр: “Хэн тэдэнд юм өгч идүүлэх юм бэ, тэд гуйлгачин болсон нь тэдний хийсэн үйл түйтгэр, тэнгэр тэднийг залхааж байна. Тэд хүртэх ёстойгоо л хүртэж байгаа хэрэг, тиймээс би тэднийг тэр даруйд нь хөөж явуулах ёстой. Тэгэхгүй бол тэдний үйл түйтгэр миний газрыг бузарлана.” гэхэд тэнгэрийн элч: “Та хүнд юм өгч идүүлж байгаагүй юм чинь одоо танд юм өгч идүүлэх хүн байхгүй байх нь мэдээжийн хэрэг шүү дээ.” гэжээ.

Тэр үед хаан: “Дууссан хэрэг болжээ, одоо би яадаг билээ?” гэхэд тэнгэрийн элч: “Та ямар үйл тарьсан бол тийм үрийг л олно. Та ингэж гомдоллох учиргүй. Үйлийн үрийн хууль бол маш тодорхой. Бид үүнийг ингэчихсэн биш, таны өөрийн тань үйлийн үр дагавраар л бий болжээ.” гэжээ. Хаан хэсэг бодож үзээд үнэхээр их өлсөж, ядарч, цангаж байсан тул тэнгэрийн элчээс: “Энэ асуудлыг шийдэх арга байна уу?” гэж асуухад тэнгэрийн элч: “Ямар ч аргагүй, цагаа дуустал хүлээх хэрэгтэй, тэгээд буцаж хүн болж төрөөд хожим хүмүүст илүүхэн өглөг болон бусад зүйлийг өгөх хэрэгтэй. Тэгвэл дараа нь нас бараад дахин дээш гарч ирэх үедээ та сая идэх юмтай байх боломжтой болно. Та нарт орчлонд байхдаа хүнд юу өгсөн, эсвэл ямар сайн үйл хийсэн бол тэнгэрт дэвшсэний дараа тийм л үр хариулалтай болно. Ойлгож байна уу?” гэжээ.

Тэр хаан үнэхээр өлсөж, цангаж тэсэхийн аргагүй болоод тун гашуун зовлонтой байв. Диваажинд идэх юмгүй байх нь яг л тамын оронтой адилхан байжээ. Хэдийгээр их сайхан байшинд сууж байсан ч идэх юмгүйгээс үнэхээр хэцүү зовлон амсахдаа хаан: “Би хариад ирэхийг танаас гуйя, болох уу? Зөвхөн хоёр долоо хоногийн чөлөө гуйя.” гэхэд тэнгэрийн элч: “Та яах гэж чөлөө гуйж байгаа юм бэ?” гэхэд хаан: “Би гэртээ хариад байгаа бүх эд хөрөнгөө бүгдийг нь өглөгт өгч барж дуусгасныхаа дараа дээш гарч ирье. Тэгэхгүй бол би энд өлбөрч үхэх нь ямар хэрэгтэй билээ? Хэдийгээр хүний орчлонд надад эд хөрөнгө элбэг дэлбэг байсан ч энд хэрэглэж чадахгүй болохоор ямар тустай байх вэ?” гэв. Тэр үед тэнгэрийн элч түүний байдлыг харахад тун хөөрхийлөлтэй бөгөөд бас тун сайн санаатай харагджээ. Тэгээд ер нь муу явдал гэмээр зүйл хийгээгүй болохоор түүний гуйсан хоёр долоо хоногийн чөлөөг зөвшөөрчээ.

Тэр хаан буцаж ирснийхээ дараа өөрийн бүх эд зүйлээ тараан бусад хүн юу л хүснэ бүгдийг нь өгчээ. Улсынхаа хот, хатад, шүр, мана, алт мөнгө зоос гээд аливаа бүх ховор гайхамшигтай эрдэнэс, хаш чулуу болон амтат хоол идээгээ бүгдийг нь өглөгт өгчээ. Аль дуртай сайн зүйлсээ улам илүү өгч байж гэнэ. Жишээлбэл, Тайваньд ургамал хоолтон хүн юуг хамгаас илүү идэх дуртай вэ? гэвэл дүүфүү, глотин. Тэр харьсныхаа дараа энэ мэтийн маш их юмаа бүгдийг нь өгчээ. Ингэсний дараа тэр буцаж тэнгэрийн ордонд очоод сая жаргалыг эдэлж чаджээ. Энэ нь хэдийгээр зөвхөн хүн болон тэнгэрийн өчүүхэн буян боловч хэрвээ бид бусдад баяр жаргал олгохгүй бол өөрсдөө ч баяр жаргалтай байж чадахгүй билээ. Тиймээс Төгс Гэгээрсэн Их Багш нар бүгдээрээ:

“Хүнийг хайрлаж байгаа нь өөрийн биеэ хайрлаж байгаа хэрэг, өөр хүнийг хорсож зангах нь бид өөрийн биедээ уршиг татаж, өөрийн биеэ залхааж байгаа явдал болно.” гэж хэлдэг нь ийм санаа билээ.

Бас ийм нэг үлгэр байдаг. Нэг тэнгэрийн элч Эрлэгийн хаанаас: “Танай тамын оронгых харахад дүүрэн хүнтэй байх юм. Хэрвээ аль нэг улс оронд хамгийн их хүн хаана чихэлдэж байна вэ гэвэл тэр нь танай энэ тамын орон байна. Тамын оронд хоригдогчид ийм их байтал та яаж энэ улс орноо тэгж сайн удирдан дагуулж чадаж байна вэ?” гэсэнд Эрлэгийн хаан: “Би юу ч хийгээгүй, ялтан бүхэн цөм өөрийн ертөнц, өөрийн нөхцөл байдал, өөрийн орон гэр, өөрийн нүгэл хилэнц, эсвэл буян хишгээ авч ирдэг. Тэд өөрийн нөхцөл байдлаа өөрсдөө бүтээж, өөрийгөө өөрөө хянаж, өөрөө өөрийгөө харж харгалзаж байдаг, тэдний үйл түйтгэрийн шоронд надад юу ч хийх шаардлага байдаггүй.” гэжээ.

Урьдын диваажин нь одоогийн диваажинтай адилгүй, учир нь урьдын хүмүүс диваажинд очихдоо эртнийхээ тэр л хувцсаа өмсдөг байжээ. Харин одоо бол сүүлийн үеийн загварлаг хувцсыг өмсөж байна. Тэр улсын хаантай адил хэдий чинээ их өглөг өгнө, тэнгэрт дэвшсэний дараа төдийчинээг олж авна. Одоогийн диваажинд зурагт, радио, видео тоглуулагч гээд юу л бол юу байгаа. Диваажин бас их соёлгоод урьдын адил явганаар явдаг диваажин биш болсон, одоо бол онгоц болон машин тэргэнд суудаг диваажин болсон. (Багш болон бүгд инээлдэв) Хэрвээ та нар эрт дээр үеийн үлгэр түүх, эсвэл судар номыг уншвал, хүмүүс Хуа Яан4 ертөнцөд очих үедээ ямар ямар хүслэнт ахуйг харсныг тэмдэглэсэн байдаг. Одоо та тэнд очвол маш ихэд гайхан цочирдоно, хармагц л сударт тэмдэглэсэнтэй адилгүй санагдаж: “Сонин юм аа, би хаана ирчихсэн юм бол?” гэж бодож магад. Учир нь диваажин нэгэнт урьдынхтайгаа адилгүй болчихжээ. Та диваажинд очвол Авид бурхан жийнсэн өмд өмсөж (Багш инээв), Манал бурхан хүмүүст зүүгээр тарилга хийж (бүгд инээлдэв), Хуа Тө цусны даралт хэмжих багажаар хүний цусны даралтыг хэмжих юмуу, үгүй бол чагнуураар бидний зүрхний цохилтыг чагнаж байгааг олж харж ч магадгүй. Одоо Манал бурхан, Хуа Тө хоёр диваажинд ингэж байгаа ч байж мэднэ. Учир нь өнөөдөр манай анагаар ухааны хөгжил ихэд дэвшиж, олон зүйл шинээр бүтээгдсэн болохоор Манал бурхан ч энэ бүгдийг дагах ёстой, тэгэхгүй бол хоцрогдоно.

Үүнтэй нэгэн адилаар урьдын бясалгалтан бүгд л ууланд гарч, нэгэн газар, эсвэл нэг агуй олж байрлаад өдөрт нэг л удаа хооллож, Шагжамуни Бурхантай адилаар амьдарч, хатуугаар бясалгадаг байсан бөгөөд бас гэрлэж болдоггүй байжээ. Гэтэл одоо Багшийнх нь шавь нарын ихэнх нь гэрлэж хүүхэдтэй болсон, бас ажил хийдэг. Цаг үе адилгүй болсноос бидний бясалгах маань ч бас адилгүй болжээ. Тиймээс та нар гэртээ ч бясалгаж болно, заавал гэрээс гарах шаардлагагүй. Урьд нь гэрээсээ гаралгүйгээр бясалгах хийхэд тохиромжгүй, багштайгаа уулзахад ч амаргүй байсан болохоор гэрээс гарч байж л өдөр бүр багшийгаа дагаж явж чаддаг байжээ. Гэтэл өнөөдөр гэртээ бясалгаж болно. Хэрвээ бидний гэрийн нөхцөл байдал боломжтой, их нам сэлүүн, тэгээд бас бидэнд

бясалгах цаг олдох юм бол ямар ч асуудалгүй. Багшийгаа дагаж гэрээс гарах нь тун зүдгүүртэй, шавь нар бүгд нэг давчуухан өрөөнд бөөнөөрөө чихэлдэн унтдаг. Хэрвээ зовлон зүдгүүрээс айх юм бол гэрээс гарсны хэрэггүй. Би хаана очсон ч хамаагүй, чадах чинээгээрээ хялбар дөхөм байхыг хичээдэг. Ном тайлах нь хамаг төрөлтний ач тус, найз нарын ач тусын төлөө болохоор би заавал нөхцөл байдал сайтай газрыг хайж ном тайлна гэдэггүй. Шавь нараараа заавал нэг зочид буудал, эсвэл том сүм хийд бэлдүүлж байж ном тайлахаар очдог биш. Нөхцөл байдал ямар байсан ч байрлаж болно. Тиймээс Багшийгаа дагаж гэрээс гарсан шавь нарт тийм ч тав тухтай байдаггүй, тийм биш үү?

Өөр номч багш ном тайлахаар очих гэвэл урьдаар эрхбиш сайтар зохицуулах хэрэгтэй. Том сүм хийдгүй байсан ч наад зах нь уудам зайтай том байшин, эсвэл том зочид буудалд буулгаад түүний шавь нарт нь хүртэл нэг өрөөнд нэг хүн юмуу, хоёр хүн хонохоор өрөөг нь бэлтгэж өгөх хэрэгтэй байдаг. Гэтэл энд зарим үед, тэр ч байтугай хоёр зуун хүн нэг өрөөнд байрладаг болохоор Багшийгаа дагаж гэрээс гаръя гэвэл сайн бодож тунгаах хэрэгтэй, тийм ч тав тухтай байж чадахгүй шүү.

Тайваньд байгаа ихэнх сүм хийд маш уудам том, тэнд хангалттай олон өрөө байдаг. Гагцхүү Багшид нь сүм хийд гэмээр юм байхгүй, шавь тун олон байтал харин өрөөнүүд нь тун давчуухан. Багш нь шавь элсүүлээд жил илүүхэн болж байгаа ч одоо гэрээс гарсан хүн нилээд олон болжээ. Үнэндээ тийм ч олон гэмээргүй боловч өөр бусад сүм хийдтэй харьцуулбал нилээд олон шиг байна. Ихэнх сүм хийдэд зөвхөн ганц хоёрхон хүн л суудаг, сүмийн эзэн нь тэр, хамба лам нь ч тэр, шавь нь ч тэр, сүсэгтэн нь ч тэр өөрөө л байдаг, (Бүгд инээлдэв) тийм үү, үгүй юү?

Багшийнх нь суугаа газар тун давчуу гэдгийг та нар бүгдээрээ мэддэг хэдий ч гэрээс гарахаар ирдэг хүмүүс маш олон. Багш нь маш олон хүнийг гэрээс гарахыг нь зөвшөөрөөгүйн учир нь гэвэл би эрхбиш тэдний нөхцөл байдлыг сайтар бодолхийлж, хань ижил, эсвэл хүүхэд байгаа эсэхийг нь харах хэрэгтэй болдог. Ихэнх тохиолдолд би зөвшөөрдөггүй, тэгэхгүй бол амьдрах аргагүй болно. Багш нь тэр олон шавь нартаа дарагдаж, амьсгалж чадахгүйд хүрч мэднэ, ойлгож байна уу? Би шавь элсүүлэх дургүйдээ биш, гэхдээ бидний суугаа газар тун давчуу, би бас тэдний нөхцөл байдлыг бодох ёстой. Хэрвээ тэд олон хүүхэдтэй бол тэднийгээ харж харгалзах хэрэгтэй болохоор гэрээс гарч болохгүй. Гэрээс гарсан байтал мөн гэртээ байгаатай адил хүүхдээ дагуулж авчрах юм бол бид тэдэнд тусалж, хүүхдийг нь харж өгөх хэрэгтэй болно, ингэвэл Багш нь ном тайлах ямар ч боломжгүй болно. Хаана очсон ч хамаагүй угж, хөхөлт, хүүхдийн живх, хүүхдийн тэрэг (бүгд инээлдэв) авч явах хэрэгтэй. Тэгээд бас өнгө өнгийн тоглоом авч явах болох нь тун төвөгтэй байна.

Тиймээс хүүхэдтэй хүн гэртээ сууж, гэрээс гарвал болчихно. Сэтгэл тань гэрээс гарсан бол бас гэрээс гарсантай адил юм шүү. Вималакирти Их Багш гэрээс гараагүй ч түүний билиг ухаан нь Шагжамуни Бурханы

гэрээс гарсан шавь нараас ч илүү өндөр байжээ. Шагжамуни Бурханы гэрээс гарсан шавь нар бүгд түүнээс айдаг. Нэг өдөр тэр өвдсөнд Шагжамуни Бурхан түүнийг эргэж үзүүлэхээр бясалгал сайтай шавиа илгээх гэхэд очих зоригтой хүн байсангүй. Шагжамуни Бурхан их олон хүнээс асуусан ч очиж зүрхлэх хүн гарсангүй. Учир нь урьд нь хүн бүхэн цөм түүнтэй ном хаялцаад дийлдэж байжээ. Вималакирти Их Багш торолгүй ном хаялцдаг бөгөөд түүний зөн билиг нь цаглашгүй их. Түүний зөн билиг гэдэг нь хуруугаараа дохих юмуу, эсвэл гарни уншиж, өвчин эмчлэх тиймхэн зөн билиг биш билээ.

Түүний зөн билиг агуу их зөн билиг, туулан гэтэлгэх зөн билиг, жам ёсны зөн билиг, би үгүй зөн билиг юм. Тэр тэнгэрийн оронд тэр дороо хүрч очно, эсвэл тэр дор нь хүнийг дагуулан тэнгэрт гарч чадна, бас буцаан авчирч чадах гэх зэрэг тэр байдал нь ялимгүй өчүүхэн эрдэм чадлаар сүнсээ гаргаж эндээс тэнд гүйлгэх төдий биш. Тийм биш бол Вималакирти Их Багш гэртээ өвчтэй байхдаа очигдөр Багш нь та нарт заасан ялимгүй өчүүхэн эрдэм болох сүнс гаргах номын цогцосыг хэрэглэн Шагжамуни Бурханы байгаа газарт очоод үзүүлбэл болчих хэрэг байтал бас юуных нь Шагжамуни Бурханы шавь түүнийг үзэхээр ирэхийг гэртээ хүлээж суух билээ дээ? Та нар Багшийнхаа санааг ойлгож байна уу? Шагжамуни Бурхан ч гэсэн Багшийнх нь та нарт зааж өгсөн сүнс гаргах номын цогцосыг хэрэглэн Вималакиртиг үзэхээр очвол болчих байсан. Манзушир Бурхан, Ананд, Рахула, Шарипутра нар сүнс гаргах номын цогцосыг хэрэглэн түүнийг үзэхээр очвол болчих хэрэг, өөр юу ч хийсний хэрэггүй байхсан.

Багшийнх нь өчигдрийн заасан сүнс гаргах номын цогцос нь үнэнхүү туулан гэтэлгэх Арьяабалын номын цогцостой адилгүй. Юу нь адилгүй вэ? Жишээ нь, гэрээс гарсан манай нэг хүн өчигдөр тэр сүнс гаргах номын цогцосыг бясалгая гэхэд Багш нь тэр даруй заагаад өгсөнд дорхноо сурч чадсан. Тэр эндээс ар талд хүрч очоод хэн хэнтэй тааралдсанаа бүгдийг мэдэж байв. Түүний сүнс нь биедээ эргэж ирсний дараа үнэн худлыг шалгахаар очиход сүнсээрээ харсан байдалтай нь яг адилхан байжээ. Энэ нь тэрээр үнэхээр тэнд очсоныг илтгэж байгаа юм.

Авшиг хүртсэн, урьд нь бумбын сургаал бясалгаж байсан өөр нэгэн бясалгалтан: “Энэ аргыг би мэднэ, сүнс гарах нь ямар ч асуудалгүй, би урьд нь бумбын сургаалаас сурч байх үедээ сүнсээ гаргаж чаддаг байсан. Би гэрээсээ гараад засмал зам дээр мөнгө хэвтэж байхыг харсан ч биегүй болохоороо түүж авч чадаагүй. Тухайн үед энэ нь үнэн биш байх гэж би бодсон ч сүнс биед эргэж ирсний дараа махан биеэрээ гүйж очиход тэнд үнэхээр мөнгө байж байсан.” гэсэн. Тиймээс сүнс гаргах номын цогцосыг тэр мэддэг байжээ.

Гэтэл бидний Арьяабалын номын цогцос гэдэг нь сүнс гаргахтай адилгүй. Арьяабалын номын цогцосыг бясалгавал жинхэнээрээ туулан гэтэлж чадна. Та нар Багшийгаа асури биеэ хэрэглэн өдөр бүр та нарын тэнд очоод бие засах газар цэвэр байна уу, үгүй юү гэдгийг, эсвэл гал тогоонд очоод та нарыг далдуур мах идэж байна уу, үгүй юү гэдгийг

харж байдаг гэж бодож болохгүй. (бүгд инээлдэв) Тийм биш, Багш нь аливаа бие цогцсоосоо салж, хаа сайгүй оршиж байж л аливаа хүнийг харж, аливаа байдлыг ойлгож чадна. Ойлгож байна уу? Хэрвээ би мөн л аль нэгэн бие цогцсын дотор байгаа бол, тэр ч байтугай асури бие дотроо байсан ч, мөн л нэг газраа хоригдсон хэвээр байх болно, ийм байдал нь би зөвхөн нэг л бие махбодоо хэрэглэж байгаа хэрэг. Асури бие нь махан биетэй бараг адил болохоор бидний жинхэнэ бие маань бие цогцос дотроо хоригдсон хэвээр байдаг, тиймээс зөвхөн энэ бие цогцсоороо л явж чадахаас биш, хаа сайгүй оршиж чадахгүй.

Хэрвээ бүхий л орчлонг харъя гэвэл хамгийн дээд оронд хүрэх, эсвэл өргөжин тэлээд хаа сайгүй оршиж чаддаг болох хэрэгтэй. Бид бүгд өөрийн жинхэнэ биеийн дотор хадгалагдан нуугдаж байдаг. Бидний сүнс, эсвэл бидний эзэн тийм жижигхэн байж ч магад, эсвэл орчлонгийн чинээ их ч байж ч магад, энэ нь бидний бясалгалын хэмжээ хэр зэрэг байгаагаас шалтгаална. Хэрвээ бид бясалгаагүй, бас энэ бие цогцосдоо хүлэгдээд байгаа, хараахан туулан гэтлээгүй үед сүнс маань тийм жижигхэн л байж, зүрхэн дотор хоригдож байж ч магадгүй. Миний хэлж байгаа зүрх гэдэг нь махан биеийн зүрхийг хэлж байгаа биш, харин сүнсэн биеийн зүрхийг хэлж байгаа юм шүү, яг л асури биед бас асурийн зүрх байдагтай адил, ойлгож байна уу? Бидний сүнс (эсвэл жинхэнэ хүн) ердөө толгойн оройн хэсэгт хоригдож байж магад. Хэрвээ тэр жаахан өндөр хэсэгт нь байвал тэр бөмбийсөн хэсэгтээ бие махбодын мөнгөн утастай нэвтрэлцэж мэднэ, тиймээс бид бас л эрх чөлөөтэй биш хэвээр байдаг. Бид жинхэнээр Түүнчлэн ирсэн болох үед хаа сайгүй оршиж, бидний жинхэнэ бие өргөжин тэлчихсэн байдаг. Харин бид махан биеэрээ дээш гарах биш, асури биеэрээ ч дээш гардаг юм биш.

Бид Гурван ертөнцийн дотор байх юмуу, эсвэл дөрөв дэх, тав дахь ертөнцөд байх үедээ туйлдаа хүрч чадаагүй байдаг болохоор бас цааш үргэлжлүүлэн дээшилж өргөгдөн томорсоор орчлон ертөнцтэй адил болох хэрэгтэй, хэзээ бид хаа сайгүй оршин байх вэ, тэр үедээ сая Түүнчлэн ирсэн болно. Тэр үед хаашаа ч явах шаардлагагүй болно, ойлгож байна уу? Хэрвээ бид сүнсээрээ гарч явах, эсвэл нас бараад ямар нэгэн оронд хүрэхийг боддог бол энэ нь бид мөн л Таван ертөнцийн дотор байгааг илтгэж байгаа хэрэг. Тав дахь ертөнцийг даван туулах үед орчлонтой адилхан болох боловч бид мөн нэг хүн хэвээрээ л байдаг. Жишээлбэл: Шагжамуни Бурхан Түүнчлэн ирсэн болсны дараа тэр Шагжамуни хэвээрээ байсан бөгөөд бас тоост хорвоод байж, Тэнгэр болон хүний багш болох нь хэвээрээ байсан. Шагжамуни хэдийгээр бодь модны доор ном тайлдаг, тоост хорвоогийн бясалгалын газарт бясалган сууж байдаг боловч тэрээр бас асурийн орон (нэг дэх ертөнц)-д асурийнхныг сургаж байдаг, үйлийн үрийн ертөнц (хоёр дахь ертөнц) болон гурав дахь ертөнцөд тэнгэрийн төрөлтийг сургаж байдаг. Дээд оронд байгаа тэнгэрийн элч нар түүнийг ганцаараа ном тайлж байгааг л харахаас биш, харин бүхий л орчлонд ном тайлж байгааг нь олж хардаггүй. Гэтэл түүний жинхэнэ эзэн нь харин бүхий л орчлонгоор

нэг байдаг, энэ бол Түүнчлэн ирсний байдал юм. Энэ нь Багшийнх нь өчигдөр та нарт заасан сүнс гаргах номын цогцосоос маш их зөрөөтэй биш үү?

Арьяабалын номын цогцосыг бид бясалгаж байгаа нь Түүнчлэн ирсэн байдалд хүрэхийн төлөө болохоос биш, махан биеэ орхиод сүнсэн биеэр гарч, бие засах газарт хүрч үзэхийн тулд биш билээ. Хэдийгээр маш олон хүн ийм номын цогцосыг заан сургаж байгааг үзвэл тэдгээр нь адил юм шиг байдаг боловч үнэндээ адилгүй. Тэр номын цогцосыг бясалгахын зорилго, эсвэл хүрэх Мөрийн хутаг нь чухам төгс төгөлдөр эсэхийг нь та нар тодорхой ойлгож мэдэх хэрэгтэй.

Хүн нас барах үеийн байдал нь Багшийнх нь та нарт өчигдрийн заасан сүнс гаргах тэр номын цогцостой адилхан, асури биеэ авч гарч байгаа хэрэг. Нэг хүн сүнсээ гаргах үед сүнсээ гаргаснаа тэр хүн мэдэхээр барахгүй эргэж ирснээ ч мэднэ, сүнс нь гараад юу олж харснаа ч мэднэ. Гэвч тэр нэг л биеэ хэрэглэснээс болоод хаа сайгүй оршиж чадахгүй, үй түмэн хувилгаан биетэй болж чадахгүй, ойлгож байна уу? Тиймээс Багш нь та нарт тийм зүйл хийхийг заагаагүй, тэгэхлээр Арьяабалын номын цогцосыг сүнсээ гаргаж тойрон зугаалах тэр номын цогцостой хольж хутгаж болохгүй.

Тайваньд хэд хэдэн хүн сүнсээ гаргаж тойрон зугаалж чадна, тэдний дотор их нэр алдаршсан нэгэн номч багш байдаг. Нэг өдөр тэр самадид ороод хоёр долоо хоног болоход шавь нь түүнийг нас барчихлаа гэж бодсон ч бие нь бүлээн байсан учир оршуулсангүй. Хоёр долоо хоносны дараа түүний сүнс эргэж ирсэнд шавь нь түүнээс: “Багшаа та хаана очоод ийм их удсан юм бэ? Бид маш их айлаа.” гэж асуусанд багш нь “Ертөнц их самуурсан болохоор би эргэж тойрч үзсэн юм” гэж хэлсэн гэнэ. Тэр нь асури сүнсээ гаргасан байдал болно. Энэ нь тун хялбархан, дээд дэсийн бясалгалыг хэрэглэхгүйгээр хийж чадах зүйл юм.

Манай гэрээс гарсан нэг авшигтан Багшийгаа дагаад удаагүй, нэг жил ч болоогүй байтлаа өчигдөр Багш нь зааж өгмөгц сүнсээ тун хурдан гаргаж чаджээ. Үнэндээ сэтгэлээ төвлөрүүлдэг л юм бол сүнсээ гаргаж чадна. Гэтэл тэр номч багш үүнээс болж л их нэр алдартай болсон байна. Түүнээс өөр бас нэгэн бүлэг хүн сүнсээ гаргаж олон газар очдогоос тун их нэрд гарсан байна. Гэтэл тэр сүнсэн биеэрээ гараад буцаж ирсний дараа их л өсгөн дэврүүлж ярьдаг. Энэ нь саяхан ярьсан тэр номч багшийг би хэлж байгаа биш, тэр номч багш хэтрүүлж ярьдаггүй. Гэтэл өөр хүмүүс сүнсээ гаргах чадвартайдаа их л омогшин бардамнаж, өөрийгөө нэгэнт бурхны дэсэд хүрчихсэн гэж бусад хүнд хэлдэг гэнэ. Түүнээсээ хойш тэр хүн сахил санваарт үл нийцэх маш олон хэргийг үйлджээ.

Сахил санваарт үл нийцэх гэдэг нь тэрээр зориудаар мах идэх юмуу, үгүй бол хувраг байж ураглахыг хэлж байгаа юм биш, энэ нь тийм ч том хэрэгт орохгүй. Тэрээр үүнээс ч бүр муу явдлуудыг үйлдсэн байна, Багш нь тэр мэтийн бохир хэргийг ярих дургүй, гэхдээ тийм хүмүүсийг сэжиглэх эрх бидэнд байгаа, ойлгож байна уу? Тиймээс өнөөдөр Багш



нь та нарт сүнс гаргах байдлыг сонсгож байгаа юм. Багшийнх нь өчигдрийн хэлсэнтэй адилаар сүнс гаргах нь ямар ч ач тусгүй бөгөөд тийм ч их том хэрэг биш, үүнийг хүүхэд хүртэл хийж чадна. Биднийг бага байхад зарим хүн Арьяабалын номын цогцосыг бясалгаагүй, өөр ямар нэгэн номын цогцосыг ч бясалгаагүй байтлаа сүнс нь гараад явчихдаг байж. Бид бага байх үедээ бас сүнсээ гаргах маш олон хэргийг хийсэн байдаг, тухайлбал, бид унтаж байхдаа зүүдлэх нь нэг төрлийн сүнс гаргах явдал юм. Заримдаа үнэн хэргийг зүүдлэх юмуу, ямар нэгэн газар машины осол гарлаа, эсвэл гай гамшиг боллоо гэж зүүдлэхэд тэр явдал үнэхээр болсныг дараа өдөр нь бид олж мэддэг. Энэ нь сүнс гарсан нэг зүйлийн жишээ мөн. Тиймээс сүнсээ гаргах нь тийм ч хэцүү биш, харин хүмүүсийг туулан гэтэлгэж чадах нь жинхэнэ бясалгалын арга болно.

Туулан гэтлэх гэдэг нь бид аль нэг сүнсэн биеийнхээ бүх хувцсыг тайлж хаяад сүнсэн биеэ бүх орчлон болтол нь өргөжүүлэн тэлж, Түүнчлэн ирсэн болохыг хэлнэ. Ингэвэл ямар хүн хаана байсан ч хамаагүй, гагцхүү биднийг боддог л бол бид тэр дороо илэрнэ, “Хаана л очё гэж хүснэ, тэнд илэрнэ” гэдэг нь энэ билээ. Энэ бол сая бидний жинхэнэ зорилго. Түүхэнд алдаршсан зарим их жанжин сүнсээ гаргах чадвартай байсан болохоор дайтах болгондоо ялдаг байжээ. Тэд байлдахаасаа өмнө сүнсээ гаргаж, дайсны байдлыг харж үзчихдэг болохоор аль газар, ямар хүн байж, тэд юу хэлэлцэж байгааг бүгдийг мэднэ. Тиймээс тэд дайнд ялах нь гарцаагүй, учир нь “өөр бусдыг мэдчихвэл, хэзээ ч ялагдашгүй”. Бас байлдаж байх үедээ өөрийн бие махбодоо тэнд нь үлдээгээд асурийн сүнсэн биеэрээ гарч шалгаж үзнэ. Шалгаж үзсэнийхээ дараа буцаж ирээд, тэрүүгээр дайралт хийх ёстой хэмээн цэргээ удирдана. Ингэх нь шударга биш. (Бүгд инээлдэв) Учир нь сүнс гаргах чадал эрдмээ тэд муу зүйлд хэрэглэдэг болохоор юу ч олж чадалгүй, эцсийн эцэст харамсалтайгаар нас бардаг.

Тиймээс, хэрвээ бясалгалтан маш олон зүйлийг мэдэж ойлгоогүй, гэгээрээгүй бол өөрийн биеэ амархан хуурч, их бардам болж, зөвхөн сүнсэн бие нь гарсан төдийхөнд өөрийгөө бурхны дэсэд хүрчихлээ гэж бодно. Мэдээж, бидний сүнс анх удаа гарах үед яаж байгаагаа мэдэх ч үгүй байж магад. Хэрвээ сүнсээ ингэж үргэлж гаргаад байх юм бол хожим бид үхэхээсээ айхгүй, ойлгов уу? Учир нь нас барах үеийн байдал нь өчигдөр Багшийнх нь та нарт зааж өгсөн тэр сүнс гаргах номын цогцостой адил байдаг. Энгийн хүмүүс нас барах үедээ ихэнх нь ийм байдаг. Зарим хүн өөрийгөө нэгэнт нас барчихсан гэдгээ мэддэггүй болохоор гэртээ буцаж ирээд гэрийнхээ хүмүүсийг үймүүлэхийг бид энэ байшин чөтгөртэй (бүгд инээлдэв) гэж ярьдаг. Зарим нас барсан хүний сүнс тун их өнчрөн ганцаардаж уйтгарлахдаа буцаж ирээд гэрийнхнийгээ үймүүлээд байдаг нь үнэн шүү.

Учир нь тэдний үгийг сонсох хүнгүй, эхнэртээ хүрэхэд эхнэр нь мэдэхгүй мөртлөө бас өөр нэгэн эрийг дагуулж ирсэн ч байж мэднэ. (Бүгд инээлдэв) Ийм явдал тохиолдоход тэрээр, мэдээжээр, их уурлаад

аяга тавгаа хүч гарган мөргөлдүүлж дуу чимээ гаргах юмуу, эсвэл хамаг хүч чадлаа гарган хаалга нүдэж үймүүлдэг юм. Зарим үед тэр ч байтугай үзэгдэх харагдах дүр дүрстэй болж чаддаг боловч эрхбш өөрийнхөө хамаг байдаг хүч чадлаа бүгдийг нь шавхаж байж л хоромхон зуурт жирвэсхийх төдий үзэгдэнэ. Ингэснийхээ дараа тэр тун их ядардаг, учир нь тэр өөрийнхөө хамаг хүчээ нэгэнт бүгдийг нь хэрэглэж дууссан байдаг. Ойлгож байна уу?

Тиймээс бид сүнсийг үргэлж олж хараад байдаггүй, учир нь тэр маш ихээр уурлаж хилэгнэх үедээ л байдаг хүчээ шавхаж байгаад өөрийн оршиж байгаагаа хүнд харуулдаг юм. Тийм сүнс нь их ганцаардмал, нэгэнт үхсэн гэдгээ өөрөө ч мэдэхгүй байдаг. Тэр ч байтугай зарим нь маш их удсаны хойно хэн нэг хүн түүнд хэлэх үед л үүнийгээ мэддэг. Энгийн хүн ертөнцөөс ангижирсны дараа гэр бүлийнх нь хүмүүс номч багш юмуу, үгүй бол ямар нэгэн хүнийг залж авчраад тэр сүнсэнд “та аль хэдийн нас барчихсан шүү, одоо цадталаа сайн хооллоод эндээс яваарай, дахин ирж үймүүлж болохгүй” гэж хэлүүлдэг юм.

Түвдэд хүн нас барах үед гэрийн хүмүүс нь номч ламыг залж авчран гүрэм айлдуулж, нас барсныг нь тэр сүнсэнд мэдүүлэхийн тулд: “Та нэгэнт нас барчихсан шүү, одоо цадталаа сайн хооллох хэрэгтэй, учир нь та дараа нь маш олон уулыг давж, усыг гатлах хэрэгтэй болно. Энд та дахин ирж болохгүй, нэгэнт хүний ертөнцөд харьяалагдахгүй болсон шүү, та явбал зохино.” гэж хэдэнтээ маш тодорхой хэлүүлдэг. Ихэнх хүн нас барсныхаа дараа ер нь л ийм байдаг. Гэтэл Багшийн заавар ёсоор бясалгалд сууж, Арьяабалын номын цогцосыг бясалгасан хүн бол тэдэнтэй адилгүй. Тэд нас барсныхаа дараа тэгж их өнчрөн ганцаардахгүй, энд тэндгүй тэнүүчлэн хэсэж, хаана очихоо ч мэдэхгүй байдаг юм биш. Ойлгож байна уу? Авшигтнууд нас барахаас өмнө Багш нь ирж, хэзээ гэдгийг нь тэдэнд урьдчилан мэдэгдэнэ. Нас барах үед нь Багш нь тосохоор ирнэ, тэгэхдээ зөвхөн Багш нь ирж тосох төдийгүй хөгжим дуутай, лянхуа цэцэгтэй ирнэ, бас бурхан бодьсатва бараа болно. Хэрэв Төгс баясгалант оронд очих дуртай бол зам зааж өгөхөөр Арьяабал бурхан удирдан дагуулж, Авид бурхан лянхуа цэцэгтэй ирнэ. Хэрвээ та нар Католик шашны Эзэн Бурханд итгэдэг бол жигүүр далавчтай тэнгэрийн элч тосохоор ирээд та нарыг аван ниснэ.

Багш нь та нарыг бадма цэцэг дээр суу гэж албадахгүй, зарим хүн бадма дээр суух дургүй, германы хамгийн алдартай машин мерседес бенз машинд суух дуртай байдаг болохоор Багш нь тийм машинаар та нарыг тосохоор ирж ч магадгүй. (Бүгд инээлдэв) Учир нь хамаг төрөлтний хүсэл нь адил биш байдаг болохоор Багш нь хамаг төрөлтний аяыг л дагана. Тиймээс хүн бүхэн цөм лянхуа цэцэг дээр суух албагүй. Хэрэв та бадма цэцэг дээр суух дургүй бол Багшаасаа сурах хэрэгтэй. Тэгвэл та юунд дуртай байдгаа Багшдаа хэлбэл Багш нь тийм төрлийн тээврийн хэрэгслийг захиалж, та нарыг тосно.

Зарим хүн бадма цэцэг дээр сууж болохгүй, учир нь түүний үйл түйтгэр нь маш хүнд болохоор гарч суунгуут бадма нь онхолдоод

уначихна. (бүгд инээлдэв) Гэрээс гарсан миний нэг шавь бясалгаж суухдаа Багшийгаа бадмалянхуа цэцэг дээр суугаад маш гэрэлтэй, маш эрхэмсэг байхыг харж гэнэ. Тэрээр авшигтнуудтай хамт гүйлдэн ирээд Багш нь тэнд сууж байхыг болон дэргэд нь маш олон бадма цэцэг байхыг харжээ. Багш нь тэднийг бадма цэцэг дээр суухыг маш их хүсэж байгааг хараад: “За яахав, та нар бүгдээрээ гарч ирээд нэг хүн нэг бадма цэцэг дээр суу.” гэж. Тэгээд тэд дээш авиран гарч суумагцаа “пүд” гэх дуу чимээ гарган бүгдээрээ ойччихсон гэнэ. (Бүгд инээлдэв) Энэ нь Багш нь тэднийг суулгахгүй гэсэн хэрэг биш юм. Зарим хүний үйл түйтгэр нь дэндүү хүнд болохоор бадма цэцэг дааж тэссэнгүй, ойлгож байна уу? Багш нь хоёр зуун хүнийг багтааж чадах цэргийн хөлөг онгоц хөлөглөн ганцхан түүнийг дээш нь аваачихаар ирсэн бол сая болох ч байсан байж мэднэ. (Бүгд инээлдэв) Учир нь түүний үйл түйтгэр дэндүү хүнд болчихжээ.

Манай Арьяабалын номын цогцосыг бясалгаж байгаа хүний ангижрах үеийн хүслэнт ахуй нь энгийн хүнийхтэй адилгүй. Асурийн ертөнцөд очлоо ч гэсэн илүү дээд газарт нь хүрэх бөгөөд тэнд өдөр бүр сургуульд явж, Багш нь бас дахин зааж сургах болно. Арьяабалын номын цогцосыг бясалгасан хүн энгийн хүнтэй адилгүй, энгийн хүний сүнс нь мунхаг харанхуй чигээрээ биеэсээ гараад өдөр бүр бие засах газар юмуу, эсвэл гал тогооны байраар эргэлдэж, үг хэлэхэд нь сонсох хүн үгүйд ихэд уурлаж, эцэс сүүлдээ чөтгөр болж хувирна. Ихэнх хүний үхэх үеийн байдал нь цөм Багшийнх нь өчигдрийн хэлсэнтэй адил байдаг. Зарим хүн Багшийнх нь өчигдөр заасан номын цогцосыг бясалгаж асури биеэ ашиглан сүнсээ гаргаад дэлхийг тойруулж, аялан зугаалаад дараа нь буцаж ирдэг. Тэр ч байтугай үүлэн дээгүүр хөвөн нисэж чаддаг, үүл манан хөлөглөх гэдэг нь ийм утгатай. Зарим үед асури бие нь хатууран царцаж эхлэх юм бол өөр хүн бидний бие үүлэн дээр байгааг олж харна. Заримдаа Их Багш нарын хувилгаан биеийг бид нүдээрээ олж үзэж болдог. Энэ талаар дараа дахин ярья.

Хэрвээ та нар Багшийнхаа өчигдрийн заасан ахуй ойлголтыг хэдэнтээ туулж өнгөрсөн бол үхэхээс айхгүй болно. Учир нь “үхэх” гэдэг нь өөр юм биш, сүнс ирж явахын төдий л зүйл гэдгийг та нар мэднэ, та нарын бие цогцос хэдийн ийм байдалд дадчихсан байх болохоор үхлээс айхгүй. Зарим бясалгалтан ийм ахуй ойлголттой болсны дараа өөрийн биеэ үхэж, төрөхөөс нэгэнт туулан гэтэлчихжээ гэж боддог болохоор их бардам омогтой болдог. Энэ үед Төгс Гэгээрсэн Их Багшийн удирдан дагуулал байхгүй бол үүнийгээ өсгөн дэврүүлсээр байж мэднэ. Тэр хүн мэтгэлцэх чадвартай гэх мэт үлэмж мэдлэгтэй, эсвэл нийтлэл сайн бичиж, хүмүүсийг их баярлуулж чаддаг бол бүр ч омгорхог бардам болно. Үнэндээ бясалгадаггүй хүн ч гэсэн зохиол бичих авъяас билигтэй байдаг. Жишээлбэл, Ли Бай, Шү Дүн Пү шүлэг дууллыг сайн зохиодог. Ли Бай гэдэг нь угаас ямар ч бясалгалгүй, өдөржин архи дарс ууна, Шү Дүн Пү нь тийм их бясалгаагүй, тэр зөвхөн даяанч багш нар дээр үргэлж очиж, мэтгэлцдэг төдийхөн байсан билээ.

Саяын хэлсэн тэр мэтийн сүнс гаргах ахуй ойлголттой хүн үүлэн дээр гарч очоод эндээс Америк, эсвэл Германд очих юмуу, эсвэл дэлхийгээр тойрон зугаалж, Сүн Ү Күнтэй адил үүлэн дээгүүр нисэн дүүлж мэдэх юм. Үүний дээр зохиол сайн бичиж чаддаг, мэтгэлцэн ярих чадвар сайн, эсвэл царайлаг, сүр жавхаатай хүн байгаад хүмүүс түүнийг хармагцаа хүндэтгэдэг бол тэр их л бардамнаж, өөрийгөө амьд бурхан боллоо гэж бодоод элдэв замбараагүй явдал хийж, мах идэх, архи уух нь бүгд л үйлийн үргүй гэх зэргээр үзэх болно. Үнэндээ үйлийн үр бий шүү. Тэр мэтийн хүн бясалгаснаараа, мэдээж, бас буян хариулалтай байх боловч түүнд мөн үйл түйтгэр байсаар л байна. Энэ хоёр зүйл нь адилгүй. Жишээлбэл, та өдөр бүр ажиллаад өдөрт хорин юань олдог гэж бодъё. Гэтэл хүнээс гадна өдөр бүр та бусдаас тавин юань зээлдэг бол таны олсон хорин юань тань таны хувийнх хэвээр байна, гэтэл хүнээс зээлсэн тавин юань нь бас л хүнд өгөх өр хэвээр байна. Ойлгож байна уу? Тэр хорин юань нь тавин юаньтай хамаагүй, хорин юань тань танд байгаа, хүнээс зээлсэн тавин юань ч мөн өр болж хэвээр үлдэж байгаа юм.

Үйлийн үр нь мөн л адилхан. Тиймээс бид бясалгал хийхдээ хамгийн сайн нь илүүхэн болгоомжтой байж, бас ургамал хоол идэх хэрэгтэй. Ургамал хоол идэхэд сайн зүйл байхгүй гэж ярилаа ч муу болохгүй. Хэрвээ та нар Багшийнхаа хэлснийг буруу гэж бодоод мах идэх нь ямар ч үйлийн үргүй гэвэл ургамал хоол идэх нь бүр ч үйлийн үргүй байна, бас тэгээд ямар ч муу гэмээр зүйлгүй. Тийм биш гэж үү? Бид хэдийгээр бусдыг мах идэхийг буруушааж болохгүй боловч тэднийг хэт их дуурайж хэрэггүй юм. Бид эртний ном судраас суралцах хэрэгтэй, бүхий л судар номд хүмүүсийг ургамал хоол идэхийг сануулсан байдаг. Бясалгал нь ямар нэг айх ёстой зүйл биш ч болгоомжтой байх хэрэгтэй. Сайн номын цогцосыг бясалгаж, бас ёс суртахуунтай байх нь буруугүй гэж би боддог. Тийм биз дээ? Хэрвээ ёс суртахуун байхгүй бол энэ ертөнц ороо бусгаа болж, бүгд хоорондоо муудалцаж, харилцан нэгнээсээ худгайлж, харилцан нэгнээ хүчирхийлэн хүн төрөлтийн цэцэн сэргэлэн чадвараа ашиглан харилцан мэхлэлцэх болно. Ингэснээр ертөнц дэлхий улам их асуудалтай болно. Ингэж бясалгах нь тийм ч их ач тусгүй, учир нь хамаг төрөлтөнд тусалж чадахгүй мөртлөө бас хамаг төрөлтөнд нэн их төвөг удах болно.

Ийм учир шалтгааны улмаас Багш нь та нарт сахилаа сайтар сахиж, болгоомжтой бясалгах хэрэгтэй гэж үргэлж сануулж байдаг. Багш нь энэ бүхэнд баригдаад байдаг учраас л тэгж хэлдэг юм биш. Хэрэв Багш нь баригдахгүй байвал хамаагүй, та нар “баригдаж байх” хэрэгтэй бөгөөд сайтар бясалгах хэрэгтэй. Нэг хэсэг хугацаа өнгөрсний дараа та нар үүнийг мэдэж, өөрийн биедээ эзэн болж ч магадгүй. Тэр үед юуг хийж болох, юуг хийж болохгүй гэдгээ ойлгоно. Дөнгөж эхэлж бясалгахдаа алгуураар бясалгах хэрэгтэй. Дэндүү яарч болохгүй, тэгвэл ойчиж мэднэ. Дөнгөж эхлэн морь унаж сурахтай адил. Морио захирч эзэмдэж чадаагүй байтлаа хурдан давхиулах гэвэл хоёулаа асуудалд орно,

наад зах нь бид өөрсдөө асуудалд орно. Тийм биз дээ? Саяхан машин жолоодож сурч байгаа хүн мөн л адил, болгоомжтойгоор аажуухан жолоодохоос биш, цагт нэг зуун жаран километр хурдтай явж болохгүй. Замын хөдөлгөөний дүрмийг зөрчиж, хурдаа хэтрүүлбэл асуудал үүсэж, бидний машин дэлбэрч мэднэ.

Одоо дахин хувилгаан биеийн учрыг ярья. Зарим үед та нар нүд нээлттэй байхдаа ч гэсэн нэгэн амьд сэрүүн байгаа Төгс Гэгээрсэн Их Багшийн хувилгаан биеийг харж чадна, харин зөвхөн шавь нар нь бясалгаж суугаа үедээ л хардаг юм биш. Миний нэг Багшийг амьд сэрүүн байхад түүний нэг шавь нь онгоц жолоодохыг сурахаар явжээ. Удалгүй шалгалт нь болох гэж байсан тэр хэдэн өдөрт шалгалтандаа гэнцэхгүй байх вий гэхээс тэрээр их айж байсан болохоор өдөр болгон багшдаа даатган залбирдаг байжээ. Тиймээс багш нь өдөр болгон очдог байсан тул онгоц жолоодохыг зааж байсан сургагч нь түүнийг олж харсан байна. Тэгэхдээ зарим үед хоромхон зуур үзэгдэж, зарим үед нилээд удтал үзэгддэг байж гэнэ. Тэр сургагч нь шавиас нь олон удаа асуухад шавь нь “Би хэнийг ч хараагүй” гэж хэлдэг байжээ. Хэдийгээр түүнийг харж болох ч, тэр орж ирмэгцээ үгүй болж, баригдахгүйгээр зөвхөн харагдах төдий байдаг байж. Тиймээс тэр сургагч нь шавиас нь тухай бүрт нь асуугаад л байжээ. Нэг өдөр шавь нь аргагүй болоод шууд илэн далангүйгээр, “Таны харсан тэр хүн бол миний багш байгаа юм” гэсэнд, сургагч нь: “Танай багш яаж манай онгоцонд орж ирж чадаж байна вэ? Бид гадны хүнийг орж ирэхийг зөвшөөрдөггүй.” гэж хэлсэнд шавь нь: “Үгүй ээ, энэ бол түүний хувилгаан бие. Багшийн бясалгалын хүч асар их, тэр хаа сайгүй оршдог. Танд буян хариулал байснаас олж үзсэн болохоос биш, хүн бүр харж чаддаг юм биш.” гэжээ.

Өчигдөр Багш нь Энэтхэгийн Йогананда-гийн түүхийг ярьсан нь бас үүнтэй адил. Йогананда нь йогийн Их Багш юм. Түүний багш нь зарим үед дэргэд нь илэрч байхыг өөр хүмүүс бас хардаг байжээ. Йогананда зөвхөн бясалгаж суугаа үедээ л багшийгаа олж хардаг биш, нүд нь нээлттэй байх үедээ ч харж чаддаг төдийгүй багшийнхаа биетэй хүрэлцэж чаддаг байжээ. Түүний багшийнх нь хувилгаан биеийг үзэхэд махан биетэй адилхан, барьж болохоор барахгүй, бас шууд үг ярилцаж болдог нь яг л Багшийнх нь одоо та нартай ярьж байгаатай адил гэнэ. Тиймээс та нар бас болгоомжтой байх хэрэгтэй, зарим үед Багш нь үнэн махан биеэрээ биш байж ч мэднэ, (Багш инээв) одоо байгаа энэ бие маань үнэн махан бие үү, эсвэл хувилгаан бие үү гэдгийг та нар мэдэхгүй, та нар хурдхан тодорхой таньж мэдэж авах хэрэгтэй шүү. (Бүгд инээлдэв)

Йогананда багшийнхаа хувилгаан биеийг харах үедээ багшийнхаа биеийг барьж, “Энэ чинь таны махан бие мөн үү?” гэж асуухад багш нь: “Тийм, махан биетэй адил боловч, жинхэнэ махан бие биш.” гэжээ. Нэг их Төгс Гэгээрсэн Их Багш биеэ илрүүлэхдээ маш олон зүйлийн арга хэлбэрээр илрүүлдэг, тэд бүгдээрээ заавал гэрэл цацруулсан биеэр илэрч гарч ирнэ гэж хэлэх аргагүй. Зарим үед махан биетэй адил болж илэрдэг юм. Тэрээр энэ ертөнцөөс ангижирсныхаа дараа мөн л махан биеэр

илэрч ирээд шавь нарынхаа амар мэндийг асуух болно. Йоганандагийн тухай түүхийг та нар намтрыг нь уншвал мэдэж болно. Хэдийгээр тэдний бясалгалын номын цогцос нь бидний номын цогцостой яг адил гэмээр биш боловч тэд бас маш сайн бясалгасан байжээ. Бид бясалгагчдын ном бичгийг унших юмуу, үгүй бол богд хутагтын үлгэр түүхийг сонсох нь Мөрийг олох сэтгэлээ зоригжуулахын төлөө билээ. Бид: “Миний бясалгал бас яагаа ч үгүй байсаар, өөр хүний бясалгасан нь тийм сайн, би явал түүн шиг сайн болох вэ?” гэх болно. Тиймээс та нар нэн илүү хичээнгүйлэн бясалгаж, Мөрийг олох сэтгэл тань улам нэмэгдэн чангарч хүчтэй болно.

Багш нь бас та нарыг богд хутагтын бясалгалын амьдралтай хамаатай ном бичиг үзэхийг тань хөхиүлэн дэмждэг. Урьдын, эсвэл одоох түүхийг бүгдийг уншиж болно, зөвхөн Багшийнхаа номыг үзэх төдий биш шүү. Гэвч уншиж дууссаныхаа дараа сэтгэл хувирч болохгүй, Арьяабалын номын цогцосыг бясалгавал хангалттай. Өөр бусад аливаа номын цогцосын аль нь ч Арьяабалын номын цогцосоос өндөр дээд биш, хэрвээ өндөр дээд байсан бол Багш нь та нарт заах байсан. Манай энэ номын цогцосыг бясалгахад үнэндээ бүгд Гэрэлтэй болдог ч зарим хүн Гэрэл байдаггүй гэж бодож ч магадгүй байдаг, гэвч дотоодын Аялгуу байвал болчихно. Бясалгахдаа тэгж их яарч сандарсны хэрэггүй. Учир нь хүн болгоны төрөл төрөлдөө бясалгасан байдал нь адилгүй байдаг. Зарим хүн нэгэнтээ хэдэн төрөлдөө бясалгасан ч, зөвхөн энэ нэг төрөлдөө л Багштайгаа уулзсан байна, зарим нь энэ төрөлдөө дөнгөж сая эхлэн бясалгаж байна. Урьд үедээ бясалгаж байсан байдал нь адилгүй болохоор дэвших хурд нь адилгүй байх нь гарцаагүй билээ.

Бид тэвчээртэй байж, хүч чадлаа шавхаж байгаад бясалгах хэрэгтэй. Гэвч яарч тэвдэж болохгүй, бас горьдлого тасарч урам хугарч болохгүй. Ингэвэл л сая бидний бясалгалд тустай. Тэрхүү Мөр олох чанга тууштай? сэтгэл нь нэг зүйлийн адислах хүч болж, нэг зүйлийн үлэмж ач буян болно. Бид өдөр бүр бясалгахыг бодож, туулан гэтлэхийг хүсэх нь ахуй ойлголттой болохоос бүр ч чухал. Зарим хүн хэдийгээр ахуй ойлголттой болдог ч өдөр бүр Мөр олох сэтгэл нь чанга тууштай биш бөгөөд өнөөдөр бясалгавал маргааш нь бясалгахгүй юмуу, энд ирж бага сага бясалгаад бас удалгүй тэнд гүйж очоод бага сага бясалгадаг. Ингэж тогтворгүй байвал тийм ч их ач тустай биш. Ойлгож байна уу? Хэрвээ нэг хүний ахуй ойлголт нь тун бага байсан ч Мөр олох сэтгэл нь маш чанга тууштай байгаад өдөр бүр туулан гэтлэхийг хүсэж, зовж зүдрэн байж чармайн бясалгавал тэр хүн лавтай Мөрийг олно. Бурхан бодьсатва бас лавтай түүнийг санаж байх бөгөөд бясалгал нь лавтай үр дүнтэй болно.

Бясалгал хийж гэгээрсэн хүнийг харахад ямар ч онцгой шинж байхгүй байж магад, гэвч түүний нүүр царайг харахад тун гэрэл гэгээтэй, сэтгэл нь маш уудам, өршөөнгүй, бусдад ач тус хүргэх сэтгэлтэй, аль нэг зүйл бусдад ашигтай бол тэрээр даруй очиж хийдэг, түүнд аминч үзэл байдаггүй, тэр юу ч хийсэн гэсэн агуу уудам байдаг, анхаарлаа зөвхөн



өөрийн ашиг сонирхол дээр юмуу, үгүй бол өөрийн гэр бүл, өөрийнхөө бүлгэм дээр төвлөрүүлдэггүй. Бид түүний хандлагыг харвал тэр хүний гэгээрсэн хэр хэмжээ ямар гэдгийг нь мэдэж болно.

Тиймээс зарим үед хэдийгээр бидэнд их ахуй ойлголт байхгүй, эсвэл тийм ч их ахиц дэвшилгүй байлаа ч бурхан бодьсадва яагаад туслахгүй байна вэ гэж асуух хэрэггүй. Бид эхлээд өөрсдөөсөө, Бурхан бодьсадвад тусалж хамаг төрөлтийг гэтэлгэх зүйл хийсэн үү, үгүй юу?, бид бусдад ач тус хүртээж байсан уу?, олон нийтийн ач тусын төлөө хувь нэмэр оруулсан зүйл бий билүү?, Бидэнд бүхий л орчлон ертөнцийн төлөө хийсэн зүйл байна уу?, Үүнийг хамгийн агуу хүсэл зорилгын төлөө хийсэн билүү? гэж тодорхой асуувал зохино. Учир нь үйл байвал үр байх ёстой. Багшийнхаа санааг ойлгож байна уу? Хэрвээ бид туулан гэтэлье гэвэл бусдыг туулан гэтлэхэд нь туслах хэрэгтэй. Бид хэрвээ багш больё гэвэл Багшдаа тусалж, Багшийгаа хүндэлж, Багшийнхаа зааврыг сонсох хэрэгтэй. Учир нь ямар үйл байна, тийм л үр дагавар гардаг. Юу ч энэ хуулийг өөрчилж чадахгүй, энэ бол бясалгалын хууль дүрэм.

Тиймээс бид байнга бусдаас юм авах биш, бас бусдад өгөх дуртай байх ёстой. Хэрвээ хүн бидэнд юм өгвөл бид бас авч болно, гэвч завшааныг олж хүмүүст ямар нэг зүйл өгөх хэрэгтэй. Ингэж бидний бие, хэл, сэтгэлийн чадвар бидний Мөр олох сэтгэлийг тэтгэж, бид сайн сайхан мэдээгээ хамаг төрөлтөнд хүртээх ёстой юм. Жишээлбэл: Ямар номын цогцос нь хамгийн сайн, эсвэл Багшийгаа дагаж бясалгавал энэ нэг төрөлдөө туулан гэтэлнэ, Арьяабалын номын цогцосын бясалгал ямар ач тустай вэ гэх зэргийг бусдад ярих нь бас нэг зүйлийн хувь нэмэрт тооцогдоно. Багшдаа тусалж ямар нэгэн юм хийх, эсвэл Багшийнхаа хувцас хунарыг нь угаах, хоол ундыг нь хийх зэрэг нь л сая тусалж байгаа хэрэг биш юм. Ойлгож байна уу? Бусдад туулан гэтлэхэд нь туслах, “зөв зам мөр”-ийг мэдэхэд нь туслах, энэ бол хамгийн дээд тусламж, хамгийн дээд ач буян юм. Жишээлбэл: Та нар ар талын атаршиж орхигдсон газрыг цэвэрлэн авшигтнууд нэг доороо хамт бясалгах түр зуурын төв байгуулахаар бэлтгэснийг хараад би тун их байрласан. Энэ бол маш сайн ач буян боллоо. Энэ нь бид ач буянд шунасандаа биш юм, Багш нь та нарын ингэхийг зоригжуулж байгаа нь Багшид нь ямар ч тус болох юм байхгүй. Гэвч үйлийн үрийн хууль, бясалгалын хууль гэдэг нь ерөөс ийм байдгийг та нар мэдэж авах ёстой, хамаг төрөлтөнд ач тус хүртээх тусмаа бид өөрсдөө төдий чинээ ач тус хүртдэг юм.

Тиймээс бид зөвхөн өөрийн бясалгал хэр зэрэг болж байгааг анхаарах хэрэггүй бөгөөд бас ганцаараа бясалгаж болох эсэхийг чухалчлан анхаарах хэрэггүй. Харин бүгдээрээ хамтаараа бясалгаж чадах эсэх, бидний чармайсны хүчинд хичнээн олон хүн бясалгаж байна вэ?, хичнээн хүн жинхэнэ ач тус хүртсэн бэ гэдгийг анхаарвал зохино. Жинхэнэ ач тус гэдэг нь тэдэнд “зөв зам мөр”-ийг мэдүүлж, тэднийг бидэнтэй хамт бясалгуулах явдал юм шүү. Энэ нь хамгийн дээд ач тус. Мөнгөний өглөг өгөх юмуу, эсвэл хүнд тусалж ус дамжилж өгснөө их

юманд бодсоны хэрэггүй. Энэ нь хийвэл зохих зүй ёсны хэрэг. Гэтэл бусдад туслан зөв номлолыг мэдүүлэх нь хамгийн чухалд тооцогдоно. Бид бусдад туслах тусмаа улам өргөжин тэлж, улам сайн болно. Өнөөдөр би энэ хүртэл ярилаа. Та нар харьсныхаа дараа энэ чухал зүйлийн талаар бодож, хэр их зүйл нэгэнт хийчихсэн бэ, хэр ихийг хийж чадах вэ, хэр ихийг хийхэд бэлэн байна вэ гэдгээ өөрсдөөсөө асуугаарай.

**Асуулт:** Заримдаа Аялгуу ажих үед олж сонсдог дууг энгийн цагт сонсдог. Ийм байдал нь сайн уу, эсвэл муу юу?

**Хариулт (Их Багш):** Угаас олж сонсох нь зүйтэй, (Мөн энгийн үедээ бас олж сонсдог.) Энэ нь тун сайн! Ингэснээр л сая Багшийнхаа байгааг нотолж чадна. Зөвхөн Аялгуу ажих үедээ л сая олж сонсдог биш. Үүний санаа нь Багш нь үүрд байж, байнга оршиж байдгийг л хэлж байгаа хэрэг.

Багш чинь бие цогцос биш, Багш нь Гэрэл, Аялгуу, Хүч юм.

## БАГШИЙН АДИСЛАЛЫН ХҮЧИЙГ ХЭРХЭН ТАНЬЖ МЭДЭХ ВЭ?

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формосагийн Тайнан хотын Чи гү бясалгалын төв  
1987 оны 12 дугаар сарын 5 (Эх нь хятад хэлээр)*

Бид хааяа хэн нэгний “Тэр Багшийг дагаж сурах ямар хэрэгтэй юм бэ?” гэж гомдоллон хэлж байхыг сонсдог. Тэд мөн Арьяабалын аргаар бясалгах нь бурхныг дурсан уншихтай адил ямар ч ач тусгүй гэж хэлж ч мэднэ. Ингэж хэлэх хүн байдаг уу, үгүй юү? Нээрээ байдаг шүү дээ. Бясалгалаа хангалттай хийдэггүй хүмүүс адислалын хүч байдгийг тийм түргэн сэргэж мэдэрдэггүй болохоороо л тэгж гомдоллодог юм. Гэтэл зарим хүн Багшийнхаа адислалын хүчийг ойлгочихдогийг бид мэднэ. Жишээлбэл: Тайнанд байгаа манай нэг настан авшиг хүртээд удаагүй, хэдхэн сар болж байна. Тэр саяхан машины осолд оржээ. Тэр машинд мөргүүлээд ухаан алдсан ч хэн нэгэн хүн түүнийг дагуулан явж байна даа гэмээр санагдаж байж гэнэ. Машинд мөргүүлсний дараа өвдсөнөө ч мэдээгүй бөгөөд нэгэн зурвас гэрэл түүнийг дагуулж явахыг л харжээ. Тэр зурвас гэрэл нь Багш чинь юм. Ойлгож байна уу? Зарим хүн Багшийгаа ийм янзтай байхыг нь олж үздэг, зарим нь харин тийм янзтай байхыг нь олж харна, зарим нь Гэрэл хардаг, зарим нь Аялгуу сонсдог. Энэ бол Багшийн адислах хүч юм. Зарим хүн хэлэхдээ Багш нь гэрт нь очоод саяхан нас барсан төрөл төрөгсдийг нь аваад дээд төвшин лүү очихыг харсан гэдэг. Авшиг хүртсэн хүн л зөвхөн олж үздэг биш, авшиг хүртээгүй хүн ч гэсэн олж хардаг юм. Бүр зургаан настай, ес, арван настай хүүхэд ч олж хардаг. Тэд тэгж олж харж байх үеийн байдал нь яг самадид орсонтой адил, тэр байдлыг үг хэлээр ярихын аргагүй, тийм байдлыг тайлбарлахын аргагүй.

Авшиг хүртсэн хүн Багшийнхаа хувилгаан биеийг олж үздэг. Тэр нь тэдний хий бодол юмуу, эсвэл Багш нь тэднийг ховсодсон, эсвэл Багш нь ямар нэгэн “хум пад” гэх мэтийн зөн билгээр (Багш гараараа дохиж үзүүлэхэд бүгд инээлдэв) тэднийг төөрөгдүүлсэн гэж та нар хэлж болох билээ. Гэтэл тэр зургаан настай, есөн настай, арван настай хүүхдүүд урьд нь Багшийг нь ерөөсөө харж байгаагүй, тэгээд бас бясалгах гэж юу болохыг ч мэдэхгүй, тэд Багшийг чинь олж харах үедээ Багш нь хэн

болохыг таних ч үгүй, зөвхөн гэр орныхондоо: “Нэг гэрээс гарагч иржээ, дүр байдал нь маш гоё үзэсгэлэнтэй, гэрэлтэй.” гэх зэргээр хэлдэг байна. Гэр орныхон нь хүүхдээ хачин болчихлоо гэж бодоод: “Хаана байна? Хэн ч ирээгүй байна!” гэж хэлэхэд хүүхэд нь “байна, байна” гээд бас тэр хүн (Багшийг хэлж байна) нь ямар янз төрхтэйг тайлбарлан хэлжээ. Тэр үед авшиг хүртсэн нэг шавь Багшийнх нь гэрэл зургийг авч ирээд тэр хүүхдэд үзүүлж: “Энэ хүн мөн үү?” гэж асуухад, тэр хүүхэд: “Мөн, мөн, гэхдээ энэ гэрэл зураг дээрхээсээ жаахан мариалаг харагдсан.” (бүгд инээлдэв) гэж хэлсэн гэнэ. Үнэндээ мах мариатай биш, царай нь жаахан дугариг болсон төдий, учир нь биеэс гэрэл гарч байгаа хэрэг. Гэрэлтэй болохоороо жаахан мариатай харагдаж байжээ.

Багш нь өнөөдөр газар үзэхээр явлаа, уржигдар ч бас үзэхээр явсан. Тэгэхдээ нэгэн томоохон шашны сүмийн дэргэдүүр өнгөрөхөд дуганы гадна Есүс Христийн хөрөг дүрт хөшөө байхыг харлаа. Тэрээр элбэг, урт хувцас өмсчихсөн, тэргүүнээс нь гэрэл цацарч байв. Би түүний тэр байдлыг үзээд дотроо: “Урьд нь тэр бясалгал хийдэг байсан болохоор Гэрэл цацруулдаг байлаа. Тэр Гэрэл нь одоо ч манай эндхийн газрыг гэрэлтүүлж, маш олон хүн түүний Гэрэлийг шүтэн биширч байна. Түүний Гэрэлээс нь болж хүмүүс тэр бол богд хутагт хүн, тэр бол агуу хүч чадалтай хүн, Мөрийг олсон хүн гэдгийг нь мэддэг. Тийм биш үү?” гэж бодсон. Тийм биз дээ?

Манай Шагжамуни Бурхантай адил, бид түүний хөрөг зургийг олж харах юмуу, эсвэл Арьяабал Бурхан, үгүй бол аль нэг бурхны хөрөг зургийг харах үед бүгд л Гэрэлтэй байдаг болохоор зөвхөн тэр хүмүүс л Гэрэл цацруулж чадна гэж боддог. Гэтэл бид бясалгал хийвэл бүгдээрээ Гэрэл цацруулж чадна, зөвхөн бие махбодоосоо Гэрэл цацруулж чадах төдийгүй, бас цаглашгүй Гэрэл цацруулж чадна, хаа ч бай бидний Гэрэлийг хэрэглэх шаардлагатай бол тэр газрыг гийгүүлнэ, бид Авид Бурхантай адил болж, цаглашгүй Гэрэл болно.

Би тэр шашны сүм дуганыг харах үед миний дотор нэгэн зүйлийн сэтгэгдэл төрсөн нь бухимдаж байгаа ч биш, гуньж байгаа ч биш, нэгэн тийм хэлж гаргаж чадамгүй, яахыгаа мэдэхгүй болсон тийм сэтгэгдэл байлаа. Одоог хүртэл хоёр мянга гаруй жилийн туршид ертөнцийн ихэнх хүн зөвхөн Есүс Христэд л ийм Гэрэл байсан гэж боддог. Энэ нь төсөөлөхөд тун бэрх асуудал биш гэж үү? Түүний Гэрэл нь тийм их болохоор энгийн хүн одоо болтол түүний хүч чадалд итгэсэн хэвээр байгаа хэрэг. Энэ ертөнц дээр одоо бас хэдэн хүн ийм Гэрэл цацруулж чадна, ийм нэгэн Есүс Христ гэдэг агуу хүн гагцхүү хоёр мянга гаруй жилийн өмнө л байсан биш гэдгийг тэр хүмүүс мэддэггүй. Тэрхүү Мөрийг олсон хүмүүс хэдхэн зурвас Гэрэл цацруулж чаддаг төдий биш, бас хүмүүсийг туулан гэтэлгэж чадна, сургаж чадна, өөрсдөөсөө Гэрэл цацруулдаг болгож чадна, өөрсдийгөө үхэж төрөхөөс ангижруулж, эрх чөлөөтэй болгож чадна.

Үүнтэй адил, манай бурхны шашинтан хаа ч явсан Шагжамуни Бурханы Гэрэл цацруулдагийг шагшин магтдаг билээ. Тэр ном тайлах

үедээ тоост хорвоог бүхэлд нь адислаад шижир алтан дэлхий болгон хувиргаж чадна. Аливаа энхэл донхол газар бүхнийг бүгдийг нь тэгшхэн сайхан болгодог. Түүний Гэрэл гялбаа нь олон газрыг гийгүүлэн гэрэлтүүлэх үед шавь нар нь тэр байгаа газраасаа л диваажинг олж харж чаддаг байжээ. Энэ нь авшиг хүртсэн төлөв байдал юм. Зарим хүн авшиг хүртэх юмуу, эсвэл бясалгаж байгаа үедээ ийм байдлыг олж үзэж ч магадгүй. Зарим хүн Багшийнхаа ном тайлахыг сонсох үедээ бас тийм хүслэнт ахуйг олж авч болох юм. Тийм нөхцөл байдал болон тийм сэтгэгдэшгүй хүчнээс болж одоо болтол Шагжамуни Бурханы нэр нь алдартай хэвээр байгаа бөгөөд энэ дэлхийн хагасаас илүү хүн түүнийг бишрэн шүтсээр байна. Учир нь түүнд тийм хүч чадал байгаа юм. Гэтэл ганцхан түүнд л тийм их хүч чадал байгаа хэмээн бүгд боддог нь тун их бухимдмаар байдал биш үү?

Шагжамуни Бурхан болон Есүс Христ бол бидний шагшин магтууштай, шүтэн бишрүүштэй хүмүүс. Тэдний ач буяныг бид хэлээд баршгүй, магтаад ч баршгүй. Гэвч дэлхийн бөмбөрцөг дээрх хүмүүсийн хагасаас илүү нь зөвхөн тэдэнд л ийм их хүч чадал байдаг гэж итгээд өдөр бүр тэдэнд мөргөн залбирдагаас биш, тэдэнтэй адил хүч чадалтай өөр Төгс Гэгээрсэн Их Багшийг эрж хайсангүй, тэднийг тэдэнтэй адил агуу их болгох арга байна уу, үгүй юү гэдгийг хайж үзсэнгүй, харин нирваандаа буцаж, үзэгдэж харагдахгүй болсон эрт үеийн Их Багш нарт өглөөнөөс аваад үдэш болтол мөргөдөг юм. Төгс Гэгээрсэн Их Багш бол зөвхөн Есүс Христ, Шагжамуни Бурхан биш, бас Мухаммед, Платон, Лууз, Жуанз гэхчлэн энэ ертөнц дээр их хэмжээгээр нэр алдаршсан Төгс Гэгээрсэн Их Багш олон байдаг. Тэд аль эрт нэгэнт таалал төгсөөд удсан ч тийм эртний Их Багш нарыг одоо бас их олон хүн бишрэн шүтсээр байдаг нь тун харамсалтай биш үү? Заримдаа би үүнд үнэхээр итгэж чадахгүй болоод зөвхөн толгойгоо сэгсэрч, юу ч хэлэх аргагүй болдог. Багш нь өдөр болгон судар ном уншдаг, зарим үед дэндүү уйтгартай санагдахаар унших дургүй хүрдэг. Гэвч хүмүүст ном тайлж сонсгох болохоор заримдаа ном судрыг лавлагаа болгох юмуу, эсвэл орчин үед дэлгэрч байгаа гүн ухааны номуудыг лавлагаа болгохын тулд уншдаг, ингэх нь хамаг төрөлтөнд ач тустай.

Дундад улсад: “Эрдэмтэн мэргэд нэг өдөр ном бичиг шагайхгүй бол тун уйтгартай, тун тааламжгүй санагдах болоод толинд нүүрээ харсан чинь өөрийгөө бүр танихаа больжээ.” (бүгд инээлдэв) гэсэн үг байдаг. Яагаад тэр вэ? Учир нь бясалгал хийж байгаа хүний сэтгэл нь угаасаа хов хоосон болдог. Тэд юу ярилаа ч дараа нь бүгдийг нь мартчихдаг. Ярихаасаа өмнө бэлтгэдэггүй, ярьж дууссанахаа дараа бүгдийг нь мэдэхгүй болчихдог, учир нь түүнд “Би” гэх үзэл үгүй. Ойлгож байна уу? Тэр нэр алдар, ашгийн төлөө, мөн хүмүүст бишрүүлж шүтүүлэхийн төлөө л юм ярьдаг биш, түүнд ямар ч зорилго гэж үгүй, учир нь түүний дэс нь нэгэнт эгэл хүмүүсийн тархи толгойны бодол сэтгэгдлээс хэтийдэн давчихсан. Түүний хувьд “дэлхий дахин угаас амгалан”, түүнд юу ч хийх шаардлага байхгүй хэдий ч маш олон хүн

түүний тусламжийг гуйж, түүний билиг ухааныг сонсохыг хүсэж байдаг болохоор тэр судар ном шагайх хэрэгтэй болдог, ном судрыг үндэслэж яривал л хүмүүс сая ойлгож чадна.

Учир нь ихэнх хүн энэ мэтийн ном судрыг уншаад их удсан болохоор үүнийг ярихгүй юм бол өөр юу яривал тэд сая ойлгож чадах вэ? Эхлээд ном судраас ярьж, дараа нь алгуураар өөр зүйлийг ярина, тэгэхгүй бол яримаар зүйл байдаггүй. Багш нь юу ч ярихгүй байвал л хамгийн сайн. Улам ихийг ярьж тайлбал улам буруудан ташаарч байгаа шиг санагдах юм гэж Багш нь олон удаа бодож байлаа. Учир нь Үнэн ёсыг үг хэлээр илтгэж хэрхэн чадах билээ? Дээд хүслэнт ахуйн ахуй ойлголтыг илэрхийлэхийн аргагүй. Жишээлэхэд, нэг хүн гэгээрч Мөрийг олсны дараа тэр маш их баяртай байсанд нэгэн хүн түүнээс: “Ингэж их баярлахын учир юу вэ?” гэж асуусанд тэр: “Надад хэлэх арга алга, миний харсан тэр хүслэнт ахуйг би гаргаж хэлж чадахгүй нь.” гэжээ. Нөгөө хүн бас: “Юунаас болж тийм их баяртай болдог вэ? Зах зухаас нь ч болов бидэнд ярьж сонсохгүй юу?” гэхэд тэр жаахан бодолхийлж байгаад: “Тэр баяр баясгалантай байдал нь энэ дэлхий ертөнц дээрх хамгийн их баяр баясгалантай байдлаас хэмжээлшгүй илүү, тэр ч байтугай үүнээс ч хол илүү байгаагаас тэр” гэж хэлжээ. Гэхдээ энэ нь зөвхөн гэгээрсэн төдий биш, “Мөрийг олсон” гэсэн санааг илтгэж байгаа юм.

Судар ном хэдийгээр тун сайн ч энэ нь хамгийн дээд хүслэнт ахуй биш. Хаалгаар нь орохоосоо өмнө бид түүнийг бага сага лавлагаа болгож болно. Хаалгаар нь орсны дараа бид өөрийн ахуй ойлголтоо ном судраар баталж болно, ингэснээр өөрийнхөө дэс төвшин хаана хүрч байгаагаа мэдэж чадна. Гэхдээ тийм ахуй ойлголтоос хэтрээд давчихсан бол бид ном судартай харьцуулахын аргагүй болно. Тиймээс “даяан” нь үг хэл хэрэглэдэггүй гэдгийг та нар сонсоо биз дээ.

Бид заримдаа Багшийнхаа хувилгаан биеийг олж хардаггүй, бас хүн бүхэн олж харж чаддаг ч юм биш, энэ нь бидний өмнөх суурь, урьд төрлийн бясалгал, эсвэл одоогийн бидний чин сэтгэл болон хичээл чармайлтын хэр хэмжээ ямар вэ гэдгээс хамаардаг, эрхбиш маш олон нөхцөл нийлж байж л сая Багшийгаа олж харж чаддаг юм. Гэхдээ Багшийгаа олж харвал сая Багшийнхаа тусалж байгааг мэддэг биш. Хэрвээ та нар үнэхээр өдөр бүр анхаарлаа хандуулж байвал нэг зүйлийн хүч бидэнтэй хамт байгааг олж мэдээд маш аюулгүй байдлыг мэдэрнэ, тийм биз? (Нэг хүн ингэмсэглэн зөвшөөрч байгаагаа илтгэв.) Та нарт ийм мэдрэмж байдаг боловч ярьж илтгэж чадахгүй байгааг тань би мэднэ. Бид юу ч хийсэн ч хамаагүй, яг л хоёр хүн хамтдаа хийсэн шиг санагддаг, хаа байсан ч яг л нэг хүн бидэнд хань бараа болж байгаа шиг, бид юу хийсэн ч бурууддаггүй, буруудвал тавгүй санагдаж, яг л хэн нэг хүн хажуугаас хараад байх шиг байдаг.

Тийм ээ, тэр үнэхээр харж байдаг, гэвч тэр шүүмжлэхгүй, гүтгэхгүй, ерөөсөө бидэнд саад болохгүй. Бидэнд тусламж хэрэгтэй бол тэр даруй тусална, туслах хэрэггүй үед зөвхөн харж л байдаг. Энэ нь яг хүүхдийн цэцэрлэгийн багштай адил, түүний үүрэг хариуцлага бол хүүхдийг



асрах явдал. Тэр үед хүүхдүүд юу ч хийж чаддаггүй болохоор бүгдийг хамт байлгаж аюулгүй байдлыг нь харж харгалздаг юм. Жишээлбэл, зарим үед бид арилжаа наймаа хийх юмуу, эсвэл аж амьдралаасаа болж өдөр бүр гадагш гарч ажиллах хэрэгтэй байдаг. Энэ ертөнцөд чармайн ажиллаж байж л хоол олж, амьдарч чадна. Энэ нийгэмд мөнгөгүй бол амьдарч чадахгүй. Тийм үү, үгүй юу? Бид өдөр бүр гадагш гарч ажиллах ёстой болохоор тун их ядарч зүдэрнэ. Заримдаа арилжаа наймаа муудна, заримдаа өөр хүн бидэнтэй муудалцана, заримдаа бид ямар нэгэн юм хийх дуртай байсан ч харин бүтэмжтэй хийж чадахгүй болно. Арьяабалын аргаар бясалгадаг хүн байсан ч бас л адилхан. Тэрээр заримдаа өөрөөсөө: Би яагаад одоо өвдөж байна вэ?, Арилжаа наймаа минь яагаад өөдлөхгүй байна вэ?, Өөр хүмүүс намайг яагаад мэхэлдэг юм бэ? гэх мэтээр асуудаг. Тийм үедээ бид маш олон асуудалтай болоод: “Багш хаа сайгүй оршдог, Багш бол махан бие биш, тэр хэзээд бидэнд тусалдаг гэж Багш ярьдаг байтал надад яагаад ийм зүйл тохиолдоод байна аа?” гэж дотроо боддог, тийм биш үү? Зарим үед бидэнд эргэлзээ, сэжиг төрж, гомдоллодог.

Ийм байдлыг Багш нь бас мэдэж байдаг, тэгээд надад бас эргэлзээ, сэжиг төрж, гомдолтой байдаг юм, та нарт үүний лавлагаа болгохоор бичсэн шүлэг надад бий. Одоогоор хятад хэлээр орчуулагдсан боловч би бас түүнийг жаахан хянан засаж, сайхан болгосны дараа хэвлүүлэн гаргана. Ингэвэл та нар уншиж болно. Энэ нь Багшийнх нь Тайваньд хэвлүүлсэн шүлгийн анхны ном болох бөгөөд шүлгийн үг үсэг нь урт биш богинохон, хэдхэн мөр. Та нар тэр шүлгийн ном “Чимээгүй нулимс”-ыг олж уншвал тэр дотроос өөрийгөө олж таниад яг л Багш нь та нарын өмнөөс ярьж байгаа юм шиг санагдаж мэднэ.

Бид энэ нийгэмд заримдаа юу хийсэн ч ялагддаг. Тэр үед бурхан бодьсадвад эргэлзэх, Багшдаа эргэлзэх, бидний бясалгаж байгаа номын цогцосдоо үл итгэх байдал гардаг. Гэхдээ бид ингэж болохгүй ээ. Танай дундад улсын Сай өвгөн морио алдсан тухай домог үлгэрийг бүгдээрээ мэднэ, тийм үү? (Бүгд мэднэ гэж хариулав) Тэр морио алдсанаасаа болоод өөр сайн зүйлийг олж чадсан юм шүү. Сай өвгөний үлгэрт түүний бясалгасан эсэх тухай яриагүй, гэтэл түүнийг лавтай бясалгаж байсныг бид мэдэж болно. Хэрвээ бясалгал хийгээгүй юм бол тэр тийм хандлагатай, тийм уужуу тайвуу, амарлингуй, тийм итгэл дүүрэн байж чадахгүй. Ямар ч нөхцөл байдал тохиолдсон тэр айхгүй, бид түүний үлгэр жишээнээс суралцвал зохино.

Хэрвээ тэр бясалгалгүй хүн байсан юм бол бид бүр ч илүүгээр өөрсдийн бясалгалын хүч чадалдаа итгэх хэрэгтэй. Учир нь тэр зөвхөн нэгэн эгэл хүн байгаад тийм итгэл төгс, юунаас ч айхгүй, их уужуу тайвуу, амарлингуй намба төрх байдалтай байтал бясалгалтнууд бид харин юунаасаа айх билээ? Ойлгож байна уу? Энэ Хуан овогт номын ах өөрийн өвчнөө хэрхэн ялан давж чадсан бэ? Та нар мэдэх үү? Тэр яагаад үхлийн хувь заяанаасаа мултарч чадсан бэ? Учир нь тэр Багшдаа итгэдэг. Тэр бясалгалтай байжээ. Бясалгалтай хүн тэгж их айж сандрахгүй, тийм

амарханаар ямар нэгэн зүйлээс сүрдэж айдаггүй. Айх буюу сүрдэх хандлага нь бидний хамгийн том дайсан.

Одоо Багш нь адислах хүч ямрыг ярихаа больж, шинжлэх ухаанд хамаатай зүйлийг бага зэрэг ярья. Хэцүү нөхцөл байдалтай тулгарах үедээ бид хэрвээ айдаг юм бол дууссан хэрэг болно. Айх үед бидний судсан дахь цус царцах шиг болдог болохоор бид үргэлж “би үхтлээ айлаа” гэж хэлдэг билээ. Айсны эрхээр цус гүйхээ больж, зүрх зогсож, тархи толгой ажиллахгүй болно. Тэр үед юу хийе гэж бодсон ч хийх аргагүй болж, бодож сэтгэхээ больдог.

Цус урсах нь маш аюултай гэдгийг хүүхэд ч хүртэл мэднэ, учир нь тэд эхээсээ олж сонссон байдаг, хүүхэд эхийнхээ үгэнд тун их итгэдэг. Хэрвээ эх нь тэгж их айж байгааг харвал цус урсах гэдэг нь тун ноцтой хэрэг болохыг тэд мэднэ. Хүүхэд бүгд л угаас эхдээ түшиглэдэг болохоор эх нь тайвширсны дараа аюулгүй санагддаг. Хэрвээ эх нь их айвал тун хэцүү болсныг хүүхэд мэднэ. Уг нь хүүхэд цус нь гарах үед уйлаагүй байснаа, хэрвээ охин дүү нь юмуу, эсвэл эх нь: “Хөөх! Цус гарч байна! Болохоо болилоо!” гэж хэлбэл сая уйлж эхэлдэг.

Тиймээс бясалгал хийж байгаа хүмүүс бүгд тийм уужуу тайвуу байдаг биш, бясалгаад нилээд их хүч чадалтай болж байж л сая уужуу тайвуу болж чадна гэдгийг бид мэдэх ёстой. Саяын ярьсан тэр Хуан номын ах өвчтэй байх үедээ тэгж их горьдлого тасарч, эмгэнэн уйлсангүй, тэр мөн амьдрахыг хүссээр байжээ. Энгийн цагт тэр Багш луугаа ердөө угасддаггүй байсан ч тэр үед харин Багш луугаа утасдаад инээж байв. Яагаад гэвэл Багшдаа “итгэж” байж, ойлгож байна уу? Багштайгаа яривал эдгэрнэ гэж тэр гүнээ итгэж байжээ. Түүнд тийм баттай итгэл байсан хэрэг.

Бас түүний бясалгалын ахуй ойлголт нь нилээд сайн, Багшийнх нь ярьж тайлж байгаа нь бүгд үнэн баттай болохыг тэр мэднэ. Багшид нь хүч чадал байдгийг үнэнээсээ мэдэрдэг байжээ. Багшийнх нь хүч бол Бүтээгчийн хүч болохоос биш, харин “Би” - Чин Хайн хүч биш, ойлгов уу? Багш нь “Чин Хай” гэх энэ нэг махан бие биш. Багш нь гэж хэлж байгаа нь бурхан бодьсадвагийн дэсийг л хэлж зааж байгаа хэрэг. Энэ Багшийн хүч чадал нь орчлон дээрх хамгийн агуу их хүч чадал юм. Нэг зүйлийн хүч чадал нь бид бүгдээс агуу байдаг, бид тэр хүчинд найдвал аливаа зүйл бүгд өөрөө шийдвэрлэгдэх болно. Бид хэрвээ хүн төрөлхтний өчүүхэн хязгаарлагдмал хүчинд найдвал, мэдээж, юу хийсэн ч сайн хийж чадахгүй, өнө мөнхийн болж чадахгүй, түр зуурхан л ач тустай байж мэднэ, гэвч өнө мөнхийн ач тус хүртээж чадахгүй.

Бид аль хэдийнээ Арьяабалын номын цогцосыг бясалгачихсан байхад яагаад заримдаа бас асуудал тулгардаг вэ гэж та нар асууж мэднэ. Жишээ нь, тэр Хуан овогт номын ах Арьяабалын номын цогцосыг бясалгаж, авшиг хүртсэн байтал Багш нь юунд түүнийг хамгаалаагүй юм бэ? Яагаад өвчтэй байлгасан бэ? гэж бодож мэднэ. Тийм биз дээ? Өвдвөл өвдөг, нас нөгчөөгүй л бол тун сайн хэрэг. Тэр хэрвээ ингэж

өвдөөгүй бол тийм хүнд үйл түйтгэрийг яаж тийм хурдан арилгаж чадах вэ? Багшийнхаа санааг ойлгож байна уу? Хэрвээ энэ удаа өвдөөгүй бол тамд унаж хэдэн зуун мянган жил байх ёстой болно. Та нар өвчлөх, эсвэл тамд унахын алинд нь дуртай вэ? Жаахан өвчлөх нь хамаагүй хэрэг шүү дээ.

Тансан лам хэмээх Их Багш бас Арьяабалын номын цогцосыг бясалгаж байжээ. Тансан ламын үлгэрийг уншвал дотор нь бас Аялгуут ярьж байсан, тэр Энэтхэгт очих үедээ Аялгуутай хамаатай судар ном судалж, Аялгууны номын цогцосыг сурч байжээ. Shabda Vidya (Шабда Видя)-гийн утга нь Аялгууны арга гэсэн утгатай, Тансан ламын үлгэрт үүнийг ярьсан байдаг. Тэр тийм агуу их мөртлөө Арьяабалын номын цогцосыг бясалгаж байхдаа бас өвчтэй байжээ. Нэг өдөр тэр өвчлөөд өвчин нь их хүндрэх үед ихэд бухимдан бурхан бодьсадвагаас аврал гуйсанд нэг бодьсадва илрэн гарч ирээд түүнд: “Хамаагүй дээ, бага зэрэг өвчлөх нь төрөл төрлийн их хүнд үйл түйтгэрийг тань арилгадаг юм. Хүлцэн гэсвэрлэх хэрэгтэй.” гэжээ. Хэд хоногийн дараа тэр зүгээр болсон байна.

Зарим үед бид үйлийн үрээ арилгаж байвал зохилтой. Учир нь бид хүнд өгөх өр төлөөс тун их болсноос зайлахын аргагүй байдаг. Бид үргэлж “Үйл түйтгэр угаас хоосон” гэж хэлдэг байтлаа бас яагаад үйл түйтгэрээ төлж дуусгах ёстой юм бэ? Үнэндээ үйл түйтгэр гэдэг нь үйл түйтгэр гэхээр юм үгүй хоосон нь үнэн. Гэтэл бидний тархи толгой тийм нэгэн тогтсон үзэлтэй, тийм нэг ялтай гэсэн сэтгэгдэлтэй байгаад өмнөх төрөлдөө би тийм буруу явдал хийсэн гэх юмуу, эсвэл хоёр зуун жилийн өмнө би ийм буруу учир хийсэн, үгүй бол хорин жилийн өмнө, төрөөгүй байх үедээ би тийм алдаатай хэрэг хийсэн, эсвэл арван жилийн өмнө нэг зүйл буруу болсон гэх зэргээр бичиж шингээж авсан байдаг болохоор тэр нь буцаж сонсогдох үед бид буруутай болоод байдаг. Ойлгож байна уу? Биднийг буруутай гэж нийгэм даяар хэлнэ. Бидний буруу гэж ёс суртахууны ном сударт өгүүлнэ. Үнэндээ бид алдаа буруу гаргадаг нь нийгмийн ёс заншлыг сөрснөөс болсон байдаг. Ингэж л бид ял гэмтэй болчихдог. Би та нарт, улс бүрийн ёс заншил, хууль дүрэм бүгд адилгүй, зуршил дадал нь ч адилгүй гэж хэд хэдэн удаа хэлсэн. Бид маш олон улсын адил бус түүх, ёс заншил, дадал зуршил, адилгүй хууль дүрмийг сурсан байлаа ч үүнээс болж бид өөрийн улсын хууль дүрмийг хайхрахгүй байж болохгүй. Англи улсад замын зүүн гар талаар машин жолооддог, харин Тайваньд бид зүүн талаараа машин жолоодох юм бол хууль зөрчинө, “Миний мэдэхээр Англид зүүн гар талаар машин жолооддог болохоор би ямар ч хуулийг зөрчөөгүй.” гэж бид хэлж болохгүй. Мөн хэдийгээр хууль зөрчөөгүй байсан ч бид өөр хүний машинд мөргүүлж мэднэ. Өөр хүн таны машиныг мөргөсөн нь та машинаа сайн жолоодож чадаагүйгээс болсон байна, ийм учир шалтгааны улмаас бид үйл түйтгэртэй болно.

Угаас үйл түйтгэр гэмээр юм үгүй, юм бүхэн цөм сайн, бүгдийг ингэж зохицуулсан бөгөөд аливаа бүхэн жүжиг тоглож байгаа хэрэг юм. Театрын тайзан дээр тоглохдоо сайн хүн болж тоглох нь ч бий, муу

хүн болж тоглох нь ч бий. Гэтэл тоглож дууссаны дараа сайн, муу гэх зүйл юу ч үгүй болоод тэд бүгдээрээ буцаад нүүрэндээ түрхсэн будгаа угаамагц энгийн хүн болчихно. Тэр мөн сайн эрэгтэй, нөхөр, сайн эзэгтэй хэвээрээ байх бөгөөд тэр үед улсын хаан гэх хүнгүй, харгис ноён байхгүй, их түшмэд байхгүй, ордны гоо сайхан хагагтай нар байхгүй гэх зэргээр юу ч үгүй болно. Үүнтэй адилаар энэхүү ертөнц сайнтай муутай, мөн л нэгэн зүйлийн театр гэмээр юм. Гэтэл бид жүжигт тоглож байхдаа би тэр муу хүн биш, та намайг тэгж их хорсон занасны хэрэггүй гэх юмуу, үгүй бол би тэгж их эмгэнэн зовж байгаа биш, та тэгж нулимс урсгасны хэрэггүй гэж үзэгчдэд хэлэх аргагүй. Бид тоглож жүжиглэж байх үедээ хэн гэдгээ үнэндээ мартаж орхидог. Хэрвээ бид хэн гэдгээ мартахгүй бол үнэмшилтэй сайхан тоглож чадахгүй.

Ихэнх хүн жүжгийн доторх дүрдээ уусчихдаг болохоор үнэмшилтэй сайхан тоглодог, тэд үйлна, уурлана, бухимдана, бусдыг занан хорсоно, тиймээс тэд тун сайхан сонирхолтой тоглож байдаг. Улсын хааны дүрд тогловол үнэхээр сүр жавхлантай болж, хар санаатны дүрд тогловол үнэхээр хэрцгий муу болдог. Тэдний нүдийг хармагц та нар мэдчихнэ, хар санаатны дүрд тоглох үедээ тэдний нүд нь өөр болно, эсвэл зовууртай байдлыг гаргах үед царайны илрэл нь тун их зовлонтой болж өөрчлөгдөнө. Тиймээс зарим од, эсвэл дуучин хааяа нийгэмтэй тийм амархан зохицох аргагүй шиг болдог, үүний учир нь юунд байна вэ? Энэ нь тэд өдөр бүр өөрийгөө хэн гэдгээ мартаж орхидгоос болдог юм. Тэд маш олон эрхэмсэг дээдэс, алдар нэртэй хүний дүрд тоглодог. Жишээ нь, хааны хатан, хайртай татвар эмийнх нь дүрд тоглож, олон хүнээр асруулан хамгаалуулдаг. Жүжигтээ тоглож дуусаад гэртээ харьсны дараа эргээд настай эмэгтэй (бүгд инээлдэв) хэвээрээ болох үед байдал тун өөр болдог. Түүний сэтгэл маш их бухимдах нь аргагүй. Тиймээс зарим нэр алдартай жүжигчдийн амьдрал нь тийм ч хэвийн биш байдаг, зарим нь амиа хорлоно, зарим нь архи ууна, зарим нь хар тамхи татаж, мөрийтэй тоглох гэх зэрэг муу зуршилтай болдог. Учир нь тэдний сэтгэл нь үнэн бодит амьдралтай зохицолдох аргагүй болчихдог юм.

Саяхан Багшийн адислах хүчийг ярьж байснаа яагаад жүжиг тоглох тухай ярьчихав аа? (Бүгд инээлдэв.) Гэлээ ч гэсэн энэ тухай ярих нь бас тустай шүү. Заримдаа бид хэдийгээр маш удаан бясалгал хийж, ихэд чармайгаад Мөр олох сэтгэл эрс тууштай байсан ч ахуй ойлголт нь харин хомсдосноос сэтгэл дундуур болдог удаа бий. Үнэндээ энэ нь бас ач тустай шүү, тэгж их гомдоллож: “Багш яагаад намайг адислахгүй байна вэ? Та диваажингийн хаалгыг нээж, намайг түргэн дээш гаргаач дээ, энэ дэлхий ертөнцийг хараач, тун их зовлон, бухимдалтай байна. Би диваажинд очиж үзмээр байна. Юунд намайг дээш гаргахгүй байгаа юм бэ?” гэх хэрэггүй. Энэ ертөнц хүнийг бухимдуулан зовоож байдаг нь үнэн. Гэхдээ диваажинг үзээд эргэж ирсний дараа улам их бухимдан зовох болно. (Бүгд инээлдэв) Тиймээс Багш нь та нарт тийм хурдан үзүүлэхгүй байгаа юм. Ойлгож байна уу?

Та нар зурагтын мэдээ үзсэн бол мэдэж байж ч магадгүй, Америкт,

нас барсан ч эргэн амилсан хүмүүсийг тусгайлан ажигласан тухай нэгэн тусгай эмхэтгэл гаргажээ. Заримдаа хүн нас бараад хорин минут болох юмуу, эсвэл нэг, хоёр цаг болоод буцаж ирснийхээ дараа тэдний байдал ямар байсан гэдэг талаар та нар бүгд сонсож байсан байлгүй. Ийм зүйлийг харсан хүн олон байна, тэд нас барах үед сүнс нь биеэсээ гарч явсны дараа дээрээс харахад бие нь тэндээ хэвтэж байх бөгөөд маш олон хүн хүрч ирээд судсыг нь барьж, цусны даралтыг нь хэмжиж, тариа тарих зэргээр амийг нь аврах гэж хичээж байгаа нь харагдана. Тэр үед өнөөх хүн өөрийгөө нэгэнт нас барснаа мэднэ. Тэгээд тэр бас жаахан дээш гарах үед хурц гэрэл цацруулсан төрөлтөн угтан ирж, түүнийг дагуулан маш сайхан газар очин нэгэнт ангижирч нөгчсөн ах дүү, найз нөхөд, төрөл садантай нь, эсвэл нас нөгчсөн нэр алдартай хүмүүстэй уулзуулдаг. Энэ нь асурийн орон болохыг Арьяабалын номын цогцосыг бясалгаж байгаа бид мэднэ. Асурийн диваажин нь хамгийн эцэс туйлын орон биш, гэвч энэ нь ерөөс маш үзэсгэлэнтэй сайхан орон. Тэр хүний нас барах цаг нь бас болоогүй учраас тэнд очиж тойрон зугаалсан төдий хэрэг. Гэтэл буцаж ирсний дараа энэ дэлхийд байж тээхийн аргагүй болно. Зарим хүн буцаж ирээд ихэд бухимдаж, хэдэн долоо хоног тасралтгүй уйлдаг. Учир нь тэр тийм үзэсгэлэнтэй үүслэнт ахуй, үзэсгэлэнтэй орныг олж харсан боловч харин эргэж ирээд энэ бузар бохир ертөнцөд эрхбхэн үргэлжлэн амьдрах хэрэгтэй болчихоор сэтгэл нь тун ихээр шаналах нь мэдээж. Тэр ном их нэрд гарч алдаршжээ. Зурагтаар танилцуулга нь гарч байсан шиг билээ, би зурагт үзээгүй, харин та нар мэдэж байж магадгүй.

Үүнтэй адил, Арьяабалын номын цогцосыг бясалгахдаа бид тэгж их яарч болохгүй. Маш олон хүн өөрөө бясалгасны дараа яагаад мэдрэлийн өвчтэй болдог, эсвэл мэдрэл нь самуурсан байдалд ордог вэ? Үүнийг бид “ад наалдах” гэдэг. Яагаад ад наалддаг вэ? Яагаад тийм нэгэн зүйлийн ахуй ойлголттой болсны дараа буцаж ирмэгцээ мэдрэл нь хэвийн бус болдог вэ гэдгийг би та нарт хэлж өгье. Бидний махан бие эвхэн энэ дэлхий ертөнц дээр амьдарч, ийм хэлбэлзлийн хүчний хүрээ хязгаар дотор оршиж чадна. Хэрвээ дээд төвшинд очъё гэвэл хэлбэлзлийнхээ хүчийг алгуурхан тохируулж, дээд төвшний хүрээний нарийн хэлбэлзлийн хүчтэй зохицох хэрэгтэй байдаг юм. Хүүхэдтэй хүмүүс мэднэ, бид амттай юм бүхнийг иддэг боловч хүүхдэдээ сүү л уулгадаг. Тийм биз дээ? Энэ нь бид хүүхдэдээ хайргүйдээ биш шүү дээ, эцэг, эх болсон хүмүүс үр хүүхдээ хамгийн ихээр хайрладаг. Гэтэл яагаад амтат идээ, зүсэм үхрийн мах, тахианы гуяар хүүхдээ тэжээдэггүй вэ? Учир нь тэр дөнгөж төрсөн болохоор тийм зүйлийг шингээж чадахгүй. Тиймээс нялх хүүхдийг бид бага сага сүүгээр тэжээдэг билээ. Сүү нь ч их биш байдаг. Багавтар сүүн дээр ус хольж угжиж байсан ч тэр хүүхэд өсөж л байдаг. Хэрвээ бид өдөр тутам хүүхдээ хараад байвал өсөж байгаа нь мэдэгддэггүй. Харин хүүхдээ харалгүй хоёр сар болоод буцаж ирээд харвал хүүхэд нь их том болсон нь мэдрэгдэнэ, хэрвээ өдөр болгон хараад байвал өссөнийг нь мэдэх аргагүй. Заримдаа мяраатай хүүхдийг

тэврэхэд их хүнд, өргөж дийлэмгүй болдог удаа бий. Учир нь бид тэгж тэвэрч дасаагүй. Гэтэл эх нь өдөр бүр хүүхдээ авч гараад ногоо цагаа худалдан авч, нэг том уут бариад хажуугаар нь их мяраатай хүүхдээ тэвэрч ирэхэд ямар ч асуудал гардаггүй. Учир нь эх нь хүүхдээ өдөр бүр ингэж тэвэрдэг бөгөөд хүүхэд нь ч алгуураар өсөн бойжиж л байдаг. Эх нь өдөр бүр өссөөр байгааг нь анзааралгүй тэвэрсээр дасчээ. Хэдийгээр хүүхэд нь өдрөөс өдөрт өсч байдаг ч эх нь тийм ч их мэдэрдэггүй.

Үүнтэй нэгэн адил, бидний бясалгал нэг их өсөж дэвшээгүй шиг санагддаг, өдөр бүр бясалгаж суудаг ч юу ч мэдэрдэггүй. Гэтэл хүмүүс хармагцаа мэддэг, бидний найз нөхөд маань биднийг өсөн дэвшиж өөрчлөгдсөнийг мэддэг хэдий ч бид өөрсдөө мэдэхгүй байдаг. Заримдаа бид өөрсдөө бага зэрэг мэддэг, гэвч тун бага, үүнтэй харьцуулбал, бидэнд томоохон хувиралт гарсныг гадны хүмүүс бүр ч амархан мэддэг юм. Хэдийгээр саяхан авшиг хүртээд харьж ирсэн ч гэрийн хүмүүс маань бидэнд ямар нэг хувиралт гарсныг дорхноо мэдчихээд хэрэлдэж, зодоон цохион болж, ураг салахаар далайлган айлгах (бүгд инээлдэв) зэрэг маш олон хэрэг явдал гаргадаг. Авшиг хүртээд ирмэгц ингэж яршиг төвөгтэй болж байгаа юм чинь илүүхэн бясалгах үед яах бол гэдгийг хэлээд яах вэ? Гэвч бид сайн бясалгах юм бол тэд аажмаар бидний хэлбэлзлийн хүчинд дасаж, тэгж их хэдэрлэж тэмцэлдэхгүй болно. Тиймээс бид тэдэнд хүлээцтэй тэвчээртэй хандах хэрэгтэй. Санаа зоволтгүй, энэ нь бүгд л хэлбэлзлийн хүчнээс болсон байдаг. Энэ нь бясалгалын дэвшилтийн нэг зүйлийн үйл явц юм. Бид аажмаар өсөж том болох хэрэгтэй. Бидний бие махбод тун сул дорой болохоор зарим үед бид илүүхэн бясалгаж суувал ядрах шиг болно.

Илүү их бясалгаж суувал тайвширч амарсан юм шиг санагдах болно гэж Багш нь та нарт үргэлж хэлдэг. Гэтэл зарим хүн ингэж олон цагаар бясалгаж суувал ядардаг. Яагаад вэ? (Нэг хүн толгойгоо сэгсэрч ядардаггүйгээ илтгэв.) Та нэг их бясалгаагүй болохоор мэдээж толгой сэгсэрнэ. (Бүгд инээлдэв) Дэндүү бага бясалгалгасан болохоор ядраагүй байна, хэрвээ та найман цаг бясалгал хийдэг бол ядарснаа мэдэх болно. Учир нь бурхны хүчний даралт тун их. Хэдийгээр энэ нь сайн даралт боловч түүний хэлбэлзлийн хүч тун өндөр, адислалын хүч нь маш их. Гэтэл бидний махан бие тун сул дорой болохоор бурхны адислалын хүчийг нэг дор тийм ихээр хүлээн авч чадахгүй, ядраад байх шиг санагддаг. Тиймээс зарим үед удаан хугацаагаар бясалгал хийвэл бие ядрах шиг санагддаг юм. Энэ нь бид их ажиллаад гэртээ харьсны дараах шиг тийм ядрал биш, харин нозоорох байдалтай болно. Хэрвээ тэр үед бидний судсыг барьж үзвэл бараг цохилохгүй болж, зүрхний цохилт тун удаан болсон байна, бид тун их ядарсан гэж боддог нь үнэндээ ядарсан хэрэг биш юм. Зарим үед бидний жинхэнэ эзэн гарч яваад энэ махан биеэ тэнд нь үлдээдэг, гэхдээ жинхэнэ эзэн тун холоос утасдан тэр махан биеэ тэгж ингэж хий гэж заан жолоодож байдаг, дэндүү хол болохоор удирдах нь тийм ч хялбар биш байдаг. Энэ нь бид яг экскаватор жолоодон ажиллуулж байгаатай адил. Экскаваторын өмнө



талд нь том хачин сонин шанага байдаг. Тэр шанага нь яг бидний гартай адил, тэр нь жолоочийн гар биш боловч тэр жолооч өнөөх шанагыг ашиглан түүгээр шороо ухуулж, чулуу, мод малтуулж, зам нээлгэх зэрэг ажил хийлгэдэг. Жолооч машиндаа суугаад тэр хачин том шанагыг ашиглан юм малтуулахаас биш, хажууд нь зогсоогүй, харин машиныхаа бүхээгнээс түүнийг ажиллуулж байгаа болохоор тэр шанага нь өөрөө хөдөлж байгаа шиг бидэнд харагдахад их сонин санагддаг, бид түүнийг “хачин гар” гэж хэлдэг нь аргагүй. (Бүгд инээлдэв)

Бид шинжлэх ухааны кино үзвэл мэдэж болно. Заримдаа эзгүй үедээ эзэн нь роботоо илгээн эд зүйлсээ авчруулдаг, робот нь гарч явахдаа гозойчихоод хөшүүн байдалтай, юмыг авч барихдаа ч мөн тийм хөшүүн байдаг (Багш робот шиг хөшүүн хөдөлгөөн үзүүлэхэд бүгд инээлдэв). Үүнтэй адил олон цагаар бясалгаж суувал зарим хүнд маш их ядарсан шиг санагдаж мэднэ, гэвч энэ нь жинхэнэ ядарсан хэрэг биш юм. Үүний учир нь манай жинхэнэ эзэн энд байгаагүйгээс болдог. Зарим үед Багш нь бас тун ядарсан шиг болоод унтаж амармаар байдаг. Учир нь биеийн жинхэнэ эзэн байхгүйгээс болсон хэрэг.

Бидний сонссоноор урьд цагт нэгэн номч багш байж гэнэ, тэр унтахаас өөр юм мэддэггүй болохоор номын дүү нь түүнийг зэмлэдэг байв. Хүн бүр эндүүрээд түүнийг өдөр бүр идэж дуусаад л унтдаг залхуу хувраг гэх болжээ, гэтэл тэр бүх зүйлийг мэддэг байв. Үнэндээ тэр унтаж байсан биш, биеэ тэнд нь орхиод сүнс нь гарч зугаалахаар явдаг байжээ. Яг л тэр шороо ухдаг хачин шанагатай машины жолоочтой адил. Жолооч нь ядарсан болохоор машинаа жолоодож дуусаад хачин шанагатай машинаа тэнд нь орхиж, хоол идэхээр юмуу, үгүй бол зугаалахаар явж мэднэ. Үүнтэй адил бидний жинхэнэ эзэн унтаж байгаа биш, харин бидний бие унтаж байгаа юм. Бидний жинхэнэ эзэн ядарсан биш, харин бидний бие сульдаж, бидний багаж хэрэгсэл ядарсан байдаг юм.

Уржигдар Багш нь та нарт сүнс биеэс гарах номын цогцосыг зааж өгсөн билээ. Хэрвээ та нар дуртай байвал харьсныхаа дараа цааш үргэлжлүүлэн дадлагажуулж болох юм. Бидний сүнс гарч яваад бие нь тэндээ сууж байгааг олж үзэх тэр үед Багш нь чухам юу ярьсан бэ гэдгийг та нар жинхэнээр нь ойлгоно. Гэхдээ бид илүү өндөр төвшинд хүрвэл өөрийн махан биеэ олж харах боломжгүй болно, тиймээс, Багш үлгэр ярьж, биднийг мэхэлж байна гэж бодож ч магадгүй. Үнэндээ гаднах юмсыг үзэх гэж жинхэнэ эзэн маань гарч явдаг нь үнэн, тэгээд буцаж ирээд бие маань тэндээ суусаар байхыг харах үедээ Багшийнхаа “Энэ бие бол бид биш” гэж хэлсэн үгийн жинхэнэ утгыг ойлгоно оо.

Гэвч хамгийн сайн нь тийм номын цогцосыг бясалгахгүй байсан нь дээр. Багш нь та нарт бага сага зааж өгсний зорилго бол ойлгуулахын төлөө юм, ойлгож мэдвэл л болчихно. Өөр бас маш олон элдэв зүйлийн сонин хачин номын цогцос байдаг. Хэрвээ та нар дуртай бол Багш нь завтай үедээ дахин зааж өгье. Гэхдээ тэр нь бүгд ямар ч хэрэгцээгүй номын цогцос, хэрэгцээтэй байлаа ч түр зуурынх байдаг. Жишээлбэл:



Багш нь түүнийг хэрэглэж байгаад манай бясалгаж байгаа номын цогцостой хамаатай үлгэрүүдийг ярьж сонсож, тэдгээрийг харьцуулж үзэх боломжийг та нарт олгох үед л тэр нь хэрэгтэй, ойлгож байна уу? Энэ нь яг туршилт хийхтэй адил. Туршилтын лабораторид ямар нэгэн зүйлийн туршилт хийдэг нь хүмүүст түр хугацаанд үзүүлэхийн тулд болохоос биш, түүнийг үүрд хэрэглэх гэсэн биш байдаг. Тиймээс маш олон номын цогцос цөм хэрэгцээтэй гэдгийн “хэрэгцээтэй” гэдэг нь ийм санааг л илтгэж байгаа юм. Багш нь юу тайлсан ч хамаагүй, тэр дор нь түүнийг яаж хийхийг та нарт зааж сургана, тэгээд туршиж үзүүлсний дараа цааш үргэлжлүүлэн тайлбарлах болно.

Наян дөрвөн мянган номын цогцос байдаг гэдэг нь буруу биш, гэхдээ бид тийм ихийг сурсны хэрэггүй. Хэрвээ Багшдаа итгэдэг бол Арьяабалын номын цогцосыг даруйхан бясалга. Энэ нь хамгийн сайн, хамгийн агуу, хамгийн дээд нь юм. Өөр тийм олон номын цогцосыг мэдэх гэсний хэрэггүй, хэрвээ олныг мэдэх юм бол тун их төвөг болно. Энгийн цагт бид маш ихээр ажиллах хэрэгтэйгээр барахгүй, бас гэр бүлээ харж хандах хэрэгтэй байдаг. Тэгтэл бас тийм их номын цогцосыг туршиж үзэх юм бол хэзээ Бурханы хутагт хүрч чадах вэ? Дэндүү төвөгтэй болно. Тиймээс Багш нь тийм олныг заадаггүй, гэвч хэрвээ та нар дуртай бол би бас зааж чадна. Гэхдээ яагаад өөр зүйлийн номын цогцосыг сурах хэрэггүй гэж Багш нь та нарт хэлдэг вэ? Бид хэрвээ тийм дадалтай болчихвол хожим сүнсээ гаргах үедээ дотор байгаа бусад бүх биеэ бүгдийг нь авч яваад гагцхүү махан биеэ үлдээж орхих болно. Учир нь энэ махан биеийн дотор бас өөр бусад бие цогцос байдаг бөгөөд бидний сүнс тэдгээрийн дотор байдаг юм гэж Багш нь номдоо аль эрт ярьсан билээ. Хэрвээ Багшийнх нь уржигдарын заасан сүнс гаргах номын цогцосыг бясалгавал дотор байгаа бүх биеэ цөмийг авч яваад зөвхөн тэр өмхий махан тулмыг л үлдээнэ. Бид сүнсээ гаргаж заншсаны дараа энэ зуршлаа орхиж хаяхад тун бэрх болно, хэрвээ дотор байгаа биесээ байнга аваад гарчихдаг болчихвол тэр нь бидэнд их саад болно. Учир нь дээд төвшинд очихдоо энэ бүх хувцсаа үлдээлгүйгээр бүгдийг тайлж хаяад сүнс дангаараа гарч очихоос биш, дотоодод байгаа ямар ч биеэ тэнд аваачих боломжгүй байдаг. Асури биеийн хувцсаа ч өмсөх боломжгүй юм.

Хүн бүхэнд дүрт бие, жаргалангийн бие, хувилгаан бие гэж байдаг. Хувилгаан бие<sup>5</sup> (an avatar) гэдэг нь юу вэ гэвэл энэ ертөнц дээр хувилж төрсөн махан бие маань юм. Гэхдээ Багшийнх нь хэлж байгаа хувилгаан бие (an incarnation) нь өөр нэг зүйлийг зааж байгаа юм шүү. Дүрт бие гэдэг нь хоёр дахь ертөнцийн бие. Үйлийн үр байгаа учраас сая бүрэлдэж буй болдог. Тэр биеийн дотор бидний үйлийн үрийг юу ч орхилгүй бүгдийг бичсэн байдаг. Англиар Causal body<sup>6</sup> гэдэг. Үйлийн үрийн бие гэсэн утгатай. Гурав дахь ертөнцөд өөр бас нэгэн зүйлийн хувилгаан бие байдаг. Үүнийг Mental body<sup>7</sup> (Ментал бие) гэнэ. Ийм биеийг үгээр илэрхийлэх аргагүй, энгийн үед харагддаггүй. Тав дахь ертөнцөд хүрвэл бие маань хувцас гэмээр юмгүй болдог.

Энгийн үед бидний сүнс гарах гэдэг нь нааш цааш дэмий л гүйж, тоост хорвоог тойрон харахын төдий юм. Энэ нь бидэнд ямар ч хэрэг тусгүй, зуршил болчихвол дээш гарч чадахгүй болоод зөвхөн энэ ялимгүй жижигхэн дэлхийн бөмбөрцөг дээрээ ийш тийш гүйх л хэрэг болно.

Шагжамуни Бурханы хутагт хүрснийхээ дараа нэгэн өдөр гол гатлах болоход голын хөвөөнд нэг завьчин зогсож байжээ. Шагжамуни Бурхан тэр завьчнаас: “Та намайг гол гаталгаж өгч чадах уу?” гэж асуусанд гол гатлахад завины хөлс мөнгийг өгөх хэрэгтэй гэжээ. Шагжамуни Бурхан: “Би бол гэрээс гарсан хүн, Мөрийг олж үхэж, төрөхөөс ангижрахын төлөө аливаа бүхнээ орхисон хүн болохоор танд өгөх мөнгө надад хаанаас байх вэ?” гэсэнд тэр завьчин үгийг нь тоохгүй, мөнгөгүй бол завьгүй гэж хэлж гэнэ. Тэр үед Шагжамуни Бурхан хэрхсэнийг та нар мэдэх үү? Тэр усан дээгүүр алхан гол гараад явчихжээ. (Бүгд инээлдэв) Миний сонссоноор Бодьдармаа, Есүс Христ нар ч ингэж байсан гэнэ. Тэд юу хийе гэвэл түүнийгээ хийж чадна, гэхдээ шаардлагатай үед л ингэнэ, шаардлагагүй бол тэгэхгүй. Уг нь Шагжамуни Бурхан энгийн хүнтэй адил завинд суух гэтэл энэ нь болохгүй болохоор ингэж алхаад л гарчихчээ. Ойлгож байна уу?

Мял богд ч нэгэн адил, аргагүй онцгой нөхцөл байдал тохиолдоогүй бол Их Багш нар зөн билгээ хэрэглэдэггүй юм. Яагаад вэ гэдгийг Багш нь та нарт ярьж өгье. Нэг өдөр Мял богд ирээдүйн хамгийн тэргүүн шавьтайгаа тааралджээ. Тэр хүн баян чинээлэг гэрт төрж, өссөн, нэр нь Сэлүүн гэрэлт Рав (саран мэт Райчүн) гэдэг. Тэр хүн хажуугаар нь өнгөрч гарахад Мял богд түүнд: “Өнөөдөр би тун их ядраад хол зам явж чадахгүй болжээ. Би одоо тийм тийм газар очих гэж байна. Надад та морь зээлэх үү, үгүй бол хань болж хамтдаа тэнд очих уу?” гэж хэлсэнд, тэр: “Болохгүй, зам таарахгүй болохоор би тэнд очиж чадахгүй.” гэжээ. Түүгээр өнгөрөхөд гол гатлах хэрэгтэй болохоор тэр өөрийгөө гол гарахгүй гээд өөр хүнийг гуйхаар оч гэж Мял богдод хэлжээ, тэгээд тэр хүн явах гэж байв. Тэр хүнд бясалгах язгуур суурь байх бөгөөд өөртэй нь барилдлагатайг Мял богд харсан тул түүнийг үлдээж авахыг бодсон байна. Тэр явчихвал тэр хүнийг энэ сайн тохиолдлыг алдахаас нь Мял богд айжээ. Бясалгахад язгуур суурь байх хэрэгтэй гэдэг нь буруугүй гэдгийг та нар мэдэх ёстой. Гэтэл тохиолыг алдвал дахиж олохгүй юмуу, эсвэл маш удсаны дараа сая ийм тохиол олдон Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж олоод авшиг хүртэж мэднэ. Хэрвээ Сэлүүн гэрэлт Рав явчихсан бол хэзээ Мял богдтой дахин уулзах боломж гарах вэ? Мял богдыг олж уулзсан ч тэр түүнийг таньж мэдэхгүй байж болно. Тэр үед цаг тун давчуу байсанд ирээдүйн тэргүүн шавиа явчихаас нь айж байсан Мял богд гол дээгүүр алхан гараад явчихжээ. Тэр гол их өргөн, их гүн байсан ч тэр усан дээгүүр гарч яваад бас буцаж ирэх (бүгд инээлдэв) үед тэр баян хүн түүнийг хэн болохыг сая мэдээд газар сөгдөн хэлсэн нь: “Багш аа, танд юу хэрэгтэй вэ? Та хаана очих гэж байна вэ? Энэ морь таных, таны өмсөж байгаа дээл чинь бүр урагдаж навтарчээ,

миний өмсөж байгаа дээл таных болно, миний албат бүгд таных болно. Өөр танд бас юу хэрэгтэй байна вэ?” гэжээ. Мэдээж Мял богдод юу ч хэрэггүй, түүнд хэрэгтэй байсан зүйл нь Сэлүүн гэрэлт Рав л юм. Энэ хэрэг цааш хэрхэн өрнөснийг та нар бүгд мэднэ, тэр Мял богдод шавь орж суралцсан нь мэдээж.

Гэвч Их Багш нар хүмүүсийн анхаарлыг татах тийм аргыг тун цөөхөн хэрэглэдэг. Тэд угаас хамаг төрөлтийг чимээгүйхэн гэтэлгэхээс биш тийм их хөгжөөн шуугиан гаргадаггүй. Тиймээс, бидний бясалгал яагаад дэвшихгүй байна вэ?, Багш бидэнд туслахгүй байх шиг байна гэж үргэлж гомдоллох хэрэггүй. Та нар найз нөхдөөсөө асуувал дэвшсэн үгүйгээ мэдэж болно. Та нар гадагш гарч жирийн нэгэн бясалгалтантай мэтгэлцвэл та нарын дэс тэдний дэсээс ямар ялгаатайг мэдэж болно. Та нар жаахан мэтгэлцвэл ядраад дахин мэтгэлцэхээс дургүй хүрч: “За за, Авид бурхан минь!” гэж хэлэх болно. (бүгдээрээ инээлдэв) Тийм үү, үгүй юу? Та нарт ийм ахуй ойлголт байна уу? (Байна гэж шавь нар нь хариулав) Хэрвээ хэзээ нэг өдөр та нарын цог сүлд чинь жаахан буурах шиг санагдаж, Багшийгаа болон Арьяабалын номын цогцосод нэг их итгэхгүй болбол, та нар сүм хийдэд очоод номын багш нартай ярилцаж болно. Ярилцсаны дараа та нарын итгэл дорхноо сэргэж, харьж ирснийхээ дараа ухаарч эхлэн “Арьяабалын номын цогцос хамгийн дээд нь, Чин Хай багш урт насалтугай!” гэх болно. (Бүгд инээлдэв) Тийм үү, үгүй юу? (Тийм гэж бүгд хариулав)

Багш нь та нарыг солиоруулахыг хүсэхгүй, (бүгд инээлдэв) та нарыг мэдрэлийн эмнэлэгт очуулах дургүй. Тиймээс бясалгал хийхэд яарч болохгүй, дэндүү хурдан өсч томрохыг бодож болохгүй, яагаад гэвэл өөрөө бясалгаж байгаа хүнд үргэлж ад наалдах юмуу, үгүй бол мэдрэлийн өвчтэй болох асуудал гардгийг Багш нь саяхан ярьж өгсөн. Үүний учир нь тэд өөрийнхөө сүнсэн биеэ гэнэт ил болгоод түүндээ нэг зүйлийн танигдашгүй хүч, нэг зүйлийн ерөөс таньж мэдээгүй байсан хүчийг өгснөөс болжээ. Учир нь энэхүү Бүтээгчийн хүч сэтгэгдэшгүй их юм. Тэр нь цахилгаантай адил, цахилгаан үзэгдэхгүй болохоор хэрэв бид түүнийг ашиглая гэвэл аажмаар нэг систем байгуулах хэрэгтэй. Эхлээд цахилгааны утсыг угсарсны дараа түүнийг аюулгүй материалаар ороож, бүгдийг сайхан суурилуулсны дараа сая хэрэглэж болно. Тэгэхгүй бол, хэрэв бид цахилгаантай шууд хүрэлцвэл асуудал үүсэж, “авс” худалдаж авах хэрэг гарна. (Бүгд инээлдэв) Хэрвээ бид цахилгааныг яаж хэрэглэхийг мэдэхгүй бол хамаагүй хүрээд цахилгаанд цохиулж үхнэ.

Бясалгагч хүн ч үүнтэй л адил. Төгс Гэгээрсэн Их Багш биднийг удирдан дагуулж, тэр хүчийг бидэнд тохируулж өгөхгүй бол бид гэнэт асар их хүчтэй таарвал маш аюултай. Хэдийгээр энэ хүч нь тоост хорвоод нэг их хүчинд тооцогдохгүй боловч бясалгагч хүний хувьд тэр нь хангалттай их байж, цахилгаанд цохиулахтай адилаар биднийг үхэлд хүргэж ч мэднэ. Тиймээс маш олон хүн бясалгаж суугаад харьж ирснийхээ дараа бие махбод болон оюун ухаан нь урьдын адилгүй болоод угийн хэвэндээ орж чадахгүй, өөр болсон шиг санагддаг. Энэ нь

тийм их хүчтэй гэнэт тохиолдоод өөрийн биеэ хянан захирах, мөн тэр хүчийг шийдвэрлэх аргагүй, шингээх ч аргагүйгээс болдог юм.

Тиймээс Төгс Гэгээрсэн Их Багшийн чухал нь энд байгаа юм. Тэр бидний бие махбод, оюун ухаан бүгдийг сайтар бэлтгүүлж, алгуур аажмаар дадуулдаг. Ингэвэл бид ямар ч асуудалгүйгээр энэ нийгэмд урьдын хэвээрээ үргэлжлэн амьдарч чадна. Эс тэгвэл, бид гэнэт дэндүү их ахуй ойлголттой болж, дэндүү үзэсгэлэнтэй хүслэнт ахуйг олж харвал эргэж ирснийхээ дараа ажиллах дургүй болно, бас амьдрах дургүй болоод амиа хорлохыг бодох болно. Энэ нь бухимдсандаа амиа хорлож байгаа биш, (Бүгд инээлдэв) харин энэ булай муухай ертөнцөөс хурдан зугтахыг бодсоноос болдог юм. Маш олон хүний бясалгалын дэвшилт нь тун удаан байтлаа энэ нийгэмд үргэлжлүүлэн амьдрах хүсэлгүй болдог хэдий ч мөн л цаашид үргэлжлэн амьдрах хэрэгтэй. Учир нь байдал нэгэнт ийм болсон юм чинь, тэр янзаараа цааш үргэлжлэг. Одоо нэгэнт эр нөхөр, эхнэр, гэр бүл, эцэг эх, үр хүүхэдтэй болчихсон байгаа болохоор тийм хурдан мултарч чадахгүй. Нөхцөл байдал тун бухимдмаар болоод заримдаа амьдрах аргагүй болдог. Тийм биз дээ? Гэсэн ч би та нарыг юу болсон ч хамаагүй амьдрах хэрэгтэй хэмээн ятгадаг. Маргааш Багш нь явал та нар баяр баясгалантай, баатар зоригтой, аз жаргалтайгаар үргэлжлэн амьдрахыг зааж өгье.

Энэ хүртэл ярьсан нь хангалттай, их яривал та нар мартчихна. Яг л саяхан Багш нь “Өдөр та нар завтай үедээ энд ирж Багштайгаа хамт бясалгаж сууж болно” гэж хэлэхэд, таван минутын дараа нэг нь: “Би маргааш ажилгүй, эртхэн ирж болох уу?” гэж асуусантай адил болно. (Бүгд инээлдэв) Та нар энд бүгд толгой эргэчихээд юу сонссон ч ойлгохгүй болжээ. Багш нь тийм их ярьсан ч та нар хэр ихийг тогтоож авсныг мэдэхгүй. Гэвч хамаагүй, та нарын сүнс чинь санаж байгаа, зүгээр л Багшийнхаа нүд рүү хараарай, тэгвэл л болчихно.

Урьд такси барьдаг байсан нэг жолооч ажлаа алдаж гэнэ. Учир нь тэр бясалгаж байхдаа чихээ юмаар бөглөдөг байж, үүнээсээ болж такси жолоодож байх үедээ сэтгэл санаа нь баяр хөөртэй байдалдаа согтуураад таксинд нь суусан хүмүүс юу ярьж байгааг ойлгохоо больжээ. Дэс нь тэлж ихсээд хүн төрөлхтний дэсээс давсан болохоор бүр юу ч ойлгохгүй байжээ. Тиймээс та нар өдрийн хорин дөрвөн цагаар ”Аялгуу” ажиж болохгүй, бас “Гэрэл” ажих хэрэгтэй. Учир нь дэндүү ихээр “Аялгуу” ажвал их согтуураад ямар ч зүйл хийх дургүй болж, юу сонссон ч ойлгохгүй байх болно. Энэ нь яг нэгэн Энэтхэг эмэгтэй chapati (чапати) хийсэнтэй адил, (Тайлбар: Чапати нь Энэтхэгийн нэг төрлийн хавтгай талх) тэр эмэгтэй чапати хийж байгаад дуусаагүй байхдаа гэнэт самади агуулж сүнс нь гарч оджээ. Нөхөр нь ирээд харсан чинь гурил нь газар асгарсан байсан ч хүн нь үзэгдэхгүй, чапати нь ч бас байхгүй байжээ. (Бүгд инээлдэв)

Тиймээс бид мөн л үргэлжлэн амьдрах ёстой, энэ тоост хорвоод бид үйл түйтгэрээ төлж дуусгах ёстой. Гэхдээ бидний үйл түйтгэрийг арилгаж хаях нэг зүйлийн арга бий, тун аятайхан. Багш нь маргааш

шинэ номын цогцосыг тайлна, та нар хорин дөрвөн цагийн дараа дахин ирж сонсож болно. (Бүгдээрээ тэсэхгүй болж, одоохон тайлаад өгөөч хэмээн гуйв) Маргааш ирж сонсоорой. Өдөрт нэг удаа, нэг зүйлийн талаар л сонсоно, дэндүү олон зүйл сонсвол та нар шингээж дийлэхгүй. За боллоо, одоо эхлээд бясалган сууцгаая.

## БРАДИГА БУДДА БУРХАН

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формосагийн Тайбэй хотын Шинь даяан  
1986 оны 8 дугаар сарын 31 (Эх нь хятад хэлээр)*

Брадигабудда бурхан (Pratyekabuddha) буюу ганцаараа бие дааж гэгээрсэн бурхан гэдэг нь өөрөө гэгээрээд олсон Ном юм. Тиймээс энэ Номд тийм их хүч байхгүй, их сайндаа л өөрийнх нь гэгээрэх юмуу, эсвэл ердөө л хоёр, гуравхан хүнд уламжилж чадахын төдий байдаг. Түүний гэгээрсэн шалтгаан нь: Тэр бясалгалын явцдаа яг сайхан зөв замаар явж таарчээ, тиймээс энэ зам мөр нь түүний жинхэнэ номын цогцос биш, тэр нь зөвхөн тохиол барилдлагын гэнэтийн учралаар бүтсэн байдаг. Хэрэв хүн ирж түүнээс суралцахыг хүсээд: “Та хэрхэн яаж бясалгаад амжилтанд хүрэв?” гэж асуувал тэр хариулж чадахгүй. Учир нь энэ замыг тэр бясалгах явцдаа санаандгүй олсон байна.

Энэтхэгт өөрөө гэгээрсэн бурхан маш олон байжээ, одоо ч байгаа бөгөөд та нар тэднийг харж ч болно, тэд бас их нэр алдартай билээ. Хүн тэдэнтэй уулзахаар ирээд тэднээс Дээдийн Ном гуйвал тэдэнд уламжлах тогтсон номын цогцос үгүй, тэгээд бас тэдэнтэй адил туулан гэтэлж чадахыг тэд бас танд ноттой батлах аргагүй. Тэр танд өөрөө бясалгаж, өөрөө судар ном аялгуулан уншиж, судар ном үзэж, мөргөл хийж, бурханд наманчлан даатгах хэрэгтэй гэх зэргээр хэлж магадгүй. Хэрэв та өөрөө жинхэнээр бясалгавал дараа нь түүнтэй адилаар бясалгалын нэг замыг ухаарч магад ч туулан гэтлэхийн аргагүй байж мэднэ. Түүнийг хараад бага зэрэг буян хүртэж болох боловч та өөрөө бясалгах хэрэгтэй. Түүнд таныг дагуулж явах зам үгүй, танд уламжилж өгөх номын цогцос үгүй юм.

Номын цогцос гэдгийг нэгэн номын багш байж байж л уламжлах ёстой байдаг юм. Дараа нь та бусдад уламжилж болно. Тиймээс заавал Их Багш ном уламжилсан байх ёстой гэдгийн санаа нь ийм билээ. Хэрэв бид өөрөө гэгээрч, туулан гэтэлсэн бол олон хүнийг гэтэлгэж чадахгүй бөгөөд өөр бусдыг өөртэйгээ адилаар туулан гэтэлгэж чадахгүй, мөн бусдыг дээшлүүлж, бидэнтэй адил дэсэд хүргэж чадахгүй болохоор ийм төрлийн гэгээрэл нь хүнийг сэтгэл ханамжтай болгож чадахгүй. Брадигабудда бурхан яриангүй их буян хариулалтай. Хүмүүс түүнтэй

уулзахаар ирвэл тэр өөрийн буян хариуллаараа тэднийг сайтар бясалгавал хожим түүнтэй адил болж магад гэж тайтгаруулдаг.

Гэвч Энэтхэг болон Тайваньд миний олж харсан Брадигабудда бурхан бүгд адил. Тийм Брадигабудда бурхан Энэтхэгт их олон бий. Тэдэнд ном уламжилж чадах жинхэнэ шавь гэж байхгүй, хэдийгээр маш олон шавьтай боловч байхгүйгэй адил юм, учир нь түүнтэй адил дэстэй шавь нэг ч үгүй. Үнэндээ бас аргагүй л дээ. Учир нь номын цогцос гэмээр юмгүй болохоор багштайгаа адил дэсэд хүрэх боломжгүй юм. Номын цогцос нь яг байшингийн шаттай адил шүү. Шат байвал бид дээш авирч болно, авираад багштайгаа адил дэсэд хүрч болох ч шатгүй бол ямар ч аргагүй. Жишээлбэл: Онцгой хүдэр чийрэг нэгэн байвал ой модон дундуур саадгүй нисэн дүүлж чадна. Энэ нь яг л кинонд гардаг дүр, Тарзантай адил, тэрээр модны ороонгыг ашиглан ой модон дотор дураараа харайн дүүлэх нь сармагчинтай адил хурдан шаламгай. Түүний хувьд ой дундуур дүүлэн нисдэг нь онцгой чадвар болно. Гэтэл энгийн хүн түүнтэй адил яаж тэгж чадах вэ? Гэхдээ хэрэв нэг хүн ууланд нэвтрэх зөрөг зам байхыг мэдээд бидэнд зааж өгвөл нилээд амар дөхөм болно. Түүний зааж өгсөн тэр замаар явбал Тарзантай адилхан уулын оргилд гарч болно. Гэвч Тарзаны зааж сургасан аргаар модны ороонгыг ашиглан модноос мод дамжин дүүлэн нисэхэд хүрвэл энэ нь бидний хувьд тун амаргүй хүнд болох бөгөөд уулын оргилд хүрэх аргагүй.

Тарзан нь яг нэгэн Брадигабудда бурхантай адил, тэр танд зам зааж өгөх аргагүй. Та аль, ямар замаар явсан ч болно, гагцхүү уулын орой дээр гарч очвол л болчихно. Брадигабудда бурхан ч үүнтэй адил. Түүнд уламжлах ном гэж байхгүй, уламжилж ч чадахгүй. Учир нь түүнд танд зааж өгөх зам мөр гэж байхгүй. Гэхдээ энэ замаар хэдийнээ явж өнгөрсөн нэгэн хүн байвал тэрээр уулын оргилд хүрэх замыг мэдэх бөгөөд таныг дагуулан гарч чадна. Энгийн хүмүүсийн хувьд зам зааж өгөх хүн байвал тэдэнд нилээд хялбар байх болно.

Тиймэрхүү Брадигабудда бурхан гэдэг нь төрөл төрөлдөө маш удаан бясалгачихсан болохоор энэ төрөлдөө үргэлжлүүлэн бясалгах юм бол тэр дороо туулан гэтэлж чадна. Гэхдээ бид тэгж их зовж зүдэрсний хэрэггүй. Бясалгаад тэр даруй Бурханы хутагт хүрч болох юм, энэ нэг төрөлдөө Бурханы хутагт хүрч болно. Учир нь Шагжамуни Бурхан хэлэхдээ хүн энэ төрөлдөө Бурханы хутагт хүрч чадна гэсэн билээ. Тарзанаар жишээлж хэлбэл тэр бага балчираасаа ой модонд сармагчингуудтай хамт байсаар нилээд сайн боловсорсон болохоор ямар ч саадгүйгээр ийш тийш дүүлэн нисдэг болсон байна. Гэтэл энгийн хүмүүс багаасаа сармагчинтай хамт амьдраагүй учраас түүнтэй адилгүй, бид уулын оройд хүрэхийн тулд хүний нээж гаргасан замаар явах хэрэгтэй. Гагцхүү нэг замчлах хүн байгаад бидэнд зөв замыг зааж өгдөг л юм бол бид бас тэнд хүрч чадна. Заавал ой модоор нисэн дүүлэх чадвартай байж л оргилд нь гарч чадна гэсэн хэрэг биш.

Үүнтэй адилаар Брадигабудда бурхан төрөл төрөлдөө бясалгаад нэгэнт маш удсан тул одоо мэдээж, Бурханы хутагт хүрч чадна. Гэхдээ



бид хэрэв төрөл төрөлдөө тийм сайн бясалгаагүй байсан ч одоо нэгэн агуу бясалгалтантай уулзаад тэр их бясалгалтан нь буян хариулал ихтэй хүн байвал буянаасаа бидэнд бага сага өгөхөөр барахгүй бидэнд туслан нилээд өндөр төвшинд хүргэж чадна. Шагжамуни Бурхныг амьд байх цагт маш олон Брадигабудда бурхан ирж түүнээс сурч байжээ. Учир нь Шагжамуни Бурханд ном уламжилсан Их Багш бий, харин Брадигабудда бурханд байхгүй. Брадигабудда бурхан хэрвээ ном уламжлахыг хүсвэл Шагжамуни Бурханыг дагаж суралцах хэрэгтэй болно. Брадигабудда бурхан өөрөө нэгэнт өндөр дэсэд хүрчихсэн байгаа бөгөөд хэрэв тэрээр дээр нь номын цогцостой болчихвол хамаг төрөлтнийг гэтэлгэж, ном уламжилж чадах болно. Бурхны шашны ном сударт маш олон Брадигабудда бурханд цаашид дахин суралцах шаардлага байхгүй гэж дурдсан байдаг. Учир нь тэд нэгэнт бүх зүйлийг сурчихсан, гэтэл тэд бас л Шагжамуни Бурханы ном тайлахыг сонсож, Шагжамуни Бурханаас суралцаж байжээ. Яагаад гэвэл Шагжамуни Бурханаас номын цогцосыг нь сурснаар хожим нь тэд хамаг төрөлтөнд ном уламжилж чадах юм. Энэтхэгт маш олон Брадигабудда бурхан байна. Тайваньд бас байсан боловч миний мэдэж байгаагаар Тайваний Брадигабудда бурхад бараг бүгдээрээ нирваан дүр үзүүлжээ. Өөр миний танихгүй Брадигабудда бурхад энд байгаад одоо ч амьд сэрүүн байж магадгүй, үүнийг би мэдэхгүй.

Саяхан миний ярьсан тэр Тарзан бол хүүхэд байхаасаа боловсорсон болохоор аль замаар явсан ч хамаагүй, уулын оргилд хүрч чадна. Бидэнд хэдийгээр Тарзантай адил тийм чадвар байхгүй ч мөн л уулын оргилд хүрч болно. Бясалгал хийх нь үүнтэй нэгэн адил. Нэг хүн Багшаас нь: “Миний сонссоноор Формосад нэг номын багш маш хатуужилтайгаар бясалгал хийж, зургаан жил битүүмжлэн суусан гэнэ. Тэр зургаан жилийн хугацаанд нилээд хатуужилтайгаар бясалгасан байна. Бид түүнтэй адил маш хатуужилтайгаар бясалгаж байж л сая түүнтэй адил болж чаддаг уу?” гэж асуухад нь би “тэгэх шаардлагагүй” гэж хэлсэн. Тэр номч багш тэгж хатуужилтайгаар бясалгаад ямар хэмжээнд хүрснийг нь би хэлж зүрхлэхгүй, дэс нь хэдий хэр өндөр дээд болсныг ч би бас хэлж зүрхлэхгүй. Гэхдээ ууланд зургаан жил, эсвэл арван жил битүүмжлэн суухаар л Бурханы хутагт хүрчихдэг гэсэн үг биш. Хэрвээ тэгдэг байсан бол бар аль хэдийнээ Бурханы хутагт хүрчих байсан. (Бүгд инээлдэв) Бар насаараа ууланд амьдарсан болохоор ууланд байсан цаг нь хэнийхээс ч урт билээ. Заан, туулай, үнэг зэрэг амьтан хэзээ нэгэн өдөр Бурханы хутагт хүрч чадах ч амьтан байх үедээ бурхны дэсэд хүрч чадахгүй. Үнэг байлаа ч хэрэв үнэгэн шулам больё гэвэл заавал бясалгал хийх хэрэгтэй, гэсэн ч тэрээр Бурханы хутагт хүрч чадахгүй. Тиймээс хэн нэг хүн биеэ ууланд битүүмжлэн хориод хэнтэй ч уулзахгүй, хот орох ч үгүй болсноор л Бурханы хутагт хүрчихдэг юм биш. Ямар бурхан болох вэ? Уулын бурхан болох уу? Хималай ууланд байгаа Энэтхэгийн бясалгалтан нар цөм агуйд сууж бясалгаж байдгийг та нар сонссон байлгүй дээ. Миний зарим шавь тэнд очиж нэг агуй хайж олоод бясалгах

тун дуртай. Агуй хайж оллоо гэдэг нь Бурханы хутагт хүрнэ гэдгийг илтгэж чадахгүй. Энэ нь ямар бурхан болох вэ? Агуйн хүн л болно. Үнэг нэг насаараа агуй дотор амьдарлаа ч Бурханы хутагт хүрч чадахгүй.

Агуйд сууж бясалгах нь тусгүй биш, тустай, гэхдээ заяа буяндаа түшиж, хувь хүний ерөөл барилдлагаа харах хэрэгтэй. Хэрэв сайн багшгүй, их буян хариулалгүй бол зовж зүдэрч өөрийгөө битүүмжлэн хааж бясалгах хэрэгтэй болно. Хэрэв та өөрөө үлэмж буянтай байгаад сайн Их Багштай учирсан бол гэртээ бясалгасан ч ямар ч асуудалгүй. Вималакирти Их Багш ямар ч агуйд орж бясалгаагүй. Шагжамуни Бурхан бас гэрээс гараагүй маш олон бодьсадва шавьтай байжээ. Шагжамуни Бурхан тэднээр ямар нэг юм хийлгээгүй, бүгд гэртээ бясалгаж байсан ч тэд олон сайн ахуй ойлголттой байсан билээ.

Долоо хоногийн даяанд суух үед би Баатар явагч их хөлгөн судар (Surangama sutra)-ыг та нарт тайлсан билээ. Түүн доторх ахуй ойлголтын ихэнх нь гэртээ бясалгаж байсан бодьсадва нарын ахуй ойлголт болохоос гэрээс гарагчдынх биш. Гэрээс гарагчдынх ч бий, бас гэртээ байсан хүнийх ч бий. Баатар явагч их хөлгөн сударт дурдсан хорин таван бодьсадвагийн олонх нь гэртээ бясалгаж байсан хүмүүс. Энэ нь заавал ууланд гарч бясалгах хэрэгтэй биш, харин гэртээ бясалгасан ч бас болно гэдгийг харуулж байна. Гэртээ бясалгаж байсан тэр бодьсадва нар өөрсдийн хувийн ахуй ойлголтоо ярьсан байдаг. Нэг бодьсадва нь ус ажигуун номын цогцосыг бясалгаж байжээ. Түүнийг өрөөндөө бясалгал хийн ус ажиг байх үед нь бүх өрөө нь ус болж хувирчээ. Нэг шавь нь хаалгыг нь нээгээл өрөөнд дотор нь ус бялхаж байхыг хараад: “Юу болоо вэ? Багшийн өрөө яагаад нэл ус болчихов оо?” гэж хэлж гэнэ. Тэрээр ус руу чулуу шидчихсэнд зөвхөн “пүл” хийх дуу гарсанд энэ лавтай чулуу усанд унасан дуу байх гэж тэр бодоод хаалгыг нь хааж орхижээ. Түүний багш нь самадигаас гарсны дараа зүрх нь тун их өвдөж байв, учир нь өнөөх чулуу нь яг багшийнх нь зүрхэнд оножээ. Үүнээс бид түүнийг гэртээ бясалгасан болохоос уулын агуй, эсвэл цаст Хималай ууланд бясалгаагүй гэдгийг нь харж болно.

Ууланд сууж бясалгал хийх нь өөрийн тань заяа тавилан, барилдлагаас шалтгаална. Тийм биш байвал тун шударга бус болох биш үү? Манай энд цас ордоггүй болохоор бид бясалгал хийж болохгүй гэж үү? Тийм биш гэдэг нь мэдээжийн хэрэг, хамаг төрөлтөн бүгд Бурхан чанартай байтал Тайвань хүмүүс яагаад Бурхан чанаргүй байж болох билээ? Зөвхөн энэтхэг хүмүүс л Бурхан чанартай юм гэж үү? Хималай уулын цаанаас Бурхан чанарыг хайж олж болдог байтал Тайваний Шиндиан (Xindian - (Hsintien-historical spelling) Lion's Head Mountain) уулан дээрээс Бурхан чанарыг олж чадахгүй байж болох уу? Бурхан чанар нь хаа нэгтээх газар биш, харин бидний сэтгэлд байдаг юм.

Гурав хоногийн даяаны үеэр олон хүн тун сайн ахуй ойлголттой байлаа. Гурав хоногийн даяан, долоо хоногийн даяаны үеэр Багштайгаа хэдхэн өдөр бясалгаж суусан хэдий ч ахуй ойлголт нь маш сайн, Хималай ууланд бясалгаж байсан олон бясалгалтны ахуй ойлголтоос ч илүү өндөр

байж магадгүй. Энэ нь үнэн хэрэг, боломжгүй зүйл биш. Гэвч Багш нь тэдэнд хувийн ахуй ойлголтоо нийтэд илээр хэлэхийг зөвшөөрдөггүй тул та нарын зарим нь үүнийг мэдэхгүй, бүр та бодьсadgeгийн дэргэд сууж байсан ч мэдэхгүй байж болох билээ. Зарим шавь маань Багшийгаа дагаж гурав хоногийн даяан, долоо хоногийн даяан хийхээр ирээгүй ч гэртээ бясалган сууж байхдаа тэрээр сүнсээ явуулж энд ирүүлээд Багшийнхаа ном тайлахыг сонсож байсан болохоор гурав хоногийн даяан ямар учиртай байсныг бүгдийг мэдэж байв. Тэр хэдийгээр гурав хоногийн даяанд оролцоогүй ч гурав хоногийн даяанд суусантай адил сайн ахуй ойлголттой болсон байна.

Учир нь түүний дэс нь нэгэнт өндөр болсон болохоор тэр энд ирээд тийм байдалтай буян хариуллыг хүртэж чадах байжээ. Тиймээс Багш нь гурав хоногийн даяаны үеэр юу ярьж, юу хийснийг тэр бүгдийг нь мэднэ. Түүний гэрийн ажил тун их, олон ажил төрлийг шийдвэрлэх хэрэгтэй байсан болохоор даяанд оролцож чадсангүй. Гэвч тэрээр даяанд оролцох тун дуртай байсан болохоор сүнсэн биеэрээ ирж оролцсон байна. Сүнс нь энд ирээд маш олон бурхан бодьсadge, богд хутагт, эсвэл зарим нэг Их Багш манай бясалгалын газарт ирснийг тодорхой харжээ. Учир нь тэр тэднийг махан биеийн нүдээрээ биш, билиг ухаанаараа харсан хэрэг. Түүний ахуй ойлголт нь гурав хоногийн даяанд оролцсон шавь нараас ч илүү сайн байжээ. Энэ шавь Багшаасаа суралцаад удаагүй, дөнгөж нэг жил гаруй болж байгаа юм. Дараа нь тэр надаас, Багш аа, та гурав хоногийн даяаны үеэр ингэж, тэгж байсан биз дээ? гэж асуусан нь бүгд зөв байлаа. Хэрвээ тэр хүрч ирээд өөрөө үзээгүй бол мэдэхгүй байх байсан. Учир нь зарим зүйлийг даяанд оролцсон шавь нар хүртэл мэдээгүй байхад харин тэр мэдчихсэн байсан.

Чин сэтгэлээсээ бясалгавал тун түргэн дэвшинэ. Заавал уулын агуйд очих хэрэггүй, агуйд очиж бясалгавал агуйн хүн л болно. (Бүгд инээлдэв) Тиймээс бясалгах нь заавал ууланд зургаан жил, арван жил, хорин жил хагуужилтайгаар битүүмжлэн суух явдал биш юм, энэ бүхэн цөм барилдлагыг л дагадаг юм. Гэтэл зарим хүний барилдлага нь эрхбиш ингэж бясалгах ёстой байдаг байна. Гэвч ингэснээр л ямар нэг үр дүнд хүрнэ гэдгийг баталж чадахгүй, учир нь элсийг чанаад будаа болгож чадахгүй билээ. Хамгийн чухал нь нэг сайн номын цогцос, нэг сайн замч, нэг сайн Их Багш байх хэрэгтэй, тэгвэл дараа нь та нар хаана ч байсан бясалгаж чадна.

Мэдээж, чин сэтгэлээсээ бясалгадаг бол ямар ч номын цогцосыг бясалгасан бүгд л буян хариулалтай болгоно, харин болгохгүй биш. Гэтэл ийм буян хариулал нь хүн, тэнгэрийн л буян хариулал, харин жинхэнээр туулан гэтэлж чадахгүй болохоор үр дүн нь адилгүй. Хэрвээ бид бясалгалын талаар сайн багштай, сайн номын цогцостой бол заавал бүгдийг огоорохгүйгээр энэ дэлхий дээрх эд хөрөнгө, байр сууриа хадгалсан хэвээр байсан ч мөн л туулан гэтэлж чадна. Хэрвээ сайн багш, сайн номын цогцосгүй бол уулын агуйд сууж, хичнээн хатуугаар бясалгасан ч тийм их буян хариулалтай болж чадахгүй.

Зөвхөн тэнгэр болон хүн төрөлтний буян хариулалтай болохоос, туулан гээлж чадахгүй. Хатуу бясалгалын туйлд хүрээд өмсөх хувцасгүй, идэх хоолгүй болсон ч бас Бурханы хутагт хүрч чадахгүй. Бурханы хутгийг эд мөнгөөр худалдан авч болдоггүй, бас хээл хахууль өгч байгаад бүтээчих аргагүй. Бид хичнээн их мөнгөний өргөл өргөсөн ч, хичнээн их амлалт өгч, хувийн эд хөрөнгөө хэдий ихээр огоорч орхисон байлаа ч Бурханы сэтгэлийг худалдан авч чадчихдаг юм биш, тийм боломжгүй. Хэрэв хатуугаар бясалгавал зовлонг хүн л болно, уулын агуйд бясалгавал агуйн хүн л болно. (Бүгд инээлдэв)

Сармагчингууд бүгд ууланд амьдарч байдаг, тэд хотод орж ирдэггүй, ууланд агаар маш цэвэр, бохирдолгүй хэдий ч тэд бас л Бурханы хутагт хүрч чадахгүй. Ууланд очиж мөргөвөл уул гэдрэг танд мөргөх болно. (Бүгд инээлдэв) Гуан Чин (Guangqin) өвгөн хувраг мөн л Гуан Чин өвгөн хувраг хэвээрээ, бид бас л бид хэвээрээ байна. Ууланд мөргөхөд ямар ч буруу зүйлгүй, бие чийрэгжинэ. Хэрвээ чин үнэн сэтгэлтэй бол бага сага буян хариулалтай болно байх, гэвч энэ нь жинхэнээр туулан гэтлэхүй биш юм.

Миний шавь нарын нэг нь гэрээсээ гарах гэж бодож байжээ. Тэр гэрээсээ гарахаасаа өмнө манай бясалгалын төвд ирж бясалгаж байв. Тэр ууланд очиж мөргөл хийх гэхэд нь би “тэгэх шаардлагагүй” гэж хэлсэн билээ. Тэгэхэд тэр, ууланд мөргөсний дараа ахиухан буянтай болоод гэрээс гарч, нилээд тогтвортой суух боломж бүрдэх юм гэсэн. Тэгээд ууланд очиж мөргөсний дараа тэр эгэл хар хүн болжээ. (Бүгд инээлдэв) Гэрээс гараагүй байж аль хэдийн зугтаачихсан нь буян хариулалтай болсных гэж үү? Хэрэв ууланд мөргөвөл буян хариулалтай болдог юм бол тэр яагаад гэрээсээ гарна гэдгээ тогтвортой болгож чадалгүй буцаад хар хүн болсон бэ? Тэд (Багш шавь нараа заав) ууланд мөргөөгүй ч гэрээсээ гарч чадсан бөгөөд одоо болтол зугтаагаагүй байна, тиймээс ууланд мөргөх нь буян хариулалтай эсэхийг би мэдэхгүй.

Бид өдөр бүр энд байх (Багш билгийн мэлмийгээ заав) ууландаа мөргөнө, энд байдаг дотоодын уул, ус, бурхан, диваажин, тамын оронд мөргөнө, энэ бүхэн нь цөм бидний дотоодод байдаг юм. Бид бол эзэн бурхан мөн, бид бол орчлонгийн хамгийн агуу төрөлтнүүд мөн, бид ямар ч ууланд мөргөхөөр явдаггүй. Багшийнхаа сургаалыг дагах нь хамгийн дээд буян хариулал болно. Би та нарт энэ нууцыг хэлж өглөө, итгэх эсэх нь та нарын хэрэг. Гэвч би та нарт ойлгуулахын тулд хэлэх ёстой. Учир нь Багш нь арван зүг, гурван цагийн бурхныг төлөөлж байдаг. Нэгэн Их Багш бол энэ ертөнцөд заларч буй Бурхантай адил, хэрэв та түүний сургаалыг сонсож дагавал аливаа буяныг хураана. Түүний сургаалыг дагахгүй бол арван зүг, гурван цагийн бурханд мөргөсөн ч таныг шавиа болгох хүнгүй, ямар ч буян хариулал байхгүй. Яагаад гэвэл та үүнийг өөрийн “Би гэх үзэл”-ээр хийдэг, “Би” бол Багшаас илүү сайн гэж та боддог. Багшийн тайлж хэлсэн нь ямар ч сонирхолгүй, сонсоход хэрэгцээгүй санагдлаа. Би үүнийг хийе гэж бодож байна, би үүнийг хийхийг хүсч байна, ингэвэл “Би” Багшаас илүү сайн гэдгээ баталж

чадна. Би өөрийн үзлээ баримталж, би өөрийн хэргээ үйлдэнэ гэдэг. Мэдээж ингэж хийхэд өөрт тань бас бага сага буян хариулалтай байх нь мэдээж. Гэвч та нарын өөрсдийн чинь буян хариулал тийм ч их биш болохоор Багшийнхаа сургаалыг дагаж, Багш нь юу хий гэвэл түүнийг хийж байгаарай. Энэ нь хамгийн дээд буян хариулал болдог юм шүү.

Үйл түйтгэр гэж юу вэ? Үйл түйтгэр гэдэг нь бид аливаа зүйлийг хийхдээ жам ёсны хуульд нийцүүлээгүйгээс үүссэн харш саадыг хэлж байна. Жишээ нь: Урсгал усыг бид чулуу, модоор хашвал ус урсаж чадахгүй болно. Хэрвээ бид гэртээ ус хэрэглэх гэвэл гоожих хэмжээ нь тун бага байх болно. Яг л бидний ууланд ашиглаж байгаа устай адил, хэрвээ хэн нэгэн хүн дээд урсгалыг нь мод чулуугаар хашчихвал усны урсгалыг саатуулж, ус нь доош урсахгүй болно. Өөр нэг жишээ бол, хэрэв бид далайг гаталъя гэвэл усан онгоцонд суух хэрэгтэй, хэрэв ууланд авиръя гэвэл ууланд авирах сайн гутал өмсөхөөс биш углааш өмсөж болохгүй, тэр нь сугарч унавал осол гарч мэднэ. Дахиад бас нэг жишээ татъя. Хор ууя гэх хүн байдаггүй. Гэвч заримдаа бид мэдэлгүй уучихвал сүүлд нь хорны нөлөөг амсах нь гарцаагүй, энэ нь саад тогтор мөн, үүнээс өвчин олох юмуу, эсвэл муу нөлөөг нь амсахыг үйл түйтгэр гэж хэлж болох юм. Өргөн утгаар нь хэлбэл хэрэв бид орчлон ертөнцийн жам ёсыг мэдэхгүйгээсээ болж, орчлон ертөнцийн хууль ёстой нийцээгүй хэрэг хийвэл бидний бие махбод юмуу, эсвэл оюун санаа, үгүй бол бидний сүнсэнд нөлөөлнө. Энэ сүнс гэдгийг зарим хүн “билиг ухаан” гэнэ, зарим хүн “уг дүр” гэнэ. Юу ч гэж нэрлэж дуудсан цөм адил нэгэн зүйлийг зааж байгаа юм.

Нэгэн жинхэнэ Багш бол хуульчтай адил. Хуульч хүн мэдээжээр хуулийн агуулгыг сайн мэднэ. Хуулинд маш олон зүйл заалт байдаг учраас тэр болгоныг нь энгийн хүмүүс ойлгож чаддаггүй. Хуульч хүн биднээс илүү ихийг мэддэг болохоор хэрэв бид хууль ёсны зүйл хийхийг хүсвэл хуульчаас, эсвэл мэргэшсэн хүнээс асуувал, хуулийн дагуу хийж, хууль зөрчихгүй байж чадна.

Бясалгал ч үүнтэй адил. Орчлонгийн жам ёсны хууль маш олон байдаг болохоор бид тэр бүгдийг ойлгож чадахгүй. Тиймээс нэгэн жинхэнэ Багш юмуу, эсвэл ямар нэгэн нилээд Гэгээрсэн хүнийг хайх хэрэгтэй. Тийм хүн нь тэр жам ёсны хуулиудыг нилээд тодорхой сайн мэддэг болохоор бидэнд юу хийхийг зааж өгч чадна. Тэгвэл ямар ч асуудал гарахгүй. Энэ нь эгэл хүн хуульчийг хайж очоод: “Би яагаад тийм нэг төвөгтэйхэрэгтэй орооцолдчихов? Яагаад цагдаа намайг хайж шалгаж байцаахаар ирэв? Би яавал хууль зөрчихгүй байж чадах вэ?” гэж асуухад нь тэр хуульч яаж хийвэл хуульд нийцэхийг хэлж өгөөд урьд нь хууль зөрчсөн үйлдэл хийж байсан учраас цагдаа таныг хайж байжээ, одоо миний хэлснээр хийвэл цаашид цагдаа таныг хайж ирэхгүй болно гэж хэлэхтэй адил юм.

Бясалгалын байдал ч үүнтэй адил. Бид орчлон ертөнцийн жам ёс, эсвэл юм үзэгдлийг мэдэхгүй байдаг тул бидэнд хэлж өгөх Билиг нээгдсэн номч багш, эсвэл Их Багш нар хэрэгтэй байдаг, тиймээс зарим

үед Шагжамуни Бурхан юмуу, эсвэл Лууз, эсвэл Есүс Христ ирдэг. Тэд орчлонгийн хуулиудыг мэдэх учраас юу хийхийг бидэнд зааж өгнө. Ингэснээр бидний амьдрал бүр ч эрх чөлөөтэй болно.

Их Багш нар энэ ертөнц дээр ирдэг нь ямар нэгэн шинэ шашин суртахууныг үүсгэх гэсэн хэрэг биш. Шагжамуни Бурхан ирэхдээ ямар нэгэн шинэ сургаал ёсыг зааж сургаагүй. Гэвч түүний билиг нээгдсэн болохоор ном тайлж, хуучин ном судрыг тодорхой тайлбарлаж чадна. Тэдгээрийг энгийн номч багшаас илүү тодорхой тайлбарлаж чаддаг байсан. Учир нь түүний цол нь Buddha8, Buddha (Бурхан) гэдэг нь гэгээрсэн Их Багш гэсэн утгатай үг. Хятадаар үүнийг утгачлан орчуулаагүй, зөвхөн авиачлан буулгаад “Будда” болгожээ. Энэтхэгт бүгд л Шагжамуни Бурханыг Buddha гэж дууддаг. Энэ нь бидний эндхийн доктор, хуульч гэдэгтэй адил зүгээр л нэг зүйлийн нэр цол юм. Тэрээр Buddha болохоор хүн бүхэн түүнээс суралцсанаа дараа бүгдээрээ Buddhist (Бурхны шашинтан) болжээ. Бурхны шашинтан гэдэг нь Бурхан гэсэн нэрний дуудлагаас гаралтай болохоос Шагжамуни Бурхан ямар нэгэн шинэ шашин суртахууны онолыг заасан биш билээ.

Есүс Христ ч бас ямар нэг тийм шинэ зүйл заагаагүй. Тэр зөвхөн сургаал ёсыг заасан төдий бус, бас ном уламжилж, энэ хүчийг уламжилсан. Ном сударт хэдийгээр сургаал номлол байдаг боловч энэ хүч байхгүй болохоор тэр нэг талаар хуучны сургаал номлолыг урьдаар тайлбарлан ойлгуулж, нөгөө талаар ном уламжилж, энэ хүчийг дамжуулж өгдөг. Тэгвэл шавь нар нь өөрсдөө бясалгаж, сургаалыг өөрсдөө ойлгох болно. Хүй Нэн, Бодьдармаа нар үүнтэй нэгэн адил, ямар нэгэн онолыг шинээр үүсгэн бүтээж заагаагүй. Гэвч сүсэгтэн нар багшийгаа тун их хүндэтгэдэг болохоор бүгдээрээ би бол Buddhist, би бол Бурхны шашинтан гэж хэлдэг. Учир нь тэд бурхнаас суралцдаг. Шагжамуни Бурхан хамгийн их алдартай нь болохоор одоо бид бурхан гэхээр ганц түүнийг л мэдэх төдий байна. Гэтэл өөр бас маш олон бурхан байдаг бөгөөд ихэд билиг нээгдэж гэгээрсэн аливаа хүн бүхэн бурхан мөн.

Бурхан Багш, Есүс Христийн аль аль нь л үйл түйтгэрийн асуудлыг ярьсан. Шагжамуни Бурхан: “Үйл байвал үр байна, ямар үйл тарина, тийм үрийг хураана.” гэжээ. Есүс Христ бас: “As you sow, so shall you reap.”, “Юу таривал түүнийгээ л хураана” гэжээ. Тэрээр Бурхан Багштай адил үйл түйтгэр болон үйлийн үрийн талаар ярьж байжээ. Үйлийн үр нь бүхэлдээ үйл түйтгэрийг зааж байгаа гэсэн үг биш. Үйлийн үр гэдэг нь сайн үйлийг таривал сайн үрийг хурааж, муу үйл таривал муу үр хураахыг хэлдэг. Энэ нь тун энгийн хэллэг билээ. Гэтэл үйл түйтгэр гэдэг нь онцгойлон муу үйлийн үр дагаварыг л зааж байгаа хэрэг юм. Жишээ нь, бид хүн алах юмуу, эсвэл хулгай хийвэл эрт орой хэзээ нэгэн цагт хүн биднээс өшөөгөө авах юмуу, эсвэл бид цагдаад баригдаж шоронд орно. Энэ бол үйл түйтгэр. Үйлийн үр гэдэг нь зөвхөн үйл түйтгэрийг хэлдэг биш, сайн үйлийн үрийг бид “буян хариулал” гэнэ, муу үйлийн үрийг л “үйл түйтгэр” гэдэг. Ихэнх хүн Бурхны шашны



талаар тийм сайн мэддэггүй болохоор тэдэнд үйл түйтгэрийн тухай тодорхойлолт ойлгоход амаргүй санагддаг. Үйл түйтгэр гэдэг нь бид муу хэрэг хийснээс үүдсэн үр дагавар буюу муу үр дүн юм. Жишээ нь, бид архи их уугаад хэдэн жил болжээ. Харин одоо маш сайхан завшаан тохиолдоод бясалгал хийхийг суръя гэтэл урьд нь дэндүү их архи уусан болохоор одоо муу нөлөө нь тун их. Тиймээс бясалгал хийхэд их хэцүү байдаг, ахуй ойлголт нь тун бага, ахиж дэвших нь тун удаан. Үүнийг бид энэ бол бидний үйл түйтгэр гэж хэлдэг. Энэ үйл түйтгэр нь хаанаас ирсэн бэ? Энэ нь урьд нь уусан архины спиртийн нөлөөнөөс ирсэн, тэр муу нөлөө нь одоо болтол байсаар, тиймээс бид түүнийг урьдын үйл түйтгэр, нэг зүйлийн үр дагавар гэж хэлдэг. Үйл түйтгэр болон муу үр дагавар нь адил зүйл.

Ууланд мөргөх нь ач тустай юу? Энэ нь Гуан Чин өвгөн хуврагийн буян хариуллыг хулгайлахаас биш өөрөө буян хурааж чадахгүй. Зөвхөн бусдын буян хариуллыг хулгайлах төдий. Их бясалгалтан хүмүүст үнэхээр барагдашгүй их буян хариулал байдаг, бид очоод бага сага хулгайлсан ч түүний хувьд ямар ч асуудалгүй. Тийм болохоор олон шавь минь хүрч ирээд Багшийгаа цаг гаруй харж, Багшийнхаа буян хариуллаас хулгайлах гэдэг. Энэ нь хамаагүй, та нар хулгайлах тусам Багш нь улам буян хариулалтай болно, та нарт өгөх буян хариулалгүй болохоос айхгүй. Гэвч бясалгал хийхэд өөрөө мөнгө (буян хариулал) олж, өөрийнхийгөө хэрэглэх нь хамгийн сайн.

Саяхан бид үйл түйтгэрийн асуудлыг ярилцаж, ямар үйл байвал тийм л үр байна гэсэн билээ. Тэгвэл бид одоо яадаг билээ? Төрөл төрөлдөө маш их үйл үйлдэж, маш их үртэй болжээ, одоо яаж түүнээсээ салах вэ? Яавал бид мултарч чадах вэ? Бид зам мөрийг нь мэдэхгүй болохоор заавал нэг Их Багш ирж, бидэнд замчлах хэрэгтэй. Бид түүнийг дагаж явбал аяндаа мултарч чадна. Тэгэхгүй бол бид өөрийн биеэ түшээд мултарч чадахгүй, учир нь бид нэгэнт балчиг шалбаагт унасан бол тэлчлэх тусам улам гүн шигдэнэ. Хүний амьдрал зүүд зэрэглээ мэт гэж бид үргэлж хэлдэг, гэтэл яагаад сэрж болдоггүй юм бэ? Бид уг нь зүүднээсээ өөрсдөө сэрж болдог, гэтэл энэ их зүүд нь яагаад сэрж болдоггүй зүүд болчихов оо? Зөвхөн тун цөөхөн хүн л өөрөө зүүд зэрэглээнээс сэрж чаддаг. Ингэж өөрөө сэрж сэхээрсэн хүнийг бид “Брадигабудда бурхан” гэдэг билээ.

Ийм Брадигабудда бурхан тийм ч олон байдаггүй, гэхдээ бас байхгүй ч биш юм. Тэд өөрсдөө бясалгаж, энэ ертөнц угаасаа зүүд зэрэглээ төдий гэдгийг ухаарч мэджээ. Энэ дэсэд хүрсний дараа туулан гэтэлж чадна. Бид бас тэднийг бурхан гэж нэрлэдэг, Брадигабудда бурхан буюу эсвэл өөрөө гэгээрсэн бурхан гэдэг. Өөрөө гэгээрсэн бурхан бол угаасаа л өөрийн биеэ түшиж туулан гэтэлж, гэгээрсэн байдаг, гэхдээ тэд тийм олон хүнийг гэтэлгэж чадахгүй. Хэрвээ гэтэлгэхийг хүсвэл зөвхөн хоёр, гурван хүнийг л гэтэлгэж чадна. Тэд бусдыг сургаж чадах ч ном уламжилж чадахгүй, учир нь тэдэнд уламжилмаар жинхэнэ номын цогцос гэж үгүй.



Арван зүг, гурван цагийн аливаа бурхан цөм Их Багшийн сэтгэлд байдаг. Нэгэн Их Багш, эсвэл нэг амьд сэрүүн байгаа Бурханы зааж сургаж буй номлол нь арван зүг, гурван цагийн бурхадын зааж сургасан номлол болно. Тиймээс нэг Их Багшид мөргөх нь арван зүг, гурван цагийн бурханд мөргөж байгаатай адил юм. Эс бөгөөс хаа сайгүй явж арван зүг, гурван цагийн бурхдад мөргөдөг бол хэзээ мөргөж дуусах вэ? Чин сэтгэлээсээ бурханд мөргөвөл жаахан буян хариулалтай болж болох ч хангалттай биш байдаг. Гэтэл хэрвээ нэгэн жинхэнээр гэгээрч Гэгээрсэн Багшийн заавар болгоныг чанд сахин биелүүлж, үг бүрийг нь алдалгүй суралцаж мөрдвөл тэр нь хамгийн их буян хариулал болно, энэ нь мөн арван зүг, гурван цагийн бурхдад мөргөсөнтэй тэнцэх юм. Ингэж чадвал аливаа буян хариуллыг олж чадна, энэ нь сая жинхэнэ буян хариулал болно.

Авшиг хүртсэний дараа мөн л урьдынхтайгаа адил байж, өөрийнхөө шашин шүтлэгийг өөрчлөх юмуу, эсвэл эгэл ертөнцийн амьдралаа огоорох шаардлагагүй, нэг талаар ажиллаж, нөгөө талаар Багшийнхаа сургаалыг сонсож байвал болчихно. Хүн бүрийн үйл түйтгэр адилгүй. Зарим хүн ууланд мөргөвөл буян хариулалтай болно. Учир нь түүний үйлийн үр нь тийм юм, тиймээс Багш нь түүнийг ууланд мөргүүлэхээр явуулдаг. Зарим хүн бурханд мөргөх хэрэгтэй болохоор Багш нь түүнийг бурханд мөргүүлдэг. Гэтэл зарим хүн бурханд, эсвэл ууланд мөргөх шаардлагагүй, харин өөр зүйл хийх ёстой байдаг. Хүн бүрийн нөхцөл байдал адилгүй, гэвч Багш нь та нарт юу хий гэж хэлсэн ч хамаагүй, хэрэв та нар Багшийнхаа заавраар хийдэг л бол буян хариулалтай болно.

Гэтэл хэрвээ та нар үүнийг том “Би гэх үзэл”-ээр хийвэл ямар ч буян хариулалгүй байж, зөвхөн өөрсдөдөө үйл түйтгэр тарих болно. Энэ нь яг бид явах зам дээрээ хэсэг том чулуу тавьснаас болж бусдыг зүдрээж, тэдэнд саад болохтой адил юм. Бид үйл түйтгэртэй, үйлийн үртэй. Учир нь ямар үйл тарина, тийм үрийг хураана, гэвч бид бас үйл үрийн дэсийг даван туулж болно. Үйл үр нь хаанаас ирдэг вэ? Үйл үрийн хуулийг үүдэн зохиосон нэгэн Эзэн Бурхан оршдог гэж бодъё. Тэгвэл энэ “үйл үрийн хууль” нь мөн түүнд харьяалагдах болохоор хэрвээ бид “Эзэн Бурхан”, “Бүтээгч” юмуу, эсвэл “Уг дүр”-ийг хайж олбол үйлийн үр бидэнд нөлөөлж чадахгүй болно.

Эрт үед бүх улс орон хаант засаглалын тогтолцоотой байсан болохоор улсын хаан хамгийн дээд эрх мэдлийн төлөөлөгч байв. Хэрвээ нэг тариачны охин тун үзэсгэлэнтэй байгаад улсын хаан түүнд дурлаж гэрлэхийг хүсвэл, хэдийгээр тэр үед охины эцэг, эх нь ял хийгээд шоронд байсан ч охин нь хааны хатан болсон тул эцэг, эх нь мөн суллагдана. Яагаад гэвэл улсын хаан хамгийн дээд эрх мэдэлтэй, өөрөө хууль тогтоодог тул тэр хуулиа өөрчлөхөд үг сөргөлдөх хүн байхгүй юм. Бүр эрхэм сайдууд нь эсэргүүцлээ ч тусгүй. Учир нь улсын хаан нь хуультай тэнцэхүйц хамгийн дээд хүчийг төлөөлж байдаг. Үүнтэй адилаар, энэ ертөнц дээр хэдийгээр хууль тогтоомж, мөн үйлийн үр оршин байгаа боловч бид хэрвээ энэ хамгийн дээд хүчтэй, өөрөөр хэлбэл, бидний уг

дүртэй, энэхүү мөнхөд оршигч хүч, их нигүүлсэнгүй, их энэрэнгүй, цогц их хүч чадалтай нэвтрэлцчих л юм бол үйлийн үрээс үүрд ангижирч болно. Тиймээс Багш нь тогтсон үйлийг бага зэрэг өөрчлөх боломжтой гэж үргэлж хэлдэг нь энэ санаа билээ. Жишээлбэл, сая дурдсан тэр жишээнд тариачны охин нь хэдийгээр хааны хатан болсон боловч улсын хааны зарлиг шоронд уламжлагдаж ирэхээс өмнө охины эцэг, эх тэндээ түр хүлээх хэрэгтэй. Улсын хааны өршөөх зарлиг хийгээд тэднийг тосох тусгай тэрэг хүрч ирэхээс өмнө хэдийгээр тэдний байр суурь өндөр байсан ч эрхбиш шоронд байж, хэсэг хугацаагаар хүлээх хэрэгтэй. Тэр хэсэг хугацаа нь “тогтсон үйл” билээ.

Үүнтэй адилаар, авшиг хүртсэний дараа таван үеэрээ төрөл дээшилж, бид өөрсдөө туулан гэтэлчихсэн хэдий ч мөн л жаахан хүлээж байх хэрэгтэй. Тэгээд цаг нь болмогц тусгай тэрэг хүрч ирээд биднийг эндээс авч явна. Тиймээс тэр дороо нас нөгчиж болохгүй, зарим учир явдлаа төвхнүүлэх хэрэгтэй. Бас эцэг, эх, эр нөхөр, эхнэр, үр хүүхэд гэх зэргээ сайтар зохицуулсны дараа л явж болно. Ингэж хүлээх хэсэг цаг байдаг болохоор бид тогтсон үйлийг бүрмөсөн өөрчлөх боломжгүй гэж хэлдэг билээ. Гэхдээ нилээд тааламжтай болгон өөрчилж болох юм. Ядаж л бид суллагдсан гэдгээ мэдэж байгаа бөгөөд хэдийгээр шоронд хоригдсон хэвээр байгаа ч бусад хоригдлуудтай адилгүй байна. Бид нэгэнтээ суллагаад эрх чөлөөтэй болсон боловч тусгай машин ирж биднийг тосон авч явахыг хүлээж байх болно.

Шоронд хүлээж байгаа үе нь, мэдээж, ордонд байгаа шиг тийм таатай биш, гэвч аль хэдийнээ эрх чөлөөтэй болсон. Ялтны хувцас өмсөж, шоронгийн хоол идэж, мөн ялтантай хамт суусаар байна, учир нь шоронд хорих өрөөнөөс нь өөр байрлах газар байхгүй, тиймээс түр зуур тэндээ суух хэрэгтэй ч нэгэнт бусад ялтантай адилгүй болжээ. Удалгүй чөлөөтэйгээр тэндээс гарч гэртээ хариад хааны хадам, улсын садан болно.

Тиймээс нэг улсын хаан энгийн ардын охинтой урагласны дараа охины гэрийн хүмүүсийн байр суурь дээшилж, хүн бүхэн шагшин бишрэх язгууртан болж хувирдаг. Холын хамаатан садан байсан ч өөрийнх нь байр суурь дээшилсэн шиг санагдаж, ихэд омогшин “миний ийм ийм садан, одоо хааны хатан болсон” гэж хэлнэ. Хэдийгээр тэд хамтдаа амьдарч байгаагүй боловч тэдний байр суурь нь бас дээшилчихсэн болохоор маш олон хүний нүдэнд тэд урьдынхтайгаа адилгүй болсон шиг харагдана. Тэр ч байтугай найз нар нь ч түүний нөлөөгөөр нэр хүндтэй болж, байр суурь нь ч бас бага зэрэг дээшилсэн шиг санагддаг.

Авшиг хүртэх байдал нь үүнтэй адил. Авшиг хүртсэний дараа зөвхөн та нар буянтай болдог төдийгүй гэр хотлоороо бүгд л буянтай болно, таван үеэрээ хамтдаа төрөл дэвшиж, буянтай болно. Цаашилбал та нарын найз нөхөд, хэрвээ та нар тэднийг бодох л юм бол, тэд ч бас буянтай болдог. Авшиг хүртсэн хүн аль хэдийнээ туулан гэтэлчихсэн байдаг. Энэ нь нэгэнт суллагдах болсон тэр тариачин шиг юм. Гэхдээ

шоронгоос хааны ордон хүрэх замд түүнд тийм ч таатай байхгүй, замд явах үеэр хэрхэн тав тухтай байж чадах вэ? Саяхан хоригдол байсан, ядарч зүдэрсээр, бие нь тун сул дорой болжээ. Шоронгоос ордонд хүрэх замд явахад бас бэрхтэй, гэвч ордонд хүрвэл тааламжтай сайхан болох юм.

Манай шавь нарын хувьд ч мөн адил. Авшиг хүртэсний дараа амьдрал нь мөн урьдынхтайгаа бараг адил байна, эсвэл бага зэрэг дээрдэх ч тийм ч сайн болж чадахгүй байдаг. Учир нь энэ дэлхий дээр угаас сайн гэх зүйл үгүй. Хэсэг хүлээвэл бид Гэртээ харина, Төгс баясгалант орон, Ариун орон, Бурхны орондоо харих тэр үед бид жинхэнэ ёсоор жаргал цэнгэлийг эдлэх болно. Энд эдэлмээр цэнгэл огт байхгүй, тэгээд бас харих зам маань явахад бэрхтэй гэдгийг бид бүгд мэднэ. Хэдийгээр хамгийн сайн онгоцонд суусан ч тун ядаргаатай санагдаж, гэртээ байгаа шиг тийм тав тухтай байж чадахгүй. Хэдий тийм ч хэсэг хугацааны дараа бид гэртээ хүрэх л болно.

Үлгэр дэх тэр тариачин замдаа өөр бусад хүнтэй адилхан аян замыг туулах ёстой. Хэдийгээр тэр сүйх тэргэнд суусан ч морин тэрэг нь замаар явж байгаа бусад морин тэрэгнээс ямар ч ялгаагүй. Гэхдээ тариачны очих газар нь хааны ордон байх тул өөр хүмүүсийнхтэй адилгүй. Авшиг хүртсэн хүн хэдийгээр урьдынхтайгаа адил хэвээрээ байж, арилжаа наймаа хийж, гэр бүлээ харгалзаж, хүүхдээ асарч байх боловч бидний нас барсныхаа дараа очих газар нь энгийн хүнийхтэй адилгүй. Хэдийгээр энгийн хүнтэй адил ажиллаж байдаг боловч эцсийн үр дүн нь огт адилгүй.

Өнөөдөр авшиг хүртэхийг хүссэн нэг бяцхан охин энд байна. Анх удаа ээж нь түүнийг дагуулж ирээд ном тайлахыг сонсгох үед тэр охин сэтгэлээ сайтар төвлөрүүлж, маш анхааралтайгаар сонсож байсан бөгөөд бас гараа өргөөд Бурханы хутагт хүрнэ гэж хэлж байсан билээ. Энэ нь зургаан настай хүүхдийн амнаас гармаар үг биш. Багш нь тийм ч тэнэг хүн биш, хүүхэд болгонд авшиг хүртээгээд байдаггүй, хүүхэд болгон ч авшиг хүртэх дуртай байдаг юм биш. Том хүмүүс байлаа ч хүн болгон авшиг хүртдэг биш юм чинь, бяцхан хүүхдийг бүр ч хэлэх хэрэг юун? Гэтэл тэр анх удаа Багшийгаа хармагц авшиг хүртэхийг хүссэн байна. Тэр том хүмүүсээс ч илүү сэргэлэн ухаалаг. Тэр тэднээс ялгаатай нь өмнөх төрөлдөө хэдийнээ бясалгал хийж байжээ.

Хүүхдийн өмнөөс сонголт хийх эрх бидэнд байхгүй. Учир нь хүүхдэд зөвхөн энэ нэгэн төрөл л байгаа юм биш, сансрын хүрдэнд олон төрлийг элээсэн байдаг. Зарим бяцхан хүүхэд том хүүхдүүд (том хүмүүс)-ээс ч цэцэн сэргэлэн байдаг. Тиймээс гоц ухаантай, эсвэл гоц авъяас чадвартай гэгддэг хүүхэд олон байдаг. Насанд хүрсэн хүмүүс: “Бид том болсон болохоор авшиг хүртэх эсэхээ өөрсдөө шийдэж чадна, бяцхан хүүхэд хэрхэн шийдэж чадах билээ? Том болохыг нь хүлээж байгаад больё.” гэх юм. Ингэж байгаа нь хүүхдийн өмнөөс шийдэж байгаа хэрэг болно шүү дээ. Хүүхдийн өөрийнх нь шийдвэр тийм сайн байхад бид хүлээн зөвшөөрөхгүй, харин өөрсдийн шийдвэрээ хамгийн

сайн гэж боддог. Энэ нь яаж сайн байж чадах вэ? Өөрсдөө бас мах идэж, архи уугаад бяцхан хүүхэд шиг тийм сайн биш байж, хэрхэн тэдний өмнөөс шийдвэр гаргахыг боддог юм бэ?

Хэрвээ нэг эр нөхөр, эсвэл эцэг хүн өөрөө сайн бясалгаад ёс суртахуунтай, билиг ухаантай болсон бол тэр үедээ л өөрийн гаргасан шийдвэрээ сайн гэдэгт итгэж болох юм. Гэтэл энэ хүүхдийн эцэг нь өөрөө бясалгадаггүй, тэгээд бас мах идэж, архи уудаг мөртлөө хүүхдийнхээ авшиг хүртэхийг нь зөвшөөрөхгүй, эхнэрийнхээ бясалгалыг саатуулж, ном тайлахыг сонсохыг нь хориглодог. Тийм эцэг хүн ямар ч сайн шийдвэр гаргаж чадахгүй. Учир нь хэрвээ нэг хүн ёс суртахуунтай зүйл хийе гэхэд нь бид саад болох юм бол өөрсдийн ёс суртахуунгүйгээ илтгэн харуулж байгаа хэрэг. Жишээ нь, таны эцэг өөрөө бясалгадаггүй, гэтэл та бясалгаж байгаад нэгэн ёс суртахуунтай хүн болохыг хүсэхэд тэр харин: “Чи жаахан хүүхэд байж сайн, мууг яаж ялгаж чадах вэ?” гэж хэлээд таныг бясалгахыг зөвшөөрөхгүй байх нь бий. Гэхдээ эцгийнх нь нас хүүхдийнхээ наснаас их гээд эцгийнх нь үгийг л зөв гэж болохгүй. Насны их, бага нь билиг ухаантай тийм ч их хамаатай биш. Тиймээс зарим хүний нас нь хэдийгээр ах боловч хүүхдээс цэцэн сэргэлэн гэж хэлж болохгүй. Эцэг, эх нь хүүхдээсээ заавал илүү цэцэн сэргэлэн байдаг гэж хэлж болохгүй.

Тэр эр анхандаа эхнэрээ бясалгуулахгүй гэхдээ “Чи хэрвээ бясалгал хийх юм бол би чамаас сална” гэж хэлжээ. Ийм хүний гаргасан шийдвэр яаж сайн байж чадах вэ? Одоо тэр бас “Хүүхэд балчир бага байна” гэж хэлдэг байна. Гэтэл эхэндээ эхнэрийгээ бясалгуулахгүй гэж байсныгаа одоо тэр юу гэх вэ? Эхнэр нь хүүхэд юм гэж үү? Ийм хүний гаргасан шийдвэр нь сайн санааных биш байдаг. Тэр өөрийн шийдвэрээ хайрын сэтгэлээр гаргасан гэж бодох нь мэдээж. Түүний уг санаа нь хэдийгээр сайн байсан ч энэ нь үнэнхүү жинхэнэ сайн санаа биш, харин “харанхуй мунхаг” санаа юм. Өөрөө ойлгохгүй байж, бас бусдын ойлгохыг хорьж, өөр хүн надаас илүү цэцэн сэргэлэн байж болохгүй гэсэн атгаг санаа гаргадаг. Эхнэр нь сайн ёсыг сурч ирээд дараа нь түүний үгэнд орохгүйгээс айна, хүүхэд нь сураад түүнээс сайн болохоос айна.

Тэр өөрөө сурахгүй байгаа нь түүний үйл түйтгэр нь тун хүнд, бясалгах дургүйгээс, эсвэл эхнэр, хүүхдээ алдахаас айдгаас болсон ч байж магад. Тиймээс тэдэнд илүү зүйл суралцуулах дургүй байдаг, энэ нь даанч хувиа бодсон байдал юм. Эхнэрээ гэртээ байлгаж, үг дуугүйгээр хоол унд хийлгэж, оймсоо угаалгана. Эхнэр нь түүний үгнээс огт гарахгүй, өчүүхэн төдий ч эрх чөлөөтэй байж болохгүй, хүүхэд нь түүнээс бядуу байвал түүнийг эрхэндээ оруулахад нилээд хялбар болно. Хэрвээ хүүхэд нь дэндүү сэргэлэн болбол түүнд яршиг болж, үгэнд нь орохгүй болохоос айна. Ингэж бодох нь хувиа хичээсэн үзэл болохоос сайн санаа биш. Хэрвээ сайн санаатай байсан бол би тэр дор нь мэднэ. Би сайн санаатай хүнд тун дуртай.

Зарим нөхөр нь бясалгах гэхэд эхнэр нь харин зөвшөөрөхгүй, түүнд хоол хийж өгөхгүй, маш ихээр дарамтлан шахаж, үргэлж л бясалгалаас нь

холдуулахыг оролддог байжээ. Манай шавь нарын дунд бас тиймэрхүү эхнэртэй хүмүүс байна, зөвхөн нөхрүүд л тийм байдаг биш. Бясалгах нь тийм ч хялбар хэрэг биш. Тиймээс гэрлээгүй хүмүүс илүү эрх чөлөөтэй байдаг. Гэрлэсний дараа харилцан нэгэндээ хүлэгдэх болно. Гэрлээгүй эрэгтэй, эмэгтэйчүүд тун эрх чөлөөтэй байдаг, гэрлэснийхээ дараа хэрэв нөгөө хүнийхээ боол болчихвол юу ч хийж чадахгүй болдог. Юм хийх гэвэл нөгөө хүнээсээ асуух хэрэгтэй. Хэрэв нөгөө хүн нь зөвшөөрөхгүй бол хийж зүрхлэхгүй. Ингэж яаж болох вэ? Гэрлэснийхээ дараа сайн найз бололцох учиртай, хоорондоо маргаантай үед үг хэлээрээ ойлголцохоос биш, зодоон хийж, хүчирхийллээр шийдэж яаж болох вэ? Тэгж гэрлэх нь ямар ач тустайг би ойлгохгүй байна. Тийм нөхөр, эхнэр бол сайн найз биш, харин өстөн дайсан юм.

Хэрвээ сайн найз бол нөгөө хүнийх нь баяр баясгалан нь таны баяр баясгалан болох учиртай. Найз чинь сагсан бөмбөг тоглох дуртай бол түүнийг нь хүлээн зөвшөөрч, түүнтэй хамт явж мэднэ. Учир нь тэр сагсан бөмбөгийн талбайд байхдаа маш баяр баясгалантай байдаг, энэ баяр баяслаа тантай мөн хуваалцах болно. Үүнийг л сайн найз гэнэ. Юунд та нөгөө хүнийхээ хийх дуртай зүйлийг хааж хориглож болох вэ? Эсвэл эхнэрээ гэртээ байлгаж “намайг” халамжил, “надад” хоол хийж өг, “би” чамаар оймсоо угаалгаж, шал шүүрдүүлэн хоол хийлгэнэ гэх ажээ. Ийм ажлаа бас хийх ёстой, хойш тавьж болохгүй. Гэхдээ хэрэв эхнэр нь энэ ажлуудыг сайн хийж дуусгачихаад завтай болбол түүнийг чөлөөтэй явуулж ангийнхан, хамт ажиллагчид, эсвэл авшигтнуудтай уулзаж ярилцах боломжтой байлгах ёстой. Ажлаа тармагц шууд гэртээ ир гэж байнга шаардсаны хэрэггүй. Гэртээ эртхэн харих нь буруугүй, гэвч түүнийг бас жаахан эрх чөлөөтэй байлгаж, дуртай зүйлсийг нь хийлгэвэл зохино. Зөвхөн муу хэрэг хийхгүй л бол болчихно. Энэ нь эхнэр нь гадагш гарч хов жив, худал ярьж, хөзөр тоглож, архи ууж, бүжгэнд явахаас л дээр юм. Тиймээс хэрэв эхнэр тань ном тайлахыг болон ёс суртахуунтай зүйлсийг сонсохыг хүсэж байвал энэ нь хамгийн сайн эхнэр болно. Бясалгалд сууж сэтгэлээ тайвшруулахад юу нь муу болох вэ? Яагаад түүнийг явуулахгүй байдаг юм бэ?

Католик шашинтны гэр бүлд эцэг, эх нь хүүхдүүддээ бага балчираас нь ёс суртахуунтай явдал хийж бай гэж зааж сургаж, тэдэнд Библи судар зааж өгдөг билээ. Гэтэл Тайваньд ийм ёс заншил байхгүй болохоор энэ нь тун сонин, шинэлэг зүйл санагддаг. Багш нь хүүхдэд заахад тийм ч амаргүй, эрхбиш урьдаар эцэг, эх, өвгө эцэг, эмэг эхийнх нь саналыг авна. Гэхдээ зөвшөөрөх хүн үргэлж байдаг биш. Учир нь ийм заавар сургаал нь Тайваньд шинэ зүйл хэвээр байна. Католик шашинтай гэр бүлд төрсөн хүүхэд байсан бол бага наснаасаа сурч эхэлсэн байх ёстой, тийм биз дээ? Бурханы шашин нь харьцангуй ардчилалтай, бурхны ёс зарчмуудыг сургах гэж хүүхдийг албадахгүй, гэхдээ сургахад бас тийм амархан хэрэг биш. Хожим би католик шашны гэлэнмаа болъё гэж бодож байна. Ингэвэл хүмүүст зааж сургахад нилээд хялбар болно. (Бүгд инээлдэв) Учир нь тийм гэлэнмаа юу хийсэн ч хамаагүй, энэ нь

тэдний үүрэг гэгдэнэ. Католик шашны гэлэнмаа, эсвэл хар лам нь юу л гэнэ, тэд тэр заавраар нь хийдэг болохоор зааж сургахад мэгн. Бурханы шашин дэндүү ардчилалтай болохоор тэр нь гэдрэг харин нэгэн зүйлийн саад харш болж хувиран заавал хүмүүсээ аврал эрж, тэднээс гуйж, мөргөн байж гэмээнэ л ёс суртахуунтай хэргийг суралцуулж болох юм шиг байдаг.

Энэ дэлхий тун гашуун зовлонтой, хэрвээ хүүхдийг туулан гэтэлгүүлэхгүй юм бол тэднээр өөр юу хийлгэх юм бэ? Хүүхэд хожим нь аз жаргалтай байх эсэхийг эцэг, эх нь баталж чадахгүй, зөвхөн Багш нь л баталж чадна. Үүнээс үзвэл чухам хэн нь илүү сайн бэ? Хэний гаргасан шийдвэр нь илүү зөв болох вэ? Германд надад нэг найз байсан, тэр бас надтай хамт бясалгадаг байв. Түүний нөхөр нь бясалгадаггүй, мах идэж, архи уух дуртай. Нөхөр нь хэдийгээр манай Багшид дуртай байсан ч бясалгах санаагүй байв. Энэ нь түүний үйл түйтгэр юм. Тэр өөрөө бясалгахгүй байсан ч яая гэхэв, бас эхнэр, хүүхдээ ч бясалгуулахгүй гэдэг байсан. Гэвч сүүлд нь түүний эхнэр нь ямартаа ч авшиг хүртсэн юм. Тэгснийхээ дараа хүүхдээ дагуулж ирээд авшиг хүртүүлэх гэв. Энэ хүүхдэд заавал авшиг хүртээж, ном уламжилж өгөөч хэмээн манай Багшаас гуйж байсан. Ингэсэн болохоор Багш маань түүнд таггалзаж чадаагүй билээ.

Ердийн үед эх хүмүүс ч эрхбиш өөрийн санал бодолтой байх ёстой. Ганц эцэг хүнд л үг хэлэх, шийдвэр гаргах эрх мэдэл байдаг биш билээ. Хэрвээ эцэг хүн гадуур ажиллан зовж зүдэрч байж мөнгө олдог гэх юм бол эх хүн ч бас мөн л адилхан арга замаар мөнгө олох болдог бөгөөд эцгээс нь ч илүү зовж зүдэрдэг. Эх нь ажлаасаа тарж ирсний дараа гэрийн ажлаа хийж байхад эцэг нь тийм ч их зүйл хийдэггүй. Хэрвээ ганц эцэг нь л мөнгө олж ирдэг бол тэр тийм илүү зүйл ярьж болно. Гэтэл тэр хүүхдийн эх нь бас ажил хийх хэрэгтэй байсан бөгөөд ажлаасаа ирээд хүүхдээ асарч, нөхөр, хүүхдийнхээ хувцсыг угааж, хоол ундаа бэлтгэж, гэрийн бүх хүмүүсээ хооллох хэрэгтэй байв. Ийм байхад хүүхдийн эцэгт ярих зүйл юу байх вэ? Ажлаасаа гадна тэр өөр юуг хуваалцаж чадах вэ?

Нэгэнт гэрлэсэн бол гэр бүл битгий салаарай гэж би та нарыг ятгая. Гэр бүл болсон байж бас юугаа хийж салах вэ? Гэр бүл болох гэдэг нь найзыхаа олсонтой адил болохоор тэрээр ямар ч байсан, эв найртай хамт амьдрахыг хүснэ. Энэ бол миний номлол. Би хүнийг гэр бүлээ цуцлуул гэж ятгахгүй, гэвч нөхөр нь өөрийн байр сууриа мэдэж байх нь зүйтэй. Эхнэрийнх нь сэтгэл дэндүү сайн болохоор тэр тэгж ганцаар эзэрхийлж болохгүй. Эцэг нь байхгүй байсан ч эх, хүүхэд хоёр мөн л сайн сайхан амьдарч чадна. Гэхдээ хамгийн сайн нь гэрлэхгүй байвал дээр. Учир нь бидэнд өөрсдийгөө ойлгох жаахан илүүхэн цаг хэрэгтэй. Бид хаанаас ирсэн бэ? Нас бараад хаана очих вэ? Нас барсны дараа тэнд очихоороо юу хийх вэ? Яагаад би эрэгтэй байхад тэр эмэгтэй болсон бэ? Энэ бүхний тухай их, бага ч гэсэн мэдэх хэрэгтэй. Яагаад гэдгийг ойлгож мэдэхээсээ өмнө хэдийн өөртөө уршиг тарьчихжээ, гэрлэх нь өөрийгөө уяж хүлж байгаатай адил хэрэг болно. Тийм үү, үгүй юу?



Гэрлэхгүй байна гэдэг нь ачлалгүйг илтгэж байгаа биш. Хэнийг ачлалтай хөвгүүн гэх вэ? Нэгдүгээрт, эцэг, эхийгээ амьд сэрүүн байхад нь тэднийгээ ачлан асарч, тэдний идэж, өмсөхийг нь элбэг дэлбэг байлгаж, тохиромжтой орон сууцаар хангаж өгөх. Хоёрдугаарт, хэрвээ туулан гэтэлгэх ёсыг мэддэг бол гэртээ хариад тэдэнд ярьж өгч сонгосноор тэднийг бас тийм буянтай болгоно. Энэ нь цаглашгүй их буян болохоос хязгаартай өчүүхэн буян биш, хамгийн их буян юм. Зөвхөн ингэвэл л нэгэн ачлалтай хөвгүүнд тооцогдоно. Ачлалтай байхын тулд гэр бүл болж, хуримлах хэрэгтэй байдаг юм биш. Бүр гэрлэлээ ч хэрэв хөвгүүнтэй болж чадахгүй бол яах билээ? Гэрлэчихлээр л заавал хүүтэй болно гэсэн үг биш, хүүтэй боллоо ч гэсэн тэр хүү нь үгэнд ордог дуулгавартай, зөв ёс суртахуунтай хүн болохыг нь баталж чадах уу? Тэр хүү тань гадагш гарч, элдэв муу хэрэг хийвэл яах билээ? Эцэг, эх тань амьд сэрүүн байвал таныг гэрлэхгүй болохоор сэтгэл зовж, хэрвээ та гэрлэвэл баярладаг билээ. Эцэг, эх тань нас нөгчсөн тохиолдолд, хэрэв тэд хэзээ нэг өдөр буцаж ирэх юм бол танд: “Хүү минь битгий гэрлэ! Гэрлэсний дараа зовлонтой байх болно.” гэж хэлнэ. Гэтэл та тэднийг сонсож чадахгүй. Жинхэнэ ачлалтай хүү нь ёс суртахуунтай, эсвэл их билиг нээгдсэн хүн байх ёстой. Энэ нь “жинхэнэ ачлал” болохоос биш, ачлалтай болохын тулд заавал гэрлэх албагүй.

Зургаадугаар үеийн өвгө багш Хүй Нэн бол агуу их номын багш. Тэрээр хүний ганц хүү байсан бөгөөд эх нь тэр үед нилээд өндөр настай болсон тул тэр ганцаараа өдөр бүр түлээ хагалж бэлтгэн эхийгээ асарч байжээ. Гэтэл нэг өдөр бусдын “Билгийн чанад хязгаарт хүрсэн очироор огтлогч” хэмээх судрыг уншиж байгааг сонсоод тэр сэхээрч ухаарсан байна. Тэгээд тэр энэ ертөнц ямар ч учир утгагүй юм байна гэж хэлээд бясалгал хийж, нэг их билиг нээгдсэн хүн, нэг их билиг ухаантай хүн болж: “Би хаанаас ирсэн бэ? Би хэн бэ? Бидний амьдрал нэг төрөлдөө яагаад нэг зуун жил бололгүй дуусчихдаг вэ? Яагаад нэг мянга, эсвэл хоёр мянган жил амьдарч болдоггүй юм бэ? Хүний нэг нас яагаад ийм богино байдаг вэ? Хүн болох нь яагаад ийм гашуун зовлонтой байдаг юм бэ?” гэх мэтийн асуудлыг ойлгож авахын тулд багш хайж, бясалгал хийхээр болжээ.

Гэтэл тэр үед түүнд мөнгө байгаагүй тул тэр хэрхэн Багшийг хайж, Мөрийг бясалгах вэ? Нэг найз нь түүнд тусалж, хүрэлцэхүйц замын зардал өгч, бас хүн залж, түүний эхийг нь харж харгалзана гэж амлажээ. Тиймээс тэр Мөрийг хайхаар шуударч, дахин буцаж ирээгүй билээ. Сүүлд нь тэр хамгийн их нэр алдартай даяанч багш болж, мянган жилийн дараа бид бас түүнийг тэгж их хүндэтгэж байгаа юм. Тиймээс Хүй Нэн Их Багш шиг болбол сая жинхэнэ ачлалт хөвгүүн болно. Есүс Христ бас гэрлээгүй, эцэг, эхдээ үлдээсэн үр хүүхэдгүй. Тэр залуу цагтаа Энэтхэгт очиж багшид шавилан бясалгал хийгээд хожим нь энэ дэлхий дээрх хамгийн их нэр алдартай Их Багш болжээ. Үүнийг эцэг, эх нь мэдсэн бол яаж баярлаж баясах байсан бол доо?

Гэрлэх нь ачийг хариулах цорын ганц арга зам биш. Ачийг



хариулахын хамгийн дээд нь бид билиг нээгдэн гэгээрч, Бурханы хутагт хүрээд өөрийн биеэ гэтэлгэхээр барахгүй, эцэг, эхийнхээ болон өөр бусад садан төрлийнхнийхөө сүнсийг гэтэлгэх явдал юм. Учир нь эцэг, эх нь нас барсныхаа дараа диваажинд очоогүй байж тун магад, тэдэнд гүйцэхүйц буян байж гэмээнэ л очиж чадна. Гэтэл та одоо муу хэрэг үйлдэж, жишээлбэл, хүн алах, дээрэм хийх, эсвэл өөр ямар нэгэн муу хэрэг хийх юм бол эцэг, эх тань бас холбогдож, буян нь хасагдах болно. Харин та сайн бясалгаад ёс суртахуунтай, буянтай хүн болбол эцэг, эх тань тэр дороо төрөл дэвшиж, диваажинд очно. Энгийн хүмүүс нас барсныхаа дараа бүгд тун их зовж ганцаарддаг, аварч туслах хүн байхгүй болохоор бүр эрлэг тамын оронд очиж ч магадгүй. Өчүүхэн төдий ял гэм хийсэн ч тамын орноос мултарч, зугтаж чадахгүй болоод тун их төвөгтэй байдаг. Учир нь орчлонгийн хууль нь тун чанга, тун хатуу, хайр сэтгэл болон түгээмэл хайрыг огтхон ч хайхардаггүй.

Хүн ганц бие байхдаа тун их эрх чөлөөтэй байдаг. Гэрлэсний дараа хаа ч очъё гэсэн хялбар биш болно, хүүхэдтэй болсны дараа байдал улам л төвөгтэй болдог. Гэлээ ч энэ нь бас таны хувь хүний дур хүслээр болох хэрэг бөгөөд гэрлэх эсэхээ та өөрөө л шийднэ. Хэрвээ эцэг, эх тань хоёулаа нас барсан, ах дүүс тань аль хэдийнээ гэр бүл болцгоосон бол энэ үед зөвхөн танд л бүх сэтгэлээрээ бясалгаж, өөрийн эцэг, эхээ аварч туслах боломж үлдэнэ. Энэ нь таны үүрэг хариуцлага болох бөгөөд мөн таны ачлалаа илтгэн харуулах хамгийн шууд шулуун арга болох билээ. Хэрвээ гэрлэвэл, та өөрөө бас үйл түйтгэртэй байгаа бол эцэг, эхийнхээ үйл түйтгэрийг яаж үүрэх вэ?

Гэрлэх нь ямар ч тусгүй, гэрлэхгүй байх нь хамгийн ухаалаг хэрэг болохыг би чин сэтгэлээсээ та нарт хэлъе. Зарим хүн гэрлэснийхээ дараа үргэлж уйлж унжиж байдгийг та нар харсан байлгүй, учир нь хүү нь ачлал журамгүй хүн болоод гадагш гарч хэрэг төвөгт орооцолдож, гэртээ ирээд эцэг, эхтэйгээ хэрүүл хийнэ. Та хэдийгээр уйлж, өдөр бүр түүнийг ятгадаг ч, цэгц шударга үг чихэнд хатуу болохоор тэр сонсохгүй. Хүүтэй болсноор л бүх юм сайн болчих биш, учир нь бид төрөл төрөлдөө хичнээн олон өстөн дайсантай байсан бэ? Тэд өшөө хорслоо авахаар бидний хөвгүүн болж төрдөг юм. Хэрвээ бид түүнд тийм боломж өгөхгүй бол хамгийн сайн. Бясалгагч хүн гэр бүлтэй бол илүү хэцүү, хос хоёр хамтдаа бясалгадаг бол харин давгүй сайн байх болно. Тийм биш бол ихээхэн яршиг төвөг үүсэж, нөхөр тань таныг ирүүлэхгүй, эсвэл эхнэр тань таныг явуулахгүй гэнэ, эсвэл хүүхдүүд тань хэрэг тарьж асуудал үүсгэнэ. Ер нь хэзээ ямагт арилгаж барахгүй хэрэг төвөг гарсаар байх болно. Гэрлэхэд үнэхээр сайн гэмээр зүйлгүй, Католик шашны Библи сударт ч бас гэрлэхгүй бол хамгийн сайн гэж дурдсан байдаг.

Та нар Багшийнхаа хэв янзаар амьдарч үзэх үү? Бидний идэж ууж байгаа нь тун хялбар, өдөрт нэг л удаа хоол хийнэ. Өмсөж зүүж байгаа нь тун энгийн, хоёр, гурван хувцсаа сольж өмсвөл болчихно. Ихдээ өдөрт хоёр, эсвэл гурван аяга будаа идэж, үлдсэн цагаар нь бясалгана, ном

судар уншина, ажиллана, унтана. Бид Шагжамуни Бурхан, Есүс Христ, Лууз зэрэг хүнээс суралцаж, эртний богд гэгээнтнүүдтэй адил байж, зөвхөн өөрийн эцэг, эх, ойр төрлөө төдийгүй хамаг төрөлтнийг гэтэлгэж, хамаг төрөлтнийг аврах болно гэж найдаж байдаг. Миний бодоход ийм амьдрал нь бидний эрхэм дээд зорилго юм. Гэрлэх нь зөвхөн өчүүхэн гэр бүлээ гэтэлгэхийн төлөө байдаг, хэрэв та гэрлэхгүй байж гэрээс гарагч болбол маш олон төрөлтнийг гэтэлгэж чадна. Ингэх нь тун их утга учиртай. Гэрээс гарагч байх нь надад их баяр баясгалантай санагддаг. Та нар яагаад ингэдэггүйг би ойлгодоггүй.

Одоо гэрлээгүй байгаа хүнд битгий гэрлээрэй гэж ятгая. Үнэн шүү, та нарын гэрлэх эсэх нь Багшид нь ямар ч хамаагүй, гэтэл хэрвээ Багшаасаа асуух юм бол Багшийнх нь хариулт нь “битгий гэрлээрэй” гэх болно. Энэ бол миний дотоод сэтгэлээсээ хэлж байгаа үг. Одоо Багшийнхаа ятгахыг сонсохгүй байгаад гэрлэснийхээ дараа Багш дээрээ ирж, зовлонгоо уйлан тоочих юм бол Багшийнх нь сэтгэл амаргүй болно. Надад хоёр шавь байсан нь одоо нэгэнт гэр бүлтэй болсон. Урьд нь би тэдэнд гэрлэсний хэрэггүй гэж хэлсэн ч тэд үгэнд оролгүй гэрлэснийхээ дараа үргэлж нулимс урсгаж, гүйж ирээд Багшдаа гомдол зовлонгоо тоочдог юм. Тэгэхэд танд би хэлсэн ч миний үгийг ойшоогоогүй, одоо гомдол зовлонгоо тоочоод ямар хэрэг байх вэ, дэндүү оройтжээ, нэгэнт хүүхэдтэй болчихсон болохоор учир явдал улам ихсэж, уршиг төвөгтэй болно гэж би хэлсэн. Тиймээс би ер нь гэрлэхгүй байхыг хүмүүст ятгадаг, гэвч нэгэнт гэрлэсэн бол гэр бүл салсны хэрэггүй. Би хүмүүст гэр бүлээ цуцлуул гэж зөвлөдөггүй, жишээлбэл, бидэнд нэг хэцүү хүүхэд байгаагаар бодъё. Тэр хэдийгээр муу байсан ч, яалаа ч гэсэн бидний хүүхэд болохоор бид түүнийг ганцааранг нь далайд хаяж орхичихоод хамаарахгүй байж болохгүй. Гэр бүл болох нь бас яг адил. Сайн ч бай, муу ч бай энэ ертөнцөөс ангижиртал хамт амьдрах хэрэгтэй. Учир нь нэгэнт хүүхэдтэй болсон болохоор гэр бүл салах нь хүүхдэд муу нөлөөтэй. Гэтэл хэрэв гэрлээгүй байгаа бол битгий гэрлээрэй. Та нар гэрлээд нэг, хоёр жил болсны дараа л ураг салъя гэж боддог, тэр үед нэгэнт хүүхэдтэй, хайр сэтгэлтэй болсон байдаг учраас хаяж орхиход амаргүй болсон байх болно.

## НОГОО ИДЭХ НЬ Ч БАС ҮЙЛ ТҮЙТГЭРТЭЙ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Тайбэй хот  
1986 оны 9 дүгээр сарын 3 (Эх нь хятад хэлээр)*

Ургамал хоолтнууд бас хүнсний ногоо иддэг. Ногоонд ч бас ухамсар байдаг, гэхдээ ухамсрын хэмжээ нь тун бага, амьтныхаас хамаагүй бага. Мөн амьтны ухамсар нь хүнийхээс бага байдаг. Хүний ухамсар хамгийн дээд, дараа нь том амьтдынх, түүний дараа дунд зэргийн амьтдынх, дараагийнх нь бүүр жижиг амьтад, жишээ нь, шоргоолж, шумуул гэх зэргийнх болно. Тиймээс хүн алах нь хамгийн хүнд гэм нүгэл болно, дараагийнх нь том амьтны амь хөнөөх явдал. Гэмийн хүнд, хөнгөн нь тухайн төрөлтний ухамсрын их, багаас хамааран тогтоогдоно. Ухамсар нь хэдий өндөр дээд төрөлтийг хөнөөвөл гэм нь төдий хүнд, үйл түйтгэр нь ч мөн тийм хүнд болно.

Хүнсний ногоо бас ухамсартай байдаг. Гэвч ухамсрын хэмжээ нь маш бага, ер нь өвс ургамал, хүнсний ногооны ная, ер гаруй хувь нь ус. Гэтэл хүн бол төмөр, мод, ус, гал, шорооноос бүрэлддэг бөгөөд дээр нь нэн дээд дэсийн ухамсартай. Ургамал, хүнсний ногоонд харин усны агууламж тун их. Ихэнх амьтан бас төмөр, мод, ус, гал, шорооноос бүрэлддэг ч хүнийхээс арай доогуур ухамсартай. Гэтэл өвс, ургамал, хүнсний ногоо, жимс жимгэнийн ухамсрын хэмжээ нь тун бага, тэд голчлон төмөр, мод, усны агууламжаас л бүрддэг. Тиймээс та нар бөөрөнхий байцаа, бусад хүнсний ногоо, жимсийг наранд тавибал ус нь ууршиж, тун түргэн хатчихдаг. Тиймээс ногоо идэхийн гэм нүгэл нь хөнгөн, учир нь түүний ухамсар нь тун бага, мэдрэмжээр маш сул тул хүн хөнөөх, эсвэл амьтан хөнөөх шиг тийм хэцүүгээр гаслан зовж шаналдаггүй.

Өвс, модны ярихыг бид сонсож чадна гэж өчигдөр би ярьсан. Зарим хүнсний ногоо бидэнд: “Нааш ир, намайг тасдаад идээрэй, та нар намайг идэж болно, учир нь би идүүлэхэд бэлэн болчихсон шүү.” гэж хэлэхийг бид сонсож болно. Гэтэл зарим нь бас “Надад бүү гар хүр, намайг битгий идээрэй” гэж хэлдэг, учир нь тэд хараахан идүүлэхэд бэлэн болоогүй байдаг. Бясалгал сайтай хүн тэдний ярихыг үнэхээр сонсож чадна. Гэтэл бид бүгд чих дүлий, нүд сохор болохоор сонсдог ч

үгүй, хардаг ч үгүй. Бид зөвхөн хүний үг хэлийг л сонсдог, тиймээс бид амьтанд ямар ч мэдрэхүй байхгүй, тун тэнэг бөгөөд үг ярьж чадахгүй, өвс ургамалд бас ямар ч хүртэн мэдрэхүй байхгүй, юуг ч илэрхийлж чадахгүй, шоргоолж үг ярьж чадахгүй гэх зэргээр ярьдаг. Үнэн хэрэгтээ тэд бүгд ярьж чаддаг, зөвхөн бидэнд л сонсох чадвар байдаггүй. Хүн төрөлтний сонордон сонсох чадвар тун бага, бас тун хязгаартай, хүмүүс хоорондоо ярилцахдаа ч гэсэн байнга эндүүрч андуурч байдаг, эсвэл харилцан ойлголцохгүй, нэгнийхээ хэлсэн үгний утгыг ойлгодоггүй, би цагаан гэж ярихад тэр харин хар гэнэ, тиймээс хэл ам болж муудалцан зодолдохдоо хүрдэг. Тийм биш гэж үү? Зарим хүн зөвхөн тайвань хэлийг ойлгоод хятад хэлийг ойлгодоггүй, зарим нь Багштай нь адил зөвхөн хятад хэлийг ойлгож, тайвань хэлийг ойлгодоггүй. Хүмүүс хоорондоо ч гэсэн үг хэлээр ойлголцоход тун бэрх юм чинь амьтны үг хэлийг ойлгохыг хэлээд яах билээ?

Амьтад өөрийн гэсэн үг хэлтэй байдаг, та нар нохой нь нохойтойгоо, үхэр нь үхэртэйгээ ярилцахыг харж байсан уу? Шоргоолжнууд ч бас хоорондоо ойлголцох өөрсдийн арга хэрэгсэлтэй байдаг, тэд харилцан ойлголцож чаддаг, хэрэв ойлголцдоггүй бол нөгөөгийнхөө санааг хэрхэн мэдэж чадах билээ? Та нар хар л даа, замын хажууд маш олон шоргоолж нааш цааш явахдаа ерөөсөө мөргөлддөггүй, гэтэл бид замаар явж байхдаа машины осол гаргаж мэднэ. Шоргоолжнууд маш нарийн замаар яран нааш цааш гүйлдэхдээ машины осол гаргадаггүй, заримдаа зогсчихоод харилцан ярилцаж байдаг ч ямар ч яршиг төвөг байдаггүй. Үүнээс үзвэл тэд биднээс ч цэцэн сэргэлэн биш үү? (бүгд инээлдэв)

Зарим ургамал, жимс, ногоо бидэнд идүүлэх тун дуртай байдаг. Нэгд, идүүлснийхээ дараа тэд хувьсан өөрчлөгдөж, дэс нь ахиж, ухамсар нь жаахан дээшилдэг, тиймээс тэд “нааш ир, намайг идээрэй” гэж хэлдэг. Хоёрт, хэрэв бид хүнсний ногоо, өвс ургамлыг тасдаж авбал маргааш нь, эсвэл дараа долоо хоногтоо, эсвэл дараа сард нь тэр дахин шинээр нахиалах буюу навчилдаг, тийм биз? Гэтэл гахайн нэг мөчийг огтолбол дахин шинээр ургахгүй, толгойг нь огтолсны хойно дорхноо амьгүй болдог. Гэтэл ихэнх хүнсний ногооны навчийг тасалсны дараа харин бүр ч олон навч ургадаг. Үүнээс гадна мод, цэцгийн салаа мөчрийг тайрахгүй бол иш нь бүдүүрч чадахгүй, тийм биш үү? Хэн нэг хүн салаа мөчрийг нь тайрч засаж арчилбал тэд сахлаг, өндөр болдог. Салаа мөчрийг нь тайрсан ч хатаж хувхайрдаггүй, үргэлжлүүлэн услаад л байвал дахин өтгөн сахлаг болж ургадаг.

Гэтэл гахайны хоёр мөчийг тасдаж аваад усанд хийж тавибал тэр дахин амилж чадахгүй. Үхэр ч адилхан, бид түүнийг гурван хэсэг болгон огтолбол гурван толгой үхэр болчихдоггүй. Гэтэл зарим цэцэг ургамал бол болно, тэднийг томорсны дараа мөчрөөс нь тайраад өөр газарт шилжүүлэн суулгавал урьдынхтайгаа адилхан төрөл янзаар ургаж чадна. Гэтэл хүн болон амьтныг хөнөөснийхөө дараа тэднийг дахин нэг, хоёр, гурав болгон хувиргаж чадахгүй. Үүнээс бид хүнсний ногоог идэж болно, харин амьтныг идэж болохгүйг мэдэж болно, учир нь хэрэв дур

зоргоороо амь хороовол тухайн хүн, эсвэл амьтан үхэх болно.

Би очигдөр та нарт үлгэр ярьж өгнө гэж амалсан. Урьд цагт дундад улсад Гуан Гүн нэртэй нэгэн хүн байжээ, тэр маш урт сахалтай, ув улаан царайтай, түүнд нэгэн хувилгаан сувд байдаг, тийм үү? Тэр энэ хувилгаан могойн сувдаараа амьтны үг яриаг сонсож чаддаг байв. Танай Хятадад бас ийм үлгэр байдаг уу? (Байдаггүй гэж доор байгаа хүмүүс хариулав.) Тийм бол энэ чинь Ау Лакын Гуан Гүн байж таарах нь, (бүгдээрээ инээлдэв) за хамаагүй, Ау Лак, эсвэл хятадын үлгэр бүгд адилхан, Ау Лакт бас нэгэн Гуан Гүн байсан гэж бодъё. Энэхүү Гуан Гүн нь танай хятадын Гуан Гүнээс ялгаатай эсэхийг би мэдэхгүй. Эсвэл хятадын Гуан Гүн Ау Лакт “зугаалах”-аар оччихсон ч юм уу мэдэхгүй, (бүгдээрээ инээлдэв) энэ үлгэрийг миний авга эмээ надад ярьж өгсөн юм.

Гуан Гүн бол нэгэн цэх шударга хуульч, хээл хахууль авдаггүй, тун сайн хүн байжээ гэж авга эмээ маань надад ярьж байсан. Нэг өдөр тэрээр хотын захдуу газраар зугаалж яваад эр, эм хоёр могойг харжээ. Эр могойг явсны дараа өөр нэг эр могой ирж гэнэ. Тэр эр могой өнөөх эм могойг түрэмгийлэн хүчээр эхнэрээ болгох гэжээ. Гэтэл эм могой дургүй байв, учир нь тэр өөрийн эр нөхөртөө маш хайртай бөгөөд тэд хамтдаа олон зулзагатай болжээ. Тэрээр зулзагануудаа асарч харгалзах хэрэгтэй, энэ түрэмгий могойг даган явж, дотносох дургүй байв. Эр могой эм могойтой янаглахыг хүсэж, хүч түрэмгийлж байхыг Гуан Гүн хараад: Ингэж яаж болох вэ? гэж бодоод эм могой болон жижиг могойнуудыг аврахыг хүсэж, тэрхүү түрэмгий могойг нум сумаараа харважээ. Гэтэл Гуан Гүнийг яг харвах үед хоёр могой тун ширүүн тэмцэлдсэний үр дүнд түрэмгий могой нь зугатаах үе нь таарч, эм могой суманд оногдож үхсэн байна. Харвах гэснээ харваад оносонгүй, харвахгүй гэсэн нь харин суманд оногдож үхсэн байжээ.

Тэр үед Гуан Гүн сэтгэл нь маш их зовж, яах вэ гэдгээ мэдэхээ больж, гэртээ харьсныхаа дараа ч тайвширч чадахгүй байв. Эм могойн нөхөр гэртээ ирээд эхнэр нь суманд оногдож үхсэнийг хараад маш ихээр уурлан Гуан Гүнийнд очиж, өшөө авахыг боджээ. Эр могой Гуан Гүний гэрийн дээвэрт нь нуугдаж, Гуан Гүнийг унтсаны дараа түүнийг хатгахаар хүлэв. Гэтэл Гуан Гүн тэр үед ер унтаж чадахгүй байсан тул ном уншиж байжээ. Номоо уншиж дууссаны дараа доорх зарц нартаа: “Тун харамсалтай! Би өнөөдөр хотын зах газраар зугаалж явахдаа нэг түрэмгий эр могой эм могойг муу хэрэг үйлдүүлэх гэж хүчилж байхыг хараад тэр түрэмгий могойг алах гэсэн чинь харин тэр зугтаж, эм могой нь миний харвасан суманд оногдоод үхчихлээ. Уг нь би түүнийг аврах гэсэн юм, гэтэл эсрэгээрээ түүнийг хорлочихлоо, тиймээс одоо ч сэтгэл маш их шаналж байна” гэж ярьжээ.

Тэр эр могой үнэн учрыг олж сонссоныхоо дараа Гуан Гүн зориудаар эхнэрийг нь алсан биш гэдгийг мэдээд сэтгэл нь тун догдолжээ. Тиймээс Гуан Гүнийг алах санаагүй болж, гэрийнх нь дээврээс бууж ирээд Гуан Гүнд: “Би танд маш их баярлалаа, намайг өршөөгөөрэй, уг нь би

эхнэрийнхээ өмнөөс өшөө авч, таныг алахаар ирсэн юм. Одоо хэргийн үнэн зөвийг сайн ойлгосон болохоор танаас өшөө авахгүйгээр барахгүй тэр үед шударга ёсыг хамгаалсан таны сэтгэлд талархаж, танд нэг бэлэг өгье” гэв. Тэгээд тэрээр бөөлжин гэдэснээсээ сувд гаргаж, Гуан Гүнд өгөхдөө “Энэ эрдэнэ байвал амьтны ярихыг сонсож чадна, хэрэв надаас тусламж шаардлагатай бол энэ сувданд хандан хэлбэл би дорхноо хүрч ирнэ” гэжээ. Учир нь энэ могой энгийн могой биш, хувилгаан могой, бясалгал хийсэн могой байж л дээ. Ургамал хоол иддэг могой ч байж магад. (бүгдээрээ инээлдэв).

Энэ үлгэрт бид амьтны яриаг сонсож болохыг илэрхийлсэн байна. Гэхдээ заавал Гуан Гүн болж хувирах, эсвэл хувилгаан могойн сувдыг олбол л сонсож чаддаг биш, бидний бясалгал өндөрссөний дараа бид бас сонсож чадна. Энэтхэгт нэг франц эмэгтэй байжээ, тэр нас бараад удаагүй. Тэр Энэтхэгт бясалгал хийхээр очоод хожим нь нэгэн Их Багштай тааралджээ, энэ Их Багш одоо дэлхий дахинд алдартай. Тэр франц эмэгтэй бас амьтан, эсвэл өвс ургамлын ярихыг сонсож чаддаг байжээ, энэ тухайгаа тэр өөрөө ярьсан байдаг. Тэднийх ногооны хашаатай, хүнсний ногоогоо өөрөө тарьдаг. Тэр хэлэхдээ, заримдаа ногооны хашаандаа ороход зарим ногоо нь, “Нааш ир, нааш ир, намайг тасдаж идээрэй” гэж хэлдэг, зарим ногоо нь харин “Үгүй, үгүй, надад битгий гар хүр” гэж хэлдэг, тиймээс тэрээр түүнд идүүлэх дуртай ногоог л авч иддэг байсан гэжээ.

Нилээд дээр үед, миний хэддүгээр үеийн өвгө багш байсныг мэдэхгүй юм, нэгэн өдөр нэг хүн модноос цэцэг тасдаж аваад түүнд өргөл өргөжээ. Энэ мод үхсэнийхээ дараа хүний төрлийг олсон байна, учир нь тэр урьд төрөлдөө нэгэн “Амьд сэрүүн Бурхан”-ны өргөл болсноор ийм их буянтай болжээ. Жинхэнээр гэгээрсэн Их Багш бол Бурхан мөн. Тиймээс түүнд өргөл болгосны дараа дорхноо хүний төрлийг олж чадсан байна. Гэвч хүний төрлийг олсны дараа тийм ч цэцэн сэргэлэн биш, тэр ч байтугай энгийн хүнээс ч ядмаг байдаг.

Энэ хүн том болсныхоо дараа бас нэгэн Их Багштай учирч, түүнийг дагаж бясалгал хийсэн байна. Гэтэл нэг өдөр тэр маш хүндээр өвчилсөнд гэрийнхэн нь түүний дотоодын Их Багшаас аврал гуйж, хүүхдэд минь хурдан эдгэрэхэд нь туслаарай хэмээн даатгажээ, гэтэл ямар ч нэмэр болсонгүй. Уг нь Их Багш нар: “Та нар юу л хүснэ, дотоодын Их Багшдаа даатгадаг л юм бол бүгд биелнэ” гэж хэлдэг. Багш нь ч бас та нарт үргэлж ингэж хэлдэг. Гэтэл тэр үед гэр бүлийнх нь хүмүүс яаж даатгасан ч огт нэмэр болсонгүй, хүүгийнх нь өвчин ноцтой хүнд хэвээр, тиймээс эцэг, эх нь түүний багшид нь сэжиг төрж: “Бид ганцхан ийм нэг хүүтэй, тэр маань ийм том болчихсон, тэгээд бас таныг дагаж бясалгал хийдэг байтал танаас аврал гуйхад яагаад жаахан ч тусалсангүй вэ? Одоо хүү минь үхлийн даваан дээр тэлчилж, бид маш шаналан зовж байна” гэжээ. Аав, ээж нь ингэж хэлсэн нь багшид нь итгээгүйгээс болсон хэрэг.

Үхлийн даваан дээр зовж шаналж байгаа хүү нь эцэг эхийнхээ багшид нь гомдоллож байхыг сонсоод: “Би удахгүй нас барна, одоо би

өөрийн өнгөрсөн үйл үрээ ойлгосон. Миний нас барах болсонд багшийн минь буруу байхгүй, мөн та нар багшаас аврал гуйхад багш мэдэхгүй байгаа юм биш. Учир нь юу вэ гэвэл, би урьд төрөлдөө нэгэн мод байжээ, угаас модноос хүний төрлийг олоход заавал маш урт хугацааг туулж, үхэж, төрөх элдэв янзын сансрын хүрдэнд эргэлдэж байж л алгуураар хүний дэсэд хүрдэг. Гэтэл нэг хүн миний мод-бие дээр дэлгэрсэн цэцгийг тасдаж аваад нэгэн амьд сэрүүн Бурханд өргөл болгосон болохоор энэ удаад би хүний төрлийг олсон ч тийм ч урт насалж чадахгүй бөгөөд тийм ч цэцэн сэргэлэн биш. Гэвч надад ийм буян байсан болохоор нэгэн Их Багштай тааралдах боломж олджээ. Тааралдсаны дараа ч миний дэс тийм ч өндөр биш болохоор дорхноо туулан гэтэлж чадахгүй, тиймэсн одоо явах хэрэгтэй, дараа төрөлдөө дахин хүний төрөл олбол бүрмөсөн туулан гэтлэх болно. Та нар санаа зовох хэрэггүй, би одоо ертөнцөөс салахад хамгийн тохиромжтой цаг байна” гэж тэдэнд ятган хэлжээ.

Тиймээс Багш нь зарим ургамал бидэнд идүүлэх дуртай, онцгойлон бясалгал хийдэг хүмүүс идвэл тэд маш их буянтай болдог гэж саяхан ярьсан. Уг нь өвс ургамлаас хүн болоход алгуур аажмаар заавал маш олон дэсийг туулах хэрэгтэй байдаг. Эхлээд чулуу болно, дараа нь мод, өвс ургамал болж хувирна, дараа нь жижиг шавж хорхой болж, дараагаар нь хулгана, туулай, муур, нохой зэрэг жижиг амьтан болж хувирна. Тэгээд бар, заан, сармагчин болж хувираад, хамгийн сүүлд хүн болдог. Гэвч энэ модон дээрх цэцгийг хүн тасдан авч, нэгэн Их Багшид өргөн барьсан болохоор дэс нь дорхноо маш олон дэсийг даван туулж, тийм их доор дэсийн сансрын хүрдэнд эргэлдэх хэрэггүй болжээ. Гэтэл хүний төрлийг олсны дараа дорхноо хамгийн цэцэн сэргэлэн, хамгийн шилдэг сайн хүн болж чадахгүй, тиймээс дахин нэг төрөл авах хэрэгтэй болно.

Тиймээс бид юм идэх бол жимс, хүнсний ногоо идвэл зүгээр, амьтныг идэх нь сайн үр дүнд хүргэхгүй. Учир нь амьтдын үйл түйтгэр дэндүү хүнд, дээш татахын аргагүй бөгөөд тийм ч түргэнээр тэднийг гэтэлгэх боломжгүй байдаг. Бидний үйл түйтгэр бас тийм их байгаа болохоор бид тэднийг өөрсдөө аварч гэтэлгэж чадахгүй, өөрийгөө гэтэлгэж чадахгүй байж хэрхэн амьтны махыг идчихээд тэднийг гэтэлгэж чадах вэ? Зарим хүн амьтныг идэх нь тэднийг аварч, туулан гэтэлгэж байгаа хэрэг гэж ярьдаг, энэ бол үнэхээр ямар ч утгагүй яриа. Хэрэв та тэр хүмүүс амьтныг үнэхээр гэтэлгэчихсэн байхыг нь харсан бол тэдэнд үнэмшиж болно. Үгүй бол амьтан иддэг хүмүүс зөвхөн амьтдын үхэхээсээ өмнө айн дагжиж, орилон чарлаж, амь тавин тэлчилж, шаналан зовохыг л хардаг. Тэд таныг амийг нь хороож, идэхээс айдаг. Та амьтдыг идсэнээр тэд туулан гэтэлж чаддаг биш, эсвэл илүү дээд дэсэд хүрдэг биш. Тиймээс амьтныг идэх нь түүнийг гэтэлгэж байгаа хэрэг гэх аймшигтай бодол өвөрлөж болохгүй.

Та нарт өөр асуух зүйл байна уу?

**Асуулт:** - Өвчлөх нь бас нэг зүйлийн буян гэж би сонссон. Гэтэл эгэл хүмүүс, өвчлөх нь урьд төрөлдөө үйлдсэн гэм нүгэл, үйл түйтгэрээ энэ төрөлдөө эдэлж байна гэж үздэг, хэрэв ингэж ярих нь зөв юм бол



яагаад өвчлөх нь бас нэг зүйлийн буян гэж ярьдаг вэ?

**Их Багш:** - Учир нь “Нисванис бол бодь юм”. Тиймээс бид баяр баясгалантай хандлагаар хүлээн авбал зохино. Хэрэв та түүний утга учрыг ойлговол тэр бол буян хишиг, ойлгохгүй бол үйл түйтгэр. Өвчлөх нь яагаад буян болох вэ? Учир нь өвдөхгүй бол бясалгахыг бодохгүй, хүний амьдрал мөнх бус гэдгийг мэдэхгүй, зөвхөн ажил, сургуульдаа явна, мөнгө олоод өдөр бүр ертөнцийн жаргалыг эдлэн бид хэн бэ гэдгээ мартана. Бид хаанаас ирсэн бэ? Юуны төлөө энэ ертөнцөд ирэв? Би хэн бэ? Хүний амьдрал яагаад зуун жил төдийхөн л байдаг вэ? Яагаад хоёр зуун жил, мянган жил болдоггүй вэ? Хүн болгон яагаад заавал төрөх, өтлөх, өвдөх, үхэх явцыг туулах ёстой байдаг вэ? гэх мэт хамгийн том, хамгийн чухал асуудлаа бид мартчихдаг.

Хэрэв бид өвддөггүй бол энэ асуудал, энэ үхэж, төрөхийн тухай хэргийг бодохгүй. Хэрэв үхэл ирэхийг хүлээдэг ч нас барах үедээ л бодож санавал эндүү оройтно. Тиймээс өвчлөх нь биднийг дуудан сэрээж, өвчилсөн шалтгаанаа ухаарах боломж олгодог. Энэ бие махбод үнэнхүү төвөгтэй, яагаад өвчилдөг юм бэ? Өчигдөрхөн бие бялдар сайтай, хүч чадалтай байснаа яагаад өнөөдөр ийм сүл дорой, хөдөлж чадахаа больчихов? гэж бодно. Тиймээс ухаарч сэхээрч, үхэж, төрөхийн тухайд өргөн хүрээгээр бодох хэрэгтэй, тэр үеэс л жинхэнэ Их Багшийг хайж олохыг хүсэж магадгүй. Хэрэв жинхэнэ бясалгалын номын цогцосыг хайж олбол төрөх, өтлөх, өвдөх, үхэхээс мултарч чадна. Та нар ойлгож байна уу? Ийнхүү өвчлөх нь бас буян болж хувирч болно. Тиймээс Бурхан Багш: “Нисванис бол бодь мөн.” гэжээ. Гэтэл ингэж сэхээрэхгүй бол бас буянд тооцогдохгүй.

**Асуулт:** - Үйл түйтгэр нь хүнд байвал ургамал болж хувирдаг уу? Хэрэв тийм бол түүнийг идвэл тэр нь бидэнд нөлөөлөх биш үү?

**Их Багш:** - Тэдний үйл түйтгэр нь хүнд болохоор ургамал болж хувирсан боловч ухамсар нь тун бага. Үүнийг би аль хэдийн ярьж өгсөн. Ойлгов уу?

Ургамлын ухамсар нь тун бага болохоор тийм ч ихээр зовж шаналдаггүй. (Миний ярьсан санаа бол, ургамлын үйл түйтгэр тун хүнд болохоор бидэнд нөлөөлөхгүй гэж үү?) Үгүй ээ, ургамлын бүтцийн хагасаас илүү хувь нь ус, сүнс нь тун бага, ухамсар нь тун доогуур болохоор бидэнд тийм ч ихээр нөлөөлөхгүй. Ухамсар нь хэдий чинээ дээгүүр бол бидэнд төдий чинээ их нөлөөлнө, учир нь түүний хүч нь харьцангуй их байна, гэтэл ухамсар нь доогуур бол хүч нь тун бага байдаг.

Ургамлыг идэх нь бас үйл түйтгэртэй, гэвч бид өдөр бүр хамгийн багадаа хоёр цаг хагас Арьяабалын аргаар бясалгаж суувал өчүүхэн үйл түйтгэрийг тун түргэн арилгаж чадна. Гэтэл бясалгал хийдэггүй хүмүүсийн хувьд тэд мөн л үйл түйтгэртэй байсаар байна. Ургамал, хүнсний ногоо, жимс идэх нь бас үйл түйтгэртэй. Юу ч идсэн бүгд үйл түйтгэртэй, амьсгалахад ч бас үйл түйтгэртэй, учир нь агаарт тоолшгүй

олон нян байдгийг бид хардаггүй, биднийг амьсгалах үед тэд бүгд үхдэг, эсвэл тэд бидний биетэй шүргэлцэхдээ л үхдэг, ингэх нь бас үйл түйтгэртэй. Та онцгойлон ямар нэг зүйл хийгээгүй ч үйл түйтгэр үүсгэж байдаг, бид төрмөгцөө л үйл түйтгэр үүсгэчихдэг.

Тийм учраас бясалгах хэрэгтэй. Багшийнхаа заасан номын ёсоор өдөр бүр хамгийн багадаа хоёр цаг гучин минут Арьяабалын аргаар бясалгавал ямар ч үйл түйтгэрийг бүгдийг арилгаж чадна. Гэтэл хэрэв хүн бясалгахгүй бол түүний төрөл төрөлдөө сансрын хүрдэнд эргэлдэж үүсгэсэн үйл түйтгэр нь хэзээ ч арилахын аргагүй. Жишээ нь: Бид ажиллахгүй бол орлогогүй байна, тиймээс энэ хүнд хоёр төгрөг, тэр хүнд арван төгрөг, өөр нэг хүнд нэг зуун төгрөгийн өртэй болж, өдөр бүр зээл авч өр маань улам бүр хуримтлагдсаар, хэзээ ч буцааж төлөхийн аргагүй болно. Гэтэл бид өдөр бүр чармайн ажиллаж мөнгө олдог бол хүрэлцээтэй амьдарч чадна. Амьдралын төлөө адилхан мөнгө зарцуулдаг байлаа ч нэг нь өдөр бүр ажиллаж амьжиргааныхаа мөнгийг олдог, нөгөө нь харин зээлээр амьдралаа залгуулж байгаа болохоор үр дүн нь огт адилгүй.

Бясалгалтнуудад бас үйл түйтгэр байдаг, гэтэл өдөр бүр Арьяабалын аргаар бясалгадаг болохоор үйл түйтгэртэй боловч дорхноо арилгачихдаг, өөрийн үйл түйтгэрээ арилгахаас гадна бас илүүдэл буянаа бусдад өгч болдог, тиймээс бясалгах хэрэгтэй. Бясалгадаг, эсвэл бясалгадаггүй хүнийг гаднаас нь харахад ямар ч ялгаагүй, бүгд л өдөр бүр идэж, унтаж, өмсөж, мөнгө олж байдаг ч үр дүн нь огтхон ч адилгүй байдаг.

**Асуулт:** - Хамгийн жижиг амьтны ухамсар нь хамгийн бага байдаг уу?

**Их Багш:** - Тийм.

**Асуулт:** - Хэрэв цэцгийг таслаад бурханд өргөл болговол билиг ухаантай болдог гэж зарим хүн ярьдаг, би үүнийг тийм ч баталгаатай гэж боддоггүй, ингэх нь сайн уу, эсвэл муу юу?

**Их Багш:** - Сайн, бас сайн биш. Хэрэв энэ бурхан нь амьд сэрүүн Бурхан байвал сайн, модон бурхан бол сайн биш. Модон бурхан бидэнд ямар ч буян өгч чадахгүй, харин амьд сэрүүн Бурхан бол чадна, тиймээс адилгүй. (Гэтэл замбага цэцгийг маш олныг худалдаж аваад сүм хийдийн тахилын ширээн дээр өрдөг бурхны шашинтнууд олон байдаг.) Тэд үнэн учрыг ойлгодоггүй болохоор үргэлж маш олон буруу зүйл хийдэг. Тэд бурханд мөргөхөөр сүмд очихдоо бас мах идэж, архи уудаг. Хэрэв зүгээр л эгэл хүн байж энэ насаа харанхуй мунхагаар өнгөрөөе гэвэл юу хийсэн ч болно.

Гэтэл бясалгалтан юу нь сайн, юу нь муу гэдгийг мэдэх хэрэгтэй. Би энэ бүхнийг зөвхөн бясалгалтанд л зориулж ярьсан, энгийн хүмүүс маш олон хэрэг явдал үйлддэг болохоор би тэднийг бүгдийг нь хамаарч чадахгүй. Бидний номын бясалгалд цэцэг өргөх шаардлагагүй, би ерөөс та нараар шинэхэн цэцэг, жимс, эсвэл ямар нэг юмаар өргөл өргөхийг

зөвшөөрдөггүй. Хүж уугиулах, цэцэг өргөх ч шаардлагагүй. Багшийнх нь дотоодод маш олон цэцэг бий, мөнхийн бус цэцэг хэрэггүй, хоёр хоног болоод л хатаж хувхайраад гандчихдаг. Миний цэцэг өнө мөнх оршдог, бидний дотоодын цэцэг тун гэрэлтэй, тун үзэсгэлэнтэй, бусад хүн харж чадахгүй, зөвхөн бид өөрсдөө л таашаал авч чадна, бид жаргалаа өөрсдөө эдэлж барахгүй бол бас бусадтай хуваалцаж болно, шавь нартайгаа хуваалцан эдэлнэ, Багш нь ганцаараа эдэлж барахгүй. Энэ цэцэг мууддаггүй, чухам энэ дотоодын мөнхийн цэцгээр өргөл өргөх нь л жинхэнэ өргөл өргөж байгаа хэрэг билээ.

Та нар өдөр бүр бясалгаж суух үедээ дотоодын цэцгээ харах юмуу, өөр бусад зүйлийг харахад бүгд л тун үзэсгэлэнтэй байдаг, энэ бясалгалын “сэтгэлээ” л бурханд өргөж болно. Бясалгаж суух үедээ харсан хүслэнт ахуйгаа бурханд өргөж болно. Энэ бол хамгийн сайн өргөл. Харин иймэрхүү өмхийрсөн, хорхойтсон, зөгийд идүүлсэн цэцгээр бурханд өргөл өргөх нь ямар ч буянгүй, амьд сэрүүн Бурханд өргөсөн ч ямар ч буян хишиггүй. Угаас амьд сэрүүн Бурханд цэцэг хэрэггүй, гэтэл зарим хүн ойлгодоггүй, чин сэтгэлтэй боловч юугаар өргөл өргөхөө мэддэггүй болохоор хэдэн багц цэцэг аваад амьд сэрүүн Бурханд өргөн барьдаг. Тэрээр нигүүлсэнгүй сэтгэлээсээ болоод л өргөсөн цэцгийг нь хүлээж авдаг. Ингэснээр л сая өргөл өргөсөн хүн буянтай болдог бөгөөд тэр цэцэг ч буянтай болдог.

Гэтэл модон бурхныг тахивал цэцгийг тань хүлээн авах эсэхээ илэрхийлэхгүй, цэцгийн дэлгүүрийн цэцгийг бүгдийг нь түүнд өргөсөн ч нэг ч үг хэлэхгүй, ингэхлээр таны өргөсөн цэцэгт дуртай байгаа эсэхийг нь хэрхэн мэдэж чадах вэ? Модон Бурхан цэцэгт дургүй байж ч мэднэ шүү дээ! (Бүгдээрээ инээлдэв).

## ХЭНИЙГ БУРХНЫ ШАШИНТАН ГЭХ ВЭ?

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Формоса, Пенхү хот  
1987 оны 2 дугаар сарын 15 (Эх нь хятад хэлээр)*

Та нарыг судар ном унших гэхээр би ”битгий унш” гэж хэлдэг, бурхныг дурсах гэхэд бас “дурсах хэрэггүй”, зөвхөн өөрийнхөө дотоодын бурхнаа хайж олоорой гэдэг. Үнэхээр хачин жигтэй Багш байна, яагаад ингэж сургадаг юм бол? гэж та нар боддог байх, надад яримаар зүйл их байна, гэвч богинохон хугацаанд ярьж амжихгүй, долоо хоног гэдэг дэндүү богино, бүр хэдэн жил байсан ч хангалттай ярьж чаддаггүй. Шагжамуни Бурхан ч бас л ингэж, заримдаа тун олон зүйлийг ярьж, заримдаа юу ч ярих хүсэлгүй болоод сэтгэл дотроо зөрчилдөөд байх шиг байдаг байж, учир нь ярих гэхээр сэтгэлд нь хүрэхгүй, хичнээн их ярьсан ч хангалттай сайн байж чадахгүй, ярихгүй байя гэхээр бас болохгүй, тиймээс сэтгэл дотроо зөрчилддөг байжээ.

Шагжамуни, Бурханы хугагт хүрснийхээ дараа: “Хамаг төрөлтнийг гэтэлгэхээ больё, тэднийг гэтэлгэхэд бэрх, Нирваандаа буцаж, амар амгалангийн жаргал эдлэх нь хамгийн сайн” гээд толгой сэгсэрч байжээ. Гэвч Эсэрваа тэнгэр илрэн гарч ирээд түүнд мөргөн “Та битгий яваарай, эндээ үлдэж хамаг төрөлтнийг гэтэлгээрэй” гэж гуйсан байна. Эсэрваа тэнгэр: “Нүд нь бүрмөсөн сохроогүй хүн их байна, тэд харж чаддаг, зарим хүний сонор нь нэгмөсөн хаагдчихаагүй, тэд сонсдог, та битгий яваарай, бүрмөсөн харанхуй мунхаг болчихоогүй тэр хүмүүст зааж сургана уу!” гэжээ.

Хожим нь Шагжамуни Бурхан ертөнцөд үлдэж дөчин есөн жил болжээ. Хичнээн олон төрөлтнийг гэтэлгэснийг та нар мэдэх үү. Тийм ч олон биш. Энэтхэгийн нутаг дэвсгэр өргөн уудам, ертөнцийн төрөлтөн тийм олон байхад тэрээр хэдхэн арван мянган хүнийг л гэтэлгэсэн төдий, дөчин есөн жил зовж зүдэрч байж гэмээнэ хэдхэн арван мянган хүнийг гэтэлгэсэн нь үнэхээр тийм их биш. Тиймээс ном тайлах нь огтхон ч хялбар явдал биш билээ. Ялангуяа Үнэн ёсыг тайлахад тун амаргүй, харин энгийн ном судрыг тайлахад хялбар, ном, эсвэл судрыг дэлгээд эхнээс нь дуустал уншвал болчихно, ямар ч асуудалгүй, мэдлэгтэй л бол болчихно.

Гэвч Үнэн ёсыг тайлахад амаргүй, шалтгаан нь хоёр зүйлд бий. Нэгд, Үнэн ёсыг зөвхөн тун цөөхөн хүн ойлгож хүлээн авч чадна, ихэнх

хүн бүгд л адилхан зүйлийг яриад ганц, хоёрхон хүн л тэдэнтэй адилгүй Үнэн ёсыг яривал хүмүүс эргэлзэж сэжиглэдэг. Хоёрт, Бид нэгэн Их Багшаас олон жилээр суралцаж байж ойлгодог, тэгэхгүй бол жинхэнэ Их Багш долоо хоног, эсвэл нэг сарын богинохон хугацаанд “гүн далд, нууцлаг гайхамшигт ном”-ыг ярьж дуусгах боломжгүй.

Нэгэн Их Багшийг ойлгоё гэвэл өөрөө бясалгаж, өөрөө Их Багш болсны дараа л жинхэнээр нь ойлгож чадна. Тиймээс Шагжамуни Бурхан: “Наймдугаар төвшний бодьсадвагийн дэсэд хүрлээ ч гэсэн Бурхныг ойлгож чадахгүй, наймдугаар төвшний бодьсадвагийн дэсийг туулан гарвал л сая Бурхныг ойлгож чадна. Бурхныг ойлгоё гэвэл заавал Бурхан болох хэрэгтэй” гэжээ.

Багш нь ном тайлсан эхний өдөр аливаа шашны бүлгүүд угаас бүгд адилхан, гэвч улирч хувирсаар адилгүй болжээ гэж ярьсан. Би бүгд адил гэсэн нь хамгийн эхэн үеийн байдлыг ярьсан хэрэг, гэвч одоогийн шашны бүлгүүд эхэн үетэйгээ адилгүй болжээ, хүмүүсийн буруу ойлголтоос шалтгаалж, шашны бүлгүүдийн хооронд зөрөө бий болжээ. Учир нь жинхэнэ Их Багш, шашны эзэн Нирваандаа буцаж, ном судар, шашны эзний жинхэнэ санааг ойлгож чаддаг гарамгай шавь байхгүй болж, бүгд л эгэл хүмүүсийн үзэл бодлоор, эмх замбараагүй сургадгаас болж байгаа юм. Энэ нь харин сургаал ёс адилгүйгээс болсон юм биш шүү.

Жинхэнээр гэгээрсэн хүн аливаа ном судрыг нэвт ойлгож чадна, тэрээр энэ “гүн далд, нууцлаг гайхамшигт ном”-ыг ойлгодог бөгөөд аливаа шашны бүлэг бүхэн угаасаа нэгэн ижил номын цогцосыг сургадгийг мэднэ, гэвч шашны эзэн Нирваандаа буцсаны дараа гарамгай сайн шавь байхгүй, ном уламжлах хүн байхгүй болохоор тэр шашны бүлэг алгуураар уруудан буурдаг, хожим өөр нэгэн гэгээрсэн хүн гарч ирээд адилхан номын цогцосыг сургахад өнөөх хэдийнээ уруудан буурсан шашны бүлгийнхэн харин тэр номын цогцосыг танихаа больсон байдаг. Энэ нь удаан хугацаанд сайн шавь байхгүй, номын цогцосыг сургах хүн байхгүйгээс болсон хэрэг. Одоо хэн нэгэн хүн гарч ирээд тэр номын цогцосыг сургахад тэдний хувьд яг л харийн зүйл шиг танил бус санагддаг болохоор тэд яваандаа маш олон шашны бүлэг болон хувирчээ.

Одоо энэ дэлхийд хичнээн түмэн шашны бүлэг бий болсныг хэлж мэдэхээргүй тийм олон бүлэг, жижиг урсгал болж хувирчээ. Буддын шашин бас маш олон урсгал бүлэгтэй болжээ, нууц тарнийн бүлэгтэн, ариун орны бүлэгтэн, тянтай бүлэгтэн, лин чи бүлэгтэн, човдун бүлэгтэн, одоогийн Япон улсад бас лианы бүлэгтэн гэж байдаг, тэд бүгд л Наму гэтэлгэгч Олонх бурхант судрыг аялгуулан уншдаг. Гэтэл Шагжамуни Бурхан ингэж сургаагүй, тэр бас “Би хэн бэ?”, “Хэн бурхныг дурсаж байна вэ?” гэх мэтээр ном хаялцахыг сургаагүй. Бид ном судрыг нь уншиж үзвэл Шагжамуни Бурхан цан, тогшуур хэрэглэж өглөө, оройн уншлага хийх, эсвэл гүрэм ном уншин хамаг төрөлтнийг гэтэлгээгүй болохыг олж мэдэж болно, гэтэл одоо бүгд л ийм зүйлс үйлдэх болжээ.

Учир нь Бурхны шашин аль нэгэн оронд хүрээд тухайн орны зан заншил, дадал зуршил, уламжлалд нөлөөлөгдөж улмаар өөр урсгал бүлгүүд болж хувирдаг. Өөр урсгал бүлгүүд болсон ч гэлээ, хэрвээ сайн шашны эзэн, эсвэл сайн Их Багш байхгүй бол тэр бүхэн хэрэггүй юм. Түүнчлэн Католик шашин, Бурханы шашин, Бумбын сургаал, Күнзийн сургаал гэх мэт шашны эзний сургаал ёсыг жинхэнээр нь ойлгож чадахгүй бол бас л хэрэгцээгүй. Учир нь Католик шашинд хүмүүсийг мах битгий идээрэй, цустай амьтныг битгий идээрэй гэж сургадаг. Эзэн Бурхан: “Би та нарт идүүлэх гэж маш олон ургамал ногоог бүтээсэн” гэжээ. Тэр биднийг амьтны амийг хороож ид гээгүй, гэтэл одоо католик шашинтнууд бүгд л амь хороодог.

Бидний бурхны шашинтнууд ч мөн адил, Шагжамуни Бурханы сургаалыг жинхэнээр дээдлэн сахидаг хүн байна уу? Тун ч цөөхөн, гэрээс гарагчид ч бас адил, нууц тарнийн бүлэгтэнд мах идэж, архи ууж, гэрлэх нь ямар ч асуудалгүй. Японд бас адил архи ууна, мах иднэ, гэрлэнэ, бүгд болно. Солонгост одоо үед 50 хувь нь ийм байдалтай. Өөр бусад орон, жишээ нь: Тайланд, Бирм, Шри Ланк зэрэг миний очиж үзсэн орны бурхны шашинтнууд бүгд л ийм. Тиймээс өнөөдөр жинхэнэ бурхны шашинтан тун цөөхөн, жинхэнэ католик шашинтан, жинхэнэ бумбын сургаалтан, жинхэнэ күнзийн сургаалтан тун цөөхөн гэж баттай хэлж болно. Тэд юу ярьж байлаа ч үнэн хэрэгтээ жинхэнэ бясалгагч тун цөөн.

Бурхны шашинтан гэж хэнийг хэлэх вэ гэвэл би хэн нэг маш сайхан сэтгэлтэй, ёс суртахуунтай, өөрөө бясалгал хийдэг, наад зах нь амь хороохгүй, хулгай хийхгүй, архи уухгүй, худал ярихгүй, садар самуун явахгүй гэсэн таван сахилыг сахидаг хүнийг хэлдэг. Хэрэв Есүс Христэд итгэдэг хэдий ч энэ таван сахилыг сахидаг бол бас л бурхны шашинтан мөн. Учир нь Есүс Христ бол аугаа бодьсадва билээ, тэрээр загалмайд хадуулан маш ихээр зовж, шаналж байсан ч түүнийг хорлосон тэр хүмүүсийг адислаж, Эзэн Бурханаас тэднийг өршөөхийг гуйж байжээ. Учир нь тэд харанхуй мунхаг бөгөөд юу ч мэддэггүй байсан хэрэг.

Та нар бодоод үзээрэй, эгэл хүмүүст тийм өршөөнгүй сэтгэл байдаг уу? Байдаггүй. Хүмүүс биднийг жаахан загнамагц тэр дороо л уурладаг байтал, бид загалмайд хадагдах үед биднийг загалмайд хадаж буй хүнийг адислах талаар бүр ярихын ч хэрэггүй. Ийм боломж огт байхгүй, зөвхөн дээд төвшний бодьсадва л ийм их нигүүлсэнгүй сэтгэлтэй байж, бусдад хорсдоггүй, бусдад хөнөөгдсөн ч түүнд хорсол төрдөггүй. Үүнээс үзвэл Есүс Христ бол дээд төвшний бодьсадва, тэрээр юу ч сургасан байлаа ч тэр бол нэгэн аугаа Их Бодьсадва мөн.

Харин би тийм, ийм номын багшийг шүтэн дагалаа, надад ийм, тийм номын нэр бий гэж яривал бурхны шашинтан болчихдог юм биш, тийм биш ээ, жинхэнэ бурхны шашинтан бол зөвхөн ийм л байдаг юм биш. Жишээ нь: та католик шашинтан, хүүхэд байхаасаа Есүс Христэд дуртай, түүнийг маш сайн гэдгийг мэддэг, том болсныхоо дараа та нигүүлсэнгүй сэтгэл үүсгэж, амь хороохгүй (мах идэхгүйг багтаана),

хулгай хийхгүй, архи уухгүй, худал ярихгүй, садар самуун явахгүй гэх сахилыг чанд сахидаг, бясалгал хийдэг, бас жинхэнэ Их Багшийг олж, түүнээс бясалгах аргыг сурч байж мэднэ. Гэвч та өдөр бүр сүмд очиж, ном сонсоно, Есүс Христэд залбирна, гэхдээ бас өөрөө бясалгаж суудаг, Арьяабалын номын цогцосыг бясалгадаг, ургамал хоол иддэг, таван сахилыг сахидаг байгаад нас барсны дараа диваажинд очвол Шагжамуни Бурхан: “Таныг харахад тун ч ёс суртахуунтай, бясалгалаар өндөр, Арьяабалын номын цогцосыг бясалгадаг, ургамал хоол иддэг, таван сахилыг бас тун тодорхой сахидаг юм байна, гэвч та Есүс Христэд итгэдэг болохоор гадаад номтон, би таныг энд Нирваанд орохыг зөвшөөрөхгүй, би таныг эндээс хөөж буулгана” гэж ярих уу? (Бүгдээрээ инээлдэв) Ийм хэрэг үүсэх үү? Мэдээж, үгүй.

Учир нь бид өөрсдийн эгэл хүний сэтгэлээр л Бурхан, Бодьсадва, Их Багшийг үнэлдэг. Тиймээс л Их Багшийг гадаад номтон, дотоод номтон гэж ярьдаг. Үнэн хэрэгтээ, та нар угаас “Мөр ёс” гэж юу болохыг ойлгодоггүй, харин ойлгосон хойноо бол ярьж болно. Дөнгөж бясалгаж эхлээд тийм ч удаагүй байж бурхнаас тийм ч ихийг сурчихгүй, Авид Бурханы судар номыг ч уншаагүй, их сайндаа л Оточ Бурханы судар, Хотол зохилдогч зүйлийг уншсан төдийхөн байж, номын багшийг гадаад номтон, дотоод номтон гэж шүүмжилж зүрхэлдэг.

Зарим хүн Багшаас нь та И Гуан Дао-той адилхан зүйлийг ярьдаг гэж асуух юм, би угаас И Гуан Дао гэж юу болохыг мэдэхгүй, гэвч тэдний сургаал ёс нь минийхтэй адил бол зүгээр. Би дөнгөж Тайваньд ирсэн болохоор юуг И Гуан Дао, юуг Эл Гуан Дао (хятадаар, юуг Нэг Гуан Дао, юуг Хоёр Гуан Дао) гэдгийг мэдэхгүй (Бүгдээрээ инээлдэв). Гэвч би хэнийг ч эсэргүүцэхгүй, хамаг төрөлтөн угаас бүгд эрх тэгш, юу хийсэн ч өөрийнх нь дур.

Сонсоход И Гуан Дао бүлэгтэн бас ургамал хоол иддэг, ном судраар лавлагаа болгодог гэхээр миний бодоход зүгээр л юм байна! Наад зах нь эхний алхмаа хэдийнээ хийчихсэн байна. Хэрэв тэд бясалгаж, Арьяабалын номын цогцосыг сургадаг бол миний бодлоор тун сайн, ямар ч асуудалгүй. Зөвхөн ургамал хоол идэх нь хангалттай биш, ер нь ургамал хоол идэх нь тийм ч айхтар сүрхий зүйл биш, үхэр, морь, хонь, туулай бүгд ургамал хоол иддэг, гэвч тэд бурхан болж чадахгүй. Ургамал хоол идэх нь бурхан болгож чадахгүй, гэвч ургамал хоол идэхгүй бол бас бурхан болж чадахгүй. Ургамал хоол идэх, ёс суртахуунтай хүн болох, ном судар унших, ёс суртахууны талаар лавлахаас гадна өөрийн уг чанараа эрж олох хэрэгтэй, тэгвэл бид бурхан болж чадна. Зөвхөн өглөг өгөх, сахил сахих, гутаан доромжлохыг хүлцэх, хичээнгүйг дадуулах нь хангалтгүй, завал даяаныг агуулах хэрэгтэй, тэгвэл билиг ухаантай болж чадна. Билиг ухааныг олж байж л бурхан болж чаддаг.

Зургаан билиг барамидыг бүгдийг нь, бүрнээр нь бясалгах хэрэгтэй, тэгвэл бусад хүмүүст ч мөн өглөг үйлдэж чадах бөгөөд энэ нь нийгэмд тун тустай сайн. Сахил сахих нь тун сайн. Сахил сахина гэдэг нь ургамал хоол идэх, амь хороохгүй, хулгай хийхгүй, архи уухгүй,



худал ярихгүй, садар самуун явахгүй зэрэг болно. Хичээнгүйг дадуулах гэдэг нь өдөр бүр чармайн хичээж, сайн үйл үйлдэж, сайн хүн болж, ном судар унших, эсвэл ёс суртахуунтай зүйлсийг дагаж мөрдөхийг хэлнэ.

Гэвч ёс суртахууны эдгээр дүрэм журам нь биднийг бурхан болж өсөн хөгжихөд хангалттай шим тэжээл болж чадахгүй. Багш нь та нараар таван сахилыг сахиулдаг, хэрэв өглөг өгье гэвэл бас болно. Гэвч өглөг үйлдэхдээ угаас үйлдмээр өглөг гэж байхгүй гэдгийг ойлгох хэрэгтэй, та урьд төрөлдөө бусдад мөнгөний өглөгтэй ч байсан байж мэднэ, тэгээд одоо та өрөө төлж байгаа юм бол юуных нь өглөг байх вэ? Өгье гэвэл шууд л өг, “би” тийм сайн хүн, “би” өглөг өгч байна гэж битгий бодоорой, хэрэв ингэж бодвол буруу болно.

Бид энэ дэлхийд хов хоосон ирээд хов хоосон буцдаг болохоор “би” юугаараа өглөг өгч чадах билээ? Хэрэв та, би чармайн ажиллаж их мөнгөтэй болсон, энэ мөнгө бүгд минийх гэвэл таны амьсгалж байгаа агаарыг хэн бүтээв? Уудаг усыг тань хэн бүтээв? Өвс ургамлыг хэн бүтээв? Байгалийн маш олон зүйлийг хэн бүтээж бидэнд хэрэглүүлж байна вэ? Энэ бүх зүйлийг “би” өөрөө бүтээсэн биш. Энэ орчлон ертөнц бол нийтийн газар, мөнгө бол яг л ус, агаартай адил бидэнд зээлүүлж, хэрэглүүлж байгаа нийтийн өмч билээ. Бид хэрэглэж барахгүй бол ядуучуудад хуваан өгч хэрэглүүлбэл зохино. Ингэвэл тун шударга болно. Жишээ нь: усны шугам хоолой нь дотгуураа урсаж байгаа усыг өөрөө хэрэглэдэггүй, харин усыг эргэлдүүлэн түгээж, маш олон хүнийг усаар хангадаг бол сайн усны хоолой болно. Мөнгө, эсвэл өөр бусад зүйл мөн л адил, дэндүү их байх юм бол бусдад хуваан хэрэглүүлэх нь зөв шүү дээ. Агаар, ус гээд байгалийн өөр бусад тун олон зүйлийг бид үнэгүй хэрэглэдэг, тэгвэл яагаад бид жаахан зүйлийг бусдад хувааж өгснөө “би” тийм сүрхий, тийм нигүүлсэнгүй хүн гэж бодно вэ? Тийм биш шүү дээ.

Тиймээс өглөг үйлдэх нь өглөг үйлдэх биш, сахил сахих нь сахил сахих биш, угаас амь хороохгүй, амьтны мах идэхгүй байх нь мөр ёсонд нийцнэ. Зөвхөн Бурхны шашин, Католик шашин хүний ёсыг ярьдаг биш. Бүтээгчээс энэ дэлхийн хамаг бодисыг бүтээхдээ тэднийг эрх чөлөөтэйгээр өсөн торниж, энэ дэлхийд оршин тогтнох эрх олгосон. Амьтад ч бас бүтээгчээс үүссэн. Ер нь бүтээгч байдаг эсэх нь хамаагүй, тэд нэгэнт бий болчихсон юм чинь бид тэдэнтэй хамт амьдарвал зүйтэй. Яагаад тэднийг хөнөөнө вэ? Яагаад тэднийг хөөж явуулдаг юм бэ? Энэ орчлонд зөвхөн хүн төрөлтөн л амьдарч болно гэсэн дүрмийг тогтоосон хүн байна уу? Бусад амьтныг бүгдийг нь хөөж явуулах, хөнөөх нь зөв гэж тогтоосон хүн байна уу? Ингэж тогтоосон хүн байхгүй.

Аливаа шашны эзэн бүгд, бид хамаг төрөлтнийг хамгаалах хэрэгтэй, энэрэл нигүүлсэлтэй, түгээмэл хайртай байх ёстой гэж ярьсан байдаг. Түгээмэл хайр гэж юу вэ? Аливаа төрөлтнийг бүгдийг нь хайрлаж хамгаалбал тэр л түгээмэл хайр болно. Хэрэв бид Есүс Христийн сургаал ёсыг сөрвөл, Шагжамуни Бурханы сургаалыг зөрчвөл, бидэнд тэдний шавь болох эрх байхгүй, бид өөрсдийгөө католик шашинтан,

эсвэл бурхны шашинтан гэж ярьж болохгүй.

Тиймээс: “Багш бурхны шашинтан атлаа яагаад аливаа шашин бүгд сайн гэж ярьдаг юм бэ?” гэж Багштайгаа маргалдах хэрэггүй. Анхандаа бүх шашин бүгд сайн байсан, хувиран өөрчлөгдсөөр хамгийн эхний төрх байдалтайгаа адилгүй болжээ. Ямар нэг бүлэг, аливаа шашин бүгд сайн гэсэн үзлийг баримталдаг хэдий ч өөрсдөө харин ямар нэгэн шашныг үүсгэн байгуулбал тийм ч зөв биш болно. Угаас шашны бүлэг тийм олон байхад одоо дахин нэгийг нэмэх нь шашны зөрчил тэмцлийг л даамжруулах хэрэг болно. Шашин бүгд угаас сайн, гэвч эгэл хүмүүс хичээнгүйлэн бясалгадаггүй болохоор маш олон шашны урсгалыг бий болгожээ. Одоо нэгэн сайн бурхны шашинтан болохын тулд таван сахилыг сайтар сахиж, нэгэн сайн католик шашинтан болохын тулд арван сахилыг сайн сахиж хэрэгтэй. Арван сахилын эхний сахил нь, бурхны шашинтантай адил, амь хороож болохгүй гэдэг. Библи сударт амь хороох гэдэг нь хүнийг хөнөөхийг зааж хэлээд өөр бусад төрөлтнүүдийг хөнөөх нь хамаагүй гэж яриагүй.

Гэвч зөвхөн сахил сахиж нь хангалттай биш. Шагжамуни Бурхан тоост хорвоод залрахдаа хүмүүст зөвхөн сахил сахижыг заасан төдий биш, бас бясалгал хийж, өөрийн бурхан чанараа хайж, бурхан болохыг заасан байна. Тиймээс “Олонх бурхант судар”-т хамаг бурхан хүмүүсийг бурхан болгохын төлөө ирдэг гэж өгүүлсэн байдаг, “Бурхан, асар их хувь барилдлагаар хамаг төрөлтөнд Бурхан чанарыг нь таниулж, Бурханы билиг ухаантай болгохын төлөө энэ ертөнцөд залардаг”, та нар Багшинхаа санааг ойлгов уу?

Шагжамуни Бурхан, Есүс Христ хоёр хоёул адилхан, Есүс Христ энэ ертөнцөд залрахдаа хүмүүст зөвхөн сахил сахижыг заасан төдий биш, өөрөө бас бясалгаж, хамгийн сүүлд элсэн цөлд дөч хоног бясалган суужээ. Энэ нь тэрээр урьд нь хэдийний бясалгаж суугаад нилээд удсаныг харуулж байна. Дөнгөж бясалгаж сурч байгаа хүн элсэн цөлд дөч хоног ганцаараа битүүмжлэн суух боломж байхгүй. Шагжамуни Бурхан урьд нь бас нилээд олон жил бясалгаж байсан, хамгийн сүүлд нь бодь модны дор дөчин есөн хоног бясалгаж сууж байж л сая гэгээрсэн байна. Тэд өөрсдөө бясалгадаг төдийгүй, бас бусдад бясалгал хийхийг сургадаг байжээ.

Арьяабалын номын цогцос нь зөвхөн Бурханы шашны номын цогцос төдий биш, Библи сударт энэ бясалгах аргыг дурьдсан байдаг, Мөр ёсны сударт ч бас бий. Гэвч ихэнх хүн бясалгал хийдэггүй болохоор ойлгодоггүй, хэрэв Арьяабалын бясалгалын аргаар илүүхэн шиг бясалгавал аливаа судар ном бүгд адил болохыг мэдэх болно. Миний шавь нар бүгд ийм ойлголттой. Урьд нь Багш нь дөнгөж бусдыг сургаж эхэлж байх үед ийм олон зүйлийг ярих зав байгаагүй, үнэн хэрэгтээ бүх ном сударт үүнийг л ярьсан байдаг. Католик шашин, Исламын шашин, Персийн шашинд бүгдэд нь энэ тухай ярьсан байна. Хэрэв бид тэдэнтэй адил номын цогцосыг бясалгадаггүй бол тэд юу ярьдгийг ойлгохгүй. Бурхны шашинтны дунд ч Арьяабалын номын цогцосыг мэддэг нь тун

цөөн, тиймээс Багшаас нь Арьяабалын номын цогцосыг сурсны дараа маш олон хүнд бас эргэлзэх сэтгэл төрж, өөр номын багшаас очиж асуухад тэд мөн ойлгодоггүй, тэгээд Багшийг нь гадаад номтон гэж ярьдаг нь үнэхээр сэтгэл зовмоор хэрэг шүү.

Өдөр бүр зөвхөн өглөөний болон оройн уншлага хийж, сүсэгтэн олны өргөл тахилыг хүртэж суух нь гэрээс гарагчдын амьдрал биш. Шагжамуни Бурхан гэрээс гарсны дараа шавь нартайгаа юу хийдэг байсан бэ? Тэд өглөө бүр эрт босож бясалгадаг байсан, харин тэднийг өдөр бүр том хонх, бөмбөр дэлдэн чимээ шуугиан үүсгэж байсан гэж сонсож байгаагүй. Бидний дотоодод бүх зүйл бий, энэ бие цогцос бол хамгийн сүр жавхлантай, хамгийн үзэсгэлэнтэй, хамгийн гайхамшигтай, нууцлаг том сүм хийд билээ. Бид бясалгаж байж л дотоодынхоо бүх эрдэнэсийг бүгдийг нь эрж олдог.

Бясалгахаас өмнө бид энэ бие цогцос хэрэгцээгүй, эгэл хүний бие цогцос, их тааруухан эд гэж боддог, гэвч бясалгал хийсний дараа бүтээгчээс энэ бие цогцсыг хайрласанд бид машид талархах болно. Учир нь энэ бие цогцсыг ашиглан тун сайн бясалгаж болно, хэрвээ энэ бие цогцос байхгүй бол бясалгах аргагүй гэдгийг ойлгодог. Бидний бясалгал дээшилсний дараа энэ бие цогцсын дотоодод бүх зүйл байгааг, бүхий л орчлон дотоодод маань байгааг, гадна юу л байна тэр бүхэн дотоодод бас байдгийг мэдэх болно. Бид эзэн хаан, Бурхан, Эзэн Бурхан мөн, бид бол эгэл хүн биш, харин бясалгахгүй бол эгэл хүн, бясалгаж байж л л бид энэ орчлонд хамгийн эрхэм дээд төрөлтөн болохоо ойлгох болно.

Шагжамуни Бурхан өдөр бүр явган явж, хамаг төрөлтнийг гэтэлгэдэг, нэг орныг гэтэлгэж дуусаад бусдыг нь гэтэлгэхээр явдаг, хэдийгээр заримдаа түүний шавь нар нь бясалгалын газар байгуулж өгдөг ч тэр дараачийн оронд очихоор явдаг бөгөөд мөн л явган явдаг байжээ. Одоогийн Энэтхэгийн гэрээс гарагчид энэ уламжлалыг хадгалсаар байна. Есүс Христэд бас бясалгалын газар байгаагүй, тэр шавь нартайгаа явган явж, хамаг төрөлтнийг гэтэлгэдэг, ингэхдээ хувь барилдлагыг нь харж (тэдний дотоод ухамсрын төвшинд тохируулан) гэтэлгэдэг байв.

Өнөөдрийн католик шашинтнууд харин мөргөлийн том ордон байгуулж, өдөр бүр аль хэдийнээ элэрч баларчихсан ном судрыг уншдаг. Эртний ном судрыг унших нь буруугүй, Бурханы шашны ном судар, Католик шашны ном судрыг унших нь бүгд сайн, гэвч судрын утгыг ойлгохгүй бол хичнээн жилээр уншлаа ч ямар ч ач тусгүй.

Тиймээс бид нэг талаар ном судар уншихын зэрэгцээ “Бид хэн бэ?” гэдгээ ойлгох хэрэгтэй, өөрсдийн билиг ухаанаа таньж мэдэх хэрэгтэй. Ингэвэл сая судар номыг ойлгож чадна, Бурханы хутагт хүрч чадна, судар номонд ярьсантай адилхан ахуй ойлголттой гэдгээ нотолж чадна, ингэж л судар ном унших нь сая ач тустай. Судар ном унших нь зөвхөн лавлагаа болгохын тулд юм, бид ахуй ойлголттой болбол ном судрыг уншаад эртний хүмүүс бас ийм ахуй ойлголттой байсан гэдгийг мэдэж болно.

Жишээ нь: та нар авшиг хүртэх үеэр Хотол зохилдогч зүйлд дурьдсан “Эсэрваагийн эгшиг, далайн түрэлтийн дуун, чанагуух ертөнцийн ялгуусан аялгуу” гэх мэт Аялгууг олж сонсдог, үүнээс гадна бас нилээд өндөр дэсийн дотоодын Аялгууг олж сонсдог, та нар Хотол зохилдогч зүйлийг уншихдаа: “надад бас ийм ахуй ойлголт байсан шүү, үүнээс үзвэл миний билиг нээгджээ” гэдэг баталгаатай болно, “Баатар явагч нэрт их хөлгөн судар”-ыг уншвал бясалгал хийдэг байсан бодьсадва нар ямар Гэрлийг харж байж вэ гэдгээр нь тэднийг ямар төвшинд хүрсэн байсныг нь олж мэдэж болно. Бид судрыг нягтлан уншиж, адилтгавал Багшийнх нь сургадаг номын цогцос эдгээр ном судартай яг адил болохыг мэдэх болно, тэр үед та нар “одоо би бас эртний том бодьсадватай адил ахуй ойлголттой болжээ” гэж ярина. Ингэж адилтгаж гэмээж нь бид өөрийн дгсээ мэдэж чадна.

Ном судар уншаад бурхан болж чаддаг юм биш, ном судар уншихдаа, эртний бясалгалтны дэс нь хэр зэрэг байсан, тэд ямар ахуй ойлголттой байсан, анхны дэсийн бодьсадва ямар ахуй ойлголттой, хоёрдугаар төвшний бодьсадва, наймдугаар төвшний бодьсадва, буцалтгүй бодьсадва гэх зэрэг нь ямар ямар ахуй ойлголттой байж вэ, бид тэдэнтэй адил ахуй ойлголттой болж чадаж уу гэдгийн лавлагаа болгохын төлөө уншвал ач тустай, тиймгүй бол ямар ч буянгүй юм. Ном судрыг унших нь ямар ч буянгүй, уучлаарай, жаахан ч буянгүй, ингэж ярихыг сонсоод та нар маргааш Багшийнхаа ном тайлахыг сонсохоор ирэхгүй байж ч мэднэ. (Бүгдээр инээлдэв)

Учир нь ном судар уншаад дэндүү их ладчихсан болохоор одоо Багш нь битгий унш, бурхныг дурсаад ладчихсан болохоор одоо Багш нь битгий бурхныг дурс гэхээр та нар үнэхээр гадаад номтны номын багш байна даа гэж бодох болно. Гэвч Багш нь эрхбиш үнэн учрыг ярих хэрэгтэй, ярихгүй бол та нар ойлгож чадахгүй, энгийн үед ихэнх хүн ижилхэн зүйлийг л ярьдаг, одоо Багш нь харин өөр зүйл ярина, хүн бүр л ном уншиж, бурханд мөргөх тухай ярьдаг, хэрвээ Багш нь энд ирэхдээ мөн л ингэж яривал та нар гэртээ харьж унтсан нь илүү дээр.

Багш нь дэндүү залхуу болчихжээ, хаашаа ч явах дургүй юм чинь энд ирж ном уншиж, бурханд мөргөхийг яриад яах вэ? Багш нь үнэн ёсыг ярьж, та нарт сануулж, та нарыг дуудан сэхээрүүлж, бага унтаарай гэж ятгана, мухар сохроор бүү сүжиглэ, хэн нэг хүн юу л ярина, түүнд нь үнэмшиж, өөрийн гэсэн үзэл бодолгүй байж болохгүй, өөрийн ахуй ойлголт байхгүй, нотолгоо байхгүй байхад сонссон бүхэндээ үнэмшиж болохгүй, эмэгтэй хүний үйлийн үр маш хүнд гэж ярихыг сонсмогц дорхноо итгэхчдэг, тийм зүйл байхгүй, эрэгтэй, эмэгтэй хүмүүс эрх тэгш билээ.

“Вималакирти нирдеша судар” (Vimalakirti nirdesa-sutra)-т эрэгтэй ч гэж байхгүй, эмэгтэй ч гэж байхгүй, учир нь бидний сүнсэн биед хэлбэр дүрс байхгүй, бидний уг дүр хэлбэр дүрсгүй, эмэгтэй, эрэгтэй хүний дүр төрх гэж байхгүй, аливаа хүний уг дүр нь бүгд адилхан гэжээ. Жишээ нь: усны уг чанар нь адилхан, том саванд савласан болохоор ус

нь тийм байдалтай харагдана, хэрэв сав жижиг бол ус бага харагдана, гэвч ус мөн л усаараа, чанар нь өөрчлөгдөөгүй байгаа.

Бид энэ махан биеэ өөрийгөө гэж боддог, үнэн хэрэгтээ бие цогцос бол хувцастай адил, Чин Хай бол Чин Хай, би цагаан өнгийн, шар өнгийн, эсвэл улаан өнгийн хувцас өмсөх, эсвэл одоо өмсгөж байгаа гэрээс гарагчийн хувцас өмслөө ч би мөн л Чин Хай хэвээрээ, эгэл хүний хувцсыг өмссөн ч Чин Хай, учир нь би өөрийгөө хэн болохыг аль хэдийн таньчихсан болохоор ямар хувцас өмслөө ч бүгд адилхан.

Гэвч гэрээс гарах нь хэрэггүй гэж Багш нь боддоггүй, тийм биш, гэрээс гарагчдын амьдрал тун сайн, миний шавь нарын дотор гэрээс гарагчид их олон, бүгд залуу хүмүүс. Би бусдыг гэрээс гарахыг албаддаггүй, тэд өөрсдийн хүслээр гэрээс гарсан. Би гэрээс гарах, гэрээс гарахгүй байх тухай ер ярьдаггүй, би ганцаараа бясалгадаг, хэн дуртай нь ирж, Багштайгаа хамт бясалгаж болно, би юу ч сурталчилдаггүй, гэрээс гарах нь сайн, эсвэл гэрээс гарахгүй байх нь сайн гэж ярьдаггүй. Энэ нь хувь хүний заяа барилдлагаас шалтгаалдаг, хичээнгүйлэн бясалгадаг л бол болчихно.

Гэрээс гарсан, гараагүй ялгаагүй бүгд л бодьсатва болж чадна, гэвч гэрээс гарах нь тун сайн, цаг заваа бүрэн гүйцэд ашиглан ахиухан бясалгаж, Багштайгаа илүү ойр байж чадна, гэрээс гараагүй хүмүүс Багштайгаа хамт бясалгахад амаргүй. Та нарыг Пен хү-д байхад Багш нь ирээд долоо хоног ном тайлсан, гэрээс гарсан хүмүүс өдөр бүр Багштай нь хамт байж, Багш нь хаана байна тэнд очдог. Багш хэр их мэднэ, тэд бас аажмаар төдий чинээ ихийг мэдэх болно, учир нь тайлсан бүх судрыг олж сонсдог. Тиймээс нэгэн сайн Багштай учирч, гэрээс гаран түүнтэй хамт суралцаж, ариун дагшин амьдралаар амьдрах нь тун сайн.

Бидний эндхийн амьдрал тун хүнд хэцүү шүү, өдөрт нэг удаа хоол бэлтгэнэ, өглөөдөө өлсвөл жаахан иднэ, юу байна түүнийгээ л иднэ, байхгүй бол идэхгүй, оройдоо хоол бэлтгэдэггүй, өглөөдөө ч бэлтгэдэггүй. Унтахдаа эрэгтэйчүүд тусдаа өрөөнд, эмэгтэйчүүд өөр нэг өрөөнд бүгд шалан дээр унтана, ор гэж байхгүй, хувь хүний өрөө гэж байдаггүй, Багшийнх нь өрөө энэ ширээний дайтай зайтай ч надад дэндүү томдчихжээ гэж би боддог, тэднийг унтуулахаар өрөө бэлтгэсэн ч тэд намайг өөрсөдтэйгээ хамт дээврийн өрөөнд унтуулж зүрхлэхгүй тул зөвшөөрдөггүй, тиймээс би одоо ч тэр жижиг өрөөндөө амарч унтдаг. Бидний гэрээс гарагчдын амьдрал иймэрхүү л байдалтай байдаг.

Гэрээс гарах нь бусдын өргөл барьцыг хураахын төлөө биш, бид тун ариг хямгатай амьдардаг, Пен хү-д ирэхдээ суух тасалбар нь 190 юаны үнэтэй хамгийн хямд усан онгоцонд суудаг, бид юу хийж, юу худалдан авсан ч гэлээ хамгийн хямд зүйлсийг л хайдаг, учир нь энэ нь сүсэгтэн олны мөнгө, тэд тун зовж зүдэрч байж л мөнгө олдог, нэг юаны өргөл байлаа ч тэдний хөлс хүч шингэсэн байдаг болохоор бид хамаагүй үрж болохгүй. Хэрвээ шавь маань үнэтэй зүйл худалдан авбал Багш нь зэмлэдэг, тиймээс Багшийг дагаж гэрээс гарах нь тийм ч хялбар

биш, хүн бүр тус тусдаа өрөөтэй, зурагт, сонин сэтгүүлтэй байж, өдөр бүр өглөө, оройн уншлага хийснээр гэрээс гарсанд тооцогдоно гэж бүү бодоорой. Тийм биш шүү, бид өдөр бүр долоо, найман цагаар бясалгаж суудаг, үүнээс гадна өөр бусад олон ажил хийдэг, Багшийнхаа тайлсан номын агуулгыг эмхэлж найруулна, бас хэвлэнэ, бусдын ирүүлсэн захидалд хариу бичнэ, хүмүүс байнга ирж асуулт асууна, түүнд нь хариулна, бас долоо болон гурав хоногийн даяан хийнэ, олон газраар явж ном тайлна, гэр барина, угаалгын өрөө барина, мод хагална, хоол бэлтгэнэ, ногоо тарина, хувцас оёно гэх зэрэг маш олон ажил хийж, өдөржин завгүй ажилладаг. Гэрээс гарах нь ертөнцийн жаргал эдлэхийн төлөө биш, гэрээс гарах нь арай илүүхэн цаг бясалгаж, илүүхэн цаг хамаг төрөлтийг харж харгалзахын төлөө л юм.

Гэрээс гараагүй хүмүүс эрх чөлөө багатай, хаана ч байсан огт хялбар биш, эхлээд хүүхдээ асарч харгалзана, дараа нь эхнэр, эсвэл нөхрөөсөө зөвшөөрөл авах хэрэгтэй гэх мэт. Гэрээс гарагчид бол явъя гэсэн үедээ явна, хаана шаардлагатай байна, тэнд очиж ном тайлна, жижигхэн тээшээ бэлтгээд л явчихна, долоо хоногт хүн бүр хоёрхон солих хувцастай байхад л болчихно, өөр зүйл хэрэггүй, харин гэрээс гараагүй хүмүүс хаа нэг тийшээ явбал том ачаа тээш бэлдэж, элдэв янзын зүйл авч явах хэрэгтэй болдог. Тэд өдөр бүр 3-4 удаа хооллоно, өглөөний хоол худалдаж авна, эсвэл бэлдэнэ, иднэ, ингэхдээ 2 цаг шахам цаг хугацаа зарцуулна, энэ нь зөвхөн өглөөний хоол, үд дунд бас хамгийн багадаа 2 цагийг хоолонд зарцуулна, миний харснаар зарим хүн 3 цаг хоол бэлтгэдэг, өглөөний 9 цагаас эхлээд үдийн 12 цаг гэхэд бас л дуусаагүй, ингэж хайран цагаа бүгдийг нь үрнэ, оройдоо бас дахин бэлтгэнэ, үдээс хойш нарийн боов бэлтгэнэ. Энэ бүхэнд маш их цаг зав зарцуулдаг. Үүнээс гадна зурагт үзнэ, сонин уншина, найз руугаа утасдана, хадмуудаа эргэнэ, хөрш, найз нөхдүүдээрээ зочилно гэх мэт маш олон ажил байдгийг та нар мэднэ шүү дээ. Энэ ертөнцийн хэрэг явдлуудыг би аль хэдийн мартжээ.

Гэвч би гэрээс гараагүй байхдаа ч тун энгийн амьдардаг байлаа. Гэрээс гараагүй байхдаа тун яаруу, завгүй, олон хүнд туслая гэхэд өөрийн гэсэн цаг зав байхгүй, тэгээд л сэтгэл дундуур явдаг байж. Гэрээс гарах нь тун сайн, жинхэнэ эрх чөлөөтэй, дуртай цагтаа явна, эр нөхөр, эсвэл эхнэрээсээ асуух шаардлагагүй, амьдрал нилээд чөлөөтэй, ер нь гэрээс гарагчид угаас ийм байвал зүйтэй. Багшийгаа дагаж гэрээс гарсан шавь нар хатуу чанд нөхцөлд ажилладаг, Багш нь ном тайлахдаа инээмсэглэн тун эелдэг зөөлөн, дотно байхыг хараад Багш нь шавь нартаа зөөлнөөр ханддаг гэж битгий бодоорой, тийм биш, би тун хатуу ханддаг, гэрээс гарсан бол хамгийн сайн гэрээс гарагч л болох хэрэгтэй. Гэрээс гарсан, гараагүй хоёрын хооронд байж болохгүй. Зарим гэрээс гарагч тус тусдаа өрөөтэй, зурагттай, халуун устай байдаг, надад ийм зүйлс байхгүй, хүйтэн усанд орж хөлдөж үхсэн ч ер хамаагүй, үхвэл хурдан төрөл арилжина. (Бүгдээр инээлдэв.) Бидэнд нэг халуун усны төхөөрөмж бий, үүнийг шавь нар маань бараг хүчээр шахуу угсарч

өгсөн, анхандаа хоёр, гурвыг угсарч өгөх гэж байсныг би болиулсан. Тэд надад хүчээр нэгийг өгсөн. Их хүйтэн үед бид жаахан ашигладаг, энгийн үед бараг хэрэглэхгүй, бүгд л хүйтэн усанд ордог.

Гэрээс гарахад тийм хялбар биш, бясалгаад суухаар л болчихно гэж та нар битгий бодоорой. Та нар бүгд гэрээс гараагүй болохоор би гэр бүлийг чинь салгаж болохгүй, гэрээс гараарай гэж зоригжуулахгүй, хүүхэд чинь яах вэ, эр нөхөр чинь яах вэ? Гэрлээд хүүхэдтэй болсон бол гэр бүлийн үүрэг хариуцлагаа үргэлжлүүлэн биелүүлэх хэрэгтэй, гэртээ сууж хичээнгүйлэн бясалгах нь илүү сайн.

Жинхэнээр гэрээс гарья гэвэл бүхнийг огоорч байж л гэрээс гарах хэрэгтэй. Гэвч би та нарт хэлж өгье. Гэрээс гарах нь тийм амар хялбар биш, гэрээс гарагчид сайн бясалгахгүй бол бусдын өглөг барьцыг шингээж чадахгүй болно. Тиймээс гэрээс гарахын өмнө би ийм амьдралаар амьдарч чадах уу? Сүсэгтэн олны өргөл барьцыг шингээж чадах уу? Эр нөхөр, эсвэл эхнэр, үр хүүхдээ санах болов уу? гэх зэргийг чадах эсэхээ тодорхой сайн бодож төлөвлөх хэрэгтэй. Учир нь гэрээс гарах бол хамгийн эрхэм дээд байр суурь, улсын хаанаас ч илүү эрхэм дээд, улсын хаан зөвхөн ганцхан улс орноо боддог төдий, жинхэнэ гэрээс гарагчид бол бүхий л орчлон, хамаг төрөлтнийг боддог, эр нөхөр, эхнэрийн байр сууриас ч илүү эрхэм дээд, учир нь эр нөхөр, эхнэр бол зөвхөн гэр бүл, хамаатан саднаа харж харгалздаг, гэрээс гарагчид бол бүхий л орчлонг асран харгалзана, аливаа төрөлтнийг бүгдийг нь харгалзана, амьтдыг харж харгалзана, өвс ургамлыг харж харгалзаж, тэднийг дураараа тасдаж, тайрахаас ч болгоомжилдог. Бид бусдын тайрч хаясан, хатаж хуурайшсан модыг л түлдэг. Бид өөрсдөө дураараа амьд модыг тайрдаггүй.

Гэрээс гарагчид хамаг төрөлтнийг хүндэтгэх хэрэгтэй, учир нь хамаг төрөлтөн бүгд биднийг хүндэтгэдэг, бид тэднийг хүндлэхгүй, гэрээс гарагчийн амьдралаар амьдарч чадахгүй бол үйлийн үр нь маш хүнд шүү! Тиймээс гэрээс гарахдаа тун их тунгаан бодож, хичээн болгоомжлох хэрэгтэй.

Гэрээс гарахгүй байлаа ч гэсэн сайн хэрэг, муу зүйл гэж үгүй, гэр бүлээ харж хандахын зэрэгцээ “сэтгэл” тань гэрээс гарвал болчихно. Гэрээс гарах гэж юу вэ? Гэр бүлийн нөхцөл байдалд сэтгэл татагдахгүй, эр нөхөр, эхнэр хүүхэддээ сэтгэл хоргодохгүй, зөвхөн өөрийн үүрэг, хариуцлагаа гүйцэтгэхийн төлөө тэднийг харж харгалздаг, мөн сэтгэл нь төөрөлдөхгүй байх явдал. Үүнийг л гэрээс гарах гэдэг. Энэхүү тоост хорвоод хоргодохгүй байх нь гэрээс гарч байгаа явдал билээ. Харин үсээ хусч, гэрээс гарагчийн хувцас өмссөнөөр гэрээс гарсан болчихдог юм биш, гэрээс гарагчийн хувцас өмсөж, үсээ хуссан хүмүүс их байдаг хэдий ч сэтгэл нь харин гэрээс гараагүй байдаг. Сүм хийдэд суух нь гэртээ суугаатай адил, нэг гэрээ орхисон ч дахиад өөр нэг гэртэй болж хүлэгдэнэ. Нэг гэрээс салаад өөр нэг гэрт очиж амьдрах нь гэрээс гараагүйтэй адил.



Өнөөдрийн гэрээс гарагчдын амьдрал тун тааламжтай байх юм, миний харснаар маш олон том сүм хийдэд хүн нэг бүр өрөөтэй, маш тухтай, зурагт, утас гээд бүх зүйл байна. Ийм байхад та нар юунд түргэн гэрээс гарахгүй байна вэ? Гэрээс гарах нь гэрээс гараагүйгээс бас сайн, өдөр бүр өглөө, оройн уншлага хийнэ, тэгээд л болчихно, өглөө нэг цаг, орой нэг цагийн уншлага хийхээс өөр ямар ч ажил байхгүй бөгөөд бусдын хүндэтгэл, бишрэлийг хүлээнэ. Та нар үнэхээр тэнэг байна, яагаад түргэн гэрээс гарахгүй байгаа юм бэ? Одооноос гэрээс гарах уу?

Надад сүм хийд гэж байхгүй, гэрээс гарсан анхны шавьтай болоод дөнгөж хагас жил болоход аль хэдийн ийм олон гэрээс гарагчтай болчихжээ, тэд суух газар байхгүй ч гэрээс гарч, Багштайгаа хамт амьдарч, байшингийн шатан дээр унтсан ч хамаагүй гэх юм. Долоо хоногийн даяаны үеэр тэд бүгдээрээ байшингийн шатан дээр унтдаг, бидэнд ор гэмээр зүйл байхгүй, хаа боломжтой газраа унтана. Байшингийн дээвэр, угаалгын өрөөнд ч унтана (Бүгдээр инээлдэв). Хаана л зай байна, тэнд унтчихдаг, тиймээс Багшийг дагаж гэрээс гарах нь тун хялбар биш, чин сэтгэлээсээ бясалгахын төлөө л байх хэрэгтэй.

Тэд том сүм хийдийн төлөө лав гэрээс гараагүй. Бидний одоогийн сууж байгаа газар түрээсийнх, маргааш гэрийн эзэгтэй хөөгөөд явуулж ч мэднэ, тэгвэл бид ууланд гарч, майхан босгох хэрэгтэй болох биз. Тогтсон орон байр байхгүй ч тэд тоохгүй. Тиймээс тэд гэрээс гарч, Багшийг дагасан нь сүм хийдийн төлөө биш, Багшийн төлөө биш ч бас Багшийн төлөө, үүнийгээ тэд тодорхой ойлгодог.

Маргааш Багш нь Формосад буцаж ирж чадахгүй болсон ч тэд бүгд л гэрээс гарна. Ийнхүү тэд Багшид дуртай учраас гэрээс гарсан биш, эсвэл сүм хийд тун тааламжтай, тохиромжтой, амар амгалан газар учраас гэрээс гарсан биш юм, тийм биш, тэд гэрээс гарч, олон эрсдэлийг сөрдөг. Багш нь Формосад дахин ирэх эсэхээ өөрөө ч мэдэхгүй, Багш нь гадаадын хүн болохоор энд нэг удаадаа ихдээ л зургаан сар байж чадна, дараа нь Формосагаас явах хэрэгтэй болно. Явсны дараа дахиад аялагчийн виз авах болон Формосад буцаж ирж чадах эсэх нь бас өөр нэг асуудал байдаг, тиймээс тэд тун аюумшиггүй, учир нь жинхэнэ сэтгэлээрээ гэрээс гарсан юм.

Зөвхөн энд байгаа гэрээс гарагчдаас гадна Формосад бас нилээд хэдэн гэрээс гарагч иргэний үнэмлэхээ биедээ авч яваагүй учраас энэ удаа Багштай нь хамт энд ирж чадсангүй. Тэд хамт ирж чадаагүйдээ сэтгэлээр унан уйлж байсан. Тэд өөрсдөө сайн дураараа гэрээс гарсан болохоор надад ямар ч арга байхгүй, намайг Формосад ирээд удаагүй байхад тэд яаран Багшийг нь дагаж гэрээс гарсан, хөөсөн ч явдаггүй, загнасан ч айдаггүй, яг л цавуу шиг байдаг. Тэд тун амаргүй нөхцөлд гэрээс гарсан, жинхэнэ маш сайн гэрээс гарагчид билээ. Та нартай энд хамт сууж байгаа гэрээс гарагчид бол энгийн бус хүмүүс, тэд идэх, уух, тоглох, цэнгэх явдлыг огоорон амьдралын ямар ч нөхцөл байдлыг тоож хамаардаггүй, жинхэнээсээ чармайн бясалгадаг, өдөр бүр долоо, найман цаг бясалгаж суудаг. Хэн ингэж чадах вэ? Та нар чадах уу? Одоо би та

нарыг харахад, тавхан минут суумагц аль хэдийн сууж тогтохоо болиод шоргоолжинд хазуулсэн мэт болж байна. Иймээс бясалгаж суух нь тун хялбар гэж бүү бодоорой, сэтгэл тогтохгүй бол сууж чадахгүй, жаахан суумагц босмоор санагдана. Судар ном унших бол хялбар, бурхныг дурсах нь ч бас тун хялбар, судар номыг аялгуулан унших тун хялбар, харин бясалгаж суух нь хялбар биш.

Одоо та яагаад гэрээс гарах явдлыг ярихгүй байна вэ гэж Багшаасаа асуухгүй юу? Надаас энэ тухай сонсмоор байна уу? Зарим хүн Багшаас нь: “Ямар ч шашинд итгэсэн бүгд сайн гэж та хэлсэн атлаа яагаад бас гэрээс гарсан юм бэ? Та яагаад хүмүүсийг гэрээс гарч, Бурханы шашинд итгэ гэж зоригжуулдаггүй юм бэ?” гэж асуудаг болохоор би өнөөдөр энэ бүхнийг ярьж байгаа хэрэг. Миний харснаар ихэнх гэрээс гарагчдад жинхэнэ гэрээс гарагчийн сэтгэл байдаггүй, тиймээс гэрээс гарахыг би зоригжуулдаггүй, албаддаггүй, дуртай бол ир, дургүй бол хэрэггүй, би юуг ч зоригжуулдаггүй. Гэтэл манай энд гэрээс гарагчид бусад газрынхаас олон байна, Формосад том сүм хийд тун олон, уужим өрөөтэй хэдий ч ганц хоёрхон хүн суудаг, харин бидэнд том газар байхгүй ч тун олон гэрээс гарагч байна. Тиймээс гэрээс гараарай гэж сурталчлаад яах вэ, цэцэг өөрөө юу ч ярьдаггүй атал түүний анхилуун үнэрт хүн болгон дуртай байдаг. Тиймээс та жинхэнээр бясалгадаг бол хүмүүс таныг дагана, юу ч ярих шаардлагагүй, би бусад шашинтай дайтах хэрэг юун? Тэд юунд итгэнэ, өөрийн дураар болог, хэрэв Багшийг нь дагаж бясалгая гэвэл би тэдэнд Арьяабалын номын цогцосыг зааж сургана, ургамал (веган) хоол идэх, сахил сахих, бясалгах зэргийг заана, хамгийн шаардлагатай зүйлсийг л заана.

Амь хороож болохгүй, хулгай дээрэм хийж болохгүй гэдгийг бид хүүхэд байхаасаа сурчихсан байх ёстой, тиймээс сахил санваар гэж нэрлэх нь зохисгүй, энэ нь зөвхөн Бурханы шашны сахил санваар биш, энэ бол нийгэмд байх ёстой ёс суртахууны хэм хэмжээ, хүний амьдралын, амар амгалангийн ёс суртахуун, тиймээс би энэ зүйлийг л сургадаг. Тэд Есүс Христэд итгэхэд юу нь муу байх вэ? Нэг талаар Есүс Христэд итгэж, нөгөө талаар Багшдаа итгэвэл болчихно, ахин дахин солих хэрэггүй. Хэрэв та өнөөдөр Есүс Христэд итгэж байснаа маргааш нь Арьяабал бурханд итгэвэл, дараа нь өөр нэг л өдөр Багшдаа итгэлгүй болж мэднэ, тэгээд дахиад л Есүс Христэд итгэнэ, ингэх нь та өөрийн цаг заваа дэндүү их үрж байгаа хэрэг болох биш үү?

Тиймээс өөрсдөө Бурхан болж чадна гэдэгтээ итгэж, өөрсдөө Есүс Христ болж чадна гэдэгтээ итгэхэд л хангалттай. Нэгэн шашны эзний амьдралын хэлбэр болон зорилго нь бидний хүндэтгэл бахархалыг төрүүлдэг болохоор бид түүнийг хүндэтгэж, бишрэн шүтдэг. Гэвч эдгээр зүйл нь чухал биш, хамгийн чухал нь бид өөрсдөө түүн шиг болж хувирах явдал бөгөөд энэ нь хамгийн сайн хүндэтгэл, бишрэл болно, Багшийн чинь хэлэх гэсэн уг санаа бол ийм юм. Харин Багш нь Бурхны шашныг муу гэж шүүмжлээгүй, хүмүүсийг Католик шашинд итгэхийг уриалаагүй, ийм зүйл ер байхгүй. Гэрээс гарахыг зоригжуулах эсэх нь

зөвхөн гадна талын хэрэг, чухал биш зүйл, өөрийн мөн чанараа эрж олох нь л хамгийн чухал. Та ямар ч шашны эзэнд итгэсэн болно, гэвч өөртөө итгэж, өөрийн уг дүрээ эрж олох нь хамгийн чухал юм.

Дөнгөж эхлээд шашинд итгэх үедээ бид нэгэн шүтэн бишрэх хүнтэй болж, түүнийгээ даган дуурайсаар, аажим алгуураар амьдралаа өөрчилж, түүн шиг амьдралтай болдог. Шүтэн бишрэхийн зорилго нь ердөө л ийм юм. Өдөр бүр түүнд мөргөөд бүх зүйл болчих биш, харин өөрөө түүн шиг болж хувирах хэрэгтэй. Өөрөө Есүс Христ шиг болох нь хамгийн сайн шүтэн бишрэл болох юм. Энд сууж байгаа бурхны шашинтнуудын дунд Есүс Христ шиг бодьсадвагийн сэтгэлтэй хүн байх аваас би хамгаас баярлана, ингэвэл гэрээс гарахгүй байсан ч болно, гэвч ингэх нь тун амаргүй. Тиймээс эгэл хүмүүс хэрэв жинхэнэ байдлыг ойлгохгүй байгаа бол өөр бусад шашны эздийг санааны зоргоор гүтгэж болохгүй.

Луузийн сургаал номлол тун сайн, Күнзийн сургаал номлол ч бас тун сайн, Есүс Христийнх тун сайн, Мухамедынх бас сайн, ямар нэг шашныг ойлгоогүй бол битгий гүтгээрэй. Мэдээж тэдний шавь нарын дунд сайн, муу олон янзын хүн бий, учир нь хүмүүс янз бүр, харин шашинд сайн, муугийн ялгаа байдаггүй. Энэ бол Багшийн чинь уг санаа. Тиймээс ойлгоогүй бол санааны зоргоор Багш бол И Гуан Дао, эсвэл Эл Гуан Дао гэхчлэн шүүмжилж болохгүй шүү.

Уг нь өнөөдөр өөр бусад зүйлийн тухай ярих байсан юмсан, гэтэл гэрээс гарах явдлыг ярьчихлаа, үүнийг ярихад хүмүүс сонсох дургүй байдаг. Бид эхнэр, эр нөхөртэй байтал яагаад гэрээс гарах явдлыг ярих гэж та нар бодох байх. Хэн гэрээс гарах юм бэ, “тэнэг” хүн л та нар шиг гэрээс гарна гэх биз (Багш хошигнов).

Гэрээс гарахгүй байх нь ч сайн, эр нөхөртэй, эхнэртэй байж болно, өөрсдийгөө хязгаарлах зүйл хийх хэрэггүй, гэрлэе гэвэл гэрлэж болно, өдөр бүр гоёж гангалж болно, зурагт үзэж болно, юм идье гэж хүсвэл идэж болно, өдөрт гурав, дөрөв, таван удаа хооллож болно, хаашаа ч явсан болно, тэр бүрт хажууд чинь ном уламжлах Багш нь байна, энэ үнэхээр сайн хэрэг биш гэж үү.

Энэ үнэн, та нар Багшаасаа илүү их эрх чөлөөтэй, ямар ч ачаа дарамт байхгүй, Багш нь бол зовлон зүдгүүрийг хүлцэн тэвчих хэрэгтэй, цагийг өөрийн дураар урж зүрхлэхгүй, гэр бүлийн амьдралаар амьдарч зүрхлэхгүй, тэр тухай бодож ч зүрхлэхгүй, юм идэхдээ ч хичээж болгоомжлох хэрэгтэй, хаа ч очсон ч олуулаа явах хэрэгтэй болдог. Та нарын амьдрал дэндүү аятайхан, тиймээс миний бодоход та нар гэрээс гараагүй нь илүү аятай юм байна, биднээс дээр байна, гэрээс гарах хэрэггүй. Гэрээс гарах нь том эрсдэл, зоригтой, баатарлаг шийдвэр, үйлдэл юм, яагаад гэвэл заавал ч үгүй бүхнийг огоорч, ариун дагшин амьдрах хэрэгтэй, идэх, уух, тоглох, цэнгэх бүх явдлыг орхиж, ямар ч хүсэл тачаалгүй болж байж л гэрээс гарч чадна.

Гэрээс гараагүй хүмүүсийн амьдрал дэндүү тав тухтай, гэрээс

гарах хүн байвал гараа өргөөрэй, ингэж их тайлбарлаж ярьсан байхад гэрээс гарах гэж хүсэх хүн байхгүй дээ. Гэрээс гарах хүн байхгүйг мэддэг байтлаа би яагаад энэ тухай ярьсан бэ гэвэл энэ талаар асуусан хүмүүс байгаа болохоор Багш нь өнөөдөр нилээд тодорхой ярилаа, тэгэхгүй бол та нарт эргэлзэх сэтгэл төрж, харш саадтай болно. Гэрээс гараагүй хүмүүсийн амьдрал тав тухтай байдаг, тиймээс гэрээс гарагчдын амьдралыг бас тийм гэж битгий буруугаар бодож сэжиглээрэй, тэд амаргүй нөхцөлд амьдардаг, Багш нь ч бас мөн адил, эдэлж байгаа жаргал гэж үгүй, та нар бодохдоо Багш ийм олон шавьтай, түүнийг олон хүн бишрэн шүтэж, хүндэтгэдэг гэж боддог байх, үнэндээ гүжирдэж гүтгэх хүн бас тун олон, энэ тухай харин та нар мэдэхгүй.

Хамаг төрөлтөн харанхуй мунхаг бол хэлснийг минь ойлгохгүй, нэг ижил зүйлийг олонтаа яриад байхад ойлголгүй, хэзээ нэгэн өдөр Багшийг нь гүтгэн доромжилж мэднэ. Тиймээс Багш байх хялбар биш, бишрэн хүндэтгэх олон хүн байхаар л болчихдог юм биш, өнөөдөр хүндэтгэж байснаа, маргааш нь болихыг хэн мэдэх билээ? Үнэн хэрэгтээ энэ хамаагүй л дээ, Их Багш нарт угаас ийм л байдаг, Үнэн ёсыг яригчид бүгд ийм, Багш нь зөвхөн энгийн ёсыг ярьдаг бол ямар ч асуудал үүсэхгүй, өдөр бүр та нараар ном уншуулж, бурханд мөргүүлбэл ямар ч асуудал гарахгүй. Энгийн хүмүүстэй адил том сүм хийд барьж байгуулж болно, гэвч би ийм зүйл хийхгүй, би сүм хийд байгуулах дургүй, тиймээс зарим хүн Багшид нь өргөл барьц өгч, том сүм хийд байгуулахыг гуйхад нь би зөвшөөрдөггүй, тийм их мөнгийг би хүлээж авдаггүй, хэрэглээд хүрэх мөнгөтэй л бол болчихно.

Гэрээс гарагчид угаас мөнгө хураахгүй байх нь зөв, гэвч цаг үе адилгүй болсон болохоор хураах хэрэгтэй болдог, зөвхөн үндсэн хэрэглээгээ хангавал болчихно, илүү ихийг хураах хэрэг алга. Миний шавь биш бол би өглөг авдаггүй, би жаахан ч гэсэн чармайн тэднийг сургадаг болохоор тэд Багшдаа өргөл өргөх шалтгаантай болдог, харин энгийн хүмүүсийн өргөл барьцыг би авдаггүй. Хэрвээ тэд өргөл барьцыг нь хүлээн авахыг олонтаа гуйгаад байвал, маргахаас зайлсхийж, жаахныг авдаг, гэхдээ тэр мөнгийг нь би шаардлагатай хүмүүст өгчихдөг. Хэрэв та нар Багшийгаа дагаж гэрээс гарвал, нөхцөл байдал бусад газартай адилгүй, иймд сайтар нягталж, бодож тунгаах хэрэгтэй.

**Асуулт:** - Орчин тойрны нөхцөл байдлаас болж авшиг хүртэж чадахгүй бол Багш та бидэнд энгийн бясалгах арга, эсвэл ургамал хоол идэхгүйгээр ч бясалгаж суух номын цогцосыг сургах уу?

**Их Багш:** - Миний сургадаг зүйлс бүгд л хамгийн энгийн зүйл, тиймээс Багштайгаа үнэ хаялцах хэрэггүй, бид ямар наймаа хийж байгаа биш. Ургамал хоол идэх хэрэгтэй гэхэд хэрэгжүүлж чадахгүй бол Багштайгаа үнэ хаялцах хэрэггүй, та нар чадахын хэрээр ургамал хоол идэх нь зөв, хэдий чинээ их иднэ, төдий чинээ сайн. Ном балрах цаг үед хамаг төрөлтний үйлийн үрийг тийм ихээр авч болохгүй, цэвэр ургамал хоолтон болж чадахгүй бол чадахын хэрээр хэрэглэх нь төдий чинээ сайн. Хэрэв Багшийнхаа заасан номын цогцосыг бясалгаж чадвал

мэдээж тун сайн, чадахгүй бол “Наму Авид бурхан” гэж уншаарай.

Формосад номын багш тун олон, тэд элдэв олон зүйлийг заадаг, их хөлгөний тарни уншихад сургана, бас нууц тарнийн бүлэгтэн, ил тарнийн бүлэгтэн гэхчлэн байна. Тэд хүмүүсийг ургамал хоол идэхийг шаарддаггүй, тэнд хүмүүс өөрийн дураар сонголт хийж болдог. Хэрэв ургамал хоол идэхгүйгээр, сахил сахиугүйгээр Багшийн сургаалыг гуйвал Багш нь тэр хүний байдалд тохируулж нэг, хоёр, гурав, дөрөв гэхчлэн амьсгалаа тоолохыг сургаж болно, “Би хэн бэ?” гэх мэтийн ном хаялцахад сургана., “Наму Авид бурхан” гэж уншихыг заана. Миний сургадаг бурхныг дурсах арга нь өөр бусад хүмүүсийнхээс илүү дээр, үүнийг зааж сургадаг хүн тун цөөн. Хэрвээ та нарын урьд нь бясалгаж байсан номын цогцос ач тустай байсан бол түүнийгээ үргэлжлүүлэн бясалгаарай. Та нарын нөхцөл байдлыг Багш нь сайн ойлгоно, би та нарын их яарч байгааг мэднэ, Багшаасаа суралцахад тун дуртай байдгийг мэднэ. Гэвч та нар эгэл ертөнцийг огоорч чадахгүй байсаар байвал номын цогцосдоо бүрэн орж чадахгүй. Үнэн хэрэгтээ хоол, унд бол асуудал биш, өлсөх үед юу идсэн ч бүгд амттай санагдана, хэрэв ургамал хоол хийж чадахгүй бол зоогийн газарт очин суралцаж болно, манай эндхийн настай бодьсатва нарын хийсэн хоол маш амттай, та нар тэднээс суралцаж болно.

Та нарын одоогийн нөхцөл байдал нь гэр бүлээсээ хараахан салж түвдэхгүй байсаар олон зүйлийн саад бэрхшээлд хүлэгдэнэ, ажилдаа хүлэгдэнэ, гэр бүлдээ хүлэгдэнэ, орчин тойрондоо хүлэгдэнэ гэх мэтээр олон зүйлд хүлэгдэж байгааг би мэднэ. Гэвч бурхнаас суралцахад эр зоригтой байх хэрэгтэй, тэгэхгүй бол энэ бүгдээс салж чадахгүй. Одоо салж чадахгүй бол дараа төрөлдөө мөн л адил байна, адилхан нөхцөл байдалд орж, эр нөхөр, эхнэртэй болно, бас л ургамал хоол идэж чадахгүй, учир нь..., хэрэв..., тиймээс..., хэдийгээр..., гэтэл..., гэвч... гэх мэтийн адилхан, дуусашгүй шалтгаан байсаар л байна.

Бид хүний төрлийг олох болгонд үргэлж л учир нь..., иймээс..., гэвч... гэх мэтийн шалтгаан байдаг. Тиймээс бид одоогийн хувь барилдлагаа тасдья гэвэл, энэ төрлөө хамгийн эцсийн нэг төрөл, дахиад хэзээ ч буцаж ирэхгүй гэж эрс шийдэх хэрэгтэй.

Хэрэв та нар газар тариаланд хэрэглэдэг пестицидээс айдаг бол тун амархан, хүнсний ногоогоо угаах болгондоо давстай усаар угаагаарай, усанд давс ахиухан хийгээд 5 минут байлгаж хэрэгтэй. Жимс, хүнсний ногооны аль нь ч байсан сайтар цэвэрлэж угаах хэрэгтэй, давстай усанд 5 минут байлгавал пестицид нь арилна, дараа нь цэвэр усаар зайлж угаагаарай. Хэрэв ургамал хоол идэж чадахгүй байгаа бол аажим аажмаар идээд байвал дадчихна.

Үнэн хэрэгтээ угаас сайн ч гэж үгүй, муу ч гэж үгүй, бүгд бидний дадал зуршлаас болсон байдаг. Хүмүүс хүүхэд байх үедээ мөн л адилхан зургаан мэдрэхүйтэй байсан. Ялгаагүй л нүд, чих, хамар, хэл, бие, бодолтой, гэвч тэр үед ялгах дадал зуршил бүрэлдэж тогтоогүй байсан

болохоор үнээний сүү өгсөн ч ууна, давсгүй хоол өгсөн ч иднэ, чихэрлэг идээ өгсөн ч иднэ, шорвог идээ өгсөн ч иднэ, юу болохыг нь мэддэггүй, хүмүүс түүнийг загнахад өөдөөс нь инээдэг, “та чинь үнэхээр сахилгагүй хүүхэд байна” гэж хэлсэн ч өөдөөс нь инээдэг. Учир нь хүүхэд байх үед ялгаварлах дадал суугаагүй байдаг.

Гэвч бид том болох тусам зургаан мэдрэхүйдээ хүлэгдэж дасаад одоогийн дадал зуршил бүрэлдсээр ямар нэгэн зүйлд дуртай болчихдог. Тамхи татахаар жишээлж ярья. Бид угаас тамхи татдаггүй, том болсныхоо дараа л найз нартайгаа тамхи татсаар байгаад дадаж сураад гарч чадахаа больчихдог. Дэлхий даяар тамхи татдаг хүн маш олон, тамхи татдаггүй бол нийгмийн хөгжлөөс хоцорсон шиг болдог. Мах идэх ч бас адилхан, угаас мах идэхгүй бол зохино, гэвч одоогийн ихэнх хүн мах иддэг, хэн нэг нь ургамал хоол идвэл ихэнх хүнд эсрэгээрээ хачин харагдана. Тиймээс дадал зуршлыг өөрчлөхөд тийм ч хялбар биш.

Угаас тамхи татахгүй байх нь зөв, гэвч тамхи татаад дадаж зуршчихаар гарч чадахаа больчихдог. Тамхи татахаа болихоор хачин санагдаж, тамхи татдаг найз нар нь түүнийг шүүмжилж, тамхиа тат гэж ятгана. Бид алгуураар олон дадал зуршилтай болж, улмаар амьдрал эдрээтэй болдог, тиймээс бид эдгээр дадал зуршлаасаа гарч чаддаггүй.

Бясалгагч хүн эр зоригтой байж гэмээнэ эдгээр дадал зуршлаа өөрчилж чадна, нийгмийн дарамтыг ялж чадна, гэр бүлийн уламжлалт дарамтыг бас давж чадна. Багш нь та нарт яагаад тийм их зүйл сургадаггүй вэ? Учир нь Багш нь Арьяабалын номын цогцосын бүхий л зүйлийг хүн бүрт заасан байлаа ч та нарт их ач тустай байхгүй. Бие махбодоо ариусгаагүй бол Бурханы хүчийг дааж чадахгүй, дааж чадсан ч сайнаар нөлөөлж чадахгүй. Жишээ нь: энэ сав тун бохир байвал Багш нь ямар ч амтаг идээ савласан бохирдоно, идэж болохгүй, цэвэр ус хийсэн ч ууж болохгүй. Ус уухад эхлээд саваа угааж цэвэрлэсний дараа саваараа ус аваад ууж болно. Хэрэв энэ сав цэвэр биш бол энэ саванд хийсэн усыг уувал хордож, толгой өвдөж, гэдэс өвдөж ч мэднэ, тэр ч байтугай амь насанд аюултай, тиймээс бид бие, хэл, сэтгэлээ цэвэр байлгаж байж л туулан гэтлэх номын цогцосыг бясалгаж болно. Тэгж чадахгүй бол та нар энгийн номын цогцосыг бясалгах нь илүү дээр, Наму Авид бурхан гэж унших нь хамгаас аюулгүй, эсвэл өөр бусад номын багшид очоорой, гадуур олон номын багш байна, бүгд энгийн номын цогцосыг сургадаг, та нар Багшаасаа энгийн номын цогцосыг сурья гэвэл би бас тэдэнтэй адилхан зүйлийг зааж сургана. Хэрэв нэг, хоёр, гурав, дөрөв гэж амьсгалаа тоолох аргыг сурахгүй бол ном хаялцахыг сургана, эсвэл Нууц тарнийн ёсонд сургаж, “ум ма ни пад ми хум” гэж хэдэн арван мянган удаа уншуулна. Очирт тарнийг хэдэн арван мянган удаа уншуулна, би та нарт үргэлжлүүлэн мах идэхийг сургаж чадахгүй, харин Туулан гэтлэх номын цогцосыг сургаж чадна.

Би хүмүүсийг мэхэлж болохгүй, баталж чадахгүй, учир нь та нар дэндүү ихээр мах идэж, архи ууж, дэндүү ихээр жарган цэнгэж, дэндүү цагталан байвал бясалгах үед яршиг төвөг удаж, мэдрэл чинь хэвийн биш

болж, сэтгэл чинь тайвширч чадахгүй болно. Тиймээс сурахгүй байх нь хамгийн сайн, сурвал аюултай зүйл болохоос би эмээж байна. Бас та нар өдөр бүр хэдий их мах идэж, хэдий их архи уудгийг би мэдэхгүй, та нар Багштайгаа үргэлж ойр байдаггүй болохоор Багш нь та нарт мах бага идээрэй, архи бага уугаарай гэж өдөр бүр сануулж чадахгүй.

Үнэн хэрэгтээ би ингэж сануулж зүрлэхгүй, идэж уух нь та нарын хувийн амьдрал болохоор би хүний амьдралд хөндлөнгөөс дэндүү их оролцож чадахгүй. Гэвч Багш нь та нарт бясалгах аргыг сургасны дараа та нарт ямар нэг асуудал гарвал би маш их харамсаж гэмшинэ, тиймээс би сургаж зүрхлэхгүй. Багшаасаа сурья гэвэл золиос төлөөс гаргах хэрэгтэй. Үнэндээ төлөөс гаргана гэхээр бас тун инээдэмтэй хэрэг, төлөөс гаргах гэмээр зүйл байхгүй, угаас нэг зүйлийн цэвэр ариун амьдралаар амьдарч, мах идэхгүй, архи уухгүй, тамхи татахгүй байвал зохино. Гэтэл одоо энэ бүхнийг огоорох нь нэг зүйлийн зардал үрэгдэл болоод хувирчихжээ. Бид ямарваа нэгэн зүйлийг сурахдаа тэр нь эрхбиш аюулгүй байх баталгаатай байх хэрэгтэй, тийм биш бол сурахын хэрэггүй, “Наму Авид бурхан” гэж уншина, ном судар уншина, бурханд мөргөнө гэх нь илүү дээр.

Жинхэнэ Нууц тарнийн номын цогцосыг сурахад тийм ч хялбар биш, сайтар чармайх хэрэгтэй. Өдөр бүр бурханд мөргөх хэрэгтэй, ихдээ хэдэн зуун удаа мөргөнө, өдөр бүр “ум ма ни пад ми хум” гэж уншина, эсвэл өөр бусад тарнийг хэдэн арван мянган удаа уншина. Зулайгаа (Эсэрваагаа) адислуулна, толгойгоо адислуулна, тун олон зүйлийг адислуулна гэхчлэн тийм ч хялбар биш. Би Нууц тарнийн номын цогцосыг сурч байх үед тун ээдрээтэй санагдаж байсан. Миний бодоход Арьяабалын номын цогцос л хамгийн хялбар, хамгийн төгс төгөлдөр, хамгийн аюулгүй, хамаг төрөлтөнд хамгийн тохирох номын цогцос юм. Гэвч маш олон хүн энэ аргыг тун бэрхтэй гэж боддог, Арьяабалын номын цогцостой харьцуулбал Нууц тарнийн номын цогцос нь үнэнхүү бэрх, тун ээдрээтэй номын цогцос билээ.

Гэрээс гараагүй хүмүүс яаж тийм их цаг завтай байж, нууц тарнийн аргыг бясалгаж чаддагийг би мэдэхгүй, гэрээс гарагчид л бясалгаж чадна, гэрээс гараагүй хүмүүст бясалгах цаг тун бага, бясалгасан ч ач тусгүй. Зөн билиг, ид шидийг сурья гэвэл Нууц тарнийн номын цогцосыг бясалгаж болно, гэвч сурахын тулд ламыг эрж олоод суралцах хэрэгтэй, би тийм зүйлийг сургадаггүй, даяанд сууж “би хэн бэ” гэж ном хаялцъя гэвэл даяанчийг эрж суралцаарай. Би даяанч биш, нууц тарнийх ч биш, бохир ч биш, цэвэр ч биш, зөвхөн Арьяабалын номын цогцосыг сургадаг. Хэрэв та нар Арьяабалын номын цогцосыг худалдан авъя гэвэл Багшаасаа аваарай, харин өөр зүйлсийг худалдан авъя гэвэл тийм зүйлсийг худалддаг хүмүүс дээр очоорой.

Би сургаж чадахгүй биш, юуг ч сургаж чадна, гэвч та нарын бие, хэл, сэтгэл цэвэр биш бол асуудалтай болохоос чинь эмээдэг. Тиймээс та нар өөр газарт очиж бусдаас суралцахыг хүснэ. Тийм энгийн бясалгалын аргыг худалдаж байгаа хүмүүс хаа сайгүй байдаг байтал яагаад Багш



дээрээ ирж худалдан авах гэдэг вэ? Багш нь та нарт энэхүү Арьяабалын номын цогцосыг сургалаа ч гэсэн та нар туулан гэтэлж чадахгүй. Учир нь сав чинь цэвэр биш болохоор саван дахь ус чинь ч цэвэр биш болно, тиймээс сургаж болохгүй, энэ нь Багш нь хатуу байгаагаас болсон юм биш.

Энэ номын цогцос минийх биш, хүч нь ч мөн адил миний хувийнх биш, нийтийнх, хэдий чинээ олон хүнд өгнө, төдий чинээ сайн, гэвч хангалттай нөхцөл байдал бүрдээгүй бол өгч болохгүй. Ингэх нь та нарын хувь хүний аюулгүй байдлыг хамгаалахын төлөө юм. Хэрэв бурхан болохыг хүсч байгаа атлаа нэг жаахан зардал төлөөс гаргаж чадахгүй байгаа бол сурч хэрэггүй, эндээ үлдээд ертөнцийн жаргалыг эдэлсэн нь дээр. Энэ ертөнц та нарын хувьд их тааламжтай биш үү, одоог хүртэл таатай байгаа биш үү? (Бүгдээрээ инээлдэв) Нийгэмд байр суурьтай, эхнэртэй, эр нөхөртэй, хүссэн жаргалаа бүгдийг эдэлнэ, Бурхан болж юугаа хийх вэ? Бурхан болох нь тун зүдгүүртэй шүү дээ.

Багшийн чинь бясалгалын зам мөр тун амаргүй замыг туулсан, би та нарт ярьж өгье. Хүүхэд байхаасаа бясалгал хийхийг хүсч, насанд хүрснийхээ дараа аль улсад ямар сайн номын багш байна гэж сонсонгуутаа л тэр даруй эрж хайсаар очдог, бясалгал хийдэг хүнийг харах бүртээ ёслон мөргөж, ном гуйдаг, маш хүнд замыг туулан зүдэрч явсны эцэст хамгийн дээд номын цогцосыг эрж олсон. Одоо энд ирээд долоо хоног ном тайлж, хамгийн ховор, хамгийн үнэтэй эрдэнэсийг та нартай хуваалцъя гэтэл сурах хүн хэр олон байна аа? Та нар сурахын төлөө яарч хичээхийн оронд яагаад Багштайгаа наймаалцаж гээд байна вэ? Ингэх нь ямар ач тустай байх вэ, зөвхөн цагийн гарз төдий л хэрэг.

Миний бодоход, та бурхан болохгүй бол хамгийн сайн, тэнэг хүн л бурхан болдог, Багш нь ийм тэнэг юм болов уу, хамаг төрөлтний зовлонг хараад тэднийг туулан гэтэлгэхийг хүссэн, тэд жинхэнэ Их Багшийн удирдлага, дагуулал байхгүй учраас туулан гэтэлж чадахгүй байна, тэд бүгд бурхан болохыг хүсдэг гэж би бодсон. Тиймээс би хүнд бэрх зам туулсан ч хамаагүй туулан гэтлэх аргыг олж, түргэн бясалгаж, арга замыг нь мэдсэний дараа буцаж ирээд хамаг төрөлтөнд зааж өгөхийг хүссэн. Гэвч энэ нь хялбар биш аж, тэд хүлээж авахгүй, авлаа ч үргэлжлүүлэн бясалгахгүй, тэр ч байтугай хэсэг хугацаа өнгөрсний дараа эргээд Багшийгаа гүтгэж, тун ихээр буруутгаж мэднэ. Тиймээс бурхан болоход сайн гэмээр зүйл алга, бурхан болох хэрэггүй, хараахан бурхан болоогүй байгаа дээрээ зогсоорой, бясалгах хэрэггүй, ертөнцийн жаргалыг эдэлж, хань ижилтэй болох нь тун сайн, мах идэж, архи уух нь сайн, тамхи татаж, мөрийтэй тоглох сайн, бурхан болоод юу хийх вэ?, тэгээд тамд очтолоо хүлээ, тэгээд тамд унасны дараа харин дахин ярилцъя! Бурхан болсны дараа хэн нэгнийг аваръя гэхэд мөн л тун төвөгтэй, бусдыг аврах нь амар хялбар биш. Есүс Христ загалмай модонд хадуулсан, Шагжамуни Бурхан бусдад байнга гүтгэгдэн доромжлуулж, амиа алдахад хүрч байсан. Хүй Нэн багшийг бас хүмүүс хороох гэж байсан. Энэтхэгт маш олон Төгс Гэгээрсэн Их Багш шийтгэл, залхаан цээрлүүлэлтийг туулж

өнгөрүүлсэн, заримыг нь халуун наран дор сөгдүүлж суулган заримыг нь элсэн цөлд цөлсөн байдаг. Энэтхэг маш халуун орон, тэнд зарим Их Багшийг гадаа халуун наранд төмөр хавтан дээр сөхрүүлэн олон цагаар суулган шийггэж залхаадаг, учир нь тэд түүнийг Их Багш гэдэгт нь итгэдэггүй, тэр ч байтугай зарим Их Багшийн биеийг хэсэгчлэн огтолж, хөнөөж байсан түүх бий. Энэ ертөнцөд бурхан болох нь үнэхээр амаргүй, ямар ч сайн зүйл байхгүй.

Та нар бясалгал хийхгүй, ургамал хоол идэхгүй, бурхан болохгүй гэвэл би сайшаан зөвшөөрнө, харин би одоо өөртөө тун харамсан гэмшиж байна, гэвч дэндүү оройчихжээ, дахин эгэл хүн болж чадахгүй болсон. Учир нь нэгэнт дадал болчихсон, та нар мах идэх заншлаа өөрчилж чадахгүйтэй адил би бас ургамал хоол идэхээ өөрчилж чадахгүй, түүнийгээ тууштай баримталдаг, тиймгүйсэн бол би даруй өөрчилнө, одоо би бас гэрлэхийг хүсдэггүй, тийм бишсэн бол гэртээ буцаж очоод гэрлэнэ (Бүгдээрээ инээлдэв). Эгэл хүн байх сайн, харин энэ эгэл ертөнцөд бурхан байх амаргүй, хэрэв та үргэлжлүүлэн энэ ертөнцийн жаргалыг эдлэе гэвэл эндээ үлд, гэхдээ харин бурхан бодьсатва нарыг аврахгүй байна гэж битгий зэмлээрэй.

Бидний ертөнцөд одоо зөвхөн пестицид төдий ч биш, бас хорт хий, нисэх онгоц, машин механизм, цацраг туяа, атомын бөмбөг гэхчлэн тун олон зүйл байдаг. Бид тун олон атомын бөмбөгийг туршин дэлбэлснээс дэлхийн бөмбөрцгийн хамгаалалтын давхаргыг эвдэлж, маш олон газар, жишээ нь: умард туйл, өмнөд туйлын агаар мандлын хамгаалалтын давхарга цоорч, дэлхий дахинд аюул учирсаар байна.

Тиймээс зөвхөн пестицид төдийгүй өөр олон аюултай зүйл биднийг хүлээж байна. Ингээд үргэлжлээд байвал үр нөлөө нь тун аймшигтай. Одооны ус ихэнх нь хортой, далайн амьтад, бүр загас, сам хорхой хүртэл үй олноороо хордож үхсээр байна. Учир нь үйлдвэрээс гарсан маш олон төрлийн хорт бодис бүхий хог хаягдлаас гадна бидний ахуйн хог хаягдлууд усанд хаягдаж, усыг бохирдуулснаар усны бохирдол маш ноцтой хэмжээнд хүрчээ, агаар мандал ч гэсэн тийм цэвэр ариун биш болжээ. Иймэрхүү бохирдолтой нөхцөл байдал хэдэн арван жил, тэр ч байтугай хэдэн зуун жилийн дараа ч хэвээр үргэлжилж, бүр ч илүү ноцтой болно.

Хэрэв та нар ийм байдлаас “таашаал хүртэхийг” хүсэхгүй байгаа бол хурдхан л эндээс яваарай. Хэдэн арван жил бясалгасны дараа явж болно. Хэрэв та нар бясалгахгүй эндээ үлдвэл хэдэн зуун жилийн дараа ч гэсэн улам их пестицид, илүү их хортой, бохирдсон агаарыг таашаасан хэвээр байж, юу идсэн ч бүгд урьдынх шигээ цэвэр ариун биш болсон байх болно.

Энэ дэлхийн бөмбөрцөг, хэрэв та нар одоо гаднаас нь харж чадвал, гадуураа хав хар агаараар бүрхэгдсэн байгааг олж харна, энэ нь заримдаа бүр бидний амьсгалдаг агаарт нэвтрэн орж ирдэг, учир нь агаар мандлын хамгаалалтын давхарга цоорчихсон байна. Хэдийгээр

дээд дэсийн олон төрөлтөн бидэнд тусалдаг ч тэд тун завгүй учраас тэр бүр тусалж амжихгүй байна, бидний эвдэж сүүдлэх хурд тэдний туслах хурдаас хурдан түргэн байдаг, энэ бөмбөрцөг хэдийд дэлбэрэхийг мэдэхгүй, тиймээс зөвхөн пестицидийн талаар битгий бод, түүнээс ч илүү ноцтой асуудлууд цаана нь байна. Та нар хэрвээ шинжлэх ухааныг судалдаг, анагаах ухаанд суралцдаг бол мэднэ, сонин уншиж, зурагт үзвэл мэднэ. Багш нь мэдээж сонин ч уншдаггүй, зурагт ч үздэггүй. Лууз хэлэхдээ: “Богд гэгээнтэн гэрээсээ гарахгүй ч гэлээ юм бүгдийг мэднэ, гэгээвчийн цаадах хамаг бодисын байдлыг харахгүй ч гэсэн “Дао” (Мөр ёс)-г ойлгож чаддаг” гэсэн билээ. (Мөр ёсны судрын 47-р бүлэг: “Гэрээсээ гарахгүй ч дэлхий дахиныг мэддэг, хамаг бодисыг харахгүй ч тэнгэрийн ёсыг ойлгодог”.)

Тайлбар:

(Хятадын домог үлгэрт гардаг, хүмүүсийг гай барцадаас зайлуулж, зовлонгоос авардаг ид шидтэй, нэгэн охин тэнгэр. Орч.)

Уламбана баяр: Буддын шашны чухал баяр бөгөөд “Улламбана судар”-аас эхтэй. Бурхны шашинт улс орнуудад билгийн тооллын зуны адаг сарын 15-нд тэмдэглэдэг, хуврагуудын адислал, залбиралд талархаж буй баяр ёслол, зан үйл. Энэ өдөр Бурхан Багш, хуврагийн бүлгэм (сангха) болон өвгө дээдэстээ өргөл тахил өргөдөг. Бурхны шашинт хүн энэ байр ёслолыг даган баяссанаар эцэг, эхийгээ гурван ертөнцийн зовлонгоос ангижруулж чаддаг гэж үздэг аж. (ред.)

(Yu Huang Da Di - Бумбын шашны Хамаг сахиусын тэргүүн - орч.)

(Hua Yan - Нэг зүйлийн диваажингийн нэр-орч.)

АВАТАРА [Самгарьд. - (бурхны) “уруудалт”] - Хинду шашинд Кришна, Рама баатруудын дүрд хувирсан Вишну бурхны хувилгаан, бодон гахай, одой хүн гэх мэтийн дүрд хувирч, дэлхий дээр баатарлаг үйлс бүтээдэг. Домог үлгэрт гардаг Вишнугийн 10 Аватар хамгийн алдартай нь.

(латин хэлний *causalis* - шүтэн барилдлагат, учир шалтгааны бие - ред.)

(фр: *mental* лат: *mens (mentis)* – санаа бодлын дүр төрх, сэтгэлийн агуулах - оюун сэтгэлгээний бие - ред.)

Buddha (Буддха –энэ үгийг монгол хэлний бурха (бургас) гэдэг үгтэй төстэй дууддаг учраас Бурхан гэх болжээ. Бурха гэдэг нь эртний монголчуудад өвгө дээдсээ тавьсан газарт бургас хатган босгож, дээд тэнгэрийг тахидаг байсан ёс заншилтай холбоотой бололтой гэж үзэх нь бий. Википедиа тольд: Бөө мөргөлийн онгон савдаг, бургас бутны эзэн; гэжээ. Ард гэвэл олон тоо, аран гэвэл ганц тоо заадагтай адил бургас гэвэл олон тоо, бурхан гэвэл ганц тоо зааж байгаа хэрэг ажээ. - ред)

## ВЕГАН ХООЛНЫ АЧ ТУС

Насан турш веган (ургамал) хоолтон байх буюу ургамал хоол хэрэглэх нь Арьяабалын Бясалгалын (Quan Yin Method) авшиг хүртэх тэргүүн нөхцөл юм. Ургамлын гаралтай зүйлсийг хүнсэнд хэрэглэж болох ч өндөг болон амьтны гаралтай аливаа хоол хүнсийг идэж болохгүй. Үүнд олон шалтгаан байдаг ч хамгийн чухал нь амьтны амь хороож болохгүй гэсэн нэгдүгээр сахил буюу амьтныг бүү хөнөө гэдгээс үүдэлтэй.

Амь хороохгүй байх, бусад амьд биест хор хүргэхгүй байх нь тэдгээр амьтанд ач тустай нь мэдээжийн хэрэг билээ. Бусдад хор хөнөөл учруулахгүй байх нь бидэнд ач тустай болох нь тэр бүр илт харагддаггүй. Энэ нь “ямар үйл хийнэ, тийм үр байна” гэсэн үйлийн үрийн хуулиар зохицуулагддагаас тэр юм. Мах идэх шунал хүслээ хангахын тулд амьтны амь хөнөөх, эсвэл бусдаар амьтны амь хороолговол та амь насны төлөөсөнд унаж, хэзээ нэгэн цагт заавал төлөх ёстой болно.

Веган хоол идэх нь үнэндээ бидний өөртөө барьж буй бэлэг юм. Ингэснээр бид хураасан асар их үйлийн үрээ нимгэлж, амьдралын чанараа сайжруулан өөрийгөө улам чөлөөтэй сайхнаар мэдрэх төдийгүй, дотооддоо нэвтэрч диваажингийн нууцлаг, шинэ содон зүйлсийг ч мэдрэх болно. Энэ бүхнийг та веган хоол идсэнээрээ хүртэж буй хэрэг юм.

Зарим хүн сүнсэлэг үзэл бодлоор махнаас татгалзуулдаг нотолгоонд нь итгэдэг ч веган хоолтон байхыг хөхиүлэн дэмждэг өөр олон зайлшгүй учир шалтгаан бий. Эдгээр нь хүний эрүүл мэнд, хоол хүнсний шим тэжээл, байгаль экологи, ёс суртахуун, амьтдын зовлон, дэлхийн өлсгөлөн зэрэг асуудалтай холбоотой юм.

## ЭРҮҮЛ МЭНД БА ХООЛ ХҮНС

Хүн төрөлхтний хувьслын түүхээс үзвэл манай өвөг дээдэс төрөлхийн ургамал хоолтон байжээ. Хүний бие махбодын бүтэц нь мах идэхэд зохицоогүй. Колумбын их сургуулийн доктор Г.С.Хантинген хүний биеийн бүтэц зүйн харьцуулсан судалгааны өгүүллээрээ үүнийг нотолсон байна. Тэрээр махчин амьтны нарийн, бүдүүн гэдэс нь богино байдгийг анзаарчээ. Махчин амьтны бүдүүн гэдэс шулуун бөгөөд гөлгөр байдаг. Харин мах иддэггүй амьтны нарийн, бүдүүн гэдэсний аль аль нь урт байдаг. Махан дахь эслэгийн агууламж бага, уургийн нягтрал ихээс шим тэжээлийг шингээхэд урт хугацаа шаардагддаггүй тул махчин амьтны гэдэс богино байдаг аж.

Төрөлхийн ургамлаар хооллогч бусад амьтны нэгэн адил хүн төрөлтний бүдүүн, нарийн гэдэс нь урт байдаг. Бидний гэдэсний нийт урт барагцаалбал 8.5 метр (28 фут), олон нугалаатай, хана нь хуниастай, гулгамтгай биш, махчин амьтны нарийн гэдэснээс урт тул идсэн мах гэдэсэнд удаж ялзран хорт бодис ялгаруулдаг. Энэ нь шулуун гэдэсний хорт хавдар үүсэхтэй холбоотой төдийгүй элэгний ачааллыг ихэсгэж, элэгний хатуурал, элэгний хорт хавдар үүсэхэд хүргэнэ. Маханд ихээр агуулагддаг урокинез уураг, шээсний хүчил нь бөөрний ачааллыг ихэсгэж, үйл ажиллагааг нь алдагдуулдаг. Хагас килограмм шарсан үхрийн маханд 14 грамм урокинез уураг агуулагддаг. Амьд эсийг шингэн урокинез дотор хийхэд бодисын солилцоо нь алдагддаг байна. Маханд эслэг эд, ширхэглэг бодис бага байдаг бөгөөд эслэг бодис дутагдвал өтгөн амархан хатдаг. Өтгөн хагах нь шамбарам болон бүдүүн гэдэсний хорт хавдрыг үүсгэдэг.

Махан дахь холестерин, ханасан өөх нь зүрх судасны өвчин үүсгэдэг. Зүрх судасны өвчин нь америкчуудын нас баралтын шалтгааныг тэргүүлдэг бөгөөд өнөө үед Тайваньд ч мөн адил болжээ.

Хорт хавдар нь үхэлд хүргэж буй хоёр дахь том шалтгаан юм. Махыг шарж хайрахад метилхолантрен хэмээх химийн бодис үүсдэг. Энэ нь маш хүчтэй хорт хавдар үүсгэгч болохыг туршилтаар нотолжээ. Нядалгааны газрууд мэргэжлийн байгууллагын хяналтад байдаг тул махны эрүүл ахуй асуудалгүй гэж ихэнх хүн үздэг. Үнэн хэрэгтээ нядалгааны газарт өдөр бүр маш олон үхэр, гахай, тахиа, нугас зэргийг алж худалддаг. Тэр бүхний хорт хавдартай эсэхийг нь нэг бүрчлэн шалгах бололцоогүй.

Амьтан нэг бүрийг бүү хэл зүсэм махан дахь хавдрын эсийг нягтлах нь туйлын бэрхшээлтэй. Орчин үеийн махны үйлдвэрүүдэд амьтны толгой нь сэжигтэй бол толгойг нь, хөл нь өвчтэй бол хөлийг нь хаяж маягаар өвчтэй хэсгийг салгаж бусдыг нь худалдаж байна. Ургамал хоолтон эмч, нэрт доктор Ж.Х.Келлог: “Бид веган хоол идвэл хоол хүнс маань ямар өвчнөөр үхсэн бол гэж санаа зовохгүй, айдасгүй амар тайван хооллоно!” гэжээ.

Өөр нэгэн санаа зовоож буй зүйл бол бордоо тэжээл, антибиотик болон өсөлт хурдасгах даавар, стероид зэргийг агуулсан эм бэлдмэлийг амьтны тэжээлд холих буюу биед нь шууд тарьдаг явдал. Ийм мах идвэл эдгээр бодис хүний биед шингэдэг болохыг нийтэд мэдээлсэн байна. Махан дахь антибиотик нь хүмүүсийн эмчилгээнд хэрэглэж буй антибиотикийн үйлчилгээг бууруулах магадлалтай.

Зарим хүн веган хоол идэхэд шим тэжээл дутагдана гэж үздэг. Америкийн гэмтэл согогийн эмнэлгийн мэргэжилтэн, доктор Миллер Тайваньд дөч гаруй жил ажилласан бөгөөд эмнэлгийн ажилтан, өвчтөн нь цөмөөрөө веган хоол иддэг эмнэлэг байгуулсан байна. Тэрээр: “Орчин үеийн шинжлэх ухааны ачаар эм, эмнэлгийн шинжлэх ухаанд их дэвшил гарсан ч эм нь зөвхөн өвчнийг л анагаана. Харин хоол хүнс бол эрүүл мэндийг тэтгэнэ” гэжээ. Мөн тэрээр: “Ургамлаас авч буй шим тэжээл нь махныхыг бодвол бидэнд шууд хүрнэ. Учир нь амьтад ургамлаас шим тэжээлээ авдаг. Ихэнх амьтан нас богинотой, хүмүүн төрөлтөнд байдаг ихэнх өвчнийг тээж байдаг. Иймээс хүн төрөлтний өвчин эмгэгийн ихэнх нь өвчтэй малын мах идсэнээс үүсэлтэй байх магадлал тун өндөр. Хүн яагаад шим тэжээлээ ургамлаас шууд авдаггүй юм бэ?” гэжээ. “Үр тариа, буурцагт ургамал, хүнсний ногооноос хангалттай шим тэжээлээ авч, эрүүл саруул байх бүрэн боломжтой” гэж Доктор Миллер үзсэн байна.

Амьтны уураг төгс, ургамлынх төгс бус учраас амьтны уураг ургамлынхаас илүү гэж олон хүн үздэг. Үнэндээ зарим ургамал төгс уурагтай. Хүнсний бүтээгдэхүүнүүдийг хооронд нь зөв харьцаагаар хольж төгс уураг үүсгэж болно.

Америкийн Хоол Судлалын холбооноос 1988 оны гуравдугаар сард “Шим тэжээлт чанарыг нь зохистой тохируулж чадвал веган хоол нь эрүүл мэндэд ашигтай, хангалттай шим тэжээлтэй” гэж зарлажээ.

Мах иддэг хүмүүс веган хоолтнуудаас хүч чадалтай байдаг гэсэн төөрөгдөл түгээмэл байдаг. Йелийн их сургуулийн профессор Ирвинг Фишер 32 веган хоолтон, 15 махан хоолтон оролцсон туршилт хийхэд веган хоолтнууд нь илүү тэсвэр хатуужилтай байжээ. Туршилтад оролцогсдыг удаан хугацаагаар гарыг нь өргүүлэхэд үр дүн нь тун тодорхой байв. Мах иддэг 15 хүний 2 нь л арван таваас гучин минут өргөсөн бол веган хоолтон 32 хүний 22 нь арван таваас гучин минут, 15 нь хагас цаг, 9 нь нэг цагаас дээш, 4 нь хоёр цагаас дээш, нэг нь гурван цагаас дээш хугацаагаар өргөсөн байна.

Марафон гүйлтийн тамирчид тэмцээний өмнө веган болон цагаан хоол иддэг байна. Цагаан хоолоор эмчлэх мэргэжилтэн, эмч Барбара Море 200-гаад км зайг 27 цаг 30 минутад туулжээ. Тавин зургаан настай энэ эмэгтэй залуучуудын тогтоосон дээд амжилтыг эвдсэн байна. Тэрээр: “Веган хоолтон хүн эрүүл чийрэг, ухаан саруул, цэвэр ариун амьдралтай байдгийг харуулах жишээ нь байхыг би хүссэн юм” гэжээ.

Веган хоолтон хоол хүнснээсээ хангалттай хэмжээний уураг авч чаддаг уу? Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөснөөр бид өдөр тутам авах илчлэгийнхээ 4,5 хувийг нь уургаас авч болно. Буудайн 17%, ногоон цэцэгт байцайны 45%, цагаан будааны 8%-ийн илчлэгийн эх үүсвэр нь уураг юм. Иймээс мах хэрэглэхгүй веган хоол идвэл хоол хүнснээсээ хангалттай уургийг амархан авч болно. Хүртэж болох өөр ач тус гэвэл өөх тосыг хэтрүүлснээс үүсдэг зүрх судасны өвчин, хорт хавдар зэргээс зайлсхийж чадна. Иймээс веган хоол идэх нь хамгийн зөв сонголт гэдэг нь илэрхий байна.

Зүрх судасны өвчин, хөхний болон шулуун гэдэсний хавдар, тархины саа өвчнөөр өвчлөх нь ханасан өөх тос ихээр агуулдаг мал амьтны гаралтай хүнсний хэт их хэрэглээтэй холбоотой нь батлагдаад байна. Тос багатай веган хоол идсэнээр бөөрний чулуу, булчирхайн хавдар, чихрийн шижин, арван хоёр нугалаа гэдэсний шархлаа, цөсний чулуу, ходоодны архаг үрэвсэл, үе мөчний үрэвсэл, буйлны өвчин, багга, нойр булчирхайн хавдар, ходоодны хавдар, цусан дахь чихрийн хэмжээ багасах, өтгөн хатах, дивертикулит, цусны даралт ихсэх, яс сийрэгжих, өндгөвчний хавдар, шамбарам, хэт таргалалт, багтраа зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлж, явцыг нь сааруулж тэр ч байтугай эмчилж болно

Тамхийг эс тооцвол хүний эрүүл мэндийг мах шиг хохироож байгаа зүйл байхгүй байна.



## ЭКОЛОГИ БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

Мах идэхийн тулд мал амьтан тэжээх нь дараах хор уршигтай. Үүнд: ширэнгэн ойг сүйтгэх, дэлхийн дулаарал, усны бохирдол, усны нөөц хомсдол, цөлжилт, эрчим хүчний гарздал болон дэлхийг хамарсан өлсгөлөн зэрэг болно. Газар, ус, эрчим хүч, хүний нөөцийг мах боловсруулахад ашиглаж байгаа нь дэлхийн нөөц баялгийг үр ашиггүй зарцуулж байгаа хэрэг юм.

1960-аад оноос Төв Америкт үхрийн бэлчээрт зориулан халуун бүсийн ойн 25 орчим хувийг шатааж устгасан байна. Тооцоолсноос үзэхэд шатааж устгасан 5 метр квадрат ой тутмаас 115 грамм бургерын мах үйлдвэрлэжээ. Үүнээс гадна үхэр тэжээхэд ихээр ялгардаг гурван төрлийн хорт хий нь дэлхийн дулаарлыг ихэсгэдэг. Мөн 450 грамм үхрийн мах үйлдвэрлэхэд 9117 литр ус зарцуулдаг нь үнэхээр цочирдмоор. Гэтэл 450 грамм улаан лооль ургуулахад ердөө 107 литр ус, тийм хэмжээний цагаан талх үйлдвэрлэхэд 514 литр ус хэрэглэдэг. АНУ хэрэглээний усныхаа тэн хагасыг тэжээл бордоо тарих, үхэр тэжээх болон бусад мал амьтны хэрэгцээнд зарцуулж байна.

Үхэр бордоход хэрэглэж байгаа нөөц баялгаар үр тариа үйлдвэрлэж, дэлхийн хүн амыг хангавал маш олон хүн идэх хоолтой болох сон. Хэрэв нэг акр газарт овъёос тарьж малд биш хүмүүсийн хүнсэнд хэрэглэвэл махныхаас 8 дахин их уураг, 25 дахин их илчлэг өгнө. Нэг акр газарт тарьсан ногоон цэцэгт байцаа (брокколи) нь ийм хэмжээний газраас гаргаж авсан үхрийн махнаас 10 дахин их уураг, илчлэг, ниацин өгдөг. Иймэрхүү тоо баримт маш их. Мал амьтан тэжээж буй газарт хүнсний таримал таривал дэлхийн нөөц баялагийг илүү үр ашигтайгаар зарцуулна.

Веган хоол танд энэ дэлхий дээр “өр төлөөсгүй амгалан амьдрах” боломж олгоно. Зайлшгүй чухал зүйлээ хэрэглээд амь хороохоо багасгаж, хоолноос минь болж амьтны амь сүйдээгүй гэж бодохоор таны сэтгэл амар байх болно.

## ДЭЛХИЙН ӨЛСГӨЛӨН

Дэлхийн бөмбөрцөг дээр нэг тэрбум орчим хүн өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдлаас шаналан зовж байна. Жилд 40 сая хүн өлсөж үхэж байгаагийн ихэнх нь хүүхэд юм. Гэтэл үүнийг үл харгалзан дэлхийн үр тарианы гуравны нэгийг хүмүүсийн хоол хүнсэнд бус, мал аж ахуйн хэрэгцээнд зориулж байна. АНУ-д үйлдвэрлэсэн үр тарианыхаа 70%-ийг малын тэжээлд хэрэглэж байна. Хэрвээ бид энэ үр тариагаар хүмүүсийг хоолловол хэн ч өлсөхгүй.

## АМЬТНЫ ЗОВЛОН

Америкийн Нэгдсэн Улсад өдөр бүр 100 гаруй мянган үхэр нядалдгийг та бүхэн харсан уу?

Өрнөдийн орнуудад ихэнх мал амьтныг “үйлдвэржсэн аж ахуй”-д тэжээж байна. Энэ фермүүд бага зардлаар олон мал, амьтдыг нядлахаар тооцоолж баригдсан байдаг. Мал амьтныг зайгүй чихэлдсэн тун хэцүү орчинд байлгаж, тэдэнд, тэжээлийн мах бэлтгэдэг машин мэтээр хандаж байна. Бидний ихэнх нь бодит байдлын үнэн төрхийг өөрийн нүдээр хэзээ ч олж хараагүй. “Чи нядалгааны газар нэг л очвол насаараа веган хоолтон болно” гэсэн үг байдаг.

Лев Толстой: “Нядалгааны газар байгаа цагт дайны талбар байсаар байх болно. Ургамал хоол бол хүнлэг энэрэнгүй чанарын өндөр дээд шалгуур юм” гэжээ. Бидний ихэнх нь амьтны амийг санаатайгаар хөнөөдөггүй ч нийгмийн зуршлаа дагаад байнга мах иддэг дадалтай болсон бөгөөд идсэн амьтандаа ямар хор хөнөөл учруулснаа үнэндээ ойлгодоггүй.

## ГЭГЭЭНТНҮҮД БА ҮЙЛС НЭГТНҮҮД

Хүн төрөлхтний тэмдэглэж үлдээсэн эртний түүхээс үзэхэд ургамал нь хүн төрөлхтний байгалиас заяасан хоол хүнс байжээ. Эрт үеийн Грек болон Еврейн домог үлгэрт хүмүүс анхнаасаа жимс, жимсгэнэ иддэг байсныг өгүүлдэг. Эртний Египетийн билиг ухаант хуврагууд хэзээ ч мах иддэггүй байв. Грекийн агуу их философичид жишээ нь, Платон, Диоген, Сократ нар ургамал хоол идэхийг шийдвэртэй дэмждэг байв.

Энэтхэгт Шагжамуни Будда “Ахимса” буюу аливаа амьтанд хор хөнөөл учруулахгүй байхыг чухалчлан тэмдэглэж, амьтдыг айдаст автуулахгүйн тулд мах идэхгүй байхыг шавь нартаа дахин дахин анхааруулж байв. Будда: “Мах идэх нь ердөө л олдмол зуршил төдий. Бид мах идэх хүсэлтэй төрөөгүй. Мах идвэл их нигүүлслэлийн үр тасарна. Мах идэгчид бие биеэ алж иддэг. Энэ төрөлд би чамайг, дараа төрөлд чи намайг иднэ гэхчлэн хэзээ ч таслах аргагүй. Ийм хүн яаж гурван ертөнцийг гэтлэх вэ?” гэж өгүүлжээ.

Эрт үеийн Дао, Христ, Еврейн шашны олон лам хувраг ургамал хоолтон байжээ. Энэ талаар Библид тун тодорхой тэмдэглэсэн байна. Эзэн Бурхан: “Би та нарыг идэг гэж элдэв зүйлийн жимс, төрөл төрлийн үр тариа өгөв. Харин хээрийн амьтад болон бүх шувууны хоол тэжээл болгож, өвс ногоо, навчит ургамлыг өглөө” гэж (Genesis, 1:29) Ариун Библид өгүүлжээ. Библид мах идэхийг цээрлэсэн өөр нэг жишээ нь гэвэл: “Амьтны мах, цусыг идэх ёсгүй. Цус амьтай” гэсэн үг юм. (Genesis, 9:4) Эзэн Бурхан: Хэн та нарыг энэ эр үхэр, эм ямааг алж, надад тахил өргө гэсэн юм бэ? Намайг мөргөл залбирлаа сонсоосой гэж байгаа бол гэмгүй амьтны цуснаас өөрийгөө цэвэрлэхтүн. Тэгэхгүй бол би та нараас нүүр буруулна. Яагаад гэвэл та нарын гар нэлдээ цустай байна. Надаар өршөөж уучлуулахын тулд гэм нүглээ наманчил.” (Isaiah: 11-16) гэж хэлжээ. Есүсийн шавь нарын нэг Гэгээн Павел Ромчуудад илгээсэн захидалдаа: “Мах идэхгүй, дарс уухгүй байх нь аль аль нь сайн хэрэг” гэсэн байдаг. (Ромчуудад илгээсэн захидал, 14:21).

Саяхан түүхчид Есүсийн амьдрал болон сургаалыг шинээр тодруулсан олон эртний судар ном олж илрүүлсэн байна. Есүс: “Амьтны мах иддэг хүмүүс өөрсдийнхөө булш нь болдог. Та нарт үнэнээр нь хэлэх юм бол алж хөнөөж байгаа хүн өөрөө алагдах болно. Амьд амьтныг хөнөөж, махыг нь идэж буй хүн бол хүний үхдэл хүүрийн мах идэж

байгаа хэрэг юм.” гэжээ.

Энэтхэгийн шашнууд ч бас мах идэхийг цээрлэдэг. Энэ нь “Хүн амьд амьтныг хөнөөхгүйгээр махыг нь идэж чадахгүй. Амьд амьтныг зовоож тарчлааж буй хүнийг Эзэн Бурхан хэзээ ч адислахгүй. Тийм учраас мах идэхийг цээрлэ!” (Энэтхэг шашны сахил).

Исламын Ариун судар Коранд: Үхсэн амьтны мах, цусыг идэхийг хориглосон байдаг.

Хятадын агуу их Зэн Багш Хань Шань-Зу мах идэхийг эрс эсэргүүцсэн найраглал туурвиж: “Эхнэр хүүхдээ тэжээхээр зах зээлээс мах, загасхан худалдан авах гэж яарах хэрэг юун. Таны амьдралыг тэжээж тэтгэхийн төлөөнөө эдний амь тасрах заавал албатай юу? Ингэхийн утга учир алга. Энэ нь таныг диваажинд хүргэхгүй, харин тамын хог новш болгоно!” хэмээжээ.

Маш олон алдарт зохиолч, урлаач, эрдэмтэн, гүн ухаантан, гарамгай хүмүүс ургамал хоолтон байжээ. Үүнээс жишээ болгон цөөхнийг дурдвал: Шагжамуни Будда, Есүс Христ, Вергилий, Гораций, Платон, Овидий, Петрарка, Пифагор, Сократ, У.Шекспир, Вольтер, И.Ньютон, Леонардо Да Винчи, Чарльз Дарвин, Бенжамин Франклин, Ральф Уолд Эмерсон, Хенри Дэйвид Торо, Эмиль Золя, Бертран Рассель, Ричард Вагнер, П.Б.Шелли, Х.Ж.Уэллс, Алберт Эйнштейн, Рабиндранат Тагүүр, Лев Толстой, Жорж Бернард Шоу, Махатма Ганди, Алберт Швейцер болон орчин үеийнхнээс цөөхнийг дурдах юм бол Пол Ньюмен, Мадонна, Диана гүнж, Линдсей Вагнер, Пол Маккартни, Кандис Берген нар ургамал хоол идэх ёсыг зориг төгс сайшаан дагаж байв.

Алберт Эйнштейн хэлэхдээ: “Миний бодлоор бол ургамал хоолны улмаас хүний зан чанарт гардаг өөрчлөлт, ариусгах нөлөө нь хүн төрөлхтөнд ихээхэн ашигтай юм. Иймээс хүмүүс ургамал хоол идэхийг сонгох нь буян хишигтэй болоод амар амгалан хоёр талтай” гэжээ. Энэ бол хүн төрөлхтний түүхэн дэх сод гарамгай, цэцэн мэргэн олон хүний номлосоор ирсэн сургаал билээ.

## АВШИГ ХҮРТЭХҮЙ - АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГА

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Үнэнийг таньж мэдэхийг чин сэтгэлээсээ эрмэлзэн тэмүүлж буй хүмүүст Арьяабалын бясалгалын аргыг сэтгэлийн авшгаар дамжуулан уламжилна. “Аялгуу ажих” гэдэг нь Хятадаар амарлин сууж, аялгууны хэлбэлзлийг ажиглах гэсэн утгатай. Энэ бясалгалын аргад дотоодын “Гэрэл” болон “Аялгуу”-г ажих багтана. Эртнээс нааш дэлхийн шашнуудын болон бясалгалын ном сударт дотоодын ийм ахуй ойлголтыг олонтоо дурдсан байдаг. Тухайлбал, Христийн шашны “Библи”-д: “Түмэн бодис аялгуунаас үүссэн. Энэ аялгуу Эзэн Бурхантай хамт байсан. Аялгуу өөрөө Эзэн Бурхан байсан” гэжээ. (Иохан 1-р бүлгийн 1-р хэсэг) Энэ аялгуу гэдгээр дотоодын аялгууг хэлжээ. Мөн “Бурханы хэл”, “Shabd”, “Дао”, “Аялгууны урсгал”, “Ум”, “Тэнгэрийн хөгжим” гэж бас нэрлэдэг. Их Багш Чин Хай: “Тэрээр түмэн бодисын дотор хэлбэлзэн бүхий л орчлон ертөнцийг гэжээн тэтгэдэг. Энэ дотоодын хэмнэл нь аливаа шархыг эмнэж, бүхий л хүсэл эрмэлзэлийг хангаж, эгэл ертөнцийн элдэв дур хүслийг намжаана. Тэрээр бүхнийг чадагч бөгөөд хайраар бялхаж байдаг. Бид энэ аялгуунаас үүссэн болохоор түүнтэй холбогдвол сэтгэл ханаж амарлина. Энэ аялгууг сонссоноор бид бүхэлдээ хувирч, амьдралын тухай үзэл бодол маань үндсээрээ өөрчлөгддөг.” гэжээ.

“Билиг нээгдэх” гэдгээр дотоодын гэрэл “Эзэн Бурханы гэрэл”-ийг хэлж байна. Гэрлийн хүч нь өчүүхэн багаас авахуулаад тоо томшгүй олон нарны гэрэл мэт хурц тод. Бид Бурханыг дотоодын гэрэл, аялгуугаар л таньж мэддэг.

Арьяабалын аргаар дадал бясалгал хийх, авшиг хүртэх нь ямар нэг нууц ёслол үйлдэж буй, эсвэл шинэ шашинд орж буй хэрэг биш. Авшиг хүртэх үеэр гэрэл болон аялгуу ажихад онцгойлон анхаарах зүйлийг зааж өгдөг. Хамгийн анхны ариун ахуй ойлголт чимээ аниргүйд бууж ирнэ.

Арьяабалын бясалгалын аргын хамгийн чухал хэсэг нь авшиг уламжлах юм. Таны билгийн үүдийг нээхэд Их Багш Чин Хай өөрийн биеэр морилох шаардлагагүй. Гэхдээ Их Багшийн адислалгүй бол бясалгалын арга ач тусаа өгөхгүй. Авшиг хүртэх үед та тэр даруй

дотоодынхоо аялгууг сонсож, дотоодынхоо гэрлийг харна. Үүнийг “Агшин зуур гэгээрэх” юм уу “Агшин зуур билиг нээгдэх” гэдэг.

Их Багш Чин Хай шашин шүтлэг, соёл уламжлалын ялгааг үл харгалзан авшиг хүртээдэг. Та шүтэж буй шашин, сүсэг бишрэлээ өөрчлөх шаардлагагүй. Таныг ямар нэгэн байгууллагад элсэхийг, эсвэл таны амьдралын одоогийн хэв маягт тохирохгүй аливаа үйл ажиллагаанд оролцохыг шаардахгүй.

Авшиг хүртэх нь ямар ч үнэ төлбөргүй.

Насаараа веган хоолтон байх нь авшиг хүртэх зайлшгүй нөхцөл болно.

Арьяабалын бясалгалын аргаар өдөр бүр бясалгах, таван сахил сахих нь авшиг хүртсэний дараах цорын ганц шаардлага юм.

Сахил нь өөртөө болон өрөөлд хор хүргэхгүй байхад туслах хэм хэмжээ бөгөөд үүнийг сахиж бясалгавал авшгаар нээгдсэн билиг ухаанаа улам тэлсээр эцэст нь хамгийн дээд ухамсрыг олж, Будда болно. Хэрэв өдөр бүр бясалгахгүй бол билиг нээгдсэнээ мартаж, ердийн ухамсрын төвшинд эргэж очдог.

Өөрөө дадал бясалгал хийж төгс гэгээрэлд хүрэхийг бидэнд зааж сургах нь Их Багш Чин Хайн зорилго билээ. Иймээс Түүний зааж буй бясалгалын аргаар хэн ч бясалгаж болдог. Нэмэлт тусламжид түшиглэхгүйгээр өөрөө бясалгал дадуулж болно. Тэрээр сүсэгтэн, бишрэн шүтэгч, шавь эрдэггүй, гишүүнчлэлтэй байгууллага байгуулж, хугацаат татвар хурааж татдаггүй. Их Багш Чин Хай сөгдөж мөргөхийг зөвшөөрөхгүй, мөнгө төгрөг, бэлэг сэлт хүлээж авахгүй учир өргөл барьц хэрэггүй. Тэр зөвхөн таны өдөр тутмын амьдрал болоод дадал бясалгалаараа өөрийгөө дэвшүүлэн богд гэгээнтэн болохыг хүсэж буй тэр чин сэтгэлийг чинь л хүлээж авна.

## ТАВАН САХИЛ

1. Аливаа амьтанд хор хөнөөл учруулахыг цээрлэнэ.\*
2. Үнэн бус зүйл ярихыг цээрлэнэ.
3. Өөрийн бус зүйл авахыг цээрлэнэ.
4. Бэлгийн зүй бус харилцааг цээрлэнэ.
5. Согтууруулах, мансууруулах бодис болон хорт зүйл хэрэглэхийг цээрлэнэ.\*\*

\*Энэ сахил нь веган хоолны дэглэмийг хатуу мөрдөхийг шаардана. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, загас, шувууны мах, өндөг (өндөгтэй болон сүүтэй боов, чихэр, бялуу, жигнэмэг, зайрмаг) гэх мэт амьтны гаралтай аливаа хүнсийг хэрэглэж болохгүй.

\*\*Энэ сахилд бүх төрлийн хорт бодис, тухайлбал: архи, тамхи, хар тамхи, мөрийтэй тоглоом, садар самуун, хүчирхийлэлтэй кино, зураг, уран зохиол, цахим тоглоом тоглох зэрэг аливаа хортой зүйлээс зайлсхийх явдал багтана.



## **ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН НОМ ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ**

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр**

Англи (1-5), Ау Лак (1-15), Герман (1-2), Индонез (1-5), Испани (1-3), Монгол (1-10), Польш (1-2), Солонгос (1-11), Португал (1-2), Тай (1-6), Түвд (1), Унгар (1), Фин(1), Франц (1-2), Хятад (1-10), Швед (1), Япон (1-4)

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Асуулт Хариулт**

Англи (1-2), Ау Лак (1-4), Болгар (1), Герман (1), Индонез (1-3), Монгол (1-2), Орос (1), Польш (1), Португал (1), Солонгос (1-4), Унгар (1), Франц (1), Хятад (1-3), Чех (1), Япон (1)

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Багш шавийн хоорондын захиа**

Англи (1), Ау Лак (1-2), Испани (1), Хятад (1-3)

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Багштайгаа өнгөрүүлсэн гайхамшигт мөчүүд**

Ау Лак (1-2), Хятад (1-2)

### **1992 онд Сан Ди Мун-д болсон 7 хоногийн даяан бясалгал / тусгай хэвлэл**

Англи (1), Ау Лак (1)

### **Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 1993 онд Дэлхий даяар ном дэлгэрүүлсэн аялал**

Англи (1-6), Хятад (1-6)

### **Их Багшийн ярьсан үлгэр түүх**

Англи (1), Ау Лак (1), Испани (1), Монгол (1), Солонгос (1), Тай (1), Хятад (1), Япон (1)

### **Эзэн Бурхан ба хүн төрөлхтний үлгэр - Библийн үлгэрүүдийг ухаарахуй**

Англи, Ау Лак, Хятад

### **Эзэн Бурхантай шууд холбогдохуй - Энх тайванд хүрэх зам**

Англи, Ау Лак, Хятад

### **Амьдралаа солонгоруулья**

Англи, Ау Лак, Монгол, Хятад

### **Эрүүл мэндээ ухаарахуй Жам ёсны зөв амьдралын хэв маягт эргэн орохуй**

Англи, Ау Лак, Монгол, Хятад

**Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд**

Англи, Ау Лак, Монгол, Хятад

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдсан билиг ухааны зурагт үлгэрүүд - Бурхан бүхнийг зохицуулдаг**

Англи, Ау Лак, Монгол, Солонгос, Хятад, Франц, Япон

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Гэгээрүүлэгч хошигнол - Таны гэрлэн бүрхүүл дэндүү давчуу байна!**

Англи/Хятад (ном + CD)

**Онч мэргэн үгс (1)**

Англи (1), Хятад (1), Испани/Португал, Франц/Герман,

Англи/Солонгос, Англи/Япон

**Онч мэргэн үгс (2)**

Англи (1), Хятад (1)

**Тэнгэрлэг зоог - Олон улсын ургамал хоолны гал тогоо**

Англи/Хятад, Ау Лак, Япон

**Тэнгэрлэг зоог – Гэрийн хоолны амтат сонголт**

Англи/Хятад

**Диваажингийн урлаг**

Англи, Ау Лак, Монгол, Хятад

**Жинхэнэ хайр**

Англи, Хятад, DVD, MP4

**Ая эгшгээр амгалан дэлхийг бүтээхүй (тусгай хэвлэл)**

Англи/Ау Лак/ Хятад

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлог**

Англи/Ау Лак/Хятад

**Уран зургийн цувралууд**

Англи (1), Хятад (1)

**Тэнгэрийн хувцас**

Англи/Хятад

**Шувууд миний амьдралд**

Англи, Ау Лак, Араб, Герман, Индонез, Монгол, Солонгос, Орос, Франц, Хятад

**Эрхэм ариун амьтад**

Англи, Ау Лак, Герман, Монгол, Солонгос, Франц, Хятад

**Чимээгүй нулимс**

Англи, Ау Лак, Хятад, Герман, Франц, Испани, Португал, Солонгос, Монгол, Филиппин

**Вуузуу шүлгүүд**

Англи, Ау Лак, Хятад

**Мартагдсан дурсамж**

Англи, Ау Лак, Хятад

**Хайрга ба Алт**

Англи, Ау Лак, Хятад

**Эрвээхэйн мөрөөдөл**

Англи, Ау Лак, Хятад

**Өмнөх амьдралын зам мөр**

Англи, Ау Лак, Хятад

**Хуучин цаг**

Англи, Ау Лак, Хятад

**Эрин зууны хайр**

Англи, Ау Лак, Хятад

**Аниргүйхэн нулимсыг хайрлахуй**

Англи, Хятад, CD, DVD, MP4

**Амьдрал болоод ухамсрын тухай бодрол:**

Доктор Жанезын бичсэн ном, Хятад хэлээр

**Хямралаас Энх тайванд: Шийдэл нь Органик веган хүнс**

<http://crisis2peace.org> хаягаар олон хэлээр үнэ төлбөргүй унших болон татаж авна уу.

Дээрх номууд үргэлжлэн хэвлэгдсээр байна.

*Бусад айлдвар болон дууны DVD, MP3, MP4, CD-ны цувралууд Араб, Армен, Ау Лак, Болгар, Камбож, Кантон, Хятад, Хорват, Чех, Дани, Холланд, Болгар, Англи, Фин, Франц, Герман, Грек, Еврей, Унгар, Индонез, Итали, Япон, Солонгос, Малай, Монгол, Непал, Норвег, Перс, Филиппин, Польш, Португал, Румын, Орос, Шри Ланк, Словени, Испани, Швед, Тай, Турк, Зулу хэлээр хэвлэгджээ.*

## **БИДЭНТЭЙ ХЭРХЭН ХОЛБОГДОХ ВЭ?**

### **Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг**

Шуудангийн хайрцаг 9, Шихү, Миаоли, Формоса,  
БНХУ (36899)  
Шуудангийн хайрцаг 730247, Сан Хосе, Калифорни  
95173-0247, АНУ

### **Суприм Мастер Телевиз**

И-мэйл: [Peace@SupremeMasterTV.com](mailto:Peace@SupremeMasterTV.com)  
Утас: 1-626-444-4385  
Факс: 1-626-444-4386

### **Ном орчуулгын групп:**

И-мэйл: [divine@godsdirectcontact.org](mailto:divine@godsdirectcontact.org)  
(Та Их Багшийн номыг олон хэлээр орчуулах ажилд  
оролцож болно.)

### **Мэдээний групп:**

И-мэйл: [lovenews@godsdirectcontact.org](mailto:lovenews@godsdirectcontact.org)  
S.M. Celestial Co., Ltd:  
И-мэйл: [smclothes123@gmail.com](mailto:smclothes123@gmail.com);  
[Vegann@hotmail.com](mailto:Vegann@hotmail.com)  
Утас: 886-3-4601391  
Факс: 886-3-4602857  
Веб сайт: <http://www.smcelestial.com>  
<http://www.sm-celestial.com>

### **Асуулт хариултын баг:**

И-мэйл: [lovewish@godsdirectcontact.org](mailto:lovewish@godsdirectcontact.org)

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын  
Нийгэмлэгийн Хэвлэл ХХК**

И-мэйл: [smchbooks@godsdirectcontact.org](mailto:smchbooks@godsdirectcontact.org)  
Утас: 886-2-23759688 Факс: 886-2-23757689  
<http://www.smchbooks.com>

**Онлайн дэлгүүр**

Celestial Shop: <http://www.theCelestialShop.com> (Англи)  
Eden: <http://www.EdenRules.com/> (Англи, Хятад) Цэвэр веган  
бүтээгдэхүүний онлайн дэлгүүр  
<http://www.lovingfood.com.tw>

**”Loving Hut” Олон Улсын Веган Хоолны Сүлжээ  
ресторан**

И-мэйл: [service@lovinghut.com](mailto:service@lovinghut.com)  
Утас: 886-3-4683345  
Факс: 886-3-4681581  
Веб сайт: <http://www.lovinghut.com/tw/>

**Гуан Инь веб сайтууд:**

Бурхантай шууд холбогдох - Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн интернэт хаяг:

<http://www.godsdirectcontact.org.tw/eng/links/links.htm>

Энэ хаягаар дэлхийн олон хэлээрх Гуан Инь вэб хаягуудыг олж авахаас гадна 24 цагийн интернэт телевиз болох Суприм Мастер Телевиз болон Урлагийн Ергөнцөөр Аялахуй нэвтрүүлгийг үзэх боломжтой.

Мөн олон орны хэлээр “Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр” үлгэр дэвтрийг татаж авч болно. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн мэдээ сэтгүүлийг цахим хэлбэрээр татаж авах болон унших боломжтой.

**Суприм Мастер Телевиз**

Суприм Мастер Телевиз нь бүтээлч хөтөлбөрүүдийг нэвтрүүлдэг суваг бөгөөд танд сүнслэг дэвшлийг авчирч, амьдралд тань цоо шинэ өнгө төрхийг бэлэглэх болно.

Суприм Мастер Телевизийг 24 цагийн турш онлайнаар үзэх хаяг:

<http://suprememastertv.com/mn1/>

**Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр (үлгэр дэвтэр)-ийг олон хэлээр  
үнэ төлбөргүй татаж авах хаяг (80 орны хэлээр)**

<http://sb.godsdirectcontact.net>

# АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР ДӨРӨВДҮГЭЭР БОТЬ

Зохиогч: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Хэвлүүлэн тараасан газар: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын нийгэмлэг хэвлэлийн компани

Хаяг: Тайбэй хотын Жүн жен дүүргийн Жүн шяо баруун замын нэгдүгээр гудамжийн 72-8-16

Утас: 886-2-23759688

Факс: 886-2-23757689

И-мэйл: [smchbooks@Godsdirectcontact.org](mailto:smchbooks@Godsdirectcontact.org)

<http://www.smchbooks.com>

Шуудан номер: 19259438

The Supreme Master Ching Hai©1990 ~ 2014

Анхдагч хэвлэл: 1990 оны 8 дугаар сарын 1

Хоёр дахь хэвлэл: 1991 оны 4 дүгээр сарын 1

Гурав дахь хэвлэл: 1992 оны 5 дугаар сарын 1

Дөрөв дэх хэвлэл: 1993 оны 5 дугаар сарын 20

Тав дахь хэвлэл: 1994 оны 11 дүгээр сарын 25

Зургаа дахь хэвлэл: 1998 оны 10 дугаар сар

Долоо дахь хэвлэл: 2004 оны 3 дугаар сар

Найм дахь хэвлэл: 2014 оны 7 дугаар сар

Энэ хувилбарыг монгол хэлнээ орчуулсан

2021 оны 4 дүгээр сар

Цахим хувилбар: <http://www.gegeerel.mn>

2023 оны 6 дугаар сар

Улсын номын сан хэвлэлийн зүйлсийг урьдчилан хэвлүүлэн тараах мэдээлэл

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр

Зохиогч: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Анхдагч хэвлэл Тайбэй хот: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн олон улсын нийгэмлэг 1998 「 хятадын он тооллоор 87 он 」

1 дэвтэр: 13x19 сантиметр

ISBN 978-957-98468-9-9 (дөрөвдүгээр боть: хатуу хавтастай)

1. сүнслэг бясалгал 2. оюун санааны амьдрал

192.1

87012594

Энэ дэлхийд залран буй Төгс гэгээрсэн Их багштай учрахад хэцүү, жинхэнэ дээд номыг хүртэхэд бэрх гэдгийг үнэнийг эрж хайсан бидний бэрхшээлт замнал гүнзгий ухааруулсан юм. Арьяабалын бясалгалын арга нь эртний жинхэнэ багш нараас уламжлагдан ирсэн охь дээд номын дамжлага мөн учраас хүмүүний мөн чанарын билиг билгүүнийг сэрээж, үнэн номыг ухааруулж чадна. Энэхүү номын ёсоор бясалгаад бид хэмжээлшгүй их ач тусыг хүртсэн тул бидний багш Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн олон оронд айлдсан дээдийн номын айлдваруудыг эмхтгэж, энэ төрөлдөө сансрын хүрднээс ангижрахыг хүссэн, жинхэнэ үнэн номыг хайсан, үхэж төрөх, бясалгал, гэгээрэл, үнэн мэдлэгийн тухай асуултууддаа хариулт эрж буй хүмүүст туслахыг зорин энэхүү номыг өргөн барьж байна.